



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2020 он

АГУУЛГА

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО	6
ХОЁР. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	17
3.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	17
3.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	18
3.3 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт ..	19
3.4 Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	21
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	22
4.1 Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	22
4.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	45
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	46
5.1 Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	46
5.2 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	46
5.3 Шударга байдлын түвшний үнэлгээ	47
ЗУРГАА. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ	48
ДОЛОО. БУСАД АСУУДАЛ	49
7.1 Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт	49
7.2 Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	55
НАЙМ. ДҮГНЭЛТ	56
ЕС. ЗӨВЛӨМЖ	56
АРАВ. ХАВСРАЛТ	59
10.1 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	59
10.2 Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	71
10.3 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт /журмын 10 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	636
10.4 Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлт /журмын 11 дүгээр хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	644
10.5 Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	655
10.6 Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	788
10.7 Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан, хамтран ажилах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	847
10.8 Зөвлөмжийн биелэлт	915

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2020.03.20

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, яамны үйл ажиллагааг бодитой үнэлэхэд чиглэгдсэн болно. Тус ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичиг, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт, УИХ, Засгийн газраас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, гадаадын зээл тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны гүйцэтгэлийн бусад мэдээ, тайланд тулгуурлан Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 багц, 9 үзүүлэлтээр дүгнэв.

Барилга, хот байгуулалтын салбарын хэрэглэгчийн үнэлгээг ЗГХЭГ нэгдсэн байдлаар зохион байгуулах тул үнэлгээнд оруулаагүй болно.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2019 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад яамны ерөнхий үнэлгээ **93,8 хувь буюу 4,7 оноотой** байна.

**БАРИЛГЫН САЛБАРТ 2019 ОНД ХИЙЖ, ХЭРЭГЖҮҮЛСЭН
ТОМООХОН АЖЛУУД**

• Хууль эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг боловсронгуй болгох ажлын хүрээнд:

Барилга, хот байгуулалтын салбарт Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал” хэрэгжүүлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын салбарын чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг байгуулж, энэ хүрээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа 200 гаруй хуулийг судалж шинжилгээ хийсэн. Салбарын 7 хуульд чиг үүрэг хуваарилах, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах талаар өөрчлөлт оруулах саналыг боловсруулж ЗГХЭГ-т шинжилгээ хийсэн тайлангийн хамт хүргүүлсэн.

Тайлант хугацаанд Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийн үзэл баримтлал, Газрын кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийн үзэл баримтлалыг тус тус боловсруулж ХЗДХЯ-тай, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Барилгын аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай” 1998 оны 167 дугаар конвенцийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг ГХЯ-тай хамтран боловсруулж батлуулсан.

Хот байгуулалтын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, БХБСайдын зөвлөлийн хуралдаанаар 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцүүлэн, хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр СЯ болон ХЗДХЯ-аас тус тус авч, УИХ-д өргөн мэдүүлэх тов тогтоолгохоор ЗГХЭГ-аас зохих албан бичгийг УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн.

- Орон сууцны тухай хууль болон Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн давхардал, хийдлийг арилгах, мөн Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль Усны тухай хуультай давхардсан зөрчлийг арилгах, төрийн байгууллагуудын эрх, үүргийг нарийвчлан тусгах ажлыг дээрх хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах явцад анхаарч, холбогдох зохицуулалтыг тусгаж байна. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлсэн.

- Геодези зураг зүйн тухай хуулийн төслийн сүүлийн хэлэлцүүлгийг 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, яамдаас хуулийн төсөлд санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Барилгын аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай” 1998 оны 167 дугаар конвенцийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулж, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн, ЗГХЭГ-т 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлсэн.

Тайлант хугацаанд дараах ЗГ-ын тогтоол, шийдвэрийг батлуулаад байна. Үүнд:

- “/Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” /Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот Аэросити/ Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 29 дүгээр тогтоол;

- “Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 30 дугаар тогтоол;

- “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого батлах тухай” Засгийн газрын 2019.02.13-ны өдрийн 70 дугаар тогтоол;

- “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” /Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журамд өөрчлөлт оруулах/ Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 105 дугаар тогтоол;

- “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлах тухай” Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 106 дугаар тогтоол;

- “Журам батлах тухай” /Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаад улсын барилгын норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам/ Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 107 дугаар тогтоол;

- “Дүрэм шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” /Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм/ Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 108 дугаар тогтоол;
- “Иргэнд 2019 онд өмчлүүлэх нийт газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” Засгийн газрын 2019.03.27-ны өдрийн 119 дүгээр тогтоол;
- “Журам батлах тухай” /Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам/ Засгийн газрын 2019.4.10-ны өдрийн 138 дугаар тогтоол;
- “Үндэсний хорооны дүрэм батлах тухай” /Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах/ Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 155 дугаар захирамж;
- “Газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах, авах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2019.04.17-ны өдрийн 155 дугаар тогтоол;
- “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Засгийн газрын 2019.05.01-ний өдрийн 174 дүгээр тогтоол;
- “Үндэсний хөтөлбөр батлах тухай” /150 мянган айл-Орон сууц хөтөлбөр/ Засгийн газрын 2019.05.22-ны өдрийн 202 дугаар тогтоол;
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд баригдсан байгууламжуудын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2019.05.29-ний өдрийн 206 дугаар тогтоол;
- “Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2019.05.29-ний өдрийн 212 дугаар тогтоол;
- “Түрээсийн орон сууцны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019.6.05-ны өдрийн 223 дугаар тогтоол;
- “Нийслэлд 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” Засгийн газрын 2019.6.28-ны өдрийн 264 дүгээр тогтоол;
- “Төв, суурин газрын 2019-2020 оны өвөлжилийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019.07.03-ны өдрийн 270 дугаар тогтоол;
- “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Засгийн газрын 2019.09.18-ны өдрийн 357 дугаар тогтоол;
- “Журам шинэчлэн батлах тухай” /Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам/ Засгийн газрын 2019.08.14-ний өдрийн 325 дугаар тогтоол;
- “Тогтоолд өөрчлөлт оруулах, тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2019.10.02-ны өдрийн 368 дугаар тогтоол;
- “Хөрөнгө гаргах тухай” /Майдар хот төсөл/ Засгийн газрын 2019.10.30-ны өдрийн 390 дүгээр тогтоол зэрэг болно.

Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгөөр 2019 онд боловсруулах норм, дүрэм, төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд 33 норм, нормативыг шинээр боловсруулах, 96 норм, нормативыг үргэлжлүүлэн боловсруулахаар төлөвлөснөөс ЗГ-ын тогтоолоор 1 баримт бичиг, барилгын норм ба дүрэм-14, стандарт-4-ийг батлуулсан. Үүнд:

- “Барилга байгууламжийн төсвийн суурь нормыг хэрэглэх аргачлал” /БД 81-119-18/;
- “Хот байгуулалтын кадастр” /БД 14-01-19/;
- “Угсармал төмөр бетон том хавтгаалжин бүтээцийн хэсэглэлийн цомгийн бүрдэл”;
- “Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах, хэрэглэх дүрэм”; “Барилга байгууламжийн төсвийн суурь нормын технологийн карт”;
- “Өндрийн III ба IV ангийн сүлжээ байгуулах барилгын дүрэм” /БД 11-121-19/;

- “Геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулах ажил” /БД 11-104-19/;
- “Хийн хангамж”/БНБД 42-01-04/2008/ баримт бичгийг шинэчлэх;
- “Барилгын инженерийн шугам сүлжээний зураглалын ажил” /БД 11-105-19/;
- “Барилгын технологийн үйл ажиллагааны автоматжуулалт, технологийн үйл ажиллагааны автоматжуулалтын зураг төслийг боловсруулах дүрэм” /БД 43-106-18/;
- “Барилга байгууламжийн цахилгаан төхөөрөмжийн газардуулгыг тооцоолох аргачлал” /БД 43-106-19/;
- “Барилга байгууламжийн 2017 оны үнийн индекс”;
- “Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” /БНБД 11-07-19/;
- “Барилгын ажилтны тарифт цалингийн жишиг”;
- “Барилга байгууламжийн 2018 оны үнийн индекс”;
- “Усны чанар сайжруулах төхөөрөмжийн стандарт”;
- “EN 442 Халаах хэрэгсэл. Радиатор ба конвектор”;
- “Барилгын шил – шилний гулзайлтын бат бэхээр тодорхойлох. 1-р хэсэг: Шилний туршилт стандарт боловсруулах ажил”;
- “Шиллэгээний шил-1-р хэсэг: Ангилал стандарт боловсруулах ажил”

• **Салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд:**

- Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын Сайд болон нийслэл, аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээний бэлтгэл ажлыг хангаж, 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, 21 аймгийн Засаг даргатай гэрээ байгуулав.

- Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Барилга, хот байгуулалт сайд Х.Баделхан болон Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны ерөнхийлөгч М.Батбаатар, Монголын Барилгачдын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбооны дарга Б.Батцогт нар хамтран гарын үсэг зурж батлав. Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг ХНХЯ-нд хүргүүлж, 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдөр бүртгүүлэв.

- Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Барилга, хот байгуулалт сайд Х.Баделхан болон Монголын Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний Холбооны тэргүүн Ж.Батсуурь, Хот Байгуулалт, Нийтийн Аж Ахуйн Ажилтны Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны дарга А.Бурмаа нар хамтран гарын үсэг зурж батлав. Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг ХНХЯ-нд хүргүүлж, 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр бүртгүүлэв.

- “Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” болон “Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г тус тус Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.

- Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 09 дүгээр тушаалаар “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай

зөвшөөрөл олгох” үйл ажиллагааг Төрийн бус байгууллагууд /8/-уудын түншлэлийг төлөөлж “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. “Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 01-ний 20 дугаар тушаалаар барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг /барилгын салбарын төрийн бус, мэргэжлийн байгууллагууд/12/-ын түншлэлийг төлөөлж/ “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-аар гэрээний үндсэн дээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх 2019/31 тоот гэрээг “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-тай, архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалт эрхлэх чиг үүргийг гүйцэтгүүлэх 2019/28 тоот гэрээг “Монголын Архитекторуудын Эвлэл” ТББ-тай 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тус тус байгуулсан.

- “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн 2019” арга хэмжээг 03 дугаар сарын 26-ны өдөр Төрийн ордны их танхимд зохион байгуулсан.

- Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2019”-ийг 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/60 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

- Геодези, зураг зүйн салбарын удирдах ажилтны 2 дугаар зөвлөгөөнийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтарч 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг холбогдох газарт 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлж, зөвлөмжийн дагуу холбогдох ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

- Хот байгуулалтын форум, хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Барилгын хөгжлийн төвд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ, НХБХГ, НГЗБА, МАЭ-ТББ, МБУА-ТББ-ын төлөөлөл 150 хүн оролцсон.

- Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд төр, орон нутаг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд түрээсийн орон сууцны санг бүрдүүлэхээр заасан тул “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ын төслийг боловсруулж, 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын 138 дугаар тогтоолоор батлуулсанаар зах зээлд түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэнд өмчлүүлэхээр хэрэгжиж буй 3457 айлын орон сууц байгаас 2387 айлын орон сууцанд иргэдийг хамруулсан. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 5389 айлын орон сууц ашиглалтад орсон байна. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 81 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкинд шилжүүлсэн 1542 айлын орон сууцны барилгыг түрээсийн орон сууцны санд шилжүүлэх тухай Засгийн газрын 2019 оны 06 дүгээр сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолыг батлуулсан. Тогтоолоор Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын орон нутгийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийн бүртгэн оруулах ажлыг зохион байгуулж эхлэхэд бэлэн болсон байна.

- **Орон сууцны ипотекийн зээлийн хүрээнд:**

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 433,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 6,476 иргэнд олгоод байна. Үүнээс Монголбанкны эх үүсвэрээс 213.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 3,009 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 112 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,820 иргэнд, банкуудын өөрийн эх

үүсвэрээс 117.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,647 иргэнд тус тус олгосон. 2019 онд үлдэгдэл санхүүжилтийг гаргуулах талаарх хүсэлтийг болон “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-д заасан амины орон сууцанд зээл олгох ажлыг эрчимжүүлэх үүднээс хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын төслийг боловсруулж Монголбанкны ерөнхийлөгчийн баталсан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-д тусгуулах тухай хүсэлтийг тус тус Монголбанкинд хүргүүлээд байна. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Ипотекийн зээлийн санхүүжилтэд 60 тэрбум төгрөгийг тусгасны дагуу Ипотекийн зээлийн журмыг шинэчлэх судалгаа хийгдэж байна.

• **Салбарт хэрэгжүүлж буй гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийн хүрээнд:**

“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН төсөл”-ийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд:

1. Сайншанд, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын 2025 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон “Шинэ Сайншанд” орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, улсын экспертизээр батлуулан, орон нутагт хүлээлгэн өгсөн.

2. Сайншанд хотод 6,45 км цэвэр усны шугам, 5,06 км бохир усны шугам, 2,7 км дулааны шугам, 8,4 МВт хүчин чадалтай дулааны зуух, дагалдах насос, тоног төхөөрөмж, зуухны барилга, харуулын байр, цахилгаан дамжуулах дэд станц, дизель цахилгаан үүсгүүр, хамгаалалтын хашаа, 2 км хатуу хучилттай авто зам барьж, ашиглалтанд оруулж, хатуу хог хаягдлын машин ханган нийлүүлсэн.

3. Даланзадгад хотод 1,000 м3 усан сан, 1,4 км цахилгаан дамжуулах шугам, гүний худаг, 1,4 км ус дамжуулах шугам, гэр хороололд 4,7 км бохир усны шугам барьж, ашиглалтад оруулсан.

4. Замын-Үүд суманд 13,4 км цэвэр усны шугам, 7,87 км бохир усны шугам, 3 ш ус түгээх байр, 2 ш бохир усны насосны станц, 3 км дулааны шугам, 3 ш дулаан дамжуулах төв, 3 ш дизель цахилгаан үүсгүүр барьж, ашиглалтанд оруулж, хог пресслэгч ханган нийлүүлж, хатуу хаягдлыг булж зайлуулах цэгийн ажил болон цэцэрлэг, сургуулийг нэгдсэн дулааны шугамд холбох ажил хийгдсэн.

5. Гурвантэс суманд 100 м3 багтаамжтай усан сан, 2 ш гүний худаг, 3,2 км цахилгаан дамжуулах шугам, 5,7 км цэвэр усны шугам, 4,1 км бохир усны шугам, бохир ус цэвэрлэх байгууламж, 3 ш ус түгээх байр, 2 км хатуу хучилттай авто зам, 1,8 км үерийн далан барьж, ашиглалтанд оруулсан.

6. Цогтцэций суманд 2 ш 100 м3 багтаамжтай усан сан, 0,6 км цахилгаан дамжуулах шугам, 3 ш ус түгээх байр, бохир усны насосны станц, 6,6 км цэвэр усны шугам, 5,8 км бохир усны шугам барьж, ашиглалтанд оруулсан.

7. Ханбогд суманд 5.5 км цэвэр усны шугам, 8.4 км бохир усны шугам, 5.4 км цахилгаан дамжуулах шугам, 2 км дулааны шугам, 2 ш ус түгээх байр, бохир ус цэвэрлэх байгууламж барьж, ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

8. Төслийн хэрэгжилтийн талаар 2011 оны суурь судалгаанд 996 өрх, 2015 оны явцын судалгаанд 1001 өрх, төслийн төгсгөлийн үр дүн, нийгэм, жендерийн судалгаанд 1000 өрхийг тус тус хамруулж, судалгаа авч нэгтгэхэд оршин суугчид төслийн үр дүнг “хангалттай сайн” гэж үнэлсэн.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл”-ийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд:

1. Архангай аймгийн Цэцэрлэг хотод баригдах цэвэрлэх байгууламжийг аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/536 тоот захирамжаар байгуулагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ажиллаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн.

2. Дорноговь аймгийн Сайншанд хотын цэвэрлэх байгууламжийн ажлыг 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлж, 2-р тунгаагуурын ханын арматурчлал, сараалжийн, дэд өртөөний барилгуудын гадна фасадын ажил, үйлдвэрийн барилгын гадна өрлөгийн ажил, лаг боловсруулах цех, уурын зуухны барилгуудын өрлөг, хучилтын цутгалтын ажлууд хийгдсэн. Нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувьтай.

3. Өвөрхангай аймгийн Хужирт сумын 310 м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсвийг 2019 оны 04 дүгээр сард магадлалаар хянуулан батлуулж, тендерийг 2019 оны 11-р сард зарлан, дүгнэж байна.

4. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төвийн ус, дулаан дамжуулах төв-10-ын дулаан хангамжийн 2-р хэлхээний 380 м бетон сувгийг цутгаж, дулааны өгөх, буцах, хэрэгцээний халуун ус, хүйтэн усны нийт 5 шугамын угсралтын ажлыг гүйцэтгэсэн. Цэвэр усны эх үүсвэрийн 2-р худгаас дулааны төв станц хүртэлх 2,5 км цэвэр усны шугам угсарч дуусган, 2019 оны 12 дугаар сарын 05-нд комисс ажиллаж, ашиглалтад оруулсан.

5. Өвөрхангай аймгийн Баянгол сумын бохир усны шугам сүлжээ, насос станцын нэмэлт ажлын хүрээнд үерийн усны бетон далангийн 200м сувгийн ажил бүрэн дууссан. Ажлын гүйцэтгэл 98 хувьтай.

6. Нийтийн аж ахуйн байгууллагуудын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх баг Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймгуудад 2019 оны 09-10 дугаар сард ажиллаж, дээрхи аймгуудын НААБ-уудын Төлөөлөн удирдах зөвлөлд тухайн байгууллагуудын стратеги төлөвлөгөөг танилцуулан, хүлээлгэн өгсөн.

7. Төслийн бүрэлдэхүүнд багтаж байгаа “Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа ТТ9100” дэд төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 200 айлд сайжруулсан нүхэн жорлон хамтарч барихаас 47 айлын нүхэн жорлонг барьж, ашиглалтад оруулаад байна.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд:

1. Төслийн аймгуудын НААУБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх компани сонгон шалгаруулах ажлын даалгаварыг боловсруулж, Үнэлгээний хороонд танилцуулсан. Ажлын гүйцэтгэл 80%.

2. Булган аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын гүйцэтгэгч “Заг инженеринг” ХХК, “Престиж Инженеринг” ХХК, “Жиангсу Зэюү Энв. Протекшн” түншлэлтэй 2019 оны 5 дугаар сард гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн. Биологи цэвэрлэгээний барилгын төмөр бетон цутгалтын ажил, талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил бүрэн дууссан. Үйлдвэрийн, механик цэвэрлэгээний барилгын 0,00 түвшингийн суурийн төмөр бетон цутгалтын ажил, бохир усны, дренажийн бохир усны барилгын 0,00 түвшингийн төмөр бетон цутгалтын ажил, лаг боловсруулах цехийн барилгын суурийн цутгалт, ханын арматурчлалын ажил хийгдсэн. Барилга угсралтын ажил 50 хувьтай байна.

3. Хөвсгөл аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг “Набсан” ХХК, “Эс энд Эй Трэйд” ХХК-ний түншлэл 2019 оны 6 дугаар сараас эхлүүлж, биологи цэвэрлэгээний блокийн барилгын ханын арматурчлал, механик цэвэрлэгээний блокийн суурийн цутгалтын ажил, үйлдвэрийн барилгын баганын арматурчлалын ажил хийгдсэн.

Захиргааны, дэд өртөөний, харуулын байрны барилгуудын хучилтын цутгалтын ажил дууссан. Цэвэрлэгдсэн усны насос станцын гадна өрлөгийн ажил, бохир усны, дренажийн барилгын цутгалт, өрлөгийн угсралтын ажлуудыг гүйцэтгэсэн. Талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил, цэвэр ус, дулааны шугамын угсралтын ажил бүрэн дууссан. Лаг, элсний талбайн бетоны ажил дууссан. Барилга угсралтын ажил 55 хувьтай байна.

4. Хэнтий аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг “Комфорт импекс” ХХК 2019 оны 8 дугаар сараас эхлүүлж, ЦДАШ-ын угсралтын ажил, захиргааны, дэд өртөөний барилга, харуулын барилгуудын өрлөг, хучилтын ажлууд хийгдэж дууссан. Барилга угсралтын нийт ажил 10 хувьтай байна. Барилгын ажил график, төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

“Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244 төсөл”-ийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд:

1. Төслийн үндсэн худалдан авалтаас хэмнэгдсэн зээлийн хөрөнгөөр “А2-4. Бохирын шугам хоолойн өргөтгөл шинэчлэл” багц ажлын хүрээнд “Цагаан зуун” ХХК нь ф300 мм-ийн голчтой 1770 м шугам, 52 худгийн барилгын ажлыг гүйцэтгэн, 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулсан.

2. Төслийн хүрээнд “Бридж констракшн” ХХК нь ф300 мм-ийн голчтой 290 м шугам, 13 худгийн барилгын ажлыг гүйцэтгэн, 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгсөн.

3. Төслийн худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөний дагуу техникийн шаардлага хангасан эксковаторыг Дарханы ус сувгийн байгууллагад 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгсөн.

4. А2-7 багц. Бохирын насос станцын засварын ажлын хүрээнд насос станцыг шинэчлэх, бохирын нэмэлт шугам хоолойн ажлын зураг төслийг “Эрчим төсөл” ХХК боловсруулж, батлуулсан.

5. Дархан-Уул аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 07 дугаар тогтоолоор “Бридж констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн 714,5 сая төгрөгийн үнэ бүхий бохир усны ф355 мм-ийн голчтой 1600 м хуванцар хоолой, ф800 мм-ийн 1230 м төмөр бетон хоолой, ф300 мм-ийн 290м хуванцар хоолойг, мөн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 10-р сарын 04-ний өдрийн 88 тоот тогтоолоор “Бридж констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн 234,2 сая төг-ийн үнэ бүхий бохир усны шугам хоолойг, “Цагаан зуун” ХХК-ийн гүйцэтгэсэн 633 сая төг-ийн үнэ бүхий бохир усны шугам хоолойг тус тус Дархан ус суваг ХК-ийн балансад бүртгэх зөвшөөрөл олгосон.

6. “Дархан дулааны сүлжээ” ТӨХК-д 1 тэрбум 260,3 сая төг-ийн үнэ бүхий дулааны насос станц, цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамыг хүлээлгэн өгч, барилга байгууламжийн ашиглалтын ногоон гэрчилгээ олгосон.

7. Төслийн хэмнэгдсэн хөрөнгөөр нэмэлт 2 байршилд бохир усны шугам угсрахтай холбогдуулан газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг шинэчлэн 2019 оны 03-р сарын 13-ны өдөр АХБ-аар батлуулсан.

8. Төслийн байгаль орчны хяналтын зөвлөхтэй 2019 оны 03 дугаар сард, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэнтэй 2019 оны 09-р сард, Дархан дахь төслийн нэгжийн захиргааны ажилтан/орчуулагчтай 2019 оны 10 дугаар сард тус тус гэрээ байгуулан, ажиллуулж байна.

9. Төслийн хүрээнд нийгмийн хөгжлийн, жендерийн үйл ажиллагааны, хэлэлцүүлэг, оролцооны, оролцогч талуудын харилцаа холбооны, олон нийтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус батлуулан хэрэгжүүлэн ажилласан байна.

“Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл /fr-01/”-ийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд:

Төслийн хүрээнд 2013-2017 онд “Ар дааган” ХХК, “Байгууламж” ХХК-ийн түншлэл Эрдэнэт хотод 20 000 м3/хоногийн хүчин чадалтай биологи цэвэрлэгээний цэвэрлэх байгууламжийг барьсан.

Энэ хугацаанд бохир ус хүлээн авах насосны станц, элс баригч, анхдагч тунгаагуурууд, анхдагч тунгаагуурын хувиарлах, насосны станц, азротенк, азротенк лагийн насосны станц, хоёрдугаар тунгаагуурууд, ус хэмжигчийн байр, ЦРП-6-гийн өргөтгөл подстанц, агаар өгөх байгууламж, анхдагч болон биологийн лаг өтгөрүүлэгч, лаг усгүйжүүлэх байгууламж, гадна дулаан, цэвэр бохир усны шугам, гадна гэрэлтүүлэг, зам талбай, технологийн шугам, тоног төхөөрөмжийн угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Барилга угсралтын ажил болон тоног төхөөрөмжүүдийн угсралт бүрэн дууссан.

Байгууламжийг ашиглалтад оруулах зорилттой ажиллаж 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор БНФУ-ын “СЭУЗ Интернэшнл” ХХК-иас инженерүүд ирж цахилгаан тоног төхөөрөмжийн холболт, дотоод сүлжээ, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллах ажиллагааг хянан шалгаж, 2020 оны 05 дугаар сараас бохир ус хүлээн авахад бэлэн болгох бэлтгэл ажлыг хангаж байна.

“Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл”-ийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд:

1. МҮОНРТ орчмын хороололд ус дулаан дамжуулах төвтэй холбосон 105 м /хос шугам/ шугам сүлжээ. 1 ширхэг дулааны худаг, гадна бохир усны 1100 метр шугам сүлжээ, 30 ширхэг худаг болон Баянгол дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт дулааны 1760 метр шугам сүлжээ, 7 ширхэг цутгамал худгийн угсралтын ажлыг гүйцэтгэн 2019 оны 8-р сарын 4-ний өдөр тус тус ашиглалтад оруулсан.

2. МҮОНРТ Чингэлтэй дүүргийн 5,8-р хорооны нутаг дэвсгэрт нийт 1700 метр бохир усны шугам сүлжээний, 54 ширхэг худгийн угсралтын ажлыг гүйцэтгэсэн.

3. МҮОНРТ-ийн усан сан, өргөлтийн насос станц, цэвэр усны шугамын ажлын хүрээнд цэвэр усны 4200 метр шугам сүлжээ, 3 ширхэг цутгамал худаг, 18 ширхэг угсармал худгийн угсралтын ажлыг 2019 онд бүрэн гүйцэтгэсэн.

4. Төслийн хүрээнд 2019 онд МҮОНРТ, VII, XIV хороололд 10 кВ-ын хуваарилах байгууламж-3 ком, 2х630 кВА-ын цахилгааны дэд өртөө -1 ком, 2х1000 кВА-ын дэд өртөө 1 ком, тэдгээрийн тэжээлийн 10 кВ-ын 25,0 км урттай цахилгааны кабель шугамын угсралтын ажил зэрэг 11 нэр төрлийн ажлыг гүйцэтгэсэн байна.

5. Тасганы усан сангийн хяналтын системийн шилэн кабелийн ажил бүрэн дуусч, 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр комисс ажиллан, байнгын ашиглалтад оруулсан. Цахилгааны ажлын хувьд: 800 кВА-ын чадалтай нөөцийн дизель генератор суурилуулсан. ХТП-1054 дэд өртөөнөөс буусан 2 ш трансформатор, 10 кВ-ын тоног төхөөрөмжийг эзэмшигч байгууллага УСУГ-т хүлээлгэн өгсөн.

“Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ /НАМА/ төсөл”-ийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд:

1. “Барилгын ХХЯ /хүлэмжийн хийн ялгарал/-ын хэмжээг тооцох аргачлал” БД23-105-20, “Барилгын ХХЯ-ыг тоолох, бүртгэх, мэдээлэх журам”, “Барилгын ХХЯ-ын

бууралтыг тооцох аргачлал” /БД25-101-20/, “Барилгын ХХЯ-ын бууралтыг бүртгэх журам”-ыг тус тус БХБС-ын 37 дугаар тушаалаар батлуулсан.

2. Барилгын салбарын ХХЯ-ын тооллогын цахим системийг бий болгосон.
<http://ghgconstruction.gov.mn/>

3. Тус яам болон Эрчим хүчний зохицуулах хорооны хооронд хүлэмжийн хийн тооллогын цахим системийг хамтран ажиллуулах тухай санамж бичгийг 2019.01.04-ний өдөр байгуулсан.

4. ХХЯ-ын суурь түвшинг тогтоох ажлын хүрээнд төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон 3000 гаруй барилгын эрчим хүчний хэрэглээнд үндэслэн, аргачлалын дагуу ХХЯ-ын суурь түвшнийг тогтоосон.

5. ЭХХ-тэй технологийн өртөг, үр нөлөөний тооцоог хийх ажлын хүрээнд технологийн өртөг, үр нөлөөг тооцох аргачлал, загвар боловсруулж, технологийн сонголт бүрээр өртөг үр нөлөөний шинжилгээний муруйг боловсруулан дүн шинжилгээ хийсэн. Бодлого боловсруулагч, технологи үйлдвэрлэгч, нэвтрүүлэгч болон хөрөнгө оруулагчдад танилцуулж, хэлэлцүүлсэн.

6. Барилгын эрчим хүчний үр ашгийг сайжруулах, эрчим хүчний хэмнэлт гаргах тал дээр бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч албан тушаалтнуудын чадавхийг сайжруулах чиглэлээр Словак улсын Братислав хотноо туршлага судлах хөтөлбөрт БХБЯ, ЭХЗХ, УБХЗАА, НҮБХХ, ДДНХБ, ОСНААУГ, НАМА төслөөс хамрагдан, Словак улсын орон сууц болон төрийн өмчит барилгын өнөөгийн нөхцөл байдал, хуучин барилгыг дулаалах, засвар үйлчилгээ эрхлэх хууль эрх зүйн орчин, барилгын шинэчлэл хийх, шинэчлэлийг санхүүжүүлэх арга замуудын талаар туршлага судалж ирсэн.

7. Төслийн хүрээнд дараах загвар төслүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд: Говь-Алтай аймгийн Жаргалан сумын сургуулийн дээврийн дулаалга, дотор халаалтын системийн шинэчлэлт, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын халаалтын системийн шинэчлэлт, Барилгын хөгжлийн төвийн лабораторийн барилгын засвар, Эрчим хүчний зохицуулах хорооны барилгын нарны цахилгаан үүсгүүр суурилуулах загвар төслүүд хэрэгжсэн. Энэхүү загвар төсөл хэрэгжсэнээр 153 сурагч, 36 багш ажилтан, нийт 189 хүн үр шимийг нь хүртсэн байна.

“Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд:

1. Төслийн зураг төсөл боловсруулах ажлыг БНХАУ-ын "Шанхай хотын инженерийн зураг төслийн институт" ХХК гүйцэтгэж, барилгын эх загвар зурагт 2019 оны 9-р сарын 12-ны өдрийн ЭЗ-5/2019 тоот магадлалын ерөнхий дүгнэлт гарсан.

2. Барилгын талбай дээр инженер геологийн судалгаа хийгдэж магадлалын ерөнхий дүгнэлтийн хүрээнд талбайн буурь хөрсний хяналтын №19/045 тоот акт гарсан.

3. Төслийн зураг төслийг боловсруулахад шаардагдах цахилгаан, дулаан, мэдээлэл холбооны техникийн нөхцлүүдийг авч зургийн компаниудад хүргүүлсэн.

4. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2019 оны 9-р сарын 27-ны өдөр авч, дараах ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд:

- 120м³/цаг-ийн хүчин чадалтай бетон зуурмаг үйлдвэрлэх узелийн угсралтын ажил 100%,

- төслийн түр барилгын ажил 70%,

- биологи цэвэрлэгээний талбайн хөрс хуулалтын ажил 50%,

- барилгын суурийн хөрс хуулалтын ажил 30%,

- хөрсний даацын хэмжилт болон ул хөрсний нягтруулалтын ажил хийгдэж биологи цэвэрлэгээний С хэсгийн нийт 800м³ М400 маркийн ул бетон цутгалтын ажил 5%.

5. Биологи цэвэрлэгээний байгууламжийн талбай дээр инженер геологийн судалгааны дагуу гүний усны түвшин доошлуулах 32 цооног өрөмдөж ул бетон цутгах бэлтгэл ажлыг ханган бетоныг хөлдөхөөс хамгаалах хучилтыг 10-р сарын 23-ны өдөр хийж талбайг өвлийн горимд оруулж хамгаалалт хийгдээд байна.

“Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1008 айлын орон сууцны хотхон” төслийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд:

1. Сүхбаатар дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэрт 3,8 га газарт баригдах 1008 айлын орон сууцны хорооллын ТЭЗҮ, ажлын иж бүрэн зураг төслийг боловсруулж, магадлалаар хянуулан батлуулсан.

2. Орон сууцны хорооллын ажлын зураг төсөл боловсруулахад шаардагдах цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, мэдээлэл холбооны техникийн нөхцлүүдийг холбогдох газруудаас авч, шугам сүлжээний зураг төслийг боловсруулан, хянуулан батлуулсан.

3. Төслийн ТЭЗҮ, ажлын иж бүрэн зураг төсөл, төсвийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн ажлын алба болон Төслийн менежментийн компанитай хэлэлцэн тохиролцож, 2019 оны 11 дүгээр сард эцэслэн хүлээлгэн өгсөн байна.

4. Төслийн барилгын ажлын бэлтгэл хангах төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, нийт 32 ажил тусгаснаас 20 ажил бүрэн биелсэн байна.

5. Барилгын түр байрны бетон суурийг цутгаж, түр ус хангамж, ариутгах татуургыг шийдвэрлэх хүрээнд цэвэр усны төв шугамаас огтолгоо авч 150 м шугам хоолой, төмөр бетон худаг барьж, бохирын 20 м3-ийн төмөр сав суулгасан.

6. Барилгажих талбай дээр байрлаж буй 37 айлын судалгааг хийж, 10 айлын газар чөлөөлөлтөд шаардагдах 2,0 тэрбум төгрөгийг 2020 оны улсын төсөвт тусгуулсан. 3 нэгж талбарыг чөлөөлөхөөр Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийн газар, төслийн нэгж, газар өмчлөгч иргэдийн хооронд “Газар чөлөөлөх 3 талт гэрээ” байгуулан, газар чөлөөлөлтийн ажил хийгдэж байна.

ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

2019 оны жилийн эцсийн байдлаар 2 хуулийн 3 заалт, Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт, Улсын Их Хурлын 4 тогтоолын 8 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2 тогтоолын 4 заалт, Засгийн газрын 36 тогтоолын 45 заалт, Ерөнхий сайдын 4 захирамжийн 6 заалт, Засгийн газрын хуралдааны 24 тэмдэглэлийн 38 заалт, Засгийн газрын 4 албан даалгаврын 9 заалт буюу нийт 77 шийдвэрийн 115 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан. Эдгээрээс бүрэн хэрэгжсэн буюу 100%-тай 95, хэрэгжих шатанд байгаа буюу 70%-ийн хэрэгжилттэй 13, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй 1, хугацаа болоогүй 4, хэрэгжээгүй 1 заалт байгаа бөгөөд хэрэгжилт **94,05 хувьтай** байна.

Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Барилга, хот байгуулалтын сайдад үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч ажилласан. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдалд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн яамны газар, хэлтсийн ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлт болгож байна.

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн

Үзүүлэлт	Бүгд	Үүнээс								
		Хууль	Ерөнхийлөгчийн зарлиг	УИХ-ын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын албан даалгавар	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	77	2	1	4	2	36	4	4	24	
Хяналтад авсан нийт заалтын тоо	115	3	2	8	4	45	6	9	38	
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100%	95	1	2	5	3	38	5	7	33
	Хэрэгжих шатанд 70%	13	2	-	1	-	6	1	1	3
	Хэрэгжилт хангалтгүй 30%	1	-	-	-	-	-	-	-	1
	Хэрэгжээгүй 0%	2	-	-	1	1	-	-	-	-
	Хугацаа болоогүй	4	-	-	1	-	1	-	1	1
	Хүчингүй болсон	-	-	-	-	-	-	-	-	-
Биелэлтийн дүн /хувь/	94,05%	80%	100%	81.4%	75%	95.9%	95%	96,2%	95,6	

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn

Үнэлгээний тайланг яамны Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01/128 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулав.

3.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2019 оны тайлант хугацаанд Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлаар 66 зорилтын хүрээнд 150 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Үүнээс Барилга хот байгуулалтын яам дангаараа хариуцан хэрэгжүүлэх 99, хамтарч хэрэгжүүлэх 51 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласан байна. Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар **94,5 хувьтай** байна.

Хүснэгт 1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний явцын үнэлгээ /2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Бодлогын чиглэл	Зорилтын тоо	Нийт арга хэмжээний тоо	Үүнээс				Хэрэгжилт /хувь/
				100%	70%	40%	Ү/Б	
1	Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого	3	4	4	-	-	-	100
2	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	26	83	63	12	1	7	86,5
3	Нийгмийн бодлого	13	27	19	5	-	3	83,3
4	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	6	10	5	3	1	1	75,0
5	Засаглалын бодлого	7	15	14	-	-	1	93,3
6	Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулах заалт	11	11	10	1	-	-	97,3
	Дүн	66	150	115	21	2	12	94,5
1	Үндсэн хэрэгжүүлэх	99	77	14	1	-	7	94,7
2	Хамтран хэрэгжүүлэх	51	38	7	1	-	5	94,1
	Дүн	150	115	21	2	-	12	94,5

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn

Үнэлгээний тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/375 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулав.

3.3 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний төлөвлөгөөг үндэслэн 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээний биелэлтийг ханган ажилласан байна. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлт жилийн эцсийн байдлаар **94,4 хувьтай** байна.

Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ /2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Бодлогын зорилт	Арга хэмжээ	Үүнээс биелэлт /хувиар/				Хувь
			100	70	40	Ү/Б	
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО							
Зорилт 4. Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний эрүүл ахуйн чанарыг сайжруулна.							
1	4.8. Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн парк байгуулах МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5-6, ЗГҮАХ-ийн 2.79 дэх заалт	1	-	-	-	1	Ү/Б
Зорилт 8. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангана.							
2	8.1. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах. МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5-6, ЗГҮАХ-ийн 2.79 дэх заалт	1	1	-	-	-	100
3	8.2. Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох. МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.81 дэх заалт	4	2	1	-	1	90
4	8.3. Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх. МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.85 дахь заалт	1	1	-	-	-	100
5	8.4. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих болон өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх. МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.91 дэх заалт	3	2	1	-	-	90
6	8.5. “Тайшир-Алтай” төслийг хэрэгжүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 2	1	1	-	-	-	100
7	8.6. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд инженерийн дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 6, 2.3.1. Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.96 дахь заалт	2	1	1	-	-	85

8	8.7. Гэр хороололд амины орон сууц барихад зориулж урт хугацааны хөнгөлөлттэй нөхцөлөөр ипотекийн зээл олгох. МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.76, 3.4.3 дахь заалт	2	2	-	-	-	100
9	8.8. Ган, төмөрлөг болон цементийн үйлдвэрлэлийг дэмжих, бизнесийн таатай орчныг бий болгох. МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.72.6 дахь заалт	1	1	-	-	-	100
Зорилт 14.Төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.							
10	14.5.Газрын төлөвлөлт, бүртгэл, бирж, үнэлгээ, мониторингийн нэгдсэн тогтолцоог бий болгох МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.80. 2.81 дэх заалт	2	2	-	-	-	100
ДҮН		18	13	3	-	2	94,4

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг 2020 оны 02 дүгээр сарын 28-ний өдрийн 01/750 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулав.

3.4 Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан Барилга, хот байгуулалтын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн нийт 18 үзүүлэлтийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн биелэлтэй байна.

Хүснэгт 1. Барилга, хот байгуулалтын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт /2019 оны жилийн эцэс/

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2016 он/	2019 он			Үнэлгээ /хувь/
			Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Өөрчлөлт	
1	Барилга байгууламжийн норм, дүрмийн тоо	477	508	511	3	100
2	Дотоодын үйлдвэрлэлээр хангах гол 45 нэр төрлийн барилгын материалын эзлэх хувь	60%	75%	80%	5%	100
3	Экспортод гарах барилгын материалд цементийн эзлэх хувь	10%	25%	-	-	Ү/Б
4	Импортыг орлох шинэ нэр төрлийн барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрийн тоо	45	53	55	2	100
5	Түрээсийн орон сууцны тоо	1512	2500	3102	602	100
6	Ипотекийн зээл авсан иргэдийн тоо	89000	101000	106178	5178	100
7	Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээний хэмжээ /км/ 100-500 мм голчтой	-	130	130	-	100
8	Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээний хэмжээ /км/ 100-600 мм голчтой	-	90	90	-	100
9	Шинээр барих цэвэрлэх байгууламжийн тоо	-	-	+5	+5	100
10	Газрын суурь үнийг шинэчилж, иргэд олон нийтэд нээлттэй ил тод болгох /%/	-	100%	100%	-	100
11	Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах ажлын гүйцэтгэлийн /%/	-	100%	100%	-	100
12	Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулах ажлын гүйцэтгэл /%/	-	100%	100%	-	100
13	Төрийн архив цахимжуулах ажлын гүйцэтгэл /%/	15%	73,6%	75%	1.4%	100
14	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах ажлын гүйцэтгэл %	-	60%	100%	40%	100
15	Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлын хэрэгжилт /%/	10%	100%	100%	-	100
16	Барилгын дулаан алдагдлын хэмжээг бууруулах /%/	-	3%	3%	-	100
17	Баталгаат ундны усаар хангагдсан байх хүн ам /%/	33%	70%	70%	-	100
18	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох хүн амын эзлэх хувь	27%	37%	37%	-	100
БИЕЛЭЛТ						100%

/Тайлбар: Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийг хавсаргав./

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1 Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн Ерөнхийлөн захирагч хянаж баталсан байна. Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 148 зорилтын 347 арга хэмжээг төлөвлөснөөс бодлогын баримт бичигт тусгагдсан 108 зорилтын хүрээнд 172 арга хэмжээг, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахаар 13 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг; хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэхээр 27 зорилтын хүрээнд 157 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилтийг тайлагнасан байна.

2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 100 хувийн хэрэгжилттэй-250 арга хэмжээ; 70 хувийн хэрэгжилттэй-73 арга хэмжээ; 30 хувийн хэрэгжилттэй-24 арга хэмжээтэйгээр **88,8 хувийн** гүйцэтгэлтэй үнэлэгдэж байна.

Зураг 1. БХБЯ-ны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /чиглэл тус бүрээр/



Мэдээллийн эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн Шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

Зураг 2. Нэгдүгээр хэсэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт



Мэдээллийн эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн Шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 1. Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн Шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ /Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилт арга хэмжээ тус бүрээр/.

Арга хэмжээ Д/д	Арга хэмжээ	Хэрэгжилт хувиар				Зорилтын хэрэгжилт /хувиар/
		100 хувь	70 хувь	30 хувь	0 хувь	
1. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ						
Гүйцэтгэлийн зорилт №1.1.1. Салбарын бодлого, үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн бодлогын зорилтуудтай нийцүүлэх, салбар хоорондын уялдааг хангах, салбарын хэмжээнд боловсруулж байгаа Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр, төслийг бодлогын удирдамжаар хангана.						
1.1.1.1	Салбарын бодлого, төлөвлөлтийг “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулинд нийцүүлэн боловсруулах	100	-	-	-	100 хувь
Гүйцэтгэлийн зорилт №1.1.2. Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт 2030-д туссан салбарын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.						
1.1.2.1	Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын дэд бүтэц, хот төлөвлөлт, барилга, ариун цэврийн байгууламжийн чиглэлийн үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлох	100	-	-	-	100 хувь
Гүйцэтгэлийн зорилт №1.1.3. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, урт хугацааны бодлогод салбарын саналыг тусгуулна.						
1.1.3.1	Монгол Улсын урт хугацааны бодлогыг шинээр боловсруулахад Үндэсний хөгжлийн газартай хамтран ажиллах.	100	-	-	-	100 хувь
Гүйцэтгэлийн зорилт №1.1.4. Төрөөс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлогод салбарын бодлогыг боловсруулан тусгуулна.						
1.1.4.1	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох стратеги боловсруулан хэрэгжүүлэх бодлогын хүрээнд байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх салбарын бодлогыг боловсруулах.	100	-	-	-	100 хувь
Гүйцэтгэлийн зорилт №1.1.5. Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх хүрээний асуудлыг тусгуулна.						
1.1.5.1	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх хүрээний асуудлыг тусгуулах арга хэмжээг зохион байгуулах	100	-	-	-	100 хувь
Гүйцэтгэлийн зорилт № 1.2.1. Салбарын суурь судалгаа, статистик тоон мэдээ, мэдээллийг буй болгох, салбарын албан ёсны статистик тоон мэдээ, мэдээллийг холбогдох газруудаас авч нэгтгэн, мэдээллийн сан үүсгэнэ.						
1.2.1.1	Салбарын суурь судалгаа, статистик тоон мэдээ, мэдээллийг цуглуулж өгөгдлийн сан үүсгэх.	100	-	-	-	100 хувь

Гүйцэтгэлийн зорилт № 1.2.2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төслийг бодлого, үйл ажиллагааны удирдамжаар хангана.					100 хувь
1.2.2.1	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх ажлыг ЗГХЭГ, ҮХГ-тай хамтран зохион байгуулах.	100	-	-	-
Гүйцэтгэлийн зорилт №1.2.3. Барилга, хот байгуулалтын салбарын бодлогын баримт бичгүүдийг уялдааг үнэлнэ.					100 хувь
1.2.3.1	Барилга, хот байгуулалтын салбарын бодлогын баримт бичгүүдэд Тогтвортой хөгжлийн зорилтуудын уялдааг үнэлэх ажлыг зохион байгуулах.	100	-	-	-
Гүйцэтгэлийн зорилт № 1.2.4. Үндэсний статистикийн хороогоор маягтын загварыг шинэчлэн батлуулна.					70 хувь
/Тайлбар: “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН төсөл”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

2. “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл МОН-3388”

Бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэ технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасч, орон нутгийн оршин суугчдын эрүүл ахуй, орчны стандартыг дээшлүүлэх зорилготой “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388” төсөл нь 2020 онд хэрэгжих бөгөөд дараах 2 зорилтын хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

Зорилт 1. Төслийн удирдлага, хэрэгжилтэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ;

Зорилт 2. Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралт.

Төслийн хэрэгжилтийн түвшин 2 зорилтын хүрээнд 74 хувь, 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт 91 хувьтай, “үр дүнтэй” хэрэгжсэн байна.

/Тайлбар: “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл МОН-3388”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

3. “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3713 төсөл”

Төслийн хүрээнд Булган, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн төвүүдэд био өнгөр тогтоогч бүхий идэвхжүүлэгч лагийн технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасч, орон нутгийн оршин суугчдын эрүүл ахуй, орчны стандартыг дээшлүүлэх зорилготой “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3713 төсөл” нь 2022 он хүртэл хэрэгжих бөгөөд дараах 2 зорилтын хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

Зорилт 1. Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ;

Зорилт 2. Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралт.

Төслийн 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт 90 хувь, “үр дүнтэй” хэрэгжсэн байна.

/Тайлбар: “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3713 төсөл”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав/

4. “Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл”

Улаанбаатар хотын агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах, VII, XIV хорооллыг барилгажуулах эхлэлийг тавих, VII хороолол, МҮОНРТ орчмын хорооллыг инженерийн дэд бүтцэд холбох, VII, МҮОНРТ-ийн хорооллын цахилгаан хангамжийг

сайжруулах зорилготой “Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл” нь 2010-2019 онд дараах 4 зорилтын хүрээнд хэрэгжсэн байна. Үүнд:

Зорилт 1. Улаанбаатар хотын VII, XIV хороололд нийт 2592 айлын орон сууц барих;

Зорилт 2. Орон сууцны VII хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх;

Зорилт 3. МҮОНРТ-ын орчмын хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх;

Зорилт 4. Улаанбаатар хотын VII хороолол, МҮОНРТ-ийн орчмын хорооллыг цахилгааны эх үүсвэрээр хангах 23,3 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам болон “Улаанбаатар” дэд станцын өргөтгөл, “7-р хороолол”, “Радио телевиз” дэд станцын угсралтын ажлыг гүйцэтгэх;

Төслийн хэрэгжилт 4 зорилтын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар **95 хувь**, “**үр дүнтэй**” хэрэгжсэн байна.

/Тайлбар: “Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

5. Бүгд Найрамдах Франц Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл”-төсөл

Бүгд Найрамдах Франц Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл”-төсөл 2020 он хүртэл хэрэгжих бөгөөд дараах 2 зорилтын хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

Зорилт 1. Цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, лагийг усгүйжүүлэх;

Зорилт 2. Цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн туршилт тохируулга, гадна тохижилт.

“Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл” төсөл нь хоногт 24000 м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай иж бүрэн цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулах зорилтын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар **97,5 хувь** “**үр дүнтэй**” хэрэгжсэн байна.

/Тайлбар: “Бүгд Найрамдах Франц Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

6. Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах, бохир усны төв цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга болон насос станцын үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэх, Дархан хотын ус сувгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл нь 2020 он дуустал хэрэгжих бөгөөд дараах 3 зорилтын хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

Зорилт 1. Цэвэрлэх байгууламжийг шинээр барих болон насос станц шинэчлэх;

- Зорилт 2. Дулааны болон бохирын шугам сүлжээг шинэчлэх;
- Зорилт 3. Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх.

Төслийн хэрэгжилтийн түвшин 75,6 хувь, 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт **80,6 хувь**, “тодорхой үр дүнд хүрсэн”, тухайн жилд тавьсан зорилгоо хангаж ажилласан байна.

/Тайлбар: “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

7. “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” төсөл

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг хөгжүүлэх, хэрэгжүүлэх замаар барилгын салбарын эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцлийг бий болгоход түлхэц үзүүлэх зорилготой “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” төсөл нь 2016-2019 онд хэрэгжих бөгөөд дараах 3 зорилтын хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

Зорилт 1. Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) тооцоо судалгааг хийх;

Зорилт 2. Барилгын салбарт ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааг бий болгох, хэрэгжүүлэх;

Зорилт 3. ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааны үр дүнг хэмжих, тайлагнах, нотлох (MRV) механизмыг бий болгох.

Төслийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар **80.2 хувь**, “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

/Тайлбар: “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ төсөл”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

8. “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”

Улаанбаатар хотод төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Монгол Улсын чанарын стандартыг хангасан хаягдал усыг байгальд нийлүүлэх, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл” нь 2023 он хүртэл хэрэгжих бөгөөд дараах 3 зорилтын хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

Зорилт 1. Зураг төсөл, барилга угсралтын ажил;

Зорилт 2. Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалт;

Зорилт 3. Сургалт, туршилт тохируулга, ашиглалтанд оруулах.

Төслийн 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **90 хувь**, “үр дүнтэй” хэрэгжсэн байна.

/Тайлбар: “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

9. “Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1008 айлын орон сууцны хотхон” төсөл

Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1008 айлын орон сууцны хотхоныг ил болон далд авто зогсоол, гадна дотор инженерийн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, дэд өртөөний хамт барих зорилготой “Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1008 айлын орон сууцны хотхон” төсөл нь 2023 он хүртэл хэрэгжих бөгөөд дараах 3 зорилтын хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

Зорилт 1. “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн Техник эдийн засгийн үзүүлэлт, зургийн даалгавар батлуулах, ажлын зураг төсөл, төсөв боловсруулах, Хятадын талтай нэг бүрчлэн санал солилцох, эцэслэн хүлээлгэж өгөх;

Зорилт 2. Барилгажих талбайн бэлтгэл ажлыг хангах, газар чөлөөлөх;

Зорилт 3. Төслийн ерөнхий гүйцэтгэгч компани сонгон шалгаруулах, Тендерийн баримт бичиг боловсруулах, Хятадын талтай санал солилцох, баримт бичигт тусгах.

Төслийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар **85 хувь**, “**тодорхой үр дүнд хүрсэн**” байна.

/Тайлбар: “Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1008 айлын орон сууцны хотхон”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

7.2 Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

1. “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах хөтөлбөр”

“Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр” нь Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд уг хөтөлбөр 2009-2014, 2015-2020 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжиж байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилт 4 зорилтын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар **88.0 хувьтай** байна.

/Тайлбар: “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав/

2. “Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр”

Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр нь Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 308 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд уг хөтөлбөрийг 2014-2020 онд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар **70.0 хувьтай** байна.

/Тайлбар: “Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

3. “Түрээсийн орон сууц хөтөлбөр”

“Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 248-р тогтоолоор батлан, хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 3 зорилтын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар **92.1 хувьтай** хэрэгжиж байна.

/Тайлбар: “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

4. “Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор тодотгон батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар **88.1 хувьтай** хэрэгжсэн байна.

/Тайлбар: “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

5. “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 202 дугаар тогтоолоор баталсан “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшин жилийн эцсийн байдлаар **15 хувьтай**, 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт **80 хувьтай**, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.

/Тайлбар: “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав./

НАЙМ. ДҮГНЭЛТ

Барилга, хот байгуулалтын яам нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ, УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төсвийн болон хөрөнгө оруулалтын зарцуулалтын үр дүн, салбарын үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангах зэрэг асуудалд өргөн хүрээтэй хандаж, 2019 онд төлөвлөсөн үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүллээ.

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг **93,8 хувь, ерөнхий үнэлгээг 4,7 оноогоор “сайн” дүнтэй** дүгнэв.

ЕС. ЗӨВЛӨМЖ

Бодлогын зорилтын хэрэгжилтийн талаар:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргахдаа тухайн зорилтын хүрээнд хийгдсэн ажил, явцын мэдээлэл, гарсан шийдвэр, хүрсэн үр дүнгийн түвшинг товч тодорхой, гүйцэд тайлагнах, тухайн тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн арга хэмжээний биелэлт гаргаж ирүүлэхэд нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд онцгой анхаарч ажиллах;

- Бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, ач холбогдолгүй болсон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүчингүй болгох санал боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх, төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулахдаа эдгээртэй холбоотой өмнө гарсан тогтоол, шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөлт оруулах асуудлыг давхар шийдвэрлэх;

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний арга хэмжээг тусгахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг үндэслэн салбарт баримталж буй урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэл зэрэгтэй уялдуулан, эдийн

засгийн тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, төлөвлөлтөө сайжруулан ажиллах; Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага анхаарч, санхүүжилтийг 2021 оны улсын төсөвт тусган шийдвэрлэж, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжоор хангах шаардлагатай байна.

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн талаар:

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа бусад бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний уялдааг хангах, гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход анхаарах;
- Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүдийг 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөмж болгож байна.

Байгууллагын нээлттэй байдлын талаар:

- Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр болон албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсанд байршуулан мэдээлж байх шаардлагатай байна.
- Тусгай зөвшөөрөл олгох, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг төрийн чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавихдаа эрх шилжүүлж авсан байгууллагын зөвхөн гэрээний хэрэгжилтийг дүгнэхээс гадна бодлогын дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээ, судалгаа, статистикийг тогтмол авч хэвших нь зүйтэй байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

(2019 он)

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	94.05	0.6	
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	94.5		
	3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	94.4		
	4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	100		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	88.8	0.2	4.7 /0.93/
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	100		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	98.8		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	73.2		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
Ерөнхий үнэлгээ:		93.8	1.0	

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.МАГНАЙСҮРЭН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Н.НАРАНТУЯА

АРАВ. ХАВСРАЛТ

10.1 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2016 он/	2019 он			
			Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Өөрчлөлт	Тайлбар
1.	Барилга байгууламжийн норм, дүрмийн тоо	477	508	398+113=511	3	<p>Өнөөдрийн байдлаар салбарын зураг төсөл, хайгуул, барилга угсралтын нийт 398 норм, дүрэм, заавар, цомог, аргачлалыг мөрдөж байгаа бөгөөд нийт норм, дүрмийн 93 хувийг өөрийн орны нөхцөлд тохируулан үндэсний норм болгоод байна.</p> <p>Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, нормативын баримт бичгийн жагсаалтыг шинэчлэх, баримт бичгүүдийн давхардлыг арилгах зорилгоор дараах өөрчлөлтүүд хийгдсэнтэй холбогдуулан барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн тоо өөрчлөгдсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ЗГ-ын тогтоол болон холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг тусад нь жагсаалтаар эмхэтгэл болгон гаргадаг болсонтой холбогдуулан жагсаалтаас хасагдсан. • Барилгын норм ба дүрэмд ОХУ-ын норм, нормативын баримт бичгүүд давхар мөрдөгддөг байсныг хасч зөвлөмжийн шинж чанартай баримт бичгээр дагаж мөрдөхөөр үлдээсэнтэй холбогдуулан суурь үзүүлэлт 364 болсон. <p>/Жагсаалтаас хасагдсан тоо: 113 ЗГ-ын тогтоол – 9, БНБД - 32, Альбом-50, СНиП -1, журам заавар – 21/ Засгийн газрын тогтоолоор дараах баримт бичгүүдийг батлуулав:</p> <ol style="list-style-type: none"> 1. "Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо"-г Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлуулсан. 2."Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам"-ыг Засгийн газрын 2019 оны 107 дугаар тогтоолоор батлуулсан. <p>Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2019 онд нийт 14 норм, нормативын баримт бичиг боловсруулж батлуулсан. Үүнд: барилгын норм ба дүрэм - 2, барилгын</p>

						<p>дүрэм - 8, альбом -1, үнийн индекс - 2, барилгын ажилчдын тарифт цалингийн жишиг тус тус баталсан.</p> <p>1. Барилга байгууламжийн төсвийн суурь нормыг хэрэглэх аргачлал” /БД 81-119-18/;</p> <p>2. Хот байгуулалтын кадастр /БД 14-01-19/;</p> <p>3. "Угсармал төмөр бетон том хавтгаалжин бүтээцийн хэсэглэлийн цомгийн бүрдэл"</p> <p>4. Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах, хэрэглэх дүрэм, Барилга байгууламжийн төсвийн суурь нормын технологийн карт</p> <p>5. Өндрийн III ба IV ангийн сүлжээ байгуулах барилгын дүрэм /БД 11-121-19/</p> <p>6. Геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулах ажил /БД 11-104-19/;</p> <p>7. Хийн хангамж /БНБД 42-01-04/2008/*2019/;</p> <p>8. Барилгын инженерийн шугам сүлжээний зураглалын ажил /БД 11-105-19/;</p> <p>9. Барилгын технологийн үйл ажиллагааны автоматжуулалт, технологийн үйл ажиллагааны автоматжуулалтын зураг төслийг боловсруулах /БД 43-106-19/;</p> <p>10. Барилга байгууламжийн цахилгаан төхөөрөмжийн газардуулгыг тооцоолох аргачлал /БД 43-106-19/;</p> <p>11. "Барилга байгууламжийн 2017 оны үнийн индекс";</p> <p>12. "Барилга байгууламжийн 2018 оны үнийн индекс";</p> <p>13. "Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" /БНБД11-07-19/;</p> <p>14. "Барилгын ажилтны тарифт цалингийн жишиг";</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
2.	Дотоодын үйлдвэрлэлээр хангах гол 45 нэр төрлийн барилгын материалын эзлэх хувь	60%	75%	80%	5%	<p>Монгол Улсын Засгийн газраас дотоодын барилгын материалын үйлдвэрүүдийг дэмжих, импортын гол нэрийн материал цемент, арматурын үнийг тогтворжуулах талаар тодорхой бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Барилгын гол нэр төрлийн материалын дотоод нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд "Барилгын материалын үйлдвэрийг дэмжих" хөтөлбөр хэрэгжүүлснээр шинээр 11 төрлийн үйлдвэр байгуулагдсан. Энэ зорилтын хүрээнд дулаан тусгаарлах материал, холбогч материал, цементийн үйлдвэрүүд технологио шинэчлэн бүтээгдэхүүнийхээ чанар, үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн цахилгаан утас, төмөр бетон хийцийн үйлдвэрүүд, хаалга цонх, чулуу бутлан ангилах үйлдвэр, ванн угаалтуур, хэв хашмалын үйлдвэр зэрэг шинэ дэвшилтэт технологийн үйлдвэрүүд ашиглалтанд ороод байна. Өнөөдрийн байдлаар барилгын материалын 700 гаруй жижиг дунд үйлдвэрүүд ажиллаж байна. Дотоодын барилгын материалын үйлдвэрийг ангилвал хаалга, цонхны үйлдвэр 380, керамик эдлэхүүний үйлдвэр 80, бетон зуурмагийн үйлдвэр</p>

						<p>144, хөнгөн бетоны үйлдвэр 30, дулаан тусгаарлах материалын үйлдвэр 16, полистрол, сендвич хавтангийн үйлдвэр 48, хуванцар хоолойн үйлдвэр 8, цементийн үйлдвэр 5 байгаа нь хаалга, цонх, бетон зуурмаг, тоосго, ханын дүүргэгч материалаар дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжтой болсон. Барилгын салбарыг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтын хүрээнд үндэсний үйлдвэрүүдийг дэмжин ажиллаж байгаа бөгөөд "150 мянган айл - Орон сууц" үндэсний хөтөлбөрийн хүрээнд барилга байгууламжийн ажилд хэрэглэгдэх 12 гол нэр төрлийн материалын эрэлт, нийлүүлэлтийн судалгаагаар арматур, чулуун хөвөн, хуванцар хоолой, түүний холбох хэрэгсэл, шохойноос бусдыг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангахаар байна. Иймд арматур, чулуун хөвөнгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх 2020 оны төлөвлөгөө гаргасан. Сүүлийн 3 жилд арматурын импорт нэмэгдсэн ч цемент, тоосго, хөнгөн блок, хаалга цонх, хуурай хольц /замаск, эмульс, чулуун будаг/-ны импорт эрс буурснаар импорт, үйлдвэрлэлийн харьцаа 20:80 хувьтай байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
3.	Экспортод гарах барилгын материалд цементийн эзлэх хувь	10%	25%	одоогоор экспортолж эхлээгүй.	-	<p>Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар цементийн хуурай аргын технологийн 4 үйлдвэр ашиглалтанд орж жилдээ нийт 4.5 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай болсон. Манай улсын дотоодын цементийн хэрэгцээ бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт ихтэй жилд 2.1 сая тонн гэсэн статистик мэдээлэл байдаг. Иймд цемент экспортлох бүрэн боломжтой.</p> <p>Монголд үйлдвэрлэсэн цементийг экспортлох хүрээнд БХБСайд Х.Баделхан дотоодын цемент үйлдвэрлэгчдийн удирдлагуудыг хүлээн авч санал хүсэлтийг сонслоо. Үйлдвэрийн удирдлагуудын хүсэлтээр Монгол Улс болон ОХУ-ын ЗГ хоорондын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ГХЯ-нд 2019 оны 05 сарын 09-ний өдрийн 01/1664 тоот албан бичгээр санал хүргүүлсэний дагуу Улаанбаатар хотод 2019 оны 05 сарын 28-30-ний хооронд зохион байгуулагдсан Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцүүлсэн. Мөн цементийн Евро стандартыг орчуулан нутагшуулах шаардлагатай болсон тул цемент үйлдвэрлэгч нартай хамтран ШУТИС-ийн багш нарын багийг ажиллуулж, цементийн турших аргын багц стандартыг боловсруулан СХЗГ-ын дэргэдэх Бетоны стандартын техникийн хорооны 3 удаагийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын турших аргын химийн шинжилгээний стандартуудыг шинээр боловсруулан Бетоны стандартын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Хятадын Стандартын байгууллага, СХЗГ-тай хамтран 2019 оны 12 дугаар сарын 2-4-ний хооронд холбогдох үйлдвэр, лаборатори, итгэмжлэлийн байгууллагуудад сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулсан.</p>

					<p>Монголд үйлдвэрлэсэн цементийг экспортлох бизнесийн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг бодлогоор дэмжин ажиллаж байна. Сүүлийн 5-6 жилийн хугацаанд Хөтөлийн “Цемент шохой” ХК, “МАК” ХХК, “Мон полимет” ХХК болон БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Мөнхийн баян гал” ХХК-ийн тус бүр 1.000.000 /нэг сая/ тонн/жил хүчин чадалтай үйлдвэрүүд ашиглалтад орж дотоодын зах зээлийн хэрэгцээнээс даруй 2 дахин их цемент үйлдвэрлэх хүчин чадал бий болсонтой холбогдуулан цементийг гадаадын зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах зорилтыг Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого” /2019-2029/, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 67 дугаар тушаалаар баталсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5.1.6-д “Цементийн үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүнийг экспортод гаргана” гэж тусгасан. Төрөөс баримтлах бодлогод цементийн экспортын хэмжээг нийт хүчин чадлын 20 хувьд хүргэхээр тусгаж, экспортын шаардлагыг хангахын тулд Евро стандарт (EN)-ыг үндэсний болгон батлуулах ажлыг 2019 онд хийж гүйцэтгэсэн. Цаашид цемент экспортлох чиглэлээр хил орчмын худалдаа, бартер, хамтарсан үйлдвэр, бизнесийн хөрөнгө оруулалт, Засгийн газар хоорондын хэлэлцээр, буцалтгүй тусламж зэрэг боломжтой бүх хэлбэрээр холбогдох улсуудад уламжлан, хамтран ажиллахыг хүссэн албан хүсэлтийг Гадаад хэргийн сайдад 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/610 тоотой хүргүүлсэн.</p> <p style="text-align: right;">Үнэлэх боломжгүй</p>	
4.	Импортыг орлох шинэ нэр төрлийн барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрийн тоо	45	53	55	2	<p>Барилга, хот байгуулалтын яамнаас дотоодын барилгын материалын үйлдвэрийг дэмжих бодлогыг авч хэрэгжүүлснээр импортын бараа материал буурч байна.</p> <p>Өнөөгийн байдлаар цементийн импорт 10 хүртэл хувь буурсан байна. Мөн импортыг орлох цахилгаан утас, арматур, ванн угаалтуур, гадна фасад, дулаалгын материалын үйлдвэрүүд байгуулагдан ашиглалтанд ороод байна.</p> <p>Сүүлийн 5 жилд 350 гаруй жижиг дунд үйлдвэр шинээр ашиглалтанд орсноор барилгад өргөн хэрэглэгддэг 40 гаруй нэр төрлийн материалын 70 хувийг дотооддоо үйлдвэрлэх боломжтой болсон. Материалын төрлөөр нь авч үзвэл цементийн хуурай аргын технологи бүхий иж бүрэн үйлдвэр 4, клинкер тээрэмдэх цех 3, уурхайн зуух бүхий шохойн үйлдвэр 2, бэлэн бетон зуурмагийн үйлдвэр 52, бетоны химийн нэмэлтийн үйлдвэр 9, бетон, төмөр бетон, угсармал байшин үйлдвэрлэх үйлдвэр 17, төрөл бүрийн дулаан тусгаарлах материалын болон сендвич хавтангийн 27 үйлдвэр, элс, хайрга, чулуу бутлан ангилах 23 үйлдвэр, барилгын төрөл бүрийн засал чимэглэл, интерьер, экстерьерийн чиглэлийн 15 үйлдвэр, автоклавын</p>

						<p>хөнгөн бетоны 11 үйлдвэр, ханын төрөл бүрийн гулдмай, хавтангийн 10 үйлдвэр, керамик тоосгоны 7 үйлдвэр, импортыг орлох, экспортын чиг баримжаатай 5 үйлдвэр, металл хийцийн 12 үйлдвэр, хуванцар цонх хаалга, түүний бэлдэцийн 68 үйлдвэр, хуванцар хоолой холбох хэрэгслийн 5 шинэ үйлдвэр тус тус ашиглалтанд орсон байна.</p> <p>Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооноос 2019 онд 45 аж ахуйн нэгж шинээр Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. Үүнд мяндас полимер арматур, зэс голтой кабел утас, өнгөлгөөний чулуун хавтан, хуурай, нойтон хольц /эмульс/, паркетан шал, OSB хавтан, гипс хавтан, гидратын шохой, чулуун обойн үйлдвэрүүд шинээр үйл ажиллагаагаа эхэлсэн байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
5.	Түрээсийн орон сууцны тоо	1512	2500	3102	602	<p>Иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар хангах бодлогын хүрээнд “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>Уг хөтөлбөрийн дагуу 2019 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Хөгжлийн банкны зээлээр Улаанбаатар хотод 1759, Архангай аймагт 120, Говь-Алтай аймагт 120, Дархан-Уул аймагт 152, Орхон аймагт 315, Ховд аймагт 116, Хөвсгөл аймагт 135, Хэнтий аймагт 130, Сэлэнгэ аймагт 102, Увс аймагт 105 айлын түрээсийн орон сууц, орон нутгийн санхүүжилтээр Төв аймагт 22 айлын орон сууц, Өмнөговь аймагт 26 айлын орон сууцыг түрээсийн санд нийт 3102 айлын төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санг тус тус бүрдүүлээд байгаа бол хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд 30,000 гаруй түрээсийн орон сууцны сан бүрдээд байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
6.	Ипотекийн зээл авсан иргэдийн тоо	89000	101000	106178	5178	<p>Монгол Улс 2017 оноос Олон улсын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсантай холбогдуулж Дэлхийн банкнаас ипотекийн зээлийн хөтөлбөрийг төсвийн шинжтэй санхүүжилт гэж үзэн Монголбанкыг уг зээлийн хөтөлбөрөөс гаргах, Засгийн газарт ипотекийн зээлийг шилжүүлэх шаардлага өгсөн боловч улсын төсвөөс энэхүү эрэлттэй зээлийн эх үүсвэрийг дангаар хариуцан үргэлжлүүлэхэд хүндрэлтэй тул уг асуудлаар Засгийн газар, Монголбанк, Олон улсын валютын сангийн төлөөллүүдтэй хэлэлцэж, Монголбанкнаас шинээр эх үүсвэр гаргалгүйгээр, өмнө олгосон зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс орж ирэх хөрөнгийг дахин гаргах, хүүгийн төлбөртэй тэнцэх хэмжээний хөрөнгийг Засгийн газраас гаргах, 2020 онд багтааж Монголбанкийг нэг мөр хөтөлбөрөөс гаргахаар шийдвэрлэсэн. Энэ ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • 2017 онд Улсын төсвөөс 111.0 тэрбум төгрөг, Монголбанкны олгосон зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс 294.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлж 6026 иргэнд жилийн 8 хувийн хүүтэй зээл;

						<ul style="list-style-type: none"> • 2018 онд Улсын төсвөөс 118.0 тэрбум төгрөг, Монголбанкны олгосон зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс 192.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлж 4676 иргэнд жилийн 8 хувийн хүүтэй зээлийг. • 2019 онд 112.0 тэрбум төгрөг, зээлийн эргэн төлөлтөөс Монголбанк 213.0 гаруй тэрбум төгрөг, арилжааны банкнаас 117.9 тэрбум төгрөг, нийт 443.3 тэрбум төгрөг зарцуулж 6476 зээлдэгчийг хамруулсан. <p>Иймд зээлийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагыг үндэслэн, эх үүсвэрийг нэмэгдүүлэх хувилбарыг боловсруулж Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж, тус хорооны 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолоор 2019 онд улсын төсөв болон зээлийн эргэн төлөлтөөс нийт 315.0 орчим тэрбум төгрөгийн хүүг бууруулж, хүүгийн зөрүүн дээр арилжааны банкуудын эх үүсвэрийг татан оролцуулж 500-600 тэрбум төгрөгийг иргэдэд жилийн 8 хувийн хүүтэй олгох боломжтой болсон.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
7.	Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээний хэмжээ /км/ 100-500 мм голчтой		130	130	-	<p>1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018- 2019 онд хэрэгжсэн “Нийслэл, аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт” багц ажлын хүрээнд 9 аймагт нийт 55 км цэвэр, 48 км бохир усны шугам баригдсан.</p> <p>2. Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд 147.2 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжихээр тусгагдсан ба аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинээр 2019 онд 112.0 тэрбум төгрөгийн нийт 96 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнээс 2019 онд 45 км цэвэр, 37 км бохир усны шугам баригдсан. 2019-2020 онд 25 км цэвэр, 35 км бохир усны шугамын барилга угсралтын ажил он дамжин хэрэгжихээр байна.</p> <p>3. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн “Тайшир–Алтай ус хангамж” төслийн хүрээнд 54 км цэвэр усны шугам хийгдэхээс 2019 онд цэвэр усны шугамын 25 км, дундын өргөх станцын барилга байгууламж, шугам, Алтай хот дахь 1000 м3 усан сангийн барилга угсралтын ажил хийгдсэн.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
8.	Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээний хэмжээ /км/ 100-600 мм голчтой		90	90	-	<p>1. Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт хоногт 20000 м3 бохир усыг цэвэрлэх байгууламжийг барьж, 2018 онд байнгын ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгсөн.</p> <p>2. БНФУ-ын зээлээр Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн хүрээнд хоногт 24000 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьсан.</p> <p>3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт хоногт 3200 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьсан.</p>
9.	Шинээр барих цэвэрлэх байгууламжийн тоо	-	-	+5	+5	

						<p>4. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн МОН 3388 төсөл"-ийн хүрээнд Архангай, Өмнөговь, Дорноговь, Өвөрхангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барьж байна. Эдгээрээс Өвөрхангай аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг 2018 онд, Архангай аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг 2019 онд байнгын ашиглалтад оруулсан.</p> <p>5. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт МОН 3713 төсөл" -ийн хүрээнд Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Сүхбаатар аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл арга хэмжээг 2019 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
10	Газрын суурь үнийг шинэчилж, иргэд олон нийтэд нээлттэй ил тод болгох /хувь/	-	100%	100%	-	<p>Газрын суурь үнэлгээ нь зөвхөн төлбөр авах зориулалттай бөгөөд зах зээлийн бодит байдалтай нийцэхгүй байх, газар зүйн байршил, газар ашиглалтын зориулалттай уялдаагүй байх зэргээс үүдэн газрын төлбөр, татвар, газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ, газрын нөхөх олговрын үнэ, бэлэглэх, барьцаалах, даатгуулах, газар ашиглалтын зөв оновчтой төлөвлөлтийг хийх, албан ёсны тайлан, мэдээ боловсруулах зэрэг үйл ажиллагаанд гарч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан газрын суурь үнэлгээг газрын үнэлгээний хэрэглээний олон төрөлд нийцүүлэн шинэчлэн тогтоож, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор батлуулан, улсын хэмжээнд мөрдөх ажлыг зохион байгуулж байна. Мөн Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болголоо. Газрын үнэлгээ, төлбөр, татварын нэгдсэн системийг байгуулж, тухайн системийг Татварын ерөнхий газартай холбон дундын мэдээллийн сан үүсгэн, иргэд олон нийтэд нээлттэй ил тод болгож, газар бүрт газрын төлбөр, татварыг тэгш шударга ногдуулах, газрын төлбөр төлөгчид банкны болон ebarimt аппликэйшн ашиглан газрын татвар, төлбөрөө төлөх боломж бүрдсэн.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
11	Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах	-	100%	100%	-	<p>Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулан ашиглаж байна. Газар зохион байгуулалтын мэдээллийн сан, програм хангамж, веб хуудас /www.egazar.gov.mn/ бүхий газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн нэгдсэн цахим системийг байгуулж, иргэд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх, хяналт тавих, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээлэл авах, өөрсдийн хэрэгцээнд нийцүүлэн сонгож газар эзэмших, ашиглах, өмчлөх түүнтэй холбоотой хүсэлтээ гаргах боломжтой болсон.</p>

	ажлын гүйцэтгэлийн хувь					Мөн газрын мэргэжлийн байгууллага болон бусад төрийн байгууллага уг системээр дамжуулан өөрсдийн салбарын орон зайн төлөвлөгөө боловсруулах боломж бүрдсэн. Биелэлт 100%
12	Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулах ажлын гүйцэтгэл /хувь/	-	100%	100%	-	Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын биржийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу газрын биржийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын уялдааг хангуулах үүрэг бүхий Газрын биржийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон "Газрын биржийн удирдах зөвлөлийн ажиллах журам"-ыг БХБСайдын 2017 оны 106 дугаар тушаалаар баталсан. Газрын цахим биржийн вэб хандалттай програм хангамж /www.mle.mn/-ийг улсын хэмжээнд 21 аймаг, нийслэл, 330 сум, 9 дүүрэгт нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэж, иргэд гар утас, таблет ашиглан холбогдож мэдээлэл авах, арилжаа, дуудлага худалдаанд оролцох, газар эзэмшүүлэх, өмчлүүлэх дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар ханган, эдийн засгийг эрчимжүүллээ. Газрын биржийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлснээр газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтанд компьютер, гар утас, таблет зэрэг төхөөрөмжүүдийг ашиглан хаанаас ч оролцох, олон шат дамжлагагүй, түргэн шуурхай үйлчилгээг авах боломжтой болсон. Биелэлт 100%
13	Төрийн архив цахимжуулах ажлын гүйцэтгэл /хувь/	15%	73,6%	75%	1,4%	БХБЯ-ны ТНБД-ын 2019 оны 05 сарын 27-ны А/82 дугаар тушаалаар "Баримт бичиг нягтлан шалгах комисс", мөн архивын баримт бичгийг цахимжуулах хуваарь гарган ажилласнаар Барилга, хот байгуулалтын яамны архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын гүйцэтгэл 75% хувьтай байна. 2019 оны 09 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулсан Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд явуулсан улсын үзлэгээр "Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, цахим сан бүрдүүлж буй ажлыг дүгнэж 92%-тай үнэлэгдсэн. Биелэлт 100%
14	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг	-	60%	100%	40%	Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулж бүрэн дууссан. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан 14500 цэг бүхий газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээ байгуулж, салбар хоорондын мэдээлэл солилцооны уялдааг хангасан вэбэд суурилсан цахим мэдээллийн системийг нэвтрүүлэн, газрын төлөв байдал, чанарын доройтол болон үүсгэгч хүчин зүйлийг богино

	байгуулах ажлын гүйцэтгэл /хувь/					хугацаанд тогтоож, түүнд тохирсон газрын харилцааны арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн. Биелэлт 100%
15	Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлын хэрэгжилт /хувь/	10%	100%	100%	-	21 аймаг, 330 сумын газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн засварлаж, техник, тоног төхөөрөмж, дэд бүтэц, нэгдсэн стандарт бүхий цахимжсан газрын кадастрын мэдээллийн санг улсын хэмжээнд байгуулаад байна. Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд бүрэн нэвтрүүллээ. Газрын кадастрын мэдээллийн санг ХУР, ДАН системтэй холбох ажил хийгдэж, иргэн, аж ахуйн нэгжүүд орон зай цаг хугацаанаас үл хамааран өөрийн газартай холбоотой буюу кадастрын зураг, гэрээ, гэрчилгээ, захирамж гэх мэдээллүүдийг QR кодоор баталгаажуулан цахимаар авах боломжтой болсон. Биелэлт 100%
16	Барилгын дулаан алдагдлын хэмжээг бууруулах /хувь/		3%	3%	-	1. Барилгын зураг төсөл боловсруулахад барилгын дулаан алдагдлын тооцоонд мөрдөгддөг “Барилгын дулаан хамгаалалт” /БНБД 23-02-09/ норм ба дүрэмд өөрчлөлт оруулах ажил хийгдэж байна. Энэ норм ба дүрэм батлагдаж мөрдөгдснөөр шинээр баригдах барилгын дулаан алдагдал 10 орчим хувиар буурна. Энэ норм ба дүрмийн өөрчлөлтийг 2020 оны I улиралд багтаан батлуулж мөрдүүлэхээр ажиллаж байна. 2. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн хөрөнгөнөөс 150,0 сая төгрөгөөр 5, 9, 12 давхар угсармал орон сууцны барилгын дулаан алдагдлыг бууруулах ажлын жишиг зураг төсөв боловсруулан магадлал хийлгэсэн. 3. “Улаанбаатар хотын орон сууцны барилгын 1077 блок барилгад дулаан техникийн шинэчлэл хийх төсөл”-ийг Үндэсний онцлогтой хүлэмжийн хийг бууруулах сан /НАМА/-д 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлсэн. Тус сангаас 18,0 сая хүртэлх еврогийн буцалтгүй тусламж авахаар /НАМА/-ийн 1, 2 дугаар шатны шалгаруулалтад тэнцсэн. Тус сангаас урьдчилсан суурь судалгааны ажилд зориулж 350,0 еврогийн санхүүжилт хийгдээд байна. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон барилгуудын дулаан хамгаалалт, халаалт, агаар сэлгэлт, хөргөлт, халуун усны тоног төхөөрөмжийн суурилагдсан үзүүлэлт хангагдаж байгаа эсэхэд хэмжилт, судалгаа хийж, хэрэглээний бодит үзүүлэлтийг тодорхойлох судалгааны ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар ашиглалтад орсон барилгуудын:

					<ul style="list-style-type: none"> • зураг төслийн шатанд төлөвлөсөн эрчим хүчний ачааллын тооцооны үзүүлэлт бодитоор эрчим хүчний тооцоолуур төхөөрөмжөөр тоолсон үзүүлэлт хоорондын хамаарлыг тогтоох; • төлөвлөлтийн болон бодит тоон үзүүлэлтийг зөрүү гарч байгаа шалтгааныг тогтоох, цаашид төлөвлөлт болон бодит хэрэглээний тоон үзүүлэлтүүдийг ойртуулах, төлөвлөлтөд нөлөөлөх хүчин зүйлүүдийг гаргаж ирэх, тооцоонд тусгах шаардлагатай болсон. <p>Иймд эхний ээлжид Улаанбаатар хотод баригдсан 62,911 барилгуудыг төлөөлөхүйц үндсэн 8 төрлийн зориулалтын 32 барилгад дулаан хамгаалалтын үзүүлэлт тодорхойлох судалгааг хийж дулааны эрчим хүчний тооцооны хэрэгцээ болон бодит хэрэглээ хоорондын хамаарлыг тодорхойлсон.</p> <ul style="list-style-type: none"> • “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт” /БНБД 23-01-09/-ийн сарын дундаж температур болон 2016, 2017, 2018 онуудын сарын дундаж температурын зөрөөнөөс 6.2%, дотоод дулааны нэгж ялгарлын сонголтоос 9.7%, барилгын ашиглалтаас хамаарсан ашиглалтын итгэлцүүрээс 19.1% тус тус нийтдээ 35% хүртэл нөлөөлж байна. <p>4. Төсвийн хөрөнгөөр Улаанбаатар хотын хэмжээнд дулаан алдагдал ихтэй угсармал барилгын гадна ханыг дулаалах, цонхыг дулаан алдагдал багатай цонхоор солих ажил хийгдэж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 24 орон сууцны барилгын гадна фасадад дулаалга хийгээд байна. Фасадад дулаалга хийхээс өмнө дулааны тоолуур тавьж дулаалга хийгээгүй байх үеийн дулаан алдагдлыг тодорхойлсон байгаа бөгөөд фасадны дулаалга хийсэн орон сууцны барилгуудад дулааны тоолуур суурилуулж дулаан алдагдлын хэмжээг тодорхойлох ажил хийгдэж байна. Энэ халаалтын улирал дуусах хүртэл хэмжилт хийгдэж түүний дараа дулаан алдагдал ямар хэмжээнд буурсныг тодорхойлох боломжтой болно. Мөн 2020 онд орон сууцны угсармал 22 барилгад фасадны дулаалга хийнэ.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>	
17	Баталгаат ундны усаар хангагдсан байх хүн ам /хувь/	33%	70%	70%	-	<p>2018 онд улсын төсвийн 348,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 21 аймгийн нийтийн аж ахуйн байгууллагуудад цэвэр, бохир усны шинжилгээний лабораторийн багаж, тоног төхөөрөмж ханган нийлүүлсэнээр хэрэглэгчид баталгаат ундны усаар хангагдах боломж бүрдсэн. Мөн АХБ-ны хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл”-ийн хүрээнд Сайншанд, Замын-Үүд, Даланзадгад, Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумдад 38,1 км цэвэр усны шугам барьж ашиглалтад оруулсан. “Нийслэл, аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт” багц ажлын хүрээнд 2018-2019 онд 9 аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэвэр усны 55 км шугам сүлжээг барьж ашиглалтад оруулсан.</p>

						<p>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн “Тайшир–Алтай ус хангамж” төслийн хүрээнд 54 км цэвэр усны шугам хийгдэхээс 2019 онд цэвэр усны шугамын 25 км, дундын өргөх станцын барилга байгууламж, шугам, Алтай хот дахь 1000 м3 усан сангийн барилга угсралтын ажил хийгдсэн. Дээрхи арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэний үр дүнд баталгаат ундны усаар хангагдсан хүн ам 70%-д хүрээд байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
18	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох хүн амын эзлэх хувь	27%	37%	37%	-	<p>Улсын хэмжээнд шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн үйлчилгээнд хамрагдсан хүн ам 41,1%-ийг эзэлж байна. Бохир ус татан зайлуулах шугамаас бохир усыг хүлээн авч цэвэрлэх цогц байгууламжид холбогдсон хүн ам 34%-ийг эзэлж байна. Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт хоногт 20000 м3 бохир усыг цэвэрлэх байгууламжийг барьж, 2018 онд байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.</p> <ul style="list-style-type: none"> - БНФУ-ын зээлээр Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн хүрээнд хоногт 24000 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьсан. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт хоногт 3200 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьсан. - АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн МОН 3388 төсөл”-ийн хүрээнд Архангай, Өмнөговь, Дорноговь, Өвөрхангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг эхлүүлсэн. Эдгээрээс Өвөрхангай аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг 2018 онд, Архангай аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг 2019 онд байнгын ашиглалтад оруулсан. Мөн энэ төслийн хүрээнд Арвайхээр хотын 1, 9, 10, 11-р хорооны гэр хорооллын 3 байрлалд 80 өрх болон Архангай аймгийн Цэцэрлэг хотын 1,2,3,4,5-р хорооны 80 өрхөд тус тус битүү доторлогоотой, суллах боломжтой сайжруулсан нүхэн жорлон барьж хүлээлгэн өгсөн. - АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт МОН 3713 төсөл” -ийн хүрээнд Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Сүхбаатар аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл арга хэмжээг 2019 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна. <p>Мөн</p> <p>1. “Нийслэл, аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт” багц ажлын хүрээнд 2018-2019 онд 9 аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэвэр усны 55 км, бохир усны 48 км шугам сүлжээг барьж ашиглалтад оруулсан.</p>

					<p>2. Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд 147.2 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжихээр тусгагдсан ба аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинээр 2019 онд 112.0 тэрбум төгрөгийн нийт 96 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнээс 2019 онд 45 км цэвэр, 37 км бохир усны шугам баригдсан. 2019-2020 онд 25 км цэвэр, 35 км бохир усны шугамын барилга угсралтын ажил он дамжин хэрэгжихээр байна.</p> <p>3. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн “Тайшир–Алтай ус хангамж” төслийн хүрээнд 54 км цэвэр усны шугам хийгдэхээс 2019 онд цэвэр усны шугамын 25 км, дундын өргөх станцын барилга байгууламж, шугам, Алтай хот дахь 1000 м3 усан сангийн барилга угсралтын ажил хийгдсэн.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>
	БИЕЛЭЛТ				100%

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

10.2 Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Үндсэн чиг үүрэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
1.	Салбарын бодлого, төлөвлөлт	36	37
2.	Хот байгуулалт, газрын харилцааны бодлого, төлөвлөлт	26	54
3.	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого, төлөвлөлт	27	31
4.	Нийтийн аж ахуйн бодлого, төлөвлөлт	15	24
5.	Инженерийн дэд бүтцийн бодлого, төлөвлөлт	3	24
Нийт		107	170

№	Стратеги төлөвлөгөө & Бодлогын баримт бичиг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030 /УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол/	7	16
2	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол/	84	
3	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /ЗГ-ын 2016 оны 121 дүгээр тогтоол/	84	167
4	"Гурван тулгуурт хөгжлийн бодлого" /ЗГ-ын 2018 оны 42 дугаар тогтоол/	5	17
5	Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль		160
6	Ногоон хөгжлийн бодлого /УИХ-2014 оны 43 дугаар тогтоол/	3	4
7	Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө/ЗГ-ын 2016 оны 35 дугаар тогтоол/	11	40
8	"Монгол Улсын Эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" /УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоол/	3	10
9	Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого /ЗГ-ын 2019 оны 70 дугаар тогтоол/	8	21
10	Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /БХБС-ын 2019 оны 67 дугаар тушаал/	8	106
11	"150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөр/ЗГ-ын 2019 оны 202 дугаар тогтоол/	4	37
12	"150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	4	97
13	Түрээсийн орон сууц хөтөлбөр /ЗГ-ын 2015 оны 248 дугаар тогтоол/	3	16
14	Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтын өргөжүүлэх хөтөлбөр /ЗГ-ын 2014 оны 308 дугаар тогтоол/	4	34
15	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр /ЗГ-ын 2017 оны 98 дугаар тогтоол/	3	16
16	Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /БОАЖС-ын 2017 оны А/107 дугаар тушаал		44
17	Газар хөдлөлтийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр /ЗГ-ын 2009 оны 157 дугаар тогтоол/	1	4
18	Барилгын салбарын Удирдах ажилтны зөвлөгөөн-2019-гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	7	43
19	Барилгын салбарын 2019-2020 оны Хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	5	41
20	БХБЯ-ны дэргэдэх Хөгжийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тоны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө		17
Нийт		307	890

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

1.САЛБАРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.1.1. Салбарын бодлого, үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн бодлогын зорилтуудтай нийцүүлэх, салбар хоорондын уялдааг хангах, салбарын хэмжээнд боловсруулж байгаа Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр, төслийг бодлогын удирдамжаар хангана.

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</i>									
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.1. Салбарын бодлого, төлөвлөлтийг “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулинд нийцүүлэн боловсруулах									
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	(ЗГҮАХХАХТ-5.6.4.1)								
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	7	8	9	10	11	12		
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>								
	<i>Суурь түвшин</i>	Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д туссан салбарын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон.								
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1. Батлуулах бодлогын баримт бичиг - 1 2. Санал өгөх бодлогын баримт бичиг - 1								
	<i>Хүрэх түвшин</i>	“Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ыг Тогтвортой, ногоон хөгжлийн үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн боловсруулж, батлуулна. Нийтийн аж ахуй, орон сууц, газрын харилцаа, геодези зураг зүйн талаар баримтлах бодлогын төслүүдэд санал боловсруулж өгөх.								
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”-ын холбогдох зорилтууд болон Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын 2019.02.03-ны өдрийн 70 дугаар тогтоолоор “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ыг батлуулсан. Сайдын 2019 оны 67 дугаар тушаалаар Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. 2019 оны 9 сард Орон сууц, нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлогын төсөлд “Тогтвортой хөгжлийн зорилт”-ын Зорилт 6, түүний шалгуур үзүүлэлт, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”-д нийцүүлэн санал боловсруулж /цаасаар/ бодлогын төслийн зөвлөх С.Чулуунхуяг, нарийн бичгийн дарга Д.Мөнхбаатар нарт өгсөн. Уг бодлогын төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн 6 хавсралтын бүрдлийг хангуулан эцэслэн боловсруулж дууссан бөгөөд яамдаас санал авахад бэлэн болсон.								
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>								
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт - 100% <ul style="list-style-type: none"> - Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогын баримт бичиг – 1 - “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө – 1 - Санал өгсөн бодлогын баримт бичиг /Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого/ - 1 								
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>										

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.1.2. Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт 2030-д туссан салбарын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.2.1. Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын дэд бүтэц, хот төлөвлөлт, барилга, ариун цэврийн байгууламжийн чиглэлийн үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлох					
	Төлөвлөлтийн уялдаа:	(ЗГҮАХХАХТ-5.6.4.1.)				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар			11	12
	Шаардагдах хөрөнгө	Үйл ажиллагаагаар				
	Суурь түвшин	2-р улиралд: Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгын Дэд бүтэц, барилга, ариун цэврийн байгууламжийн шалгуур үзүүлэлт, үндэсний зорилтот түвшин тодорхойлох дэд ажлын хэсгийн төлөвлөгөө гарган ажиллаж, ажлын хэсгээс гаргах 24 шалгуур үзүүлэлтийн мэдээллийг гарган явцын тайланг Үндэсний хөгжлийн газарт 5 дугаар сарын 02-ны өдрийн 04/1577 тоотор, эцсийн тайланг 5 дугаар сарын 27-нд цахимаар хүргүүлэв.				
	Шалгуур үзүүлэлт	Дэд бүтцийн салбарын 24 шалгуур үзүүлэлт				
	Хүрэх түвшин	3-р улиралд: Үндэсний хөгжлийн газраас өгсөн чиглэлийн дагуу 24 шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинийг тооцоолсон тооцоолол, аргачлал, эдгээрийг боловсруулахад тулгарч буй сорилт бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан ҮХГ-т хүргүүлнэ. 4-р улиралд: Ажлын хэсгээс гаргасан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, ажлын үр дүнг Үндэсний хэлэлцүүлэгт тайлагнан хэлэлцүүлнэ.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>-ЗГХЭГ-ын даргын 2019.03.18-ны өдрийн 29 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар “Дэд бүтэц, хот төлөвлөлт, барилга, ариун цэврийн байгууламжийн чиглэлийн зорилт /3, 5, 6, 7, 9, 11, 12, 17/-ын үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлох үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ыг баталж, даргаар Төрийн нарийн бичгийн дарга, дэд даргаар БТГ-ын дарга, нарийн бичгийн даргаар БТГ-ын ахлах мэргэжилтэн нар тус тус томиологдсон.</p> <p>-Тус Дэд ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, ажлын хэсгээс гаргах 24 шалгуур үзүүлэлтийн мэдээллийг нэгтгэн гаргаж явцын тайланг Үндэсний хөгжлийн газарт 5 дугаар сарын 02-ны өдрийн 04/1577 тоотор, эцсийн тайланг 5 дугаар сарын 27-нд цахимаар хүргүүлэв.</p> <p>-Үндэсний хөгжлийн газраас өгсөн чиглэлийн дагуу 24 шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинийг тооцоолсон тооцоолол, аргачлал, эдгээрийг боловсруулахад тулгарч буй сорилт бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан 2019 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 03/3373 тоот албан бичгээр ҮХГ-т хүргүүлсэн.</p> <p>-Үндэсний хөгжлийн газраас нэгтгэн ирүүлсэн “Тогтвортой хөгжлийн зорилтын үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинийг нэгтгэлтэй танилцаад Барилга, хот байгуулалтын салбарын мэдээллийг нягтлан холбогдох газруудаас санал авч нэгтгэн 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 03/3735 тоотор хүргүүлсэн.</p> <p>-Ажлын хэсгээс гаргасан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, ажлын үр дүнг 2019 оны 9 дүгээр сард “Холидэй инн” зочид буудалд зохион байгуулсан Үндэсний хэлэлцүүлэгт БТГ-ын дарга бөгөөд ажлын хэсгийн дэд дарга тайлагнан хэлэлцүүлсэн. Үндэсний хэлэлцүүлэгээс гарсан санал зөвлөмжийн дагуу дахин тодотгол хийж, 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 03/3998 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт мэдээллийг хүргүүлсэн.</p> <p>-Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилтуудыг үндэсний бодлого, хөтөлбөр боловсруулах үйл явцад уялдуулан тусгах арга</p>				

		хэрэгсэл /tool/-ийг боловсруулах батлуулахтай холбоотой хэлэлцүүлэгт 10 дугаар сарын 11-ний өдөр оролцож, санал өгсөн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт - 100% -Дэд бүтэц, хот төлөвлөлт, барилга, ариун цэврийн байгууламжийн чиглэлийн зорилтын 24 үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин -Үндэсний хэлэлцүүлэг -1.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.1.3. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, урт хугацааны бодлогод салбарын саналыг тусгуулна.

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.3.1. Монгол Улсын урт хугацааны бодлогыг шинээр боловсруулахад Үндэсний хөгжлийн газартай хамтран ажиллах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	(ЗГҮАХХАХТ 2.79.4), (Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.3)						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>		7	8	9	10	11	12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>						
	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд: Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт мэргэжил, аргагүйн дэмжлэг үзүүлэх, салбарын чиглэлээр бодлогын санал боловсруулах Ажлын хэсгийг Сайдын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 99 дүгээр тушаалаар, дэд Ажлын хэсгүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/88 дугаар тушаалаар тус тус байгуулан мэдээллийг Үндэсний хөгжлийн газарт 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 03/2119 тоотор хүргүүлэв.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1. "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020-2045"-д тусгах салбарын бодлогын төсөл 2. "Бүсчилсэн хөгжлийн бодлого"-д тусгах салбарын бодлогын төсөл						
	<i>Хүрэх түвшин</i>	3-р улиралд: "Монгол Улсын урт хугацааны бодлого 2020-2045 он"-д тусгах салбарын бодлогын төслийг холбогдох талуудыг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулан хэлэлцүүлж, Үндэсний хөгжлийн газар, Засгийн газарт хүргүүлнэ. 4-р улиралд: Салбарын бодлогыг "Монгол Улсын урт хугацааны бодлого 2020-2045 он"-д тусгах талаар Ерөнхий сайдын 52 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг, Үндэсний хөгжлийн газар болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.						
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 52 дугаар захирамжийн дагуу "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" боловсруулах ажлыг ЗГХЭГ хариуцан зохион байгуулж ажиллаж байна. Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт мэргэжил, аргагүйн дэмжлэг үзүүлэх, салбарын чиглэлээр бодлогын санал боловсруулах ажлын хэсгийг Сайдын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 99 дүгээр тушаалаар, дэд ажлын хэсгүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/88 дугаар тушаалаар тус тус байгуулан мэдээллийг Үндэсний хөгжлийн газарт 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 03/2119 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үндсэн болон дэд ажлын хэсгээс боловсруулсан төслийг нэгтгэн 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 03/2772 тоот албан бичгээр ҮХГ-т хүргүүлж, шаардлагатай мэдээллээр ЗГХЭГ-аас байгуулсан ажлын хэсгийг ханган ажилласан. "Монгол						

		<p>Улсын урт хугацааны бодлого 2020-2045 он"-д салбарын бодлогыг тусгах чиглэлээр Ерөнхий сайдын 2019 оны 52 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Үндэсний хөгжлийн газар болон холбогдох байгууллагуудтай тогтмол харилцан мэдээлэл солилцож, хамтран ажилласан.</p> <p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019.07.10-ны өдрийн 65 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс "Монгол Улсын урт хугацааны бодлого 2020-2045 он"-ыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийн төсөл болгож өөрчлөн эхний хувилбарыг боловсруулж 2019.11.22-ны өдрийн ХЭГ/3280 тоот албан бичгээр санал авахаар тус яаманд ирүүлсэн. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн "Алсын хараа-2050" бодлогын баримт бичиг нь 9 логик хүрээ, I (2021-2030), II(2031-2040), III (2041-2050) гэсэн гурван үе шаттай бөгөөд үе шат тус бүрд зорилт дэвшүүлж, зорилт тус бүрийн хүрэх үр дүн, тухайн үр дүнд хүрэхийн тулд хийгдэх үйл ажиллагаа гэсэн бүтэцтэй болж шинэчлэн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус яамнаас хариуцсан салбарын зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагааг 2050 он хүртэл буюу 30 жилийн хугацаатай шинэ загварт нийцүүлэн дахин шинэчлэн боловсруулсан. Уг бодлогын баримт бичгийн төслийн "Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын логик хүрээ", "Эдийн засаг зорилгын логик хүрээ", "Сайн засаглал зорилгын логик хүрээ", "Ногоон хөгжил зорилгын логик хүрээ", "Нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжил" гэсэн 5 логик хүрээнд барилга, хот байгуулалтын салбарын бодлогын асуудлуудыг шинээр болон шинэчилэн тусгуулахаар саналыг бэлтгэж, 2019.11.22-ны өдрийн 03/4411 тоот албан бичгээр болон цахим шуудангаар ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Бүсчилсэн хөгжлийн бодлогын чиглэлээр "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийн төслийн "Нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжил" логик хүрээний "Байгаль, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зүй тогтлын дагуу хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутаг, хот суурин газрын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хөгжүүлнэ" гэсэн зорилгын хүрээнд "Тогтвортой хөгжлийн зорилтод тулгуурласан Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж хэрэгжүүлэх" зорилтыг дэвшүүлж, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ХБГХБХЗГ-аас авч нэгтгэн 2019.11.22-ны өдрийн 03/4411 тоот албан бичгээр болон цахим шуудангаар ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт 100% <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын урт хугацааны хөгжлийн "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийн төслийн эхний хувилбар – 1 - "Бүсчилсэн хөгжлийн бодлого"-д тусгах салбарын бодлогын саналын төсөл – 1
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.1.4. Төрөөс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлогод салбарын бодлогыг боловсруулан тусгуулна.

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.4.1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох стратеги боловсруулан хэрэгжүүлэх бодлогын хүрээнд байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх салбарын бодлогыг боловсруулах.					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	("Ногоон хөгжлийн бодлого"-ын Стратегийн зорилт Нэг.) (ЗГҮАХХАХТ-ний 4.1.5.)				
	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>				11 12

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Шаардагдах хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>
	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд: Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 91 дүгээр тушаалаар байгуулсан.
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах салбарын бодлого, төлөвлөгөөний төсөл – 2 баримт бичиг, 6 хавсралт (Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмын дагуу)
	<i>Хүрэх түвшин</i>	3-р улиралд: Салбарын бодлогын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч, талуудын уулзалтаар хэлэлцүүлэн БОАЖЯ-нд хүргүүлсэн байна. 4-р улиралд: Барилга, хот байгуулалтын салбарын бодлого, зорилтыг “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого” (Засгийн газраар батлах үндэсний бодлого) болон “Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичиг” (НҮБ-аас дэмжих олон улсын баримт бичиг)-т тусгуулсан байна.
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсэг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 91 дүгээр тушаалаар байгуулагдсан. Барилга, хот байгуулалтын салбарын бодлого, зорилтыг “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого” (Засгийн газраар батлах үндэсний бодлого) болон “Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичиг” (НҮБ-аас дэмжих олон улсын баримт бичиг)-т тусгуулахаар 1 зорилго, 4 зорилт, 9 үйл ажиллагааны чиглэл, 45 арга хэмжээний төлөвлөгөө бүхий бодлого боловсруулан холбогдох 6 хавсралтын хамт БОАЖЯ-ны Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. Мөн тус ажлын хэсгээс бусад яам, салбарын бодлогыг нэгтгэн ирүүлсэн төсөлтэй танилцаж, санал бэлтгэн БОАЖЯ-нд 2019 оны 10-р сарын 23-ны өдрийн 01/3983 тоотор хүргүүлэв. “Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичиг” оруулах салбарын бодлого боловсруулсан. Уг баримт бичиг Засгийн газрын тогтоолоор батлагдах шийдвэр гарсан. Тогтоолын төсөл албажих шатандаа байна./ БХБЯ-наас боловсруулсан барилгын салбарын бодлогын төлөвлөгөөг тусад нь гаргаж хэрэгжүүлэхээр Ажлын хэсэг шийдвэрлэсэн тул энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд Барилгын салбараас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Action plan боловсруулах НҮБ-ын 540.000\$-ийн гэрээнд 2019 оны 10 дугаар сард БХБ-ын сайд Х.Баделхан гарын үсэг зурсан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт 90% – “Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр” (INDC) бодлогын баримт бичиг - 1 – Салбарын бодлогыг хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөөний төсөл – 1 – Бодлого, төлөвлөгөө боловсруулах гэрээ - 1
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.1.5. Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх хүрээний асуудлыг тусгуулна.

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</i>
----------	--

Арга хэмжээний нэр, дугаар	1.1.5.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх хүрээний асуудлыг тусгуулах арга хэмжээ зохион байгуулах							
	Төлөвлөлтийн уялдаа:	(МУ-ын ЗГ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэг), (Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх хэсэг), (Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл)						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	7	8	9	10		
	Шаардагдах хөрөнгө	Үйл ажиллагаагаар						
	Суурь түвшин	2-р улиралд: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/44 дугаар тушаалаар батлуулсан. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах салбарын саналыг боловсруулж Сангийн Сайдад 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/717 тоотор хүргүүлсэн.						
	Шалгуур үзүүлэлт	1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөө 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн санал						
	Хүрэх түвшин	4-р улиралд: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, 2020 оны үндсэн чиглэлийн төлөвлөлттэй уялдуулах санал боловсруулна.						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/44 дугаар тушаалаар батлуулсан. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах салбарын саналыг боловсруулж Сангийн Сайдад 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/717 тоотор хүргүүлсэн. УИХ-ын 2015 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 54 дүгээр тогтоолын хавсралтаар "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" батлагдсан бөгөөд тус бодлогын баримт бичигт БХБЯ-аас хэрэгжүүлэх 14 зорилт, арга хэмжээ туссан.						
	Зарцуулсан хөрөнгө	Үйл ажиллагаагаар						
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт 100% - Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөө - 1 - Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл - 1						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ								

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.2.1. Салбарын суурь судалгаа, статистик тоон мэдээ, мэдээллийг буй болгох, салбарын албан ёсны статистик тоон мэдээ, мэдээллийг холбогдох газруудаас авч нэгтгэн, мэдээллийн сан үүсгэнэ.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	1.2.1.1. Салбарын суурь судалгаа, статистик тоон мэдээ, мэдээллийг цуглуулж өгөгдлийн сан үүсгэх.							
	Төлөвлөлтийн уялдаа:	(Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 1.2.4), (Статистикийн хууль)						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа		7	8	9	10	11	12
	Шаардагдах хөрөнгө	Үйл ажиллагаагаар						

	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд: Барилгын салбарын голлох үзүүлэлтүүдээр сүүлийн 10 жилийн статистик мэдээг нэгтгэн гаргасан. Мөн Газрын нэгдмэл сангийн 10 жилийн тайланг нэгтгэсэн.
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	<ul style="list-style-type: none"> - Барилгын салбарын статистик мэдээний 33 маягт - Газрын нэгдмэл сангийн тайлангийн хүснэгт - 9
	<i>Хүрэх түвшин</i>	<p>3-р улиралд: Сүүлийн 10 жилийн тайлангуудаар өгөгдлийн сан үүсгэсэн.</p> <p>4-р улиралд: 10 жилийн тайлан мэдээнд үндэслэн эрх бүхий албан тушаалтан, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажилласан.</p>
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын статистик мэдээллийн нэгтгэсэн. Газрын харилцааны салбарын 2009-2019 оны 10 жилийн статистик мэдээг нэгтгэн гаргаж архив үүсгээд байна.</p> <p>Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн мэдээллийн сангийн чиглэл, өгөгдлийн сангийн төрөл, өгөгдлийн сангийн ангилал, хамрах хүрээ, өгөгдлийн төрөл, өгөгдлийн өргөтгөлөөр нь ангилан ялгасан.</p> <p>Барилгын салбарын албан ёсны статистик, тоон мэдээллийг 2019 оны гуравдугаар улирлын байдлаар нэгтгэн гаргасан.</p> <p>ГЗБГЗЗГ болон БХТ-д байршиж буй мэдээллийн сангууд тэдгээрийн өгөгдлийн мэдээг авч нэгтгэн гаргасан, мөн энэ талаарх судалгааг Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн хүрээнд хэрэгжиж буй “Салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх” төсөлд хүргүүлсэн.</p> <p>Барилга, хот байгуулалтын салбарын өнөөгийн байдал, өмнөх 25 жил болон ирээдүйн 25 жилийн бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэн ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэд 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр салбарын статистик мэдээллийн талаар танилцуулга бэлтгэн өгсөн.</p> <p>Мөн НҮБ-н Үндэсний илтгэлд барилгын салбарын статистик мэдээг бэлтгэн өгсөн.</p> <p>Үндэсний статистикийн хороо, ГЗБГЗЗГ-тай хамтран Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын Газрын харилцааны салбарын статистик мэдээг гарган ҮХГ-т цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>“Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан”-ийг шинэчлэн хөгжүүлж, ашиглалтад оруулж байгаатай холбогдуулан яамны албан хаагчдад системийн хөгжүүлэлтийг хийж байгаа БХТ-ийн мэргэжилтнээр системийн танилцуулга хийж, санал солилцсон. Мөн уг системд холбогдох саналуудыг БТГ болон бусад газруудаас авч нэгтгэн 2019 оны 3/4174 тоот албан бичгээр БХТ-д хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шинээр хийгдсэн 4 мэдээллийн системийг уг системд нэмэх, холбогдох хөгжүүлэлт, хяналтыг тавих, - Барилгын салбарын инженер, техникийн ажилтан болон мэргэжилтэй ажилчдын эрэлт, нийлүүлэлтийн судалгааны тайлан. - Барилгын салбарын ажилтнуудыг бэлтгэж буй их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын мэдээлэл. - Барилгын салбарын статистик судалгаа, мэдээлэл/бүтэн жил, хагас жил, улирал, сараар/. - Барилга, хот байгуулалтын салбарт “Жендерийн талаар баримтлах бодлого (2018-2025)-ын судалгаа, мэдээлэл. - Барилга, хот байгуулалтын салбарт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг хангах чиглэл”-ээр хийгдэж буй үйл ажиллагааны судалгаа, мэдээлэл. - Орон сууцны хөнгөлөлттэй ипотекийн зээлийн судалгаа, мэдээлэл. - Мэдээллийн сангийн хөгжүүлэлт болон төрийн үйлчилгээнд нэгтгэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд: - Уг мэдээллийн системийн баяжилт, ашиглалтын журмыг боловсруулж, батлуулах;

		<ul style="list-style-type: none"> - Үндэсний дата төв дээр байрлаж буй "Хур" Төрийн мэдээлэл солилцооны системд барилгын салбарын холбогдох сервисийг оруулах; - Мэдээллийн системийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор баазуудыг 2 болон түүнээс дээш байршилд хадгалах; - Барилгын салбарын тоон болон статистик мэдээллийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хэрэгжүүлж буй "Төрийн нэгдсэн мэдээллийн сан" цахим хуудсанд байршуулах.
	Зарцуулсан хөрөнгө	Үйл ажиллагаагаар
	Хүрсэн түвшин	Тухай бүрийн мэдээлэл Хэрэгжилт 100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.2.2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төслийг бодлого, үйл ажиллагааны удирдамжаар хангана.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	1.2.2.1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх ажлыг ЗГХЭГ, ҮХГ-тай хамтран зохион байгуулах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	(Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль), (Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 1.2.2)						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа		7	8	9	10	11	12
	Шаардагдах хөрөнгө	Үйл ажиллагаагаар						
	Суурь түвшин	2-р улиралд: 2 удаа төслийн платформ хөгжүүлэлтийн танилцуулга хуралд суусан. Журмын төсөлд санал өгсөн.						
	Шалгуур үзүүлэлт	Холбогдох журмын төсөлд санал өгсөн байна. Саналын тоо - 1						
	Хүрэх түвшин	3-р улиралд: ТУЗөвлөлийн хүрээнд холбогдох хуралд сууж салбарын чиглэлээр саналыг хүргүүлсэн. 4-р улиралд: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн систем хөгжүүлэх ажилд саналыг хүргүүлсэн.						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>-ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэнгээр ахлуулсан "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төсөл"-ийн Удирдах хорооны гишүүнээр ажиллаж, шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажиллаа. Энэхүү хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан бий болсноор хөгжлийн бодлого төлөвлөгчдөд дэмжлэг үзүүлэх мэдээллийн нэгдсэн цогц сан бүхий web-д суурилсан платформ бий болж бодлого боловсруулагчид болон олон нийт мэдээллийн санг ашиглаж нэгдсэн мэдээллээр хангагдах, Хөгжлийн бодлогыг удирдах, хянах тогтолцоо боловсронгуй болгох юм.</p> <p>-Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын Засгийн газарт үзүүлэх буцалтгүй тусламжийн хүрээнд "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх" төслийг 2 жилийн хугацаанд Үндэсний хөгжлийн газарт хэрэгжүүлсэн бөгөөд тус системийг хөгжүүлэх төслийн анхан шатны танилцуулгад 2019 оны 02 дугаар сарын 22, явцын танилцуулгад 04 дүгээр сарын 10-ны өдөр оролцож холбогдох саналуудыг өгсөн. Төсөл амжилттай хэрэгжиж 2019.12.05-ны өдөр хаалтаа хийсэн /Гүйцэтгэгч: "Айтүүлс" ХК/.</p> <p>Энэхүү мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан цаашид хөгжлийн бодлого, төлөвлөлтийг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд технологийн дэвшилтэд шийдлээр оновчтой, уялдаатай боловсруулаад зогсохгүй, бодлогын баримт бичгийн уялдааг сайжруулснаар төсвийн хувиарлалтыг үндэслэлтэй, үр дүнтэй хийх боломж бүрдсэн. Түүнчлэн систем</p>						

		<p>хэрэглээнд нэвтэрснээр хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой мэдээллийг иргэдэд ойлгомжтой байдлаар хүргэх, бодлогын баримт бичиг боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн хэрэгцээ шаардлагыг бодлого боловсруулагч нар цахимаар хүлээн авах, цаашлаад гадаадын хөрөнгө оруулагч нарт үнэн, бодит мэдээлэл хүргэх зэрэг олон давуу тал үүсч байгаа юм. www.development.gov.mn</p> <p>Мөн ЗГХЭГ-аас ирүүлсэн “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сангийн журам”-д 2019 оны 01/1780 тоот албан бичгээр санал өгсөн.</p> <p>“Нэг маягийн загвар зураг” цахимжуулж байгаатай холбогдуулан Үндэсний хөгжлийн газраас холбогдох газрын дарга, мэргэжилтэнг урьж, яамны албан хаагчдад 12 дугаар сарын 06-ны өдрийн “Мэдээллийн цаг”-аар системийн талаар танилцуулга хийж, санал солилцсон. Мөн яамны удирдлагуудтай уг системийн санхүүжилт, хэрэгжилтийн талаар уулзалтыг зохион байгуулсан. Системийг 2020 оны 1 сард багтаан ашиглалтад оруулахаар шийдвэрлэж, ҮХГ-тай хамтран ажиллаж байна.</p>
	Зарцуулсан хөрөнгө	Үйл ажиллагаагаар
	Хүрсэн түвшин	<p>Хэрэгжилт 100%</p> <ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем www.development.gov.mn - 1 - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сангийн журам - Саналын тоо 1
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.2.3.Барилга, хот байгуулалтын салбарын бодлогын баримт бичгүүдийг уялдааг үнэлнэ.

Төлөвлөлтийн уялдаа: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.2.3.1. Барилга, хот байгуулалтын салбарын бодлогын баримт бичгүүдэдТогтвортой хөгжлийн зорилтуудын уялдааг үнэлэх ажлыг зохион байгуулах.					
	Төлөвлөлтийн уялдаа:	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нээж	Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Баярбат				
	Суурь түвшин	Барилга, хот байгуулалтын салбарын УИХ болон ЗГ-аар батлагдсан 10 бодлогын баримт бичиг.				
	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ хийх баримт бичгийн тоо -10 Ажлын хэсгийн дүгнэлт -1				
	Хүрэх түвшин	<p>Эхний хагас жилд: ҮХГ-ын даргын 2019 оны А/29 тоот тушаалаар батлагдсан “Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын уялдаа холбооны үнэлгээ хийх заавар, хүснэгт”-ийн дагуу үнэлж ҮХГ-рт хүргүүлсэн байна.</p> <p>Жилийн эцэст:</p>				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 ны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 1.1 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын уялдаа холбооны үнэлгээ хийх” үүрэг бүхий ажлын хэсгийг тус яамны Төрийн нарийн				

		бичгийн даргын 2019 оны А-29 дүгээр тушаалаар байгуулан ажилласан. –“Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын уялдаа холбоонд үнэлгээ хийх заавар, хүснэгт”-ийн дагуу тус салбарын бодлогын баримт бичгүүд /11 бодлогын баримт бичиг/-ийн уялдааг үнэлж, ажлын хэсгийн санал, дүгнэлтийн хамт Үндэсний хөгжлийн газарт 2019 оны 02/1568 тоот албан бичгээр хүргүүлсэн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	
	<i>Хүрсэн түвшин</i>	Үнэлгээ хийх баримт бичгийн тоо -11 Ажлын хэсгийн дүгнэлт -1
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.2.4. Үндэсний статистикийн хороогоор маягтын загварыг шинэчлэн батлуулна.

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</i>						
Арга хэмжээний нэр, дугаар	1.2.4.1. Үндэсний статистикийн хороогоо зөвшөөрснөөр Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар барилгын салбарын статистикийн маягтын загварын шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулах.						
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	(Статистикийн тухай хууль), (Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 1.2.4)					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	7	8	9	10	11	12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Үйл ажиллагаагаар					
	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд: 2009 онд батлагдсан салбарын статистикийн маягтуудыг анхдагч мэдээллийн 11, нэгтгэсэн 9 хүснэгт болгон цөөлж боловсруулсан.					
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Шинэчлэн батлуулсан маягтын тоо -11					
	<i>Хүрэх түвшин</i>	3-р улиралд: Салбарын статистикийн маягтуудыг анхдагч мэдээллийн 11, нэгтгэсэн 9 хүснэгт загварыг шинэчлэн боловсруулж холбогдох газруудаас саналыг авч, Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулна. 4-р улиралд: Салбарын статистикийн маягтуудыг шинэчлэн боловсруулж БХБСайд, ҮСХорооны даргын хамтарсан тушаалаар батлуулна.					
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 105 дугаар тушаалаар батлагдсан салбарын статистик мэдээ гаргах 33 маягтын загварыг шинэчлэн, анхдагч мэдээллийн 11 маягт болгон боловсруулж, холбогдох газруудаас саналыг авч Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 173 дугаар тушаалаар батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яаманд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01/4170 албан тоотой хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2019 оны 11 дүгээр сарын 19-ний 1/1-5149 албан тоотой Үндэсний статистикийн хороотой хамтран баталж, хянуулах нь зүйтэй гэсэн хариуг ирүүлсэн. Үүний дагуу Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалын төсөл болон бүртгэл мэдээллийн маягт, нөхөх зааврын төслийг боловсруулж санал авахаар 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 03/4428 албан тоотой Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Үндэсний статистикийн хорооноос 2019 оны 12 дугаар сарын 02-ны 01/1160 албан тоотой тушаалын төсөлд санал хүргүүлсэн. Ирүүлсэн саналыг тушаалын төсөлд тусган, Хуулийн хэлтсээр хянуулан, тушаалын төслийг батлуулахаар Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн					

		хорооны даргын хамтарсан тушаалаар 2019 оны 12 дугаар сард багтаан батлуулахаар тогтсон. Анхдагч маягт -11
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт 100% - Сайдын болон хамтарсан тушаал -1 - Барилгын салбарын бүртгэл мэдээллийн маягт - 11
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.2.5. Дээд шатны эрх бүхий байгууллагыг барилга, хот байгуулалтын салбартай холбоотой судалгаа мэдээллээр хангах, салбарын суурь мэдээлэл буй болгох чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.2.5.1. Барилга, хот байгуулалтын салбартай холбоотой судалгаа мэдээллийг нэгтгэх, өгөгдлийн сан үүсгэх, холбогдох газруудыг мэдээллээр хангах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	(Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль), (Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 1.2.5)						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>		7	8	9	10	11	12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>						
	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд: 2019 оны хагас жилийн байдлаар ЗГХЭГ-т салбарын мэдээллийг хүргүүлсэн.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хүргүүлэх мэдээллийн тоо -2						
	<i>Хүрэх түвшин</i>	3-р улиралд: Холбогдох бусад байгууллагад салбарын мэдээллийг хүргүүлсэн. 4-р улиралд: Салбарын жилийн эцсийн статистик, тоон мэдээллийг ЗГХЭГ-азарт хүргүүлсэн байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<ul style="list-style-type: none"> - ЗГХЭГ-т салбарын албан ёсны статистик тоон мэдээллийг гарган 2019 оны 03/3326 тоот албан бичгээр хүргүүлсэн. - ЗГХЭГ-т салбарт хэрэгжүүлсэн томоохон 10 ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цахим шуудангаар хүргүүлсэн. - “Барилгын ажилтны удирдах ажилтны зөвлөгөөн”-ий УИХ-ын даргын мэндчилгээг бэлтгэн УИХ-ын тамгын газарт хүргүүлсэн. - “Барилгын ажилтны удирдах ажилтны зөвлөгөөн”-ий Ерөнхий сайдын илгээлтийг бэлтгэн ЗГХЭГ болон Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлсэн. - “Барилгын ажилтны удирдах ажилтны зөвлөгөөн”-тэй холбоотойгоор хэвлэлийн мэдээг бэлтгэн хэвлэлийн төлөөлөгчид хүргүүлсэн болно. - УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд БХБЯ-ны 01 дүгээр улирал, 2019 оны эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн томоохон ажлуудын тайланг хүргүүлсэн. - ЗГХЭГ-т ЗГҮАХ-ийн хэрэгжилт, яамны эрхлэх асуудалтай холбоотойтой мэдээ, тайланг шуурхай хүргүүлэн ажиллаж байна. - ҮСГ, ГЗБГЗЗГ-тай хамтран Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгын Газрын харилцааны салбарын статистик мэдээг гарган ҮХГ-т хүргүүлсэн. - Засгийн газрын тогтоолоор батлагддаг Монгол Улсад нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр /мэргэжил/-ийн жагсаалтад Барилгын салбарын инженер техникийн ажилтнууд болон мэргэжилтэнг нэмж тусгах саналыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/2151 тоот албан бичгээр хүргүүлсэн. - ЗГХЭГ-аас тус яамны Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг үнэлээд хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн 25 						

		<p>ажлын тайлан тайлбарыг ЗГХЭГ-т 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 03/2189 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Үндэсний статистикийн хороо болон Статистикийн хөгжлийн төлөөх түншлэл /Парис21/-ийн хүрээнд зохион байгуулагдсан Статистикийг дэмжих улс орны тайланд барилгын салбарын мэдээллийг тусгахаар санал өгсөн. - Үндэсний статистикийн хороонд “Статистикийг дэмжих тухай улс орны асуулгын хуудас”-ыг маягтын дагуу гарган 2019 оны 03/2815 тоот албан бичгээр хүргүүлсэн. - Эрчим хүчний яамны харьяа “Диспетчерийн үндэсний төв”-д салбарын цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэлтийн талаарх мэдээллийг гарган хүргүүлсэн. - ХНХЯ-нд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд салбарын хэмжээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх дараах мэдээллийг 2019 оны 03/4255 тоот албан бичгээр хүргүүлсэн. - Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн телевизийн “Тулга тав” студи-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлигийн дагуу Барилга, хот байгуулалтын яам болон харьяа байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг батлагдсан бүтэц, орон тоонд нийцүүлэн ажиллуулж буй талаарх мэдээллийг 2019 оны 04/4380 тоот албан бичгээр хүргүүлсэн. - Үндэсний статистикийн хороотой хамтран барилгын салбарын статистикийн мэдээний тухай, тооцох арга зүй, мэдээллийн сан, түүний хэрэглээ, ашиглалтын талаарх сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Сургалтанд Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвийн нийт 20 албан хаагч хамрагдсан.
	Зарцуулсан хөрөнгө	Үйл ажиллагаагаар
	Хүрсэн түвшин	<p>Хэрэгжилт 100%</p> <ul style="list-style-type: none"> - ЗГХЭГ-т хүргүүлсэн албан мэдээллийн тоо – 4 - ҮСХ-нд хүргүүлсэн албан баримт бичгийн тоо – 2 - Бусад байгууллагуудад хүргүүлсэн албан баримт бичгийн тоо – 9 - Зохион байгуулсан сургалтын тоо - 1
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.3.1. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх, түрээсийн орон сууцыг өмчлөх боломжтой иргэдэд өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	<p>1.3.1.1. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд түрээсийн орон сууцны санг 1000 айлын орон сууцаар нэмэгдүүлэх.</p> <p>1.3.1.2. “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам” боловсруулж, батлуулах.</p> <p>1.3.1.3. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжаар орон сууц барих ажлыг зохион байгуулах.</p>							
	Төлөвлөлтийн уялдаа:	(МУЗГҮАХ-ын 3.4.3.4)						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар		8	9	10	11	12
	Шаардагдах хөрөнгө	109.0 тэрбум төгрөг						
	Суурь түвшин	<p>2-р улиралд: Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоолоор 1542 айлын орон сууцны барилгыг түрээсийн орон сууцны санд шилжүүлж авах талаар Нийслэл, Говь-Алтай, Хөвсгөл, Орхон аймгуудын Засаг дарга нарт чиглэл өгсөн.</p> <p>“Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх” журмын төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор баталсан.</p>						

	<i>Шалгуур үзүүлэлт</i>	<ul style="list-style-type: none"> - Журам - 1 - Засгийн газрын тогтоолоор түрээсийн орон сууцыг нэмэгдүүлэх - Гадаадын зээл, тусламжаар түрээсийн орон сууц барих ажлыг зохион байгуулах
	<i>Хүрэх түвшин</i>	<p>3-р улиралд: Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллана.</p> <p>4-р улиралд: Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллана.</p>
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Засгийн газрын “Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 81 дүгээр тогтоолоор МУ-ын Хөгжлийн банканд шилжүүлсэн 1542 айлын орон сууцны барилгыг түрээсийн орон сууцны санд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 6 дүгээр сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолоор батлуулсан. Тус тогтоолоор Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын орон нутгийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийн бүртгэн оруулах ажлыг зохион байгуулж эхлэхэд бэлэн болсон.</p> <p>Мөн ЗГ-ын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд төр, орон нутаг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд түрээсийн орон сууцны санг бүрдүүлэхээр заасан тул “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ын төслийг боловсруулж 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын 138 дугаар тогтоолоор батлуулсанаар зах зээлд түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэнд өмчлүүлэхээр хэрэгжиж буй 3457 айлын орон сууц байгаас 2387 айлын орон сууцанд иргэдийг хамруулсан. Үл хөдлөх зуучлалын цахим мэдээллийн санд 390 айлын хөлслүүлэх судалгаа байна. Эндээс харахад “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 5389 айлын орон сууц бэлэн болоод байна.</p> <p>Мөн БНСУ-ын Засгийн газраас манай улсын агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг орон сууцжуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохиролцсоны дагуу Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд “Солонго 1”, “Солонго 2”, Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороонд “Баянголын ам” орон сууцны 7000 айлын орон сууцнуудыг барихаар төлөвлөсөн. БХБЯ “Солонго 1”, “Солонго 2” орон сууцны хороолол барих төслийг хариуцан хэрэгжүүлж байна. Дээрх төслүүдийн ТЭЗҮ-ийн судалгааг боловсруулах төслийн багийг БНСУ-ын “Экспорт-Импорт” банкнаас томилсон. Уг төслийн багтай 2019 оны 6 дугаар сараас эхлэн нийт 5 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, 13 удаа цахим шуудангаар мэдээлэл солилцсоны үндсэн дээр дээрх төслүүдийн ТЭЗҮ-ийн судалгааг боловсруулж, 2019.04.05-06-ны ТЭЗҮ-ийн судалгааны эцсийн шатны тайлангийн танилцуулгыг хийж, холбогдох саналуудыг тусгасан.</p> <p>БНСУ-ын Экспорт-Импорт банкны Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан /EDCF/-ийн Үнэлгээний ажлын хэсэг, Сангийн яам, “ТОСК” ТӨХХК-тай хамтран “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих” төслийн зээлийн гэрээнд тусгах “Хэлэлцээрийн тэмдэглэл”-ийг эцэслэн боловсруулж, 2019.11.28-ний өдөр албажуулан, талууд гарын үсэг зурж баталгаажуулсан. 2020 оны 1 дүгээр сард багтаан Зээлийн хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна.</p> <p>2019 оны 7 дугаар сард “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт БХБЯ-ын ТНБД, БНХАУ-ын Буцалтгүй тусламжийн албаны дарга нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Тус ажлын хүрээнд “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн барилга угсралтын ажлын бэлтгэл хангах төлөвлөгөө /2019-2020/-н ТНБД-аар 2019 оны 7 дугаар сард батлуулсан. Төслийн барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Интеллект тауер” ХХК шалгаран ажиллаж байгаа бөгөөд 2019.11.01-нд зураг төслийг боловсруулан батлуулж, эх хувь материалыг хүлээлгэн өгсөн. Барилгын зураг төслийн дагуу барилгын ажлын гүйцэтгэчийн сонгон шалгаруулах Тендерийн баримт бичгийг боловсруулах</p>

		ажлыг Төсөл хэрэгжүүлэх нэгж хариуцан гүйцэтгэж байна. Барилгын ажил 2020 онд эхэлнэ.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	0.00
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт - 100% 1. Батлуулсан баримт бичгийн тоо - 2; - "Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам" - ЗГ-ын 2019.04.10-ны өдрийн 138 дугаар тогтоол; - "Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай" ЗГ-ын 2019.06.05-ны өдрийн 223 дугаар тогтоол. 2. 2019 онд түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн орон сууны тоо - 1542 айл; 3. Гадаадын зээл, тусламжаар баригдах түрээсийн орон сууцны тоо - 8008 айл; - БНСУ-ын хөнгөллтэй зээлээр - 7000 айлын орон сууц - БНХАУ-ын буцалтгүй тусламжаар - 1008 айлын орон сууц
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.3.2. Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг эрчимжүүлнэ.

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	1.3.2.1. Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгох ажлыг зохион байгуулах.					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	(ЗГҮАХХАХТ-2.85)				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	7	8		12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>				
	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд: Монгол Улсын Хөгжлийн банкнаас Хятадын экспорт, даатгалын зээлийн корпорацитай Хамтын ажиллагааны гэрээг 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр байгуулав.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	БНХАУ-аас зээл авах ажлыг зохион байгуулна.				
	<i>Хүрэх түвшин</i>	3-р улиралд: Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжүүлэгчдийн ажлыг эрэмблэх ажлыг нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулна. 4-р улиралд: Зээл олгох төсөл хэрэгжүүлэгчдийн жагсаалт болон шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлно.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн хангамж, шугам, сүлжээний ажлын хөрөнгө оруулалтыг БНХАУ-аас олгож буй 2.0 тэрбум юаны буцалтгүй тусламжаар шийвэрлэх талаар болон хийж гүйцэтгэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 179 дүгээр тогтоолоор батлуулсан. 2018 онд Эхний ээлжийн 600.0 сая юаныг 2018 онд авах байсан боловч тус эх үүсвэрээс "Хилийн боомт болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын салбар"-т хэрэгжиж буй "Гаалийн хяналт шалгалтад шаардлагатай тоног төхөөрөмж"-ийн хөрөнгө оруулалтад зарцуулагдахаар болсон. Иймд эх үүсвэрийн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан хэрэгжүүлэх арга, хэмжээний жагсаалтыг өөрчлөх зорилгоор Барилга, хот байгуулалтын сайд 2019 оны 35 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулж Барилга, хот байгуулалтын дэд сайдаар ахлуулаад байна. Уг ажлын хэсгийг 2 удаа хуралдуулж, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг эцсийн байдлаар боловсруулж, санхүүжилтийн хувиарыг эцэслэн 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 01/2082 тоот албан бичгээр Сангийн яаманд				

		<p>хүргүүлсэн. Хэрэв энэхүү төсөл арга хэмжээ хэрэгжсэн нөхцөлд БНХАУ-ын талаас МУХБ-аар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох боломжтой талаар МУХБ-д мэдэгдсэн. Энэ хүрээнд дээрх ажлын хэсгээс ГХДТ-ын гүйцэтгэгч нарын ажлын гүйцэтгэлд шинжилгээ хийж, төслийг хэрэгжүүлсэн байдлаар эрэмблэн, зээлийн шаардлага хангасан нөхцөлд зээл олгох боломжтой аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг хүргүүлсэн.</p> <p>Мөн Монгол Улсын Хөгжлийн банкнаас Хятадын экспорт, даатгалын зээлийн корпорацитай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах ажлыг хамтран зохион байгуулж, 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан. Ингэснээр БНХАУ-ын Хөгжлийн банкнаас даатгалын Корпорациар дамжуулан МУХБ-д зээл олгох боломж бүрдсэн. Энэ ажлын хүрээнд МУХБ-наас гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд загвар төсөл хэрэгжүүлэх үүднээс ЧД-ын 9, 10 дугаар хороо, “Дэнжийн 1000” орчмын “Б” хэсэгчилсэн талбайд төсөл хэрэгжүүлэгч “Бармон” ХХК-д 10.0 тэрбум төгрөгийн зээлийн олгосон.</p> <p>2019 оны 8 дугаар сард МУХБ-ны удирдлага солигдсонтой холбоотойгоор хариуцаж байсан албан тушаалтан байхгүйгээс болж энэхүү ажил нь удаашралтай явагдаж байна.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>
	<i>Хүрсэн түвшин</i>	<p>Хэрэгжилт - 80%</p> <ul style="list-style-type: none"> - БНХАУ-аас олгох санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний саналыг боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн. - МУ-ын Хөгжлийн банк, Хятадын экспорт, даатгалын зээлийн корпорацитай хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулсан. - Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч “Бармон” ХХК-д хөнгөлөлттэй зээл олгосон.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.3.3. “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	<p>1.3.3.1. “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>1.3.3.2. АХБ-аас Сангийн яамтай хамтран хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах төслийн 2 дугаар ээлжийн хэрэгжүүлэх арга хэмжээний төсөлд санал өгөх.</p>							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	ЗГ-ын 2017 оны 98 дугаар тогтоол, Агаар орчныг бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /БОАЖС-ын 2017 оны А/107 дугаар тушаал/						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	7	8	9	10	11	12	
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	<i>Үйл ажиллагаагаар</i>						
	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд: Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын дэд сайд бөгөөд агаар орчны бохирдлыг бууруулах дэд хорооны даргаар батлуулсан. АХБ-ны төслийн саналд санал хүргүүлсэн.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1. Тайлан 2. Санал						
	<i>Хүрэх түвшин</i>	3-р улиралд: АОББҮХ-ний төлөвлөгөөний биелэлтийг боловсруулж хүргүүлнэ. 4-р улиралд: АХБ-ны төслийг Сангийн яамаар батлуулна.						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан төсөл арга хэмжээнээс 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд тус яамнаас хэрэгжүүлэх арга хэмжээг тусгуулахаар хүргүүлсэн. Түүнчлэн Барилга, хот байгуулалтын						

		<p>сайдын 2018 оны 15 дугаар тушаалаар байгуулсан дэд хороог хуралдуулж хорооны зүгээс 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг дэд сайдаар батлуулсан. Энэ ажлын хүрээнд барилга нийт 17 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс 2019 оны хагас жилийн байдлаар 5 төсөл 100 биелэсэн 8 төсөл хувиарын дагуу хэрэгжилтийн явцтай байгаа бол 4 төсөл арга хэмжээ удаашралтай хэрэгжиж байна. Тайланг эцсийн байдлаар нэгтгэж, хуваарийн дагуу 2020 оны 1 дүгээр сард Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлнэ.</p> <p>Мөн АХБ-ны Зүүн азийн газрын Байгаль орчин, Байгалийн нөөц, Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн дарга Omar Shariff B. Belisario-тай 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдөр, 9 сарын 6-ны өдрүүдэд уулзаж "Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах" төслийн 2 дугаар үе шатны бодлогын матрицад санал тусгуулсан бөгөөд Гэрээний саналтай танилцаж 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01/4460 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.</p> <p>Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр БНСУ-ын Засгийн газраас Монгол Улсад олгох хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр тохиролцсон "Солонго 1, 2" 7000 айлын орон сууц барих төслийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлж эхлүүлэхээр холбогдох ажлуудыг зохион байгуулж, хариуцан хэрэгжүүлж байна. Төслийн зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийн төслийг холбогдох газруудтай хамтран боловсруулж, БНСУ-ын Экспорт-Импорт банканд хүргүүлж, батлуулахаар ажиллаж байна.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	
	<i>Хүрсэн түвшин</i>	<p>Хэрэгжилт - 100%</p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөө баталсан. - Тайлан хүргүүлсэн. - АХБ-ны төсөлд санал тусгуулсан. - АХБ-тай байгуулах зээлийн хэлэлцээрт санал хүргүүлсэн. - "Солонго 1, 2" орон сууцны хороолол барих төслийн зээлийн хэлэлцээрийн төсөл – 1
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.3.4. “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ын хэрэгжилтийг хангуулна.

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</i>						
Арга хэмжээний нэр, дугаар	1.3.4.1. “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ын хэрэгжилтийг хангуулах, арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлэх .						
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	(ЗГ-ын 2018 оны 369 дүгээр тогтоол)					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	7	8	9	10	11	12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	460.0 тэрбум төгрөг					
	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд: Монголбанк, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалаар Санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулсан.					
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Мэдээлэл					
	<i>Хүрэх түвшин</i>	3-р улиралд: мэдээллийг тухай бүрт гаргана. 4-р улиралд: мэдээллийг тухай бүрт гаргана.					
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2019 оны 11 сарын байдлаар нийт 380 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 5,566 иргэнд олгоод байна. Үүнээс Монголбанкны эх үүсвэрээс 175.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2,513 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,616 иргэнд, банкуудын өөрийн эх үүсвэрээс 104 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,437 иргэнд тус тус олгосон. 2019 онд гүйцэт					

Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн-нэмэлт санхүүжилт L3388- МОН” төсөл, “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын 7, 14, МҮОНТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл”-ийн 2019 оны үйл, ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр Төслийн удирдах хороог хуралдуулж шийдвэр, тогтоол гарган төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажилласан. 2019 оны 4-р улирлын байдлаар “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн 100 хувь, төслийн санхүүжилтийн төлөвлөгөө 82%, худалдан авалтын төлөвлөгөөг 99.2% хувьтай биелэгдсэн. “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн-нэмэлт санхүүжилт L3388- МОН” төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө 100%, төслийн санхүүжилтийн төлөвлөгөө 95%, худалдан авалтын төлөвлөгөөг 100% биелэлттэй байна. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн 100 хувь, төслийн санхүүжилтийн төлөвлөгөөний хэрэгжилтийн 90%-ийн биелэлттэй байна. Төслийн хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор ТУХ-ийг 11 сарын 25-нд хуралдуулж, холбогдон гарсан шийдвэрийг СЯ-нд 03/4400 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн төслийн нэгжийн үйл ажиллагаа энэ онд дуусч байгаатай холбогдуулан санхүүжилтийн хугацааны асуудлаар барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч “БСИЖМН” ХХК-ийн төлөөлөлтэй яамны удирдлагууд 2 удаагийн уулзалт хурлыг хийсэн.</p> <p>“Ногоон нуур 1008 айлын түр суурьшуулах орон сууц барих төсөл”-ийн ТУХ-ны бүрэлдэхүүнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 76 дугаар тушаалаар, “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн ТУХ-ны бүрэлдэхүүнийг 106 дугаар тушаалаар тус тус батлуулав.</p> <p>“Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийн ТУХ-ны хурлыг 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хуралдуулж, холбогдох шийдвэрийг албажуулан СЯ-нд 2019 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 01/4284 тоот албан бичгээр хүргүүлэв.</p> <p>Төслийн удирдах хороо нь эрх, үүргийнхээ хүрээнд тулгамдсан асуудлуудаар тухай бүр хуралдаж, хэлэлцэж шийдвэр гаргаж мэргэжил арга зүйн удирдамжаар хангаж байна.</p> <p>Төслийн нэгжүүдийн 2019 оны тайланг хэлэлцэх мөн 2020 оны төлөвлөгөөг батлуулах ТУХ-ны хурлыг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулахаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Төслийн нэгжүүдийн ажилтнуудыг “ЭЙБЛ” системд бүртгэл үүсгэн хандах эрхийг нээж, харилцан мэдээлэл дамжуулах нөхцлийг бүрдүүлсэн.</p> <p>ТУХ-ны хурлын тоо:</p> <ol style="list-style-type: none"> 1. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын 7,14, МҮОНТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл”- 3 удаа

		2. “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн-нэмэлт санхүүжилт L3388-МОН”-2 удаа 3. “Ногоон нуур 1008 айлын түр суурьшуулах орон сууц барих төсөл”-2 удаа 4. “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-2 удаа 5. “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-1 удаа
	Зарцуулсан хөрөнгөө	Үйл ажиллагаагаар
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт 100% Төслүүдийн удирдах хорооны хурлыг зохион байгуулсан тоо -10
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.6.8. Салбарын хэмжээнд гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдээс бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин						
Арга хэмжээний нэр, дугаар	1.6.8.1. Салбарын хэмжээнд гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдээс бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх.						
	Төлөвлөлтийн уялдаа:	(Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль), (Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам)					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	7	8			12
	Шаардагдах хөрөнгө	Үйл ажиллагаагаар					
	Суурь түвшин	2-р улиралд: Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдээс бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх саналыг боловсруулагдсан байна. холбогдох байгууллагуудад санал хүргэгдсэн байна. Хөрөнгө шилжсэн байна.					
	Шалгуур үзүүлэлт	Засгийн газрын шийдвэр – 3 хүртэл					
	Хүрэх түвшин	3-р улиралд: Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдээс бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх саналыг боловсруулагдсан байна. 4-р улиралд: Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдээс бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх саналыг боловсруулагдсан байна.					
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	“Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц дэд бүтцийн төсөл”-ийн хүрээнд хийгдсэн 33,401165,010.30 /Гучин гурван тэрбум дөрвөн зуун нэг сая нэг зуун жаран таван мянга арван төгрөг гучин мөнгө/ төгрөгийн Цахилгааны дэд станцууд болон цахилгаан дамжуулах шугам, кабель шугам сүлжээ, 9,068,854,551.00 /есөн тэрбум жаран найман сая найман зуун тавин дөрвөн мянга таван зуун тавин нэгэн/ төгрөгийн өртөг бүхий ус, дулаан дамжуулах төв, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ түүний иж бүрдлийг үндсэн хөрөнгийг асуудлыг шийдвэрлүүлэх саналыг 03/1308 тоот албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн. “Эрдэнэтийн цэвэрлэх байгууламж” болон “Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц дэд бүтцийн төсөл”, мөн “Дэд бүтэц төсөл”-ийн хөрөнгийн өмчлөлийн асуудлаар Сангийн яамтай 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргын өрөөнд уулзалт зохион байгуулж, холбогдох шийдвэрийг 2019 оны 11 сарын 12-ны өдрийн 03/4243, 03/4245 тоот, мөн НӨАУГ-т 03/4244 тоот албан бичгээр ТӨБЗГ-т тус тус хүргүүлсэн.					

		Дамжуулан зээлдэх гэрээнээс шалтгаалан Улсын комисс хүлээн авсан төслүүдийн зарим хөрөнгийг шилжүүлэн авах эзэмшигч тодорхойгүй байна. 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 328 дугаар тогтоолоор Дэд бүтэц төслийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 33,984,459,042.14 /гучин гурван тэрбум есөн зуун наян дөрвөн сая дөрвөн зуун тавин есөн мянга дөчин хоёр төгрөг арван дөрвөн/ төгрөгийн хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэсэн.
	Зарцуулсан хөрөнгө	Үйл ажиллагаагаар
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт 100% Засгийн газрын тогтоолын тоо-1 Хөрөнгийн өмчлөлийн асуудал шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний тоо-8
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.6.9. Баруун бүсэд байгуулах цементийн үйлдвэрийг дэмжинэ.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.6.9.1. Баруун бүсэд байгуулах цементийн үйлдвэрийг дэмжих.					
	Төлөвлөлтийн уялдаа:	(ЗГҮАХХАХТ-ний 2.87.4)				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	7			12
	Шаардагдах хөрөнгө					
	Суурь түвшин	2-р улиралд: цементийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн.				
	Шалгуур үзүүлэлт	Баруун бүсэд байгуулах цементийн үйлдвэрийн барилгын ажил эхэлсэн байна.				
	Хүрэх түвшин	3-р улиралд: Санхүүжилтийн асуудлыг эрчимжүүлэх талаар Хөгжлийн банктай хамтарч ажиллах. 4-р улиралд: Барилгын ажлыг эхлүүлэх.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээг гадаадын шууд хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслүүдийн жагсаалтыг гаргаж, Үндэсний хөгжлийн газар 2019 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 03/2642 тоот албан бичгээр хүргүүлэв. Баруун бүсийн цементийн үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэгч "Вестерн холд" ХХК-ийн барилгын ажилд шаардлагатай тоног төхөөрөмжийг "Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1-д "барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих зорилгоор импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулах замаар татварын дэмжлэгийг үзүүлж болно" гэж заасны дагуу тус төслийн цементийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх хүсэлтийг Сангийн яаманд 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 03/832 албан тоотоор хүргүүлсэн. Сайдын 2019 оны 05 дугаар сарын 7-ны өдрийн 01/1627 дугаар албан бичгээр Хөгжлийн банкинд санхүүжилтийн асуудлыг эрчимжүүлэх талаар хүсэлтийг хүргүүлсэн. Хөгжлийн банк нь уг төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэж, санхүүжилтийг "Вестерн холд" ХХК-д олгож эхлээд байна. Хөгжлийн банкнаас "Баруун бүсийн Цементийн үйлдвэр барих төсөл"-ийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн. Уг төсөл, арга хэмжээний ТЭЗҮ батлагдсан. Тоног төхөөрөмжийг захиалсан.				

	Зарцуулсан хөрөнгө	Үйл ажиллагаагаар
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт 100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 1.6.10. Төрийн худалдан авалтаар ногоон барилгын ажил, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.6.10.1. Төрийн худалдан авалтаар ногоон барилгын ажил, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих.					
	Төлөвлөлтийн уялдаа:	(Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль)				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар			11	12
	Шаардагдах хөрөнгө	Үйл ажиллагаагаар				
	Суурь түвшин	2-р улиралд: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дотоодын давуу эрх тооцож ажилласан.				
	Шалгуур үзүүлэлт	Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын ажил, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ.				
	Хүрэх түвшин	3-р улиралд: Ногоон барилгын үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлнэ. 4-р улиралд: Ногоон барилгын үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлнэ.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан 7 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 24 байрны гадна фасадны дулаалгын ажлыг хийхэд 6.5 тэрбум төгрөгийн эрчим хүчний хэмнэлттэй дулаалгын материалыг ашигласан. Барилга, хот байгуулалтын ямаар дамжуулан хэрэгжүүлэх 42 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дотоодын давуу эрх тооцохоор зарласнаас 17 компани хүсэлтээ ирүүлснээс 14 компани шалгарсан.				
	Зарцуулсан хөрөнгө	Үйл ажиллагаагаар				
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт 100% Төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж -7				
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ						

Гүйцэтгэлийн зорилт №1.1.1-ийн үр дүн: Засгийн газрын тогтоолоор батлуулах салбарын бодлогын баримт бичгүүдэд “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”-ын зорилтуудтай нийцүүлэн санал өгсөн байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			2018 он	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1.	Салбарын бодлого, үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн бодлогын	2-оос доошгүй баримт бичиг	Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д туссан салбарын зорилт, шалгуур	“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”-ын холбогдох зорилтууд болон Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн	Хэрэгжилт - 100% • Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогын баримт бичиг – 1

зорилтуудтай нийцүүлнэ.		үзүүлэлтүүдийг тодорхойлсон.	<p>газрын 2019.02.03-ны өдрийн 70 дугаар тогтоолоор "Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого"-ыг батлуулсан. Сайдын 2019 оны 67 дугаар тушаалаар Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. 2019 оны 9 сард Орон сууц, нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлогын төсөлд "Тогтвортой хөгжлийн зорилт"-ын Зорилт 6, түүний шалгуур үзүүлэлт, "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", "Ногоон хөгжлийн бодлого"-д нийцүүлэн санал боловсруулж /цаасаар/ бодлогын төслийн зөвлөх С.Чулуунхуяг, нарийн бичгийн дарга Д.Мөнхбаатар нарт өгсөн. Уг бодлогын төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн 6 хавсралтын бүрдлийг хангуулан эцэслэн боловсруулж дууссан бөгөөд яамдаас санал авахад бэлэн болсон.</p>	<ul style="list-style-type: none"> • "Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө – 1 • Санал өгсөн бодлогын баримт бичиг /Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого/ -1
-------------------------	--	------------------------------	---	--

Гүйцэтгэлийн зорилт №1.1.2-ийн үр дүн: Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын дэд бүтэц, хот төлөвлөлт, барилга, ариун цэврийн байгууламжийн чиглэлийн үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлсон байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал		Жилийн эцэст	
					Төл.	Гүй.
1.	Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт 2030-д туссан салбарын зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тооцоолох ажлыг зохион байгуулна.	Тодорхойлох шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний тоо – 24	-		Дэд ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, ажлын хэсгээс гаргах 24 шалгуур үзүүлэлтийн мэдээллийг нэгтгэн гаргаж явцын тайланг Үндэсний хөгжлийн газарт 5 дугаар сарын 02-ны өдрийн 04/1577 тоотой, эцсийн тайланг 5 дугаар сарын 27-нд цахимаар хүргүүлэв. Үндэсний хөгжлийн газраас өгсөн чиглэлийн дагуу 24 шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинийг тооцоолсон тооцоолол, аргачлал, эдгээрийг боловсруулахад тулгарч буй сорилт бэрхшээл,	<p>Хэрэгжилт - 100%</p> <ul style="list-style-type: none"> • Дэд бүтэц, хот төлөвлөлт, барилга, ариун цэврийн байгууламжийн чиглэлийн зорилтын 24 үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин • Үндэсний хэлэлцүүлэг -1.

				<p>цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан 2019 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 03/3373 тоот албан бичгээр ҮХГ-г хүргүүлсэн. Үндэсний хөгжлийн газраас нэгтгэн ирүүлсэн “Тогтвортой хөгжлийн зорилтын үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний нэгтгэлтэй танилцаад Барилга, хот байгуулалтын салбарын мэдээллийг нягтлан холбогдох газруудаас санал авч нэгтгэн 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 03/3735 тоотоор хүргүүлсэн. Ажлын хэсгээс гаргасан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, ажлын үр дүнг 2019 оны 9 дүгээр сард “ХOLIDЭЙ ИНН” зочид буудалд зохион байгуулсан Үндэсний хэлэлцүүлэгт БТГ-ын дарга бөгөөд ажлын хэсгийн дэд дарга тайлагнан хэлэлцүүлсэн. Үндэсний хэлэлцүүлэгээс гарсан санал зөвлөмжийн дагуу дахин тодотгол хийж, 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 03/3998 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт мэдээллийг хүргүүлсэн. Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилтуудыг үндэсний бодлого, хөтөлбөр боловсруулах үйл явцад уялдуулан тусгах арга хэрэгсэл /tool/-ийг боловсруулах батлуулахтай холбоотой хэлэлцүүлэгт 10 дугаар сарын 11-ний өдөр оролцож, санал өгсөн.</p>
--	--	--	--	--

Гүйцэтгэлийн зорилт №1.1.3-ийн үр дүн: Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, урт хугацааны бодлогод салбарын саналыг тусгуулна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1.	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, МУ-ын урт хугацааны бодлогыг	Урт хугацааны 2 бодлого	Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн “Төрөөс барилгын салбарын талаар	Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 52 дугаар захирамжийн дагуу “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн	Хэрэгжилт 100% • Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлогын баримт

	<p>шинээр боловсруулахад Үндэсний хөгжлийн газартай хамтран ажилласан байна.</p>		<p>баримтлах бодлого 2019-2029” боловсруулан батлуулсан.</p>	<p>бодлого” боловсруулах ажлыг ЗГХЭГ хариуцан зохион байгуулж ажиллаж байна. Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт мэргэжил, аргагүйн дэмжлэг үзүүлэх, салбарын чиглэлээр бодлогын санал боловсруулах ажлын хэсгийг Сайдын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 99 дүгээр тушаалаар, дэд ажлын хэсгүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/88 дугаар тушаалаар тус тус байгуулан мэдээллийг Үндэсний хөгжлийн газарт 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 03/2119 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үндсэн болон дэд ажлын хэсгээс боловсруулсан төслийг нэгтгэн 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 03/2772 тоот албан бичгээр ҮХГ-т хүргүүлж, шаардлагатай мэдээллээр ЗГХЭГ-аас байгуулсан ажлын хэсгийг ханган ажилласан. “Монгол Улсын урт хугацааны бодлого 2020-2045 он”-д салбарын бодлогыг тусгах чиглэлээр Ерөнхий сайдын 2019 оны 52 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Үндэсний хөгжлийн газар болон холбогдох байгууллагуудтай тогтмол харилцан мэдээлэл солилцож, хамтран ажилласан. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019.07.10-ны өдрийн 65 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс “Монгол Улсын урт хугацааны бодлого 2020-2045 он”-ыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн төсөл болгож өөрчлөн эхний хувилбарыг боловсруулж 2019.11.22-ны өдрийн ХЭГ/3280 тоот албан бичгээр санал авахаар</p>	<p>бичгийн төслийн эхний хувилбар – 1</p> <ul style="list-style-type: none"> • “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-д тусгах салбарын бодлогын саналын төсөл – 1
--	--	--	--	--	---

				<p>тус яаманд ирүүлсэн. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн "Алсын хараа-2050" бодлогын баримт бичиг нь 9 логик хүрээ, I (2021-2030), II(2031-2040), III (2041-2050) гэсэн гурван үе шаттай бөгөөд үе шат тус бүрд зорилт дэвшүүлж, зорилт тус бүрийн хүрэх үр дүн, тухайн үр дүнд хүрэхийн тулд хийгдэх үйл ажиллагаа гэсэн бүтэцтэй болж шинэчлэн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус яамнаас хариуцсан салбарын зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагааг 2050 он хүртэл буюу 30 жилийн хугацаатай шинэ загварт нийцүүлэн дахин шинэчлэн боловсруулсан. Уг бодлогын баримт бичгийн төслийн "Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын логик хүрээ", "Эдийн засаг зорилгын логик хүрээ", "Сайн засаглал зорилгын логик хүрээ", "Ногоон хөгжил зорилгын логик хүрээ", "Нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжил" гэсэн 5 логик хүрээнд барилга, хот байгуулалтын салбарын бодлогын асуудлуудыг шинээр болон шинэчилэн тусгуулахаар саналыг бэлтгэж, 2019.11.22-ны өдрийн 03/4411 тоот албан бичгээр болон цахим шуудангаар ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Бүсчилсэн хөгжлийн бодлогын чиглэлээр "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийн төслийн "Нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжил" логик хүрээний "Байгаль, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зүй тогтлын дагуу хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутаг, хот суурин газрын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хөгжүүлнэ" гэсэн зорилгын хүрээнд "Тогтвортой хөгжлийн зорилтод тулгуурласан Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг</p>	
--	--	--	--	---	--

				боловсруулж хэрэгжүүлэх” зорилтыг дэвшүүлж, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ХБГХБХЗГ-аас авч нэгтгэн 2019.11.22-ны өдрийн 03/4411 тоот албан бичгээр болон цахим шуудангаар ЗГХЭГ-т хүргүүлсэн.	
--	--	--	--	---	--

Гүйцэтгэлийн зорилт №1.1.4-ийн үр дүн: Төрөөс уур амьсгалын өөрчлөлтийн сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах бодлогод салбарын бодлогыг боловсруулан тусгуулна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал		Жилийн эцэст	
					Төл.	Гүй.
1.	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох стратеги боловсруулан хэрэгжүүлэх бодлогын хүрээнд байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх салбарын бодлогыг боловсруулан холбогдох баримт бичгүүдэд тусгуулсан байна.	Салбарын бодлого, төлөвлөгөөний төсөл, 6 хавсралт	-		Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсэг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 91 дүгээр тушаалаар байгуулагдсан. Барилга, хот байгуулалтын салбарын бодлого, зорилтыг “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого” (Засгийн газраар батлах үндэсний бодлого) болон “Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичиг” (НҮБ-аас дэмжих олон улсын баримт бичиг)-т тусгуулахаар 1 зорилго, 4 зорилт, 9 үйл ажиллагааны чиглэл, 45 арга хэмжээний төлөвлөгөө бүхий бодлого боловсруулан холбогдох 6 хавсралтын хамт БОАЖЯ-ны Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. Мөн тус ажлын хэсгээс бусад яам, салбарын бодлогыг нэгтгэн ирүүлсэн төсөлтэй танилцаж, санал бэлтгэн БОАЖЯ-нд 2019 оны 10-р сарын 23-ны өдрийн 01/3983 тоотгоор хүргүүлэв. “Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичиг” оруулах салбарын бодлого боловсруулсан.	Хэрэгжилт 90% <ul style="list-style-type: none"> • “Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр” (INDC) бодлогын баримт бичиг - 1 • Салбарын бодлогыг хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөөний төсөл – 1 • Бодлого, төлөвлөгөө боловсруулах гэрээ - 1

				Уг баримт бичиг Засгийн газрын тогтоолоор батлагдах шийдвэр гарсан. /Тогтоолын төсөл албажих шатандаа байна./ БХБЯ-наас боловсруулсан барилгын салбарын бодлогын төлөвлөгөөг тусад нь гаргаж хэрэгжүүлэхээр Ажлын хэсэг шийдвэрлэсэн тул энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд Барилгын салбараас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Action plan боловсруулах НҮБ-ын 540.000\$-ийн гэрээнд 2019 оны 10 дугаар сард БХБ-ын сайд Х.Баделхан гарын үсэг зурсан.	
--	--	--	--	--	--

Гүйцэтгэлийн зорилт №1.1.5-ийн үр дүн: Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх хүрээний асуудлыг тусгуулах ажлыг зохион байгуулсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1.	Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх хүрээний асуудлыг тусгуулсан байна.	Үндсэн чиглэл	Жил бүрийн МУ-ын ЭЗ, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд салбарын үйл ажиллагааг хууль, тогтоомжид нийцүүлэн тусгуулж, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/44 дугаар тушаалаар батлуулсан. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах салбарын саналыг боловсруулж Сангийн Сайдад 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/717 тоотоор хүргүүлсэн. УИХ-ын 2015 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 54 дүгээр тогтоолын хавсралтаар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” батлагдсан бөгөөд тус бодлогын баримт бичигт БХБЯ-аас хэрэгжүүлэх 14 зорилт, арга хэмжээ туссан.	Хэрэгжилт 100% Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөө – 1 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл – 1

Гүйцэтгэлийн зорилт №1.1.6-ийн үр дүн: Барилга, хот байгуулалтын салбарт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын байгууллагын санхүүжилт татах ажлыг зохион байгуулсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт
			Өмнөх улирал	Жилийн эцэст

				Төл.	Гүй.
1.	Барилга, хот байгуулалтын салбарт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тогтвортой, ногоон барилга, байгууламжийг хөгжүүлэх чиглэлд холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.	Үндсэн чиглэл	Ногоон барилгын үнэлгээний систем нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах Санамж бичгийг БОАЖЯ, БХБЯ, ЭХЗХ, Олон улсын санхүүгийн корпорацитай 2018 онд байгуулсан. Эрчим хүчний хэмнэлттэй барилгын чиглэлээр хамтран ажиллах Санамж бичгийг ЭХЗХ-той 2019 онд байгуулсан.	Барилга, хот байгуулалтын салбарт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тогтвортой, ногоон барилга, байгууламжийг хөгжүүлэх асуудлыг Төрөөс барилгын салбарын талаар бодлого-д тусгаснаас гадна Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх бодлогод тусгах саналыг 2019 оны 7-8 дугаар сард Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу 6 хавсралтаар гарган БОАЖЯ-ны Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Ц.Анандад хүргүүлсэн. Энэхүү бодлогын баримт бичигт салбарын Төрийн бус байгууллагуудаас 2019 оны 8 дугаар 19-ний 03/3168 тоотой санал авч нэгтгэн зарим саналыг тусгасан. Энэ чиглэлээр гадаадын техник туслалцааны төслүүд болох GIZ, GGGI, НҮБ-ийн НАМА төсөл, НЗДТГ, УБ хотын ЗАА, ЭХЗХ-той хамтран ажиллаж байна. "Пассив барилгын төлөвлөлт" сэдэвт сургалтыг НАМА төсөл ШУТИС-ын Барилгын эрчим хүч хэмнэлтийн төвтэй хамтран 2019 оны 9 дүгээр сарын 23-аас 27-ны хооронд 5 өдрийн сургалтыг барилгын архитектор, зураг төслийн инженерүүд, их дээд сургуулийн багш нарыг оролцуулан зохион байгууллаа. Тус сургалтыг Олон Улсын пассив сууцны хүрээлэнгийн мэргэшсэн багш заасан ба нийт 25 хүнийг чадавхжуулав. НАМА төслөөс боловсруулан Сайдын тушаалаар батлуулсан "Төвлөрсөн халаалтад холбогдсон барилга, байгууламжаас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг тоолох, хэмжих аргачлал"-ыг сурталчилан таниулах сургалт, семинарыг 2019	Хэрэгжилт 100% Зохион байгуулсан сургалтын тоо – 3 Санал өгсөн, оролцсон арга хэмжээний тоо – 8

				<p>оны 12 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулсан. Тогтвортой, ногоон барилга, байгууламжийг хөгжүүлэх чиглэлээр GIZ байгууллагатай хамтран 11 дүгээр сарын 1-нд “Тогтвортой барилгын үнэлгээний систем, санхүүжилтын арга механизм” сэдэвт семинарыг холбогдох талуудын 50 гаруй төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Семинарын үеэр хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан санал, хүсэлтийг нэгтгэн цаашдын үйл ажиллагаанд тусгахаар болсон.</p> <p>НЗДТГ, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-тэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол дахь барилга, байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн Ажлын хэсэгт орж ажиллаж байна. Уг ажлын хэсэг төлөвлөгөөний дагуу 2019 онд 5 удаа хуралдан зарим асуудлыг шийдвэрлэснээс гадна 11 дүгээр сарын 18-наас 12 дугаар сарын 2-ны хооронд Латви, ХБНГУ-д танилцах аялал зохион байгуулж, оролцсон.</p> <p>Тус төслийн үйл ажиллагаанд голлох үүрэгтэй оролцох, хамтран ажиллахын тулд төслийн удирдах хороонд БХБЯ саналын эрхтэй оролцох хүсэлтийг 2 удаа албан бичгээр хүргүүлээд байна. /Удирдах хороонд саналын эрхтэй оролцох тухай эхний хүсэлтийг төслийн удирдагч Дэвид Ханкоқд 4 дүгээр сарын 26-ны 02/1474 тоотойр, удаах хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын орлогч, ТУХ-ны дарга Ш.Анхмаад 2019 оны 11 дүгээр сарын 04-ний 02/4118 тоотойр хүргүүлэв./</p> <p>“Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэл” төслийн оролцогч талуудын уулзалтад 2019 оны 12 дугаар сарын 5-ны өдөр</p>
--	--	--	--	---

				<p>09.00-13.00 цагт оролцож, УАНС-ын НАМА арга хэмжээнээс 18 сая ам. долларын буцалтгүй тусламж авах гэж байгаатай холбогдуулан Техникийн Ажлын хэсэг байгуулсан. БХБ-ын яамыг төлөөлж санал өгсөн.</p> <p>GIZ төслөөс Эрчим хүчний хэмнэлттэй АОС-ны загвар байшин танилцуулах Нээлтийн арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 10-ны 10.00-14.00 цагт зохион байгуулж, Эрэл ХХК, Изохаус ХХК, Дэлгэр констракшн ХХК-иудын барьсан 50 м2 байшинг танилцуулсан.</p>
--	--	--	--	---

Гүйцэтгэлийн зорилт №1.2.1-ийн үр дүн: Салбарын суурь судалгаа, статистик тоон мэдээ, мэдээллийг цуглуулж, мэдээллийн системд байршуулсан судалгааг гаргасан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1.	Салбарын суурь судалгаа, статистик тоон мэдээ, мэдээллийг холбогдох маягтуудын дагуу цуглуулна. Харьяа газрууд дээр байгаа мэдээллийн сангуудын байршил, холбогдох мэдээллийг цуглуулж, холбогдох саналыг боловсруулсан байна	Цуглуулсан мэдээлэл	Статистикийн 33 маягт, Газрын Нэгдмэл сангийн тайлан	Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын статистик мэдээллийн нэгтгэсэн. Газрын харилцааны салбарын 2009-2019 оны 10 жилийн статистик мэдээг нэгтгэн гаргаж архив үүсгээд байна. Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн мэдээллийн сангийн чиглэл, өгөгдлийн сангийн төрөл, өгөгдлийн сангийн ангилал, хамрах хүрээ, өгөгдлийн төрөл, өгөгдлийн өргөтгөлөөр нь ангилан ялгасан. Барилгын салбарын албан ёсны статистик, тоон мэдээллийг 2019 оны гуравдугаар улирлын байдлаар нэгтгэн гаргасан. ГЗБГЗЗГ болон БХТ-д байршиж буй мэдээллийн сангууд тэдгээрийн өгөгдлийн мэдээг авч нэгтгэн гаргасан, мөн энэ талаарх судалгааг Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн хүрээнд хэрэгжиж буй "Салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх" төсөлд хүргүүлсэн.	Хэрэгжилт 100% Тухай бүрийн мэдээллийг холбогдох газруудад хүргүүлсэн.

				<p>Барилга, хот байгуулалтын салбарын өнөөгийн байдал, өмнөх 25 жил болон ирээдүйн 25 жилийн бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэн ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэд 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр салбарын статистик мэдээллийн талаар танилцуулга бэлтгэн өгсөн.</p> <p>Мөн НҮБ-н Үндэсний илтгэлд барилгын салбарын статистик мэдээг бэлтгэн өгсөн.</p> <p>Үндэсний статистикийн хороо, ГЗБГЗЗГ-тай хамтран Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын Газрын харилцааны салбарын статистик мэдээг гарган ҮХГ-т цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>“Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан”-ийг шинэчлэн хөгжүүлж, ашиглалтад оруулж байгаатай холбогдуулан яамны албан хаагчдад системийн хөгжүүлэлтийг хийж байгаа БХТ-ийн мэргэжилтнээр системийн танилцуулга хийж, санал солилцсон. Мөн уг системд холбогдох саналуудыг БТГ болон бусад газруудаас авч нэгтгэн 2019 оны 3/4174 тоот албан бичгээр БХТ-д хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шинээр хийгдсэн 4 мэдээллийн системийг уг системд нэмэх, холбогдох хөгжүүлэлт, хяналтыг тавих, - Барилгын салбарын инженер, техникийн ажилтан болон мэргэжилтэй ажилчдын эрэлт, нийлүүлэлтийн судалгааны тайлан. - Барилгын салбарын ажилтнуудыг бэлтгэж буй их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын мэдээлэл. - Барилгын салбарын статистик судалгаа, мэдээлэл/бүтэн жил, хагас жил, улирал, сараар/. - Барилга, хот байгуулалтын салбарт “Жендерийн талаар 	
--	--	--	--	---	--

				<p>баримтлах бодлого (2018-2025)-ын судалгаа, мэдээлэл.</p> <ul style="list-style-type: none"> - Барилга, хот байгуулалтын салбарт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдын хөдөлмөр эрхлэлтийг хангах чиглэл”-ээр хийгдэж буй үйл ажиллагааны судалгаа, мэдээлэл. - Орон сууцны хөнгөлөлттэй ипотекийн зээлийн судалгаа, мэдээлэл. - Мэдээллийн сангийн хөгжүүлэлт болон төрийн үйлчилгээнд нэгтгэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Уг мэдээллийн системийн баяжилт, ашиглалтын журмыг боловсруулж, батлуулах; - Үндэсний дата төв дээр байрлаж буй “Хур” Төрийн мэдээлэл солилцооны системд барилгын салбарын холбогдох сервисийг оруулах; - Мэдээллийн системийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор баазуудыг 2 болон түүнээс дээш байршилд хадгалах; - Барилгын салбарын тоон болон статистик мэдээллийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хэрэгжүүлж буй “Төрийн нэгдсэн мэдээллийн сан” цахим хуудсанд байршуулах. 	
--	--	--	--	--	--

Гүйцэтгэлийн зорилт №1.2.2-ийн үр дүн: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төслийг бодлого, үйл ажиллагааны удирдамжаар хангах, ерөнхий хяналтыг хэрэгжүүлнэ.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1.	Төслийн удирдах хороонд орж ажиллаж Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем боловсруулах ажилд санал өгсөн байна.	Мэдээллийн сан-1 Журам-1	ЗГХЭГ-ын даргын тушаалаар Төслийн Удирдах Хороо байгуулагдан ажиллаж байна.	ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэнгээр ахлуулсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төсөл”-ийн Удирдах хорооны гишүүнээр ажиллаж, шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажиллаа. Энэхүү хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан	Хэрэгжилт 100% -Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем www.development.gov.mn - 1 -Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сангийн журам - Саналын тоо 1

				<p>бий болсноор хөгжлийн бодлого төлөвлөгчдөд дэмжлэг үзүүлэх мэдээллийн нэгдсэн цогц сан бүхий web-д суурилсан платформ бий болж бодлого боловсруулагчид болон олон нийт мэдээллийн санг ашиглаж нэгдсэн мэдээллээр хангагдах, Хөгжлийн бодлогыг удирдах, хянах тогтолцоо боловсронгуй болгох юм.</p> <p>-Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын Засгийн газарт үзүүлэх буцалтгүй тусламжийн хүрээнд “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх” төслийг 2 жилийн хугацаанд Үндэсний хөгжлийн газарт хэрэгжүүлсэн бөгөөд тус системийг хөгжүүлэх төслийн анхан шатны танилцуулгад 2019 оны 02 дугаар сарын 22, явцын танилцуулгад 04 дүгээр сарын 10-ны өдөр оролцож холбогдох саналуудыг өгсөн. Төсөл амжилттай хэрэгжиж 2019.12.05-ны өдөр хаалтаа хийсэн /Гүйцэтгэгч: “Айтүүлс” ХК/.</p> <p>Энэхүү мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан цаашид хөгжлийн бодлого, төлөвлөлтийг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд технологийн дэвшилтэд шийдлээр оновчтой, уялдаатай боловсруулаад зогсохгүй, бодлогын баримт бичгийн уялдааг сайжруулснаар төсвийн хувиарлалтыг үндэслэлтэй, үр дүнтэй хийх боломж бүрдсэн. Түүнчлэн систем хэрэглээнд нэвтэрснээр хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой мэдээллийг иргэдэд ойлгомжтой байдлаар хүргэх, бодлогын баримт бичиг боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн хэрэгцээ шаардлагыг</p>	
--	--	--	--	--	--

				<p>бодлого боловсруулагч нар цахимаар хүлээн авах, цаашлаад гадаадын хөрөнгө оруулагч нарт үнэн, бодит мэдээлэл хүргэх зэрэг олон давуу тал үүсч байгаа юм. www.development.gov.mn Мөн ЗГХЭГ-аас ирүүлсэн “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сангийн журам”-д 2019 оны 01/1780 тоот албан бичгээр санал өгсөн.</p> <p>“Нэг маягийн загвар зураг” цахимжуулж байгаатай холбогдуулан Үндэсний хөгжлийн газраас холбогдох газрын дарга, мэргэжилтэнг урьж, яамны албан хаагчдад 12 дугаар сарын 06-ны өдрийн “Мэдээллийн цаг”-аар системийн талаар танилцуулга хийж, санал солилцсон. Мөн яамны удирдлагуудтай уг системийн санхүүжилт, хэрэгжилтийн талаар уулзалтыг зохион байгуулсан. Системийг 2020 оны 1 сард багтаан ашиглалтад оруулахаар шийдвэрлэж, ҮХГ-тай хамтран ажиллаж байна.</p>	
--	--	--	--	---	--

Гүйцэтгэлийн зорилт №1.2.3-ийн үр дүн: Барилга, хот байгуулалтын салбарын бодлогын баримт бичгүүдийг уялдааг үнэлнэ.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			2018 он	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1	Салбарын 10 бодлогын баримт бичигт үнэлгээ хийж ҮХГазарт хүргүүлсэн байна.	Бодлогын баримт бичгийн тоо	-	Бодлогын баримт бичиг -10	Үнэлгээ хийх баримт бичгийн тоо -11 Ажлын хэсгийн дүгнэлт -1

Гүйцэтгэлийн зорилт №1.2.4-ийн үр дүн: Үндэсний статистикийн хороогоор маягтын загварыг шинэчлэн батлуулсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1.	Үндэсний статистикийн хороонд салбарын	Шинэчлэн батлуулсан маягтын тоо	33 маягт	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 105 дугаар тушаалаар	Хэрэгжилт 100% • Сайдын болон хамтарсан тушаал -1

	<p>статистик мэдээ, тайланг хүргүүлэх, Үндэсний статистикийн хороогоор маягтын загварыг шинэчлэн батлуулла.</p>		<p>батлагдсан салбарын статистик мэдээ гаргах 33 маягтын загварыг шинэчлэн, анхдагч мэдээллийн 11 маягт болгон боловсруулж, холбогдох газруудаас саналыг авч Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 173 дугаар тушаалаар батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яаманд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01/4170 албан тоотоор хүргүүлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2019 оны 11 дүгээр сарын 19-ний 1/1-5149 албан тоотоор Үндэсний статистикийн хороотой хамтран баталж, хянуулах нь зүйтэй гэсэн хариуг ирүүлсэн. Үүний дагуу Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалын төсөл болон бүртгэл мэдээллийн маягт, нөхөх зааврын төслийг боловсруулж санал авахаар 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 03/4428 албан тоотоор Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Үндэсний статистикийн хорооноос 2019 оны 12 дугаар сарын 02-ны 01/1160 албан тоотоор тушаалын төсөлд санал хүргүүлсэн. Ирүүлсэн саналыг тушаалын төсөлд тусган, Хуулийн хэлтсээр хянуулан, тушаалын төслийг батлуулахаар Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар 2019 оны 12 дугаар сард багтаан батлуулахаар тогтсон. Анхдагч маягт -11</p>	<p>• Барилгын салбарын бүртгэл мэдээллийн маягт - 11</p>
--	---	--	---	--

Гүйцэтгэлийн зорилт №1.2.5-ийн үр дүн: Дээд шатны эрх бүхий байгууллагыг барилга, хот байгуулалтын салбартай холбоотой судалгаа мэдээллээр хангах, салбарын суурь мэдээлэл буй болгох чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1.	Барилга, хот байгуулалтын салбартай холбоотой судалгаа мэдээллийг нэгтгэн,	Хүргүүлсэн мэдээлэл, тайлангийн тоо	-	-ЗГХЭГ-т салбарын албан ёсны статистик тоон мэдээллийг гарган 2019 оны 03/3326 тоот албан бичгээр хүргүүлсэн. -ЗГХЭГ-т салбарт хэрэгжүүлсэн томоохон 10 ажлын талаарх	Хэрэгжилт 100% -ЗГХЭГ-т хүргүүлсэн албан мэдээллийн тоо – 4

	<p>өгөгдлийн сан үүсгэж, холбогдох газруудыг мэдээллээр хангасан байна</p>		<p>дэлгэрэнгүй мэдээллийг цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>-“Барилгын ажилтны удирдах ажилтны зөвлөгөөн”-ий УИХ-ын даргын мэндчилгээг бэлтгэн УИХ-ын тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>-“Барилгын ажилтны удирдах ажилтны зөвлөгөөн”-ий Ерөнхий сайдын илгээлтийг бэлтгэн ЗГХЭГ болон Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлсэн.</p> <p>-“Барилгын ажилтны удирдах ажилтны зөвлөгөөн”-тэй холбоотойгоор хэвлэлийн мэдээг бэлтгэн хэвлэлийн төлөөлөгчид хүргүүлсэн болно.</p> <p>-УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд БХБЯ-ны 01 дүгээр улирал, 2019 оны эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн томоохон ажлуудын тайланг хүргүүлсэн.</p> <p>-ЗГХЭГ-т ЗГҮАХ-ийн хэрэгжилт, яамны эрхлэх асуудалтай холбоотойтой мэдээ, тайланг шуурхай хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>-ҮСГ, ГЗБГЗЗГ-тай хамтран Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгын Газрын харилцааны салбарын статистик мэдээг гарган ҮХГ-т хүргүүлсэн.</p> <p>-Засгийн газрын тогтоолоор батлагддаг Монгол Улсад нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр /мэргэжил/-ийн жагсаалтад Барилгын салбарын инженер техникийн ажилтнууд болон мэргэжилтэнг нэмж тусгах саналыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/2151 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- ЗГХЭГ-аас тус яамны Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг үнэлээд хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн 25 ажлын тайлан тайлбарыг ЗГХЭГ-т 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 03/2189 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Үндэсний статистикийн хороо болон Статистикийн хөгжлийн төлөөх түншлэл /Парис21/-ийн хүрээнд зохион байгуулагдсан Статистикийг дэмжих улс орны тайланд барилгын салбарын мэдээллийг тусгахаар санал өгсөн.</p> <p>- Үндэсний статистикийн хороонд “Статистикийг дэмжих тухай улс орны асуулгын хуудас”-ыг маягтын дагуу гарган 2019 оны 03/2815 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>	<p>-ҮСХ-нд хүргүүлсэн албан баримт бичгийн тоо – 2</p> <p>-Бусад байгууллагуудад хүргүүлсэн албан баримт бичгийн тоо – 9</p> <p>-Зохион байгуулсан сургалтын тоо - 1</p>
--	--	--	---	--

				<p>- Эрчим хүчний яамны харьяа “Диспетчерийн үндэсний төв”-д салбарын цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэлтийн талаарх мэдээллийг гарган хүргүүлсэн.</p> <p>- ХНХЯ-нд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд салбарын хэмжээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх дараах мэдээллийг 2019 оны 03/4255 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн телевизийн “Тулга тав” студи-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлигийн дагуу Барилга, хот байгуулалтын яам болон харьяа байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг батлагдсан бүтэц, орон тоонд нийцүүлэн ажиллуулж буй талаарх мэдээллийг 2019 оны 04/4380 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Үндэсний статистикийн хороотой хамтран барилгын салбарын статистикийн мэдээний тухай, тооцох арга зүй, мэдээллийн сан, түүний хэрэглээ, ашиглалтын талаарх сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Сургалтанд Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвийн нийт 20 албан хаагч хамрагдсан.</p>	
2	Барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох судалгааны ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.	Сургалтын тоо, тайлангын тоо	-	<p>Барилга, хот байгуулалтын яамнаас Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институттэй хамтран барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох судалгааны ажлыг зохион байгуулж байна. Судалгааны зорилго нь барилгын салбарт 2020 онд хэрэгцээтэй байх ажиллах хүчнийг ажил мэргэжил, байршлаар тодорхойлж, салбарын бодлого тодорхойлогчид, дээд болон мэргэжлийн боловсрол сургалт, хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчид, судлаачид болон бусад хэрэглэгчдийг мэдээллээр хангахад оршиж байна.</p> <p>2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр “Барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох судалгаа”-г зохион</p>	<p>Хэрэгжилт 100%</p> <p>-Зохион байгуулсан сургалтын тоо - 14 (УБ-6, Орон нутагт -8)</p> <p>-Судалгааны тайлангийн эхний хувилбар - 1</p>

				байгуулах уулзалтыг хийсэн. Уулзалтанд “Барилгын хөгжлийн төв” ТӨААҮГ, мэргэжлийн холбоодуудын төлөөллүүд оролцсон. 21 Аймгийн ГХБХБГ-т хамтран ажиллах тухай 2019 оны 11 дүгээр сарын 11-ний 03/4231, 11 дүгээр сарын 18-ны 03/4332 албан тоотыг хүргүүлсэн. “Барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох судалгаа”-нд оролцогчдын сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийн дагуу нийслэлд зургаан удаагийн сургалт, 21 аймгийг бүсчлэн найман аймагт 2019 оны 11 дүгээр сарын 15-аас 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд сургалтыг зохион байгуулан ажилласан. Одоогийн байдлаар нийслэл болон аймгуудад зохион байгуулсан сургалтуудад барилгын салбарын тусгай зөвшөөрөлтэй нийт 170 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл хамрагдсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын вэб хуудсаар дамжуулан цахим асуулгын аргаар аж ахуй нэгжийн хүний нөөцийн мэргэжилтэн, захирал эсвэл холбогдох мэргэжилтнүүдээс мэдээллийг цуглуулж боловсруулж байна. http://rilsp.gov.mn/barilga/ Уг мэдээлэлд үндэслэн төслийн гүйцэтгэгчээс барилгын салбарын эрэлтийн судалгааны тайлангийн эхний хувилбарыг боловсруулсан. Энэхүү тайлангийн эхний хувилбарыг 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр БХБЯ, ХНХЯ болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгт /GIZ/ танилцуулна.
--	--	--	--	---

Гүйцэтгэлийн зорилт №1.3.1-ийн үр дүн: Залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжид орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулдаг арга хэмжээг үе шаттай нэвтрүүлнэ. Дээд шатны эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангаж ажиллана.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1.	“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд түрээсийн орон сууцны санг 1000 айлын орон сууцаар нэмэгдүүлэх	Орон сууцанд орсон айлын тоо; Боловсруулсан журмын тоо; Боловсруулсан ТЭЗҮ;	-	Засгийн газрын “Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 81 дүгээр тогтоолоор МУ-ын Хөгжлийн банканд шилжүүлсэн 1542 айлын орон сууцны барилгыг түрээсийн орон сууцны	Хэрэгжилт 100% -Батлуулсан баримт бичгийн тоо - 2; -“Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам” - ЗГ-ын 2019.04.10-ны өдрийн 138 дугаар тогтоол;

	<p>талаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж батлуулна. “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ыг боловсруулж, батлуулна. “Ногоон нуур 1008 айлын орон сууц”, “Солонго-1”, “Солонго-2” орон сууцны төслүүдийг барих ажлыг зохион байгуулна.</p>			<p>санд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 6 дүгээр сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолоор батлуулсан. Тус тогтоолоор Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын орон нутгийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийн бүртгэн оруулах ажлыг зохион байгуулж эхлэхэд бэлэн болсон. Мөн ЗГ-ын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд төр, орон нутаг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд түрээсийн орон сууцны санг бүрдүүлэхээр заасан тул “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ын төслийг боловсруулж 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын 138 дугаар тогтоолоор батлуулсанаар зах зээлд түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэнд өмчлүүлэхээр хэрэгжиж буй 3457 айлын орон сууц байгаас 2387 айлын орон сууцанд иргэдийг хамруулсан. Үл хөдлөх зуучлалын цахим мэдээллийн санд 390 айлын хөлслүүлэх судалгаа байна. Эндээс харахад “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 5389 айлын орон сууц бэлэн болоод байна. Мөн БНСУ-ын Засгийн газраас манай улсын агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг орон сууцжуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохиролцсоны дагуу Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд “Солонго 1”, “Солонго 2”, Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороонд “Баянголын ам” орон сууцны 7000 айлын орон сууцнуудыг барихаар төлөвлөсөн. БХБЯ “Солонго 1”, “Солонго 2”</p>	<p>-“Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай” ЗГ-ын 2019.06.05-ны өдрийн 223 дугаар тогтоол. -2019 онд түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн орон сууцны тоо - 1542 айл; - Гадаадын зээл, тусламжаар баригдах түрээсийн орон сууцны тоо - 8008 айл; -БНСУ-ын хөнгөлөлтэй зээлээр - 7000 айлын орон сууц -БНХАУ-ын тусламжаар - 1008 айлын орон сууц - “Солонго 1”, “Солонго 2” орон сууц барих төслийн ТЭЗҮ-ийн судалгаа -2</p>
--	--	--	--	--	--

				<p>орон сууцны хороолол барих төслийг хариуцан хэрэгжүүлж байна. Дээрх төслүүдийн ТЭЗҮ-ийн судалгааг боловсруулах төслийн багийг БНСУ-ын “Экспорт-Импорт” банкнаас томилсон. Уг төслийн багтай 2019 оны 6 дугаар сараас эхлэн нийт 5 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, 13 удаа цахим шуудангаар мэдээлэл солилцсоны үндсэн дээр дээрх төслүүдийн ТЭЗҮ-ийн судалгааг боловсруулж, 2019.04.05-06-ны ТЭЗҮ-ийн судалгааны эцсийн шатны тайлангийн танилцуулгыг хийж, холбогдох саналуудыг тусгасан.</p> <p>БНСУ-ын Экспорт-Импорт банкны Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан /EDCF/-ийн Үнэлгээний ажлын хэсэг, Сангийн яам, “ТОСК” ТӨХХК-тай хамтран “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих” төслийн зээлийн гэрээнд тусгах “Хэлэлцээрийн тэмдэглэл”-ийг эцэслэн боловсруулж, 2019.11.28-ний өдөр албажуулан, талууд гарын үсэг зурж баталгаажуулсан. 2020 оны 1 дүгээр сард багтаан Зээлийн хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна.</p> <p>2019 оны 7 дугаар сард “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт БХБЯ-ын ТНБД, БНХАУ-ын Буцалтгүй тусламжийн албаны дарга нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Тус ажлын хүрээнд “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн барилга угсралтын ажлын бэлтгэл хангах төлөвлөгөө /2019-2020/-н ТНБД-аар 2019 оны 7 дугаар сард батлуулсан. Төслийн барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Интеллект тауер” ХХК шалгаран ажиллаж байгаа бөгөөд</p>	
--	--	--	--	---	--

				2019.11.01-нд зураг төслийг боловсруулан батлуулж, эх хувь материалыг хүлээлгэн өгсөн. Барилгын зураг төслийн дагуу барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах Тендерийн баримт бичгийг боловсруулах ажлыг Төсөл хэрэгжүүлэх нэгж хариуцан гүйцэтгэж байна. Барилгын ажил 2020 онд эхэлнэ.	
--	--	--	--	---	--

Гүйцэтгэлийн зорилт №1.3.2-ийн үр дүн: Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг эрчимжүүлнэ.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1.	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн санхүүжилт олгох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, хуралдуулна.	Ажлын хэсэг		Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн хангамж, шугам, сүлжээний ажлын хөрөнгө оруулалтыг БНХАУ-аас олгож буй 2.0 тэрбум юаны буцалтгүй тусламжаар шийвэрлэх талаар болон хийж гүйцэтгэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 179 дүгээр тогтоолоор батлуулсан. 2018 онд Эхний ээлжийн 600.0 сая юаныг 2018 онд авах байсан боловч тус эх үүсвэрээс “Хилийн боомт болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын салбар”-т хэрэгжиж буй “Гаалийн хяналт шалгалтад шаардлагатай тоног төхөөрөмж”-ийн хөрөнгө оруулалтад зарцуулагдахаар болсон. Иймд эх үүсвэрийн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан хэрэгжүүлэх арга, хэмжээний жагсаалтыг өөрчлөх зорилгоор Барилга, хот байгуулалтын сайд 2019 оны 35 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулж Барилга, хот байгуулалтын дэд сайдаар ахлуулаад байна. Уг ажлын хэсгийг 2 удаа хуралдуулж, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг эцсийн байдлаар боловсруулж, санхүүжилтийн хувиарыг эцэслэн 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 01/2082 тоот албан	Хэрэгжилт 100% -Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 35 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан.

				бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Хэрэв энэхүү төсөл арга хэмжээ хэрэгжсэн нөхцөлд БНХАУ-ын талаас МУХБ-аар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох боломжтой талаар МУХБ-д мэдэгдсэн. Энэ хүрээнд дээрх ажлын хэсгээс ГХДТ-ын гүйцэтгэгч нарын ажлын гүйцэтгэлд шинжилгээ хийж, төслийг хэрэгжүүлсэн байдлаар эрэмблэн, зээлийн шаардлага хангасан нөхцөлд зээл олгох боломжтой аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг хүргүүлсэн.	
	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд хүрсэн чанарын болон тоон утга. - Засгийн газрын 2017 оны 05 дугаар тогтоолоор байгуулсан “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулан батлуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороо байгуулагдсан. - БХБ-ын сайдын 2019.02.19-ний өдрийн 31 дүгээр тушаалаар “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл” боловсруулах ажлыг мэргэжлийн арга зүй, зөвлөгөөгөөр хангах үүрэг бүхий салбарын эрдэмтэд, зөвлөхүүдээс бүрдсэн Зөвлөх багийг байгуулан ажиллаж байна. - “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах ажлын даалгаврыг батлуулан, зөвлөх үйлчилгээний 119 тоот гэрээг 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тэй байгуулан, тус төслийн судалгааны ажлыг гүйцэтгэж байна. - “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл” боловсруулах ажлын зургийн даалгаврын төсөлд ирүүлсэн саналуудыг тусган эцэслэн боловсруулан, холбогдох яамдуудаас санал авах ажлыг зохион байгуулж батлагдах шатандаа байгаа болно. - Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд уг төслийг						

		<p>боловсруулах 2,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгуулсан боловч Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд 600 сая төгрөгийг баталсан тул 2019 оны төсвийн тодотгол, 2020 оны төсвийн хязгаарын төсөлд шаардлагатай нэмэлт санхүүжилтийг тусгах саналыг өгсөн.</p>
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	<p>1.Төсөл боловсруулах ажлын зургийн даалгаврын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах.</p> <p>2.Төсөл боловсруулах ажлын судалгааны ажлыг үргэлжүүлэн гүйцэтгэж, шаардлагатай санхүүжилтийн асуудлыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, шийдвэрлүүлэх.</p>
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: Судалгааны ажлыг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын “Хот байгуулалт, зураг төсөл, төлөвлөлтийн институт” үргэлжлүүлэн гүйцэтгэсэн байна.
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<ul style="list-style-type: none"> - “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах 2019/26 дугаартай зургийн даалгаврыг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулсан. - Барилгын хөгжлийн төвийн институт нь сумдаас цуглуулсан мэдээллийг боловсруулах арга зүйг Өмнөговь аймгийн Ханбогд сумыг загвар болгон боловсруулсан. - “Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-д Байгаль орчны стратегийн үнэлгээ хийх ажлын даалгаврын төслийг боловсруулан үнийн санал авахаар БХБЯ-ны 2019.08.12-ны өдрийн 03/3112 тоот албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлсэн. БОАЖЯ-аас тус яамны тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудад хандан үнийн санал авах тухай хариу ирүүлсэн. Аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг гарган санал авах тухай албан бичиг хүргүүлсэн. - Тус төслийн зөвлөх багуудын аль баг нь ямар түвшинд ажиллах, авсан мэдээллийг хэрхэн ашиглах талаар ЖАЙКА болон АХБ-ны багуудтай хамтарсан зөвлөлдөх уулзалтыг 8 удаа зохион байгуулав. - Японы Олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын техникийн туслалцаагаар хэрэгжүүлэх “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” болон Азийн хөгжлийн банкны, Японы ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн бодлогын баримт бичгүүдийг харилцан уялдаатай боловсруулах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төслийн зөвлөх багуудтай хамтран ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг БХБ-ын Сайдын 2019.09.17-ны өдрийн 158 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. - Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 32 дугаар захирамжаар байгуулсан “Төслийн хамтарсан зохицуулах хороо”-ны хуралдааныг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулж, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх багийн “Дунд шатны тайлан 1”-ийг хэлэлцүүлсэн. Тус хэлэлцүүлэгт “Төслийн хамтарсан зохицуулах хороо”-ны бүрэлдэхүүн, ХАНСХЕТ-ийг боловсруулах ажлыг мэргэжлийн арга зүй, зөвлөгөөгөөр хангах “Зөвлөх баг”-ийн гишүүд болон БХБЯ, ГЗБГЗЗГ, ҮХГ, Барилгын хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтнүүд оролцсон. Дунд шатны тайланд санал авах тухай 2019.12.02-ны өдрийн 03/4475 тоот албан бичгийг холбогдох яам, газруудад хүргүүлсэн. - Азийн хөгжлийн банкны, Японы ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн Зөвлөх багийн эхний шатны тайлан ирсэн боловч англи хэл дээр боловсруулсан тул Монгол хэл дээр ирүүлэх талаар 2019.10.29-ний өдрийн 03/4057 тоот албан бичгээр хүргүүлсэн. - Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах дунд шатны тайланг 2019.12.06-ны өдрийн

		3726 тоот албан бичгээр БХТ-өөс ирүүлж, уг тайланг Төслийн Зөвлөх баг болон дэд ажлын хэсгийн гишүүдээс санал авахаар хүргүүлсэн. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд 2.8 тэрбум төгрөгний санхүүжилт батлагдсантай холбогдуулан тус төслийг боловсруулах ажлыг эрчимжүүлэх талаар 2019.12.05-ны өдрийн 03/4534 тоот албан бичгийг БХТ-д хүргүүлсэн. - “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн явц болон Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг түшиглэн хөгжих дагуул хотын тухай” нээлттэй форумыг 2019.11.15-ны өдөр БХТ-ийн 5 давхарт зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах ажлыг мэргэжлийн арга зүй, зөвлөгөөгөөр хангах Зөвлөх баг, ажлын хэсгийн гишүүд болон БХБЯ, ГЗБГЗЗГ, ҮХГ, Барилгын хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтнүүд, Хот байгуулалт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн гишүүд, судлаач нар оролцсон.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	<i>1.2 тэрбум төгрөг</i>
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт – 100 хувь
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин</i>							
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	2.1.1.2. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	МУЭЗН-ийг 2019 онд ХҮЧ-ийн 8.3, УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолын 2.1 дэх заалт, МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын1, ЗГҮАХХАХТ-2.83.2, НХБХҮАТ-6.1.7, ЗГҮАХХАХТ-2.85.4, НХБХҮАТ-6.1.4, 6.1.7						
<i>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</i>	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	<i>1 / 7</i>	<i>2 / 8</i>	<i>3 / 9</i>	<i>4 / 10</i>	<i>5 / 11</i>	<i>6 / 12</i>
	<i>Шаардагдах хөрөнгө</i>							
	<i>Харцуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах шинжээч Д.Бэлэгсайхан Ахлах мэргэжилтэн Б.Нямдаш						
	<i>Суурь түвшин</i>	2-р улиралд хүрсэн чанарын болон тоон утга: “Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа”-ны ажлын эхний хувилбарыг боловсруулж 2018 онд БХБЯ-ны ШУТТЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, зөвлөлийн гишүүдээс өгөгдсөн саналыг тусган дахин боловсруулж ШУТТЗ-д танилцуулахаар шийдвэрлэсэн. “Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа”-ны ажлыг НИТХТ-дэд 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр танилцуулсан. Хуралдаанаас НИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	“Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа”-ны ажлыг НЗДТГ, НХТЕТГ-ай хамтран боловсруулсан байна.						
<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: “Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”-ийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар НИТХТ-ийн хурлаар, БХБ-ын ШУТЗХ-аар тус тус хэлэлцүүлж, Засгийн газарт өргөн мэдүүлнэ.							

Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийн хэрэгжилтийн байдал, “Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа”-ны ажлыг НИТХ-ын Тэргүүлэгчдэд 2019.09.11-ний өдөр танилцуулсан. Хуралдаанаас НИТХ-аар, мөн намын бүлгүүдээр тус тус хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Баримт бичгийг НИТХ-ын дэргэдэх намын бүлгүүдийн хурлаар 2019.09.24-ний өдөр, НЗД-ын дэргэдэх “Аз жаргалын хороо”-ны хурлаар 2019.09.25-ны өдөр, НИТХ-аар 2019.09.26-ны өдөр тус тус хэлэлцүүлж, НИТХ-ын Тэргүүлэгчдээс санал авсан. Хуралдаанаас НИТХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан, санал өгөх ажил зохион байгуулагдсан. Нийслэлийн хэмжээнд НИТХ-ын Тэргүүлэгчид, НИТХ, намын бүлгүүд, холбогдох хорооны хурлаар хэлэлцэгдэж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны ээлжит 28 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, 2019 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 28/26 дугаар тогтоолоор дэмжигдсэн. Тус ажлыг БХБЯ-ны Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хурал, БХБ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж өгөх тухай Нийслэлийн Засаг даргаас 2019.11.07-ны өдрийн 01/5305 тоот албан бичгийг ирүүлсэн. Уг ажлыг БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар, мөн БХБ-ын сайдын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн дэмжиж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэж, уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж байна.
	Зарцуулсан хөрөнөг	Нийслэлийн төсөв
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт-100 хувь
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

Гүйцэтгэлийн зорилт № 2.1.1.-ийн үр дүн:

1. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах боловсруулах зургийн даалгавар батлагдсан байна.
2. “Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци” боловсруулагдаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдсэн байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
			Өмнөх улирал	Төл.	Гүй
1.	Төсөл боловсруулах ажлын зургийн даалгаврын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулна.	Зургийн даалгавар 1	“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл” боловсруулах ажлын зургийн даалгаврын төсөлд ирүүлсэн саналуудыг тусган эцэслэн боловсруулан, холбогдох яамдуудаас санал авах ажлыг зохион байгуулсан.	Төсөл боловсруулах ажлын зургийн даалгаврын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах.	“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах 2019/26 дугаартай зургийн даалгаврыг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулсан.
2	“Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний	“Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий	“Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”,	“Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”-ийг	Уг ажлыг БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн

	<p>концепци”, "Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа"-ны ажлыг НЗДТГ, НХТЕТГ-ай хамтран боловсруулсан байна.</p>	<p>төлөвлөгөөний концепци” 1</p>	<p>"Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа"-ны ажлыг НИТХТ-дэд 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр танилцуулсан. Хуралдаанаас НИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар НИТХТ-ийн хурлаар, БХБ-ын ШУТТЗХ-аар тус тус хэлэлцүүлж, Засгийн газарт өргөн мэдүүлнэ.</p>	<p>хурлаар, мөн БХБ-ын сайдын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн дэмжиж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Уг ажлыг БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар, мөн БХБ-ын сайдын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн дэмжиж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэж, уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p>
--	--	--------------------------------------	--	--	---

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.2. Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.

Төлөвлөлтийн уялдаа: "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030"-ийн 2.1.5 Зорилт 6-ийн 1.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.2.1. Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, батлуулах							
	Төлөвлөлтийн уялдаа:	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030 Зорилт 6-ийн I үе шат, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 4.1.13, НХБХҮАТ- 6.6.1, 6.1.3, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 4.4.4						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	12,0 сая төгрөг						
	Хариуцах нэгж	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах шинжээч Д.Бэлэгсайхан						
	Суурь түвшин	2-р улиралд хүрсэн чанарын болон тоон утга: БХТ-ийн даргын 2017.12.05-ны өдрийн А/335 дугаар тушаалаар 2017.12.05-ны өдрийн 2017/269 дугаар гэрээг зөвлөх "Эко сити, эко						

		корпорэйшн ХХК"-тай байгуулан, ажлыг гүйцэтгэж стандартын төслийг 2018.08.01-ний өдөр зөвлөх компаниас хүлээн авсан. "Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт" боловсруулахад суурь болгон ашигласан материал нь 2018 оны 07 дугаар сард ISO 37120:2018 "Sustainable cities and communities -Indocators for city services and quality of life" болж шинэчлэгдсэн тул дахин нийцүүлэн боловсруулалт хийгдэж байна.
	Шалгуур үзүүлэлт	1."Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт"-ын төслийг шинээр боловсруулах, холбогдох газруудаас санал авч тусгагдсан байна. 2.2018 онд шинэчлэгдсэн ISO 37120:2018 "Sustainable cities and communities -Indocators for city services and quality of life" нийцүүлэн дахин боловсруулалт хийгдсэн байна.
	Хүрэх түвшин	4-р улиралд: 2018 онд шинэчлэгдсэн ISO 37120:2018 "Sustainable cities and communities -Indocators for city services and quality of life" нийцүүлэн дахин боловсруулалт хийгдсэн байна.
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	2018 онд шинэчлэгдсэн ISO 37120:2018 "Sustainable cities and communities -Indicators for city services and quality of life" нийцүүлэн дахин боловсруулалт хийгдэж, 2019 оны 12 дугаар сард холбогдох байгууллагуудаас санал авч, ажил гүйцэтгэх гэрээний хугацааг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан.
	Зарцуулсан хөрөнгө	Нормчлолын сан
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт-100 хувь
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

Гүйцэтгэлийн зорилт №2.1.2-ийн үр дүн: "Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт"-ын төслийг боловсруулагдсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин Өмнөх улирал	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт Жилийн эцэс	
				Төл.	Гүй
1	"Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт"-ын төслийг шинээр боловсруулах, холбогдох газруудаас санал авч тусгагдсан байна. Стандартын төсөл боловсруулагдсан байна.	Стандартын төсөл 1	"Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт" боловсруулахад суурь болгон ашигласан материал нь 2018 оны 07 дугаар сард ISO 37120:2018 "Sustainable cities and communities - Indocators for city services and quality of life" болж шинэчлэгдсэн тул дахин нийцүүлэн боловсруулалт хийгдэж байна.	2018 онд шинэчлэгдсэн ISO 37120:2018 "Sustainable cities and communities - Indocators for city services and quality of life" нийцүүлэн дахин боловсруулалт хийгдсэн байна.	2018 онд шинэчлэгдсэн ISO 37120:2018 "Sustainable cities and communities - Indicators for city services and quality of life" нийцүүлэн дахин боловсруулалт хийгдэж, 2019 оны 12 дугаар сард холбогдох байгууллагуудаас санал авч, ажил гүйцэтгэх гэрээний хугацааг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.3. Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.

Төлөвлөлтийн уялдаа: "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030"-ийн 2.1.5 Зорилт 6-ийн 1

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.3.1. Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх ажлын хүрээнд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журмын төслийг боловсруулж батлуулах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	ЗГҮАХХАХТ-2.85.1, МУЭЗНХҮЧ-8.3.2, “150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөр 4.2.1, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 4.1.3, 4.4.4, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030” Зорилт 6-ийн I үе шат,НХБХҮАТ- 6.6.1,						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1/7	2/8	3/9	4/10	5/11	6/12
	Шаардагдах хөрөнгө	-						
	Хариуцах нэгж	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах мэргэжилтэн Д.Болормаа						
	Суурь түвшин	“Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”, “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам” боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж журмын төслүүдийг боловсруулж холбогдох газруудаас санал авсан.						
	Шалгуур үзүүлэлт	1. 2 журмын төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авч тусгагдсан байна 2. 2 журмын төсөл боловсруулагдаж батлагдсан байна						
	Хүрэх түвшин	4-р улиралд: “Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”, “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам” –ын төслийг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар батлуулсан байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 60 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус хуулийг дагалдан гарах “Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”, “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам”–ын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авсан. Мөн холбогдох байгууллагуудын вэб сайтад байрлуулж санал авч, ирүүлсэн саналуудыг нэгтгэн товъёог хийсэн. Журмын төсөл бүрийг хариуцан боловсруулахаар 2 дэд ажлын хэсэг байгуулж, саналын товъёог бүр дээр ажиллан санал өгсөн. Ажлын хэсгийн хурлыг 4 удаа, дэд ажлын хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулсан. Журмын төслийг “Архитектур, хот байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэхээр 2019.11.25-ны өдрийн 06/4416 тоот албан бичгээр МАЭ-д хүргүүлсэн. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2019.12.11-ний өдөр хэлэлцүүлж, БХБ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр хурлын товыг хүлээж байгаа болно.						
	Зарцуулсан хөрөнгө	---						
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт – 100 хувь						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ								

Гүйцэтгэлийн зорилт №2.1.3-ийн үр дүн: “Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх ажлын хүрээнд хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журмын төслийг боловсруулж батлуулна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт		
			Суурь түвшин	Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.

1	“Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”, “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам” –ын төсөл боловсруулагдсан байна.	Журмын төсөл 2	“Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”, “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам” боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж журмын төслүүдийг боловсруулж холбогдох газруудаас санал авсан.	2 журмын төсөл боловсруулагдаж батлагдсан байна.	2 журмын төслийг Архитектур, хот байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар 2019.12.11-ний өдөр хэлэлцүүлж дэмжигдсэн. БХБ-ын сайдын тушаалаар батлагдах шатандаа байгаа болно.
---	---	-------------------	---	--	---

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.4. Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлэх ажлын хүрээнд хот, тосгоны газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

Төлөвлөлтийн уялдаа: “Ногоон хөгжлийн бодлого”-ын баримт бичгийн 3.6.2.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин								
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.4.1. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг боловсруулах.								
	Төлөвлөлтийн уялдаа:	УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт), МУТХҮБ-ын 2.1.5. Зорилт 5, 6, ЗГҮАХХАХТ-5.2.11.3, МУЭЗНХҮЧ-8.3.3, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 4.1.13, 4.4.4, НХБХҮАТ- 6.6.1, “Ногоон хөгжлийн бодлого”-ын баримт бичгийн 3.6.2.							
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12	
	Шаардагдах хөрөнгө	-							
	Хариуцах нэгж	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах шинжээч Д. Бэлэгсайхан							
	Суурь түвшин	2-р улиралд хүрсэн чанарын болон тоон утга: Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг БХБ-ын болон ХЗДХ-ын сайд нар 2019.02.14-ний өдөр тус тус баталсан.							
	Шалгуур үзүүлэлт	1.Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал боловсруулагдсан байна. 2.Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдсан байна.							
	Хүрэх түвшин	4-р улиралд: Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газарт өргөн мэдүүлнэ.							
	Хэрэгжилт	“Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах” ажлын хүрээнд тус яамны ахлах мэргэжилтэн							

Арга хэмжээний хэрэгжилт		<p>Д.Бэлэгсайхан, Д.Болормаа, М.Гантөмөр, мэргэжилтэн Б.Нямдаш, зөвлөх архитектор Э.Дондмаа нар болон Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөх багийн хуулийн зөвлөх А.Дэлгэрмаагийн хамт хуулийн төслийн хувилбар, хуулийг дагалдан гарах "Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх тайлан", "Хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан"-ийн судалгааны ажил, хуулийн төслийг даган холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан. Уг ажлын хүрээнд ажлын хэсэг нийт 16 удаа вакуумжсан орчинд ажиллаж, ажлын хэсгээс Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд хуулийн төслийг 2019.09.20, 2019.10.07-ний өдөр тус тус танилцуулан санал авч, тухай бүр холбогдох засваруудыг оруулсан. Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2019.10.09-ний өдөр Холлидэй Инн зочид буудалд зохион байгуулж, тус хэлэлцүүлэгт 60 гаруй хүмүүс оролцож санал өгсөн. Хэлэлцүүлгээс өгөгдсөн саналыг судлан үзэж, хуулийн төсөлд тусгах ажлыг 2019.10.10-11-ний өдрүүдэд зохион байгуулж, холбогдох тодотгол, засварыг оруулсан. Ажлын хэсгийн хурлыг 2019.10.16-ны өдөр зохион байгуулж, хуралд 20 хүн оролцон саналаа өгсөн. Хуулийн төслийн эцсийн найруулгын саналыг 2019.10.21-ний өдөр боловсруулж, хуулийн төслийг БХБ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар 2019.10.22-ны өдөр хэлэлцүүлсэн. Тус Зөвлөлийн гишүүдээс гарсан саналуудыг тусган хуулийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4131 тоот, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4132 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Сангийн яамны холбогдох хүмүүстэй 2019.11.19-ны өдөр уулзаж тодруулга, тайлбар өгч, хуулийн төсөлтэй холбоотой бүх холбогдох материалыг 2019.11.08-ны өдөр bilquun_e@mof.gov.mn цахим хаягаар, 2019.11.19-ны өдөр zolboo_t@mof.gov.mn цахим хаягаар тус тус хүргүүлсэн. Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамны холбогдох мэргэжилтэнтэй 2019.12.04-ний өдөр тус тус уулзаж тайлбар, тодруулга өгсөн.</p> <p>Сангийн яамны 2019.12.06-ны өдрийн 6/8044 тоот албан бичгээр санал ирүүлсний дагуу хуулийн төсөлд холбогдох засвар, өөрчлөлтүүдийг оруулж саналын тавьёогийг боловсруулж дахин зөвшөөрөл авахаар 2019.12.10-ны өдрийн 01/4597 тоот албан бичгийг, мөн урьдчилсан байдлаар 2019.12.09-ний өдөр асуудал хариуцсан мэргэжилтэн Бат-Эрдэнэд цахим шуудангаар хүргүүлсэн. ХЗДХЯ-ны боловсруулсан саналыг урьдчилсан байдлаар авч саналын дагуу холбогдох засвар, саналын товъёогийг боловсруулж, 2019.12.09-ний өдөр ХЗДХЯ-ны асуудал хариуцсан мэргэжилтэн Нарантунгалагт цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>Хуулийн төслийг ЗГ-ын 2019.12.18-ний өдрийн 55-р хуралдаанаар хэлэлцэж, дэмжигдсэн. УИХ-аар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар СЯ-нд 2019.12.23-ны өдрийн 01/4816 тоот албан бичгээр, ХЗДХЯ-нд 2019.12.23-ны өдрийн 01/4817 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p>
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт -100 хувь
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

Гүйцэтгэлийн зорилт №2.1.4-ийн үр дүн: Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
			Өмнөх улирал	Төл.	Гүй
1	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал боловсруулагдсан байна.	Хуулийн үзэл баримтлал 1 Хуулийн төсөл 1	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан.	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газарт өргөн мэдүүлнэ.	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг БХБ-ын болон ХЗДХ-ын сайд

	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдсан байна.				нар 2019.02.14-ний өдөр тус тус баталсан. Хуулийн төслийг боловсруулж, Сангийн яам, ХЗДХЯ-аас холбогдох зөвшөөрлийг авч, ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хуулийн төслийг ЗГ-ын 2019.12.18-ний өдрийн 55-р хуралдаанаар хэлэлцэж, дэмжигдсэн. УИХ-аар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар СЯ-нд 2019.12.23-ны өдрийн 01/4816 тоот албан бичгээр, ХЗДХЯ-нд 2019.12.23-ны өдрийн 01/4817 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.
--	--	--	--	--	--

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.5. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн нэгдсэн тээвэр, логистик, дэд бүтцийг хөгжүүлж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлнэ.

Төлөвлөлтийн уялдаа: “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын баримт бичгийн 3.3.3.12, 3.3.3.13

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.5.1. Хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	ЗГҮАХХАХТ-5.6.7.7, 5.6.7.8, МУЭЗН-ийг 2019онд ХҮЧ-ийн 8.3, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын баримт бичгийн 3.3.1, 3.3.3						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	214.2 сая төгрөг						
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах мэргэжилтэн Б.Нямдаш						
	<i>Суурь түвшин</i>	Замын-Үүд хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зураг төслийн “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-тай 152 тоот гэрээ байгуулан боловсруулж байна. Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зураг төслийн “Нью-урбанизм” ХХК-тай 155 тоот гэрээ байгуулан боловсруулж байна. Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зураг төслийн гэрээг “Идеал групп” ХХК-тай 153 тоот гэрээ байгуулан боловсруулж байна.						
<i>Шалгуур үзүүлэлт</i>	Замын-Үүд, Алтанбулаг, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулагдсан байна.							

	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: Замын-Үүд, Алтанбулаг, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын явцын тайланг хүлээн авсан байна. Замын-Үүд, Алтанбулаг, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулагдсан байна.
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	<p>Замын-Үүд хилийн боомтын ХЕТ боловсруулах 2018/67/СС/305 тоот зургийн даалгавар, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 2018/65/СС/305 тоот зургийн даалгаврыг 2018.12.28-ны өдөр тус тус батлуулсан. Замын-Үүд хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 152 дугаар гэрээг “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-тай 2018.07.19-ны өдөр, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 155 дугаар гэрээг “Нью урбанизм” ХХК-тай 2018.07.23-ны өдөр, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 153 дугаартай гэрээг “Идеал групп” ХХК-тай 2018.07.19-ны өдөр тус тус байгуулж, ирүүлсэн эхлэлийн тайлан зэргийг хянан холбогдох актыг тус тус үйлдэн баталгаажуулсан. Замын-Үүд хилийн боомтын төлөвлөлтийн ажилтай холбогдуулан холбогдох байгууллагуудаас саналыг авсан.</p> <p>“Алтанбулаг” хилийн боомтын ажилтай холбогдуулан МХАҮТ-тай хамтран хувийн хэвшлийнхнийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p> <p>Мөн Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын хүрээнд Сангийн яам, Хилийн боомтын үндэсний зөвлөлөөс 2019.02.02-ны өдрийн 11/881 тоот албан бичгээр санал ирүүлснийг гүйцэтгэгч компанид 2019.03.01-ний өдрийн 06/734 тоот албан бичгээр холбогдох саналыг хүргүүлсэн. Мөн тус хилийн боомтод хэрэгжихээр төлөвлөгдөж буй төсөл, хөтөлбөрүүдийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажилтай уялдуулах үүднээс боомтын шалган нэвтрүүлэхийн төлөвлөлт хийж буй “Татах хүч” ХХК-д 2019.06.03-ны өдрийн 06/2081 тоот албан бичгийг хүргүүлсэн. Тус газрын дарга Б.Гүнболд тус хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын явцын талаар гүйцэтгэгч компанийн төлөөлөл, захиалагчийн хяналт гүйцэтгэж буй БХТ-ийн төлөөлөл нартай уулзалтыг 2019.11.01-ний өдөр хийсэн. “Алтанбулаг”, “Замын-Үүд” хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажилд магадлал хийх ажилтай холбогдуулан “Орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг байгуулах тухай” БХБ-ын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 177, 180 дугаар тушаал гарч, гүйцэтгэгч “Нью урбанизм” ХХК, “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ газар, БХТ-д 2019.11.08-ны өдрийн 03/4228 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>“Алтанбулаг”, “Замын-Үүд” хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө гүйцэтгэж буй “Нью урбанизм” ХХК 2019.10.31-ний өдрийн №-ну/215, “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ 2019.10.11-ний өдрийн №02/480 тоот, “Бичигт” хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж буй гүйцэтгэгч “Идеал групп” ХХК эцсийн шатны тайланг БХТ-д 2019.12.06-ны өдрийн 046/2019 тоот албан бичгээр тус тус эцсийн шатны тайланг БХТ-д хүргүүлж тайлан хянагдсан. Замын-Үүд хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэл 2019.12.04-ний өдрийн 1/3630 тоот, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэлийг 2019.12.06-ны өдрийн 1/3717 тоот албан бичгээр БХТ-өөс тус яаманд ирсэн бөгөөд тус тус хянагдаж байна.</p> <p>Тус хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ, БХБ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг зохион байгуулж байна.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	---
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт – 100 хувь
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

Гүйцэтгэлийн зорилт №2.1.5-ийн үр дүн: Хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин			Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Өмнөх улирал			Жилийн эцэс	
						Төл.	Гүй
1	Замын-Үүд, Алтанбулаг, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулагдсан байна.	Боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 3	Замын-Үүд хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зураг төслийн “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-тай 152 тоот гэрээ байгуулан боловсруулж байна. Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зураг төслийн “Нью-урбанизм” ХХК-тай 155 тоот гэрээ байгуулан боловсруулж байна. Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зураг төслийн гэрээг “Идеал групп” ХХК-тай 153 тоот гэрээ байгуулан боловсруулж байна.	Замын-Үүд, Алтанбулаг, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын явцын тайланг хүлээн авч, Замын-Үүд, Алтанбулаг, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулагдсан байна.	Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэлийг 2019.12.04-ний өдрийн 1/3630 тоот, 2019.12.06-ны өдрийн 1/3717 тоот албан бичгээр БХТ-өөс тус яаманд ирүүлж, хянагдаж байна. Тус хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ, БХБ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг зохион байгуулж байна.		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.6. Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” жишиг хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

Төлөвлөлтийн уялдаа: “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 6.1.2

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин								
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.6.1. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу аймгийн төвүүд болон 15000-аас дээш хүн амтай суурин газрыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлаар холбогдох тооцоо, судалгааг хийх.								
	Төлөвлөлтийн уялдаа:	ЗГҮАХХАХТ-5.1.21, НХБХУАТ-6.1.2							
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12	
	Шаардагдах хөрөнгө	-							
	Хариуцах нэгж	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Шинжээч М.Гантөмөр							
	Суурь түвшин	2-р улиралд хүрсэн чанарын болон тоон утга. Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 дугаар захирамжаар “Зарим хотуудад улсын зэрэглэл							

		<p>тогтоох тухай” асуудлын хууль, эрх зүйн орчныг судлан дүгнэлт гаргах” үүрэг бүхий ажлын хэсгийг, тус ажлын хэсгийг шаардлагатай судалгаа, тооцоо, бусад мэдээллээр хангах үүрэг бүхий Техникийн ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тушаалаар тус тус байгуулсан.</p> <p>Аймгийн төвүүд болон 15000-аас дээш хүн амтай суурин газрыг улсын зэрэглэлтэй хот болгох тухай асуудлыг шийдвэрлэхээр УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл, практик хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу урьдчилан тандан судалсан бөгөөд уг судалгааны үр дүнд “Хот нь улсын болон аймгийн зэрэглэлтэй эсэхээс үл хамаарч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болдоггүй тул Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, “хот”-ыг засаг захиргааны нэгж болгох асуудлыг шийдвэрлүүлэх, үүний үр дүнд аймаг, сум, хотын удирдлагын давхцалыг арилгах нь зүйтэй” гэсэн зөвлөмжийн хувилбарыг боловсруулсан.</p> <p>Тус үнэлгээний тайланд уг асуудлыг цогцоор шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах нь илүү нөлөөтэй бөгөөд гагцхүү Үндсэн хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах, “Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-өөр аймгуудын нийгэм-эдийн засгийн таталцал, орон нутгийн хөгжлийн чадавхи, нөөцөд тулгуурлан аймаг, сумдын бүлэг суурингийн тогтолцоо буюу сумдын бүсчлэл, сум дундын төвүүдийг тогтоох чиглэлийг судалснаар уг асуудлыг шийдвэрлэх нь тохиромжтой гэсэн дүгнэлт, зөвлөмж гарсан.</p>
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	“Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн хүрээнд аймгуудын нийгэм-эдийн засгийн таталцал, орон нутгийн хөгжлийн чадавхи, нөөцөд тулгуурлан аймаг, сумдын бүлэг суурингийн тогтолцоог тогтоох судалгаа, тооцоог хийх.
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: “Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн хүрээнд холбогдох судалгааны ажил боловсруулагдсан байна.
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>ЗГХЭГ-т хүргүүлсэн “Зарим хотуудад улсын зэрэглэл тогтоох” тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайланд “Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-өөр аймгуудын нийгэм-эдийн засгийн таталцал, орон нутгийн хөгжлийн чадавхи, нөөцөд тулгуурлан аймаг, сумдын бүлэг суурингийн тогтолцоо буюу сумдын бүсчлэл, сум дундын төвүүдийг тогтоох чиглэлийг судалснаар уг асуудлыг шийдвэрлэх нь тохиромжтой гэсэн дүгнэлт, зөвлөмж гарсны дагуу уг төслийн хүрээнд хот, суурин газарт улсын зэрэглэл тогтоох асуудлаар судалгаа ирүүлэх тухай 2019.11.04-ны өдрийн 02/4120 тоот албан бичгийг хүргүүлсэн.</p> <p>Тус төслийн судалгааны өнөөгийн байдлын дүн шинжилгээнд тулгуурлан судалгаа, тооцоо, саналыг боловсруулж, 2019.11.28-ний 1/3505 тоот албан бичгээр ирүүлж, уг саналд Дархан, Эрдэнэт, Чойр гэсэн 3 улсын зэрэглэлтэй хотоос Чойр хотыг хасч, бүсийн тулгуур төв болон хүн амын тоо, өсөлт, нийгэм-эдийн засгийн таталцал, хөгжлийн нөөц, чадавхи, стратегийн ач холбогдол зэргийг харгалзан Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Ховд, Мөрөн, Замын-Үүд хотыг улсын зэрэглэлтэй, үлдэх 16 аймгийн төв болон Сэлэнгэ аймгийн Зүүнхараа, Хөтөл, Хөвсгөл аймгийн Хатгал, Өвөрхангай аймгийн Хархорин, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Завхан аймгийн Тосонцэнгэл, Ховд аймгийн Булган Дархан-Уул аймгийн Шарын гол, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдыг аймгийн зэрэглэлтэй хотоор тодорхойлох хувилбарын тооцоолол, судалгааг боловсруулсан.</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтоох, хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ шийдвэрлэнэ гэж заасны дагуу удирдлагын давхардлыг арилгаж, хотуудын засаглалын эрх мэдэл нэмэгдэх боломжтой болсон.</p>

	Зарцуулсан хөрөнгө	----
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт – 100 хувь
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

Гүйцэтгэлийн зорилт №2.1.6-ийн үр дүн: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу аймгийн төвүүд болон 15000-аас дээш хүн амтай суурин газрыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлаар холбогдох тооцоо, судалгаа хийгдсэн байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	“Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн хүрээнд аймгуудын нийгэм-эдийн засгийн таталцал, орон нутгийн хөгжлийн чадавхи, нөөцөд тулгуурлан аймаг, сумдын бүлэг суурингийн тогтолцоог тогтоох судалгаа, тооцоог хийнэ.	Судалгааны ажил 1	УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл, практик хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу урьдчилан тандан судалсан бөгөөд уг судалгааны үр дүнд “Хот нь улсын болон аймгийн зэрэглэлтэй эсэхээс үл хамаарч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болдоггүй тул Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, “хот”-ыг засаг захиргааны нэгж болгох асуудлыг шийдвэрлүүлэх, үүний үр дүнд аймаг, сум, хотын удирдлагын давхцалыг арилгах нь зүйтэй” гэсэн зөвлөмжийн хувилбарыг боловсруулсан.	“Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн хүрээнд холбогдох судалгааны ажил боловсруулагдсан байна.	Тус төслийн судалгааны өнөөгийн байдлын дүн шинжилгээнд тулгуурлан судалгаа, тооцоо, саналыг боловсруулж, 2019.11.28-ний 1/3505 тоот албан бичгээр ирүүлсэн.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.7. Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” жишиг хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

Төлөвлөлтийн уялдаа: “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 6.1.4, 6.6.3

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
---	--

Арга хэмжээний нэр, дугаар	2.1.7.1.Аймгийн төв болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудыг түшиглэн хөгжих хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	МУЭЗН-ийг 2019ондХҮЧ-ийн 8.3, МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын1, ЗГҮАХХАХТ-2.85.4, НХБХҮАТ-6.1.4, 6.1.8, Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.3.3.15, НХБХҮАТ-6.6.3, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 4.4.3				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Улирал</i>	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	1458.2 сая төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд				
	<i>Суурь түвшин</i>	2018 оны байдлаар: Дархан-Уул, Архангай, Хэнтий, Завхан, Өвөрхангай аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулах ажлын даалгавар боловсруулагдаж батлагдсан.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1.Дархан-Уул, Архангай, Хэнтий, Завхан, Өвөрхангай аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулах ажлын явцын тайланг хүлээн авсан байна. 2.Хот байгуулалтын баримт бичгийг Мэргэжлийн зөвлөл, ШУТТЗ болон сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, улсын экспертизийн дүгнэлт гаргуулж, Архангай, Өвөрхангай аймгийн холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж батлуулсан байна. 3.Бүсийн тулгуур төвүүд болох Дархан-Уул, Хэнтий, Завхан аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.				
<i>Хүрэх түвшин</i>	<p>Эхний хагас жилд:Дархан-Уул, Архангай, Хэнтий, Завхан, Өвөрхангай аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулах ажлыг эхлүүлж явцын тайланг хүлээн авсан байна.</p> <p>Жилийн эцэст: - Дархан-Уул, Архангай, Хэнтий, Завхан, Өвөрхангай аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг Мэргэжлийн зөвлөл, ШУТТЗ болон БХБ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох зөвлөмж, шийдвэр гарсан байна.</p> <p>- Дархан-Уул, Архангай, Хэнтий, Завхан, Өвөрхангай аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичигт улсын экспертизийн дүгнэлт гарсан байна.</p> <p>- Архангай, Өвөрхангай аймгийн холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж батлуулсан байна.</p> <p>- Бүсийн тулгуур төвүүд болох Дархан-Уул, Хэнтий, Завхан аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.</p>					
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Архангай аймгийн төв Цэцэрлэг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 157 дугаартай гэрээг “Өрх” ХХК-тай 2018.07.23-ны өдөр, Завхан аймгийн төв Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 156 дугаартай гэрээг “Некст степ инженеринг” ХХК-тай 2018.07.23-ны өдөр, Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 150 дугаартай гэрээг “Зууны гүүр” ХХК-тай 2018.07.18-ны өдөр, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 151 дугаартай гэрээг “Эрхэт констракшн” ХХК-тай 2018.07.18-ны өдөр тус тус байгуулж, ирүүлсэн эхлэлийн тайлангуудыг хянан үзэж, холбогдох актыг тус тус үйлдэн баталгаажуулсан.</p> <p>Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд уг ажлын зөвлөх “Арт констракшн” ХХК-ний төлөөлөлтэй 2019.04.02-ны өдөр БХБ-ын дэд сайд Б.Мөнхбаатар, ХБГХБХЗГ-ын дарга Б.Гүнболд, мөн газрын мэргэжилтэн Э.Ариунням нар уулзав. Тус уулзалтаас тус яамны дэд сайдын өгсөн үүрэг даалгаврын дагуу Төвийн бүсийн тулгуур төв Дархан хотыг хөгжлийн ерөнхий</p>				

		<p>төлөвлөгөөний төслийг холбогдох шатны хурал, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019.04.22-ны өдрийн А/64 дугаар байгуулан ажиллаж байна.</p> <p>Дархан-Уул аймгийн төв Дархан хотыг “Жишиг хот” болгон хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын явц 60 хувьтай, Архангай, Завхан, Өвөрхангай, Хэнтий аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын төлөвлөлтийн шийдлийг орон нутгийн байгууллагуудаар хэлэлцүүлэх болон эдгээр аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн 2019 оны 06 сарын 17-ны өдрийн хурлаар Хэнтий, Завхан, 2019 оны 10 сарын 08-ны өдрийн хурлаар Өвөрхангай аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тус тус хэлэлцүүлсэн. Архангай аймгийн төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган хурлын тов хүлээж байгаа болно. Газрын дарга Б.Гүнболд тус аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын явцын талаар гүйцэтгэгч компанийн төлөөлөл, захиалагчийн хяналт гүйцэтгэж буй БХТ-ийн төлөөлөл нартай 2019 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр уулзалтыг хийсэн. Хэнтий аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгэгч “Эрхэт констракшн” ХХК 2019.10.30-ны өдрийн 79/2019 тоот, Архангай аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгэгч “Өрх” ХХК 2019.11.14-ны өдрийн 3 тоот, Завхан аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгэгч “Некст степ инженеринг” ХХК 2019.11.21-ний өдрийн 79 тоот эцсийн шатны тайлангаа БХТ-д хургуулсан бөгөөд тайлан хянагдаж, Архангай, Завхан, Хэнтий, Өвөрхангай аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэлийг 2019.12.06-ны өдрийн 1/3717 тоот албан бичгээр БХТ-өөс тус яаманд ирүүлсэн бөгөөд гүйцэтгэл хянагдаж байгаа болно.</p> <p>Завхан, Архангай, Өвөрхангай, Хэнтий аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг холбогдох орон нутгийн ИТХ-аар хэлэлцүүлж дэмжигдсэн.</p>
	Зарцуулсан хөрөнгө	
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт – 70 хувь
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

Гүйцэтгэлийн зорилт №2.1.7-ийн үр дүн: Дархан-Уул, Архангай, Хэнтий, Завхан, Өвөрхангай аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулагдсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
			Өмнөх улирал	Төл.	Гүй
1	1. Дархан-Уул, Архангай, Хэнтий, Завхан, Өвөрхангай аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулах ажлын явцын тайланг хүлээн авсан байна. 2. Хот байгуулалтын баримт бичгийг Мэргэжлийн зөвлөл, ШУТТЗ	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 5	Дархан-Уул, Архангай, Хэнтий, Завхан, Өвөрхангай аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулах ажлын даалгавар боловсруулагдаж батлагдсан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	- Архангай, Өвөрхангай аймгийн холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж батлуулсан байна. - Бүсийн тулгуур төвүүд болох Дархан-Уул, Хэнтий, Завхан аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Завхан, Архангай, Өвөрхангай, Хэнтий аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг холбогдох орон нутгийн ИТХ-аар хэлэлцүүлж дэмжигдсэн.

болон сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, улсын экспертизийн дүгнэлт гаргуулж, Архангай, Өвөрхангай аймгийн холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж батлуулсан байна. Бүсийн тулгуур төвүүд болох Дархан-Уул, Хэнтий, Завхан аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.		тусгай зөвшөөрөл бүхий нэгжүүд сонгон шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, ажлаа эхлүүлсэн.		
---	--	---	--	--

Гүйцэтгэлийн зорилт № 2.1.8. Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” жишиг хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

Төлөвлөлтийн уялдаа: “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 6.1.6

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.8.1. Хөшигийн хөндийд баригдах олон улсын нисэх буудлыг даган бий болох жишиг “ухаалаг” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол болон эхний ээлжийн барилгажилтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	ЗГҮАХХАХТ-2.84.3, НХБХҮАТ-6.1.6, ЭЗСХ-2.2.5, НХБХҮАТ-6.1.4,						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө							
	Хариуцах нэгж	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах мэргэжилтэн Б.Нямдаш Шинжээч М.Гантөмөр						
	Суурь түвшин	2-р улиралд хүрсэн чанарын болон тоон утга: Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдсан Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлаар БНСУ-ын хамтын ажиллагааны KSP программын хүрээнд KDI институттай хамтран эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлаар 2019 оны 5 дугаар сард судалгааны ажлыг эхлүүлсэн.						
	Шалгуур үзүүлэлт	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталсан Засгийн газрын тогтоол гарсан байна. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлаар судалгаа хийгдсэн байна.						
	Төлөвлөлтийн уялдаа:	Монгол Улсын төсөвийн тухай хууль, (МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), (ЗГҮАХХАХТ-2.11.3), Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого.												
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Шаардагдах хөрөнгө	-												
	Суурь түвшин	2018 оны байдлаар: "Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого" /2018-2028/-ын баримт бичигт ажлын хэсэгт "Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх" чиглэлээр саналыг боловсруулж хүлгүүлэн тусгуулсан.												
	Шалгуур үзүүлэлт	Боловсруулсан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн тоо												
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Холбогдох бодлогын баримт бичигт нийцүүлсэн боловсруулсан инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээрх урт болон бонгино хугацааны төлөвлөлтийн саналыг боловсруулж танилцуулсан байна. Жилийн эцэст: 3-аас доошгүй бодлогын санал боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн байна.												
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>1. "Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого" /2018-2028/-ын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбоотой "Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого тодорхойлох" чиглэлээр саналыг боловсруулж БТГ-т хүргүүлэн, саналуудыг тусгасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Барилга, хот байгуулалтын салбарт 2019-2022 онд баримтлах дунд хугацааны стратеги төлөвлөгөөний төсөлд инженерийн дэд бүтцийн чиглэлээр хийгдэх ажлуудыг тусган нэгтгэж, газрын даргаар баталгаажуулан 2019.02.18-ны өдөр БТГ-т хүргүүлсэн. 2. Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд инженерийн дэд бүтцийн чиглэлээр тусгуулах саналыг холбогдох маягт, хавсралтын дагуу боловсруулан хүргүүлсэн. 3. БХБЯ-ны ТНБД-ын 2019.06.05-ны өдрийн А/88 тоот тушаалаар байгуулагдсан Монгол Улсын урт хугацааны бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын чиглэлээр тусгах санал боловсруулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж урт хугацааны хөгжлийн бодлого /2020-2045/, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө /2020-2025/-г хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилттэй уялдуулан боловсруулж саналыг маягт 1-10-ын дагуу холбогдох тооцооллыг гарган ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн засвар шүүмж, саналыг тусган 2019.07.23, 2019.09.13-нд ажлын хэсэгт файлаар болон цаасаар хүргүүлсэн ба эцсийн байдлаар дахин санал авч саналыг боловсруулан 2019.12.02-нд ББМҮБХЗГ-т хүргүүлсэн. 4. "МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО 2020-2050 ОН"-ын төсөлд тусгах барилга, хот байгуулалтын салбарын санал /30 жил/ (2020-2050 он)-д инженерийн дэд бүтцийн чиглэлээр I /2021-2030/, II /2031-2040/, III /2041-2050/ гэсэн 3 үе шаттын хүрээнд үе шат тус бүрд зорилт дэвшүүлж, зорилт тус бүрийн хүрэх үр дүн, тухайн үр дүнд хүрэхийн тулд хийгдэх үйл ажиллагаа гэсэн бүтэцтэйгээр саналыг боловсруулан БТГ-т 2019.11.22-нд хүргүүлсэн. 												

	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт – 100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин													
Арга хэмжээний нэр, дугаар	5.1.2.2. Хууль, тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх.													
	Төлөвлөлтийн уялдаа:	(МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого 2.2.3, ЗГҮАХХАХТ												
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Шаардагдах хөрөнгө	-												
	Суурь түвшин	2018 оны байдлаар: “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого” /2018-2028/-ын баримт бичигт ажлын хэсэгт “Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх” чиглэлээр саналыг боловсруулж хүргүүлэн тусгуулсан.												
	Шалгуур үзүүлэлт	Санал өгсөн хууль, бодлогын баримт бичгийн тоо.												
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Санал өгч ажилласан байна. Жилийн эцэст: 5-аас доошгүй хууль, эрх зүйн бодлогын баримт бичигт санал өгч ажилласан байна.												
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>- Барилга, хот байгуулалтын салбарт 2019-2022 онд баримтлах дунд хугацааны стратеги төлөвлөгөөний төсөлд инженерийн дэд бүтцийн чиглэлээр хийгдэх ажлуудыг тусган нэгтгэж, газрын даргаар баталгаажуулан БТГ-т хүргүүлсэн.</p> <p>- БХБЯ-ны ТНБД-ын 2019.06.05-ны өдрийн А/88 тоот тушаалаар байгуулагдсан Монгол Улсын урт хугацааны бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын чиглэлээр тусгах санал боловсруулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж урт хугацааны хөгжлийн бодлого /2020-2045/, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө /2020-2025/-г хүчин төгөлдөр үйлчилж байгаа урт хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтэй уялдуулан боловсруулж саналыг холбогдох маягт 1-10 дагуу холбогдох тооцооллыг гарган 2019.06.20-нд ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн засвар шүүмж, саналыг тусган 2019.07.23, 2019.09.13, 2019.12.02-нд ажлын хэсэгт файлаар болон цаасаар хүргүүлсэн.</p> <p>- Эрчим хүчний салбарын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй 2019.06.27-ны өдрийн 01/2504 тоот албан бичгийн ЭХЯ-д хүргүүлсэн.</p> <p>- Баруун бүсийн эрчим хүчний системийн санхүүгийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл санал боловсруулж, 2019.07.02-ны өдрийн 01/2595 тоот албан бичгээр ЭХ-ний Сайдад хүргүүлсэн.</p> <p>- Эрчим хүч хэмнэлтийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд боловсруулсан “Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл болон “Заавал шошго авах бараа, бүтээгдэхүүний жагсаалт” батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж, 2019.10.11-ний өдрийн 01/3851 тоотоор ЭХЯ-д хүргүүлсэн.</p> <p>- “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020-2050 он”-ын төсөлд тусгах барилга, хот байгуулалтын салбарын санал /30 жил/ (2020-2050 он)-д инженерийн дэд бүтцийн чиглэлээр I /2021-2030/, II /2031-2040/, III /2041-2050/ гэсэн 3 үе шаттын хүрээнд үе шат тус бүрд зорилт дэвшүүлж, зорилт тус бүрийн хүрэх үр дүн, тухайн үр дүнд хүрэхийн тулд хийгдэх үйл ажиллагаа гэсэн бүтэцтэйгээр саналыг боловсруулан БТГ-г 2019.11.22-нд хүргүүлсэн.</p> <p>- Сангийн яамнаас боловсруулсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын төслийг судлан танилцаж, аргачлал нь оновчгүй учраас нэн тэргүүнд хийгдэх инженерийн шугам сүлжээний төсөл, арга хэмжээ нь нилээн доогуур, ач холбогдол багатайд тооцогдохоор шинжилгээний дүн гарч байгаа тул уг журмыг батлуулж, хэрэглэхээс өмнө шалгуур үзүүлэлтээр тодорхойлж буй аргачлалыг маш зөв, бодитой байхаар өөрчилж, шинэчлэн</p>												

		<p>боловсруулах, ингэснээр төсөл, арга хэмжээг сонгох, санхүүжилтийг шийдвэрлэх, мөн тухайн жилийн төсвийн төсөлд тусгах ажил бодитой болох талаар санал боловсруулж, Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>- Сангийн яамнаас боловсруулсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын төслийг судлан танилцаж, аргачлал нь оновчгүй учраас нэн тэргүүнд хийгдэх инженерийн шугам сүлжээний төсөл, арга хэмжээ нь нилээн доогуур, ач холбогдол багатайд тооцогдохоор шинжилгээний дүн гарч байгаа тул уг журмыг батлуулж, хэрэглэхээс өмнө шалгуур үзүүлэлтээр тодорхойлж буй аргачлалыг маш зөв, бодитой байхаар өөрчилж, шинэчлэн боловсруулах, ингэснээр төсөл, арга хэмжээг сонгох, санхүүжилтийг шийдвэрлэх, мөн тухайн жилийн төсвийн төсөлд тусгах ажил бодитой болох талаар санал боловсруулж, санал хүргүүлсэн.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	Санал өгсөн хууль, бодлогын баримт бичгийн тоо – 5 Хэрэгжилт – 100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>													
Арга хэмжээний нэр, дугаар	5.1.2.3. Инженерийн дэд бүтцийн мэдээллийн санд 21 аймгийн инженерийн дэд бүтцийн мэдээллийг оруулах, баяжилт хийх ажлыг зохион байгуулах, зохицуулахад тусалцаа үзүүлнэ.													
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Монгол Улсын төсөвийн тухай хууль, (МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), (ЗГҮАХХАХТ-2.11.3), Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого.												
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-												
	<i>Суурь түвшин</i>	2018 оны байдлаар: "Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах" ажлын хүрээнд 19 аймгийн инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан үүссэн ба зураглал, мэдээллийн сан, программ хангамжийг ашиглах, баяжуулалт хийх чиглэлээр Барилга хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын холбогдох хариуцсан мэргэжилтэн нэвтрэх эрхээ авсан.												
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Инженерийн дэд бүтцийн мэдээллийн баяжилт, хувь /50%/												
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Журмын төсөлд санал өгч ажилласан байна Жилийн эцэст: Журмын төслийг батлуулж, мэдээллийн санг дэлгэрүүлсэн байна.												
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>- "Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх журам"-ыг 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр БХБ сайдын 74 дүгээр тушаалаар батлуулсан.</p> <p>- Нийслэл, 21 аймгийн инженерийн шугам сүлжээний өнөөгийн байдлын хүчин чадал /цэвэр, бохир ус, дулаан, цахилгаан, холбоо, үерийн далан суваг, ус зайлуулах шугам г.м/, мөн 2016-2019 онд инженерийн шугам сүлжээний хангамжийг нэмэгдүүлэхэд шинээр болон шинэчлэх өргөтгөх чиглэлээр хийсэн ажил, 2020-2024 онд хийгдэх инженерийн шугам сүлжээний мэдээллийг 21 аймгаас авч, хүчин чадал, төсөвт өртгийн тооцоог график болон хүснэгтээр гаргаж, ИШС-ний мэдээллийн баазыг нэмэгдүүлсэн бөгөөд энэ талаар дэлгэрэнгүй таницуулга /пресентаци/ бэлтгэж, Засгийн газарт танилцуулсан.</p>												
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-												
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт – 100%												
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>														

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>
	5.1.2.4. 2019 оны тодотгол, 2020-2022 онд улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хийгдэх инженерийн дэд бүтцийн ажлуудын судалгаа, зураг төсөл,

Арга хэмжээний нэр, дугаар	ТЭЗҮ хийхэд шаардагдах хөрөнгө санхүүжилтийн тооцоо судалгааг аймаг, нийслэлээс авч нэгтгэн боловсруулж холбогдох газарт хүргүүлнэ.													
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Монгол Улсын төсөвийн тухай хууль, (МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), (ЗГҮАХХАХТ-2.11.3), Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого.												
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Улсын төсөв 2020-2021 онд 465,0 тэрбум. /төслийн санал/												
	<i>Суурь түвшин</i>	<p>2018 оны байдлаар:</p> <p>- МУ-ын Ерөнхий сайдад салбарын бүтээн байгуулалтын ажлын явц болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад санал болгох томоохон төслүүдийн талаар мэдээлэл хийхтэй холбогдуулан инженерийн дэд бүтцийн чиглэлээр хийгдэж буй ажил болон цаашид шийдвэрлэх асуудлуудын талаар Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын газар, Нийслэлийн орон сууц корпорац, Нийслэлийн гэр хорооллын инженерийн дэд бүтцийн газрууд болон Инженерийн шугам сүлжээний газруудтай хамтран танилцуулга бэлтгэж, Барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний шаардлагатай хөрөнгө оруулалтын санал, жагсаалтыг гаргаж, тайлбар, үндэслэл, зураг төсөл, ТЭЗҮ зэрэг холбогдох хавсралт материалуудын хамт БХБ-ын дэд сайд болон Нийслэлийн орлогч даргад 2018.05.26-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>- Засгийн газрын 2017.06.20-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор БНХАУ-ын Засгийн газраас МУ-ын Засгийн газарт олгох 2.0 тэрбум юаны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан. Энэ ажлын хүрээнд уг тогтоолын хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээний талаар БХБЯ-ны БТГ, ИДББХЗГ, Нийслэлийн орлогч дарга, Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, НХТЭТГ-ын Инженерийн дэд бүтцийн хэлтэс хамтран 2018.04.10-ны өдөр хуралдаж төслийг эрэмбэлэж ажлын тоо хэмжээ, нэр, байршлыг тодорүүлсан бөгөөд жагсаалтад орсон ажлуудын ажлын тоо хэмжээг эцэслэж, давхцал, гүйцэтгэлийн нарийвчилсан судалгаа, мэдээллийг гаргаж нэгтгэн 2018.04.20-ны өдөр Нийслэлийн орлогч даргад танилцуулахаар хүргүүлсэн</p>												
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Аймаг, нийслэлээс санал авч, шаардагдах санхүүжилтийн тооцоог боловсруулж, холбогдох газарт хүргүүлж, тусгуулах.												
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Төсөвт тусгах санал, мэдээлэл, тооцоо судалгааг аймаг, нийслэлээс авч, бэлтгэсэн байна. Жилийн эцэст: Шаардлагатай тооцоо судалгааг гаргаж, мэдээлэл бэлтгэн, холбогдох газарт хүргүүлж, тусгуулсан байна.												
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>- Монгол Улсын төсвийн 2020 оны төсвийн төсөлд санал оруулахтай холбогдуулан нийслэл, 21 аймгийн инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний чиглэлээрх 66 төсөл арга хэмжээний зардлын шинжилгээний маягт, төсөл арга хэмжээ бүрээр бөглөх 30 асуулгыг боловсруулж, зураг төслийн нүүр, магадлалын дүнэлтийг цаасаар болон файлаар жагсаалт гарган нэгтгэж албажуулан БТГ-т 2019.06.08-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>- Монгол Улсын хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлд Нийслэлд 36.8 км инженерийн шугам сүлжээ, 31.2 тэрбум, аймаг орон нутагт 68.2 км инженерийн шугам сүлжээ, 53.8 тэрбум төгрөг нийт 85,0 тэрбум төгрөг шаардлагатай тул холбогдох саналыг боловсруулж БТГ-т хүргүүлсэн.</p> <p>- Монгол Улсын төсвийн 2020 оны төсвийн санал боловсруулахтай холбогдуулан нийслэл, 15 аймгийн инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний нийт 46 төсөл арга хэмжээ, инженерийн бэлтгэл арга хэмжээний чиглэлээр нийслэл, 6 аймгийн 20 төсөл арга хэмжээний саналыг авч, зардлын шинжилгээний маягтад төсөл арга хэмжээ тус бүрээр 30 асуулагд бөглөж, зураг төсвийн нүүр, магадлалын дүгнэлтийн файл, шаардагдах материалыг 2019.08.13-ны өдөр Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.</p> <p>- Монгол Улсын хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлд үерийн хамгаалалтын барилга байгууламжийн чиглэлээрх 21 аймгийн үерийн эрсдэлийн үнэлгээ хийх, зураглал боловсруулахад</p>												

		шаардлагатай 5 багц ажилд 2 тэрбум төгрөг, орон нутгийн батлагдсан зураг төсөвтэй 5 байршилд 64,9 тэрбум төгрөгийн 86 км үерийн далангийн шууд хөрөнгө оруулалт, мөн Улаанбаатар хотын 9 дүүргийн шинээр газар олгогдож байгаа 52 байршлын 15300 га талбай, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр зэрэг шаардлагатай бүсүүдэд хайгуул судалгаа, зураг төсөв боловсруулахад 2.0 тэрбум төгрөг, Улаанбаатар хотод шинээр 5 байршилд 72,3 тэрбум төгрөгийн 22 км урт үерийн хамгаалалтын барилга байгууламж, тохижилтын ажлын шууд хөрөнгө оруулалт шаардлагатай тул нийт 139.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын 108 км үерийн далан барьж байгуулах болон хайгуул судалгааны ажлын үндэслэл, тоон мэдээллийг гарган санал хүргүүлсэн. - Сангийн яамнаас ирүүлсэн 2020 оны улсын төсөвт өргөн барьсан жагсаалтад байгаа зарим төсөл арга хэмжээний талаар нэмэлт тайлбар, холбогдох материал, танилцуулга, мэдээллийг бэлтгэж, нотлох баримт болох батлагдсан зураг төсөл, магадлалын дүгнэлт, төсвийн нүүр зэргийг хуулбарлан төсөл арга хэмжээ бүрээр бэлтгэн БТГ-ын ХОУХ-т 2019.10.29-ны өдөр хүргүүлсэн.
	Зарцуулсан хөрөнгө	Улсын төсөв 2020 онд 215,7 тэрбум.төгрөг
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт – 100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

Гүйцэтгэлийн зорилт № 5.1.2-ийн үр дүн: Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, үргэлжлүүлэх төсөл арга хэмжээний тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллээр хангана.үзүүлнэ.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				2019 оны жилийн эцэс	
				Төл.	Гүй.
1	Холбогдох бодлогын баримт бичигт инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх урт болон богино хугацааны төлөвлөлтийн саналыг боловсруулж танилцуулах.	Саналын тоо	“Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого” /2018-2028/-ын баримт бичигт ажлын хэсэгт “Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх” чиглэлээр саналыг боловсруулж хүргүүлэн тусгуулсан.	3-аас доошгүй бодлогын санал холбогдох газарт хүргүүлсэн байна.	100% Салбарын дээрх урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөлтийг тусгаж оруулснаар системтэй хөгжүүлэх нөхцөл бүрдсэн.
2	Хууль, тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх.	Саналын тоо			- “Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх журам”-ыг 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр БХБ сайдын 74 дүгээр тушаалаар батлуулсан. - Нийслэл, 21 аймгийн инженерийн шугам сүлжээний өнөөгийн байдлын хүчин чадал /цэвэр, бохир ус, дулаан, цахилгаан, холбоо, үерийн далан суваг, ус зайлуулах шугам г.м/, мөн 2016-2019 онд инженерийн шугам сүлжээний хангамжийг нэмэгдүүлэхэд шинээр болон шинэчлэх өргөтгөх чиглэлээр хийсэн ажил,

					2020-2024 онд хийгдэх инженерийн шугам сүлжээний мэдээллийг 21 аймгаас авч, хүчин чадал, төсөвт өртгийн тооцоог график болон хүснэгтээр гаргаж, ИШС-ний мэдээллийн баазыг нэмэгдүүлсэн.
3	Инженерийн дэд бүтцийн мэдээллийн баяжилт, хувь /50%/	Баяжилтын хувь	19 аймгийн инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан үүссэн	“Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх журам”-ыг батлуулах.	“Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх журам”-ыг батлуулж, ИШС-ний мэдээллийн баазыг нэмэгдүүлснээр мэдээллийг богино хугацаанд авах, цаашид хийгдэх төлөвлөлтийг бодитой, хэрэгжих үндэслэлтэй боловсруулах нөхцөл бүрдсэн.
4	Аймаг, нийслэлээс санал авч, шаардагдах санхүүжилтийн тооцоог боловсруулж, холбогдох газарт хүргүүлж, тусгуулах.	хөрөнгө оруулалт /төгрөг/	2018-2019 онд 147,2 тэрбум төгрөг	Шаардлагатай тооцоо судалгааг гаргаж, мэдээлэл бэлтгэн, холбогдох газарт хүргүүлж, тусгуулсан байна.	2020-2021 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг бодит тооцоо судалгаан дээр үндэслэн боловсруулж, шаардагдах санхүүжилтийг батлуулснаар төлөвлөлт оновчтой болж, хэрэгжих үндэслэл бүрдсэн.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 5.1.3. “Салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгох, шинээр боловсруулах, үргэлжлүүлэх, техникийн даалгавар боловсруулж батлуулах” ажлыг зохион байгуулах, зохицуулах зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, үргэлжлүүлэх төсөл арга хэмжээний тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллээр хангана.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин													
Арга хэмжээний нэр, дугаар	5.1.3.1. EN 442 Халаах хэрэгсэл. “Радиатор ба конвектор” стандарт боловсруулах ажилд хяналт тавьж, санал өгч хэлэлцүүлэх.													
	Төлөвлөлтийн уялдаа:	Монгол Улсын төсвийн тухай хууль, (МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), (ЗГҮАХХАХТ-2.78), Нормчлалын сангийн төлөвлөгөө-2018, 2019,												
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Шаардагдах хөрөнгө	Нормчлолын сангийн хөрөнгөөр												
	Суурь түвшин	2018 оны байдлаар: EN 442 Халаах хэрэгсэл. “Радиатор ба конвектор” стандарт боловсруулсан.												
	Шалгуур үзүүлэлт	Барилгын дүрэм боловсруулах ажлын явц, хэрэгжилтийн хувь 70%-д хүрсэн байна.												
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: EN 442 Халаах хэрэгсэл. “Радиатор ба конвектор” стандарт боловсруулах ажлыг эхлүүлж, явц, хэрэгжилтийн хувь 100%-д хүрсэн байна. Жилийн эцэст: Стандартчилалын Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.												
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Стандартчилалын Үндэсний зөвлөлийн 2019.11.15-ны өдрийн хурлаар EN 442 Халаах хэрэгсэл. “Радиатор ба конвектор” стандартыг хэлэлцүүлж дэмжигдсэн бөгөөд зөвлөмжийн дагуу дахин редакц /найруулгыг засах/ хийж, 2019.12.03-ын өдөр СҮЗ-д хүргүүлсэн.												

	Зарцуулсан хөрөнгө	Нормчлолын сангийн хөрөнгөөр
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт –100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	5.1.3.2. “Радиатор ба конвектор. Турших арга”-ын стандарт боловсруулах ажилд хяналт тавьж, санал өгч батлуулна.					
	Төлөвлөлтийн уялдаа:	Монгол Улсын төсөвийн тухай хууль, (МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), (ЗГҮАХХАХТ-2.78), Нормчлалын сангийн төлөвлөгөө-2018, 2019				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	5.414.500.0 /таван сая дөрвөн зуун арван дөрөв мянга таван зуун төгрөг /				
	Хариуцах нэгж	Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Батжаргал				
	Суурь түвшин	2018 оны байдлаар: Холбогдох техникийн даалгаварыг батлуулж, ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулсан.				
	Шалгуур үзүүлэлт	Холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн боловсруулсан стандарт.				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Барилгын стандартыг шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. Жилийн эцэст: Барилгын стандартыг батлуулсан байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	“Радиатор, конвекторын турших аргын стандарт” EN442-2 - гүйцэтгэгчээр “Ногоон сууц” ТББ шалгарч, стандартын төслөө ирүүлсэн бөгөөд стандартын төсөлд холбогдох байгууллага, мэргэжлийн холбоодоос санал авч тусгаад Стандарт, хэмжил зүйн газрын Үндэсний зөвлөлд хүргүүлсэн боловч зөвлөл татан буугдсан тул дахин тус газрын Техникийн хороо /ТХ-22/-ын хурлаар хэлэлцүүлж, батлуулахаар 2019.11.20-д хүргүүлсэн. Техникийн хороо /ТХ-22/-ын шийвэр хүлээгдэж байна.				
	Зарцуулсан хөрөнгө	"Ногоон сууц" ТББ -тай 5.414.500.0 /таван сая дөрвөн зуун арван дөрөв мянга таван зуу/ ₮ гэрээ байгуулсан, 40% /2.165.800.0 ₮/-ийг олгосон.				
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт – 70%				
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ						

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	5.1.3.3. Хийн хангамж” /БНБД 42-01-04/ 2008 нэмэлт өөрчлөлт оруулах ажилд бодлого, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж, санал өгч батлуулж ХЗЯ-д бүртгүүлэх.					
	Төлөвлөлтийн уялдаа:	Монгол Улсын төсөвийн тухай хууль, (МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), (ЗГҮАХХАХТ-2.78), Нормчлалын сангийн төлөвлөгөө-2018, 2019,				
	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр, тоо хэмжээг бичнэ үү. 12.0 тэрбум төгрөг
	Хариуцах нэгж	Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Батжаргал
	Суурь түвшин	2018 оны байдлаар: “Хийн хангамж”-ийн БНБД 42-01-04/2018 нь бусад норм ба дүрэмтэй зөрчилдөж байсан тул нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.
	Шалгуур үзүүлэлт	Холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн боловсруулсан БНБД.
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: БНБД-ийг батлуулж, ХЗЯ-д бүртгүүлсэн байна. Жилийн эцэст:
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	“Хийн хангамж”-ийн БНБД 42-01-04/2018 -д нэмэлт өөрчлөлт оруулан, хянаж санал өгч БНБД 42-01-04/2018 -д нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 5 дугаар сарын 29-ийн өдрийн Барилга, хот байгуулалтын сайдын № 98 тушаалаар батлуулсан. Хууль зүйн яам 2019.06.28-ын өдрийн №1-1/3148 тоотор захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.
	Зарцуулсан хөрөнгө	Нормчлолын сангийн хөрөнгөөр
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт – 100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	5.1.3.4. “Автоматжуулалтын систем” дүрмийг боловсруулахад боловсруулалтад оруулах засварт эцсийн хяналт хийж, санал өгч батлуулна.					
	Төлөвлөлтийн уялдаа:	Монгол Улсын төсөвийн тухай хууль, (МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), (ЗГҮАХХАХТ-2.78), Нормчлалын сангийн төлөвлөгөө-2018, 2019				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	2019 оны нормчлолын сангийн хөрөнгөөр				
	Хариуцах нэгж	Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Батжаргал				
	Суурь түвшин	2018 оны байдлаар: “Автоматжуулалтын систем” /БД/ барилгын дүрмийн төсөлд редакц, шүүмж хийж, ирүүлсэн саналуудыг тусган, зөвлөмжийн дагуу засвар өөрчлөлтийг хийж, дуусгасан. Мэргэжлийн зөвлөлийн 2018.09.12-ны өдрийн хурлаар оруулан дэмжигдэж, яамны ШУТЗ-ийн 2018.10.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж, төслийг хянаж, санал өгч ажилласан.				
	Шалгуур үзүүлэлт	Холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн боловсруулсан БД.				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Дүрмийг боловсруулахад боловсруулалтад оруулах засварт эцсийн хяналт хийж, санал өгч ажилласан байна. Жилийн эцэст: Дүрмийг, батлуулсан байна				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцооны дагуу “Барилгын технологийн үйл ажиллагааны автоматжуулалт, технологийн үйл ажиллагааны автоматжуулалтын зураг төслийг				

		боловсруулах” /БД43-106-18/ барилгын дүрмийг БХБ-ын Сайдын 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 123 дугаар батлуулж, 2019.07.10-ны өдрийн 03/2758 тоот албан бичгээр хавсралтын хамт БХТ-д хүргүүлсэн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	<i>Нормчлолын сангийн хөрөнгө</i>
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт – 100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	5.1.3.5. Барилгын холбоо дохиоллын зураг төслийн төлөвлөлтийн дүрэм /БД/ боловсруулах ажилд хяналт тавьж, санал өгч БД-ийн төслийг боловсруулсан байна.					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Монгол Улсын төсөвийн тухай хууль, (МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), (ЗГҮАХХАХТ-2.78), Нормчлалын сангийн төлөвлөгөө-2018, 2019				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	12.0 тэрбум төгрөг				
	<i>Хариуцах нэгж</i>	Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Батжаргал				
	<i>Суурь түвшин</i>	2018 оны байдлаар:				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн боловсруулсан БД.				
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Дүрмийг боловсруулахад боловсруулалтад оруулах засварт эцсийн хяналт хийж, санал өгч ажилласан байна. Жилийн эцэст: Дүрмийг, батлуулсан байна				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Барилгын холбоо дохиоллын зураг төслийн төлөвлөлтийн дүрэм /БД/ боловсруулах ажлын техникийн даалгаврыг хянаж, яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 22/2018 тоотой батлуулсан бөгөөд уг дүрмийг боловсруулах сонгон шалгаруулалтын гүйцэтгэгчээр “Монголын цахилгаан холбоо харилцаа” ХК шалгарч, барилгын дүрмийг боловсруулж, дуусган, мэргэжлийн холбоод болон салбарын ТББ, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, редакц, шүүмж хийж, засвар өөрчлөлтийг оруулан, салбарын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	<i>Нормчлолын сангийн хөрөнгө</i>				
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт – 100%				
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>						

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>	
Арга хэмжээний нэр, дугаар	5.1.3.6. “Усны барилга байгууламжийн буурь” /БНБД 33-04-09/ шинэчлэх ажилд бодлого, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж, санал өгч батлуулах.	
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Монгол Улсын төсвийн тухай хууль, (МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1), (ЗГҮАХХАХТ-2.78), Нормчлалын сангийн төлөвлөгөө-2018, 2019,

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Шаардагдах хөрөнгө	Нормчлолын сангийн хөрөнгө												
	Суурь түвшин	2018 оны байдлаар: Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, боловсруулалтын ажил хийгдэж байгаа.												
	Шалгуур үзүүлэлт	Холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн боловсруулсан БНБД.												
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: БНБД-ийг боловсруулахад боловсруулалтад оруулах засварт эцсийн хяналт хийж, санал өгч ажилласан байна. Жилийн эцэст: БНБД-ийг батлуулсан байна.												
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	"Усны барилга байгууламжийн буурь" /БНБД 33-04-09/ шинэчлэх ажлыг Монхидроконстракшн ХХК-тай 2017.09.28-ны өдрийн 2017/206 тоот зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгч байгууллага эх материалын дагуу төслийг боловсруулж байгаа бөгөөд судлах эх материал их байгаа тул хугацааг сунгах шаардлагатай гэж үзэн гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу гэрээг сунгасан. Төслөөр ирүүлсэн бөгөөд редакци шүүмж хийгдэж, ирүүлсэн төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч тусгасан. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.												
	Зарцуулсан хөрөнгө	Нормчлолын сангийн хөрөнгө												
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт – 80%												
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ														

Гүйцэтгэлийн зорилт № 5.1.3-ийн үр дүн: “Салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгох, шинээр боловсруулах, үргэлжлүүлэх, техникийн даалгавар боловсруулж батлуулах” ажлыг зохион байгуулах, зохицуулах зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, үргэлжлүүлэх төсөл арга хэмжээний тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллээр хангана.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
			2018 он	Төл.	Гүй
1	EN 442 Халаах хэрэгсэл. “Радиатор ба конвектор” стандарт боловсруулах ажилд хяналт тавьж, санал өгч батлуулна.	Стандартын тоо	Холбогдох техникийн даалгаварыг батлуулж, ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулсан.	1	Стандартчилалын Үндэсний зөвлөлийн 2019.11.15-ны өдрийн хурлаар EN 442 Халаах хэрэгсэл. “Радиатор ба конвектор” стандартыг хэлэлцүүлж дэмжигдсэн бөгөөд зөвлөмжийн дагуу дахин редакц /найруулгыг засах/ хийж, 2019.12.03-ын өдөр СҮЗ-д хүргүүлсэн.
2	“Радиатор ба конвектор. Турших арга”-ын стандарт боловсруулах ажилд хяналт тавьж, санал өгч батлуулна.	Хувь %/	Холбогдох техникийн даалгаварыг батлуулж, ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулсан.	100%	70%
3	“Хийн хангамж” /БНБД 42-01-04/ 2008 нэмэлт өөрчлөлт оруулах ажилд бодлого, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж,	БНБД-ийн тоо	Холбогдох техникийн даалгаварыг батлуулж, ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг	1	“Хийн хангамж”-ийн БНБД 42-01-04/2018 -д нэмэлт өөрчлөлт оруулан, хянаж санал өгч БНБД 42-01-04/2018 -д нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 5 дугаар сарын 29-ийн өдрийн Барилга, хот

	санал өгч батлуулж ХЗЯ-д бүртгүүлэх		сонгож гэрээ байгуулсан.		байгуулалтын сайдын № 98 тушаалаар батлуулсан. Хууль зүйн яам 2019.06.28-ын өдрийн №1-1/3148 тоотор захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.
4	“Автоматжуулалтын систем” дүрмийг боловсруулахад боловсруулалтад оруулах засварт эцсийн хяналт хийж, санал өгч батлуулна.	Дүрмийн тоо	Холбогдох техникийн даалгаварыг батлуулж, ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулсан.	1	Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцооны дагуу “Барилгын технологийн үйл ажиллагааны автоматжуулалт, технологийн үйл ажиллагааны автоматжуулалтын зураг төслийг боловсруулах” /БД43-106-18/ барилгын дүрмийг БХБ-ын Сайдын 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 123 дугаар батлуулж, 2019.07.10-ны өдрийн 03/2758 тоот албан бичгээр хавсралтын хамт БХТ-д хүргүүлсэн.
5	Барилгын холбоо дохиоллын зураг төслийн төлөвлөлтийн дүрэм /БД/ боловсруулах ажилд хяналт тавьж, санал өгч БД-ийн төслийг боловсруулсан байна.	Дүрмийн тоо	Холбогдох техникийн даалгаварыг батлуулж, ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулсан.	1	Уг дүрмийг боловсруулах сонгон шалгаруулалтын гүйцэтгэгчээр “Монголын цахилгаан холбоо харилцаа” ХК шалгарч, барилгын дүрмийг боловсруулж, дуусган, мэргэжлийн холбоод болон салбарын ТББ, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, редакц, шүүмж хийж, засвар өөрчлөлтийг оруулан, салбарын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.
6	“Усны барилга байгууламжийн буурь” /БНБД 33-04-09/ шинэчлэх ажилд бодлого, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж, санал өгч батлуулна.	БНБД-ийн тоо	Холбогдох техникийн даалгаварыг батлуулж, ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулсан.	1	“Усны барилга байгууламжийн буурь” /БНБД 33-04-09/ шинэчлэх ажлыг Монхидроконстракшн ХХК-тай 2017.09.28-ны өдрийн 2017/206 тоот зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2. ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэнд / Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин</i>								
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.1.1. Хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглээний соёлыг төлөвшүүлэх сурталчилгааны арга хэмжээг тогтмол зохион байгуулах.								
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	-							
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-							
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Газрын бүх мэргэжилтнүүд.							
	<i>Суурь түвшин</i>	“Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл”-ийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.							
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчины талаарх мэдлэг боловсронгуй болгож, хэрэглэгчдийн хэрэглээний боловсрол дээшилсэн байна.							
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: Хэрэглэгчдийн хэрэглээний боловсрол дээшлүүлэх арга хэмжээ авагдсан байна.							
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийн танилцуулга, БХБ-ын яамнаас барилгын салбарын хүрээнд баримталж буй бодлогын талаарх сургалт хэлэлцүүлгийг 2019 оны 06 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулсан. Холбогдох илтгэл, танилцуулгыг БХБЯ-ны ХБГХБХЗГ-ын ахлах мэргэжилтэн Д.Бэлэгсайхан, ББМУБХЗГ-ын ахлах мэргэжилтэн Батзориг нар илтгэл тавьсан. Тус сургалтад Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Орхон, Дархан-Уул, Ховд аймгийн холбогдох албан тушаалтнууд, Хөвсгөл аймгийн ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтэнүүд зэрэг 30 гаруй мэргэжилтнүүд оролцсон болно.</p> <p>Засгийн газраас Сүхбаатарын талбайд 2019.9.13-ны өдөр зохион байгуулсан нээлттэй хаалганы өдрийн хүрээнд БХБЯ, тус газартай холбоотой хот байгуулалт, газрын харилцааны талаарх танилцуулга, мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилсан. Мөн БХБЯ-ны нээлттэй хаалганы өдрийн хүрээнд 2019.09.27-ны өдөр Схбаатарын талбайд ажиллаж салбарын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, сурталчилгаа хийх, видео шторк танилцуулсан.</p> <p>Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “5.1.4.хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон олон нийтийн оролцоо, оролцогч этгээдийн эрх тэгш байдлыг хангах,” заалтыг тусгаж хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.Улсын бүртгэлийн багц хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2018 оны 54 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Газрын сангийн нэгдмэл удирдлагыг Газрын тухай хуулийн төсөлд тусгах талаар нийтийн эрх зүйн</p>							

		судалгаа, Иргэний хуулийн суурь зохицуулалт, үзэл баримтлалд нийцүүлэн газрын эрхийн төрлийг Газрын тухай хуулийн төсөлд томъёолох талаар иргэний эрх зүйн судалгааг гэрээгээр гүйцэтгүүлэн хүлээн авсан. Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын дагуу хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны ажлын тайлангийн хамт боловсруулсан. 2019.03.15-нд Улаанбаатар зочид буудалд 50 хүний, 2019.05.03-ны өдөр Блю скай зочид буудалд 150 хүний бүрэлдэхүүнтэй хуулийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт -100 хувь
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №2.1.2. Хэрэглэгчийг соён гэгээрүүлэх, мэдлэг боловсрол олгох зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэнд / Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин</i>									
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.2.1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах урьдчилан сэргийлэх үүднээс салбарын хэвлэл мэдээлэл, сэтгүүлүүдтэй хамтран ажиллах;									
	2.1.2.2.Хэрэглэгч шаардлагатай мэдээллээ хүссэн цагтаа авч, санал гомдлоо чөлөөтэй илэрхийлж, шуурхай шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Санал хүсэлт” хэсгийг тогтмол ажиллуулах, “хэрэглэгчийн утас”-ыг ажиллуулан санал хүсэлтийг сонсож, мэдээлэл зөвлөгөө тогтмол өгч байх боломжийг бүрдүүлэх;									
	2.1.2.3. Хэрэглэгчдэд зориулсан гарын авлага, ном, товхимол, зурагт хуудас, сурталчилгааны бусад материал бэлтгэн хэвлүүлж, олон нийтэд түгээх.									
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	-								
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар		
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-								
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Газрын бүх мэргэжилтнүүд.								
	<i>Суурь түвшин</i>	“Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл”-ийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.								
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хэрэглэгчдийн салбарын талаарх мэдлэг боловсрол дээшилнэ. Хэрэглэгчдийн санал хүсэлтийг тогтмол авсан байна. Салбарын хэрэглэгчдийн мэдлэг боловсролын түвшин дээшилнэ.								
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: Хэрэглэгчдэд салбарын талаарх хэрэглээний мэдлэг боловсрол олгогдсон байна								
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийн танилцуулга, БХБ-ын яамнаас барилгын салбарын хүрээнд баримталж буй бодлогын талаарх сургалт хэлэлцүүлгийг 2019 оны 06 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулсан. Холбогдох илтгэл, танилцуулгыг БХБЯ-ны ХБГХБХЗГ-ын ахлах мэргэжилтэн Д.Бэлэгсайхан, ББМҮБХЗГ-ын ахлах мэргэжилтэн Б.Батзориг нар тавьсан. Тус сургалтад Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Орхон, Дархан-Уул, Ховд аймгийн холбогдох албан тушаалтнууд,								

		Хөвсгөл аймгийн ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтнүүд зэрэг 40 гаруй мэргэжилтнүүд оролцсон болно. Хот байгуулалтын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2019.10.09-ний өдөр зохион байгуулж, хэлэлцүүлэгт төр, ТББ, хувийн хэвшлийн 100 гаруй хүмүүс оролцож санал солилцсон, бичгээр санал авч хуулийн төсөлд тусгасан. - Засгийн газраас Сүхбаатарын талбайд 2019.9.13-ны өдөр зохион байгуулсан нээлттэй хаалганы өдрийн хүрээнд БХБЯ, тус газартай холбоотой хот байгуулалт, газрын харилцааны талаарх танилцуулга, мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилсан. Мөн БХБЯ-ны нээлттэй хаалганы өдрийн хүрээнд 2019.09.27-ны өдөр Сүхбаатарын талбайд ажиллаж, салбарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, сурталчилгаа хийх, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн танилцуулга видео шторкийг олон нийтэд танилцуулсан. - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, түүнтэй холбоотой дүрэм журмын талаарх танилцуулга, гарын авлага боловсруулагдаж 21 аймаг, нийслэлд хүргэгдсэн, сургагч багш бэлтгэгдсэн. Иргэдээс ирсэн санал гомдлыг тухайн бүр барагдуулж, холбогдох зөвлөмж мэдээлэл өгөгдсөн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт – 100 хувь
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №2.1.3. Хэрэглэгчид хүрч байгаа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлнэ.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэнд / Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.3.1. Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд иргэдийн эрх ихээр зөрчигдөж байгаа асуудлыг судлан тогтоож тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	-						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-						
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Газрын бүх мэргэжилтнүүд.						
	<i>Суурь түвшин</i>	"Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл"-ийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө" БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Байгууллагын талаарх иргэдийн мэдлэг боловсрол дээшилсэн байна.						
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: Хэрэглэгчдэд байгууллагын талаарх хэрэглээний мэдлэг боловсрол олгогдсон байна						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Засгийн газраас Сүхбаатарын талбайд 2019.9.13-ны өдөр зохион байгуулсан нээлттэй хаалганы өдрийн хүрээнд БХБЯ, тус газартай холбоотой хот байгуулалт, газрын харилцааны талаарх танилцуулга, мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилсан. Мөн БХБЯ-ны нээлттэй хаалганы өдрийн хүрээнд 2019.09.27-ны өдөр Сүхбаатарын талбайд ажиллаж салбарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, сурталчилгаа хийж, видео шторк танилцуулсан. Нээлттэй нийгэм форумас 2019.11.14-ний өдөр зохион байгуулагдсан "Хотын хөгжил ба орхигдсон иргэд" сэдэвт						

		хэлэлцүүлэгт газрын дарга Б.Гүнболд, ахлах мэргэжилтэн Д.Болормаа нар оролцож, гэр хорооллын дахин төлөвлөлтийн явцад эрх, өрхийн гишүүн бүрийн эрх, тэдгээрийн нийгмийн хамгаалал, бүртгэл, ажиллах нөхцөл, үүнтэй холбоотой нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, дасан зохицох чадварыг үнэлэх асуудлаар хэлэлцэж, хотын дахин төлөвлөлт нь зөвхөн БХБЯ-ны асуудал бус эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн болон хууль зүйн салбарын нэгдсэн цогц бодлогоор зохицуулагдах талаар хэлэлцэж санал солилцож, холбогдох тайлбар мэдээлэл хийгдсэн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	----
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт-100 хувь
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №2.1.4. Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэнд / Мэргэжилтэй ажилтанд

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин</i>								
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1-р арга хэмжээ 1.Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах. 2.Барилга, хот байгуулалтын салбарт жендерийн талаар баримтлах бодлого (2018-2025)-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтийг тайлагнах								
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	-							
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-							
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Газрын бүх мэргэжилтнүүд.							
	<i>Суурь түвшин</i>	“Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн” 2019 үйл ажиллагааны төлөвлөгөө” БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.							
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1.Холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөг Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулинд нийцүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ 2.Бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой холбогдох үйл ажиллагаануудыг байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, эхний хагса жил болон жилийн эцсийн бадлаар тайлагнасан байна							
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: 1.Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжсэн байна. 2. Бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой холбогдох үйл ажиллагаануудыг байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн жилийн эцсийн байдлаар тайлагнасан байна.							
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Жендерийн тэгш байдлын болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай зэрэг хуулиудад нийцүүлэн боловсруулсан. Хуулийн төслийг боловсруулж ажлын хэсэг, олон нийтийн хэлэлцүүлэг, БХБ-ын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал дүгнэлтийг тусган ЗГХЭГ-т хүргүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.							

		Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн. Холбогдох биелэлтийг ТЗУГ болон БТГ-т тухай бүр хүргүүлсэн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт- 100 хувь
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.5. Хэрэглэгчид хүрч байгаа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлнэ

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэнд / Мэргэжилтэй ажилтанд

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин								
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1-р арга хэмжээ 2.1.5.1.Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах.								
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	-							
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-							
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Газрын бүх мэргэжилтнүүд.							
	<i>Суурь түвшин</i>	“Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн” 2019 үйл ажиллагааны төлөвлөгөө БХБЯ-ын ТНБД –ын оны тушаалаар батлагдсан							
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөг Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулинд нийцүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна.							
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжсэн байна.							
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодезийн тухай хуулийн төсөл, холбогдох норм, дүрэм, журмын төсөл боловсруулахад Жендерийн тэгш байдлын болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай зэрэг хуулиудад нийцүүлэн боловсруулсан. Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн. Холбогдох биелэлтийг ТЗУГ болон БТГ-т тухай бүр хүргүүлсэн.							
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-							
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт-100 хувь							
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>									

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ 2.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэнд

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин
---	---

Арга хэмжээний нэр, дугаар	2.1.6.1. БНХАУ-ын буцалтгүй туламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” барих төслийг хэрэгжүүлэхэд ХНХЯ-тай хамтран ажиллах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	-						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	Шаардагдах хөрөнгө							
	Хариуцах нэгж	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах шинжээч Д.Бэлэгсайхан						
	Суурь түвшин	ХНХЯ, БНХАУ-ын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.БНХАУ-ын талаас хамтран ажиллаж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.						
	Шалгуур үзүүлэлт	БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” төслийг хэрэгжүүлэхэд ХНХЯ-тай хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагааг мэргэжлийн зөвлөмж, удирдлагаар хангасан байна						
	Хүрэх түвшин	Жилийн эцэст: “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” барих төсөл үе шаттайгаар хэрэгжинэ.						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” барих төслийн хүрээнд холбогдох чиглэл, мэдээлэл, зөвлөмж өгч ажиллаж байна. ХНХЯ, Японы олон улсын ЖАЙКА байгууллага хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд “Дэд бүтцийн хүртээмжийг бодитоор сайжруулах” сэдэвт сургалт, семинарыг 2019.09.26-ны өдрийн зохион байгуулсан. Тус арга хэмжээнд оролцож санал өгч ажилласан. Тус арга хэмжээнээс “Монгол дахь орчны саадгүй байдлыг хангах стратеги”-д өгөх зөвлөмж гарсан. Барилга, хот байгуулалтын сайдын 162 дугаар тушаалаар байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах зорилгоор холбогдох норм, нормативын баримт бичиг, стандартад үзлэг хийх, Засгийн газрын 2018 оны 317, 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт гаргах” үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. Ажлын хэсгийн анхдугаар хурал 2019.10.03-ны өдөр хуралдаж, үндсэн 3 чиглэлээр ажиллахаар ажлын хэсгийн гишүүдийг хуваарилан үүрэг өгсний дагуу Хот төлөвлөлтийн болон барилга байгууламжийн зураг төсөл төлөвлөлтийн норм, нормативын баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлага тусгагдсан эсэх талаар үзлэг хийж, дүгнэлт гаргав. Мөн Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн хэрэгжилт болон барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагад холбогдох норм, дүрмийн хэрэгжилтийг шалгах ажлын биелэлтийг гаргав. Ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтийг БХБ-ын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.						
	Зарцуулсан хөрөнгө	-						
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт- 100 хувь						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ								

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэнд

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.7.1. Хот төлөвлөлтийн болон барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаанд холбогдох хууль, норм, нормативын баримт бичгийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагаг хангуулах арга хэмжээ авч ажиллах							
	Төлөвлөлтийн уялдаа:	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 4.4.4						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	Шаардагдах хөрөнгө	-						
	Хариуцах нэгж	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Газрын бүх мэргэжилтнүүд.						
	Суурь түвшин	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан. Хот байгуулалтын тухай хуулийн дагуу хот байгуулалтын баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах ажлын хэсгийг БХБ-ын сайдын тушаалаар тухай бүр байгуулан ажиллаж байгаа.						
	Шалгуур үзүүлэлт	Хот байгуулалтын тухай хуулийн дагуу хот байгуулалтын баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулсан тушаалын тоо.						
	Хүрэх түвшин	4-р улиралд: Хот байгуулалтын тухай хуулийн дагуу хот байгуулалтын баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах ажлын хэсэг хууль тогтоомжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагаг хангуулахад чиглэсэн дүгнэлт гаргасан байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Хот байгуулалтын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлсон 5-р зүйлд “5.1.4.хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон олон нийтийн оролцоо, оролцогч этгээдийн эрх тэгш байдлыг хангах”, Хот байгуулалтын баримт бичгийн ангилал, тавигдах шаардлага зүйлд “6.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтцийн хэрэгцээг хангах нь хот байгуулалтын баримт бичигт тавигдах үндсэн шаардлага болно”, 13-р зүйлд “13.1.5.гадна тохижилтын ажил, барилга байгууламжийн орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хязгаарлалттай хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүртээмжтэй орчинг бүрдүүлэн төлөвлөсөн байх; 28-р зүйлд “28.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөл, барилгажилтын шийдэл, зураг төсөлд зөвшөөрөл олгох.”, 50-р зүйлд “50.4.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчны талаарх мэдээлэл;” зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн зүйл, заалтыг тусгаад байна. Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2019.10.09-ний өдөр, ажлын хэсгийн хурлаар 2019.10.16-ны өдөр, БХБ-ын сайдын Зөвлөлийн хуралдаанаар 2019.10.23-ны өдөр тус тус хэлэлцүүлж санал аваад байна. Тус хуулийн төслийг эцэслэн боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.						
	Зарцуулсан хөрөнгө							
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт- 100 хувь						

<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.8. Аймаг нийслэлийн ерөнхий архитекторуудыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Мэргэжилтэй ажилтанд

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.8.1. Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын 2018 оны ажлын нэгдсэн тайланд дүгнэлт хийж, холбогдох зөвлөмжийг аймгуудад хүргүүлсэн байна.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 4.4.4						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-						
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах мэргэжилтэн Б.Нямдаш Ахлах шинжээч Д.Бэлэгсайхан						
	<i>Суурь түвшин</i>	Хот байгуулалтын тухай хуулийн холбогдох зүйл заалтын дагуу жил бүр аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын тайланг хүлээн авч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгч холбогдох зөвлөмжийг хүргүүлдэг.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	21 аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын 2018 оны ажлын нэгдсэн тайланг нэгтгэн, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж хүргүүлсэн байна.						
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: Тайланг хүлээн авч нэгтгэн, аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудад холбогдох зөвлөмжийг хүргэсэн байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	-Нэгдсэн тайланг ГЗБГЗЗГ-аас хүлээн авч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт хийж аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын тайлантай холбоотой зөвлөмжийг гарган ГЗБГЗЗГазарт 2019.12.05-ны өдрийн 03/4531 тоот албан бичгээр хүргүүлсэн.						
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-						
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт- 100 хувь						
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>								

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.9. Аймгийн төвүүдэд батлагдсан ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлтийн санг байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Мэргэжилтэй ажилтанд

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.9.1. 21 аймаг, нийслэлээс "Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар"-ын хэрэгжилтийн тайланд дүгнэлт хийх ажлыг зохион байгуулсан байна.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 4.4.4						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-						
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах мэргэжилтэн Б.Нямдаш Ахлах шинжээч Д.Бэлэгсайхан						

	<i>Суурь түвшин</i>	Жил бүр “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийг 21 аймаг тус бүрээр дүгнэлт гаргаж, холбогдох зөвлөмжийг аймгуудад хүргүүлдэг.
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	21 аймгийн “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийг дүгнэж, зөвлөмж гарсан байна.
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийн тайланг нэгтгэх ажлыг зохион байгуулсан байна. “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийн тайлантай холбоотой зөвлөмжийг 21 аймагт хүргэсэн байна.
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	“Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийн тайланг нэгтгэх ажлыг зохион байгуулж, жижүүрийн хөтлөлтийн зөвлөмжийг боловсруулан аймаг, нийслэлийн холбогдох албадуудад 2019.12.06-ны өдрийн 01/4571 тоот албан бичгээр хүргүүлсэн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	Хэрэгжилт- 100 хувь
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 2.1.10. Хувийн хэвшилтэй хамтран “Хот байгуулалтын форум”-ыг зохион байгуулна.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэнд / Мэргэжилтэй ажилтанд / Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.10.1. Хот байгуулалтын форумыг зохион байгуулах							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	(ЗГҮАХХАХТ-2.85.2)						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-						
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Газрын бүх мэргэжилтнүүд.						
	<i>Суурь түвшин</i>	“Хот байгуулалтын форум” зохион байгуулах ажлын хэсгийг БХБ-ын сайдын тушаалаар байгуулагдсан.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	“Хот байгуулалтын форум” зохион байгуулах ажлын хэсгийг БХБ-ын сайдын тушаалаар байгуулсан байна “Хот байгуулалтын форум” -ыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.						
	<i>Хүрэх түвшин</i>	4-р улиралд: “Хот байгуулалтын форум” холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулагдсан байна.						
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.85.2-т тусгагдсан “Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Хот байгуулалтын форум”-ыг жил бүр зохион байгуулах” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Хот байгуулалтын форум”-ыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг БХБ-ын сайдын 2019 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 126 дугаар тушаалаар байгуулсан. Хот байгуулалтын форум, хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Барилгын хөгжлийн төв дээр зохион байгуулсан. Уг арга хэмжээнд БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ, НХБХГ, НГЗБА, МАЭ-ТББ, МБҮА-ТББ-ын төлөөлөл 150 хүн оролцсон.						

	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт- 100 хувь
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

Гүйцэтгэлийн зорилт №2.1.1-ийн үр дүн: Хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглээний соёлыг төлөвшүүлэх сурталчилгааны арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчины талаарх мэдлэг боловсронгуй болгож, хэрэглэгчдийн хэрэглээний боловсрол дээшилсэн байна.		“Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл”-ийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.	Хэрэглэгчдийн хэрэглээний боловсрол дээшлүүлэх арга хэмжээ авагдсан байна.	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “5.1.4.хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон олон нийтийн оролцоо, оролцогч этгээдийн эрх тэгш байдлыг хангах,” заалтыг тусгаж хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

Гүйцэтгэлийн зорилт №2.1.2-ийн үр дүн:

-Хэрэглэгчийн эрхийг хамгаалах урьдчилан сэргийлэх үүднээс салбарын хэвлэл мэдээлэл, сэтгүүлүүдтэй хамтран ажиллана

-Хэрэглэгч шаардлагатай мэдээллээ хүссэн цагтаа авч, санал гомдлоо чөлөөтэй илэрхийлж, шуурхай шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Санал хүсэлт” хэсгийг тогтмол ажиллуулах, “хэрэглэгчийн утас”-ыг ажиллуулан санал хүсэлтийг сонсож, мэдээлэл зөвлөгөө тогтмол өгч байх боломжийг бүрдүүлнэ;

-Хэрэглэгчдэд зориулсан гарын авлага, ном, товхимол, зурагт хуудас, сурталчилгааны бусад материал бэлтгэн хэвлүүлж, олон нийтэд түгээнэ.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	Хэрэглэгчдийн салбарын талаарх мэдлэг боловсрол дээшилнэ. Хэрэглэгчдийн санал хүсэлтийг тогтмол авсан байна. Салбарын хэрэглэгчдийн мэдлэг боловсролын түвшин дээшилнэ.		“Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл”-ийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.	Хэрэглэгчдэд салбарын талаарх хэрэглээний мэдлэг боловсрол олгогдсон байна	БХБЯ-ны нээлттэй хаалганы өдрийн хүрээнд 2019.09.27-ны өдөр Сүхбаатарын талбайд ажиллаж, салбарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, сурталчилгаа хийх, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн танилцуулга видео шторкийг олон нийтэд танилцуулсан. - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, түүнтэй холбоотой дүрэм журмын талаарх танилцуулга,

					гарын авлага боловсруулагдаж 21 аймаг, нийслэлд хүргэгдсэн, сургагч багш бэлтгэгдсэн. Иргэдээс ирсэн санал гомдлыг тухайн бүр барагдуулж, холбогдох зөвлөмж мэдээлэл өгөгдсөн. 2019.03.15-нд Улаанбаатар зочид буудалд 50 хүний, 2019.05.03-ны өдөр Блюскай зочид буудалд 150 хүний бүрэлдэхүүнтэй хуулийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.
--	--	--	--	--	---

Гүйцэтгэлийн зорилт №2.1.3-ийн үр дүн: Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд иргэдийн эрх ихээр зөрчигдөж байгаа асуудлыг судлан тогтоож тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	Байгууллагын талаарх иргэдийн мэдлэг боловсрол дээшилсэн байна.		“Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл”-ийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.	Хэрэглэгчдэд байгууллагын талаарх хэрэглээний мэдлэг боловсрол олгогдсон байна	БХБЯ-ны нээлттэй хаалганы өдрийн хүрээнд 2019.09.27-ны өдөр Сүхбаатарын талбайд ажиллаж, салбарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, сурталчилгаа хийх, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн танилцуулга видео шторкийг олон нийтэд танилцуулсан. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, түүнтэй холбоотой дүрэм журмын талаарх танилцуулга, гарын авлага боловсруулагдаж 21 аймаг, нийслэлд хүргэгдсэн, сургагч багш бэлтгэгдсэн. Иргэдээс ирсэн санал гомдлыг тухайн бүр барагдуулж, холбогдох зөвлөмж мэдээлэл өгөгдсөн.

Гүйцэтгэлийн зорилт №2.1.4-ийн үр дүн: Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах.

2.Барилга, хот байгуулалтын салбарт жендерийн талаар баримтлах бодлого (2018-2025)-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтийг тайлагнах

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	Холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр,		“Жендерийн орон тооны бус	1.Жендерийн тэгш байдлыг хангах	Хот байгуулалтын тухай хуулийн

	төлөвлөгөөг Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулинд нийцүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой холбогдох үйл ажиллагаануудыг байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, эхний хагса жил болон жилийн эцсийн бадлаар тайлганасан байна		салбар зөвлөлийн” 2019 үйл ажиллагааны төлөвлөгөө” БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.	тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжсэн байна. 2. Бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой холбогдох үйл ажиллагаануудыг байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн жилийн эцсийн байдлаар тайлагнасан байна.	шинэчилсэн найруулгын төслийг Жендерийн тэгш байдлын болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай зэрэг хуулиудад нийцүүлэн боловсруулсан. Тус яамны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, холбогдох биелэлтийг тус яамны ТЗУГ болон БТГ-т тухай бүр хүргүүлсэн.
--	---	--	---	--	--

Гүйцэтгэлийн зорилт №2.1.5-ийн үр дүн: 1.Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнана.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	Холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөг Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулинд нийцүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна.		“Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн” 2019 үйл ажиллагааны төлөвлөгөө БХБЯ-ын ТНБД –ын оны тушаалаар батлагдсан	Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжсэн байна.	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Газрын кадастрын тухай, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулиудын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодезийн тухай хуулийн төсөл, холбогдох норм, дүрэм, журмын төсөл боловсруулахад Жендерийн тэгш байдлын болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай зэрэг хуулиудад нийцүүлэн боловсруулсан. Тус яамны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, холбогдох биелэлтийг тус яамны ТЗУГ болон БТГ-т тухай бүр хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн зорилт №2.1.6-ийн үр дүн: БНХАУ-ын буцалтгүй туламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” барих төслийг хэрэгжүүлэхэд ХНХЯ-тай хамтран ажилласан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдах “Хөгжлийн		ХНХЯ, БНХАУ-ын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол	БНХАУ-ын буцалтгүй туламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй

	бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” төслийг хэрэгжүүлэхэд ХНХЯ-тай хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагааг мэргэжлийн зөвлөмж, удирдлагаар хангасан байна.		байгуулсан.БНХАУ-ын талаас хамтран ажиллаж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан.	бүхий спорт цогцолбор” барих төсөл үе шаттайгаар хэрэгжинэ.	иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” барих төслийн хүрээнд холбогдох чиглэл, мэдээлэл, зөвлөмж өгч ажиллаж байна. Засгийн газрын 2018 оны 317, 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт гаргах” үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. Ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтийг БХБ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.
--	--	--	--	---	---

Гүйцэтгэлийн зорилт №2.1.7-ийн үр дүн: Хот төлөвлөлтийн болон барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаанд холбогдох хууль, норм, нормативын баримт бичгийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагаг хангуулах арга хэмжээ авч ажиллана.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	Хот байгуулалтын тухай хуулийн дагуу хот байгуулалтын баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулж ажиллана.		Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө БХБЯ-ын ТНБД –ын тушаалаар батлагдсан. Хот байгуулалтын тухай хуулийн дагуу хот байгуулалтын баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах ажлын хэсгийг БХБ-ын сайдын тушаалаар тухай бүр байгуулан ажиллаж байгаа.	Хот байгуулалтын тухай хуулийн дагуу хот байгуулалтын баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах ажлын хэсэг хууль тогтоомжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлага хангуулахад чиглэсэн дүгнэлт гаргасан байна.	Хот байгуулалтын тухай хуулийн дагуу хот байгуулалтын баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах ажлын хэсэг хууль тогтоомжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлага хангуулахад чиглэсэн дүгнэлтийг 15 удаа гаргасан байна.

Гүйцэтгэлийн зорилт №2.1.8-ийн үр дүн: Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын 2018 оны ажлын нэгдсэн тайланд дүгнэлт хийж, холбогдох зөвлөмжийг аймгуудад хүргүүлсэн байна.

№	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			Жилийн эцэс	

	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		Өмнөх улирал	Төл.	Гүй
1	21 аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын 2018 оны ажлын нэгдсэн тайланг нэгтгэн, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж хүргүүлсэн байна.	Зөвлөмж, дүгнэлт - 1	Хот байгуулалтын тухай хуулийн холбогдох зүйл заалтын дагуу жил бүр аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын тайланг хүлээн авч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгч холбогдох зөвлөмжийг хүргүүлдэг	Тайланг хүлээн авч нэгтгэн, аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудад холбогдох зөвлөмжийг хүргэсэн байна.	Нэгдсэн тайланг ГЗБГЗЗГ-аас хүлээн авч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт хийж аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын тайлантай холбоотой зөвлөмжийг боловсруулан ГЗБГЗЗГазарт 2019.12.05-ны өдрийн 03/4531 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн зорилт №2.1.9-ийн үр дүн: 21 аймаг, нийслэлээс “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийн тайланд дүгнэлт хийх ажлыг зохион байгуулсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	21 аймгийн “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийг дүгнэж, зөвлөмж гарсан байна.	Зөвлөмж, дүгнэлт - 1	Жил бүр “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийг 21 аймаг тус бүрээр дүгнэлт гаргаж, холбогдох зөвлөмжийг аймгуудад хүргүүлдэг.	Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийн тайланг нэгтгэх ажлыг зохион байгуулсан байна. “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийн тайлантай холбоотой зөвлөмжийг 21 аймагт хүргэсэн байна.	“Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийн тайланг нэгтгэх ажлыг зохион байгуулж, жижүүрийн хөтлөлтийн зөвлөмжийг боловсруулан аймаг, нийслэлийн холбогдох албадуудад 2019.12.06-ны өдрийн 01/4571 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн зорилт №2.1.10-ийн үр дүн: Хот байгуулалтын форумыг зохион байгуулсан байна.

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
				Жилийн эцэс	
				Өмнөх улирал	Төл.
1	“Хот байгуулалтын форум” зохион байгуулах ажлын хэсгийг БХБ-ын сайдын тушаалаар байгуулсан байна “Хот байгуулалтын форум” -ыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.		“Хот байгуулалтын форум” зохион байгуулах ажлын хэсгийг БХБ-ын сайдын тушаалаар байгуулагдсан.	“Хот байгуулалтын форум” холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулагдсан байна.	Хот байгуулалтын форум, хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Барилгын хөгжлийн төв дээр зохион байгуулсан. Уг арга хэмжээнд БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ, НХБХГ, НГЗБА, МАЭ-ТББ, МБУА-ТББ-ын төлөөлөл 150 хүн оролцсон.

4. НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 4.1.1. Хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.1.1. Хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хүрээнд хамтарч ажиллан салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын орлого, ашгийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх. (2019-2020 он)					
	Төлөвлөлтийн уялдаа:	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3, 29, 30 дахь заалт, ТБСББХАХТ-ний 7.2.1.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилт шаардлагагүй				
	Хариуцах нэгж	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн				
	Суурь түвшин	Энэхүү арга хэмжээ нь 2019-2020 онуудад хэрэгжих бөгөөд 2019 онд хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хүрээнд: 1.Салбарын байгууллагуудын санхүүгийн чадавхи, үйлчилгээний хамрах хүрээ зэрэг чиглэлүүдээр судалгаа хийх шаардлагатай; 2.Салбарын хэмжээнд гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах хэлбэрээр аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллах судалгаа хийх шаардлагатай; 3.Салбарын хэмжээнд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хийлгэх ажлын жагсаалт гаргах зэрэг ажлуудыг шийдвэрлэх шаардлагатай.				
	Шалгуур үзүүлэлт	Боловсруулах баримт бичгийн тоо-1 багц				
Хүрэх түвшин	<p>Эхний хагас жилд: Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан.Төслийн баримт бичиг-1.</p> <p>Жилийн эцэст: Судалгаа хийгдсэн байна. Боловсруулах баримт бичгийн тоо-1 багц.</p>					
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулж, талуудыг төлөөлж Барилга, хот байгуулалтын дэд сайд Б.Мөнхбаатар, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны тэргүүн Ж.Батсуурь, Хот байгуулалт, нийтийн аж ахуйн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга А.Бурмаа нар гарын үсэг зурсан. Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2019 оны 6 дугаар сарын 4-ны өдөр бүртгэж авсан тухай 2019.09.04-ны өдрийн 8/2404 тоот албан бичгээр мэдэгдсэн.</p> <p>Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрт туссаны дагуу салбарт ажиллагсдын талаар шинэчилсэн судалгаа гаргаж нэгтгэн дүгнэлт хийх зорилгоор Хот байгуулалт, нийтийн аж ахуйн ажилтны үйлдвэрчний холбоотой хамтран 10 төрлийн асуумж бүхий судалгааг салбарын ашиглалт, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас 2019.12.15-ны дотор гаргуулж авахаар 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 03/4619 тоот албан бичгийг хүргүүлсэн. (Судалгааны асуумж бүхий хүснэгтүүдийг хавсаргав).</p> <p>Орон сууц нийтийн аж ахуйн салбарт ажиллаж буй ажилтан албан хаагчдын талаар 40 гаруй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагаас 10 төрлийн судалгааг авч нэгтгэн ХСУХАТАУ33-ын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр 01/1014 тоот албан бичгээр ирүүлээд байна</p>				
	Зарцуулсан хөрөнгө	-				
	Хүрсэн түвшин	100%				
<i>Төсвийн шууд захирагчийн</i>						

Гүйцэтгэлийн зорилт № 4.1.1.”Хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох”-ийн үр дүн:

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			2018 он	2019 жилийн эцэст	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулсан байна.	Боловсруулах баримт бичгийн тоо-1 багц	Энэхүү арга хэмжээ нь 2019-2020 онуудад хэрэгжих бөгөөд 2019 онд хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хүрээнд: 1.Салбарын байгууллагуудын санхүүгийн чадавхи, үйлчилгээний хамрах хүрээ зэрэг чиглэлүүдээр судалгаа хийх; 2.Салбарын хэмжээнд гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах хэлбэрээр аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллах судалгаа хийх; 3.Салбарын хэмжээнд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хийлгэх ажлын жагсаалт гаргах зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.	Төслийн баримт бичиг-1. Боловсруулах баримт бичгийн тоо-1 багц	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2019 оны 6 дугаар сарын 4-ны өдөр бүртгэж авсан тухай ХНХЯ 2019.09.04-ны өдрийн 8/2404 тоот албан бичгээр мэдэгдсэн. Орон сууц нийтийн аж ахуйн салбарт ажиллаж буй ажилтан албан хаагчдын талаар 40 гаруй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагаас 10 төрлийн судалгааг авч нэгтгэн ХСУХАТАҮЗЗ-ын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр 01/1014 тоот албан бичгээр ирүүлээд байна

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 4.1.2.Хөдөлмөр эрхлэлт.

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.2.1.Тус салбарын мэргэжлийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох санал боловсруулж, шийдвэрлүүлэх.(2019-2020 он)					
	Төлөвлөлтийн уялдаа:	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 6, 7, 13, 14, 15, 19 дэхь заалт.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилт шаардлагагүй.				
	Хариуцах нэгж	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн				
	Суурь түвшин	Салбарын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд: 1. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүний нөөцийн талаарх мэдээллийг шинэчлэх; 2.Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүний нөөцийн талаарх мэдээлэлд суурилан жендэрийн талаар судалгаа хийх; 3.Орон сууц нийтийн аж ахуйн салбарын норм, норматив, үнэ тарифын талаарх судалгааг сүүлийн 5 жилээр гаргах;				

		4.Орон сууц нийтийн аж ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн зааг, тусгай зөвшөөрлийн талаарх судалгааг сүүлийн 5 жилээр гаргах; 5.Салбарын хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэх; 6.Салбарын ажилтнуудын цалин хөлсний талаарх судалгааг сүүлийн 5 жилээр гаргах зэрэг судалгааны ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Боловсруулах баримт бичгийн тоо-1 багц
	<i>Хүрэх түвшин</i>	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулсан байна. Төслийн баримт бичиг-1
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдаар 2019 оны 6 дугаар сард батлуулж, талуудыг төлөөлж Барилга, хот байгуулалтын дэд сайд Б.Мөнхбаатар, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны тэргүүн Ж.Батсуурь, Хот байгуулалт, нийтийн аж ахуйн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга А.Бурмаа нар гарын үсэг зурсан. Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2019 оны 6 дугаар сарын 4-ны өдөр бүртгэж авсан тухай 2019.09.04-ны өдрийн 8/2404 тоот албан бичгээр мэдэгдсэн. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл ОСНАА-н байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох тэдгээрийг нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангах талаар санал, танилцуулга боловсруулж 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/918 тоот албан бичгээр яамны НААБХЗГ-т санал ирүүлсэн. Уг саналыг судалж 2020 оны эхний улиралд багтаан нэгтгэж яамны удирдлагад танилцуулан чиглэл авч шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд ОСНАА-н байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох тэдгээрийг нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангах талаар багц үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхээр тусгасан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.2.2.Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтнуудын улсын зөвлөгөөнийг 2019-2020 онуудад талууд хамтран зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулж, биелэлт үр дүнг тайлагнаж ажиллах.					
	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 12 дахь заалт.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Улирал</i>	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр, тоо хэмжээг тухайн үед нь шийдвэрлэнэ.				
	<i>Хариуцах нэгж</i>	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн				
	<i>Суурь түвшин</i>	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2019 оны 3 дугаар сард зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Арга хэмжээний тоо-1, төлөвлөгөөний төсөл-1.				
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулна. Арга хэмжээний тоо-1 Жилийн эцэст: Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын улсын зөвлөгөөнийг 2020 онд зохион байгуулах төлөвлөгөөний төсөл боловсруулна. Төсөл -1.				

Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2019"-ийг 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/60 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төсөл -1. Хэрэгжих шатандаа.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-				
	<i>Хүрсэн түвшин</i>	100%				
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>						

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.2.3.Салбарын хэмжээнд ХАБЭА-н хамтын ажиллагааны салбар хороог байгуулах.					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 24, 25 дахь заалт, ТБСТБХАХТ-ний 1.6.3				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилт шаардлагагүй.				
	<i>Хариуцах нэгж</i>	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн				
	<i>Суурь түвшин</i>	Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хамтын ажиллагааны салбар хороог байгуулж, салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гаргаж, тайлант хугацаанд хийгдсэн ажлыг хэлэлцүүлж хэрэгжилтийг ханган ажиллана.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Төслийн баримт бичиг-1, Салбар хорооны төлөвлөгөө-1.				
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна. Төслийн баримт бичиг-1.				
		Жилийн эцэст: Салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан байна. Төлөвлөгөө-1.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Салбарын хэмжээнд ХАБЭА-н салбар хорооны бүрэлдэхүүнд нэр авахаар НААБХЗГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 08/4697 тоот албан бичгийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон салбарын төрийн бус байгууллага, салбарын мэргэжлийн байгууллага, Барилгын хөгжлийн төвд болон ажил олгогчид хүргүүлсэн. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан салбарын ХАБЭА-н салбар хороог 2019 онд багтааж Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар байгуулж, тушаал гарснаар салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 2 дугаар сард багтаан боловсруулж батлуулна.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-				
	<i>Хүрсэн түвшин</i>	100%				
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>						

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.2.4.Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудыг төсөл, хөтөлбөрт хамруулах, ялангуяа ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг сайжруулах, тэдний мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төсөлд хамруулах.(2019-2020 он)					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 10 дахь заалт, ТБСБХАХТ-ний 6.3.1.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилт шаардлагагүй.				

	<i>Хариуцах нэгж</i>	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн
	<i>Суурь түвшин</i>	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг сайжруулах, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулна.
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Төслийн баримт бичиг-1, Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө-1.
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна. Төслийн баримт бичиг-1. Жилийн эцэст: Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө-1.
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/60 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг сайжруулах, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд “Мэргэшсэн инженер”-ийн зэрэг горилох, сунгах заавал болон сонгон суралцах багц /кредит/ цаг тооцох сургалтыг 2019 онд амжилттай зохион байгууллаа. Тус сургалтаар: Нийт 21 удаагийн сургалтыг Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулж 329 инженер техникийн ажилтан хамруулж чадавхижуулж мэргэжил, мэдлэг олголоо. -ОСНАА-н салбарын Эдийн засагч, Нягтлан бодогч-38 -Хүний нөөц-24 -Лаборитори-9 -Танилцах-6 -Дулаан хангамж, агаар сэлгэлтийн ашиглалтын мэргэшсэн болон зөвлөх инженер- 70 -Цахилгаан хангамжийн ашиглалтын мэргэшсэн болон зөвлөх инженер-14 -Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын мэргэшсэн болон зөвлөх инженер-116 -Машинист-30
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

Гүйцэтгэлийн зорилт № 4.1.2. "Хөдөлмөр эрхлэлт"-ийн үр дүн:

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			2018 он	2019 жилийн эцэст	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулсан байна.	Боловсруулах баримт бичгийн тоо-1 багц	Салбарын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд: 1. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүний нөөцийн талаарх мэдээллийг шинэчлэх; 2. Орон сууц, нийтийн аж ахуйн	Төслийн баримт бичиг-1. Боловсруулах баримт бичгийн тоо-1 багц	Хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдаар 2019 оны 6 дугаар батлуулж, талуудыг төлөөлж Барилга, хот байгуулалтын дэд сайд Б.Мөнхбаатар, МНААҮХ-ны тэргүүн Ж.Батсуурь, Хот байгуулалт, нийтийн аж ахуйн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга А.Бурмаа нар гарын үсэг зурсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

			салбарт ажиллаж байгаа хүний нөөцийн талаарх мэдээлэлд суурилан жендэрийн талаар судалгаа хийх; 3. Орон сууц нийтийн аж ахуйн салбарын норм, норматив, үнэ тарифын талаарх судалгааг сүүлийн 5 жилээр гаргах; 4. Орон сууц нийтийн аж ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн зааг, тусгай зөвшөөрлийн талаарх судалгааг сүүлийн 5 жилээр гаргах; 5. Салбарын хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэх; 6. Салбарын ажилтнуудын цалин хөлсний талаарх судалгааг сүүлийн 5 жилээр гаргах зэрэг судалгааны ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.		
2.	Салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.	Арга хэмжээний тоо-1, төлөвлөгөөний төсөл-1	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2019 оны 3 дугаар сард зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.	арга хэмжээний тоо-1. Төлөвлөгөөний төсөл-1.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2019"-ийг 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/60 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.
3.	Салбарын хэмжээнд ХАБЭА-н хамтын ажиллагааны салбар хороог байгуулсан байна.	Төсөл -1, Төлөвлөгөө 1	Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хамтын ажиллагааны салбар хороог байгуулж, салбар	Төслийн баримт бичиг-1. Төлөвлөгөө 1	Салбарын хэмжээнд ХАБЭА-н салбар хорооны бүрэлдэхүүнд нэр авахаар НААБХЗГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 08/4697 тоот албан бичгийг. Холбогдох

			хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гаргаж, тайлант хугацаанд хийгдсэн ажлыг хэлэлцүүлж хэрэгжилтийг ханган ажиллана.		байгууллагуудад хүргүүлсэн. Салбарын ХАБЭА-н салбар хороог 2019 онд багтааж Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар байгуулна.
4.	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг батлуулж сургалтуудыг зохион байгуулсан байна.	Төсөл -1, Төлөв лөгөө-1	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг сайжруулах, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулна.	Төсөл -1 Төлөв лөгөө-1	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/60 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Нийт 21 удаагийн сургалтыг Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулж 329 инженер техникийн ажилтан хамруулж чадавхижуулж мэргэжил, мэдлэг олголоо.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ № 4.1.3. Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад олон нийт, бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлнэ.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.3.1. "Хэрэглэгчээ сонсьё-2019" нээлттэй өдөрлөг арга хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран зохион байгуулах.					
	Төлөвлөлтийн уялдаа:	"Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл"-ийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.1 дэхь заалт.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр, тоо хэмжээг бичнэ үү.				
	Хариуцах нэгж	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн				
	Суурь түвшин	Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын байгууллагуудын үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад таниулах, мэдлэг, мэдээлэл олгох, санал, өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, зөвлөмжөөр хангах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг "Хэрэглэгчээ сонсьё" уриан дор улсын хэмжээнд 2 удаа зохион байгуулдаг. Тухайлбал, 2018 онд "Хэрэглэгчээ сонсьё" өдөрлөгийг 5 дугаар сард орон нутагт, 10 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулсан.				
	Шалгуур үзүүлэлт	Зохион байгуулах арга хэмжээний тоо-2				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Дорнод аймагт 2019 оны 6 дугаар сард зохион байгуулна. Арга хэмжээний тоо-1. Жилийн эцэст: Улаанбаатар хотод 10 дугаар сард зохион байгуулна. Арга хэмжээний тоо-1.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	БХБЯ, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо, "Дорнод Нийтийн аж ахуй" ОНӨААТҮГ-тай хамтран Нийтийн аж ахуйн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн, нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019 оны 06-р сарын 10-ны өдөр Дорнод аймагт зохион байгууллаа. Тус зөвлөгөөнөөр ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагуудын удирдлагад салбарын зохицуулалтын талаар баримтлах бодлого чиглэл, усны аюулгүй байдал, хүний				

		<p>нөөцийг чадавхижуулах, Европын орнуудын туршлага, Ус-нийгмийн эрүүл мэндийн талаар мэдээлэл өгч, санал солилцлоо.</p> <p>Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний 88 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад таниулах, мэдлэг, мэдээлэл олгох, санал, өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, зөвлөмжөөр хангах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг “Хэрэглэгчээ сонсьё” уриан дор улсын хэмжээнд 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

Гүйцэтгэлийн зорилт № 4.1.3. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад олон нийт, бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх”-ийн үр дүн:

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			2018 он	2019 жилийн эцэст	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	“Хэрэглэгчээ сонсьё-2019” нээлттэй өдөрлөг арга хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран зохион байгуулсан байна.	Арга хэмжээ 2	Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын байгууллагуудын үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад таниулах, мэдлэг, мэдээлэл олгох, санал, өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, зөвлөмжөөр хангах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг “Хэрэглэгчээ сонсьё” уриан дор улсын хэмжээнд 2 удаа зохион байгуулдаг. Тухайлбал, 2018 онд “Хэрэглэгчээ сонсьё” өдөрлөгийг 5 дугаар сард орон нутагт, 10 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулсан.	Дорнод аймагт зохион байгуулна. Арга хэмжээний тоо-1. Улаанбаатар хотод зохион байгуулна. Арга хэмжээний тоо-1.	“Дорнод Нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-тай хамтран Нийтийн аж ахуйн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн, нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019 оны 06-р сарын 10-ны өдөр Дорнод аймагт зохион байгууллаа. Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний 88 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Хэрэглэгчээ сонсьё” уриан дор улсын хэмжээнд 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан.

**ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

/ ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ /

№	Эрх зүйн акт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
1	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай		8
2	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль		7
3	Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль		14
4	Төсвийн тухай хууль		160
5	Барилгын тухай хууль		22
6	Газрын тухай хууль		11
7	Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль		2
8	Геодези, зураг зүйн тухай хууль		6
9	Хот байгуулалтын тухай		12
10	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль		7
11	Орон сууцны тухай хууль		4
12	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль		8
13	Статистикийн тухай хууль		2
14	УИХ-ын тогтоол		
15	Засгийн газрын тогтоол		
Нийт			

ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

2. ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №2.1.1. Хот байгуулалтын төрийн бодлогыг хэрэгжүүлж, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

Эрх зүйн акт: Хот байгуулалтын тухай хууль, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.8, 7.1.9

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.1.1. Хот байгуулалтын төрийн бодлогыг хэрэгжүүлж, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн ерөнхий төсөл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	МУЭЗН-ийг 2019онд ХҮЧ-ийн 8.1, МУЭЗН-ийг 2019онд ХҮЧ-ийн 8.3, МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын 1, ЗГҮАХХАХТ-2.79.2, НХБХҮАТ-6.1.1, АББҮХ-5.1, ЗГҮАХХАХТ- 2.79.4, ЗГҮАХХАХТ-2.84.3, НХБХҮАТ-6.1.6, ЭЗСХ-2.2.5, МУТХҮБ-ын 2.1.5. зорилт 5-ын1, ЗГҮАХХАХТ-2.85.4, НХБХҮАТ-6.1.4, 6.1.8, ЗГҮАХХАХТ-5.6.7.7, 5.6.7.8, Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.8, 7.1.9						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	<i>Шаардагдах хөрөнгө</i>							
	<i>Хариуцах нэгж</i>	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Гүнболд Ахлах мэргэжилтэн Д.Болормаа Шинжээч М.Гантөмөр Ахлах мэргэжилтэн Б.Нямдаш Ахлах шинжээч Д.Бэлэгсайхан						
	<i>Суурь түвшин</i>	1.Төв аймгийн төв Зуунмод, Архангай аймгийн төв Цэцэрлэг, Завхан аймгийн төв Улиастай, Өвөрхангай аймгийн төв Арвайхээр, Дархан-Уул аймгийн төвийн Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Замын-үүд, Алтанбулаг, Бичигт хилийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Хөшигийн хөндийд баригдах олон улсын нисэх буудлыг даган бий болох жишиг “ухаалаг” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд зургийн даалгавар боловсруулагдаж батлагдсан. 2.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах зургийн даалгаврыг БХБ-ын сайд 2019.07.01-нд баталсан. Төслийг ҮХГ, ЖАЙКА байгууллагын хамтран гүйцэтгэж байна. 3.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулах ажил ҮХГ-тай хамтран боловсруулагдаж байна.						
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	Салбарын байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан байна.	Сургалтад хамрагдсан аймгийн тоо-21, хот-1.	Нийслэл, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагууд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтанд тусгайлан хамрагдаагүй.	Сайдын албан даалгавар боловсруулж батлуулах. ХАБЭА сургалт зохион байгуулах.	Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдлыг хангуулах тухай 2019 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 2019/25 тоот албан даалгаврыг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн олон улсын OHSAS 18001:2007 стандартыг танилцуулж, хэрэгжүүлж буй туршлагыг түгээх сургалтыг 2019 оны 10-р сарын 3-4-ний өдрүүдэд Булган аймагт зохион байгууллаа.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №4.1.6. Ажлын хэсэг байгуулах тухай.

Эрх зүйн акт: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал 2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 61 дүгээр тушаал.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.6.1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн протокол, зээлийн гэрээний дагуу хэрэгжүүлсэн “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд шинээр баригдсан хоногт 24000м ³ бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээг хариуцах мэргэжлийн байгууллагыг тогтоох, ашиглалтад оруулах ажлыг шуурхай зохион байгуулж, уг цэвэрлэх байгууламжийн

	цаашдын өмчлөлийн болон зээлийн эргэн төлөлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулах.
	<i>Төлөвлөлтийн үялдаа:</i> Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал 2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 61 дүгээр тушаал.
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i> Улирал 1-р улирал 2-р улирал 3-р улирал 4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i> Санхүүжилт шаардлагагүй.
	<i>Хариуцах нэгж</i> Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн
	<i>Суурь түвшин</i> Бүгд Найрамдах Франц Улсын зээлээр “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл”-ийн хүрээнд хоногт 24000м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьсан. Байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан боловч уг байгууламжийн ашиглалтыг хариуцах байгууллага тодорхойгүйн улмаас байнгын ашиглалтад ороогүй байна.
	<i>Шалгуур үзүүлэлт</i> Ашиглалтад орсон барилга байгууламжийн тоо-1
	<i>Хүрэх түвшин</i> Эхний хагас жилд: Байнгын ашиглалтад оруулах бэлтгэл ханган ажилласан байна. Жилийн эцэст: Ашиглалтад орсон барилга байгууламжийн тоо-1.
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i> Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд шинээр баригдсан хоногт 24000м ³ бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийн тухай хэлэлцэж Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн протокол, зээлийн гэрээний дагуу хэрэгжүүлсэн “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд шинээр баригдсан хоногт 24000м ³ бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн ашиглагч байгууллагаар “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг сонгосон. Цэвэрлэх байгууламжийн зээлийн эргэн төлөлтийн асуудлыг судлан “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт үүсэх зардлыг бууруулах, зээлийн хүүг хөнгөлөх хүсэлтийг Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Зээлийн хөрөнгөнөөс авсан эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарарх бөгөөд Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болох хүртэл зээлдэгч нь тайлан тэнцэлдээ өглөг хэлбэрээр бүртгэхээр тогтсон. Энэ шийдвэрийн дагуу Франц Улсын “СУЭЗ Интернэшнл” ХХК нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас уг цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийг хариуцан ажиллах багийг ашиглалтад сургаж дадлагажуулах болон барилгын гүйцэтгэгч “Ардааган” ХХК-ийн ажлын чанар, гүйцэтгэлийг хянан шалгах, цэвэрлэх байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг товлох зэрэг ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд гүйцэтгэсэн байна. “СУЭЗ Интернэшнл” ХХК-ийн мэргэжилтнүүд энэ хугацаанд ажиллахдаа барилгын ажлын болон тоног төхөөрөмжийн суурилуулалтын чанар, гүйцэтгэлийн талаар зайлшгүй засаж залруулах шаардлагатай ажлуудын жагсаалтыг яаманд ирүүлээд байна. Иймд энэхүү жагсаалтад дурдсан гүйцэтгэл чанаргүй, дутуу ажлууд болон үлдэгдэл ажлуудын зөрчил, дутагдлыг 2020 оны 4 дүгээр сард багтаан арилгах, туршилт тохируулга хийх ажлын төлөвлөгөөг захиалагч, ашиглагч байгууллагатай зөвшилцөн боловсруулж тус ямаар батлуулан хэрэгжүүлж ажиллахаар НААБХХЗГ-ын даргын 2019.11.05-ны өдрийн 08/4160 дугаар албан бичгийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирал Ц.Амарсанаа, гүйцэтгэгч “Ардааган” ХХК-д тус тус хүргүүлж холбогдох чиглэл өгч ажиллаж байна.

		<p>“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар уг барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахтай холбогдуулан шаардлагатай техникийн баримт бичгүүдийг хянан шалгах ажлын хэсэг томилон ажиллуулж байна. НААБХЗГ-ын дарга О.Лхагвацэдэн дарга 2019 оны 10 дугаар сард Орхон аймагт ажиллахдаа тус ажлын хэсэгтэй уулзаж, уг барилга байгууламж ашиглалтад оруулахаар 2018 онд ажилласан комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах талаар ярилцаж холбогдох чиглэл гарган орон нутагт ажлын явцыг 2 долоо хоног тутам хэлэлцэж ТУН- тэй хамтран ажиллаж байна.</p> <p>Шинээр баригдсан 24000 м3/хон хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжид Барилгын тухай хуульд барилга, байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой заасан шаардлагууд хангагдсаны дараа “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу уг байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг 2020 оны 7 дугаар сард багтаан зохион байгуулахаар төлөвлөсөн болно.</p>
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

Гүйцэтгэлийн зорилт №4.1.6 -ийн үр дүн: “Ажлын хэсэг байгуулах тухай”

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			2018 он	2019 жилийн эцэст	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	“Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд шинээр баригдсан хоногт 24000м ³ бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийн ашиглагч байгууллагыг сонгож ашиглалтад оруулсан байна.	Ашиглалтад орсон барилга байгууламжийн тоо-1.	БНФУ-ын зээлээр “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл”-ийн хүрээнд хоногт 24000м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьсан. Байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан боловч уг байгууламжийн ашиглалтыг хариуцах байгууллага тодорхойгүйн улмаас байнгын ашиглалтад ороогүй байна.	Байнгын ашиглалтад оруулах бэлтгэл ханган ажилласан байна.	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар ашиглагч байгууллагаар “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг сонгосон.
					Шинээр баригдсан 24000 м3/хон хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжид Барилгын тухай хуульд барилга, байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой заасан шаардлагууд хангагдсаны дараа “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу уг байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг 2020 оны 7 дугаар сард багтаан зохион байгуулахаар төлөвлөсөн болно.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №4.1.7. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Эрх зүйн акт: Засгийн газрын 2017 оны 311 дүгээр тогтоолын 2 дахь заалт.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
Арга хэмжээний нэр, дугаар	4.1.7.1.“Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийг батлагдсан техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу барьж байгуулах асуудлыг шуурхай зохион байгуулан барилгын ажлыг 2018 оны II улиралд багтаан эхлүүлэх талаар бүх талын арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд болон холбогдох сайд нарт даалгасугай.

	<i>Төлөөлөлтийн уялдаа:</i>	Засгийн газрын 2017 оны 311 дүгээр тогтоолын 2 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 73 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2017 оны 175 дугаар захирамжийн 2 дахь заалт, БХБСайдын 2019 оны 18 дугаар тушаал.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Улирал</i>	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл, 252 сая америк доллар.				
	<i>Хариуцах нэгж</i>	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн				
	<i>Суурь түвшин</i>	Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээ хангах, одоо байгаа цэвэрлэх байгууламжийн хүчин чадал 170000м3/хон, төлөвлөж байгаа цэвэрлэх байгууламжийн хүчин чадал 250000м3/хоног, 2018 онд хуримтлагдсан 720000м3 лаг, өдөр тутам гарч буй 1200м3 түүхий лагийг боловсруулсан. Цэвэрлэх байгууламжийн лагийг усгүйжүүлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулна. .				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1.Шинэ цэвэрлэх байгууламж барих төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Төслийн нэгжийг байгуулна. Төслийн хэрэгжилт 10 хувь. 2.2019 онд 360000 м3 лагийг үнэргүйжүүлэх ажил хийгдэнэ. Лаг усгүйжүүлэх байгууламжийн хүч чадал 2500 м3/хоног. Ашиглалтад орох байгууламжийн тоо-1.				
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Төслийн нэгжийг байгуулсан байна. Шинэ цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын гэрээг байгуулсан байна.Төслийн тоо-1. Жилийн эцэст: 1.Төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Барилга угсралтын ажлын талбайн бэлтгэл ажлыг хангуулах, газар шорооны ажлыг 10 хувьд хүргэсэн байна. 2.2019 онд нийт 720000м3 лаг, өдөр тутам гарч буй 1200м3 түүхий лагийг үнэргүйжүүлэх ажлыг гүйцэтгэсэн байна. Лаг усгүйжүүлэх байгууламжийг байнгын ашиглалтад орсон байна. Байгууламжийн хүч чадал 2500 м3/хоног.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	1 а) БНХАУ-ын Худалдааны яамнаас шаардлага хангасан гурван оролцогчийг санал болгосны дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, түлхүүр гардуулах нөхцлөөр “Чайна тисижу сивил инженеринг групп ба Бээжин констракшн инженеринг групп консорциум”-тай 262,710,119.53 ам.долларын гэрээ байгуулсан. Гэрээг Сангийн яамаар уламжлуулан БНХАУ-ын Худалдааны яам болон Эксим банкинд хүргүүлж санхүүжилтын гэрээг байгуулах бэлтгэл ажлыг хангаад байна. б) Шинэ цэвэрлэх байгууламжийн ажлын нарийвчилсан зураг төслийг Шанхайн зураг төслийн хүрээлэнд боловсруулж, орчуулан холбогдох байгуулагуудтай зөвшилцөж 2019.09.12-нд магадлал хийлгэн баталгаажуулсан. в) Төслийн байгаль орчны нөлөөлөлийн үнэлгээг шинэчлэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ерөнхий үнэлгээг баталгаажуулсан. г) Төслийн барилга угсралтын талбайн бэлтгэл ажлыг хангаж түр ажилчдын байр, хашаа, цамхагт краныг байршуулан, биологи цэвэрлэгээний байгууламжийн суурийн газар шорооны ажил, бетон зуурмагын узель угсрах, байгууламжийн суурийн ул бетон цутгах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. 2. Төв цэвэрлэх байгууламжид хуримтлагдсан нийт 820,000 м ³ гаран түүхий лагийг 2018-2019 оны хооронд бүрэн цэвэрлэж, үнэргүйжүүлж дуусгаад байна. Цэвэрлэх байгууламжид технологи дамжлагыг шинээр нэмж хоногт 2500 м ³ лаг усгүйжүүлэх байгууламжийг барьж, 2019.09.09.-ний өдөр байнгын ашиглалтад оруулсан. Байгууламж ашиглалтад орсноор лагийн хэмжээг 6-10 дахин багсагаж, лагаас гарах үнэрийн хэмжээг 5 дахин бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-				
	<i>Хүрсэн түвшин</i>	100%				
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>						

Гүйцэтгэлийн зорилт №4.1.7 -ийн үр дүн: Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай.

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			2018 он	2019 жилийн эцэст	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	Шинэ цэвэрлэх байгууламж барих төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна	1.Шинэ цэвэрлэх байгууламж барих төслийн нэгжийг байгуулна. Төслийн хэрэгжилт 10 хувь. 2.2019 онд 360000 м3 лагийг үнэргүйжүүлэх ажил хийгдэнэ. Лаг усгүйжүүлэх байгууламжийн хүч чадал 2500 м3/хоног. Ашиглалтад орох байгууламжийн тоо-1.	Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээ хангах, одоо байгаа цэвэрлэх байгууламжийн хүчин чадал 170000м3/хон, төлөвлөж байгаа цэвэрлэх байгууламжийн хүчин чадал 250000м3/хоног, 2018 онд хуримтлагдсан 720000м3 лаг, өдөр тутам гарч буй 1200м3 түүхий лагийг боловсруулсан. Цэвэрлэх байгууламжийн лагийг усгүйжүүлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулна.	Төслийн нэгжийг байгуулсан байна. Шинэ цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын гэрээг байгуулсан байна.Төслийн тоо-1.	1.Төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Барилга угсралтын ажлын талбайн бэлтгэл ажлыг хангуулах, газар шорооны ажлыг 10 хувьд хүргэсэн байна. 2.2019 онд нийт 720000м3 лаг, өдөр тутам гарч буй 1200м3 түүхий лагийг үнэргүйжүүлэх ажлыг гүйцэтгэсэн байна. Лаг усгүйжүүлэх байгууламжийг байнгын ашиглалтад орсон байна. Байгууламжийн хүч чадал 2500 м3/хоног.

**ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтууд	Арга хэмжээний тоо
1.	1.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, салбарын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох, судалгаа хийх, мэдээллийн сан байгуулах.	37
2.	1.2. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх.	12
3.	1.3. Салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх.	8
4.	1.4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах, тайлан, баланс гаргах.	12
Нийт		69

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

1. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.1.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, салбарын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох, судалгаа хийх, мэдээллийн сан байгуулна.

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.1. Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхтэй холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын аймгуудын Засаг дарга нартай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалт						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	2018 онд аймаг, нийслэлийн засаг дарга нартай 22 гэрээ байгуулсан						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээний тоо						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 22 гэрээ байгуулсан байна. Жилийн эцэст: Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 22 гэрээ байгуулсан байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Засгийн газрын гишүүн, барилга, хот байгуулалтын Сайд болон нийслэл, аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээний бэлтгэл ажлыг хангаж улмаар 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, 21 аймгийн Засаг даргатай гэрээ байгуулав.						
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-						
	<i>Хүрсэн түвшин</i>	100%						
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>								

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.2. Яамны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	2018 оны үр дүнгийн гэрээний биелэлт 91.2%						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан байна. Жилийн эцэст: 1. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж, 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулна. 2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулна.						

Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2019 оны 2 дугаар сарын 08-ны өдөр батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн А/107 тоот тушаалаар Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан загвар, аргачлалын дагуу шинээр боловсруулан батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2019 оны 7 дугаар сарын 05-ны өдөр батлуулсан.
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.3. Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг байгуулах, хэрэгжүүлэх, биелэлтийг дүгнэх ажлыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	Хөдөлмөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь заалт						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1/7	2/8	3/9	4/10	5/11	6/12
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	Суурь түвшин	Барилгын салбарын 2017-2019 оны хамтын хэлэлцээр						
	Шалгуур үзүүлэлт	ШҮ1: Салбарын хамтын хэлэлцээрийн тоо ШҮ2: Хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, тайлангийн тоо						
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: 1. "Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээр" болон "Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээр"-ийг байгуулсан байна. Жилийн эцэст: "Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө" болон "Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г БХБ-ын сайдаар батлуулж, биелэлтийг дүгнэсэн байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> - Барилгын салбарын 2017-2018 оны хамтын хэлэлцээрийн биелэлтийг дүгнэх, 2019-2020 оны гурван талт хамтын хэлэлцээрт Барилга, хот байгуулалтын яамыг төлөөлөн хэлэлцээ хийх ажлын хэсгийг БХБ-ын Сайдын 2019 оны А/41 тоот тушаалаар байгуулж ажилласан. - Барилгын салбарын 2017-2018 оны хамтын хэлэлцээрийн биелэлтийг нэгтгэн дүгнэж, БХБ-ын Сайдын 2019 оны А/41 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсгийн 2019.04.09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж зөвшөөрөгдсөн. - Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг боловсруулж, 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Барилга, хот байгуулалт сайд Х.Баделхан болон Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны ерөнхийлөгч М.Батбаатар, Монголын Барилгачдын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбооны дарга Б.Батцогт нар хамтран гарын үсэг зурж батлав. - Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг ХНХЯ-нд хүргүүлж, 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдөр бүртгүүлэв. 						

		<p>- Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг боловсруулж, 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Барилга, хот байгуулалт сайд Х.Баделхан болон Монголын Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний Холбооны тэргүүн Ж.Батсуурь, Хот Байгуулалт, Нийтийн Аж Ахуйн Ажилтны Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны дарга А.Бурмаа нар хамтран гарын үсэг зурж батлав.</p> <p>- Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг ХНХЯ-нд хүргүүлж, 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр бүртгүүлэв.</p> <p>- Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээр болон Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгах саналуудыг Монголын Барилгачдын Нэгдсэн Холбоо болон Монголын Барилгачдын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбоо, Монголын Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний Холбооны тэргүүн Ж.Батсуурь, Хот Байгуулалт, Нийтийн Аж Ахуйн Ажилтны Үйлдвэрчний Эвлэлийн Холбооноос тус тус авч нэгтгэн боловсруулсан.</p> <p>-“Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө ” болон “Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г тус тус Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>- Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2019-2020 оны улсын хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг яамны хариуцсан ажлын чиглэлээр гаргаж, ХНХЯ-нд 2019.12.06-ны өдрийн 01/4554 тоот албан бичгээр хүргүүлэв.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	<p>1.“Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээр” болон “Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээр”-ийг байгуулсан.</p> <p>2.“Барилгын салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө ” болон “Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г БХБ-ын сайдаар батлуулан хэрэгжүүлж байна.</p> <p>3. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2019-2020 оны улсын хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг яамны хариуцсан ажлын чиглэлээр гаргаж, ХНХЯ-нд 2019.12.06-ны өдрийн 01/4554 тоот албан бичгээр хүргүүлэв.</p>
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.4. Салбарын ажилтны давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Барилгын тухай хуулийн 33.1.9 дэх заалт , 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэг						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	<i>1 / 7</i>	<i>2 / 8</i>	<i>3 / 9</i>	<i>4 / 10</i>	<i>5 / 11</i>	<i>6 / 12</i>
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	35.0 /Зохион байгуулагч талын зардлаар/						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	2018 онд 29 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 959 салбарын ажилтныг чадавхижуулав.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Орон тооны бус зөвлөлийн хуралдааны тоо ШҮ2: Сургалтын чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх тухай 2019 оны гэрээний тоо ШҮ3: 2019 оны сургалтын хөтөлбөр, шалгалтын төлөвлөгөөний тоо						

		<p>ШҮ4: Мэргэшлийн зэрэг олгох, сунгах тушаалын тоо</p> <p><i>Хүрэх түвшин</i></p> <p>Эхний хагас жилд: 1. Орон тооны бус зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулна.</p> <p>2. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээг МБНХ-той, “Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг хэрэгжүүлэх гэрээг МАЭ-тэй тус тус байгуулсан байна.</p> <p>3. 2019 оны сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө -1, шалгалт авах төлөвлөгөө -1 –ийг тус тус Төрийн нарийн бичгийн даргын тушаал батлуулсан байна.</p> <p>4. Мэргэшлийн зэрэг олгох, сунгах тухай Төрийн нарийн бичгийн даргын тушаал 2-оос доошгүй гарсан байна.</p> <p>Жилийн эцэст: 1. Орон тооны бус зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулна.</p> <p>2. Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2019 оны сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө, шалгалт авах төлөвлөгөөний хэрэгжилтийг МБНХ, МАЭ-ээр тус тус хангуулж ажилласан байна.</p> <p>3. Мэргэшлийн зэрэг олгох, сунгах тухай Төрийн нарийн бичгийн даргын тушаал 2-оос доошгүй гарсан байна.</p>
<p>Арга хэмжээний хэрэгжилт</p>	<p><i>Хэрэгжилт</i></p>	<p>- “Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 01-ний 20 дугаар тушаалаар барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг барилгын салбарын төрийн бус, мэргэжлийн байгууллагууд/12/-ын түншлэлийг төлөөлж “Монголын барилгачдын нэгдсэн хоолбоо” ТББ-аар гэрээний үндсэн дээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>- Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх 2019/31 тоот гэрээг “Монголын барилгачдын нэгдсэн хоолбоо” ТББ-тай, архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалт эрхлэх чиг үүргийг гүйцэтгүүлэх 2019/28 тоот гэрээг “Монголын Архитекторуудын Эвлэл” ТББ-тай 2019.02.02-ны өдөр тус тус байгуулсан.</p> <p>- Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 24 дүгээр тушаалаар “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн болон тус зөвлөлийн ажлын албаны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулсан. Энэ тушаалын дагуу “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн ажлын албыг “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ хариуцан ажиллаж байна.</p> <p>- “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн хуралдааныг дараах байдлаар зохион байгууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Анхдугаар хуралдааныг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр яамны хурлын танхимд хийж, 4 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. ➢ Хоёрдугаар хуралдааныг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр яамны хурлын танхим хийж, 2 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. <p>- Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын 2019 оны нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/50 тоот тушаалаар батлуулав. Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын 2019 оны нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу архитектор, инженер, төсөвчний багц цагийн сургалтууд зохион байгуулагдаж байна. Батлагдсан сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалт эрхлэгч байгууллагууд нь 2019 оны эхний хагас жилийн байдлаар заавал болон сонгон суралцах багц цагийн сургалтыг давхардсан тоогоор нийт 76 удаа явуулж, 1739 гаруй мэргэжилтэн хамрагдсан байна. Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны мэдээллийн санд мэргэжлийн 6 хүрээгээр нийт 902 мэргэжилтэн бүртгэгдээд байна.</p>

		<p>- Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалт авах 2019 оны төлөвлөгөөг "Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл"-ийн 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/51 тоот тушаалаар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу "Шалгалтын комисс томилох тухай" БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019.04.19-ны А/61, 2019.05.14-ний А/75, 2019.12.06-ны А/157 тоот тушаалыг гаргуулан хэрэгжүүлж, энэ оны эхний хагас жилийн байдлаар мэргэшсэн горилох-417, мэргэшсэн инженер сунгах-250, зөвлөх инженерийн зэрэг горилох-48, зөвлөх инженерийн зэрэг сунгах-72 нийт 785 мэргэжилтэн шалгалтанд хамрагдсан байна. Шалгалтанд орсон нийт мэргэжилтний 574 буюу 73% нь тэнцлээ.</p> <p>- "Барилгын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх шалгалтын тест, мэргэшлийн ур чадварын шалгалтын даалгавар"-ыг шинэчилэн боловсруулж, "Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл"-ийн 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.</p> <p>- "Мэргэшлийн зэрэг олгох, сунгах тухай" БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019.01.25-ны А/109, 2019.04.03-ны А/52, 2019.06.27-ны А/103, "Мэргэшлийн зэрэг олгох тухай" БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019.06.11-ны А/92 тоот тушаалыг тус тус гаргасан. Үүний дагуу шинээр "Зөвлөх инженер"-ийн зэрэг -74, "Зөвлөх архитектор"-1, "Зөвлөх эдийн засагч" зэрэг-3, "Тэргүүлэх төсөвчин" зэрэг -16, "Мэргэшсэн инженер" зэрэг -209, "Мэргэшсэн архитектор" зэрэг-21, "Мэргэшсэн төсөвчин" зэрэг -85, сунгахаар "Зөвлөх инженер"-ийн зэрэг -114, "Зөвлөх архитектор"-8, "Зөвлөх эдийн засагч" зэрэг-1, "Тэргүүлэх төсөвчин" зэрэг -27, "Мэргэшсэн инженер" зэрэг -259, "Мэргэшсэн архитектор" зэрэг-44, "Мэргэшсэн төсөвчин" зэрэг -95 мэргэжилтэнд тус тус олгосон.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	<p>1.Орон тооны бус зөвлөлийн хуралдааныг 2 удаа зохион байгуулсан.</p> <p>2.Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээг МБНХ-той, Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг хэрэгжүүлэх гэрээг МАЭ-тэй тус тус байгуулан ажиллаж байна.</p> <p>3. 2019 оны сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө -1, шалгалт авах төлөвлөгөө -1 –ыг тус тус Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу "Шалгалтын комисс томилох тухай" БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019.04.19-ны А/61, 2019.05.14-ний А/75, 2019.12.06-ны А/157 тоот тушаалыг гаргуулан Эдгээр төлөвлөгөө, тушаалын биелэлтийг БХТ, МБНХ-оор тус тус хангуулж ажилласан.</p> <p>4. Мэргэшлийн зэрэг олгох, сунгах тухай Төрийн нарийн бичгийн даргын 4 тушаалыг гаргуулсан.</p>
	<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>	

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.5. Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн дэргэдэх Барилгын салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1/7	2/8	3/9	4/10	5/11	6/12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						

	<i>Суурь түвшин</i>	-
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Барилгын салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын зөвлөлийн хуралдааны тоо ШҮ2: Батлуулах дүрмийн тоо ШҮ3: Шинээр байгуулах дэд зөвлөлийн тоо
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: 1. Салбарын зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Үндэсний зөвлөлөөр батлуулсан байна. 2. Үндэсний зөвлөлийн хуралдаанд оролцсон байна. 3. Салбарын зөвлөлийн уулзалт, хэлэлцүүлэг болон сургалт-семинарыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна. Жилийн эцэст: 1. Хуралдааныг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна. 2. Салбар зөвлөлийн жилийн эцсийн тайланг гаргана. 3. Салбар зөвлөлийн дэргэд 2 дэд зөвлөлийг байгуулсан байна.
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн дэргэдэх Барилгын салбарын зөвлөлийн гишүүдийн чадавхи дээшлүүлэх уулзалт, хэлэлцүүлгийг ХНХЯ, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл, Европын холбооны "МОНГОЛ УЛСЫН ТМБССДТ-1" ТӨСӨЛ, МАОЭНХ хамтран 2019.02.29-03.01-ний өдрүүдэд зохион байгуулсан. 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн 2019 оны анхдугаар хуралдаанд ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн оролцож, 10 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Мэргэжлийн боловсрол, сургалтын Салбар зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах хөтөлбөр"-төсөлтэй танилцаж, холбогдох саналыг бэлтгэн 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 05/2077 тоот албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлэв. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлтэй хамтран Барилгын салбарын зөвлөлийн гишүүд болон аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлд зориулсан сургалт-семинарыг 2019.06.27-ны өдөр Улаанбаатар зочид буудалд зохион байгуулсан. Барилгын салбар зөвлөлийн дэргэд Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын болон Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2 дэд зөвлөлийг байгуулах саналыг боловсруулаад байна.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	1. Барилгын салбарын зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Үндэсний зөвлөлөөр батлуулсан. 2. Үндэсний зөвлөлийн 1 удаагийн хуралдаанд оролцсон. 3. Барилгын салбарын зөвлөлийн уулзалт, хэлэлцүүлэг -1, сургалт-семинар 1-ийг холбогдох байгууллагуудтай хамтран тус тус зохион байгуулсан.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.6. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх мэргэжлийн зөвлөлд оролцон ажиллах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Боловсролын тухай хуулийн 26.1 дэх хэсэг						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1/7	2/8	3/9	4/10	5/11	6/12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	2018 оны сургалтын хөтөлбөр						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Мэргэжлийн зөвлөлийн хурлын тоо						

		ШҮ2: Магадлан итгэмжилсэн хөтөлбөрийн тоо
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: 1. Мэргэжлийн зөвлөлийн 2 удаагийн хуралд оролцож, мэргэжлийн боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх дүгнэлтийг гаргана. Жилийн эцэст: Мэргэжлийн зөвлөлийн 2 удаагийн хуралд оролцож, мэргэжлийн боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх дүгнэлтийг гаргана.
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	БХБЯ-ыг төлөөлөн Мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх мэргэжлийн зөвлөлд гишүүнээр орж ажиллаж байна. Энэхүү зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 09, 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралд тус тус оролцов.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	Мэргэжлийн зөвлөлийн 2 удаагийн хуралд оролцож, мэргэжлийн боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх дүгнэлтийг гаргасан.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>								
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.7. “Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн сан бүрдүүлэх” болон барилгын салбарын ажиллах хүчний эрэлт/2019он/-ийг тодорхойлох судалгааны ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.								
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Барилгын тухай хуулийн 34.1.7 дахь заалт							
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12	
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй							
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан							
	<i>Суурь түвшин</i>	2018 онд хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй ТОП-20 мэргэжлийн жагсаалтаар барилга угсралтын туслах ажилтан, засалчин, шаварчин, арматурчин мэргэжлүүд тэргүүлсэн байна. Судалгаа мэдээллийг ЗГХЭГ-ын Төрийн нэгдсэн мэдээллийн самбар болон яамны сайтад байршуулсан.							
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Батлуулах ажлын даалгаврын тоо ШҮ2: Төслийн гүйцэтгэгчийн тоо ШҮ3: Хамтран ажиллах дотоодын болон олон улсын байгууллагын тоо ШҮ4: Төслийн ажлын гүйцэтгэлийн хувь (%)							
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: : 1.Төрийн нарийн бичгийн даргаар “Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн сан бүрдүүлэх” ажлын даалгаврыг батлуулна. Жилийн эцэст: 1. “Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн гүйцэтгэгчийг БХТ-өөс сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлнэ. 2. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-тэй хамтран барилгын салбарын ажиллах хүчний эрэлт /2019 он/-ийг тодорхойлох судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгож, тухай ажлын гүйцэтгэлийг 50-иас дээш хувьд хүргэсэн байна.							
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	1.“Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн сан бүрдүүлэх” ажлын даалгаврыг боловсруулж, 2019.02.22-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.“Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн сан бүрдүүлэх” батлагдсан ажлын даалгаврыг 2019 оны 4 дүгээр сайрын 23-ны өдрийн 03/1424 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг даалгасан. Уг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангах чиглэлээр Барилгын хөгжлийн төвтэй хамтран ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан							

		<p>БХТ-өөс өгсөн саналын дагуу “Ажлын даалгавар”-т зарим өөрчлөлтийг оруулах ажил хийгдэж байна.</p> <p>2. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-тэй хамтран барилгын салбарын ажиллах хүчний эрэлт /2019 он/-ийг тодорхойлох судалгааны ажлыг 2019.10.01-ний өдрөөс эхлүүлээд байна. Энэхүү ажлын гүйцэтгэгчээр ХНХЯ-ны судалгааны институт ажиллаж байгаа бөгөөд уг судалгааны ажлыг танилцуулах уулзалтыг тус яаманд дээр 2019.10.01-ний өдөр зохион байгуулж салбарын 8 төрийн бус байгууллагын төлөөллийг оролцууллаа. Мөн эдгээр ТББ-аас гишүүн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн судалгаа авах тухай Төрийн нарийн бичгийн даргын 2019.10.08-ны 03/3797 тоот албан бичгийг хүргүүлж, хариуг хүлээн авч ХНХЯ-ны судалгааны институтэд хүлээлгэн өгсөн. Энэ судалгааны ажлыг онлайнаар хийж байгаатай холбогдуулан одоогийн байдлаар барилгын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд нийслэлийн хэмжээнд -1, орон нутагт /аймгуудыг бүсчлэн/ -4 удаагийн сургалтыг зохион байгууллаа.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	<p>1.Төрийн нарийн бичгийн даргаар “Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн сан бүрдүүлэх” ажлын даалгаврыг батлуулсан. Уг сангийн төслийн гүйцэтгэгчийг БХТ-өөс сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>2. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-тэй хамтран барилгын салбарын ажиллах хүчний эрэлт /2019 он/-ийг тодорхойлох судалгааны ажлын гүйцэтгэгчээр ХНХЯ-ны судалгааны институтыг сонгож, сургалт, онлайн судалгааны ажлыг гүйцэтгүүлж байна.</p>
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.8. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлыг салбарын үндсэн чиг үүргийн хэмжээнд зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль 8.2.6						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	Засгийн газрын 2018 оны 45,72,106,134 дүгээр тогтоолоор 50 аж ахуйн нэгжид 8525 ажилтанг гадаадаас урьж хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл олгосон байна.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Аж ахуйн нэгжийн албан хүсэлтийн тоо ШҮ2: ХНХЯ-нд хүргүүлэх тодорхойлолтын тоо						
	<i>Хүрэх түвшин</i>	<p>Эхний хагас жилд: 40-өөс доошгүй тооны хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ, 20-аас доошгүй аж ахуйн нэгжид тодорхойлолтыг гаргаж хүргүүлнэ.</p> <p>Жилийн эцэст: 1. Жилд 10-аас доошгүй тооны хүсэлтийг хүлээн авч, судлан шийдвэрлэнэ.</p> <p>2. 5-аас доошгүй аж ахуйн нэгжид тодорхойлолтыг гаргаж хүргүүлнэ.</p>						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Барилгын салбарын чиглэлээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахаар хүсэлт ирүүлсэн 97 аж ахуйн нэгжийн материалыг судлан, 62 аж ахуйн нэгжийн холбогдох тодорхойлолтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Барилга, хот байгуулалтын сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын албан бичгээр хүргүүлэв.						
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-						

	<i>Хүрсэн түвшин</i>	1. Хүлээн авсан аж ахуйн нэгжийн албан хүсэлтийн тоо: 97 2. ХНХЯ-нд Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын албан тоотоор хүргүүлсэн тодорхойлолтын тоо: 62
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8.3, 17.3						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	“Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл”-өөс зохион байгуулсан ажлын тайланг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд хүргүүлсэн.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн хуралдааны тоо ШҮ2: Дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн тоо						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: 1. дэд зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулсан байна. 2. 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, биелэлтийг хангасан байна. Жилийн эцэст: : 1. Жилд дэд зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулсан байна. 2. 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж тайлагнана.						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<ul style="list-style-type: none"> - БХБЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны эхний хуралдааныг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан. - БХБЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2019 ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж, уг зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн гишүүдийн саналыг авч тусгав. - ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019.03.27-ны өдрийн А/81 тоот тушаалаар байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессын зохион байгуулах хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх Бичиг баримтын боловсруулалт, орчуулгын асуудлаарх дэд ажлын хэсэг болон Дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийг сайжруулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. - БХБЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2019 ажлын төлөвлөгөөг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөг 2019 оны 03/1423, 03/1463, 05/1565 тоот албан бичгүүдээр ГЗБГЗЗГ, БХТ, ТОСҚ, НЗДТГ, 21 аймгийн ГХБХБГ-г тус тус хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн 2018 оны ажлын тайлан, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2018 оны ажлын товч тайланг 2018 оны жилийн эцсийн байдлаар гаргаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2019.01.11-ний өдөр 03/111 дугаартай албан бичгээр хүргүүлэв. Мөн Нэгдсэн үндэсний 						

		<p>байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн хорооноос ирүүлсэн асуултын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар биелэлтийг гаргаж хүргүүлэв.</p> <p>- Монгол Улсад Ази, номхон далайн бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх IV конгрессыг зохион байгуулахтай холбогдуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг”-ийг шалгаруулах журмын 4.1.6-д заасныг баримтлан Улаанбаатар хот болон Дархан-Уул, Өмнөговь аймгуудад хийгдсэн ажлуудыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт” төрөлд нэр дэвшүүлэн тодорхойлж, холбогдох материалыг ХНХЯ-нд БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019.05.14-ний 03/1759, 2019.05.16-ны 03/1793 албан тоотоор хүргүүлсэн.</p> <p>- ХНХЯ-наас бэлтгэн ирүүлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа” мэдээллийн лавлах ном болон Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийн товч танилцуулга болон “Мэдээллийн эмхэтгэл”-г ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК-д 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 03/1769 тоот албан бичгээр тус тус хүргүүлж үйл ажиллагаанд нь ашиглуулж байна.</p> <p>- Барилга байгууламжийн норм, нормативын сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд “Монголын тэргэнцэртэй иргэдийн холбоо” ТББ-ын УЗ-ийн гишүүн Ганбаатар оруулж, холбогдох шийдвэрийг гаргуулав. Тус сангийн үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний тодотголд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй саадгүй орчныг бүрдүүлэх зөвлөмжийн веб сайт, аппликейшн боловсруулах” ажлыг нэмэлтээр тусгуулан батлуулав.</p> <p>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлигийн дагуу Барилга, хот байгуулалтын яам болон харьяа байгууллага / ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК, 21 аймгийн ГХБХБГ/-уудад Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг батлагдсан бүтэц, орон тоондоо нийцүүлэн авч ажиллуулж буй талаарх мэдээллийг нэгтгэн гаргасан. Уг мэдээллийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хамгаалах өдөр /2019.12.03/ угтан хийх нэвтрүүлэгт зориулж ХБХХЕГ-ын харьяа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн телевизийн “ТУЛГА ТАВ” студид 2019 оны 04/4380 тоот албан бичгээр хүргүүлэв.</p> <p>- Тус яамнаас ХБХХЕГ-ын харьяа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн телевизийн “ТУЛГА ТАВ” студитэй гэрээ байгуулж “Дэд бүтцийн хүртээмжтэй орчинг бүрдүүлцгээе” сурвалжлага нэвтрүүлгийг бэлтгэн барилга, хот байгуулалт салбарт хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг телевизийн 2 сувагаар дамжуулан олон нийтэд хүргэв.</p> <p>- Барилга, хот байгуулалтын яам болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас санаачлан Монгол улсад анх удаа харааны бэрхшээлтэй иргэд, сурагчдад зориулсан 4 төрлийн брайль газрын зургийг зохион хэвлүүлж 2019 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар тусгай дунд сургуульд хүлээлгэн өгсөн.</p> <p>- ХНХЯ-наас ирүүлсэн 2019 оны 6/3760 тоот албан бичгийн дагуу салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар 2019 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэж байна.</p> <p>- Хүртээмжийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлыг ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж ахлан ажиллаж байна.</p>
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	<p>1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулсан.</p> <p>2. 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК, НЗДТГ, 21 аймгийн ГХБХБГ-т тус тус хүргүүлж биелэлтийг хангуулан ажиллаж байна.</p>
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	

Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.10. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 11.4, 19.1.6, 19.1.7						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	Суурь түвшин	"Барилга, хот байгуулалтын салбарт жендерийн талаар баримтлах бодлого" боловсруулж 2018-2025 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.						
	Шалгуур үзүүлэлт	ШҮ1: Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн хуралдааны тоо ШҮ2: Салбар зөвлөлийн 2019 оны төлөвлөгөө, тайлангийн тоо						
	Хүрэх түвшин	<p>Эхний хагас жилд: 1. 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, холбогдох газруудад хүргүүлэн хэрэгжүүлнэ.</p> <p>2. Жендерийн сургагч багшийн анхан шатны сургалтад 1 мэргэжилтнийг хамруулна.</p> <p>Жилийн эцэст: 1. Салбар зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулна.</p> <p>2. Салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж, тайлагнана.</p>						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>- БХБЯ-ны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжүүллээ. Уг ажлын төлөвлөгөөний биелэлтийн тайланг харьяа байгууллага /ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК, 21 аймгийн ГХБХБГ/-уудаар гаргуулан хүлээн авч байна. Одоогийн байдлаар Дорноговь, Дундговь аймгуудын ГХБХБГ-аас 2019 оны тайланг ирүүлээд байна.</p> <p>- БХБЯ-ны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Жендерийн үндэсний хорооноос 2019 оны 5 дугаар сарын 27-28, 2019 оны 9 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулсан "Жендэр ба бодлого төлөвлөлт" сэдэвт сургагч багшийн анхан шатны сургалтад Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ц.Баярбат, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2, "Барилгын хөгжлийн төв" /ЛӨААТҮГ/-ийн 2 нийт 5 мэргэжилтэн, Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй "Ази, Номхон далайн орнууд дахь уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдлийг даван туулах эмэгтэйчүүдийн чадавхийг бэхжүүлэх нь" бүсийн техник туслалцааны төслөөс 2019 оны 06 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдлийн удирдлагын жендерийн мэдрэмжтэй бодлого, хууль, эрх зүйн орчин ба эмэгтэйчүүдэд зориулсан ногоон ажлын байр" сэдэвт семинарт Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Б.Амартүвшин нар тус тус хамрагдлаа.</p> <p>- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар хийсэн ажлын тайланг бэлтгэн Хүний эрхийн үндэсний комисст Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 03/897 тоот албан бичгээр хүргүүлэв.</p> <p>- Жендерийн үндэсний хорооноос ирүүлсэн "Монгол Улсын жендерийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт ба сургамж" тайлан, зөвлөмжтэй танилцаж, саналыг 2019 оны 05/1197 тоот албан бичгээр хүргүүлэв.</p> <p>- Барилга, хот байгуулалтын салбарт жендерийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн талаар Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 03/4050 тоот албан бичгийг Жендерийн үндэсний хороонд хүргүүлэв.</p> <p>- Жендерийн үндэсний хорооноос бэлтгэн ирүүлсэн "Монгол Улсын жендерийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг</p>						

		хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж” тайлан /англи, монгол хэлээр боловсруулсан./-г ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК-д 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 03/1769 тоот албан бичгээр тус тус хүргүүлж үйл ажиллагаанд нь ашиглуулж байна. - ХНХЯ-наас 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Хүний эрхийн төлөө” төр-нийгэмийн талуудын уулзалтад оролцов. - БХБЯ-ны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу удирдах албан хаагчдын жендерийн цахим сургалтад хамруулах тухай 2019 оны 03/4427 тоот албан бичгийг ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК, 21 аймгийн ГХБХБГ-т хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	1. БХБЯ-ны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, холбогдох газруудад хүргүүлэн хэрэгжүүлж байна. 2. Жендерийн сургагч багшийн анхан шатны сургалтад БХБЯ болон ГЗБГЗЗГ, БХТ-ийн 4 мэргэжилтнийг хамруулсан. 100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	1.1.1.11. Салбарын шагнал олгох болон төрийн дээд одон медалиар шагнуулах иргэдийн асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх, бүртгэл судалгааг хөтлөх, материалыг архивд хүлээлгэн өгөх.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	МУ-ын Ерөхийлөгчийн 1995.5.7-ны өдрийн №71 тоот зарлиг, ЗГ-ын №53 тогтоол, Сайдын 2015.11.20-ны №227 тоот тушаал						
<i>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</i>	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	<i>1 / 7</i>	<i>2 / 8</i>	<i>3 / 9</i>	<i>4 / 10</i>	<i>5 / 11</i>	<i>6 / 12</i>
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	Сайдын 2018.02.06-ны №24, 2018.05.14-ны №86 тоот шагналын тушаал гарсан. Аймаг, нийслэл, сум, дүүрэг болон аж ахуйн нэгжүүдээс Төрийн одон медалиар шагнуулах хүсэлтээ нилээд ирүүлсэн бөгөөд үүнээс 1 иргэнийг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн баатар” цолоор, 6 иргэнийг “Гавьяат барилгачин” цолоор, 11 иргэнийг “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон-оор, 26 иргэнийг “Алтан гадас одон”-оор, 10 иргэнийг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулахаар ирүүлсэн материалтай танилцаж дэмжиж буй саналаа холбогдох байгууллагууд руу хүргүүлсэн байна.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Сайдын тушаал, бүртгэл судалгааны тоо						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Тушаал-1 Жилийн эцэст: Бүртгэл-1, Тушаал-3 гарсан байна.						
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Жилийн эцэйн байдлаар Засгийн газрын салбарын шагнал “Тэргүүний барилгачин” цол тэмдгээр 447 ажилтнуудыг, Нийтийн аж ахуйн Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 290, “Газрын харилцааны Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 31, яамны “Хүндэт жуух бичиг”-ээр 492 ажилтнууд ба нийт 1260 салбарын ажилтнуудыг шагнуулах асуудлыг Сайдын 2019 оны 17, 46, 144, 166, 188 дугаар тушаалаар шийдвэрлүүлэн, олгох ажлыг зохион байгуулсан. Өнгөрсөн оны мөн үед 1760 шагнал олгосон бөгөөд өнгөрсөн тайлант хугацаанд олгосон шагналын тоотой харьцуулахад 500 шагналаар цөөн ба 30%-иар буурсан.						

	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 30%-иар цөөн шагнал олгосон шагналын тэмдэг, үнэмлэх хэвлүүлэх зардал зохих хувиар хэмнэсэн. Хүний нөөцийн хавсран гүйцэтгэсэн цалингийн 40 хувь.
	<i>Хүрсэн түвшин</i>	Жилийн эцсийн байдлаар Сайдын 2019 оны 17, 46, 144, 166, 188 дугаар бүхий 5 тушаалаар 14410 салбарын ажилтнуудыг шагнуулах асуудлыг шийдвэрлүүлэн, олгох ажлыг зохион байгуулсан. Зардлын зохих хэмнэлт гарсан. Салбарын шагналын нэр хүнд, үнэ цэнийг хадгалахад нөлөөлсөн.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.12. Яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хуралдааныг зохион байгуулах, төлөвлөгөөнд тусгагдсан болон цаг үеийн асуудлыг салбар зөвлөлөөр шийдвэрлүүлэх, хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Төрийн албаны тухай хууль 65.3						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	<i>1 / 7</i>	<i>2 / 8</i>	<i>3 / 9</i>	<i>4 / 10</i>	<i>5 / 11</i>	<i>6 / 12</i>
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	Салбар зөвлөлийн 2018 оны төлөвлөгөө						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Салбар зөвлөлийн 2019 оны төлөвлөгөө, хэлэлцэх асуудлын жагсаалт, тогтоол, шийдвэрийн тоо. Тайлангийн тоо 2						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Тайлан-1 Жилийн эцэст:Төлөвлөгөө-1 Тайлан-2-с дээш Зөвлөлийн тайлан – 2 /хагас, бүтэн жил/						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Төрийн албаны тухай хууль шинээр батлагдаж яамны бүтцийг өөрчлөх, албан тушаалын жагсаалтыг өөрчилсөнтэй холбоотой албан тушаалын тодорхойлолтуудыг өөрчлөх, Төрийн албаны зөвлөлөөр батлуулах шаардлага гарсан бөгөөд энэ ажлыг хэрэгжүүлэх хүрээнд яамны нийт албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Салбар зөвлөлөөр хэлэлцэн Төрийн албаны зөвлөлд танилцуулан зөвшөөрөл авч баталсан. Үүнтэй холбоотой яамны бүтцийг өөрчлөх тушаал гарч төрийн албан хаагчдыг албан тушаалд томилсон. Яамны болон харьяа агентлагийн сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах асуудлыг салбар зөвлөлөөр шийдвэрлэж улмаар Төрийн албаны зөвлөлд зар хүргүүлсэний үндсэн дээр 3 албан тушаалд сонгон шалгаруулалт явуулж, зохион байгуулсан. Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотой Төрийн албаны зөвлөлд санал болгож зөвшилцсөний үндсэн дээр Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийг 11 гишүүнтэйгээр төв зөвлөлийн тогтоолоор байгуулсан.						
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-						
	<i>Хүрсэн түвшин</i>	Төрийн албаны салбар зөвлөл шинэчлэн байгуулагдсан. Яамны болон харьяа агентлагийн сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулсаны үндсэн дээр сул орон тоог нөхсөн. Яамны бүтцийн өөрчлөлт, албан тушаалын жагсаалт, албан тушаалын чиг үүргийг шинэчлэн боловсруулсан.						

Төсвийн шууд захирагчийн үнэлгээ									
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин								
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.13. Яамны хүний нөөцийн удирдлагатай холбоотой нийтлэг үйлчилгээ, өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, албан хаагчдыг ажилд томилох, чөлөөлөх, тэдгээрийн цалин, нэмэгдэл, урамшууллын хэмжээг тогтоох, ээлжийн амралт олгох санал боловсруулах, ажлын үнэмлэх олгох, бүртгэл, судалгааг хөтлөх зэрэг хүний нөөцтэй холбоотой бүхий л асуудлыг цаг тухайд нь шийдвэрлүүлэх.								
	Төлөвлөлтийн уялдаа: Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль								
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1/7	2/8	3/9	4/10	5/11	6/12	
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй							
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан							
	Суурь түвшин	Албан хаагчдыг ажилд томилох, чөлөөлөх, буцалтгүй тусламж, дэмжлэг олгох, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах зэрэг хүний нөөцтэй холбоотой ТНБД-ын 27 тушаал гарсан.							
	Шалгуур үзүүлэлт	Төрийн нарийн бичгийн даргын тушаал, хэрэгжилтийн хувь, тайлан							
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Хэрэгжилтийн хувь-90%-с дээш. Жилийн эцэст: Хэрэгжилтийн хувь-90%-с дээш. Тушаал- тухай бүр Хүний нөөцийн судалгаа, тайлан- шаардлагатай тухай бүр							
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Яамны албан хаагчдын 2019 оны ээлжийн амралтын хуваарийг Төрийн нарийн бичгийн даргын 2019.01.09-ний өдрийн Б/06 дугаар тушаалар шийдвэрлүүлсэн.</p> <p>3 улирлын байдлаар яамны албан хаагчийг ажилд томилох, ажлаас чөлөөлөх, албан үүрэг түр орлуулан гүйцэтгүүлэх, сэлгэн болон шилжүүлэх ажиллуулах, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох, ажлын чөлөө олгох, жирэмсний болон хүүхэд асрах чөлөө олгох, төслийн ажилтнуудыг ажилд томилох, чөлөөлөх зэрэг хүний нөөцтэй холбоотой асуудлуудыг ТНБД-ын 89 тушаалаар шийдвэрлүүлэн, холбогдох албан хаагчдад мэдэгдэн ажилласан. Тухайн албан хаагчтай холбоотой гарсан шийдвэр бүрийг албан хаагчийн хувийн хэргийн бүрдэлд оруулж, бүртгэсэн.</p> <p>Ажлын хэсэг яамны чиг үүрэгт шинжилгээ хийсний үндсэн дээр албан тушаалын чиг үүргийн давхардал, хийдэл, ачааллыг илрүүлэн, албан тушаалын чиг үүргийг дахин хуваарьлаж, Төрийн нарийн бичгийн даргын “Яамны бүтцийн нэгжийн орон тоо, чиг үүрэг, албан тушаал, албан тушаалын чиг үүргийг шинэчлэн батлах тухай” 2019/9/9-ний Б/85 дугаар тушаалаар батлуулсан. Энэ дагуу БХБЯ-ны албан тушаалын тодорхойлолт боловсруулах, албан хаагчдын чиг үүрэг, гүйцэтгэх ажлууд нь байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, салбарын бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээтэй хир уялдаж байгааг ШАЛГАХ зорилгоор Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор баталсан Албан тушаалын тодорхойлолт боловсруулах журам"-ын 1, 3, 4 дүгээр хавсралтын дагуу яамны газар, хэлтсийн албан тушаалын чиг үүргийн хүрээнд албан тушаалын тодорхойлолт боловсруулах мэдээлэл цуглуулах асуулгын хуудас, хяналтын хуудсаар яамны албан хаагчдаас шаардлагатай мэдээллийг цуглуулсан. Үүний үндсэн дээр яамны Бодлого, төлөвлөлтийн газар-6, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс-3, Төрийн захиргааны удирдлагын газар-15, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс-3, Хуулийн хэлтэс-4, Санхүүгийн хэлтэс-7, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-9, Барилга,</p>							

		<p>барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-10, Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-7, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар-6, Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-5, нийт 78 албан тушаалаас төрийн захиргааны болон үйлчилгээний 69 албан тушаал хамрагдсан</p> <p>“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний 21 дүгээр тогтоол, “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоол, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 275 дугаар тогтоол, “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 07 дугаар сарын 03-ны өдрийн 277 дугаар тогтоол, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоолын 1, 9 дүгээр хавсралтыг хэрэгжүүлэхээр Яамны албан хаагчдыг ажилд томилж, цалингийн хэмжээг тогтоох тухай асуудлыг ТНБД-ын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/100 дугаар тушаалаар шийдвэрлүүлэн, 10 дугаар сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Яамны зарим албан хаагчдад буцалтгүй тусламж олгох, цалинтай чөлөө олгох, зэрэг дэвийн нэмэгдэл олгох болон бусад зардлын санхүүжилт төсвийн зардлаас гарсан.
	<i>Хүрсэн түвшин</i>	<p>Төрийн албаны тухай хууль, хуулийг дагалдаг гарсан дүрэм журмуудыг яамны чиг үүргийг шинэчлэн тодорхойлох, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлуулах, ажлын байрны сонгон шалгаруулалт, томилгоо, цалин олгох болон бусад холбогдох үйл ажиллагаанд чанд мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>ТНБД-ын 2019 оны 89 тушаалаар хүний нөөцтэй холбоотой холбогдох асуудлуудыг тухай бүр шийдвэрлүүлсэн.</p> <p>Цалингийн хэмжээ, унаа хоолны хэмжээг шинэчлэн тогтоож 2019.10.01-ний өдрөөс эхлэн олгуулсан.</p> <p>ТНБД-ын 2019 оны Б/85 дугаар тушаалаар яамны албан тушаал, албан тушаалын чиг үүргийг шинэчлэн баталсантай холбоотой зарим нэг албан хаагчдаас гаргасан гомдол нь үндэслэлтэй гэж үзсний дагуу Салбар зөвлөлөөс шийдвэр гарч тус яамны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын “яамны хүний нөөцийн бодлого, зохицуулалт хариуцсан”, Хуулийн хэлтсийн “салбарын эрх зүйн зохицуулалт, мэдээллийн сан хариуцсан”, Санхүүгийн хэлтсийн “Төсвийн нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан” шинжээч гэснийг ахлах шинжээч, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын “Геодези, зураг зүй, орон зайн мэдээллийн бодлого, зохицуулалт хариуцсан” ахлах мэргэжилтэн гэснийг шинжээч болгосонтой холбоотой холбогдох тушаал шийдвэрт өөрчлөлт оруулж холбогдох албан тушаалтнуудыг өөрчлөн томилсон. Мөн үүнтэй холбоотой албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулж, зохих байгууллагаар хянуулсан.</p> <p>Нийт албан хаагчдын унаа, хоолны олговор 5000 төгрөг байсныг 8000 төгрөг болгож, 2020 оны 1 дүгээр сараас эхлэн 15000 төгрөг болгож нэмэгдүүлэх шийдвэр гарсан. 100%.</p>
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.14. Албан хаагчдын хувийн хэрэг, тоо бүртгэлийг хөтлөх, хувийн хэрэгт баяжилт хийх, төрийн албан хаагчдын мэдээллийг хүний нөөцийн программд оруулж, шаардлагатай мэдээллээр удирдлагыг хангах, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх.							
	Төлөвлөлтийн уялдаа:	Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3, 37.4, Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөх журам"-ын 13 Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	Суурь түвшин	БХБЯ-ны Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.						
	Шалгуур үзүүлэлт	Албан хаагчдын хувийн хэрэг, мэдээллийн бүртгэл хөтлөлтийн тайлан						
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Тайлан мэдээ-1Төрийн албаны хүний нөөцийн системд бүрэн тусгах Жилийн эцэст:Нэгдсэн тайланг гаргаж, ТАЗ-д хүргүүлсэн байна. Тайлан-1						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	"Журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам", "Хувь хүний намтар бичиг санамж", "Төрийн албан хаагчийн анкет А, Б маягт" –ын дагуу шинээр анкет бөглөх, намтар бичих болон бусад хувийн хэргийн бүрдэлд байх шаардлагатай баримт бичгүүдийн бүрдэлийг хангуулан, яамны нийт албан хаагчдын хувийн хэргийг шинээр дахин хөтөлсөн. Энэ нь жилийн эцсээр яамны албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг иж бүрэн гаргаж, ТАЗ-д мэдээлэхэд суурь мэдээлэл, баримтыг бүрдүүлсэн болно.						
	Зарцуулсан хөрөнгө	-						
	Хүрсэн түвшин	Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн чиглэлийн дагуу яамны Төрийн жинхэнэ албанд ажиллаж байгаа албан хаагчид болон Төрийн өндөр албан тушаал хашиж байсан, яамны нөөцөд байгаа хүмүүсийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж хүргүүлсэн. Шинээр томилогдсон 10 албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлж, баяжилт хийсэн. 100%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ								

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.15. Яамны "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	ТНБД-ын 2017.12.28-ны А/135 тоот тушаалаар батлагдсан ""Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						

	<i>Суурь түвшин</i>	Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/135 дугаар тушаалаар баталсан “Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2018-2020 оны батлагдсан төлөвлөгөө
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Яамны дотоод журам, 2019 оны төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Тайлан-1
		Жилийн эцэст:Төлөвлөгөө-1 Хэрэгжилтийн тайланг гаргасан байна. /Жилд 2-оос дээш/
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/135 дугаар тушаалаар баталсан “Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2018-2020 оны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг тухайн жилийн эцсээр үнэлж, дүгнэн, дээд шатны байгууллагад тайлагнах, жил бүр төлөвлөгөөнд тодотгол хийж, ажиллаж байна.</p> <p>“Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017-2019 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд 2019 оны эхний хагас жилд нийт албан хаагчдад Сонгино хайрхан дүүргийн Баянголын аманд зуслангийн газар олгох ажлыг зохион байгуулж байна. Уг газрын геотехникийн судалгааны үндсэн дээр газрыг дахин хуваарьлаж, барилгын зураг, төслийг боловсруулж, газар олгох асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлсэн.</p> <p>Түүнчлэн яамны нийт албан хаагчдыг 2019 оны 4 дүгээр сард “Люкс” оношлогоо, шинжилгээний төвд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамруулсан. Энэ нь албан хаагчдыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнддээ анхаарч, зарим холбогдох арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлсэн ажил болов.</p> <p>Тэрээр 15 албан хаагчдын ар гэр, бусад асуудлаар цалинтай чөлөө, буцалтгүй тусламж олгох, хүүхдээ асрах чөлөө олгох зэрэг асуудлуудыг тухай бүр Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар шийдвэрлүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлд дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал:</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны Б/22 дугаар тушаалаар ТЗУГ-ын хүний нөөцийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Б.Цолмон-Эрдэнийн хүсэлтийн дагуу хүүхэд асрах чөлөөг 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл, Б/45 дугаар тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Б.Болормаагийн хүсэлтийн дагуу хүүхэд асрах чөлөөг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаагаар тус тус сунгав. Дээрх 2 албан хаагчдын хүүхэд асрах чөлөөг хүсэлтийнх нь дагуу сунгаж, тэдний хуухдээ асрах, хүүхдийнхээ эрүүл мэндийг хамгаалахад нь дэмжлэг үзүүлэв.</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/70 дугаар тушаалаар яамны Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 2 албан хаагчдад тэтгэвэрт гарсан, 4 албан хаагчдад 50 насны ойг тохиолдуулан тус бүр бэлэг дурсгалын зүйл олгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны Б/29 тушаалаар Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Нямдашийн хүсэлтийн дагуу 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн ажлын 7 хоног, Б/35 тоот тушаалаар Орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Д.Мөнхбаатарын хүсэлтийн дагуу 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн ажлын 7 хоног, Б/61 тоот тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Монголжингоогийн эрүүл мэндийн шалтгаанаар чөлөө авах хүсэлтийн дагуу 2018 оны 03 дугаар сарын 28-ний өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 28-ий өдрийг дуустал цалинтай чөлөөг тус</p>

		<p>тус олгож, албан хаагчдыг эрүүл мэндээ хамгаалах, ар гэрийн нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хүүхдийн баярын өдрийн тохиолдуулан ТНБД-ын 2019 оны А/77 дугаар тушаалаар бүх нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан яамны албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг, дурсгалын зүйл гардуулав.</p> <p>Яамны 5 албан хаагчийн аав, ах, салбарын төрийн дээд шагналт 1 ахмад таалал төгсөхөд ар гэрт нь тус бүр буцалтгүй тусламж олгох асуудлыг шийдвэрлүүлж, хэрэгжүүлсэн.</p> <p>Энэ онд яамны 15 албан хаагчдын компьютерийн хүчин чадлыг сайжруулан шинээр сольсон.</p> <p>Яамны төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг 2018 онд хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэн Төрийн нарийн бичгийн даргын "Урамшуулал олгох тухай" 2018.6.29-ны Б/101 дүгээр тушаал, 2018.10.11-ний Б/172 дүгээр тушаал, Урамшуулал олгох тухай" 2018.12.24-ний Б/177 дүгээр тушаалаар урамшуулал олгосон.</p> <p>Яамны төрийн захиргааны боон үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг 2019 оны эхний хагас жилийн байдлаар байдлаар үнэлж, Төрийн нарийн бичгийн даргын 2019/6/27-ны өдрийн Б/58 дугаар тушаалаар 68 албан хаагчдад "Урамшуулал олгох" асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Яамны албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор "Эрүүл агаар-эм" сэдэвт аялалыг Монголын Бариллагчдын өдрийг тохиолдуулан 2019 оны 9 дүгээр сард зохион байгуулсан.</p> <p>БХБ-ын сайдын нэрэмжит 5 төрөлт спортын тэмцээнийг яам болон харьяа байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулсан.</p> <p>Газрын харилцааны албан хаагчдын өдөрт зориулсан болон Varlga.mn сэтгүүлийн нэрэмжит спортын тэмцээнд яамны баг тамирчдыг оролцуулсан.</p> <p>Засгийн газрын цом -2019" тэмцээнд гар Засгийн газрын цом-2019 тэмцээнд оролцох баг тамирчид бэлтгэл хийхэд дэмжлэг үзүүлэн, сагсан бөмбөгийн эмэгтэй, эрэгтэй багийн төрөлд "мөнгөн медаль" хүртсэн албан хаагчдад ТНБД-ын 2019 оны А/79 дүгээр тушаалаар нэг сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулалыг олгов.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Төсвийн санхүүжилтээс
	<i>Хүрсэн түвшин</i>	<p>Яамны 80 албан хаагчид зуслангийн газартай болсон.</p> <p>Нийт албан хаагчдыг эмнэлэгийн үзлэгт хамруулсан.</p> <p>Нийт ажиллаж байгаа албан хаагчдын хагас жилийн ажлыг дүгнэн ажлын үр дүнгээр үндсэн цалингийн 80 хүртэлх хувиар урамшуулал олгов.</p> <p>Ар гэрийн болон хувийн хүндэтгэн үзэх шалтгаанаар 15 албан хаагчдад цалинтай чөлөө, бие эмчлүүлэхэд 2 албан хаагчдад буцалтгүй тусламж, гэр бүлийн нь гишүүн нас нөгцөх шалтгаанаар 5 албан хаагчдад тус тус буцалтгүй тусламж үзүүлсэн.</p> <p>15 албан хаагчдын компьютерийг шинээр сольсон.</p> <p>Хүүхэд асрах чөлөөг 3 албан хаагчдад олгосон.</p> <p>Шинээр хүүхэдтэй болсон 6 албан хаагчдад буцалтгүй тусламж олгов.</p> <p>Тэтгэвэр тогтоолгосон 2, 50 нас хүрсэн 4 албан хаагчдад яамны хөдөлмөрийн дотоод журмын дагуу дурсгалын зүйл олгуулсан.</p> <p>Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад эрүүл мэндэд анхаарах, яамны төсвийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг бодит дээрх ажлуудыг хэрэгжүүлсэн.</p> <p>Спортын арга хэмжээ зохион байгуулсан нь албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалахад, бие бялдарыг хөгжүүлэхэд болон байгууллага, хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлж, харилцаа, хамтын ажиллагааг илүү сайжлуулахад болон хувь хүний багаар ажиллах чадварт эерэг нөлөө үзүүлсэн. 100%.</p>
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		
<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>	

Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.16. Төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх, шинээр томилогдсон албан хаагчдад яамны хөдөлмөрийн дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, ажлын байрыг танилцуулах, албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	Төрийн албаны тухай хуулийн 27.1, ТНБД-ын 2017 оны А/111 тушаалаар батлагдсан “Яамны хөдөлмөрийн дотоод журам”						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1/7	2/8	3/9	4/10	5/11	6/12
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	Суурь түвшин	БХБЯ-ны Салбар зөвлөлийн төрийн албан хаагчийн нөөцийн санд 16 хүн бүртгэлтэй байна. Хүний нөөцийн сул орон тоог нөхөхдөө дотоод нөөц боломжийг ашиглах чиглэлийг баримтлах						
	Шалгуур үзүүлэлт	Сул ажлын байрны захиалгыг хүргүүлсэн тоо						
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Ажлын байрны хэрэгцээ, тухайн ажлын байранд тавигдах шаардлага, албан хаагчийн мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага зэргийг харгалзан 7 албан хаагчийг сэлгэн ажиллуулсан. Жилийн эцэст:Хамрагдсан хүний тоо – 15 хүртэл						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Төрийн албаны тухай хуулийн дагуу яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан тушаалтныг шатлан дэвшүүлэх замаар нэр дэвшүүлж өгөх хүсэлтийг ТАЗ-д 2019.3.5-ны 03/760 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Барилга, хот байгуулалтын яамны сул орон тоог Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу тус яаманд, Засгийн газрын агентлаг зэрэг төрийн холбогдох байгууллагаас нөхөх зарчмыг баримтлан ажиллаж байна. Салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтний орон тоог нөхөхөөр захиалгыг ТАЗ-д тус тус хүргүүлсэн. Яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын сул орон тооны жагсаалтыг холбогдох материалуудын хамт ТАЗ-д хүргүүлээд байна.</p> <p>Яамны нийт 11 эрхэлсэн түшмэлийн албан тушаалын тодорхойлолтыг дахин боловсруулж, 2019 оны 7 дугаар сарын 18-ны өдөр имэйлээр ТАЗ-д хүргүүлсэн.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журмын 2.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 2019/9/10-ны 03/3414 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төрийн жинхэнэ албаны нөөцөд байсан албан хаагчдаас Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Барилгын Барилга байгууламжийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу зохион байгуулах комиссыг Салбар зөвлөлийн 2019/6/17-ны өдрийн 2 дугаар хуралдаанаар байгуулан, сонгон шалгаруулах ажлыг уг журмын дагуу зохион байгуулсан.</p> <p>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд нийтэд зарлах, Төрийн албаны зөвлөлд мэдээлэл ажлыг тухай бүр хэрэгжүүлж байна. Сул болон эзгүй орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл болон бусад холбогдох зүйл, заалтын дагуу ажлын зайлшгүй шаардлагын үндсэн дээр сэлгэн</p>						

		ажиллуулах, шилжүүлэх, нөөцөд байгаа албан хаагчдаас сонгон шалгаруулах, түр орлон гүйцэтгүүлэх зэрэг хэлбэрээр хуулийн хүрээнд албан хаагчийг томилон, ажил үүргийг нь гүйцэтгүүлэх арга хэмжээг авч байна.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Сонгон шалгаруулалт зохион байгуулахаар бүртгэл явуулахдаа төлбөр аваагүй ба тусгайлсан зардал төсөвлөөгүй.
	<i>Хүрсэн түвшин</i>	Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль, хуулийг дагалдан гарсан дүрэм, журмын дагуу одоо ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, сул орон тоог яам дотор болон харьяа байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас шатлан дэвшүүлэх эсхүл нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас нөхөх бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна. Яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын сул орон тоог нийтэд нээлттэй зарлуулж, сонгон шалгаруулалтыг ТАЗ явуулсан. ГЗБГЗЗГ-ын 1 удирдах албан тушаал, 5 гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлуулсан. Төрийн албаны тухай хуулийн 27.1.2 дахь хэсгийг үндэслэн тус яамны нийт 5 сул орон тоонд сонгон шалгаруулалт зарласан талаарх зарыг газрын дарга нарт дотоод албан бичгээр хүргүүлж, мөн энэ талаарх мэдээллийг Эйбел системд байршуулсан. 100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	1.1.1.17.Салбарын төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, сургах ажлыг зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Төрийн албаны тухай хуулийн 27.1, ТНБД-ын 2017 оны А/111 тушаалаар батлагдсан "Яамны хөдөлмөрийн дотоод журам"						
<i>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</i>	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	2018 онд гадаад дотоодын сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо-15						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Сургалтад хамрагдах албан хаагчийн тоо						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Урт, дунд, богино хугацааны сургалтад 5-аас дээш тооны албан хаагчийг хамруулсан байна. Жилийн эцэст: Урт, дунд, богино хугацааны сургалтад 10-аас дээш тооны албан хаагчийг хамруулсан байна.						
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Салбарын төрийн албан хаагчдыг 2019 онд мэргэшүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжүүлж байна. Энэ оны 10 дугаар сарын байдлаар ЗГХЭГ, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академиас зохион байгуулсан сургалтад удирдах албан тушаалтан, мэргэжилтэн 12 хүн, ҮХГ-аас зохион байгуулсан сургалтад хэлтсийн дарга, мэргэжилтэн 2 хүн, ТӨБЗГ-аас зохион байгуулсан сургалтад мэргэжилтэн 11 хүн, Архивын ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад мэргэжилтэн 1 хүн, АХБ-наас зохион байгуулсан сургалтад мэргэжилтэн 2 хүн, гадаад улс/БНХАУ, БНСУ, Япон, Малайз/-д зохион байгуулагдсан сургалтад мэргэжилтэн 18 хүнийг тус тус хамрууллаа. Мөн Удирдлагын академийн Төрийн захиргааны менежментийн магистрын "Гарагийн сургалт"-д ахлах мэргэжилтэн 1 хүн, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/-ийн шугамаар "Чунг-Анг" их сургуульд "Urban Development Policy" сэдэвт урт хугацааны магистрын сургалтад						

		мэргэжилтэн 1 хүнтус тус суралцуулж байгаа бөгөөд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын "Вестминстерийн Их сургууль"-д хот төлөвлөлт ба тогтвортой хөгжлийн чиглэлээр магистрантурт мэргэжилтэн 1 хүн суралцаж төгссөн. - Удирдлагын академиас ирүүлсэн 2019 оны 01/87 тоот албан бичгийн дагуу БХБЯ-наас Удирдлагын академийн магистр, мэргэшүүлэх диплом (менежерийн сургалт), сертификат(2-3 сар)-ын сургалтыг суралцаж төгссөн 13 албан хаагчийг онлайн хэлбэрээр бүртгүүлэв.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	Дотоод болон гадаадын урт, дунд, богино хугацааны сургалтад тус яамны 63 албан хаагчийг хамруулсан. Төрийн албаны тухай хуулийг 2019 оны 1 дүгээр сараас мөрдөж эхэлсэнтэй холбоотой төрийн албаны мэргэшүүлэх багц сураглалтад тус яамны эрхэлсэн түшмэлийн ангилалд ажиллаж байгаа 9 албан хаагчдыг, ахлах түшмэлийн ангилалд ажиллаж байгаа 5 албан хаагчийг хамруулсан. 100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	1.1.1.18. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж нэгтгэх, хуралдааны бэлтгэлийг хангуулж зохион байгуулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	ЗГ-ын 1996 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №259 тоот тогтоол						
<i>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</i>	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	<i>1/7</i>	<i>2/8</i>	<i>3/9</i>	<i>4/10</i>	<i>5/11</i>	<i>6/12</i>
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	2.000.000 төг						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	2018 онд Сайдын зөвлөлийн хуралдаан 9 удаа хуралдсан						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	2019 онд Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх 22 асуудлын батлагдсан төлөвлөгөө, хуралдааны тэмдэглэл, шийдвэр						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Хуралдааны тоо-5, тэмдэглэл -5 Жилийн эцэст: Хуралдааны тоо – 10-с доошгүй, тэмдэглэл 10-с доошгүй						
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Сайдын зөвлөлийн хуралдаан эхний хагас жилд (I/14,II/1,III/1,III/29,VI/24-ны өдрүүдэд) 5 удаа хуралдаж нийт 22 асуудлыг, сүүлийн хагас жилд (VII/2,IX/12,X/22,XII/3-ны өдрүүдэд) 4 удаа хуралдаж 13 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулсан.						
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Сайдын зөвлөлийн 9 гишүүнд хуралдах тухай бүр 40.000 төгрөгийн урамшуулал олгох Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/20 тоот тушаал албажсан.Эхний хагас жилд 1.840.000 төгрөгийн урамшуулал олгосон. Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/135 тоот тушаалаар 9 гишүүнд хуралдах тухай бүр 50.000 төгрөгийн урамшуулал олгосон.						
	<i>Хүрсэн түвшин</i>	Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг яамны нэгжүүдээс болон харьяа газруудаас авч, боловсруулан нэгтгэж 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдөр ТНБД-аар батлуулсан. Сайдын зөвлөлийн 9 хуралдааны бэлтгэлийг зохион байгуулж 35 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Хуралдааны тэмдэглэлийг албажуулан, гарсан шийдвэрийн						

		хэрэгжилтийг хангах, үр дүнг танилцуулахад хяналт тавьж ажилласан. 100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.19. Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын шуурхай зөвлөгөөнөөр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, тайлагналыг зохицуулалтаар хангах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	Яамны эрх зүйн байдлын тухай хууль 24.1.6						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	Суурь түвшин	2018 онд Сайдын шуурхай 22 удаа, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай 45 удаа хуралдсан.						
	Шалгуур үзүүлэлт	Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаан, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, тайлан						
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Сайдын шуурхай хуралдаан–11 -с доошгүй, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаан – 20-с доошгүй Жилийн эцэст: Сайдын шуурхай хуралдаан–20 -с доошгүй, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаан – 40-с доошгүй удаа хуралдсан байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Сайдын шуурхай 14 хоног тутамд хуралдаж , Төрийн нарийн бичгийн даргын шуурхай 7 хоног тутамд хуралдаж өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон хийгдэх ажлын талаар газар, хэлтсийн дарга, харьяа газруудын удирдлага, төслийн удирдагч нартай санал солилцож, үүрэг даалгавар өгсөн. Өгсөн үүрэг даалгаврыг тэмдэглэж дотоод сүлжээнд байршуулан хэрэгжилтийг шуурхай бүрт танилцуулан ажилласан.						
	Зарцуулсан хөрөнгө	-						
	Хүрсэн түвшин	Сайдын шуурхайд танилцуулах мэдээллийг шинэчлэн боловсруулж, харьяа газрууд, төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийг тогтмол авч танилцуулсан. 2019 онд Сайдын шуурхай 23, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай 46 удаа хуралдсан байна. Шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврыг дотоод сүлжээнд байршуулан хэрэгжилтийг хангаж ажиллахад хяналт тавьж үүрэг даалгаврын биелэлтийг шуурхай бүрт эргэн танилцуулж хэрэгжилтийг хангуулсан байна. 100%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ								

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.20. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	Суурь түвшин	2018 онд шийдвэрлэлт 100 хувь						

	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тоо, хувиар хэмжинэ.
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Тайлан – 2 /улирал бүр/ , шийдвэрлэлт 95-100 хувь Жилийн эцэст: : Тайлан – 4 /улирал бүр/ , шийдвэрлэлт 95-100 хувь
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Барилга, хот бйгуулалтын яам болон түүний харьяа байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тайланг 2019 оны 2 дугаар сарын 14-ны 03/518, 4 дүгээр сарын 16-ны 03/1298, 8 дугаар сарын 23-ны 03/3225, 10 дугаар сарын 08-ны өдрийн 03/3792 тоот албан бичгээр тус тус Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	98.1%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.21. Яамны нууцын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	2018 онд биелэлт 100 хувь						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хууль, дүрэм, журам хэрэгжсэн байна.						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Тайлан – 1 Жилийн эцэст: Тайлан – 2 /хагас, бүтэн жил/						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулсан. Ирсэн явсан албан бичгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох албан тушаалтнуудад танилцуулан, хариуг цаг хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг хэрэгжүүлсэн.						
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Тусгай баримт бичиг хадгалах электрон кодтой төмөр сейфийг 800.000 төгрөгөөр худалдан авсан.						
	<i>Хүрсэн түвшин</i>	100%						
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>								

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.22. Засгийн газрын 1996 оны 265 дугаар тогтоолын дагуу яамны аппаратын ажилтнуудад хийгдэх “Мэдээллийн цаг” арга хэмжээг зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Засгийн газрын 1996 оны 265 дугаар тогтоол, ТНБД-ын 2018.10.25-ны өдрийн №А/177 тоот тушаал, ТНБД-ын 2019.10.21-ны өдрийн А/141 тоот тушаал						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						

	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан
	<i>Суурь түвшин</i>	2018 онд биелэлт 100 хувь
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Мэдээллийн цаг арга хэмжээг зохион байгуулах тушаал 1, төлөвлөгөө 1, хамрагдсан хүний тоо
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Мэдээллийн цаг 15 удаа зохион байгуулагдаж, хамрагдсан хүний тоо давхардсан байдлаар 300-д хүрсэн. Жилийн эцэст: Мэдээллийн цаг 25-с доошгүй удаа зохион байгуулагдаж, хамрагдсан хүний тоо давхардсан байдлаар 700-д хүрэх
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	"Мэдээллийн цаг" арга хэмжээг зохион байгуулах тухай ТНБД-ын А/141 тушаалаар 2019 оны 10-р сарын 25-аас 2020 оны 5-р сарын 1-ны өдөр хүртэл 14 хоног тутамд нэг удаа зохион байгуулах төлөвлөгөөг батлуулсан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	"Мэдээллийн цаг" арга хэмжээнд уригдаж оролцох эрдэмтэн судлаачид, багш, холбогдох хүмүүст дурсгалын зүйл гардуулахад 450.000 төгрөг төсөвлөсөн.
	<i>Хүрсэн түвшин</i>	Нийт 15 удаа "Мэдээллийн цаг" арга хэмжээг зохион байгуулахаас 5 удаагийн арга хэмжээг зохион байгуулаад байна. 95 хүн оролцсон.
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.23. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Ахмад настны тухай хууль 12.1, 15.2						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1/7	2/8	3/9	4/10	5/11	6/12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Яамны үйл ажиллагааны зардлаас						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	2018 онд Сар шинийн баяраар 76, Ахмадын баяраар 80 ахмадад хүндэтгэл үзүүлсэн.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо Төрийн нарийн бичгийн даргын тушаал 2 гарсан байна						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Цагаан сараар 80 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн байна. Жилийн эцэст: Цагаан сар, Олон улсын ахмадын баяраар 80 ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн байна.						
	Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 1 дүгээр сарын 22-ны А/08 тоот тушаалаар Сар шинийн баярыг тохиолдуулан Хөдөлмөрийн баатар, гавьяат барилгачин, яамнаас тэтгэвэрт гарсан нийт 75 ахмадад хүндэтгэл үзүүлсэн. Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн А/128 тоот тушаалаар Монголын ахмадын өдрийг тохиолдуулан 78 ахмадуудад хүндэтгэл үзүүлж амралтанд нэг өдөр амрах арга хэмжээг зохион байгуулсан.					
<i>Зарцуулсан хөрөнгө</i>		Энэхүү арга хэмжээнүүдэд зориулж /5.125.000, 8.000.000/ нийт 13.125.000 төгрөгийг зарцуулсан.						
<i>Хүрсэн түвшин</i>		Давхардсан тоогоор нийт 175 ахмадад хүндэтгэл үзүүлж "Ахмад настны нийгмийн хамгааллын тухай" хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан.						
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>								

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.24. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу зохион байгуулж, баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 68 тоот тушаалаар батлагдсан Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1/7	2/8	3/9	4/10	5/11	6/12
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	Суурь түвшин	2018 онд ирсэн албан бичгийн тоо-7583, явсан-5101						
	Шалгуур үзүүлэлт	Ирсэн, явсан албан бичгийн тоогоор хэмжигдэнэ						
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Албан бичгийн тайлан-2 /улирал бүр/ Жилийн эцэст: Албан бичгийн тайлан-4 /улирал бүр/						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Яаманд ирсэн бичгийн бүрдлийг шалган хүлээж авч, сканердан, цахим албан хэрэг хөтлөлтийн программ /able/-д бүртгэн оруулж, удирдлагуудад танилцуулан холбогдох газар, хэлтэст хүлээлгэн өгч байна.</p> <p>Мөн яамнаас гадны байгууллагад явуулж буй албан бичгийн бүрдлийг шалган бүртгэлийн дугаар өгч, цахим албан хэрэг хөтлөлтийн программ /able/-д бүртгэн оруулж, шуудан болон өөрөө хүлээн авах дэвтэрт бүртгэн хүлээлгэн өгч байна.</p> <p>Ирсэн, явсан албан бичиг, шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрч байгаа албан бичгийн мэдээг 7 хоног бүр удирдлагуудад танилцуулж байна.</p> <p>Албан хаагчид явах албан бичиг, тушаал албажуулах бүрт тухайн үед хэрэглэсэн хэвлэмэл хуудас /бланк/-ыг бүртгэлийн дэвтэрт бүртгэдэг бөгөөд алдаатай гарсан, акталсан хэвлэмэл хуудсыг тухай бүрт нь бүртгэлийн дэвтэрт бүртгэн устгадаг.</p> <p>Албан хаагчдад, архив албан хэрэг хөтлөлтийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажиллаж байна.</p> <p>Яамны хэмжээнд ирсэн бичиг – 7051, явсан бичиг – 4561. ТЗУГ-т ирсэн бичиг – 2,220, явсан бичиг – 1,716. Хэрэглэсэн хэвлэмэл хуудасны тоо: Нийт 16,524 хэвлэмэл хуудас хэрэглэснээс – 1,731 хэвлэмэл хуудас актлагдсан /устгасан/ байна.</p>						
	Зарцуулсан хөрөнгө	-						
	Хүрсэн түвшин	93.4%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ								

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.25. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдүүлж ажиллах, зөвлөмжөөр хангах.							
	Төлөвлөлтийн уялдаа:	Архивын тухай хуулийн 21,22,23,25						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1/7	2/8	3/9	4/10	5/11	6/12
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Хариуцах нэгж	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	Суурь түвшин	Архивын хадгаламжийн нэгж Байнга хадгалах-285 боть Түр хадгалах-390 боть						

	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Архивын нэгж бий болгох төлөвлөгөө
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Архивын нэгж бий болгох төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан-1
		Жилийн эцэст: Архивын нэгж бий болгох төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан-1
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	“Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг-2019” бэлтгэл ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн “Улсын үзлэгийн бэлтгэл хангах тухай” А/85 дугаар тушаалаар салбар комиссыг байгуулан ажиллаж 93.4 буюу А үнэлгээтэй дүгнүүлсэн. Энэ ажлын хүрээнд архивын өрөөний багтаамжийг нэмэгдүүлэн, стандартын дагуу тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмж техник хэрэгслээр хангагдсан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	2ш нягтруулсан шүүгээ-6.900.000, CD хадгалах шүүгээ-1.400.000, чийг дулаан хэмжигч, галын хор, галын самбар зэрэгт-400.000 Нийт 8.700.000 төгрөг зарцуулсан.
	<i>Хүрсэн түвшин</i>	Биелэлт 93.4%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

№	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	1.1.1.26. Яамны мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүд, байгууллагын дотоод болон гадаад мэдээллийн урсгалын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2017 оны 159-р тогтоолоор батлагдсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ын 3.5.3						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан						
	<i>Суурь түвшин</i>	Хэвийн ажиллагаа 100 хувь						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	ШҮ1: Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь хэмжээ ШҮ2: Судалгааны тоо						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Хэвийн ажиллагаа 90-ээс дээш хувиар хангагдсан байна Жилийн эцэст: 1. Хэвийн ажиллагаа 90-ээс дээш хувиар хангагдсан байна. 2. Судалгаа -1 хийгдсэн байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Яамны дотоод болон гадаад сүлжээний сервер компьютер болон Үндэсний дата төв дээр байршуулсан 3 виртуал сервер/Яамны цахим хуудас, “Орон сууцны мэдээллийн сан”, “Барилгын тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан”-ийн хэвийн ажиллагаанд хяналт тавь, Үндэсний дата төвд яам болон харьяа агентлаг, байгууллагын дотоод удирдлагын “Эйбл” системийн серверийг байршуулж, дотоод удирдлагын “Эйбл” системийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.Системд mcsd.able.mn хаягаар хандах эрхийг авч, системийн тохируулга, хөгжүүлэлтийг хийсэн. Яамны 30 албан хаагчидад тоон гарын үсгийн төхөөрөмжийг шинээр авах баримт бичгийг бүрдүүлж, Үндэсний дата төвөөс төхөөрөмжид тохируулгыг хийлгэсэн.						

	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Дотоод удирдлагын "Эйбл" системийн ашиглалтын зардал 2,640,000.0 төгрөг, вирусны эсрэг програмын зардал 2,766,720.0 төгрөг, Сүлжээний хамгаалалтын төхөрөөмжийн програмын лицензын зардалд 2,740,540.0 төгрөг, тоон гарын үсгийн төхөрөөмжийн зардалд 1,155,000.0 төгрөгийг тус тус зарцуулсан байна.
	<i>Хүрсэн түвшин</i>	Биелэлт 100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	1.1.1.27. Яамны мэдээллийн системийн хэвийн ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэн тасралтгүй, найдвартай ажиллагааг ханган ажиллана.							
			<p>нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нөөс манай яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг гаргаж, Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.</p> <p>Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу боловсруулж батлуулсан 5 төрлийн дүрэм, журмын төсөлд санал өгч, хэлэлцүүлэгт оролцсон.</p>		
13	1.2.1.13. Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Төлөвлөгөө, Тайлангийн тоо	2018 оны байдлаар: Барилга, хот байгуулалтын салбарын дайчилгааны төлөвлөгөө, штабын бүтэц, удирдлагын бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, төлөвлөгөөний төслийг тус тус боловсруулж, Батлан хамгаалах яаманд хянуулахаар хүргүүлсэн./нууцад хамаарна/	Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулагдсан байна. Харъяа байгууллага, салбарын дайчилгааны төлөвлөгөөг батлах, биелэлтэд хяналт тавих ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.	Төлөвлөгөө "мн" зэрэглэлтэй боловсруулагдсан.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.3.1. Салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлнэ.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	
Арга хэмжээний нэр, дугаар	1.3.1.1. Барилга, орон сууц, хот байгуулалт, нийтийн аж ахуй, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын төслүүдэд хөрөнгө оруулалт татах зорилго бүхий уулзалт, форум зохион байгуулах, хоёр талын бизнес уулзалтад оролцож, мэдээлэл хийх, төслийн саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	
	Төлөвлөлтийн уялдаа:	<p>Монгол Улсын Их хурлын 2011 оны "Гадаад бодлогын үзэл баримтлалын тухай" 43 дугаар тогтоол.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам.</p> <p>НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн "Хориг арга хэмжээ авч ажиллах тухай"2375 (2017) тогтоол.</p>

		Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор батлагдсан Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр. Засгийн газрын 2019 оны “150 мянган айлын орон сууц” үндэсний хөтөлбөр батлах тухай 202 тогтоол.						
	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Тилеухан						
	<i>Суурь түвшин</i>	Хөрш орнуудтай хийж буй хамтын ажиллагаа хүрээнд ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулах талаар холбогдох байгууллагуудад тавьсан санал. БНСУ, Япон Улсын ижил төстэй байгууллагатай байгуулсан Санамж бичиг Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулагдсан Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрүүдэд барилга, хот байгуулалтын чиглэлийн төсөл хэрэгжүүлэх санал. Монгол, Оросын ЗГХК-ын 2018 оны хуралдаанаар барилга, хот байгуулалтын чиглэлээр хамтран ажиллах асуудлыг хэлэлцэх протокол НҮБ-ын Бүсийн хөгжлийн төвтэй хамтран Монгол Улсын Улаанбаатар хотноо 2018 оны 10 дугаар сард Тогтвортой тээврийн хөгжил сэдэвт олон улсын арга хэмжээ 1						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Төлөвлөгөөний дагуу байгуулагдсан олон улсын хурал, зөвлөгөөн, форум зохион байгуулах тухай ЗГ-ын тогтоол, удирдамж, зөвлөмж Уулзалт, форумын тоо, тайлан - 1						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Салбарын төслүүдэд хөрөнгө оруулалт татах зорилго бүхий уулзалт, форум зохион байгуулах, хоёр талын бизнес уулзалтад оролцож, мэдээлэл хийх, төслийн саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Жилийн эцэст: Жилийн эцэст: Салбарын чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн гадаад харилцааны асуудлыг шийдвэрлүүлэхэд чиглэлээр дэмжлэг үзүүлсэн байна. Ингэхдээ Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар болон бусад гадаадын байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, албан тоот хүргүүлэх зэрэг асуудлыг хэрэгжүүлсэн байна. Салбарын мэдээлэл технологи, хөрөнгө оруулалт, хүний нөөцийг дээшлүүлэх олон улсын арга хэмжээнд яамны төлөөлөл оролцуулсан байна. Ингэхдээ Төрийн нарийн бичгийн даргаар удирдамжийг батлуулж салбарын гадаад харилцааны чиглэлээр саналаа тусгаж батлуулсан байна. Хэрэгжилтэд байнгын хяналт тавьж хэрэгжилтийг хангуулсан байна. Улаанбаатар хотноо, аль эсвэл бусад улс оронд НҮБ-ын салбарын чиглэлээр зохион байгуулагдах уулзалт, арга хэмжээнд тус хэлтсийн төлөөлөл оролцуулж хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлыг тавьж ажилласан байна. Ингэхдээ хөрөнгө оруулалт, хамтран ажиллах тухай баримт бичиг, төсөл, хөтөлбөрт салбарын саналыг тусгуулсан байна. Улаанбаатар гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх орон сууцны хороолол төсөлд хөрөнгө оруулалт эх үүсвэрийг тодорхойлж шийдвэрлүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж ажилласан байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	1. Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шин Хайминтай 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр салбарын эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулж, протокол хөтлөв. Уулзалтаар БНХАУ-ын Засгийн газрын хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар найрсгаар санал солилцож хэрэгжийг эрчимжүүлэхэд анхаарах хэд хэдэн асуудлыг шийдвэрлэхээр тогтов.						

	<p>“Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн тоног төхөөрөмж, ажилчид түр байрлах газрыг шийдвэрлэсэнээр төслийн бэлтгэл ажлын хүрээнд талбай тэгшлэх болон бусад үйл ажиллагааг эхлүүлэх боломжтой гэдэгт талууд харилцан ойлголцолд хүрэв.</p> <p>Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан хоёр талын уулзалтаар хэлэлцсэн асуудлаар эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллуулах чиглэлээр холбогдох газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгов.</p> <p>2. БНХАУ-ын Засгийн газраас ӨМӨЗО-ны Бугат хотыг албан ёсоор итгэмжилж Бугат хотоос буцалтгүй тусламжийн алба байгуулж 2019 оны 07 дугаар сарын 16-30-ны өдрүүдэд Монгол Улсад ирж ажиллаа. Энэ үеэр Барилга, хот байгуулалтын яам болон Бугат хотын Ардын Засгийн ордон хооронд Төсөл хэрэгжүүлэх протоколыг амжилттай байгууллаа.</p> <p>Цаашид төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахаар айлын талтай хамтран ажиллаж байна. Урьдчилсан төлөвлөгөөт хуваарийн дагуу энэ оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <p>3. АНУ-ын МСК-ийн 2 дахь компакт гэрээний 350 сая ам долларын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн талаар уулзалтыг 4 удаа зохион байгуулсан. Уулзалтын үеэр Талууд МСК-ийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх 2 төсөл нь Төв цэвэрлэх байгууламжийн төсөлтэй салшгүй холбоотой тул уг төслийн санхүүжилт, хэрэгжилтийн талаар мэдээлэл солилцож, хоёр орны Засгийн газар хоорондын Зээлийн хэлэлцээр байгуулах ажил болон ТЦБ-ийн техникийн нөхцөлийг авах үйл явцыг шуурхай шийдвэрлэх талаар хамтран ажиллах нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>БНКУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-наас ирүүлсэн тус улсад болох олон улсын экспо, семинар, үзэсгэлэн худалдааны талаарх мэдээллийг харьяа байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>4. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдах 77.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 1800 айлын орон сууцны хороолол, 164.5 сая ам.долларын төсөвт өртөгтэй 4320 айлын орон сууцны цогцолбор хорооллуудыг барьж байгуулах төслүүдэд хөрөнгө оруулалт хийж, хамтран хэрэгжүүлэх саналыг Кувейтийн талд болон АНУ-ын талд тавьж, албан бичгээр төслийн саналын хамт хүргүүлсэн.</p> <p>5. Эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол-Австрийн Засгийн газар хоорондын комиссын 7 дугаар хуралдааныг Улаанбаатар хотноо 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулахтай холбогдуулан Монгол Улсын Сангийн яам, БНАвстриУ-ын Сангийн яамны хооронд байгуулсан 3 дах шатны “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн /40 сая евро/ хүрээнд төсөл хэрэгжүүлэх саналаа БСШУЯ, БХБЯ, ХЗДХЯ, ХХААХҮЯ, ЭМЯ, НЗДТГ зэрэг байгууллагуудаас ирүүлснийг нэгтгэн яамны удирдлагад танилцуулсан. Комиссын хуралдааны Монголын талын Ажлын хэсгийн 2 удаагийн хуралдаан дээр мөн танилцуулсан.</p> <p>Монгол, Австрийн Засгийн гаазр хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны 3 дахь удаагийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр зарим яамд, НЗДТГ-аас ирүүлсэн 15 төслийн жагсаалтыг Сайд Х.Баделханаас Сангийн сайд Ч. Хүрэлбаатарт 2019/11/18-ны 01/4322 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүнтэй холбоотой тус яаманд 2019/11/22-ны өдөр болсон хуралд оролцож, Улаанбаатар хотын бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх төсөл, Аймгийн төв, суурин газруудын хатуу хог хаягдлын менежментийн төслийг тус тус танилцуулан Австрийн нэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хүсэлтийг дахин тавьсныг Сангийн яам хүлээн авч болохыг мэдэгдсэн.</p> <p>6. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын 2018 оны 12 дугаар сард Катар, Кувейт Улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд “Кувейтийн Хөгжлийн санд 10 хүртэлх сая ам.долларын төслийг хүргүүлэх” гэж заасны дагуу 2019.10.01-ний 01/3700 албан бичгээр уг хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий аймгийн газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй олон нийтийн барилгыг буулгаж, шинээр барих дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэх саналыг хүргүүлсэн. Хариу хүлээгдэж байна.</p>
--	--

		<p>7. Монгол Улсад 2019 оны 7 дугаар сарын 9-13-ны өдрүүдэд хийсэн Бүгд Найрамдах Польш Улсын Гадаад хэргийн дэд сайд Мацей Лангийн айлчлал болон энэ үеэр болсон Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Польш Улсын Гадаад хэргийн яам хоорондын улс төрийн зөвлөлдөх уулзалтын үеэр Польшийн Засгийн газрын нөхцөлт тусламжийн зээлийн гэрээний хугацааг сунгаж, зээлийн хүрээнд хэрэгжүүлэх Монголын Улсын Баян-Өлгий, Завхан, Увс, Дорнод, Говьсүмбэр аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн гэрээг байгуулах чиглэлд талууд анхаарч ажиллах саналыг хүргүүлсэн.</p> <p>8. Улаанбаатар хотын агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, иргэдийг төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах зорилт, арга хэмжээний хүрээнд Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороонд 5002 айлын түрээсийн орон сууцны Солонго-1, 2 хорооллын төслийг БНСУ-ын Засгийн газрын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангийн агентлаг болох Экспорт-Импорт банк (ЭКСИМ)-ны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 2019 оны эхний улирлаас хойш хэлэлцэн, тохиролцсныг 2019.11.28-ны өдөр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, БНСУ-ын Засгийн газрын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангийн агентлаг болох Экспорт-Импорт банкны Ази хариуцсан захирал Кү Боньон нар Хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж, албажуулав.</p> <p>Уг тэмдэглэлийг албажуулснаар хоёр орны Засгийн газар хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн үйл явцыг урагшлуулахад дэмжлэг болох суурь баримт бичгийг бүрдүүллээ.</p> <p>9. БНХАУ-ын Засгийн газраас ӨМӨЗО-ны Бугат хотыг албан ёсоор итгэмжилж Бугат хотоос буцалтгүй тусламжийн алба байгуулж 2019 оны 07 дугаар сарын 16-30-ны өдрүүдэд Монгол Улсад ирж ажиллаа. Энэ үеэр Барилга, хот байгуулалтын яам болон Бугат хотын Ардын Засгийн ордон хооронд Төсөл хэрэгжүүлэх протоколыг 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр амжилттай байгууллаа.</p> <p>Цаашид төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахаар айлын талтай хамтран ажиллаж байна. Энэ оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар зураг, төсөл, тендерийн баримт бичгийг Бугат хотын Ардын Засгийн ордонтой хэлэлцэж, харилцан ойлголцолд хүрсэн талаар талууд уулзалтын протокол байгуулав. Тус протоколд худалдан авах ажиллагааг энэ сард багтаан эхлүүлэхээр тогтов.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	1.3.1.2. Олон Улсын байгууллага, гадаад улс орнуудтай барилга, хот байгуулалтын салбарт хамтран ажиллах хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрт санал өгөх, яамтай байгуулах гэрээ, санамж бичгийг боловсруулах, байгуулах ажлыг зохион байгуулах, бүртгэх, биелэлтийг тайлагнах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан "Журам шинэчлэн батлах тухай"						
	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нээж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Тилеухан						
	<i>Суурь түвшин</i>	Барилга, хот байгуулалтын яам болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулсан баримт бичгийн тоо-24.						

	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Олон улсын гэрээ, конвенци, Олон улсын гэрээний тухай хууль болон холбогдох журам, байгуулсан гэрээ, хэлэлцээр, хүргүүлсэн санал, албан бичиг Гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн тоо, тайлан - 1
	<i>Хүрэх түвшин</i>	<p>Эхний хагас жилд: Салбарт хамтран ажиллах хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрт санал өгөх, яамтай байгуулах гэрээ, санамж бичгийг боловсруулах, байгуулах ажлыг зохион байгуулаж, бүртгэж, биелэлтийг тайлагнасан байна.</p> <p>Жилийн эцэст: Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар олон улсын байгууллагуудтай эрх зүйн хүрээнд хамтран ажиллах баримт бичгийн тоог нэмэгдүүлэх.</p> <p>БНСУ, Япон Улсын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай байгуулсан Санамж бичгийн хэрэгжилтийг дээшлүүлж эл чиглэлээр яамны удирдлагын хэмжээнд айлчлал зохион байгуулсан байна. Ингэхдээ төлөвлөгөө боловсруулж холбогдох удирдлагаар батлуулан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</p> <p>Хөрш орнуудын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран ажиллах тухай Санамж бичгийн төслийг эцэслэн тохирсон байна.</p>
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>1.Барилга, хот байгуулалтын яам, “Каритас Чех Репаблик” байгууллагын хооронд байгуулах харилцан ойлголцлын Санамж бичгийн төслийг монгол, англи хэл дээр хянан боловсруулж, 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Санамж бичгийг үзэглэх ажлыг зохион байгуулсан. Санамж бичгийн зорилго нь техник туслалцааны “Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төсөл”-ийг хамтран хэрэгжүүлэх явдал юм. Санамж бичгийн хүрээнд барилгын хатуу хог хаягдлын хэмжээ, түүнийг ашиглах боломжуудыг талаар судалгаа хийж байна.</p> <p>2. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам болон ӨМӨЗО-ны Бугат хотын Ардын Засгийн ордонтой “1008 айлын орон сууцны төсөл”-ийн хүрээнд Төсөл хэрэгжүүлэх протоколыг 2019 оны 07 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан. Уг протоколыг байгуулахдаа Сангийн яамнаас холбогдох саналыг авч, протоколын төсөлд тусгуулсан байна.</p> <p>3. Барилга, хот байгуулалтын дэд сайд Б.Мөнхбаатар тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсын Токио хотноо 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хийсэн айлчлалын үеэрээ Барилга, хот байгуулалтын яам болон Япон Улсын Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын яамтай байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийн хүрээнд хоёр талын уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар мэдээлэл солилцов. Уулзалтаар дээрх санамж бичгийг байгуулснаас хойш анх удаагаа яамны удирдлагын түвшинд уулзалт зохион байгуулсан бөгөөд цаашид Японы Засгийн газрын төрөөс баримталж буй орон зайн бодлогын хүрээнд хамтран ажиллахаар талууд харилцан тохирсон байна.</p> <p>4. БХБЯ болон БНСУ-ын Хөгжлийн институттай байгуулсан хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд “Аэросити” шинэ хотын анхан шатны ТЭЗҮ-ийг боловсруулах асуудлаар хамтран ажиллаж, 2019 оны 09 дүгээр сард амжилттай дуусгавар болгов.</p> <p>5. БХБЯ болон БНХАУ-ын Газар, ашигт малтмалын яамтай хамтран ажиллах Санамж бичгийн төслийг Монгол, Англи хэл дээр хүргүүлж төслийн хамтран ажиллах цар хүрээг эцэслэх асуудлаар хамтран ажиллаж байна.</p> <p>6. БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн БНСУ-д 2019 оны 11 дүгээр сарын 18-24-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийж, айлчлалаар ижил төстэй байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, Солонго-1, 2 төслийн асуудлаар санал солилцов. Айлчлалын үр дүнд төслийн төсвийн тооцооны асуудлаар талууд байр сууриа нэгтгэж, эцэслэн шийдвэрлэсэн байна.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-

	<i>Хүрсэн түвшин</i>	Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрт санал өгөн ажилласан ба БХБЯ гадаадын хуулийн этгээдтэй байгуулсан Санамж бичиг, төслийн гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний төсөлд санал өгч, газрын үсэг зурах ажлыг зохион байгуулж ирсэн. Ингэснээр тухайн санамж бичиг, төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ хэрэгжих боломж бүрдсэн. Хэрэгжилт 100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	1.3.1.3. Салбарын гадаад арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулж, холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, биелэлтийг тайлагнаж ажиллах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн гадаад бодлого, үйл ажиллагаанынэгдмэл байдлыг хангах журам. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны а/77 дугаар тушаалаар баталсан “Гадаадад томилолтоор ажиллах тухай журам”						
	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	<i>1 / 7</i>	<i>2 / 8</i>	<i>3 / 9</i>	<i>4 / 10</i>	<i>5 / 11</i>	<i>6 / 12</i>
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Шаардлагатай. Тухайн төлөвлөгөөгөөр хөрөнгийг дэлгэрэнгүй байдлаар батална.						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Тилеухан						
	<i>Суурь түвшин</i>	2018 оны гадаад арга хэмжээний батлагдсан төлөвлөгөө						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Гадаад арга хэмжээний 2019 оны төлөвлөгөө-1 Тайлан-1						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Салбарын гадаад арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулж, холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, биелэлтийг тайлагнаж ажилласан байна. Жилийн эцэст: Гадаад арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, дэвшилтэд технологи нэвтрүүлж эл асуудлаар холбогдох биелэлт тайланг хүргүүлж танилцуулсан байна.						
<i>Арга хэмжээний хэрэгжилт</i>	<i>Хэрэгжилт</i>	Яам, харьяа байгууллагуудын гадаад арга хэмжээний 2019 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, яамны дотоод сүлжээнд байрлуулж, харьяа байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал: Хоёр орны Засгийн газар хоорондын комиссын хуралдаан, гадаад томиололтой холбоотой ажлуудыг тухай бүр хугацаанд нь зохион байгуулан ажиллаж байна. 2019 онд батлагдсан Гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд Монгол, Оросын ЗГХК-ын хуралдаанд салбарын төлөөлөл оролцуулж харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Батжаргал тэргүүтэй холбогдох байгууллагын төлөөллийн хамт 2019 оны 06 дугаар сарын 23-30-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны Б/52 дугаар тушаалын дагуу томилолтоор ажиллуулав. Чингэхдээ, Монгол Улсын барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарт олон улсын норм, нормативын баримт бичиг, стандартыг нэвтрүүлэх арга замыг эрчимжүүлж, барилгын чанар, аюулгүй ажиллагааг сайжруулах, салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, барилга, байгууламжийн зураг төсөлд магадлал хийх боловсон хүчинг мэргэшүүлэхэд түлхэц болж, үр дүнтэй ажиллав. Монгол Улсын нийтийн аж ахуйн салбарт “Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийг 1965 оноос хойш анх удаагаа хэрэгжүүлэхтэй холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай уулзах үеэрээ эл асуудлаар санал солилцож, салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх						

		асуудлыг айлын талд тавьсны мөрөөр БНХАУ-ын Худалдааны яамны санхүүжилтээр “Монгол Улсын бохир ус” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Яамнаас салбарын харьяа байгууллагуудын мэргэжлийн ажилчдыг мэргэшүүлэх, дадлагажуулах, чадавхийг дээшлүүлэх бодлогыг баримталж, ГЗБГЗ, БХТ, ТОСК, УСУГ, УЗҮЗҮЗ болон ТХН зэрэг нийт 25 хүний бүрэлдэхүүнтэй сургалтад 1 сарын хугацаатай хамруулав. Гадаад арга хэмжээний 2019 оны төлөвлөгөөний биелэлт, 2020 оны төлөвлөгөөнд санал болон гадаад дипломат, албан паспортын мэдээг 12 дугаар сарын 10-ны дотор авахаар яамны газар, хэлтэс, харьяа байгууллагуудад албан бичиг, маягтууд хүргүүлсэн. Энэ онд яамны албан хаагчдын 87% нь гадаадад албан томилолт, сургалтад хамрагдсан.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Гадаад томилолтын 95% нь зохион байгуулагч талын зардлаар хийгдсэн. Гадаад томилолт, зочин хүлээн авахад 2019 онд 25,605,555.0 төгрөг нормчлолын сан болон холбогдох эх үүсвэрээс гаргасан.
	<i>Хүрсэн түвшин</i>	98%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>						
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	1.3.1.4. Засгийн газар хоорондын комиссын хуралдаан, зөвлөлдөх уулзалт, ажлын хэсгийн хуралдааны удирдамж, яриа хэлэлцээний сэдэвт салбарын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны санал боловсруулж хэлэлцүүлэх, мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, биелэлтийг тайлагнах.						
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Монгол Улсын Их хурлын 2011 оны “Гадаад бодлогын үзэл баримтлалын тухай” 43 дугаар тогтоол. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам.					
<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Тилеухан						
<i>Суурь түвшин</i>	Монгол, Хятадын ЗГХК, Монгол, Оросын ЗГХК, Монгол, Солонгосын ЗГХК, Монгол, Японы ЗГХК, Монгол, Австрийн ЗГХК, Монгол, Беларусын ЗГХК, Монгол, Германы ЗГХК, Монгол, Польшийн ЗГХК зэрэг нийт 7 хуралдаанд барилга, хот байгуулалтын чиглэлээр холбогдох саналыг тусгуулж батлуулсан.						
<i>Шалгуур үзүүлэлт</i>	Гадаад арга хэмжээний 2019 оны төлөвлөгөө, боловсруулсан санал, албан бичиг Албан бичиг, хүсэлт-10 хүртэл Хэрэгжилтийн нэгдсэн тайлан-1						
<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Засгийн газар хоорондын комиссын хуралдаан, зөвлөлдөх уулзалт, ажлын хэсгийн хуралдааны удирдамж, яриа хэлэлцээний сэдэвт салбарын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны санал боловсруулж хэлэлцүүлэх, мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, биелэлтийг тайлагнасан байна.						

		<p>Жилийн эцэст: Комиссын хуралдааны асуудлаар холбогдох газруудаас биелэлтийг авч нэгтгэн Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн байна.</p>
<p>Арга хэмжээний хэрэгжилт</p>	<p><i>Хэрэгжилт</i></p>	<p>Улаанбаатар хотноо 10 дугаар сарын 17-ны өдөр болсон Эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол, Австрийн Засгийн газар хоорондын 7 дугаар хуралдааныг Гадаад харилцааны яамтай хамтран зохион байгуулсан. Хуралдааныг Барилга, хот байгуулалтын сайд, тус комиссын монголын хэсгийн дарга Х.Баделхан, австрийн талаас Холбооны Цахимжуулалт, эдийн засгийн яамны Олон улсын эдийн засгийн газрын Ерөнхий захирал, тус комиссын австрийн хэсгийн дарга Франц Вессиг нар удирдав. Хуралдааны эхэнд өмнөх хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө амжилттай биелснийг танилцуулаад Австрийн Засгийн газраас олгож буй 40 сая еврогийн нэн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд байгуулах Санхүүгийн хамтын ажиллагааны 3 дахь хэлэлцээрт хоёр талын Сангийн сайд нар гарын үсэг зурсныг талууд сайшаав.</p> <p>Монгол, Австрийн эдийн засгийн харилцааны механизм болох энэхүү хамтарсан комиссын хуралдаан нь хоёр орны хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааны чухал хөшүүрэг болох учиртайг сайд Х.Баделхан тэмдэглээд байгаль орчин, тэр дундаа байгалийн нөхөн сэргээлт, цэвэр эрчим хүчний үйлдвэрлэл зэрэг салбарт арвин туршлагатай, дэлхийд тэргүүлэх өндөр техник, технологитой Австри Улстай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, мөн сонгодог урлагын салбарт хамтран ажиллах, түүхэн дурсгалт барилга, байгууламжийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр австрийн туршлагаас суралцах хүсэлтэй буйгаа илэрхийлэв.</p> <p>Австри Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Монголд хэрэгжих төслүүдийн цар хүрээ, хамрах салбарыг өргөжүүлэхэд австрийн тал өндөр ач холбогдол өгч, манай талын саналыг дэмжин, энэ удаагийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт “Нийгмийн дэд бүтэц” хэмээх шинэ салбарт тэр дундаа соёлын салбарт төслүүд хэрэгжүүлэх боломжтойг тэмдэглэн, хуралдааны протоколд тусгахыг дэмжив.</p> <p>Хуралдааны үеэр Монгол Улсын эдийн засаг, хөрөнгө оруулалтын нөхцөл байдал, хоёр талын худалдаа, эдийн засгийн эргэлтийг Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал В.Энхболд төлөөлөгчдөд танилцуулав. Мөн Монгол Улсын Засгийн газраас соёл урлаг, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр баримталж буй бодлого болон Монгол, Австрийн Засгийн газар хооронд байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Тайшир-Алтай” ус хангамжийн төсөл, “Дэд бүтцийн хөгжил” төслийн явцын талаар салбарын төлөөлөгчид товч танилцуулга хийв.</p> <p>Улаанбаатар хотын ачааллыг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар ирэх жилийн 6 дугаар сард ашиглалтад орох шинэ нисэх онгоцны буудлын дагуу Аэросити, 300 мянган хүн амьдрах Майдар сити хэмээх 2 дагуул хот байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллахад бэлэн буйгаа Сайд Х.Баделхан танилцуулсныг туршлага судлах чиглэлээр айлын тал манай төлөөлөгчдийг хүлээн авахаа илэрхийлсэн.</p> <p>Дээрх хуралдааны мөрөөр Барилга, хот байгуулалтын сайд, тус комиссын монголын хэсгийн дарга Х.Баделханаас БНАвстриУ-ын Холбооны Цахимжуулалт, эдийн засгийн яамны Олон улсын эдийн засгийн газрын Ерөнхий захирал, комиссын австрийн хэсгийн дарга Франц Вессид 2019.11.21-ний 01/4372 тоот албан захидал хүргүүлсэн. Уг албан захидалд хуралдааны үеэр хэлэлцэн тохирсон ажлуудыг ажил хэрэг болгоход идэвхитэй хамтран ажиллахаа илэрхийлэн, түүний дотор, хоёр орны Засгийн гаазр хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны 3 дахь удаагийн хэлэлцээрийн хүрээнд “Нийгмийн дэд бүтэц” чиглэлд түүхэн дурсгалт барилга, байгууламжийг хамгаалах, сэргээн засварлах төслийг хамтран хэрэгжүүлэх, манай төлөөлөгчдийг Австри Улсад хүлээн авч, Асперн эко хоттой</p>

		<p>танилцуулах ажлыг 2020 оны эхний улиралд зохион байгуулах зэрэг саналыг тавьлаа.</p> <p>Монгол, Австрийн Засгийн гаазр хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны 3 дахь удаагийн хэлэлцээрийн хүрээнд БХБЯ, БСШУЯ, БОАЖЯ, ХЗДХЯ, ЭМЯ, НЗДТГ зэрэг байгууллагуудаас 15 төслийн жагсаалт ирүүлснийг Сайд Х.Баделханаас Сангийн сайд Ч. Хүрэлбаатарт 2019/11/18-ны 01/4322 тоот албан бичгээр хүргүүлж, тус яаманд 2019/11/22-ны өдөр болсон хуралд оролцож, Улаанбаатар хотын бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх төсөл, Аймгийн төв, суурин газруудын хатуу хог хаягдлын менежментийн төслийг тус тус танилцуулан зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хүсэлтийг дахин тавьсан. Сангийн яам эдгээр 2 төслийг дэмжиж болохоо илэрхийлсэн.</p> <p>Берлин хотноо 2019 оны 5 дугаар сард болох “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн 7 дугаар хуралдааны удирдамж, яриа хэлэлцээний сэдэвт дараах саналыг тусгуулж, айлын талд тавьж, хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Үүнд: Шинжлэх ухаан-үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ технологи, инновацийг дамжуулах, нутагшуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, барилгын материалын үйлдвэрлэл- технологийн парк бий болгож хөгжүүлэх;</p> <p>-Эх орны эрдэс түүхий эдийг гүн боловсруулах, газар хөдлөлт, үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, “ногоон” технологийг хөгжүүлэх;</p> <p>-Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгож, сургалтын чанарыг дээшлүүлэх, салбарын мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдыг давтан сургах, богино хугацаагаар өндөр хөгжилтэй оронд ажиллуулах, техникийн боловсролын түвшинг хөгжиж буй орны сургалтын түвшинд хүргэх;</p> <p>-Улаанбаатар хотын гэр хороолол, орон нутгийн сум, суурин газрын эрчим хүчний бие даасан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Германы газрын гүний дулааныг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх технологийг Монгол Улсад нэвтрүүлэх чиглэлээр хамтарсан төслийг хэрэгжүүлэх зэрэг болно.</p> <p>Ажлын хэсгийн хуралд болон Берлин хотноо 2019 оны 5 дугаар сарын 13-19-ний өдрүүдэд “Инновацийн талаарх Ази-Европын хэлэлцүүлэг” сэдвийн дор болох “Ази Номхон далайн орнуудын 7 хоног” арга хэмжээний хүрээнд “Монголын эдийн засгийн өдөрлөг”-т оролцож, “Салбарын мэргэжилтнүүдийг евро нормыг судлах болон бусад чиглэлд сургах, Улаанбаатар хотын гэр хороолол, орон нутгийн сум, суурин газрын эрчим хүчний бие даасан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Германы газрын гүний дулааныг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх технологийг Монгол Улсад нэвтрүүлэх хамтарсан төсөл” болон бусад төсөл арга хэмжээг танилцуулах, яриа хэлэлцээ хийхээр Барилга, хот байгуулалтын яамнаас төлөөлөгч оролцуулах саналыг 2019/03/19-ний 01/923 тоот албан бичгийг Монгол Улсаас ХБНГУ-д суугаа ЭСЯ-нд, 2018/03/29-ний 01/1082 тоот албан бичгээр УУЯ-нд тус тус хүргүүлсэн.</p> <p>Астана хотноо 2018 оны 3 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд болсон Монгол, Казахстаны Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны ЗГХК-ын VII хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд болон Бельгийн Вант Улсын Брюссель хотноо 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр болсон Монгол Улс, Европын Холбооны Хамтын ажиллагааны хамтарсан хорооны 18 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 28-д тусгагдсан ажлын талаарх товч мэдээлэл болон 19 дүгээр хуралдааны үеэр “Өмнөх хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх чиглэлд талууд идэвхитэй хамтран ажиллах” асуудлыг тавьж, ярилцахаар хүргүүлээ.</p>
--	--	---

		<p>Ром хотноо 2019 оны 6 дугаар сарын сүүлийн долоо хоногт зохион байгуулагдах Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Монгол, Италийн Засгийн газар хоорондын холимог комиссын гуравдугаар хуралдааны яриа хэлэлцээний жагсаалтад “Италийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр тус улсад барилга, хот байгуулалтын чиглэлээр богино хугацааны сургалтад хамруулах, туршлага судлах, тухайлбал;Италийн Олон улсын хөдөлмөрийн байгууллага /International Labour Organization-ILO/-ын шугамаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ногоон ажлын байр, олон улсын гэрээ /FIDIC/ боловсруулах аргачлалын талаар зэрэг сургалтад хамруулах” асуудлыг тусгуулж, айлын талтай хамтран хэрэгжүүлэх саналыг ГХЯ-нд хүргүүлж, тусгуулсан.</p> <p>Улаанбаатар хотноо энэ оны 6 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд болох Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Беларусийн ЗГХК-ын 5 дугаар хуралдааны протоколын төсөлд санал боловсруулж, ГХЯ-нд имэйлээр хүргүүлсэн.</p> <p>Монгол, Киргизийн Засгийн газар хоорондын комиссын хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд ГХЯ-нд санал хүргүүлэв.</p> <p>Монгол, Хятадын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын хуралдааны XV хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг яамны холбогдох газар, хэлтсээс авч нэгтгэн боловсруулж ГХЯ-д албан тоотоор хүргүүлэв. Мөн тус ЗГХК-ын XVI дугаар хуралдаан 2019 оны 08 дугаар сарын 02-04-ны өдрүүдэд зохион байгуулагдсан холбогдуулан дараах саналыг Монголын талын яриа хэлэлцээний сэдэвт тусгуулахаар хүргүүлэв. Үүнд:</p> <p>“Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн монголын талын бэлтгэл ажлыг хангасантай холбогдуулан Тусгайлсан зээлийн хэлэлцээрийг байгуулах асуудлыг түргэлүүлэх чиглэлээр айлын талтай яриа хэлэлцээ хийх;</p> <p>БНХАУ-ын 2.0 тэрбум юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Улаанбаатар хотын гэр хорооллын инженерийн дэд бүтцийг сайжруулах төслийн “Солилцох захидал” баримт бичгийг байгуулах асуудлыг эрчимжүүлэх;</p> <p>Улаанбаатар хотноо зохион байгуулагдах ээлжит хуралдаанд тус яамны төлөөлөл оролцуулах.</p> <p>ЗГХК-ын үеэр УБХТЦБШБ төслийн хүрээнд БНХАУ-ын Эксим банкны төлөөлөлтэй хоёр талын уулзалт зохион байгуулж, уулзалтаар зээлийн тусгайлсан хэлэлцээрийг байгуулах асуудлыг түргэлүүлэх чиглэлээр санал солилцлоо. Айлын талаас зээлийн хэлэлцээрийг байгуулахад шаардлагатай нэмэлт баримт бичгийг Монголын талаас хүсэж, үүний мөрөөр ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, төслийн шинэчлэгдсэн ТЭЗҮ болон төсөл хэрэгжүүлэх талбайн байгаль орчны үнэлгээний дүгнэлтийг Хятадын талд хүргүүлэв. Одоогийн байдлаар зээлийн хэлэлцээрийг байгуулахад шаардагдах үнэлгээний шатны ажил хийгдэж байна.</p> <p>Монгол, Оросын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын 22 дугаар хуралдаан зохион байгуулахтай холбогдуулан барилга, хот байгуулалтын чиглэлээр санал хүргүүлэхийн зэрэгцээ өмнөх хуралдааны биелэлтийн хамт хүргүүлэв. Дээрх ЗГХК-ын хуралдааны хүрээнд барилга, хот байгуулалтын салбарын төлөөлөл ОХУ-д айлчлав.</p> <p>Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хамтарсан хорооны ээлжит хуралдааны Монголын талын хэлэлцэх асуудалд дараах саналыг хүргүүлж ажилласан байна. Үүнд:</p> <p>-БНСУ-ын Засгийн газрын 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, түргэлүүлэх чиглэлээр яриа хэлэлцээ хийх;</p>
--	--	---

		<p>-Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам нь БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яамтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хоёр улсын барилга, хот байгуулалт, дэд бүтцийн асуудал хариуцсан яам хоорондын байнгын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах асуудлаар дэмжлэг үзүүлж, шийдвэрлүүлэх чиглэлээр яриа хэлэлцээ хийх;</p> <p>-Уг хуралдаанд тус яамны төлөөлөл оролцуулах боломжийн талаар судалж мэдээлэх зэрэг болно.</p> <p>Уг хуралдаан БНСУ-д зохион байгуулагдсан бөгөөд БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих түрээсийн орон сууцны төсөл, хөтөлбөрийн зээлийн ерөнхий хэлэлцээрийг энэ онд багтаан байгуулахаар тохиролцжээ.</p> <p>Монгол, Японы ЗГХК-ын хуралдаан энэ онд зохион байгуулагдаагүй.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгөө</i>	ТНБД-ын 2019 оны Б/52 дугаар тушаалын дагуу Монгол, Оросын ЗГХК-ын хүрээнд ажиллах Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Батжаргалын гадаад томилолтын зардалд 7,071,555.4 төгрөгийг зарцуулсан байна.
	<i>Хүрсэн түвшин</i>	<p>Хуралдаан нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд, хамтын ажиллагааны ажлуудаа хэлэлцэн шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол, Австрийн Засгийн газар хоорондын 7 дугаар хуралдааны үеэр талууд "Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийг амжилттай хэрэгжүүлэх чиглэлээр нягт хамтран ажиллахаар болсон. Хуралдааны мөрөөр Австрийн Асперн хоттой танилцахаар болсон.</p> <p>Хэрэгжилт 100%.</p>
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	1.3.1.5. Өндөр дээд түвшний айлчлалын удирдамж, яриа хэлэлцээний сэдэвт салбарын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны санал боловсруулж, яриа хэлэлцээний сэдэвт болон мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, биелэлтийг тайлагнах.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Монгол Улсын Их хурлын 2011 оны "Гадаад бодлогын үзэл баримтлалын тухай" 43 дугаар тогтоол. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам.						
<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	<i>1/7</i>	<i>2/8</i>	<i>3/9</i>	<i>4/10</i>	<i>5/11</i>	<i>6/12</i>	
<i>Шаардагдах хөрөнгөө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй							
<i>Хариуцах нээж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Тилеухан							
<i>Суурь түвшин</i>	Монгол Улсын Ерөнхийлөгчийн хийсэн төрийн айлчлалын удирдамж яриа хэлэлцээний сэдэвт, Монгол Улсын Их Хурлын даргын өндөр түвшний айлчлалын удирдамж яриа хэлэлцээний сэдэвт, Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн дээд түвшний айлчлалын удирдамж яриа хэлэлцээний сэдэвт тус тус барилга, хот байгуулалтын чиглэлээр нийт 8 удаа санал тусгуулсан байна.							
<i>Шалгуур үзүүлэлт</i>	Гадаад арга хэмжээний 2019 оны төлөвлөгөө, хүргүүлсэн санал, албан бичиг Албан бичиг, хүсэлт-10 хүртэл Хэрэгжилтийн нэгдсэн тайлан-1							
<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Өндөр дээд түвшний айлчлалын удирдамж, яриа хэлэлцээний сэдэвт салбарын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны санал боловсруулж, яриа хэлэлцээний сэдэвт болон мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах,							

		<p>хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, биелэлтийг тайлагнаж ажилласан байна.</p> <p>Жилийн эцэст: Нэг болон түүнээс дээш удаа өндөр дээд түвшний айлчлалд салбарт баримталж буй бодлогыг холбогдох газар, нэгжээс нэгтгэн авч айлчлалын үеэр баримтлах удирдамж, монголын талын яриа хэлэлцээний сэдэвт тусгуулж шийдвэрлүүлэхээр чиглэлээр дэмжлэг үзүүлж хэрэгжилтэд хяналт тавьж биелэлт гарган ажилласан байна.</p>
<p>Арга хэмжээний хэрэгжилт</p>	<p><i>Хэрэгжилт</i></p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2019 оны 3 дугаар сард, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын 2019 оны 11 дүгээр сард Америкийн Нэгдсэн Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр айлын талд тавьж шийдвэрлүүлэх саналыг боловсруулж, ГХЯ-нд хүргүүлсэн. Тухайлбал: Улаанбаатар хотод бие даасан эрчим хүчний эх үүсвэр бүхий төлбөрийн чадварт нийцсэн амины орон сууцны хорооллын жишиг төслийг хамтран хэрэгжүүлэх саналыг тавих; АНУ-ын мөргэйжийн зээлийн санхүүжилтийн систем, зээлийн төлбөрийн нөхцөлүүд, үүнтэй холбоотой дүрэм журмууд болон хот төлөвлөлт, бүтээн байгуулалтын менежмент, төлөвлөлтийг хэрэгжүүлэх механизмын талаар туршлага судлал хамтран ажиллах; Чөлөөт зах зээлийн нийгэмд чөлөөт сонголт хийсний төлөө хариуцлага хүлээдэг улс төр, нийгмийн хариуцлагын механизмын талаарх АНУ-ын туршлагыг судлах эдгээр болно.</p> <p>Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын урилгаар Бүгд Найрамдах Чех Улсын Сенатын танхимын дарга Ярослав Кубера 2019 оны 9 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 2-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд “Засгийн газрын 2016-2020 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Монгол Улсад шилний үйлдвэр байгуулах зорилт тусгагдсан ба уг айлчлалын үеэр Чехийн талаас манай улсад шилний үйлдвэр байгуулах боломжийг судлах санал тавьсныг хүлээн авч, судлан үзэх” саналыг тусгуулав. Уг асуудал айлчлалын үеэр айлын талтай яригдсан.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Япон Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр баримтлах удирдамжид барилга, хот байгуулалтын чиглэлээр дараах саналыг холбогдох газар хэлтсээс нэгтгэн авч, албан бичгээр ГХЯ-д хүргүүлж ажилласан байна. Үүнд:</p> <p>Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын техникийн туслалцааны хүрээнд “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа”, “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль”-ийн төсөл боловсруулах, “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний чадавхийг сайжруулах дэд төсөл-1”, “Хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх”-ийн 2 дугаар үе шат зэрэг төслүүдийг амжилттай хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газраас хот байгуулалтын салбарт баримтлах бодлогыг дэмжиж ирсэнд талархал илэрхийлэх;</p> <p>Цаашид ЖАЙКА-ийн санхүүжилтээр “Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах төсөл”-ийн хүрээнд “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан хот байгуулалтын баримт бичиг “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого” зэрэг ажлыг эхлүүлж, хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлэх зэрэг болно.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Казахстан Улсад 2019 оны 10 дугаар сарын 10-12-нд хийсэн албан ёсны айлчлалын удирдамж, яриа хэлэлцээний сэдэвт барилга, хот байгуулалтын чиглэлээр тодорхой санал тусгуулсан. Айлчлалын бүрэлдэхүүнд БХБ-ын сайд Х.Баделхан, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Гүнболд нар оролцохтой холбоотой ажлуудыг зохион байгуулсан. Айлчлалын үеэр Нурсултан хотын төлөвлөлт, БНКУ-ын хүн амын нутагшилт суурьшлын болон орон нутгийн дэд бүтцийн төлөвлөлт, бүтээн байгуулалтын чиглэлээр</p>

		<p>хэрэгжүүлж буй туршлагыг судлах; Казахстан Улсын ипотекийн зээлийн системийг хэрэгжүүлэн иргэдээ орон сууцаар хангаж байгаа, орчин үеийн барилгыг газрын системд холбоход шаардлагатай норм, дүрэм, стандарт болон технологийн талаар туршлага судлах; Эхний ээлжинд аймгуудад байгуулах лабораторуудад шаардлагатай тоног төхөөрөмжүүд нийлүүлэх, мэргэжлийн шинжээч нарыг мэргэшүүлэх хэрэгцээ бий. Иймд БНКУ-ын Барилга, архитектурын шинжлэх ухаан-судалгаа, төслийн хүрээлэн зэрэг байгууллагатай хамтран баруун бүсийн аймгийн төвүүдийн барилгын материалын лабораторуудыг тоног төхөөрөмжөөр ханган хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллах; Баруун бүсийн аймгуудад шаардлагатай барилгын материалыг импортлон хоёр орны салбарын худалдаа, эдийн засгийг хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллах саналуудыг тус улсын холбогдох талуудад тавьсан байна.</p> <p>Айлчлалын мөрөөр 2019 оны 11 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд Алмата хотод болох “Хамтын нийгэмлэгийн орнуудын газар хөдлөлтөд тэсвэртэй барилгын асуудал хариуцсан байгууллагуудын хурал”-д БХТөвийн орлогч захирал М.Ибрай тэргүүтэй БХБЯ-наас О.Баярбаатар, БХТ-өөс 4 төлөөлөгчид оролцохтой холбоотой ажлуудыг зохион байгуулсан.</p> <p>Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНКУ-д хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд салбарын чиглэлээр тус улстай хамтран хэрэгжүүлэх саналыг ГХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн 2019 оны 12 дугаар сард Оросын Холбооны Улсад хийсэн албан ёсны айлчлалын удирдамж, яриа хэлэлцээний сэдэвт тус яамнаас хамтын ажиллагааны туршлага дээр суурилсан дагуул хотуудыг төлөвлөн байгуулах, барилгын ул хөрсний судлагааг хамтран хийж, санал боловсруулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг нураах, хүчитгэх техникийн баримт бичгүүдийг судлах, Евро нормыг нутагшуулж буй туршлагаас суралцах, холбогдох ехнийн баримт бичгээр хангах зэрэг саналуудыг боловсруулж, айлын талд тавихаар ГХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын 2019 оны 01 дүгээр сарын 22-26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан, Киргиз Улсад хийсэн албан ёсны айлчлалын яриа хэлэлцээний сэдэвт Барилга, хот байгуулалтын яам, харьяа байгууллагатай хамтран 2019 онд Казакстаны Хөрөнгө оруулалт, хөгжлийн яамны “Казнекс Инвест” экспорт, хөрөнгө оруулалтын агентлаг, Барилга, архитектурын шинжлэх ухаан-судалгаа, төслийн хүрээлэн болон бусад холбогдох байгууллагатай уулзах, газар хөдлөлтийн лабораторитой танилцах, Алма-Ата хотыг Астана хот руу нүүлгэн шилжүүлсэн туршлага судлах, “Астана барилга–Astana Build” эсхүл “KazBuild 2019”-д оролцох саналыг хүргүүлсэн. Уг саналыг мөн БНКУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-нд хүргүүлж, энэ онд багтаан тус улсад айлчлал зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <p>Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын БНЧехУлсад, АНУ-д хийсэн айлчлалын яриа хэлэлцээний сэдэвт салбарын чиглэлээр санал тусгуулахаар ГХЯ-д тус тус хүргүүлсэн.</p> <p>АНУ-ын Вашингтон хотноо 2019 оны 4 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд болох Олон улсын валютын сан, Дэлхийн банкны 2019 оны хаврын уулзалт, Нью-Йорк хотноо 4 дүгээр сарын 15-18-ний өдрүүдэд болох НҮБ-ын эдийн засаг, нийгмийн зөвлөлийн дөрөвдүгээр чуулга уулзалт, Фижи Улсын Нади хотноо энэ оны 05 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд болох Азийн хөгжлийн банкны захирагч нарын 52 дахь удаагийн жилийн уулзалт, Босни Херцеговина Улсын Сараево хотноо 05 дугаар сарын 08-9-ний өдрүүдэд болох Европын сэргээн босголт, хөгжлийн банкны захирагч нарын 28 дахь удаагийн жилийн уулзалтад тус тус оролцох тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, удирдамжийн төслүүдтэй танилцаад “Монгол Улсад АХБ, ЕСБХБ, Дэлхийн банкнаас явуулах үйл ажиллагаандаа хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлж байх;</p> <p>Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэн хотын тоосжилт, агаар, хөрсний бохирдлоос</p>
--	--	--

		ангжрах, орон сууцны ипотекийн зээлийн хүүг бууруулах чиглэлд нэн хөнгөлөлттэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлах” зэрэг саналыг 2019/3/19-ний 01/922 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын БНХАУ-ын Шанхай хотноо зохион байгуулагдах Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх боломж-2019 сэдэвт экспод оролцох үеэр Худалдааны сайд Жун Шантай хийх хоёр талын монголын талын баримтлах яриа, хэлэлцээний сэдэвт “Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийн Тусгайлсан зээлийн хэлэлцээрийг түргэлүүлэх чиглэлээр санал тусгуулсан байна. Уулзалтаар төслийн асуудал үнэлэх шатандаа явж байгаа бөгөөд энэ онд байгуулах чиглэлээр ажиллаж байгаа талаар айлын талаас мэдээлсэн юм. Нийт 9 дээд өндөр түвшний айлчлалын үеэр салбарын чиглэлээр айлын талд тавих хамтын ажиллагааны саналуудыг хүргүүлсний үр дүнд зарим нь хэрэгжиж байна.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		

<i>№</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
<i>Арга хэмжээний нэр, дугаар</i>	1.3.1.6. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, урт дунд хугацааны хөтөлбөрүүдэд тусгуулах салбарын төсөл, хөтөлбөрүүдийн саналыг боловсруулж, хүргүүлэх, яриа хэлэлцээнд оролцох, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Олон Улсын Гэрээний тухай хууль. Монгол Улсын Их хурлын 2011 оны “Гадаад бодлогын үзэл баримтлалын тухай” 43 дугаар тогтоол. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам. Монгол Улс, БНХАУ-ын Худалдаа, эдийн засаг хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр. Монгол Улс, Япон Улс хоорондын эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр.						
	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	<i>Хариуцах нэгж</i>	Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Тилеухан						
	<i>Суурь түвшин</i>	Холбогдох баримт бичигт тусгасан барилга, хот байгуулалтын асуудалд хамаарах заалт						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Гадаад арга хэмжээний 2019 оны төлөвлөгөө, хүргүүлсэн санал, албан бичиг Албан бичиг, хүсэлт-25 хүртэл						
	<i>Хүрэх түвшин</i>	Эхний хагас жилд: Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, урт дунд хугацааны хөтөлбөрүүдэд тусгуулах салбарын төсөл, хөтөлбөрүүдийн саналыг боловсруулж, хүргүүлэх, яриа хэлэлцээнд оролцох, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн байна.						
		Жилийн эцэст: Холбогдох гэрээ, хэлэлцээр, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, урд дунд хугацааны хөтөлбөрт санал тусгаж холбогдох асуудлаар хэрэгжилтийг хангаж жилийн эцэст эл асуудлаар тайлагнасан байна. Монгол Улсын Засгийн газрын түвшинд бусад улс орнуудтай байгуулсан худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт барилга, хот байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал боловсруулж хүргүүлсэн байна.						
	<i>Хэрэгжилт</i>	Бүгд Найрамдах Аргентин Улсын Буэнос Айрес хотноо 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр гарын үсэг зурсан “Техникийн						

	тайланг Сайдын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, ЗГХЭГ-т хүргүүлэх				шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Сайдын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тэмдэглэл, шийдвэрийн хамт 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/1079 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн 2019 онд байгуулсан төлөвлөгөөний биелэлтэд эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Сайдын зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тэмдэглэл, шийдвэрийн хамт ЗГХЭГ-т 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 01/2594 тоот албан бичгээр хүргүүлсэн.
2	Харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайландүнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал өгөх.	Тайлангийн тоо	1	1	Төсвийн ерөнхийлөн захирагчтай Төсвийн шууд захирагч /Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар/-ийн 2019 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтэд 2019 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2019 оны 6 дугаар сарын 24-ны өдөр Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан шийдвэр, зөвлөмж, үнэлгээ дүгнэлтийг хэрэгжилт хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай ажлын жагсаалтын хамт Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 2019.07.05-ны өдрийн 09/2685 тоот албан бичгээр хүргүүлсэн.
			1	1	Төсвийн ерөнхийлөн захирагчтай Төсвийн шууд захирагч /Барилгын хөгжлийн төв/-ийн 2019 онд байгуулсан үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд 2019 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2019 оны 6 дугаар сарын 24-ны өдөр Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан шийдвэр, зөвлөмж, үнэлгээ дүгнэлтийг хэрэгжилт хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай ажлын жагсаалтын хамт Барилгын хөгжлийн төвд 2019.07.09-ны өдрийн 09/2745 тоот албан бичгээр хүргүүлсэн.
			1	1	Төсвийн ерөнхийлөн захирагчтай Төсвийн шууд захирагч /Төрийн өмчийн орон сууцны корпораци/-ийн 2019 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтэд 2019 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2019 оны 6 дугаар сарын 24-ны өдөр Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж,

					хуралдаанаас гарсан шийдвэр, зөвлөмж, үнэлгээ дүгнэлтийг хэрэгжилт хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай ажлын жагсаалтын хамт ТОСК-д 2019.07.05-ны өдрийн 09/2686 тоот албан бичгээр хүргүүлсэн.
3	Төсвийн шууд захирагчтай нэгжийн менежерүүдийн байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,	Тайлангийн тоо			Төсвийн шууд захирагчтай нэгжийн менежерүүдийн байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2019 оны 4 дүгээр сард яамны удирдлагад танилцуулсан. 2019 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж яамны удирдлагад танилцуулан 2019 оны 6 дугаар сарын 24-ны өдөр Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвлөмж хүргүүлсэн. 2019 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.
4	"Төсвийн ерөнхийлөн захирагчтай аймаг, нийслэлийн Засаг дарга нарын байгуулсан үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, ЗГХЭГ-т хүргүүлэх	Тайлангийн тоо	1	1	Барилга, хот байгуулалтын сайд болон 21 аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Сайдын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тэмдэглэл, шийдвэрийн хамт 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/1079 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
5	Салбарт гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах;	Тайлангийн тоо	8	8	Төслүүдийн хэрэгжилтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж яамны удирдлагад танилцуулан тайланг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулж 2019 оны 02 дугаар сарын 29-ний 01/1079 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.
6	Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах.	- Үнэлгээний дүнг яамны удирдлагуудад танилцуулах; - Зөвлөмж гарган холбогдох газар, байгууллагад хүргүүлэх;	1	1	2018 оны жилийн эцсийн байдлаар: 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан Сайдын 150 тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт 97.5 хувь, ТНБД-ын 157 тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт 95 хувьтай үнэлэгдсэн. Зөвлөмжийг холбогдох нэгжийн удирдлагуудад өгсөн.
7	Хууль тогтоомжийн хэрэгжилт болон салбарт хийгдсэн томоохон ажлууд, гадаадын зээл,	Тайлангийн тоо	4	4	Холбогдох эрх зүйн актын биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан болон салбарт хийгдсэн томоохон ажлууд, гадаадын зээл,

	тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн явцын мэдээллийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх;				тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн явцын мэдээллийг 2018 оны жилийн эцсийн байдлаар гаргаж 2019.03.06-ны өдрийн 03/785 тоот, 2019 оны 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэсэн томоохон ажлуудын тайланг 2019.05.07-ны өдрийн 03/785 тоот, 2019 оны 2 дугаар улиралд хийж гүйцэтгэсэн томоохон ажлуудын тайланг 2019.07.05-ны өдрийн 01/2688 тоот, 2019 оны 3 дугаар улиралд хийж гүйцэтгэсэн томоохон ажлуудын тайланг 2019.11.01-ний өдрийн 03/4097 тоот албан бичгээр УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн.
8	Яамны сар бүрийн үйл ажиллагааны мэдээллийг газруудаас гаргуулан авч нэгтгэн боловсруулж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын www.unelgee.mn сайтад байрлуулах	Тайлангийн тоо	12	12	Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны 01-12дугаар сард хийсэн ажлын тайланг газруудаас "Абле" систем болон газрын дарга нараар баталгаажуулан авч, нэгтгэн, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем / www.unelgee.gov.mn /-д байрлуулж, сар бүр хугацаанд нь баталгаажуулж 2018 оны 12 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 01 сарын 04-ний 03/20 тоот, 2019 оны 01 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 02 сарын 01-ний 03/431 тоот, 2019 оны 02 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 03 сарын 04-ний 03/744 тоот, 2019 оны 03 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 04 сарын 04-ний 03/1160 тоот, 2019 оны 04 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 05 сарын 03-ны 09/1588 тоот, 2019 оны 05 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 06 сарын 04-ний 09/2078 тоот, 2019 оны 06 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 07 сарын 04-ний 03/2640 тоот, 2019 оны 07 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 08 сарын 02-ний 03/3000 тоот, 2019 оны 08 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 09 сарын 04-ний 03/3348 тоот, 2019 оны 09 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 10 сарын 04-ний 03/744 тоот, 2019 оны 10 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 11 сарын 04-ний 03/4115 тоот, 2019 оны 11 сард хийсэн ажлын тайланг 2019 оны 12 сарын 04-ний 09/4520 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн.
9	Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж боловсруулсан	1	1	Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт хяналт шинжилгээ үнэлгээ хийж тайланг Сайдын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тэмдэглэл, шийдвэрийн

	хэлэлцүүлэн, ЗГХЭГ-т хүргүүлэх.				хамт 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/1079 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
10	Яамны болон харъяа байгууллагуудын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн ажилд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Сайдын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, ЗГХЭГ-т хүргүүлэх.	Тайлан бичсэн байх, холбогдох газарт хүргүүлсэн байх	1	1	Яамны болон харъяа байгууллагуудын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн ажилд хяналт шинжилгээ үнэлгээ хийж тайланг Сайдын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тэмдэглэл, шийдвэрийн хамт 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/1079 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
11	Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг хийж, тайланг Сайдын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, ЗГХЭГ-т хүргүүлэх.	Тайлан бичсэн байх, холбогдох газарт хүргүүлсэн байх	1	1	Яамны шударга байдлын түвшний үнэлгээг хийж, тайланг Сайдын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тэмдэглэл, шийдвэрийн хамт 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/1079 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
12	Шилэн дансны тухай хуулийн дагуу санхүүгийн гүйлгээнд сар, улирал, хагас, бүтэн жил тутам хяналт тавьж, цахимаар Сангийн яаманд хүргүүлж, баталгаажуулах.	Тайлангийн тоо	4	4	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2018 оны 4 дүгээр улирлын тайланг 2019 оны 01 сарын 25-ны өдрийн 09/327, 2019 оны 1 дүгээр улирлын тайланг 2019 оны 04 сарын 30-ны 09/1518 тоот, 2 дугаар улирлын тайланг 2019 оны 07 сарын 19-ны 09/2847 тоот, 3 дугаар улирлын тайланг 2019 оны 10 сарын 22-ны 09/3981 тоот албан бичгээр Сангийн яамны Төсвийн хяналт эрсдэлийн удирдлагын газарт тус тус хүргүүлсэн.
13	Сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайлан харъяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас гаргасан аудитын зөвлөмжийн биелэлтийг хангуулах.	Тайлангийн тоо			Сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайлан харъяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас гаргасан аудитын зөвлөмжийг хангуулах төлөвлөгөөг ТНБД-аар батлуулан ажиллаж байна. - Барилга, хот байгуулалтын яамны Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудит, Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 03/633, - ҮАГ-аас 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 05/797 тоот албан бичгээр ирүүлсэн Гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага,

					<p>зөвлөмжийн жагсаалтад орсон тус яам болон “ТОСК” ТӨҮГ, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т хамаарах зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 03/1816 тоот,</p> <ul style="list-style-type: none"> - Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2018 оны санхүүгийн нэгдсэн тайланд өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг 2019 оны хагас жилийн байдлаар гаргаж 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 03/2549 тоот, - 8 дугаар сарын 30-ны байдлаар гаргаж 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 03/3354 тоот, - Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар өгөгдсөн албан шаардлагын биелэлтийг 2019 оны 12 сарын 02-ны өдрийн 03/4484 тоот - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгууд, Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2019 оны 12 сарын 09-ны өдрийн 03/4593 тооталбан бичгээр Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн.
14	Дотоод аудитын тоон болон бичмэл тайланг Сангийн яаманд хүргүүлэх.	Тайлангийн тоо	2	2	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хамт 2019 оны 6 дугаар сард Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн.</p> <p>2019 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хамт 2019 оны 12 дугаар сард Сангийн яаманд хүргүүлсэн байна.</p>

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №2.1.3. Яам, агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган тайлагнаж эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.3.1. “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх” арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудад хяналт, шинжилгээ дотоод аудит хийх.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Барилга, хот байгуулалтын яамны 2019 онд хийх дотоод аудитын төлөвлөгөө						
<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	<i>1</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>	<i>5</i>	<i>6</i>	

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй
	Суурь түвшин	
	Шалгуур үзүүлэлт	Дотоод аудитын тайланг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.
	Хүрэх түвшин	“Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх” арга хэмжээний санхүүгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийж дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн байна.
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	ТНБД-ын 2018 оны 11 сарын 27-ны өдрийн А/182 тоот тушаалаар батлагдсан “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх” арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийн дагуу ажиллаж тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт 100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин						
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.3.2. “Түрээсийн орон сууц хөтөлбөр” –ийн хэрэгжилтэд дотоод аудит хийх							
	Төлөвлөлтийн уялдаа:	Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Барилга, хот байгуулалтын яамны 2019 онд хийх дотоод аудитын төлөвлөгөө						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	4	5	6	7	8	9
	Шаардагдах хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагагүй						
	Суурь түвшин							
	Шалгуур үзүүлэлт	Дотоод аудитын тайланг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.						
	Хүрэх түвшин	“Түрээсийн орон сууц хөтөлбөр” –ийн хэрэгжилтэд дотоод аудит хийж дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Барилга хот байгуулалтын яамны дотоод аудитын 2019 оны ажлын төлөвлөгөөний дагуу БХБСайдын 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу “Түрээсийн орон сууц хөтөлбөр” –ийн хэрэгжилтэд дотоод аудит хийж 2019 оны 12 сарын 26-ны өдөр Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.						
	Хүрсэн түвшин	Хэрэгжилт 70%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ								

		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин						
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.3.3. Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын үйл ажиллагаанд дотоод аудит хийх							
	Төлөвлөлтийн уялдаа:	Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Барилга, хот байгуулалтын яамны 2019 онд хийх дотоод аудитын төлөвлөгөө						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1/7	2/8	3/9	10	11	12
	Шаардагдах хөрөнгө	Хөрөнгө шаардагдахгүй.						
	Суурь түвшин							
	Шалгуур үзүүлэлт	Дотоод аудитын тайланг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.						

	<i>Хүрэх түвшин</i>	“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ Барилга, захиалагчийн техник хяналтын үйл ажиллагаанд дотоод аудит хийж дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн байна.
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Барилга хот байгуулалтын яамны дотоод аудитын 2019 оны ажлын төлөвлөгөөний дагуу Барилга, хот байгуулалтын сайд, дотоод аудитын хорооны даргын 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр баталсан удирдамжийн дагуу дотоод аудит хийж 2019 оны 12 сарын 23-ны өдөр Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. байна.
	<i>Хүрсэн түвшин</i>	<i>Хэрэгжилт 70%</i>
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		

	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	2.1.3.4. Сайдын эрхлэх асуудлуудын хүрээний нийт байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийх.							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Барилга, хот байгуулалтын яамны 2019 онд хийх дотоод аудитын төлөвлөгөө						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Сар</i>	<i>1/7</i>	<i>2/8</i>	<i>3/9</i>	<i>10</i>	<i>11</i>	<i>12</i>
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Хөрөнгө шаардагдахгүй.						
	<i>Суурь түвшин</i>	2018 оны жилийн эцсийн байдлаар: Тайлангаар						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Дотоод аудитын тайланг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.						
	<i>Хүрэх түвшин</i>	Сайдын эрхлэх асуудлуудын хүрээний нийт байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийж дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Барилга хот байгуулалтын яамны дотоод аудитын 2019 оны ажлын төлөвлөгөөний дагуу Барилга, хот байгуулалтын сайд, дотоод аудитын хорооны даргын 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр баталсан удирдамжийн дагуу дотоод аудит хийж 2019 оны 12 сарын 23-ны өдөр Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. байна.						
	<i>Хүрсэн түвшин</i>	<i>Хэрэгжилт 70%</i>						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ								

Гүйцэтгэлийн зорилт №2.1.3-ийн үр дүн: Яам, агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган тайлагнаж эрсдэлээс урьдчилан сэргийлэх

№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			2018 он	Жилийн эцэст	
				Төл.	Гүй.
1	2.1.3.1. “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх” арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудад хяналт, шинжилгээ дотоод аудит хийх.	Дотоод аудитын тайлан		1	ТНБД-ын 2018 оны 11 сарын 27-ны өдрийн А/182 тоот тушаалаар батлагдсан “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх” арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийн дагуу ажиллаж тайланг 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Сайдын зөвлөлийн

					хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.
2	2.1.3.2. “Түрээсийн орон сууц хөтөлбөр” –ийн хэрэгжилтэд дотоод аудит хийх	Дотоод аудитын тайлан		1	БХБСайдын 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу “Түрээсийн орон сууц хөтөлбөр” –ийн хэрэгжилтэд дотоод аудит хийж тайланг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн зөвлөмж хүргүүлсэн.
3	2.1.3.3 Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Дотоод аудитын тайлан		1	Барилга, хот байгуулалтын сайд, дотоод аудитын хорооны даргын 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын үйл ажиллагаанд дотоод аудит хийж тайланг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн зөвлөмж хүргүүлсэн.
4	2.1.3.4. Сайдын эрхлэх асуудлуудын хүрээний нийт байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийх.	Дотоод аудитын тайлан		1	Барилга, хот байгуулалтын сайд, дотоод аудитын хорооны даргын 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Сайдын эрхлэх асуудлуудын хүрээний нийт байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж тайланг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн зөвлөмжийг харьяа байгууллагуудад хүргүүлсэн.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

2020.01.13

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагч хянаж баталсан байна.

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь **5 үндсэн чиг үүрэг** болох:

- салбарын бодлого, төлөвлөлт;
- хот байгуулалт, газрын харилцааны бодлого, төлөвлөлт;
- барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого, төлөвлөлт;
- нийтийн аж ахуйн бодлого, төлөвлөлт;
- инженерийн дэд бүтцийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр мөн түүнчлэн төрийн захиргааны удирдлага болон хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр дараах **3 хэсгээс** бүрдсэн байна. Үүнд:

Нэгдүгээр хэсэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ;
Хоёрдугаар хэсэг. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ;
Гуравдугаар хэсэг. Хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ болно.

Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, Төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг боловсрууллаа.


2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь тухайн жилийн хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлсэн болно.

3. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь дээрхи 3 хэсгийн хүрээнд нийт **148 зорилтын 347 арга хэмжээг** төлөвлөснөөс **Бодлогын баримт бичигт тусгагдсан 108 зорилтын хүрээнд 172 арга хэмжээг, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахаар 13 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг; Хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэхээр 27 зорилтын хүрээнд 157 арга хэмжээг** төлөвлөж хэрэгжилтийг тайлагнасан байна.

Зураг 3. БХБЯ-ны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ яамны газар тус бүрээр /эзлэх хувиар/



Мэдээллийн эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн Шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 100 хувийн хэрэгжилттэй 250 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 73 арга хэмжээ, 30 хувийн хэрэгжилттэй 24 арга хэмжээ байна гэж дүгнэсэн ба Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт **88,8 хувьтай** үнэлэгдэж байна.

Зураг 4. БХБЯ-ны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /чиглэл тус бүрээр/



Мэдээллийн эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

3.1 БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД

Салбарын бодлого төлөвлөлтийн чиглэлээр 36 зорилтын хүрээнд 40 арга хэмжээ; Хот байгуулалт, газрын харилцааны бодлого төлөвлөлтийн чиглэлээр 26 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ; Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр 27 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ; Нийтийн аж ахуйн бодлого төлөвлөлтийн чиглэлээр 16 зорилтын хүрээнд 24 арга хэмжээ; Инженерийн дэд бүтцийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр 3 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг тус тус төлөвлөсөн байна.

Зураг 5. Нэгдүгээр хэсэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт



Мэдээллийн эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн тайлан

Салбарын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжсэн томоохон арга хэмжээнүүдээс дурдвал:

Салбарын бодлого, үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн бодлогын зорилтуудтай нийцүүлэх, салбар хоорондын уялдааг хангах, салбарын хэмжээнд боловсруулж байгаа Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр, төслийг бодлогын удирдамжаар хангах зорилт №1.1-ийн хүрээнд:

✓ “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”-ын холбогдох зорилтууд болон Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолоор “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”, БХБСайдын 2019 оны 67 дугаар тушаалаар “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан. Мөн Орон сууц, нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг “Тогтвортой хөгжлийн зорилт”-ын Зорилт 6, түүний шалгуур үзүүлэлт, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”-д нийцүүлэн боловсруулаад байна.

✓ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн төслийн “Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын логик хүрээ”, “Эдийн засаг зорилгын логик хүрээ”, “Сайн засаглал зорилгын логик хүрээ”, “Ногоон хөгжил зорилгын логик хүрээ”, “Нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжил” гэсэн 5 логик хүрээнд барилга, хот байгуулалтын салбарын бодлогын асуудлуудыг шинээр болон шинэчлэн тусгуулахаар санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Мөн Бүсчилсэн хөгжлийн бодлогын чиглэлээр “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн төсөлд тусгагдсан “Нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжил” логик хүрээний “Байгаль, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зүй тогтлын дагуу хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутаг, хот суурин газрын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хөгжүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд “Тогтвортой хөгжлийн зорилтод тулгуурласан Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн

хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж хэрэгжүүлэх” зорилтыг дэвшүүлж, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

✓ Барилга, хот байгуулалтын салбарын бодлого, зорилтыг “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого” болон “Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичиг” (НҮБ-аас дэмжих олон улсын баримт бичиг)-т тусгуулахаар 1 зорилго, 4 зорилт, 9 үйл ажиллагааны чиглэл, 45 арга хэмжээний төлөвлөгөө бүхий санал боловсруулан холбогдох 6 хавсралтын хамт БОАЖЯ-ны Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. “Парисын хэлэлцээрт оруулах Монгол Улсын зорилтот хувь нэмэр (INDC) бодлогын баримт бичиг”-т оруулах салбарын бодлогын төслийг боловсруулсан бөгөөд тус баримт бичиг Засгийн газрын тогтоолоор батлагдаад байна. Барилгын салбараас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөө боловсруулах НҮБ-ын 540.000\$-ийн гэрээнд 2019 оны 10 дугаар сард БХБСайд Х.Баделхан гарын үсэг зураад байна.

✓ УИХ-ын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 54 дүгээр тогтоолын хавсралтаар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” батлагдсан бөгөөд тус бодлогын баримт бичигт БХБЯ-аас хэрэгжүүлэх 14 зорилт, арга хэмжээ туссан байна.

Салбарын суурь судалгаа, статистик тоон мэдээ, мэдээллийг буй болгох, салбарын албан ёсны статистик тоон мэдээ, мэдээллийг холбогдох газруудаас авч нэгтгэн, мэдээллийн сан үүсгэх зорилт №1.2-ын хүрээнд:

✓ Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын Засгийн газарт үзүүлэх буцалтгүй тусламжийн хүрээнд “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх” төсөлд холбогдох саналыг өгсөн бөгөөд мэдээллийн нэгдсэн систем хэрэглээнд нэвтэрсэнээр хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой мэдээллийг иргэдэд ойлгомжтой байдлаар хүргэх, бодлогын баримт бичиг боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн хэрэгцээ шаардлагыг бодлого боловсруулагч нар цахимаар хүлээн авах, цаашлаад гадаадын хөрөнгө оруулагч нарт үнэн, бодит мэдээлэл хүргэх зэрэг олон давуу талтай /www.development.gov.mn/.

✓ Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 105 дугаар тушаалаар батлагдсан салбарын статистик мэдээ гаргах 33 маягтын загварыг шинэчлэн, анхдагч мэдээллийн 11 маягт болгон боловсруулж, Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар батлуулахаар бэлтгэж байна.

Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг салбарын үйл ажиллагаатай уялдуулах, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, төрөөс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг нэгтгэж, цаашид шаардлагатай төсөл, хөтөлбөрийн саналыг боловсруулж, бодлогын удирдамжаар хангах зорилт № 1.3-ын хүрээнд:

✓ Засгийн газрын “Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 81 дүгээр тогтоолоор Хөгжлийн банкинд шилжүүлсэн 1542 айлын орон сууцны барилгыг түрээсийн орон сууцны санд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолоор Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын орон нутгийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийг бүртгэн оруулах ажлыг зохион байгуулсан байна.

✓ Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд төр, орон нутаг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд түрээсийн орон сууцны санг бүрдүүлэхээр заасан тул “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ын төслийг боловсруулж 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын 138 дугаар тогтоолоор батлуулсанаар зах зээлд түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэнд өмчлүүлэх 3457 айлын орон сууц байгаас 2387 айлын орон сууцанд иргэдийг хамруулсан. Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд 5389 айлын орон сууц бэлэн болоод байна.

✓ БНСУ-ын Засгийн газраас Монгол Улсын агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг орон сууцжуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохиролцсоны дагуу Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд “Солонго 1”, “Солонго 2”, Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороонд “Баянголын ам” орон сууцны 7000 айлын орон сууцнуудыг барихаар төлөвлөсөн. БНСУ-ын Экспорт-Импорт банкны Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан /EDCF/-ийн Үнэлгээний ажлын хэсэг, Сангийн яам, “ТОСК” ТӨХХК-тай хамтран “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих” төслийн зээлийн гэрээнд тусгах “Хэлэлцээрийн тэмдэглэл”-ийг 2019.11.28-ний өдөр албажуулан, талууд гарын үсэг зурж баталгаажуулсан. 2020 оны 01 дүгээр сард багтаан Зээлийн хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна.

✓ “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, БНХАУ-ын Буцалтгүй тусламжийн албаны дарга нар 2019 оны 07 дугаар сард гарын үсэг зурж баталгаажуулсан. Уг ажлын хүрээнд “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн барилга угсралтын ажлын бэлтгэл хангах төлөвлөгөө /2019-2020/-г баталсан. Төслийн барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг “Интеллект тауер” ХХК гүйцэтгэсэн бөгөөд барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, барилгын ажлыг 2020 онд эхлүүлнэ.

“Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилт № 1.3.4-ийн хүрээнд:

✓ Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2019 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 380 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 5,566 иргэнд олгоод байна. Үүнээс Монголбанкны эх үүсвэрээс 175.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2,513 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,616 иргэнд, банкуудын өөрийн эх үүсвэрээс 104 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,437 иргэнд тус тус олгосон. 2019 онд үлдэгдэл санхүүжилтийг гаргуулах талаарх хүсэлт, мөн “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-д заасан амины орон сууцанд зээл олгох ажлыг эрчимжүүлэх үүднээс хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал, Монголбанкны ерөнхийлөгчийн баталсан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-д тусгуулах саналаа тус тус Монголбанкинд хүргүүлээд байна. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Ипотекийн зээлийн санхүүжилтэд 60 тэрбум төгрөгийг тусгасны дагуу Ипотекийн зээлийн журмыг шинэчлэх судалгаа хийгдэж байна.

“Салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлэх” зорилт №1.4-ийн хүрээнд:

✓ Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”-г боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоог Барилгын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн

шинэчлэн боловсруулсан бөгөөд тогтолцооны баримт бичгүүдэд тавих шаардлага, агуулга, боловсруулахад тавих шаардлага, боловсруулах ажлын зохион байгуулалтын тухай зохицуулалтуудыг тусган Засгийн газрын 106 дугаар тогтоолоор батлуулсан байна.

✓ “Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам”-ыг Засгийн газрын 107 дугаар тогтоолоор батлуулсан байна. Уг журам батлагдсанаар Монгол Улсад шинээр нэвтэрч байгаа техник, технологи, олон улсын норм, стандартыг цаг алдалгүй хэрэглэх боломжийг бүрдүүлээд байна.

✓ Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Стандартын улсын үзлэгийн дүн болон харьяа газар, байгууллагуудаас ирүүлсэн саналд үндэслэн боловсруулж, Сангийн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 19-ны хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Төлөвлөгөөнд нийт 110 норм, нормативын баримт бичиг шинээр болон шинэчлэн боловсруулахаар тусгасан. Үүнд: техникийн зохицуулалт- 3, барилгын норм ба дүрэм - 32, барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал - 53, стандарт – 22-ыг тусгасан ба сангаас нийт 2,087,900,932 төгрөгийг зарцуулахаар баталсан. Баталсан төлөвлөгөөний дагуу норм, нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж байна.

✓ Төрөөс барилгын талаар баримтлах бодлого, Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлагдсантай холбогдуулан барилга, хот байгуулалтын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 396 норм, нормативын баримт бичигт үзлэг хийснээр шийдвэрлэх асуудал, хүрэх үр дүнг тодорхойлоод байна.

✓ “Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” БХБСайдын 2019 оны 104 дүгээр тушаалыг баталж Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хуралдааныг 2019 оны 03 дугаар сарын 01, 06 дугаар сарын 06, 07 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 22, 12 дугаар сарын 11-ний өдрүүдэд нийт 5 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 30 асуудал хэлэлцүүлж, холбогдох шийдвэрүүдийн гаргуулсан байна.

Салбарын ногоон хөгжлийн зорилтыг хангах, “ногоон” барилгын талаарх хууль, эрхзүйн орчин, бүтцийг бүрдүүлэх, салбарт хэрэгжүүлэх шаардлагатай “ногоон” хөтөлбөр, төслийн саналыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах зорилт №1.5-ийн хүрээнд:

✓ Барилга байгууламжийг эрчим хүчний хэрэглээгээр нь үнэлж гэрчилгээжүүлэх журам боловсруулах ажлын хэсгийг БХБСайдын 95 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Гэр, байшингаа дулаалах, халаалтын зуухаа дэвшилтэт халаагуураар солих иргэдийг дэмжих ногоон зээлийн санхүүжилтыг БОАЖЯ эхлүүлсэнтэй холбогдуулан салбарын аж ахуй нэгжүүдэд сурталчлах сургалт, семинарыг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Блю Скай зочид буудалд зохион байгуулж, салбарын 60 гаруй төлөөллийг хамруулсан байна. Даян дэлхийн ногоон хөгжлийн банк, НЗДТГ-ын хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж буй “Орон сууцны дулаан техникийн шинэчлэл” төслийн багтай хамтран 2019 оны 12 дугаар сарын 05-нд семинар зохион байгуулсан байна. Мөн эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцанд тавигдах шаардлагын саналыг боловсруулж Монголбанкнд хүргүүлээд байна.

✓ НАМА төслийн хүрээнд “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тооцох аргачлал” БД 23-105-19, “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцох аргачлал” БД 23-106-19 дүрмүүдийг боловсруулж, 2019 оны 12 дугаар сарын 11-ний Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн байна.

Салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогын удирдамжаар хангах зорилт № 1.6.1-ийн хүрээнд:

✓ Засгийн газрын 2019 оны 206 дугаар тогтоолоор Эрчим хүчний шугам сүлжээний барилга байгууламжийг Замын-Үүд сумын “Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх” ТӨХК-д, ус хангамж, ариутгах татуургын барилга, байгууламжийг Замын-Үүд сумын “Чандмань бадрал” ОНӨААТҮГ-т, Инженерийн барилга байгууламжийг Захирагчийн ажлын албанд тус тус шилжүүлсэн байна.

✓ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 328 дугаар тогтоолоор “Дэд бүтэц” төслийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 33,984,459,042.14 /гучин гурван тэрбум есөн зуун наян дөрвөн сая дөрвөн зуун тавин есөн мянга дөчин хоёр төгрөг арван дөрвөн/ төгрөгийн хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хот байгуулалт, газрын харилцааны бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээнүүдээс дурдвал:

Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилт № 2.1.1-ийн хүрээнд:

✓ “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах 2019/26 дугаартай зургийн даалгаврыг Барилга, хот байгуулалтын сайд 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан. Мөн Японы Олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын техникийн туслалцаагаар хэрэгжүүлэх “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” болон Азийн хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн бодлогын баримт бичгүүдийг харилцан уялдаатай боловсруулах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төслийн зөвлөх багуудтай хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 158 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын “Хот байгуулалт, зураг төсөл, төлөвлөлтийн институт” нь сумдаас цуглуулсан мэдээллийн арга зүйг Өмнөговь аймгийн Ханбогд сумыг загвар болгон боловсруулсан бөгөөд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-д байгаль орчны стратегийн үнэлгээ хийх ажлын даалгаврыг боловсруулан БОАЖЯ болон холбогдох аж ахуйн нэгжүүдээс санал авч, батлуулахаар ажиллаж байна. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн явц болон Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг түшиглэн хөгжих дагуул хотын тухай” нээлттэй форумыг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт төслийг боловсруулах ажлыг мэргэжлийн арга зүй, зөвлөгөөгөөр хангах зөвлөх баг, ажлын хэсгийн гишүүд болон Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Үндэсний Хөгжлийн Газар, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын холбогдох мэргэжилтнүүд болон Хот байгуулалт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн гишүүд, судлаач нар оролцсон. Мөн түүнчлэн Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 32 дугаар захирамжаар байгуулсан “Төслийн хамтарсан зохицуулах хороо”-ны хуралдааныг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулж, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх багийн “Дунд шатны тайлан 1”-ийг хэлэлцүүлсэн байна. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын “Хот байгуулалт,

зураг төсөл, төлөвлөлтийн институт” нь “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах дунд шатны тайланг боловсруулсан бөгөөд Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж, судалгааны ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.

✓ Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийн хэрэгжилтийн байдал, “Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа”-ны ажлыг Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар, мөн Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн дэмжигдэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргээх чадавхид нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлэх ажлын хүрээнд хот, тосгоны газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилт № 2.1.4-ийн хүрээнд:

✓ Хот байгуулалтын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, БХБСайдын зөвлөлийн хуралдаанаар 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцүүлэн, хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг СЯ-ны 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 6/8616 тоот албан бичгээр, ХЗДХЯ-аас 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1-1/5796 тоот албан бичгээр тус тус авсан. УИХ-д өргөн мэдүүлэх тов тогтоолгохоор ЗГХЭГ-аас албан бичгийг УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн.

Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн нэгдсэн тээвэр, логистик, дэд бүтцийг хөгжүүлж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлэх зорилт № 2.1.5-ын хүрээнд:

✓ Замын-Үүд хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 152 дугаар гэрээг “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-тай, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 155 дугаар гэрээг “Нью урбанизм” ХХК-тай, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 153 дугаартай гэрээг “Идеал групп” ХХК-тай тус тус байгуулсан бөгөөд Замын-Үүд хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ, БХБСайдын зөвлөлийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг зохион байгуулж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” жишиг хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилт № 2.1.8-ын хүрээнд:

✓ “Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн судалгааны өнөөгийн байдлын дүн шинжилгээнд тулгуурлан судалгаа, тооцоо, саналыг боловсруулж, бүсийн тулгуур төв болон хүн амын тоо, өсөлт, нийгэм-эдийн засгийн таталцал, хөгжлийн нөөц, чадавхи, стратегийн ач холбогдол зэргийг харгалзан Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Ховд, Мөрөн, Замын-Үүд хотыг улсын зэрэглэлтэй, үлдэх 16 аймгийн төв болон Сэлэнгэ аймгийн Зүүнхараа, Хөтөл, Хөвсгөл аймгийн Хатгал,

Өвөрхангай аймгийн Хархорин, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Завхан аймгийн Тосонцэнгэл, Ховд аймгийн Булган, Дархан-Уул аймгийн Шарын гол, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдыг аймгийн зэрэглэлтэй хотоор тодорхойлох хувилбарын тооцоолол, судалгааг боловсруулсан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтоох, хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлсэнээр УИХ шийдвэрлэнэ гэж заасны дагуу удирдлагын давхардлыг арилгаж, хотуудын засаглалын эрх мэдэл нэмэгдэх боломжтой болсон байна.

Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилт №2.2.28-ын хүрээнд:

✓ Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 105 дугаар тогтоолоор батлуулсан.

✓ Монгол Улсын нутаг дэвсгэрийн газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллыг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 323 дугаар тогтоолоор батлуулсан.

Улсын тусгай хэрэгцээний газарт хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, холбогдох дүрэм, журам, норм, стандартыг боловсронгуй болгох зорилт №2.2.30-ын хүрээнд:

✓ Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт “Аж үйлдвэрийн цогцолбор” байгуулах зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан 3512.5 га газар, мөн Замын-Үүд сумын нутагт “Замын-Үүд хилийн боомт”-ын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан 882.3 га газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргаж, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх” төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд ашиглаж байгаа 400 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын 2019 оны 155 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан.

✓ Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилтын зориулалтаар Дархан-Уул аймгийн Орхон, Хонгор, Дархан сум, Сэлэнгэ аймгийн Мандал суманд тус тус байрлах газар зүй, гео-экологи, ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, сорилт, туршилтын талбайн нийт 1364.4 га газрыг болон нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Төв аймгийн Баянгол, Баянцагаан, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Зуунмод, Сэргэлэн суманд тус тус байрлах гравиметр, зай хэмжлийн жишилтийн полигон, агаарын зургийн полигоны нийт 1160.26 га газрыг Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан.

✓ Аюултай хог хаягдлын зориулалтаар 32 га газрыг Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 28-ны 337 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан. Газрын тос боловсруулах үйлдвэр барих зориулалтаар 405.17 га газрыг Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 02-ны 368 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан. 2019 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 357 дугаар тогтоолоор Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан.

✓ Батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай Улсын Их Хурлын тогтоолыг 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

батлуулсан. Арабын нэгдсэн Эмират улсын элчин сайдын яамны газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай Улсын Их Хурлын тогтоолыг 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр батлуулсан.

Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцлийг бүрдүүлэх зорилт №2.2.32-ын хүрээнд:

✓ “Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”, “Тариалан, атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”, “Хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”, “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын аргачилсан заавар”-ыг Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ний өдрийн 34 дүгээр тушаалаар батлуулсан.

Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох зорилт №2.2.40-ын хүрээнд:

✓ Геодези, зураг зүйн салбарын удирдах ажилтны 2 дугаар зөвлөгөөнийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтарч 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг холбогдох газарт 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлж, зөвлөмжийн дагуу холбогдох ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

✓ Монгол Улсын нутаг дэвсгэрийн 45 хувь буюу шинээр тавихаар төлөвлөж буй төмөр замын дагуу 704000 кв.км талбайг 1:25000-ны масштабтай байр зүйн зургийг агаарын зураглалын аргаар зурагжуулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд зөвлөх үйлчилгээ хийж буй “Геосан” ХХК нийт ажлыг 94 хувьтай гүйцэтгэж байна. “Геосан” ХХК-ний гэрээ дууссантай холбоотой 2019.05.14-ний өдөр гэрээ сунгах асуудлаар холбогдох хүмүүстэй уулзалт зохион байгуулж, 2019.11.01-ний өдрийг хүртэл сунгасан. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын мэдээллийн санд материал хүлээж авсан актыг үндэслэн 2019.05.20-ны өдөр Акт11-ийг үйлдэж, Санхүүгийн хэлтэст хүлээлгэж өгсөн. “Геосан” ХХК нийт ажлын гүйцэтгэл 96.12 хувьтай байна.

✓ ОХУ-ын буцалтгүй тусламжаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах эсэх асуудлыг Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, уг хуралдаанаас энэхүү асуудлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэн зөвлөмж авах нь зүйтэй гэж шийдвэрлэсний дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Үндэсний аюулгүй байдлын зөвлөл рүү хэлэлцүүлэх асуудлын материалыг хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий Сайдын ОХУ-д 2019 онд хийх албан ёсны айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсад суугаа ОХУ-ын Элчин сайдаас айлчлалын үеэр хэлэлцэх асуудлуудыг тэмдэглэсэн албан бичгийг ирүүлсэний дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Гадаад харилцааны яам руу холбогдох албан бичгүүдийг боловсруулж /нууцын зэрэглэлтэй/ хүргүүлсэн байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх зорилт №2.2.43-ын хүрээнд:

✓ “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020-2050 он”-ын төсөлд тусгах барилга, хот байгуулалтын салбарын саналыг боловсруулах ажлын хүрээнд “Зорилго 1. Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй, ая

Гүйцэтгэлийн зорилт № 4.1.5. Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.						
4.1.5.1	Шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг цэвэршүүлэн ариутгах татуургын систем, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах боломжит технологийг судлан, барилгын зураг төсөлд тусгах санал боловсруулж хэрэгжүүлэх.	100	-	-	-	100 хувь
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.6. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот болон бусад томоохон хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ.						
4.1.6.1	АХБ-ны зээлээр “Дархан хотын бохир усны менежментийн төсөл”-ийг хэрэгжүүлэх.	-	70	-	-	
4.1.6.2	АХБ-ны зээлээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийг хэрэгжүүлэх.	100	-	-	-	
4.1.6.3	Аймгийн төвүүдэд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийг эхлүүлэх.	100	-	-	-	90 хувь
4.1.6.4	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх.	-	70	-	-	
4.1.6.5	Цэвэрлэх байгууламжийн хяналтын лабораториудын тоног төхөөрөмжийг шинэчлэх, боловсон хүчнийг чадавхижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.	100	-	-	-	
4.1.6.6	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид лагийг бүрэн боловсруулах, дахин ашиглах технологи нэвтрүүлэх асуудлыг үе шаттай шийдвэрлүүлэх.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.7. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.						
4.1.7.1	Цэвэрлэсэн усыг үйлдвэрлэлийн зориулалтаар эргүүлэн (дахин) ашиглах технологийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх.	-	70	-	-	85 хувь
4.1.7.2	Хур борооны усны багц стандартыг боловсруулж, батлуулах.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.8. Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ.						
4.1.8.1	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний насжилтыг уртасгах, шинэчлэх, засварлах ажилд шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх.	100	-	-	-	100 хувь
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.9. НҮБХХ-ийн санхүүжилтээр “Барилгын салбарт үндэсний онцлогт тохирсон хүлэмжийн хийг бууруулах төсөл”-ийг хэрэгжүүлнэ.						
4.1.9.1	Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төслийг мэргэжлийн удирдлага, зохицуулалт, бодлогын удирдамжаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллах.	-	70	-	-	70 хувь
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.10. Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр боловсруулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.						
4.1.10.1	Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлэх.	-	70	-	-	70 хувь
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.11. Нийслэл, хот суурин газрын ундны эх үүсвэрийг хамгаалах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.						
4.1.11.1	Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, усыг хэмнэлттэй зарцуулах хэвшлийг бий болгох.	-	70	-	-	70 хувь
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.12. Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.						
4.1.12.1	Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага MNS 5924:2015 стандартыг хэрэгжүүлэх, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	100	-	-	-	100 хувь
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.13. Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах, шинэ хуулийн төсөл боловсруулахад эрх зүйн цахим мэдээллийн нэгдсэн санг ашиглах замаар хууль, эрх зүйн баримт бичгийн агуулга, уялдаа холбоог дээшлүүлнэ.						
4.1.13.1	Орон сууцны тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлэх.	100	-	-	-	85 хувь


4.1.13.2	Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлэх.	-	70	-	-		
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.14. Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн стандарт, зураг төсөл, технологийн шийдэлд шинэчлэл хийж ногоон хөгжлийн шаардлагад нийцүүлэн шинэчлэнэ.							70 хувь
4.1.14.1	Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн стандарт, зураг төсөл, технологийн шийдэлд шинэчлэл хийж ногоон хөгжлийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх.	-	70	-	-		
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.15. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн цэвэр усны шугам хоолойн барилга угсралтын ажлыг хийж, өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлнэ.							70 хувь
4.1.15.1	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2-р багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж.	-	70	-	-		
5. ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ							
Гүйцэтгэлийн зорилт № 5.1.1. Инженерийн дэд бүтцийн чиглэлээрх хууль, тогтоомж, стратеги хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулна.							
5.1.1.1	"Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-өөр баригдсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу өмчлөл, эзэмшилд шилжүүлэх, ашиглах, санхүүжилтийг шийдвэрлүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэх.	100	-	-	-		
5.1.1.2	Шингэрүүлсэн хийн түлш, сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах болон ногоон барилгын чиглэлээр төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай норм, дүрэм, стандартыг боловсруулах, батлах ажлын хүрээнд "Хийн хангамж"-ийн БНБД 42-01-04/2018 -д нэмэлт өөрчлөлт оруулан, хянаж санал өгч батлуулах.	100	-	-	-		
5.1.1.3	Норм, нормативын сангийн 2019 оны төлөвлөгөөнд салбарын холбогдолтой норм, дүрэм, журам, заавар, стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг нэгтгэж холбогдох газарт нь хүргүүлнэ.	100	-	-	-		
5.1.1.4	2019 оны улсын төсөвт тусгагдсан аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.	-	70	-	-		
5.1.1.5	Инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөх стандарт боловсруулах ажлын хүрээнд барилгын дүрэм боловсруулах ажлыг эхлүүлэх.	-	70	-	-		
5.1.1.6	"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, байгууламжийг үе шаттайгаар барьж байгуулах ажлыг үргэлжлүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллана.	100	-	-	-		
5.1.1.7	Сумын төвийн шинэчлэл төслийг 16 суманд хэрэгжүүлж дуусгах ажлын хүрээнд Говь-Алтай аймгийн Дэлгэр, Дорнод аймгийн Баян-уул, Хэнтий аймгийн Биндэр, Сүхбаатар Эрдэнэ-Цагаан сумдад хэрэгжиж буй төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.	100	-	-	-	91.4 хувь	
5.1.1.8	Нийслэл, аймгуудын үерийн байгууламжийг барьж байгуулах, нэмэгдүүлэх чиглэлээрх 2019 оны улсын төсөвт тусгагдсан төсөл арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	100	-	-	-		
5.1.1.9	ЗГ-ын 2017 оны 179 дүгээр тогтоолын хавсралтад тусгагдсан Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хийгдэх ажлуудыг эрэмбэлж жагсаалтыг БНХАУ-ын Засгийн газраас олгох 2.0 тэрбум юаны буцалтгүй тусламжийн 1.4 тэрбум юанд тохируулан гаргаж холбогдох газарт хүргүүлэх.	100	-	-	-		
5.1.1.10	Австри улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх "Дэд бүтцийн хөгжил-Сонгинохайрхан", "Дэд бүтцийн хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ төсөл"-ийн худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж ажиллана.	-	70	-	-		
5.1.1.11	Улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний үнэлгээний хороонд ажиллах, санал, зөвлөмж, дүгнэлт гаргаж төсвийн шууд захирагчид хүргүүлнэ.	-	70	-	-		
5.1.1.12	2018 -2019 онд улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй, орон сууцны хорооллуудын инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт, гэр хорооллын дахин төлөвлөлт, дахин барилгажуулах төслүүдийн хүрээнд хийгдэж буй инженерийн шугам сүлжээний барилга байгууламжын барилга угсралтын ажлын явц байдалтай газар дээр нь танилцаж, цаашид авах арга хэмжээний санал дүгнэлт гарган, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, зохицуулах.	100	-	-	-		
5.1.1.13	Хот суурин газрын цахилгаан түгээх сүлжээнд ухаалаг төхөөрөмж, тоолуур нэвтрүүлэх ажилд холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, удирдлага, зохицуулалтаар ханган ажиллана.	100	-	-	-		
5.1.1.14	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, нүүрс боловсруулж ашиглах шинэ технологи нэвтрүүлэн, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан үйлдвэрлэл, бизнесийг олон улсын хамтын ажиллагааны хүрээний дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.	100	-	-	-		

Гүйцэтгэлийн зорилт № 5.1.2. Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, үргэлжлүүлэх төсөл арга хэмжээний тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллээр хангана.					
5.1.2.1	"Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт тусгагдсаны дагуу Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг холбогдох газартай хамтарч боловсруулах.	-	70	-	-
5.1.2.2	Хууль, тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх.	-	70	-	-
5.1.2.3	Инженерийн дэд бүтцийн мэдээллийн санд 21 аймгийн инженерийн дэд бүтцийн мэдээллийг оруулах, баяжилт хийх ажлыг зохион байгуулах, зохицуулахад туслалцаа үзүүлнэ.	-	70	-	-
5.1.2.4	2019 оны тодотгол, 2020-2022 онд улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хийгдэх инженерийн дэд бүтцийн ажлуудын судалгаа, зураг төсөл, ТЭЗҮ хийхэд шаардагдах хөрөнгө санхүүжилтийн тооцоо судалгааг аймаг, нийслэлээс авч нэгтгэн боловсруулж холбогдох газарт хүргүүлнэ.	-	70	-	-
Гүйцэтгэлийн зорилт № 5.1.3. "Салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгох, шинээр боловсруулах, үргэлжлүүлэх, техникийн даалгавар боловсруулж батлуулах" ажлыг зохион байгуулах, зохицуулах зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ Инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, үргэлжлүүлэх төсөл арга хэмжээний тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллээр хангана.					
5.1.3.1	EN 442 Халаах хэрэгсэл. "Радиатор ба конвектор" стандарт боловсруулах ажилд хяналт тавьж, санал өгч батлуулна.	100	-	-	-
5.1.3.2	"Радиатор ба конвектор. Турших арга"-ын стандарт боловсруулах ажилд хяналт тавьж, санал өгч батлуулна.	-	70	-	-
5.1.3.3	Хийн хангамж" /БНБД 42-01-04/ 2008 нэмэлт өөрчлөлт оруулах ажилд бодлого, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж, санал өгч батлуулж ХЗЯ-д бүртгүүлэх.	100	-	-	-
5.1.3.4	"Автоматжуулалтын систем" дүрмийг боловсруулахад боловсруулалтад оруулах засварт эцсийн хяналт хийж, санал өгч батлуулна.	100	-	-	-
5.1.3.5	Барилгын холбоо дохиоллын зураг төслийн төлөвлөлтийн дүрэм /БД/ боловсруулах ажилд хяналт тавьж, санал өгч БД-ийн төслийг боловсруулсан байна.	100	-	-	-
5.1.3.6	"Усны барилга байгууламжийн буурь" /БНБД 33-04-09/ шинэчлэх ажилд бодлого, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж, санал өгч батлуулна.	-	-	30	-

3.2 ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД

Хот байгуулалт, газрын харилцааны бодлого, төлөвлөлтийн чиглэлээр 10 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ; Нийтийн аж ахуйн бодлого төлөвлөлтийн чиглэлээр 3 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг төлөвлөсөн байна.

Зураг 6. Хоёрдугаар хэсэг. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хэрэгжилт



Мэдээллийн эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн тайлан

Хот байгуулалт, газрын харилцааны бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс дурдвал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна гүйцэтгэлийн зорилт 2.1.6-ын хүрээнд:

✓ БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” барих төслийн хүрээнд холбогдох чиглэл, мэдээлэл, зөвлөмж өгч ажиллаж байна. ХНХЯ, Японы олон улсын ЖАЙКА байгууллага хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд “Дэд бүтцийн хүртээмжийг бодитоор сайжруулах” сэдэвт сургалт, семинарыг 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээнд оролцож санал өгч ажилласан. Тус арга хэмжээнээс “Монгол дахь орчны саадгүй байдлыг хангах стратеги”-д өгөх зөвлөмж гарсан. Барилга, хот байгуулалтын сайдын 162 дугаар тушаалаар байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах зорилгоор холбогдох норм, нормативын баримт бичиг, стандартад үзлэг хийх, Засгийн газрын 2018 оны 317, 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Хот төлөвлөлтийн болон барилга, байгууламжийн зураг төсөл төлөвлөлтийн норм, нормативын баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлага тусгагдсан эсэх талаар үзлэг хийж, дүгнэлт гаргав. Мөн барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн хэрэгжилт болон барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагад холбогдох норм, дүрмийн хэрэгжилтийг шалгах ажлын биелэлтийг гаргав.

Хувийн хэвшилтэй хамтран “Хот байгуулалтын форум”-ыг зохион байгуулна гүйцэтгэлийн зорилт № 2.1.10-ын хүрээнд:

✓ Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.85.2-т тусгагдсан “Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Хот байгуулалтын форумыг жил бүр зохион байгуулах” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор БХБСайдын 2019 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 126 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Хот байгуулалтын форум, хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Барилгын хөгжлийн төвд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ, НХБХГ, НГЗБА, МАЭ-ТББ, МБУА-ТББ-ын төлөөлөл 150 хүн оролцсон.

Нийтийн аж ахуйн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс дурдвал:

Хөдөлмөр эрхлэлт гүйцэтгэлийн зорилт № 4.1.2-ын хүрээнд:

✓ Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2019”-ийг 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/60 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

✓ Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайд 2019 оны

06 дугаар сард баталсан байна. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан салбарын ХАБЭА-н салбар хороог Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар байгуулж, тушаал гарснаар салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 2 дугаар сард багтаан батлуулахаар ажиллаж байна.

✓ Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг сайжруулах, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд “Мэргэшсэн инженер”-ийн зэрэг горилох, сунгах заавал болон сонгон суралцах багц /кредит/ цаг тооцох сургалтыг 2019 онд амжилттай зохион байгууллаа. Нийт 21 удаагийн сургалтыг Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулж 329 инженер техникийн ажилтан хамруулж чадавхижуулж мэргэжил, мэдлэг олголоо.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад олон нийт, бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлнэ гүйцэтгэлийн зорилт № 4.1.3.-ын хүрээнд:

✓ БХБЯ, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо, “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-тай хамтран Нийтийн аж ахуйн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн, нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Дорнод аймагт зохион байгууллаа. Тус зөвлөгөөнөөр ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагуудын удирдлагад салбарын зохицуулалтын талаар баримтлах бодлого чиглэл, усны аюулгүй байдал, хүний нөөцийг чадавхижуулах, Европын орнуудын туршлага, Ус-нийгмийн эрүүл мэндийн талаар мэдээлэл өгч, санал солилцсон. Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний 88 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад таниулах, мэдлэг, мэдээлэл олгох, санал, өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, зөвлөмжөөр хангах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг “Хэрэглэгчээ сонсьё” уриан дор улсын хэмжээнд 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан.

Хүснэгт 6. Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ /Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хэрэгжилт арга хэмжээ тус бүрээр/.

Арга хэмжээ Д/д	Арга хэмжээ	Хэрэгжилт хувиар				Зорилтын хэрэгжилт /хувиар/
		100 хувь	70 хувь	30 хувь	0 хувь	
2.ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ						
Гүйцэтгэлийн зорилт № 2.1.1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.						
2.1.1.1	Хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглээний соёлыг төлөвшүүлэх сурталчилгааны арга хэмжээг тогтмол зохион байгуулах.	-	70	-	-	70 хувь
Гүйцэтгэлийн зорилт №2.1.2. Хэрэглэгчийг соён гэгээрүүлэх, мэдлэг боловсрол олгох зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.						
2.1.2.1	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах урьдчилан сэргийлэх үүднээс салбарын хэвлэл мэдээлэл, сэтгүүлүүдтэй хамтран ажиллах;	100	-	-	-	70 хувь
2.1.2.2	Хэрэглэгч шаардлагатай мэдээллээ хүссэн цагтаа авч, санал гомдлоо чөлөөтэй илэрхийлж, шуурхай шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Санал хүсэлт” хэсгийг тогтмол ажиллуулах, “хэрэглэгчийн утас”-ыг ажиллуулан санал хүсэлтийг сонсож, мэдээлэл зөвлөгөө тогтмол өгч байх боломжийг бүрдүүлэх;	100	-	-	-	

2.1.2.3	Хэрэглэгчдэд зориулсан гарын авлага, ном, товхимол, зурагт хуудас, сурталчилгааны бусад материал бэлтгэн хэвлүүлж, олон нийтэд түгээх.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт №2.1.3. Хэрэглэгчид хүрч байгаа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлнэ.						70 хувь
2.1.3.1	Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд иргэдийн эрх ихээр зөрчигдөж байгаа асуудлыг судлан тогтоож тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.	-	70	-	-	
Гүйцэтгэлийн зорилт №2.1.4. Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.						100 хувь
2.1.4.1	1.Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах. 2.Барилга, хот байгуулалтын салбарт жендерийн талаар баримтлах бодлого (2018-2025)-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтийг тайлагнах.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 2.1.5. Хэрэглэгчид хүрч байгаа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлнэ						100 хувь
2.1.5.1	Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт 2.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.						100 хувь
2.1.6.1	БНХАУ-ын буцалтгүй туламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” барих төслийг хэрэгжүүлэхэд ХНХЯ-тай хамтран ажиллах.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 2.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.						100 хувь
2.1.7.1	Хот төлөвлөлтийн болон барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаанд холбогдох хууль, норм, нормативын баримт бичгийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагаг хангуулах арга хэмжээ авч ажиллах	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 2.1.8. Аймаг нийслэлийн ерөнхий архитекторуудыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.						100 хувь
2.1.8.1	Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын 2018 оны ажлын нэгдсэн тайланд дүгнэлт хийж, холбогдох зөвлөмжийг аймгуудад хүргүүлсэн байна	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 2.1.9.Аймгийн төвүүдэд батлагдсан ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтөлтийн санг байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.						100 хувь
2.1.9.1	21 аймаг, нийслэлээс “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтөлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын хэрэгжилтийн тайланд дүгнэлт хийх ажлыг зохион байгуулсан байна.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 2.1.10.Хувийн хэвшилтэй хамтран “Хот байгуулалтын форум”-ыг зохион байгуулна.						100 хувь
2.1.10.1	Хот байгуулалтын форумыг зохион байгуулах	100	-	-	-	
4. НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ						
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.1. Хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох.						100 хувь
4.1.1.1	Хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хүрээнд хамтарч ажиллан салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын орлого, ашгийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 4.1.2.Хөдөлмөр эрхлэлт.						92.5 хувь
4.1.2.1	Тус салбарын мэргэжлийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох санал боловсруулж, шийдвэрлүүлэх	100	-	-	-	
4.1.2.2	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтнуудын улсын зөвлөгөөнийг 2019-2020 онуудад талууд хамтран зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулж, биелэлт үр дүнг тайлагнаж ажиллах.	100	-	-	-	
4.1.2.3	Салбарын хэмжээнд ХАБЭА-н хамтын ажиллагааны салбар хороог байгуулах.	-	70	-	-	
4.1.2.4	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудыг төсөл, хөтөлбөрт хамруулах, ялангуяа ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг сайжруулах, тэдний мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төсөлд хамруулах.	100	-	-	-	

Гүйцэтгэлийн зорилт № 4.1.3. Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад олон нийт, бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлнэ.					100 хувь
4.1.3.1	"Хэрэглэгчээ сонсьё-2019" нээлттэй өдөрлөг арга хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран зохион байгуулах.	100	-	-	

3.3 ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД

Хот байгуулалт, газрын харилцааны бодлого, төлөвлөлтийн хүрээнд 7 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ, барилга, барилгын материалын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр 6 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ; нийтийн аж ахуйн бодлого төлөвлөлтийн чиглэлээр 7 зорилтын хүрээнд 8 арга хэмжээ; төрийн захиргааны удирдлагын чиглэлээр 4 зорилтын хүрээнд 69 арга хэмжээ; хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр 3 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг төлөвлөсөн байна.

Зураг 7. Гуравдугаар хэсэг. Хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт



Мэдээллийн эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн тайлан

Хот байгуулалт, газрын харилцааны бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээнүүдээс дурдвал:

Нийслэл болон бүсийн хөгжлийн тулгуур төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл боловсруулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, зохицуулна гүйцэтгэлийн зорилт №2.1.5.-ын хүрээнд:

✓ Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийн хэрэгжилтийн байдал, “Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа”-ны ажлыг НИТХ-ын Тэргүүлэгчдэд 2019.09.11-ний өдөр танилцуулсан. Баримт бичгийг НИТХ-ын дэргэдэх намын бүлгүүдийн хурлаар 2019.09.24-ний өдөр, НЗД-ын дэргэдэх “Аз жаргалын хороо”-ны хурлаар 2019.09.25-ны өдөр, НИТХ-аар 2019.09.26-ны өдөр тус тус хэлэлцүүлж, НИТХ-

ын Тэргүүлэгчдээс санал авсан. Хуралдаанаас НИТХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан, санал өгөх ажил зохион байгуулагдсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны ээлжит 28 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, 2019 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 28/26 дугаар тогтоолоор дэмжигдсэн. Уг ажлыг БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар, мөн БХБСайдын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн дэмжиж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэхтэй холбогдох дүрэм, журам, заавар, норм, нормативыг батлан мөрдүүлнэ гүйцэтгэлийн зорилт №2.1.7-ын хүрээнд:

✓ Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 60 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хуулийг дагалдан гарах “Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”, “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авсан. Танилцуулга материалыг бэлтгэн 2019.12.11-ний өдөр Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, БХБ-ын Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээнүүдээс дурдвал:

Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, холбогдох дүрэм, журам, норм, нормативын баримт бичгийг боловсруулж батлуулах, салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр төлөвлөлтийг удирдлага зохицуулалтаар хангах, мэргэжлийн удирдлага, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих мэдээллийн сан байгуулах гүйцэтгэлийн зорилт №3.1.1-ийн хүрээнд:

✓ “Барилгын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын дотоод хяналтын жишиг дүрэм”-ийг Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлуулсан.

Барилга байгууламжийн үйлдвэрлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах гүйцэтгэлийн зорилт № 3.1.2-ын хүрээнд:

✓ Барилгын салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг цахим хэлбэрт оруулж, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-аас улирал тутам тайлан, судалгааг хүлээн авч мэдээллийг нэгтгэн ажиллаж байна.

✓ Барилга угсралтын гүйцэтгэгч байгууллагуудын удирдах ажилтнуудын уулзалт, семинарыг МХЕГ-тай хамтран 2019 оны 04 дүгээр сарын 05-нд “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т зохион байгуулсан. Тус уулзалт, семинарт салбарын 150 гаруй аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд хамрагдсан байна.

✓ Барилга угсралт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй инженер техникийн ажилчдыг чадавхжуулах сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан.

✓ “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2019 оны төлөвлөгөөг хамтарсан зохицуулах хорооны хурлын 2019 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцэж баталсан.

✓ “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-тэй хамтарч “Уналтаас хамгаалах бүсний зөв хэрэглээ” гарын авлагыг боловсруулж, хэвлүүлэн, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчилсан.

✓ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.19 дэх заалт, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр /2017-2020/-ийн хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 220 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 46 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ны 6-н зорилтын хүрээнд 30 үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон боловсруулж, 2021 он хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан.

✓ Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийн тэмдэглэл, дүгнэлтийг албажуулж сайдын тушаалын төсөл боловсруулж батлуулах ажлын хүрээнд “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын ерөнхийлөгчийн тушаалаар байгуулагдсан “Тусгай зөвшөөрлийн урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсэг”-ийн ирүүлсэн 43 удаагийн тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн БХБСайдын тушаалын төслийг боловсруулан баталгаажуулж хүргүүлээд байна.

✓ Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд харъяа байгууллага, төрийн бус байгууллагуудын ирүүлсэн саналыг нэгтгэн Төрийн нарийн бичгийн даргаар төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Тендерийн үйл ажиллагааг зохион байгуулна гүйцэтгэлийн зорилт № 3.1.3-ын хүрээнд:

✓ 2019 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний хэрэгжилтийн эрх шилжсэн 24 төсөл арга хэмжээний ажлын 23 нь цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтыг зарласан бөгөөд гэрээ байгуулан, ажил эхэлсэн 21, дахин зарлагдсан 2, газрын асуудал шийдэгдээгүйгээс 1 тендерийн зарлагдаагүй байна. БХБЯ-аас зарлагдсан нийт 14 худалдан авах ажиллагааны гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн 13, дахин зарласан 1 төсөл байна.

✓ 2019 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартын дагуу бий болгох ажлын хүрээнд Барилгын тухай хууль, “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага” /БД 31-101-04/, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт”/БД 31-112-11/-д тус тус үндэслэн барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн эсэхийг шалган ажиллав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартын дагуу бий болгох, барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн эсэхийг шалгах ажлын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаад байна. 2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар орон сууцны барилга 221, орон сууцны бус барилга 691, их засварын ажил 229, ерөнхий төлөвлөгөө 21, тохижилтын ажил 120, нийт 1282 зураг төсөлд магадлал хийсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартын дагуу бий болгох

ажлын хүрээнд: - Зураг төсөлд магадлал хийх шатанд шинээр батлагдсан норм нормативын хэрэгжилтийг тухайн зураг төсөлд тусгагдсан эсэх, - орон сууц, цэцэрлэг, олон нийтийн барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт" /БД 31-112-11/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл зохиох дүрэм /БД 31-101-04/ нормуудын заалтад нийцүүлэн зураг төслийг баталгаажуулан ажиллаж байна.

✓ Шинээр боловсруулах нэг маягийн зураг төслийн жагсаалтыг гаргаж, хөрөнгийн тооцоог урьдчилсан байдлаар боловсруулж, 2020 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар санал хүргүүлсэн.

✓ Паспортжуулалт, гэрчилгээжүүлэлтэд заавал хамрагдах шаардлагатай онцгой зориулалт бүхий барилгуудын жагсаалтыг дараах байдлаар гаргасан. Үүнд:

1. Гамшгийн үеийн улс орны үйл ажиллагааг нэгтгэн удирдаж, чиглүүлэх үүрэг бүхий төр засгийн газрын төв байрууд;

2. Газар хөдлөлтийн хор уршгийг арилгах нэгдсэн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай барилга, байгууламжууд болох Харилцаа холбоо, Онцгой байдал, Мэргэжлийн хяналтын байгууллагын лаборатори, барилгууд, хот, суурин газрын цэвэр ус хангамж, эрчим хүчний системийн барилга, байгууламжууд;

3. Газар хөдлөлтийн үеийн эвдрэл гэмтлээс шалтгаалан онцгой хүнд сүйрэл учруулж болохуйц барилгууд болох цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, төв эмнэлгүүд, нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг үзвэр үйлчилгээ, худалдааны төвүүд, спортын ордон, нисэх онгоцны болон төмөр замын төв буудлууд, нийтийн орон сууцны барилгууд;

4. Газар хөдлөлтийн үеийн нүүлгэн шилжүүлэх үүрэг бүхий төв болон гол замуудын урсгал хөдөлгөөнийг нуралтаас шалтгаалан хааж болзошгүй өндөр барилгууд.

✓ Тус яам нь Онцгой байдлын ерөнхий газар, Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл"-тэй хамтран Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталсан барилга байгууламжийг хүчитгэх болон үнэлэх дүрмийн хүрээнд нийслэлийн 105 дугаар цэцэрлэг, 97 дугаар сургууль, 1 дүгээр төрөх эмнэлэг, 9 давхар угсармал орон сууц, Онцгой байдлын ерөнхий газрын барилга байгууламжийг сонгож төмөр бетон, угсармал хавтгаалжин, өрөгт бүтээцтэй барилгын хүчитгэлийн зураг төслийг боловсруулсан. Хүчитгэлийн талаарх сургалтыг БХБЯ, ОБЕГ, МХЕГ, НХБХГ, МБИХ болон төслийн 2 дугаар ажлын хэсэг хамтран "Барилгын хүчитгэлийн аргачлал" сэдэвт сургалтыг 2019 оны 05 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад төрийн болон хувийн хэвшлийн нийт 65 инженер, мэргэжилтнүүд хамрагдсан байна.

✓ Засгийн газрын 2018 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй буулгаж, шинээр барих шаардлагатай барилга байгууламжийн жагсаалт"-д багтсан бөгөөд уг орон сууцыг буулган шинээр барих төслийг нийслэлийн төсөвт тусган 2019 оноос эхлүүлэх, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах талаарх албан бичгийг Н/67 тоотоор аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Мөн 2020 онд шаардлагатай байгаа төсвийг тусгуулах талаар санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн. Нийслэлд 163 барилгыг 67 багц болгон төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг 2019 оны байдлаар 12 удаа зарласанаас 29 багцын 75 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдсаны үр дүнд 531 айлын 27 орон сууцыг буулган 1054 айлын 11 орон сууц ашиглалтад орсон байна. 2019 оны 4 дүгээр улиралд багтаан 4 орон сууц шинээр ашиглалтад оруулахаар төлөвлөн

ажиллаж байна. Аймаг орон нутгийн хэмжээнд 6 орон сууц, 1 сургууль, 2 хичээлийн байр, 2 соёлын төв, 1 асрамжийн барилгыг буулган шинээр барих ажил хэрэгжиж байна.

✓ Архангай аймагт 4 байршлын 8 барилга байгууламжийн төлөвлөлтийн зураг хийлгэх 20 сая төгрөгийг аймгийн хөгжлийн санд тусгаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Баянхонгор аймагт 12 айлын 2 орон сууцыг /Баянхонгор сумын 3, 8 дугаар байр/ дахин төлөвлөлтөд оруулж, 60, 25 айлын 2 орон сууц барихаар төлөвлөсөн. Нэг айлд 15 сая орчим төгрөгний хөнгөлөлт үзүүлж, барих бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Өмнөговь аймагт 2, 3, 9 дүгээр орон сууцны барилга байгууламжийг буулган шинээр барьж байна. Сайншанд сумын 2, 3 дугаар байрны 12 айлын орон сууц, 9 дүгээр байрны 27 айлын орон сууцыг буулгаж 2 дугаар байрыг 45, 3 дугаар байрыг 50, 9 дүгээр байрыг 64 айлын орон сууц болгон өргөжүүлэн барихаар төлөвлөн барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. Хөвсгөл аймагт 36 айлын орон сууцны барилга байгууламжийг буулгаж шинээр барих шийдвэр гарсан. Дархан-Уул аймагт ашиглалтын шаардлага хангахгүй Дархан сумын 4, 5, 6 дугаар багийн 19 барилгыг буулгаж дахин барихаар батлагдаж, эхний ээлжинд 6 дугаар багийн 61, 62, 63 дугаар байрыг буулгаж 60 айлын орон сууцны шийдвэр гарсан. Барилга угсралтын ажлыг эхлүүлж, 2019 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Аймаг, орон нутгийн хэмжээнд 6 орон сууц, 1 сургууль, 2 хичээлийн байр, 2 соёлын төв, 1 асрамжийн барилгыг буулган шинээр барих ажил хэрэгжиж байна.

✓ “Барилгын ул хөрсний усны горимын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашдын чиг хандлага” сэдэвт нээлттэй уулзалт, ярилцлагыг төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагуудын хүрээнд зохион байгуулж, хурлаас гарсан санал, дүгнэлт, зөвлөмж, шийдвэрийн дагуу 2019 онд боловсруулах норм, норматив, төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд санал өгч, тусгасан.

Нийтийн аж ахуйн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээнүүдээс дурдвал:

Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай гүйцэтгэлийн зорилт № 4.1.5.-ын хүрээнд:

✓ Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдлыг хангуулах тухай 2019 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 2019/25 тоот албан даалгаврыг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Салбарын байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулж, тайлагнах үүрэг өгөв. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн “Осол, гэмтлээс урьдчилсан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 236 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн олон улсын OHSAS 18001:2007 стандартыг танилцуулж, хэрэгжүүлж буй туршлагыг түгээх сургалтыг “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн 3713-МОН” төслийн гүйцэтгэгч ЗАГ Инженеринг ХХК-тай 2019 оны 10-р сарын 3-4-ний өдрүүдэд Булган аймгийн төвд баригдаж байгаа төв цэвэрлэх байгууламжийн ажлын талбайн жишээнд тулгуурлан сургалтыг зохион байгуулсан.

✓ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд шинээр баригдсан хоногт 24000м3 бохир ус цэвэрлэх хүчин чадал

бүхий цэвэрлэх байгууламжийн ашиглалт, өмчлөлийн асуудлыг хэлэлцэж, уг цэвэрлэх байгууламжийн ашиглалт үйлчилгээг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар хариуцахаар шийдвэрлэсэн. Шинээр баригдсан 24000 м3/хон хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийг Барилгын тухай хуульд барилга, байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой заасан шаардлагууд хангагдсаны дараа “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу ашиглалтад оруулах ажлыг 2020 оны 07 дугаар сард багтаан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хүснэгт 7. Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ /Хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хэрэгжилт арга хэмжээ тус бүрээр/.

Арга хэмжээ Д/д	Арга хэмжээ	Хэрэгжилт хувиар				Зорилтын хэрэгжилт /хувиар/
		100 хувь	70 хувь	30 хувь	0 хувь	
2. ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ						
Гүйцэтгэлийн зорилт №2.1.1. Хот байгуулалтын төрийн бодлогыг хэрэгжүүлж, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавина.						100 хувь
2.1.1.1	Хот байгуулалтын төрийн бодлогыг хэрэгжүүлж, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт №2.1.2. Хот байгуулалтын норм ба дүрэм, журам батлана.						100 хувь
2.1.2.1	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх, тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт тавих журам, Хот байгуулалтын баримт бичигт улсын экспертиз хийх дүрэм, журам, “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах аргачилсан заавар”, “Хот, тосгоны барилгажилтын норм ба дүрэм” (БНБД 30-01-04), “Хот байгуулалтын кадастр эрхлэх дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах, “Хот байгуулалтын мэдээллийн сан”-ийн журам боловсруулах.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт №2.1.3. Хот байгуулалтын баримт бичигт улсын экспертизийн дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулна.						70 хувь
2.1.3.1	Хот байгуулалтын баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах экспертиудыг БХБСайдын тушаалаар томилон, магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах	-	70	-	-	
Гүйцэтгэлийн зорилт №2.1.4. Хот байгуулалтын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулна.						70 хувь
2.1.4.1	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг боловсруулах.	-	70	-	-	
Гүйцэтгэлийн зорилт №2.1.5. Нийслэл болон бүсийн хөгжлийн тулгуур төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл боловсруулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, зохицуулна.						70 хувь
2.1.5.1	“Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа”-ны ажлын эхний хувилбарыг боловсруулах.	-	70	-	-	
Гүйцэтгэлийн зорилт №2.1.6. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх чиглэлээр салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ						100 хувь
2.1.6.1	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх чиглэлээр салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэхтэй холбогдсон бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт №2.1.7. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэхтэй холбогдох дүрэм, журам, заавар, норм, нормативыг батлан мөрдүүлнэ						70 хувь
2.1.7.1	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэхтэй холбогдох дүрэм, журам, заавар, норм, нормативыг батлан мөрдүүлэх, стандартыг хэрэгжүүлэх	-	70	-	-	
3. БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ						
Гүйцэтгэлийн зорилт № 3.1.1. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, холбогдох дүрэм, журам, норм, нормативын баримт бичгийг боловсруулж батлуулах, салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр төлөвлөлтийг удирдлага зохицуулалтаар хангах, мэргэжлийн удирдлага, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих мэдээллийн сан байгуулна.						85.5 хувь
3.1.1.1	“Барилга байгууламжийн цахим тооцооллын программ хангамжийг баталгаажуулж, хэрэглэх журам”-ийг СЗХуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах.	-	70	-	-	

3.1.1.2	Барилгын салбарын байгууллагууд үйл ажиллагаандаа дотоод хяналт шалгалт хийх нийтлэг журам боловсруулж, батлуулна.	100	-	-	-	
3.1.1.3	Барилгын үйл ажиллагаанд холбогдсон зөвшөөрөл олгох хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэх болон барилгын салбарт нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх нийтлэг журам боловсруулна.	100	-	-	-	
3.1.1.4	“Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4-р хавсралтад дурьдсан актуудын загварыг шинэчлэн боловсруулж батлуулна.	-	70	-	-	
3.1.1.5	Барилга хот байгуулалтын сайдын 2005 оны 39 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Барилга, байгууламжийн хийц бүтэц, даацын чанар бат бэх, тогтворын байдал, найдвартай үйл ажиллагаанд үнэлгээ өгч паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын жишиг үнэ”-ийг шинэчлэн боловсруулж батлуулна.	-	-	30	-	
3.1.1.6	Салбарын норм, нормативын 61 баримт бичгийг үргэлжлүүлэн хийж боловсруулж, батлуулна.	100	-	-	-	
3.1.1.7	Салбарын норм, нормативын 26 баримт бичгийг шинээр хийж боловсруулах ажлыг эхлүүлнэ.	100	-	-	-	
3.1.1.8	Барилга байгууламжийн нэг маягийн зураг төсөлд тодотгол хийж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлын судалгааг хийх	100	-	-	-	
3.1.1.9	Гамшгийн мэдээллийн нэгдсэн сан байгуулна.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 3.1.2. Барилга байгууламжийн үйлдвэрлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;						
3.1.2.1	“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.	100	-	-	-	
3.1.2.2	Барилгын салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн судалгааг авч нэгтгэсэн байна.	100	-	-	-	
3.1.2.3	Барилга угсралтын гүйцэтгэгч байгууллагуудын удирдах ажилтнуудын уулзалт, семинар зохион байгуулна.	100	-	-	-	
3.1.2.4	Барилга угсралт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй инженер техникийн ажилчдыг чадавхижуулах сургалт зохион байгуулна.	100	-	-	-	
3.1.2.5	JICA-тай хамтран “Барилгын салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2019 оны төлөвлөгөөг боловсруулна.	100	-	-	-	
3.1.2.6	“ILO”Олон улсын хөдөлмөрийн байгууллагын барилгын үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 167-р конвенци болон 175-р зөвлөмжийг УИХ-аар батлуулж конвенцид нэгдэх, ОУ-ын хөдөлмөрийн байгууллага болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллана.	100	-	-	-	
3.1.2.7	“ILO”Олон улсын хөдөлмөрийн байгууллагын барилгын үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 167-р конвенци болон 175-р зөвлөмжийг УИХ-аар батлуулж конвенцид нэгдэх, ОУ-ын хөдөлмөрийн байгууллага болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллана.	100	-	-	-	
3.1.2.8	“Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна.	100	-	-	-	
3.1.2.9	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах” ажлын хэрэгжилтийг хангаж ажиллана.	100	-	-	-	100 хувь
3.1.2.10	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах” ажлын хэрэгжилтийг хангаж ажиллана.	100	-	-	-	
3.1.2.11	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах” ажлын хэрэгжилтийг хангаж ажиллана.	100	-	-	-	
3.1.2.12	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах” ажлын хэрэгжилтийг хангаж ажиллана.	100	-	-	-	
3.1.2.13	“Барилгын салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-Удирдах хорооны хурлыг зохион байгуулна.	100	-	-	-	
3.1.2.14	“Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2019” зохион байгуулна.	100	-	-	-	
3.1.2.15	“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний зөвлөгөөн-2019”-г зохион байгуулна.	100	-	-	-	
3.1.2.16	“Барилгын салбарын оны шилдэг байгууллага, аж ахуй нэгж байгууллага шалгаруулах журам” шинэчлэн боловсруулж, батлуулна.	100	-	-	-	
3.1.2.17	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулдаг Төрийн болон ААНБайгууллага, төрийн бус байгууллагуудын нэгдсэн өдөрлөг, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулна.	100	-	-	-	

3.1.2.18	Барилгын салбарын 93 жилийн ой, "Барилгачдын өдөр"-2019, салбарын шилдэг 10 аж ахуйн нэгж байгууллага шалгаруулна.	100	-	-	-	
3.1.2.19	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох Урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийн тэмдэглэл, дүгнэлтийг албажуулж сайдын тушаалын төсөл боловсруулж батлуулах ажлыг тогтмол зохион байгуулна.	100	-	-	-	
3.1.2.20	Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулна.	100	-	-	-	
3.1.2.21	Салбарын чиг үүрэг хэрэгжүүлж буй "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ, "ТОСК" ТӨААТҮГ, ГЗБГЗГазруудад "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл" байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	100	-	-	-	
3.1.2.22	Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийг дагуу хэрэгжүүлж, мэдээллийг улирал бүр гаргуулан авсан байна.	100	-	-	-	
3.1.2.23	Барилга угсралт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй инженер техникийн ажилчдыг чадавхижуулах сургалт зохион байгуулна.	100	-	-	-	
3.1.2.24	Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлэх техникийн зохицуулалтын баримт бичгийг боловсруулна.	100	-	-	-	
3.1.2.25	БНЭУ-ын зээлийн хөрөнгөөр баригдах Газрын тос боловсруулах үйлдвэр барих ажлын үйлдвэрийн гадна хашаа, газар шорооны ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллана.	100	-	-	-	
Гүйцэтгэлийн зорилт № 3.1.3.Тендерийн үйл ажиллагааг зохион байгуулна.						
3.1.3.1	XI.1.60, XI.2.6, XI.2.17, XI.2.22, XI.2.29, XI.2.14, XI.2.7, XI.2.9, XI.2.19, XI.1.25, XI.1.94, XI.1.60, XI.1.52, XI.1.65, XI.1.66, XI.3.4, XI.1.99, XI.1.100, XI.1.97, XI.4.2, XI.1.53, XI.4.3, XI.4.4, XI.4.5, XI.1.107, XI.1.90, XI.3.2, XI.1.108, XI.3.3, XI.2.28, XI.1.105, XI.1.35, XI.1.106 тус тус хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийг хангаж ажиллах	100	-	-	-	100 хувь
Гүйцэтгэлийн зорилт № 3.1.4.Барилга байгууламжийн зураг төсөл, инженер геологи, барилгын машин механизм, механикжуулалт, газар хөдлөлтийн тэсвэрлэлт чанар, аюулгүй байдал, төсөв, үнэ бүрдлийн талаар баримтлах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангах						
3.1.4.1	Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийхдээ холбогдох хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангуулах арга хэмжээг авч ажиллана.	100	-	-	-	
3.1.4.2	5, 7, 9, 16, 25 давхар барилгын нэг маягын зураг төсөл боловсруулахад шаардлагатай хөрөнгийн судалгааг хийнэ.	100	-	-	-	
3.1.4.3	Засгийн газрын 157 дугаар тогтоолоор баталсан "Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжилтийг ханган ажиллаж төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллана.	-	70	-	-	
3.1.4.4	Паспортжуулалт, гэрчилгээжүүлэлтэд заавал хамрагдах шаардлагатай онцгой зориулалт бүхий барилгуудын жагсаалтыг батлан гаргасан байна.	-	70	-	-	
3.1.4.5	Газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон барилгын үндсэн хийц бүтээцийн бэхэлгээ хүчитгэлийн техникийн шийдлийг боловсруулах, батлагдсан байна.	-	70	-	-	
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	56 албан хаагч/ 100 хувь	-	Тайлант хугацаанд нийт 67 албан хаагч ажилласанаас 56 буюу 86,1 хувь нь 3 –аас дээш жил төрийн албанд тогтвортой ажиллаж байна.
	Хэсгийн дундаж:					100 хувь	
1. Албан хаагчдын нийгмийн баталгааг	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан	Гүйцэтгэлээр	Нийт албан хаагч/ 100 хувь	85,5 сая	Нийт ажиллаж байгаа албан хаагчдын хагас жилийн ажлыг дүгнэн ажлын үр дүнгээр үндсэн цалингийн 80 хүртэлх хувиар урамшуулал олгов. Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/70 дугаар тушаалаар яамны Хөдөлмөрийн

хангах	тогтолцоог хэрэгжүүлэх	хаагчдын тоо				<p>дотоод журмын дагуу 3 албан хаагч тэтгэвэрт гарсан, 4 албан хаагчдад 50 насны ойг тохиолдуулан тус бүр бэлэг дурсгалын зүйл /600 мянган төгрөг/ олгосон. Тэтгэвэрт гарсан хүмүүсийн буцалтгүй тэтгэмжид 52,7 сая төгрөгийг хуульд заасан журмын дагуу тооцож олгосон.</p> <p>2019 онд үр бүтээлтэй ажилласан нийт ажилчдад үр дүнгийн гэрээний урамшуулал олгохоос гадна Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахлах мэргэжилтэн Э.Бат-Эрдэнэ Алтан гадас одонгоор, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан, Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Б.Амартүвшин нар Хөдөлмөрийн хүндэт медалиар, Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ү.Бадамсүрэн Эрчим хүчний тэргүүний ажилтан цол тэмдэгээр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч Д.Монголжингоо Хууль зүйн албаны тэргүүний ажилтан цол тэмдэгээр, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Т.Батцэнд Барилгын тэргүүний ажилтан цол тэмдэгээр тус тус шагнагдсан.</p>
		Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	нийт албан хаагч / 100 хувь	40,3 сая	<p>“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” УИХ-ын 2019 оны 2 дугаар сарын 01-ний 21 дүгээр тогтоол, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны 275 дугаар тогтоол, “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 277 дугаар тогтоолуудыг үндэслэн ТНБД-ын 2019 оны 10-р сарын 01-ний Б/100 дугаар тушаалаар албан тушаалын цалин, зэрэг дэв, ажилласан хугацааны нэмэгдлийн тус тус шинэчлэн тогтоосон.</p>
	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	100 хувь	-	<p>Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/135 дугаар тушаалаар баталсан “Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2018-2020 оны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг тухайн жилийн эцсээр үнэлж, дүгнэн, дээд шатны байгууллагад тайлагнан, жил бүр төлөвлөгөөнд тодотгол хийн ажиллаж байна.</p> <p>“Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017-2019 оны ажлын</p>

						<p>төлөвлөгөөний хүрээнд 2019 оны эхний хагас жилд нийт албан хаагчдад Сонгино хайрхан дүүргийн Баянголын аманд зуслангийн газар олгох ажлыг зохион байгуулж байна. Уг газрын геотехникийн судалгааны үндсэн дээр газрыг дахин хуваарьлаж, барилгын зураг, төслийг боловсруулж, газар олгох асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн 2019 оны 12 дугаар сард нийт албан хаагчиддаа газар эзэмших эрхийн гэрчилгээг гардуулсан.</p> <p>Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгаар 100 хувьтай байна.</p>
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	100 хувь	2,8 сая	Унаа хоолны мөнгөний хэмжээг шинэчлэн тогтоож 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлж 8000 төгрөг болгосон.
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	1 удаа / 100 хувь	8,9 сая	Барилга, хот байгуулалтын яамны албан хаагчид “Люкс Мэд” Эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт /цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, биохимийн шинжилгээ, Хелико бактери амьсгалын тестээр, Хэвлийн эхо, Зүрхний цахилгаан бичлэг, цээжний рентген зураг, дотрын эмчийн үзлэг гэх мэт/ хамрагдсан болно. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд жил бүр албан хаагчдыг хамруулж хэвшсэн.
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	100 хувь		Барилга, хот байгуулалтын яамны нийт албан хаагчид 100 хувь хамрагдсан болно.
		Хэсгийн дундаж:				100 хувь
		Үнэлгээний дундаж хувь:				100 хувь

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ
АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**
/2019 оны жилийн эцсийн байдлаар/

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын яамны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг хангах арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Барилга, хот байгуулалтын яамны хүний нөөцийг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг хангах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

Барилга, хот байгуулалтын яамны бүтцийн нэгжүүдийн гаргасан мэдээлэл, арга хэмжээний биелэлтийг үндэслэл болгон хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан гүйцэтгэлийн түвшинг үнэлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

ГУРАВ. ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Барилга, хот байгуулалтын яамны хүний нөөцийг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг хангах нийт 10 шалгуур үзүүлэлтээс 100 хувийн биелэлттэй – 10 арга хэмжээ тус байна.

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг зорилт тус бүрээр харуулбал:

№	Шалгуур үзүүлэлтүүд	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт /хувиар/				Дундаж хувь
			100	70	30	0	
1	Хүний нөөцийг чадавхжуулах	5	5	-	-	-	100

2	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	5	5	-	-	-	100
Дүн		10	10	-	-	-	100

Тайлбар: Барилга, хот байгуулалтын яамны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг тайлагнах хүснэгт буюу журмын 10 дугаар хавсралтыг хавсаргав.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Барилга, хот байгуулалтын яамны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын хүрээнд албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр дотоодын 15 удаагийн сургалтыг зохион байгуулсан нь өмнөх оныхоос 2-оор илүү, оролцсон албан хаагчид давхардсан тоогоор нийт 113 байсан нь өмнөх оныхоос 28-аар илүү, гадаадын сургалтад нийт 51 албан хаагчийг хамруулсан нь өмнөх оныхоос 32-оор илүү байна. Өөрөөр хэлбэл сургалтанд хамрагдагсдын тоог ахиулж, яамны зүгээс болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан сургалтуудад албан хаагчдаа хангалттай хамруулжээ.

Түүнчлэн Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт албан хаагчдыг 100 хувь хамруулахаас гадна хоол унааны мөнгийг өмнөх жилүүдэд өгч байсан хэмжээнээс үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна.

Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр 3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлтийг мөн өсгөсөн. Нийт албан хаагчдын дунд эзлэх хувь 86,1%-тай байна.

Мөн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, мөн зуслангийн газар олгосон байна.

Хүний нөөцийн хөгжлийн талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг бататган төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангахад өнөөгийн хүрсэн түвшинг цаашид үе шаттай ахиулах нь зүйтэй.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

10.4 Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлт /журмын 11 дүгээр хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	<p>Байгууллагын https://mcud.gov.mn/gov цахим хуудас болон мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан, байнга шинэчилж, баяжуулалтыг хийж хөтлөн явуулдаг.</p> <p>БХБЯ-ны үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээнээс 230 мэдээ, мэдээлэл бэлтгэж яамны вэб сайт болон нэйж хуудаст нийтэлж, эдгээр мэдээ мэдээллийг гэрээт болон гэрээт бус 4 өдөр тутмын сонин, 30 вэб сайтад давхардсан тоогоор 1050 удаа мэдээ нийтлүүлж ажилласан байна. Түүнчлэн гэрээт болон гэрээт бус телевизүүдээр БХБЯ-ны үйл ажиллагаатай холбоотой 150 мэдээ, нэвтрүүлэг цацагдсан байна.</p> <p>Монголын Медиа корпорацийн “Барилга-2019” медиа экспо арга хэмжээг 2 сарын хугацаанд хамтран зохион байгуулж, Ийгл тв, Ийгл фм, Ийгл.мн, Орон нутгийн 21 сүлжээ зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр салбарын мэдээ, мэдээллийг сурталчилж ажилласан байна.</p> <p>Мөн тус яамны харьяа байгууллагууд тайлант хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>1.Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар нь байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө болон гүйцэтгэлийн тайлан мэдээг мөн зохион байгуулалтын бүтцийг цахим хуудсанд байршуулсан. Дээд газраас ирүүлсэн тушаал, шийвэр болон газрын даргын гаргасан шийдвэрийг байгууллагын мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажилласан.Холбоос: http://www.qazar.gov.mn</p> <p>2. Барилгын хөгжлийн төв нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хууль, БХБЯ-ны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөнд туссаны дагуу Эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Барилгын хөгжлийн төвийн цахим хуудас http://barilqa.gov.mn –нд байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.</p> <p>3.Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь 2019 оны байдлаар байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тус бүр 4 удаа мэдээллийг шинэчлэн оруулсан. Цахим хуудасны холбоос: http://wsrc.mn/new/mn/introduction</p>	100
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой	<p>Байгууллагын бүх газар, хэлтсийн нэр, чиг үүрэг, албан хаагчдын албан тушаал, овог, нэр, утасны дугаарыг https://mcud.gov.mn/gov цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Өргөдөл гомдол хариуцсан албан хаагч нь цахимаар, утсаар, бичгээр ирүүлсэн иргэдийн өргөдөл гомдлыг тухай бүрт нь хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлэлтэнд хяналт тавин ажилладаг. Тайлант хугацаанд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх дэлгэрэнгүй тайланг ЗГХЭГ, АТГ-т тус тус хүргүүлсэн. Сайдын шуурхай бүрт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг яамны удирдлагуудад танилцуулдаг.</p> <p>Иргэдийн санал асуулгыг яамны цахим хуудасны өргөдөл, гомдол форумд өөрийн хаягийг бүртгүүлснээр өгөх мөн хариу авах</p>	100

	<p>байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>боломжийг бүрдүүлсэн. Мөн салбарын хуулийн төслийн санал асуулгыг тогтмол тухай бүр цахим хуудсанд байршуулан иргэдэд нээлттэйгээр санал хүсэлтийг авч ажиллаж байна. Бичиг хэргийн ажилтнууд иргэд, байгууллагын харилцах бичгийг тухай бүр хүлээн авч бүртгэлжүүлэн холбогдох албан тушаалтанд танилцуулж, бичгийн мэдээг 7 хоног тутам абле системд байршуулан, удирдлагад танилцуулж шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажилладаг.</p> <p>Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар нь үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн холбогдох мэдээллийг цахим хуудсандаа байршуулсан. http://www.gazar.gov.mn/transparency/cat-1/ http://www.gazar.gov.mn/contact</p> <p>Барилгын хөгжлийн төв, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь мэдээллийн цахим хуудсандаа үйлчилгээ, захидал харилцаа, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний мэдээллийг байршуулдаг. Холбоос нь: http://barilga.gov.mn http://wsrc.mn/new/mn/introduction/contact</p>	
3.	<p>Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилж байгаа бөгөөд цахимаар шууд үйлчилгээ авах боломжийг ч бүрдүүлэн ажиллалаа.</p> <p>Үндэсний дата төвд яам болон харьяа агентлаг, байгууллагын дотоод удирдлагын "Эйбл" системийн серверийг байршуулж, дотоод удирдлагын "Эйбл" системийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Системд msud.able.mn хаягаар хандах эрхийг авч, системийн тохируулга, хөгжүүлэлтийг хийж байна. Мөн уг системд тоон гарын үсгийг ашиглах системийн хөгжүүлэлтийг хийж дууссан. Салбарт хэрэгжүүлж буй төслүүдийн зохицуулагч болон захиргааны ажилтнуудыг "Эйбл" системд оруулсан. "Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн систем"-ийн хөгжүүлэлт болон шинэчлэлийн ажилд холбогдох саналуудыг өгч, Барилгын салбарын ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн судалгааг цахимжуулах талаар бэлтгэл ажлыг хангаж холбогдох саналыг өгч ажиллаж байна.</p> <p>Төрийн архивын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон Архивын ерөнхий газрын даргын "Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2019 оны А/127 дугаар тушаалыг вэб хуудсандаа нийтэлсэн.</p> <p>Барилгын хөгжлийн төв нь цахим хуудасныхаа бүтээгдэхүүн, үйлчилгээ хэсэгт Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг байршуулсан.</p> <p>Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь 2019 оны байдлаар 17 удаа цахим хуудас мэдээллийн самбартаа шинэчлэл хийж ажилласан. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой шаардагдах баримт бичгийн жагсаалт болон бүрдүүлэх материалын маягыг байгууллагын цахим хуудсанд дараах байдлаар оруулсан байна. Үүнд: http://wsrc.mn/new/mn/license-documents, мөн тарифын санал хүлээн авахад шаардлагатай бичиг баримтын жагсаалт болон бүрдүүлэх материалын маягыг байгууллагын цахим хуудсанд дараах байдлаар оруулсан. Үүнд: http://wsrc.mn/new/mn/economic-and-financial-forms</p>	100

4.	<p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн нэгдсэн судалгааг гаргаж, яамны веб сайт, able системд байршуулсан. Салбарын хэмжээнд батлагдсан хэрэгжиж байгаа 132 захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн бүртгэлийг хөтөлж, ХЗДХЯаманд хүргүүлж, “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлд тухай бүр нь хэвлүүлсэн. Тайлант хугацаанд Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар 9 төрлийн захиргааны хэмжээний актыг батлуулж, хууль зүйн нэгдсэн санд бүртгүүлж, www.legalinfo.mn цахим хуудаст байршуулсан. Яамны http://www.mcud.gov.mn -цахим хуудсын Эрх зүйн баримт бичиг талбарт салбарын 12 хууль, УИХ-ын 1 тогтоол, Засгийн газрын 17 тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 51 тушаалыг байршуулсан.</p> <p>Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар нь үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомжуудыг ангилан 7 хэсэг болгон цахим хуудсандаа байршуулсан. http://www.gazar.gov.mn Салбарын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актыг батлагдсан даруйд нь мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн.2019 онд мэдээллийн самбарт нийт 57 дүрэм журам, зааврыг байрлуулж нийтэд мэдээлсэн.</p> <p>Барилгын хөгжлийн төв нь “Барилгын төсөв зохиох дүрэм”, Барилга, хот байгуулалтын сайдын тушаал, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, норм дүрмүүдийг мэдээллийн самбартаа байршуулан ажилладаг.</p>	100
5.	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;</p>	<p>Тус яам боловсруулж байгаа дараах хууль тогтоомжийн төсөлд иргэд, олон нийт, бусад байгууллагаас санал авахаар цахим хуудасны хэлэлцүүлэг хэсэгт байршуулсан.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /2019.04.01-2019.07.06/; 2. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /2019.07.05-2019.08.06/; 3. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл/2019.10.15-2019.11.18/; 4. Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг хуулийн этгээдэд олгох, тэдгээрт хяналт тавих журмын төсөл; 5. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын төсөл; 6. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. <p>Дараах ЗГ-ын тогтоол, шийдвэрийг боловсруулж, батлуулсан бөгөөд https://mcud.gov.mn/ld?typeId=7 цахим хаягт тухай бүр бүр байршуулан иргэд, байгууллагаас санал авч ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө -Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 29 дүгээр тогтоол 2. Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө -Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 30 дугаар тогтоол 3. Төрөөс барилгын салбарын талаар төрөөс баримтлах бодлого -Засгийн газрын 2019.02.13-ны өдрийн 70 дугаар тогтоол 4. Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам -Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 105 дугаар тогтоол 5. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо -Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 106 дугаар тогтоол 6. Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаад улсын барилгын норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам -Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 107 дугаар тогтоол 	100

		<p>7. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм -Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 108 дугаар тогтоол</p> <p>8. Иргэнд 2019 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай -Засгийн газрын 2019.03.27-ны өдрийн 119 дүгээр тогтоол</p> <p>9. Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам батлах тухай -Засгийн газрын 2019.4.10-ны өдрийн 138 дугаар тогтоол</p> <p>10. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах үүрэг бүхий Үндэсний хорооны дүрэм батлах тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 155 дугаар захирамж</p> <p>11. Газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах, авах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай -Засгийн газрын 2019.4.17-ны өдрийн 155 дугаар тогтоол</p> <p>12. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай -Засгийн газрын 2019.5.01-ний өдрийн 174 дүгээр тогтоол</p> <p>13. 150 мянган айл-Орон сууц хөтөлбөр -Засгийн газрын 2019.5.22-ны өдрийн 202 дугаар тогтоол</p> <p>14. “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд баригдсан байгууламжуудын талаар авах зарим арга хэмжээний тухай -Засгийн газрын 2019.5.29-ний өдрийн 206 дугаар тогтоол</p> <p>15. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай -Засгийн газрын 2019.5.29-ний өдрийн 212 дугаар тогтоол</p> <p>16. Түрээсийн орон сууцны талаар авах зарим арга хэмжээний тухай -Засгийн газрын 2019.6.05-ны өдрийн 223 дугаар тогтоол</p> <p>17. Нийслэлд 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай Засгийн газрын 2019.6.28-ны өдрийн 264 дүгээр тогтоол</p> <p>18. Төв, суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай -Засгийн газрын 2019.7.03-ны өдрийн 270 дугаар тогтоол</p> <p>19. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай -Засгийн газрын 2019.9.18-ны өдрийн 357 дугаар тогтоол</p> <p>20. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам – Засгийн газрын 2019.8.14-ний өдрийн 325 дугаар тогтоол</p> <p>21. Тогтоолд өөрчлөлт оруулах, тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай – Засгийн газрын 2019.10.02-ны өдрийн 368 дугаар тогтоол</p> <p>22. Хөрөнгө гаргах тухай /Майдар хот төсөл/ – Засгийн газрын 2019.10.30-ны өдрийн 390 дугаар тогтоол</p> <p>Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн дагуу хууль тогтоомжийн төсөл, сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлах норм, дүрэм, журмын төслийг тухай бүр нь яамны цахим хуудас болон Барилгын хөгжлийн төвийн http://www.barilga.gov.mn цахим хуудаст байршуулж, цахим хэлэлцүүлгээр санал авч ажилласан.</p>	
6.	<p>Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p>	<p>Барилгын салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, сургалт эрхлэх чиг үүргийг барилгын салбарын түншлэлд гэрээгээр гүйцэтгүүлэхээр Монголын Барилгачдын нэгдсэн холбоо, Монголын Архитекторуудын Эвлэл зэрэг байгууллагуудтай гэрээг жил бүр сунгаж ажиллаж байна. Эдгээр байгууллагуудын гэрээний үүргийн биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэн, зөвлөгөө өгч ажиллав. Гэрээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан.</p> <p>1.Тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> • Барилга байгууламж, ашиглалтын хүрээг салгаж МНААҮХолбоог түншлэлээр оролцуулж сургалт зохион байгуулсан. • Зарим сонгон суралцах багц цагийн хичээлүүдийг цахим болгосон. 	100

	<ul style="list-style-type: none"> • БНХолбоо болон түншлэгч ТББ-уудын хооронд зар сурталчилгаа явуулах, вэб хуудсанд холбоос үүсгэн мэдээлэл солилцох болсноор хамтын ажиллагаа идэвхжсэн. <p>2.Сургалтын чанар ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> • Багш нарын судалгаа гаргаж цаашид мэргэшүүлэх, сурган заах арга зүйн чадавхжуулах сургалтыг хийхээр төлөвлөж бэлтгэл хангаж байна. • Сургалтын явцад сэтгэл ханамжийн судалгаа авах замаар сургалтын чанарт хяналт тавьж байна. • Сургалт хариуцсан менежерүүдтэй болж, үйл ажиллагаа өргөжиж, чадавхижсанаар түншлэгч холбоодуудын сургалт өргөжсөн. <p>3.Мэргэшлийн зэрэг олгох ажлыг боловсронгуй болгох чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> • Шалгалтын комисс шинэчилэгдэж байна. • Шалгалтын тест шинэчилэгдэж, эмхэтгэл ном болгон нийтэд хүртээмжтэй болголоо. • Дүрэм журмаа сайтар сурталчилсаны үр дүнд ойлголцлын зөрүү багассан. <p>Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн хурлыг 3 удаа хуралдуулж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулж, тайлан болон бусад асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлүүлээ.</p> <p>Сургалтын хөтөлбөрийн дагуу 2019 онд мэргэжлийн 56 хүрээний сургалт төлөвлөгдсөнөөс 6 хүрээнд сургалт зохион байгуулагдаагүй бөгөөд сургалтын хөтөлбөр төлөвлөгөө 98% биелэлттэй байсан.</p> <ul style="list-style-type: none"> • Шалгалтын комисс томилох тухай тушаалыг 3 удаа, мэргэшлийн зэрэг олгох сунгах тухай тушаалыг 4 удаа гаргуулав. • 2019 онд 156 удаагийн сургалт зохион байгуулж, 2868 хүн хамрууллаа. • Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтыг 3 удаа зохион байгуулж, 1168 хүн хамрагдаж, 1195 хүн тэнцлээ. • Сургалт болон шалгалтанд хамрагдсан мэргэжилтний материалаар нэгдсэн бүртгэл мэдээлийн санг баяжуулж, архивын нэгж болгон хадгалах үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж байна. • Сургалт эрхлэгч байгууллагуудын сургалтын явцад сэтгэл ханамжийн судалгаа хийж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, сургалтын тайланг хүлээн авч ажилласан. • Мэргэшлийн хоёр хүрээнд гарсан өргөдөл гомдлыг ажлын албаны хүрээнд шийдвэрлэсэн. <p>Газрын төлбөрийн тухай хуульд 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж батлагдсантай холбоотойгоор газрын төлбөр, татварын асуудлыг Татварын ерөнхий газар болон ГЗБГЗЗГ хооронд дундын мэдээллийн сан байгуулан мэдээллээ харилцан солилцох замаар шийдвэрлэхээр болсон. Өөрөөр хэлбэл ГЗБГЗЗГ-аас газрын төлбөр, татварын ногдуулалтыг Газрын төлбөр, татварын системээр ногдуулж Татварын удирлагын нэгдсэн системд илгээх бөгөөд энэхүү системээс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэхэмжлэл илгээх, нэхэмжлэлийн дагуу төлөгдсөн төлбөр буцаад тус системд бүртгэгдэж байна. Ингэснээр байрлалд суурилсан төлбөр, татварын тогтолцоо байгуулж, нэг талаас иргэд, олон нийтэд хүрч буй үйлчилгээ шуурхай явагдах, нөгөө талаас улсын төсвийн орлогын биелэлтийг хангахад чухал ач холбогдолтой ажил болсон. Дээр дурдсан газрын үнэлгээтэй холбоотой бүх мэдээллүүдийг иргэд, олон нийт http://www.egazar.gov.mn хаягаас харах мөн төрийн үйлчилгээний танилт нэвтрэлтийн ДАН системээр нэвтрэн өөрийн газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийн дэлгэрэнгүй мэдээллийг харах, эргээд төрийн</p>	
--	--	--

		<p>үйлчилгээ үзүүлж буй байдалд хяналт тавих боломжийг бүрдүүлж чадлаа. 2019 оныг Иргэн төвтэй, ил тод, ухаалаг, газрын харилцааны жил болгон зарласантай холбогдуулан хийгдсэн газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим мэдээллийн сан, газрын үнэлгээний систем, газрын бирж, кадастрын нэгдсэн мэдээллийн сан, газрын мониторингийн сүлжээг нэгтгэн газрын удирдлагын систем байгуулсан. Үүнийг 2020 онд 21 аймагт хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Цахим системийг хөгжүүлэхтэй холбоотойгоор 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө хууль эрх зүйн орчныг сайжруулах, шаардлагатай журам, заавар, норм, дүрэм, стандартыг боловсруулах зэрэг томоохон ажлуудыг тусгасан.</p> <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн системийн геопортал geoportals.gov.mn хуудасны Webappbuilder платформыг ашиглан орон зайн өгөгдлүүдийг олон нийтэд гаргах, гаргасан өгөгдлөөс засаг захиргааны хил болон бусад орон зайн давхаргаар хайлт шүүлт хийж, хэвлэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Геопорталын Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем нь ArcGIS сервер (ArcGIS server manager), өгөгдлийн сан (ArcGIS Datastore), Веб газрын зургийн (Enterprise site) гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэн ажиллаж байгаа бөгөөд ArcGIS серверт орон зайн өгөгдлийн суурь 16 төрлийн мэдээлэл, дэд ангиллууд агуулагдаж байна. 16 давхаргад агуулагдах мэдээллийг веб үйлчилгээнд гаргаж, суурь давхаргуудын мэдээллийг хянах, удирдах, тайлан гаргах системийг хөгжүүлсэн.</p> <p>Байрлалд суурилсан орон зайн мэдээллийн 14 үндсэн агуулгаар төрөл бүрийн үйлчилгээ цахимаар түгээж эхэлсэн. Нийт 16 суурь орон зайн мэдээллийн ангилал, тодорхойлолт, дүрст тэмдэглэгээг боловсруулсан. Эдгээр суурь орон зайн мэдээллийг нээлттэйгээр албан ёсоор хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Хууль эрх зүйн орчныг сайжруулахаар Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн үзэл баримтлалыг ХЗДХ-ийн сайдтай хамтран баталж хуулийн төслийг боловсруулж байна.</p>	
7.	<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;</p>	<p>“Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 01-ний 20 дугаар тушаалаар барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг барилгын салбарын төрийн бус, мэргэжлийн байгууллагууд/12/-ын түншлэлийг төлөөлж “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-аар гэрээний үндсэн дээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх 2019/31 тоот гэрээг “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-тай, архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалт эрхлэх чиг үүргийг гүйцэтгүүлэх 2019/28 тоот гэрээг “Монголын Архитекторуудын Эвлэл” ТББ-тай 2019.02.02-ны өдөр тус тус байгуулсан.mncud.gov.mn, https://tz.mncud.gov.mn/, http://mnca.mn хаягаар орж мэдээллийг авах боломжтой юм. Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлж байгаад хөндлөнгийн хяналт хийхээр АТГ-ын УССГХ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан бие даасан судалгааны байгууллага болох Жи Би Эм Сошиал ресерч консалтинг ХХК-д шаардлагатай мэдээлэл судалгааг 2019 оны жилийн эцсийн байдлаар гаргаж өгсөн. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар нь геодезийн хэмжлийн багаж хэрэгслийг шалгах, баталгаажуулах чиг үүргийг Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулаад байна.</p>	100

8.	<p>Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан чиг үүргийг мөн хуулийн 18.4-т заасны дагуу төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай” гэрээг Монголын барилгачдын үндэсний ассоциаци ТББ-тай 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр анх байгуулсан.</p> <p>Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02-р сарын 01-ний 21 дүгээр тушаалаар “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн.</p> <p>Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг гэрээгээр шилжүүлэн авч хэрэгжүүлж байгаа дээрх байгууллагууд нь тус бүрийн цахим хуудсаар зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг мэдээлдэг бөгөөд энэ талаарх дэлгэрэнгүй судалгаа, тайланг тус яам авч ажилласан. 2019 оны жилийн эцсийн байдлаар олгосон тусгай зөвшөөрлийн тоо:</p> <table border="1" data-bbox="719 701 1317 903"> <thead> <tr> <th rowspan="2">Нэр</th> <th colspan="2">2019</th> </tr> <tr> <th>шинэ</th> <th>сунгалт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Тусгай зөвшөөрлийн ангилал</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Өргөх байгууламж</td> <td>36</td> <td>15</td> </tr> <tr> <td>Зураг төсөл</td> <td>61</td> <td>50</td> </tr> <tr> <td>Барилга угсралт</td> <td>610</td> <td>297</td> </tr> </tbody> </table> <p>Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр</p> <table border="1" data-bbox="719 982 1317 1260"> <thead> <tr> <th rowspan="2">он</th> <th colspan="2">2019</th> </tr> <tr> <th>Нийт олгосон</th> <th>МБМҮХ 2019,04,16-аас хойш</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>тусгай зөвшөөрөл олгосон</td> <td>84</td> <td>77</td> </tr> <tr> <td>Үүнээс: сунгасан</td> <td>39</td> <td>-</td> </tr> <tr> <td>Улсын тэмдэгтийн хураамжийн дүн, мян.төгрөг</td> <td></td> <td>7700</td> </tr> </tbody> </table> <p>Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар нь геодези зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 227 аж ахуйн нэгжийн эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааны мэдээллийг байгууллагын http://www.gazar.gov.mn цахим хуудсанд байршуулсан.</p>	Нэр	2019		шинэ	сунгалт	Тусгай зөвшөөрлийн ангилал			Өргөх байгууламж	36	15	Зураг төсөл	61	50	Барилга угсралт	610	297	он	2019		Нийт олгосон	МБМҮХ 2019,04,16-аас хойш	тусгай зөвшөөрөл олгосон	84	77	Үүнээс: сунгасан	39	-	Улсын тэмдэгтийн хураамжийн дүн, мян.төгрөг		7700	100
Нэр	2019																																	
	шинэ	сунгалт																																
Тусгай зөвшөөрлийн ангилал																																		
Өргөх байгууламж	36	15																																
Зураг төсөл	61	50																																
Барилга угсралт	610	297																																
он	2019																																	
	Нийт олгосон	МБМҮХ 2019,04,16-аас хойш																																
тусгай зөвшөөрөл олгосон	84	77																																
Үүнээс: сунгасан	39	-																																
Улсын тэмдэгтийн хураамжийн дүн, мян.төгрөг		7700																																
9.	<p>Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Салбарын хэмжээнд гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц байдлын талаар улирал бүр тайлан авч, нэгтгэн УИХ-ын ЭЗБХ-нд албан тоотоор хүргүүлдэг. Мөн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Сангийн яам болон ЗГХЭГ-т хүргүүлдэг. Яамны вэб сайтад https://mcud.gov.mn хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг байршуулдаг.</p>	100																															
Хэсгийн дундаж хувь:			100																															

Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд нийтэд зарлах, Төрийн албаны зөвлөлд мэдээлэх ажлыг тухай бүр хэрэгжүүлж байна. Сул болон эзгүй орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл болон бусад холбогдох зүйл, заалтын дагуу ажлын зайлшгүй шаардлагын үндсэн дээр сэлгэн ажиллуулах, шилжүүлэх, нөөцөд байгаа албан хаагчдаас сонгон шалгаруулах, түр орлон гүйцэтгүүлэх зэрэг хэлбэрээр хуулийн хүрээнд албан хаагчийг томилон, ажил үүргийг нь гүйцэтгүүлэх арга хэмжээг авч байна. Сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн http://www.csc.gov.mn/s/35/38 цахим хаягт байршуулж, мөн Барилга, хот байгуулалтын яамны https://mcud.gov.mn/p/137 цахим хаягт байршуулан ажилласан.	100
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, Зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн А/104 дүгээр тушаалаар батлуулсан. Зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан хуралдаанаар тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/26 дугаар тушаалаар батлагдсан үнэлгээний хорооны гишүүн Санхүүгийн хэлтсийн дарга Д.Баярсайхан, Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Э.Бат-Эрдэнэ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Л.Лувсан, Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч М.Батбаатар, Монголын Барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга Ц.Батцогт, нарийн бичгийн дарга Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Э.Батболд нарын "Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн барилга"-ын гүйцэтгэчийг сонгон шалгаруулахдаа гаргасан зөрчлийн талаар хэлэлцэн шийдвэр гаргасан. Зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг БХБЯ-ны дотоод сүлжээ, https://mcud.gov.mn вэбсайтад байршуулсан.	100
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль, хуулийг дагалдан гарсан дүрэм, журмын дагуу одоо ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, сул орон тоог яам дотор болон харьяа байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас шатлан дэвшүүлэх эсхүл нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас нөхөх бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг https://mcud.gov.mn/p/61 цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар яамны https://mcud.gov.mn/p/64 цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулан баяжилтыг тухай бүр хийж байна.	100
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч	Яамны төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг 2019 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар үнэлж, Төрийн нарийн бичгийн даргын 2019/6/27-ны өдрийн Б/58 дугаар тушаалаар 68 албан хаагчдад, 2019/12/23-ны өдрийн А/165	100

	<p>хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;</p>	<p>дугаар тушаалаар 64 албан хаагчдад "Урамшуулал олгох" асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Яамны албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор "Эрүүл агаар-эм" сэдэвт аялалыг Монголын Барилагчдын өдрийг тохиолдуулан 2019 оны 9 дүгээр сард зохион байгуулсан.</p> <p>БХБ-ын сайдын нэрэмжит 5 төрөлт спортын тэмцээнийг яам болон харьяа байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулсан.</p> <p>Газрын харилцааны албан хаагчдын өдөрт зориулсан болон Barilga.mn сэтгүүлийн нэрэмжит спортын тэмцээнд яамны баг тамирчдыг оролцуулсан.</p> <p>Засгийн газрын цом -2019" тэмцээнд Засгийн газрын цом-2019 тэмцээнд оролцох баг тамирчид бэлтгэл хийхэд дэмжлэг үзүүлэн, сагсан бөмбөгийн эмэгтэй, эрэгтэй багийн төрөлд "мөнгөн медаль" хүртсэн албан хаагчдад ТНБД-ын 2019 оны А/79 дүгээр тушаалаар нэг сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгов.</p> <p>https://mcud.gov.mn, barilga.mn, яамны пэйж хуудаст байршуулан олон нийтэд мэдээлж, мэдээллийг байнга шинэчилж баяжуулан ажилласан.</p>	
Хэсгийн дундаж хувь:		100	
Хэрэгжилтийн дундаж хувь:		100	

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**
/2019 оны жилийн эцсийн байдлаар/

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн дагуу Төрийн байгууллагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын яамны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Барилга, хот байгуулалтын яамны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

Барилга, хот байгуулалтын яамны бүтцийн нэгжүүдийн гаргасан мэдээлэл, арга хэмжээний биелэлтийг үндэслэл болгон хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан гүйцэтгэлийн түвшинг үнэлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

ГУРАВ. ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийн бодлогын ил тод байдал зэргийг илтгэх нийт 14 арга хэмжээ 100 хувийн биелэлттэй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Барилга, хот байгуулалтын яамны ил тод, нээлттэй байдлыг шалгуур үзүүлэлт, заалт бүрээр тогтмол хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудасны мэдээ, мэдээллийн шинэчлэлийг тогтмол хийж, баяжуулж байх;
2. 2019 онд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлоос хамгийн их хувийг эзэлж байгаа асуудлуудаар тодорхой арга хэмжээг авч ажиллах. */Тус яаманд тайлант хугацаанд нийт*

4887 өргөдөл ирүүлсэнээс хүсэлт-843, гомдол-144, санал-3900 ирүүлсэн. Агуулгаар нь авч үзвэл ипотекийн зээлд хамрагдах, орон сууцанд ороход дэмжлэг үзүүлэх, түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй-3455 буюу 70,7%, орон сууцны ашиглалт, нийтийн аж ахуйн асуудлаар 310 буюу 6,3%, гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудлаар 280 буюу 5,7% байна./

3. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсанд мэдээлж байх шаардлагатай байна.

4. Тусгай зөвшөөрөл олгох, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлсэнтэй холбоотойгоор эрх шилжүүлж авсан байгууллагын гэрээний хэрэгжилтийг дүгнэхээс гадна бодлогын дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээ, судалгаа, статистикийг асуудал хариуцсан мэргэжилтэн бүр тогтмол авч хэвших нь зүйтэй.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**10.5 Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/,
хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан**

**“ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Төслийн агуулга		Гүйцэтгэл	
1.	“Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр” 2009 оны 157 дугаар тогтоол		Монгол орны нутаг дэвсгэрт учирч болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хүчтэй газар хөдлөлтийн голомт бүхий бүс нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах, ашиглагдаж байгаа зарим барилга, байгууламжийн хийц, бүтээцийг хүчитгэх замаар эвдрэл, нуралтаас үүсэх хохирлыг багасгах, орон сууц, олон нийт, иргэн болон үйлдвэрийн барилга, зам гүүр, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлыг хангаж, байгалийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино.	
2.	Санхүүжилтийн эх үүсвэр		Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сангийн яам, Гадаадын зээл тусламжийн байгууллагууд.	
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	2009 – 2014, 2015 - 2020 он Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам		
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Эрүүл мэндийн яам; Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам; Сангийн яам; Онцгой байдлын ерөнхий газар; Аймаг, нийслэлийн Засаг дарга нар.		
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Хөтөлбөрийн зорилтууд: Зорилт 1. Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх; Зорилт 2. Газар хөдлөлтийн аюулын үнэлгээ хийж, ерөнхий болон бичил мужлалын зураг зохиох, газар хөдлөлт бүртгэх станцын сүлжээг өргөтгөх; Зорилт 3. Хот суурин болон бүс нутгийн эрсдэлийн үнэлгээг хийх; Зорилт 4. Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах.	
5.	Зардал	Төсөв /Нийт шаардагдах зардал/	1 тэрбум төгрөг	
		Тухайн жилд төсөвлөсөн	-	
		Гүйцэтгэл /Тухайн жилд/	-	
		Үүнд:	Төсөв: 1,901,485,148 төгрөг /Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар/	Гүйцэтгэл: Гэрээт ажлын хоёрдугаар шатны тайланг хүлээн авсан.

	“Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгаа”-ны ажил			
	Санхүүгийн талаар	2020 оны төсвийн тухай хуулинд “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрийн газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил”, барилга байгууламжийн паспортжуулах ажил, ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй барилга байгууламжийн буулгаж шинээр барихад шаардагдах төсвийн саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч хасагдаж батлагдсан болно.		
6.	Төслийн зорилтууд:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.		
1 дүгээр зорилтын хүрээнд: Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх				
	1.1. Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх /2009-2014 он /Хэрэгжилт 70% /	<p>Монгол Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоол, Засгийн газрын 157 дугаар тогтоол “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн Байнгын хорооны 2018 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хамтарсан 05/13 дугаар тогтоол, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/467 тоот албан бичгийг хүргүүлэн хэрэгжилтийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргуулж холбогдох байгууллагуудад цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Барилга, хот байгуулалтын яам/</i></p> <p>Нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл 2019 онд 3 удаа хуралдаж газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлаа хэлэлцэн мөн зөвлөлийн 2019 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлд 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 02-01/5600 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/НЗДТГ/</i></p> <p>Орхон аймагт 2019 оны 08 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газар, Нэгдсэн үндэсний байгууллагатай хамтран “Аюулгүй, гамшигт тэсвэртэй, тогтвортой хөгжилтэй хотыг бий болгох нь” сэдэвт сургалт зохион байгуулж уг сургалтад Архангай, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан, Сүхбаатар, Хэнтий, Дорнод гэсэн 8 аймгийн ОБГ, аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтэн, алба хаагчид оролцсон. Уг сургалтаар гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа болон Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээнд “Аюулгүй, гамшигт тэсвэртэй, тогтвортой хөгжилтэй хотыг бий болгох нь” санал санаачлага, орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааны арга хэрэгсэл зэрэг сэдвээр илтгэл тавьж, орон нутгийн эрсдэлийг үнэлж төлөвлөгөө боловсруулан дадлага ажил хийж, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцүүлгийг 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулан ажилласан байна.</p>		

/Булган аймаг/

Аймгийн Засаг даргын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн А/115 дугаар захирамж, Онцгой байдлын газрын даргын 04 дүгээр сарын 11-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Улаан загалмайн хороотой хамтран 4 дүгээр сарын 12-ноос 15-ны өдрүүдэд Баян-уул сумд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Жаргалан, Тайшир сумдад Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг, 5 дугаар сарын 18-24-ний өдрүүдэд Дэлгэр сумын Гуулин тосгонд гамшгаас хамгаалах иж бүрэн, Цогт, Чандмань сумдад команд штабын сургууль, Дэлгэр, Эрдэнэ, Бигэр сумдад Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг, 6 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд Дарив суманд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, бусад сумдад бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулсан байна. Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль, Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт сумдын онцгой комисс, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн нийт 1206 хүнийг хамруулан мэргэжил арга зүйн зөвлөмж чиглэл өгсөн байна. Дээрх сумдын Засаг даргын захирамжаар 5-15 хүний бүрэлдэхүүнтэй гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, 8-10 хүний бүрэлдэхүүнтэй гал унтраах сайн дурын хэсгийг тус тус байгуулж, тэдгээрийн ажиллах журам, эрүүл мэндийн анхны шатны тусламжийн чиглэлээр сургалтыг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан байна.

/Говь-Алтай аймаг/

Барилга, хот байгуулалтын яам, JICA олон улсын байгууллагатай хамтран 2018 оны 6 дугаар сарын 4-7-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ”, “Инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн хохирлын үнэлгээ” сэдэвт сургалтад орон нутгаас 2 албан хаагч хамрагдсан байна. Мөн Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, JICA олон улсын байгууллага хамтран 11 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулсан “Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээнд ашиглагдах багаж” сэдэвт танилцуулга сургалтад 1 албан хаагч хамрагдсан байна.

/Говьсүмбэр аймаг/

Дорноговь аймгийн Засаг даргын 2017 оны А/161 тоот захирамжаар “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийг байгуулсан. Тус зөвлөл нь газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлагнах, гамшгийн аюулын бэлэн байдлыг хангахад мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг чиглэлээр ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан үйл ажиллагааны гэрээнд тусгагдсан “Говийн чоно-2019” гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургуулийн үеэр Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн түвшинд удирдлага зохион байгуулалтаар хангах, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн харилцан ажиллагааг уялдуулах зорилгоор техникийн болон онолын 21 төрлийн сургалт, туршлага солилцох үйл ажиллагааг нийт 448 цаг буюу 14 хоногийн турш тасралтгүй зохион байгуулахад давхардсан тоогоор 984 хүн хамрагдсан байна.

Дээрх үйл ажиллагааны гэрээ, аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Онцгой байдлын газрын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Говийн чоно-2019” гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургууль болон Гамшгаас хамгаалах Иж бүрэн, Команд штабын сургуулийг Замын-Үүд, Сайншанд, Айраг, Даланжаргалан, Эрдэнэ сумдад зохион байгуулахад газар хөдлөлтийн гамшгийн үед иргэдийн нүүн шилжих үйл ажиллагаанд нийт 40059 иргэн хамрагдаж болзошгүй гамшгийн үед аюулгүй талбайд нүүн шилжих дадлагыг эзэмшсэн байна.

/Дорноговь аймаг/

НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах үйл ажиллагааг дэмжих замаар хот суурин газрын тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот” хөтөлбөрийг Дэлхийн боловсролын төвтэй хамтран хэрэгжүүлж эхэлсэн. 2018 онд Дорнод аймаг тус хөтөлбөрт нэгдэж, батламжаа гардаж авсан байна. Онцгой байдлын ерөнхий газар, НҮБ-ын Улаанбаатар хотноо 2018 оны 12-р сарын 3-5-ны өдрүүдэд зохион байгуулсан “Аюулгүй, гамшигт тэсвэртэй, тогтвортой хөгжилтэй хот бий болгох нь” сэдэвт туршлага солилцох сургалтад Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Хэрлэн сумын ЗДТГ-ын алба хаагчдыг оролцуулсан байна.

/Дорнод аймаг/

Ерөнхий боловсролын сургуулиудад Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг таниулах өдөр, Гамшгийн аюулын Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг зохион байгуулах зорилгоор “Сургуулийн аюулгүй байдал” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудад гал түймрийн улсын хяналтыг зохион байгуулж, багш ажилчдад байгууллагын галын аюулгүй байдал, хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар танхимын сургалт, 1-2 дугаар ангийн сурагчдад аюулгүй амьдрах ухааны мэдлэг олгох үлгэрчилсэн сургалт, 9-11 дүгээр ангийн сурагчдад “Гал түймэр гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт”, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, гал түймрийн тархалтын сургуулиудыг 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулан ажилласан байна. Нэгдсэн арга хэмжээнд нийт 5 сургуулийн 1923 багш, хүүхэд, ажилчид оролцсон байна.

/Дундговь аймаг/

2014 онд Дэлхийн зөн Монгол ОУБ-ын “Завхан” ОНХХ-тэй хамтран 10 дугаар сарын 13-ны өдөр Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг “Өндөр настай иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг, чадварыг дээшлүүлэх нь” уриатайгаар Улиастай сумын “Товчо”, “Чигэстэй”, “Өлзийт”, “Жаргалант”, “Жинст”, “Богдын гол” гэсэн 6 багийн 80 гаруй өндөр настаныг хамруулан арга хэмжээг зохион байгуулсан байна.

2015 онд “Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Завханхангай ОНХХ”-тэй хамтран 2015 оны 1 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд аймгийн ерөнхий боловсролын 24 сургуулийн нийгмийн ажилтан албан хаагчдад сургалтыг амжилттай зохион байгуулсан. Мөн сургуулийн гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг хийж, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. 2019 онд Улиастай сумын Богдын гол багийн Политехник коллежийн оюутан сурагчдад болон ажилчдад объекын гал түймэр, газар хөдлөлтийн үед өөрийгөө аврах бусдад үзүүлэх анхны тусламж гал унтраагуур ашиглалт “Тактикийн сургуулийн” үйл явцыг ажлын зураг дээр тайлбарлаж дадлагажуулах сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 41 багш 312 оюутан нийт 415 хүн хамрагдсан. Мөн Засгийн газрын 339,340 тогтоолын талаар мэдээлэл хийж үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 08 тоот “Хүн нэг бүрийн үүргэвчинд байх зүйл”-ийг танилцуулан ард иргэдийг дуут дохио 3 удаа дуугарахад багийн цугларах талбайд үүргэвчтэй цугларах талаар сургалт сурталчилгаа зохион байгуулж нийт 1400 гаруй хүн хамрагдсан байна.

/Завхан аймаг/

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн орон сууцны болон эрүүл мэнд боловсролын нийт 71 барилга байгууламж байгаагаас 1970 оноос өмнө баригдсан газар хөдлөлтөд тооцож төлөвлөөгүй нийт 17 барилгад хөндлөнгийн мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргуулсан. Сэлэнгэ аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн орон сууцны болон эрүүл мэнд боловсролын нийт 295 барилга байгууламж

		<p>байгаагаас 1970 оноос өмнө баригдсан газар хөдлөлтөд тооцож төлөвлөөгүй нийт 58 барилгад хөндлөнгийн мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргуулсан байна. Дээрх барилгуудыг хүчитгэх хүсэлтийг Эрүүл мэндийн яам болон Барилгын хөгжлийн төвд эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж хүргүүлсэн байна. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 47 барилга ашиглагдаж байгаа бөгөөд тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээллийг судалгаагаар гаргаж хүргүүлсэн байна. Газрын даргын баталсан тушаалын хүрээнд 15 сумын төр, төсвийн байгууллагуудын барилга байгууламжийн ашиглалт болон насжилт тухайн барилгад гарсан эвдрэл гэмтлийн талаарх судалгааг авч ажилласан байна. 2019 онд 15 сумын 62 барилга байгууламжид үзлэг шалгалт хийснээс ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга байгууламж 2 байна.</p> <p style="text-align: right;"><i>/Сэлэнгэ аймаг/</i></p> <p>"Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх зорилгоор Төв аймагт байнгын ажиллагаатай зөвлөлийг аймгийн Засаг даргын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А/38 тоот захирамжаар байгуулж, зөвлөлийн ажиллах журам, зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан 4 зорилт, 27 арга хэмжээтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулалт 2019 оны 10 дүгээр 04-ний өдрийн 06 цаг 15 минутад дуут дохио дугарч, онцгой комисс, мэргэжлийн анги, салбар, цагдаа цэргийн бие бүрэлдэхүүн нь тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлын жагсаал, хувийн бэлтгэл байдлыг танилцуулсан. Мөн өдрийн 10.00 цагаас эхлэн эрэн хайх, аврах үзүүлэн сургуулалтад мэргэжлийн анги бүрэлдэхүүн, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй оролцож, үүрэг гүйцэтгэсэн байна.</p> <p>Газар хөдлөлтийн үед 24 цагийн байдлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сургуулалтад 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ажиллаж, 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Зуунмод хотын бүх нийтээр нүүн шилжих ажил зохион байгуулагдаж, 10900 иргэн хамрагдсан дүнтэй байна. Эрдэнэ суманд 1000 гаруй иргэнийг нүүлгэн шилжүүлэх ажил зохион байгуулагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Төв аймаг/</i></p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд "Дэлхийн зөн-Монгол", "Жайка" олон улсын байгууллага, Монголын улаан загалмайн нийгэмлэг хамтран санаачлаг "БЭЛЭН БАЙ" сургалтын багц "Хэн ч, Хэзээ ч, Хаана ч бэлэн" гамшгаас хамгаалах буухиа тэмцээний удирдамжийн дагуу хөтөлбөр төлөвлөгөөг 2019 онд боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Өмнөговь аймаг/</i></p> <p>Аймгийн Улаан загалмайн хороотой хамтран тус аймгийн Давст, Хяргас, Малчин, Цагаанхайрхан, Өндөрхангай сумуудад гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулсан байна. Тус байгуулагдсан сайн дурын хэсгийн бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах зохион байгуулж, Хяргас, Өндөрхангай суманд байгуулагдсан сайн дурын хэсгийг Австралийн Улаан Загалмайн Нийгэмлэгийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд аймгийн Улаан загалмайн хороотой хамтран тус бүр 10.0 сая төгрөгийн багаж хэрэгслийг 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдөр хүлээлгэн өгсөн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Увс аймаг/</i></p> <p style="text-align: right;"><i>/Хэрэгжилт 70% /</i></p>
	<p>1.2. Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх авран хамгаалах чиглэлээр гадаад улсын зөвлөл, ижил чиг үүрэг бүхий зөвлөл,</p>	<p>Барилга, хот байгуулалтын яам, Онцгой байдлын ерөнхий газар, Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл"-тэй хамтран 2019 оны 3 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд "Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хүчитгэл хийх аргачлал" сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургалтад аймаг нийслэлийн</p>

<p>байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтын ажиллагааг тогтворжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгт элсэх, хамтарсан сургалт, семинар зохион байгуулахад туслалцаа үзүүлэх</p> <p>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>МХЕГ-ын байцаагчид, аймгуудын ГХБХБГ-ын мэргэжилтнүүд болон НЕТГ-ын мэргэжилтэн зэрэг 50 гаруй хүн хамрагдсан байна.</p> <p><i>/Барилга, хот байгуулалтын яам/</i></p> <p>Гадаад улс оронд зохион байгуулагдсан 67 удаагийн айлчлал, хурал, зөвлөгөөн, уулзалт, сургалт, семинар, үзэсгэлэнд Онцгой байдлын байгууллагаас давхардсан тоогоор нийт 257 алба хаагчийн оролцсон. Үүнээс газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр дараах бага хурал, дадлага сургууль зохион байгуулагдсан байна. Үүнд:</p> <p>Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газартай хамтран Нью Дели хотод зохион байгуулсан “Гамшигт тэсвэртэй дэд бүтэц” сэдэвт бага хуралд 2019 оны 03 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд 2 алба хаагч, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Шинэ Дэли хотод зохион байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны улсуудын “Газар хөдлөлтийн үед хот дотор эрэн хайх, аврах ажиллагаа” сэдэвт дадлага сургалтад 2019 оны 11 дүгээр сарын 4-8-ны өдрүүдэд 1 алба хаагч, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлгээс Тайландын Вант Улсын Засгийн газартай хамтран тус улсын Чиан Май хотод зохион байгуулсан “Олон Улсын Эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлгийн Ази, Номхон далайн бүсийн газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах дадлага сургууль”-д 2019 оны 12 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд 1 алба хаагч тус тус оролцсон байна.</p> <p><i>/Онцгой байдлын ерөнхий газар/</i></p> <p>Нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Гамшигт тэсвэртэй хотууд” төслийн нэгдүгээр үе шат 2016-2018 онд хэрэгжиж, 2019-2020 онд хэрэгжих төслийн 2 дугаар үе шатыг нийслэлийн 9 хороонд хэрэгжүүлэхээр 2018 оны 12 сард Хамтран ажиллах санамж бичиг байгуулсан байна. Төслийн хүрээнд “Эрсдэлгүй айл-Аюулгүй хөрш” аяныг 2019 оны 4-9 дүгээр сард зохион байгуулж, нийслэлийн 9 хорооны гамшгийн менежментийн багийн 154 хүнийг чадавхжуулах сургалтад хамруулан сургагч багшаар, 2019 оны 5 дугаар сард 9 хорооны 54 иргэнийг бэлэн бай модулийн сургагч багшаар тус тус бэлтгэж, нийт 9244 иргэнийг сургалтад хамруулж, болзошгүй гамшгийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг, чадвар олгоод байна.</p> <p><i>/НЗДТГ/</i></p> <p>Аймгийн Засаг даргын баталсан 2019 онд зохион байгуулах гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөөний дагуу Дэлхийн зөн, Мерси кор, Каритас Монгол олон улсын байгууллага, Японы хүүхдийг ивээх сан зэрэг олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран иргэдэд чиглэгдсэн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтыг энэ хугацаанд 9 удаа, 515 хүнд зохион байгуулсан байна.</p> <p><i>/Баян-Өлгий аймаг/</i></p> <p>Тус аймгийн Дэлхийн Зөн Баянхонгор-2 ОНХХ-тэй хамтран “Хүүхдэд чиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах” болзошгүй газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, дадлагыг тус аймгийн 7 сумын Ерөнхий боловсролын сургуулиудын нийт 372 багш, ажилчдад 2 ээлжээр зохион байгуулсан байна. Сургалтаар тухайн сум орон нутгийн цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулсан /Газар хөдлөлтийн гамшиг/ цагийн байдал үүсгэн ажиллуулж сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг туршин шалгах “Штабын дадлага” сургуулалтын хийлгэж болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдлэг ойлголт өгч, ур чадварыг дээшлүүлсэн байна. Дээрх сургалт дадлагын үр дүнд Дэлхийн Зөн Баянхонгор-2 ОНХХ-тэй хамтран “ЕБСургуулийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах” сургалт, дадлагыг тус аймгийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл бүхий 9 сумын Ерөнхий боловсролын сургуулиудын төлөөлөл болох нийт 58 багш, ажилтан, эцэг эхчүүд, 1299</p>
---	---

	<p>сурагчдад бүсчилэн зохион байгуулж сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх талаар тэдний оролцоонд тулгуурлан мэдлэг ойлголтыг дээшлүүлж чадавхжуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Баянхонгор аймаг/</i></p> <p>Аймгийн барилгын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг БХБЯ болон барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулсан. БД /22-105-18/ "Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал", БД /22-106-18/ "Цутгамал төмөр бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал" нормуудтай танилцах 2 удаагийн сургалтад 2019 оны 4 дүгээр сарын 17-19-ны өдрүүдэд хамруулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Булган аймаг/</i></p> <p>Америкийн нэгдсэн улсын Агаарын нисэх хүчний техникийн төвийн Говь-Алтай аймаг дахь газар хөдлөлтийн мэдээлэл бүрдүүлэх сүлжээ /10 станц/ станцын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж, мэдээлэл бүрдүүлэлт ба мэдээлэл дамжуулалтыг хэвийн 100%-тай гүйцэтгэсэн. Одон орон геофизикийн хүрээлэнгийн газар хөдлөл судлах секторын инженерүүд болон АФТАС-ын инженерүүдтэй хамтран ажилласан байна. Онцгой байдлын ерөнхий газар, Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Япон улсын сангийн санхүүжилтээр "Зуд, ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхийг бэхжүүлэх" төслийн хүрээнд тус аймагт 2019 оны 4 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд "Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн удирдлага" сургалтыг зохион байгуулж, тус сургалтад Шарга, Алтай, Дарви сумдын төслийн ажилтнууд, багийн Засаг дарга, иргэд, Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Өвөрхангай, Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтнүүд нийт 33 иргэд, алба хаагчид хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Говь-Алтай аймаг/</i></p> <p>Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 24-ны өдрийн А/213 тушаалаар Япон Улсын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-аас 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс 2019 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хооронд Япон улсын Хокайдо мужийн Токачи бүсийн төв Обихиро хотод зохион байгуулагдсан "Токачи өргөн хүрээний бүсийг хамарсан гал унтраах, яаралтай түргэн тусламж үзүүлэх сургалт"-нд Онцгой байдлын газраас 1 алба хаагч хамрагдсан байна. Аймгийн газар хөдлөлтийн үед үүсч болзошгүй хохирлын цагийн байдлыг боловсруулахын тулд газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ судалгаа хийсэн. "Экселийн томъёо бүхий хүснэгтийг ашиглан газар хөдлөлтийн хохирлын хялбарчилсан тооцоо хийх гарын авлага"-ын дагуу, Дархан-Уул аймгийн хувьд 2018-2019 онд ЖАЙКА-ын төсөл хэрэгжүүлсэн "Дархан-Уул аймгийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд хохирлыг тооцоолж гаргах дадлага, сургалтад хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дархан-Уул аймаг/</i></p> <p>Монгол Улсын Шадар сайд аймгийн Засаг даргатай байгуулсан үйл ажиллагааны гэрээнд тусгагдсан "Говийн чоно-2019" гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургуулийг аймгийн Засаг даргын 2019 оны А/312 дугаар захирамжийн дагуу Онцгой байдлын ерөнхий газар, Америкын нэгдсэн улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яам, Энэтхэг-Номхон далайн цэргийн командлал, Аляскын үндэсний гвардитай хамтран 2019 оны 9 дүгээр сарын 9-21-ний өдрүүдэд зохион байгуулсан байна. Дадлага сургуульд Монгол, Америкын нэгдсэн улсаас гадна Австрали, Канад, Франц, Непал, Турк, Их Британи, Бангладеш, Индонези, Казахстан, Киргизстан, Лаос, Балба, Шри-Ланка, Тайланд, Тажикистан, Вьетнам зэрэг</p>
--	---

		<p>21 улс орон, Нэгдсэн үндэстийн байгууллагын төрөлжсөн агентлагийн төлөөлөл, гамшгийн эрсдэлийн бууруулах чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагууд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Эрүүл мэндийн яам, Барилга хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Улаанбаатар төмөр зам, Автотээврийн үндэсний төв болоод Өмнөд Бүсийн төв Өмнөговь, Дорноговь, Зүүн бүсийн төв Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр аймгуудын Онцгой комисс, Онцгой байдлын газрууд, Үндэсний аврах бригад, Нийслэлийн Онцгой байдлын газар, Дотоодын хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын нийт 500 гаруй төлөөлөл оролцсон байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дорноговь аймаг/</i></p> <p>Аймгийн Засаг даргын 2017 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн А/74 Тоот захирамжаар Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийг 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Байнгын ажиллагаатай зөвлөл нь 2017-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган Аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. 2019 оны 6 дугаар сарын 15-21-ны өдрүүдэд Нийслэлийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг Аймгийн БАЗ-ийн үйл ажиллагаатай танилцаж заавар зөвлөгөө өгөхөөр ажиллав. Тус сургалт, зөвлөгөөнд Аймгийн ОБГ-ын дарга, Аймгийн ГХБХБГ-ийн дарга, Аймгийн МХГ-ийн дарга нар мэдээлэл хийв. Энэ үеэр Аймгийн БАЗ-ийн 3-р өргөтгөсөн хуралдаан болсон байна. Зөвлөгөөний үер ашиглалтын шаардлага хангахгүй орон сууц, олон нийтийн барилга байгууламжийг хүчитгэх, дахин төлөвлөх ажлыг зохион байгуулж ажиллах талаар шийдвэрлэсэн байна. 2018 онд Онцгой байдлын ерөнхий газар, Дэлхийн зөн ОУБ-ын Завханхангай ОНХ Хөтөлбөр, Жайяка Олон улсын байгууллагатай хамтарч Улиастай, Отгон сумдын 12 багийн 110 иргэнд "Бэлэн бай" сургалт, ХЭН Ч ХААНА Ч ХЭЗЭЭ Ч БЭЛЭН сургалт дадлагыг зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Завхан аймаг/</i></p> <p>Төлөвлөгөөний дагуу иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг, хандлага, чадвар олгох "Сайн дурын бүлэг"-ийн гишүүддээ "БЭЛЭН БАЙ" багц сургалтыг 2019 оны 3 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулж, иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар олгох "Сургагч багш"-ийн СЕРТИФИКАТ олгогдсон байна.</p> <p style="text-align: right;"><i>/Өмнөговь аймаг/</i></p> <p>ОХУ-ын Тува улсын онц байдлын яамтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Уг гэрээний хүрээнд 2019 онд Төв аймгийн ОБГ-ын 8-н албан хаагчдыг сургаж бэлтгэсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Төв аймаг/</i></p> <p style="text-align: right;"><i>/Хэрэгжилт 70%/</i></p>
	<p>1.3. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгтэй мэдээлэл болон мэргэжилтэн харилцан солилцох, үндэсний мэргэжилтнийг бэлтгэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулах</p> <p>/2009-2020 он</p>	<p>Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгийн урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл болон Дэлхийн Зөн Олон улсын байгууллагатай байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн "Гамшигт тэсвэртэй Улаанбаатар" төслийн хүрээнд үндэсний болон орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх зорилгоор "Бэлэн бай" сургалтын модулийг боловсруулсан байна. Үүний дагуу 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Онцгой байдлын байгууллагын 67 албан хаагч, Дэлхийн зөн Монгол ОУБ-ын 192 хүнийг "Үндэсний сургагч багш"-аар, нийслэлийн 9 дүүрэг тус бүрт 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан сайн дурын бүлэг, хэсгийн 491 хүний "орон нутгийн сургагч багш"-аар бэлтгэж сертификат олгосон байна.</p> <p style="text-align: right;"><i>/НЗДТГ/</i></p>

<p>/Хэрэгжилт 70%/</p>	<p>Дэлхийн зөн олон улсын байгууллагын Архангай аймаг дахь 1, 2 дугаар салбар, Мерси кор олон улсын байгууллага, Япон хүүхдийг ивээх сангаас Гамшгийн менежементийн төслийн хэрэгжүүлж нийт 16.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн “Аюулгүй өрх” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтыг Эрдэнэбулган сумын 1-7-р багийн 70 иргэн, “Мал сүрэгт тохиолдсон онцгой байдлын үед баримтлах заавар стандарт” сэдэвт сургалтыг сумдын удирдах албан тушаалтан 20 хүнд, “Сургуулийн цогц аюулгүй байдал” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалт”-ыг 19 сумын 33 сургуулийн 116 багш ажилтанд 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, сургалтаар газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр мэдлэг дадлага олгож, сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан байна.</p> <p style="text-align: right;">/Архангай аймаг/</p> <p>Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний дэд хөтөлбөрийн хүрээнд ОБГ, ХГБХХ, УЗХороо, ДЗ-Баянхонгор-1,2 ОУБ-аас нийт 6 сургагч багшийг 3 удаагийн давтамжтай сургалтад 2019 оны 9 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд хамруулж мэдлэг чадавхийг дээшлүүлэн нийт 10,000 орчим ажилтан албан хаагч, иргэд, хүүхдүүдэд газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сургалт дадлагыг зохион байгуулж тодорхой үр дүнд хүрсэн байна.</p> <p>Мөн аймгийн 19 суманд сумдын Засаг дарга болон Засаг даргын тамгын газрын дарга, Цаг уурын ажилтан, Эрүүл мэндийн нийгмийн ажилтан болон Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг 2019 оны 3-4 дүгээр сарын хооронд сургагч багшаар бэлтгэж тэднээр дамжуулан тухайн сум орон нутагт нь сургалт дадлагыг зохион байгуулсан байна.</p> <p>Аймгийн Зарлан мэдээлэх алба, Түлш эрчим хүчний алба, Эрүүл мэндийн албадын нийт 238 хүнд, Нутгийн удирдлагын ордон, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, өрхийн эмнэлэг, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЗДТГ, Нисэх буудал, шатахуун түгээх станцуудад нийт 597 хүн, тавилгын дэлгүүр, супер маркетууд, өрхийн эрүүл мэндийн төв, шатахуун түгээх станц, авто засвар зэрэг объектуудад 2019 онд нийт 74 удаа зохион байгуулж, нийт 5100 багш, ажилтан албан хаагч хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;">/Баянхонгор аймаг/</p> <p>Аймгийн Онцгой комиссын дарга, гишүүдэд болон аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал, 16 сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нарт цахим сүлжээ ашиглан 88 гар утсанд нэгэн зэрэг мессэж илгээн, Булганы мэдээ телевиз, “Сайхан монгол аялгуу” FM радиогоор заавар зөвлөмжийг хүргэж ажиллаа. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах талаар Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгөгдсөн үүрэг, Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүрийн 03 дугаар сарын 4 дэх 7 хоногийн Пүрэв гарагийн 16 цагт улс орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах, дуут дохио дуугаргаж шалгах, дадлага хийгдэх шийдвэр гарсантай холбогдуулан, Булган аймгийн Засаг даргын 2012 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/87 тоот захирамж, аймгийн Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 01/301 тоот албан бичгээр 16 сум, 1 тосгон 70 байгууллага, аж ахуйн нэгжид гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах үүрэг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж Онцгой байдлын газраас алба хаагчдыг байгууллага, аж ахуйн нэгж, багуудад хуваарилан зарлан мэдээлэх дохиогоор хэрхэн ажиллах тухай заавар зөвлөмжийг өгч ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Булган аймаг/</p> <p>Онцгой байдлын ерөнхий газар, Америкийн нэгдсэн улсын элчин сайдын яамтай хамтран баруун бүсийн төв Ховд аймагт зохион байгуулагдсан “Говийн чоно-2019” гамшгийн хор уршгийг арилгах, олон улсын сургалт дадлага, сургууль, туршлага солилцох үйл 2019 оны 6 дугаар сарын 14-ны</p>
-------------------------------	---

		<p>өдрөөс 7 дугаар сарын 8-ны өдрийн хооронд аврагчид уул, ус, нурагинаас эрэн хайх, аврах ажиллагааны онолын сургалтад хамрагдсан байна. <i>/Говь-Алтай аймаг/</i></p> <p>ОХУ-н Тува улсад болсон газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдал авч хэрэгжүүлж буй арга хэмжээний байдалтай хэлтсийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүн 2019 оны 6 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд газар дээр очиж танилцан туршлага судласан. Япон улсад мэргэжилтнүүдийг дадлагажуулах, сургалтад хамруулахаар төлөвлөгөөнд тусган ажилласан байна. <i>/Завхан аймаг/</i></p> <p>Гамшгийн эрсдлийг бууруулах мэдлэг ойлголтыг иргэдэд илүү хүртээмжтэй сонирхолтойгоор хүргэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжиж буй "Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах нь" төслийн хүрээнд 2019 онд 21 удаа албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудад зохион байгуулсан байна. <i>/Увс аймаг/</i> <i>/хэрэгжилт 70%/</i></p>
	<p>1.4. Гамшгийн хор холбогдлыг бууруулахад шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх</p> <p>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Одон орон, геофизикийн хүрээлэнгээр хийж гүйцэтгүүлсэн 12 аймаг болон Улаанбаатар, Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2018 онд Geoportals системд оруулан олон нийтийн хүртээл болгон ашиглаж эхлүүлсэн байна. <i>/Барилга, хот байгуулалтын яам/</i></p> <p>Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгээс санаачлан Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар (UNDRR)-тай хамтран "Хот суурин газрын гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэх арга зам" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж, нийт 17 илтгэл хэлэлцүүлэн 13 заалт бүхий зөвлөмжийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. Мөн хүмүүнлэгийн өдрийг тохиолдуулан Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн, Монголын Улаан Загалмай нийгэмлэгтэй хамтран "Гамшгийн хохирол, хэрэгцээг үнэлэх аргазүйн асуудал" сэдэвт онол, практикийн бага хурлыг 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулж, нийт 7 илтгэл хэлэлцүүлэн 9 заалт бүхий зөвлөмжийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. Тус хүрээлэнгийн дэргэд Тэжээлийн үйлдвэрийн болон сорт сорилтын үйл ажиллагаанд инновацийг нэвтрүүлэх зорилгоор "Байгалийн эрдэст багсармал тэжээл" гарааны компанийг байгуулж шаардагдах дугуйт трактор, чиргүүл, будаа сортлогч, будаа цэвэрлэгч, будаа ачигч, хор цацагч, үрлүүр зэрэг 1.2 тэрбум төгрөгийн 7 нэр төрлийн 22 нэгж техник, тоног төхөөрөмжийг ХХААХҮЯ-ны Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сангаас хүлээн авсан. Мөн Тэжээлийн үйлдвэрийг Төв аймгийн Жаргалант сум дахь Улсын нөөцийн салбарыг, Сорт сорилтын лабораторийг Гамшиг судлалын хүрээлэнг түшиглэн байгуулан ажиллаж байна. <i>/Онцгой байдлын ерөнхий газар/</i></p> <p>Онцгой байдлын ерөнхий газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран "Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн газар хөдлөлтийн тусгай тоноглол бүхий танхимд газар хөдлөлтийг биеэр мэдрүүлэх төхөөрөмжийг 2019 оны 3 дугаар сард суурилуулсан байна. Сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн чичирхийлэл нэмэгдэж байгаатай холбогдуулан ард иргэдэд газар хөдлөлтийн 3-12 баллын газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрүүлэх төхөөрөмжийг суурилуулснаар 342 удаагийн сургалтаар 30034 иргэнийг сургалтад хамруулж, газар хөдлөлтийн үед өөрийгөө болон бусдыг авран</p>

		<p>хамгаалах мэдлэг, ойлголт өгсөн байна. Мөн Улаанбаатар хотод Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2019 оны 4 дүгээр сард зохион байгуулсантай холбогдуулан бэлтгэлийг хангах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 9.5 сая төгрөгийн өртөг бүхий нисгэгчгүй нисэх төхөөрөмж 2, байршил тогтоогч 1 ширхгийг тус тус худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/НЗДТГ/</i></p> <p>Газар хөдлөлийн гамшгийг бууруулах зорилгоор Солонгос улсын дэмжлэгтэйгээр Дэрэнгийн хагарал, түүний газар хөдлөлийн голомтын орчимд амжиж анхааруулах станц 3ш, баталгаажуулах станц Төв аймгийн Баянцагаан суманд 1 ш нийт 4 станц баригдан 2015 оноос ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дундговь аймаг/</i></p> <p>Гамшгийн хор холбогдлыг бууруулахад шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх талаар олон улсын туршлага, техник технологи судлаж барилгын зураг төсвийг тухайн орон нутгийн онцлогийг харгалзан инженер геологийн судалгааг өндөр түвшинд хийж үнэн зөв дүгнэлт гаргахад мэргэжлийн байгууллагуудтай 2017 оноос эхлэн хамтран ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Завхан аймаг/</i></p> <p>Гамшгийн эрсдлийг бууруулах мэдлэг ойлголтыг иргэдэд илүү хүртээмжтэй сонирхолтойгоор хүргэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжиж буй "Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах нь" төслийн хүрээнд Batu digital comrapu "ANHAAR" нэртэй аппликэйшнийг тус газрын андройд утастай бүх албан хаагчдад суулгаж, 2019 онд албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудад зохион байгуулсан сургалтын үеэр сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</i></p>
	<p>1.5. Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх сургалт зохион байгуулах</p> <p>/2009-2014 он Хэрэгжилт 70%/</p>	<p>ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүн амын сан, Азийн хөгжлийн банкны төсөл, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Норвегийн тусламжийн байгууллага зэрэг олон байгууллагатай хамтран нийслэлийн дүүрэг, хөдөө орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүд ард иргэдэд анхны тусламжийн сургалт явуулж ирсэн. Энэ хүрээнд яаралтай тусламжийн үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг яаралтай тусламжийн мэргэжлийн эмч нараас бэлтгэн эмч мэргэжилтнүүд болон ард иргэдэд энэхүү сургалтыг тасралтгүй хүргэж ирсэн байна.</p> <p>1. Энэ хүрээнд УНТЭ-ийн сувилахуйн алба болон яаралтай тусламжийн сувилхуйн багтай хамтран Олон Улсын сувилахуйн баярыг угтан "Иргэн бүр аврагч" нэртэй сургалтыг 2019 оны 5 дугаар сарын 08-ны 14:00-14:40 цаг Чингис зочид буудлын хаан танхимд зохион байгууллаа. Сургалтад нийт 200 сувилагч хамрагдсан.</p> <p>2. "Амь тэнссэн үеийн үнэлгээ болон тусламж" сэдвээр Орхон аймгийн бүсийн оношилгооны төвд Жайка Олон Улсын байгууллагатай хамтран 2019 оны 5 дугаар сарын 25-ны өдөр нийт 12 эмчид сургалт зохион байгуулсан.</p> <p>3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, байгууллагаас гаргасан журамтай танилцах талаар сургалт 14 хоног тутамд явуулж байна. Эмнэлгүүдийн Профессорын багтай хамтран "Лариделийн амбу"-г сургалтад авч ашиглаж 3 дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын нийт-36 эмч, сувилагч суралцагч нарыг хамруулсан.</p> <p>4. УНТЭ-ийн инженер техникийн албанаас 2019 оны 06 дугаар сарын 06-07-ны өдөр Хүчилтөрөгчийн баллоны аюулгүй байдал, хэрхэн ажиллах, хэрэглээний сэдвээр сургалт явуулж, 3 дахь шатлалын эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн туслах резидент эмч, сувилагчид нийт 10 эмнэлгийн мэргэжилтэнийг хамруулсан.</p> <p>5. 2019 онд Сонгино хайрхан дүүргийн засаг даргын тамгын газар болон Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газар, Налайх дүүргийн засаг</p>

	<p>даргын тамгын газар JCI улаанбаатар байгууллагатай хамтран төрийн өмчийн цэцэрлэгт ажиллаж байгаа удирдах ажилтан, багш, ажиллагсад “Анхны тусламж” Иргэн бүр аврагч сургалтыг СХДүүргийн 56, Хан-Уул дүүргийн 29, Налайх дүүргийн 8 цэцэрлэгт амжилттай зохион байгууллаа. Мөн хүүхдийн яаралтай тусламжийн тасагт тоног төхөөрөмжийг 8 цэцэрлэгт, 119-р сургуульд анхны тусламжийн хайрцаг гардуулан өгсөн.</p> <p>6. Амилуулах суурь тусламж болон анхны тусламж сургалтыг АПУ ХХКомпанийн ажлын байран дээр 2019 оны 5 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад нийт 55 ажилчид хамрагдсан.</p> <p>7. JICA олон улсын байгууллага, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран Анхан болон Хоёр дугаар шатлалын эмнэлэгийн 12 эмчид “Амьлуулах суурь тусламж” сэдвээр 2 өдрийн сургалтыг амжилттай зохион байгуулсан зэрэг ажлууд хийгдсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Эрүүл мэндийн яам/</i></p> <p>Анхны тусламж үзүүлэх талаарх сургалтыг 2019 онд дараах байдлаар явууллаа. Үүнд: Ерөнхий боловсролын 28 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 17 цэцэрлэгийн хүүхэд, сурагчдын эцэг, эх, асран хамгаалагч, 9 дүүргийн 28 хорооны хэсгийн ахлагч, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн нийт 6400 хүнд анхны тусламж хэрхэн зөв үзүүлэх дадал олгох практик сургалтыг явуулсан байна. Түүнчлэн 28 цэцэрлэгийн 5150 эцэг эхчүүдэд, 21 сургуулийн 8640 хүүхдэд түлэгдэлт, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх сургалтыг зохион байгууллаа. Онцгой байдлын албан хаагчид нийт 49 удаагийн сургалтаар 3594 иргэн, аж ахуйн нэгжийн албан хаагчдад анхан шатны тусламж үзүүлэх сургалтыг тус тус зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/ИЗДТГ/</i></p> <p>“Бэлэн бай” сургалтын багцаар өөртөө болон бусдад “Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх” сургалтыг 48 удаа 60 цаг 1584 иргэнд онолын болон дадлагын хэлбэрээр 2019 онд зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Говьсүмбэр аймаг/</i></p> <p>Эрүүл мэндийн газрийн стумляц сургалтын төвөөр дамжуулан 8 сэдвээр нийт 84 эмч эмнэлгийн ажилтанд танхимын сургалт зохион байгуулсан байна. 2019 оны 5 дугаар сард Онцгой байдлын газраас зохион байгуулсан Гамшгаас хамгаалах албадын бэлэн байдлын үзүүлэх сургалтын үеэр 5 сэдвээр сурталчилгааны материал 240 ширхэг, үзүүлэх болон дадлага сургуулийг 80 гаруй иргэнд амилуулах суурь тусламж, осол гэмтлийн үед үзүүлэх яаралтай тусламж, зэрэг сэдвээр Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч Д.Хишигсүрэн зохион байгуулав. Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг Нэгдсэн эмнэлэг, Өрхийн сумын ЭМТ-үүдтэй хамтран Амилуулах суурь тусламж болон лавшруулсан суурь тусламжийн чиглэлээр нийт 150 гаруй мэргэжилтэнд сургалтыг 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр дадлага сургуулийг зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дархан-Уул аймаг/</i></p> <p>Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, шалгалтыг зохион байгуулж, 8 сумын гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, Гамшгаас хамгаалах орон нутгийн 13 алба, тусгай зориулалтын 22 мэргэжлийн ангийн нийт 1131 хүнд “Гамшиг ослоос өөрийгөө болон бусдыг аврах ажиллагаа”, “Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх” сэдэвт 72 цагийн танхимын, 8 цагийн дадлага сургалтыг 2019 онд зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дорнод аймаг/</i></p> <p>Улиастай, Тосонцэнгэл, Их-уул сумдын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад 2019 оны 4 дүгээр сард Дэлхийн зөн Монгол ОУБ-н Завхан болон Завханхангай ОНХХөтөлбөртэй хамтран 581 хүүхдэд болзошгүй газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд өөртөө болон бусдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх нь</p>
--	--

		<p>сэдвээр танхимийн болон бодит дадлага сургуулилтийг зохион байгуулсан байна.</p> <p>Үүнд: Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулиар газар хөдлөлтийн цагийн байдлаар нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг зохион явуулж 3241 хүнийг хамруулсан байна. Танхимын сургалтаар удирдах бүрэлдэхүүний сургалтыг 4 удаа 15 цаг 95 албан тушаалтанд, мэргэжлийн ангийн сургалтыг 10 удаа 30 цагийн багтаамжтай 224 хүнд, ажилтны сургалтыг 7 удаа 16 цаг 176 хүнд, оюутан сурагчдын сургалтыг "Эх орон-36" Хүүхэд хөгжлийн хөтөлбөр, Газар хөдлөлтийн "Говийн баавгай" сургалтуудыг 3 удаа 12 цаг 960 оюутан сурагчдад өртөөчилсөн сургалтыг дадлагаар , бусад иргэдийн сургалтыг 12 удаа 24 цаг 165 иргэнийг хамруулан "газар хөдлөлтийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах вэ", "хүн нэг бүрийн үүргэвчинд байх зүйлсийн жагсаалт", "өөртөө болон бусдад үзүүлэх анхны тусламж" зэрэг сэдвүүдийн хүрээнд зохион байгуулан явуулж гарын авлага материал тарааж хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр сурталчилгаа хийн Улиастай, Тосонцэнгэл сумдын багуудад "Гамшиг ослоос урьдчилан сэргийлье" ухуулга сурталчилгааг зохион байгуулж "нурангинд даруулсан хүнд үзүүлэх анхны тусламж" "хүн нэг бүрийн үүргэвчинд байх зүйлс"-ийн жагсаалтыг үзүүлэх дадлага сургууль хийн 460-д хүнийг хамруулан газар ухуулга сурталчилгаа хийж гарын авлага материал тараасан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Завхан аймаг/</i></p> <p>Аймгийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2019 онд 7 үе шаттай зохион байгуулж явуулсан. Команд штабын дадлага сургуулийн талаар: Гамшгаас хамгаалах Иж бүрэн сургуулийн үеийн команд штабын сургуулийг "Газар хөдлөлт", "Шар усны үер", "Малын гоц халдварт шүлхий өвчин", "Ой, хээрийн түймэр" зэрэг сэдвээр зохион байгуулсан байна. Уг өгөгдсөн цагийн байдлын дагуу аймгийн Онцгой комиссын гишүүд, Сумдын Онцгой комисс гишүүд, Засаг дарга, Тамгын газрын дарга, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, алба газар, аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нар өгөгдсөн цагийн байдал дээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар аймгийн Засаг даргын ажлын зураг, шийдвэрийн зурагт оруулж, холбогдох захирамж шийдвэрийг өгөгдсөн даалгаварын хүрээнд гаргаж ажилласан. Хээрийн хүн эмнэлэг дэлгэх үйл ажиллагааны талаар: Гамшигын голомтод нэрвэгсэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг газар дээр нь үзүүлэх, олон улсын хөл хориот өвчний дэгдэлт гарсан тохиолдолд халдварт өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг шаардлагад нийцүүлэн 200 ортой "Хөдөлгөөнт хээрийн эмнэлэг"-ийг дэлгэн бэлэн байдлыг хангасан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</i></p>
	<p>1.6. Хот байгуулалт, барилгын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт газар чичирхийллийн нөлөөллийг тооцох, төлөвлөх хичээл нэмэх, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, кредит цагийг нэмэгдүүлэх, багш нарыг давтан сургах, мэргэшүүлэх</p> <p>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын 3.2.14-т "Ерөнхий боловсролын сургуульд сурагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургана" гэж тусгасан билээ. Мөн Монгол Улсын "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 13.3.6-д "оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалтыг батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн шатны боловсролын байгууллага зохион байгуулна" гэж заасан байна.</p> <p>"Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого"-ын 2.1, 2.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор баталсан "Гамшигийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн 3.2.10-т "Гамшигийн эрсдэлийг бууруулах, аюулгүй амьдрах ухааны боловсрол, хүмүүжил олгох хичээлийг сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын сургалтын хөтөлбөрт оруулах, сургалтыг хүүхдийн насны онцлогт тохируулан явуулах" гэсэн ажлыг тус яам хариуцан зохион байгуулахаар тусгасан байна.</p> <p>Дээрх хуулиуд болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх "Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр"-ийн төслийг Боловсролын Хүрээлэн дээрх байгуулсан БМДИ, Онцгой байдлын ерөнхий</p>

		<p>газрын холбогдох мэргэжилтнүүд оролцсон ажлын хэсэг боловсруулж, тус яамны төсөлд дараах байгууллагуудын саналыг авч тусгалаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн; 2) Зоонозын өвчин судлалын үндэсний төв; 3) Гал түймэртэй тэмцэх газар; 4) ОБЕГ-ын гамшгийн шуурхай удирдлагын газар; 5) Цаг уур орчны шинжилгээний газар; 6) Одон орон, геофизикийн хүрээлэн; 7) Замын цагдаагийн газар; 8) Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар. <p>Хөтөлбөрийн төслийг сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд 1) ахуйн орчны аюулгүй байдал, ii) нийгмийн орчны аюулгүй байдал, iii) гамшиг осол, аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй боловсруулж БСШУС-ын сайдын 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн А/181 дүгээр тушаалаар батлуулсан байна.</p> <p>"Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр"-ийг бие даасан хичээл биш, хичээлүүдийн агуулга, сургалтыг дэмжих үйл ажиллагаа, хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааны цагт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хөтөлбөр боловсруулсантай холбогдуулан, , багш, удирдах ажилтныг арга зүйгээр хангах сургалтыг зохион байгуулж 90 сургагч багш бэлтгэлээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулж, 2019 оны 1 дүгээр улиралд ерөнхий боловсролын сургуульд хүргүүлсэн байна.</p> <p>Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид аюулгүй байдлаа хангах аргад суралцах, ахуй амьдралдаа хэрэгжүүлж хэвших, болзошгүй осол, аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах аргад суралцах боломж бүрдэх юм байна.</p> <p style="text-align: right;">/БСШУСЯ/</p> <p>2019 онд тус аймгийн Улаангом Политехник коллеж, Хөдөлмөрийн дээд сургуулийн 640 оюутанд "Гамшгаас хамгаалах менежментийн үндэс" хичээлийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай ойлголт, эрх зүй сэдвээр 12 цаг, Аюулт үзэгдлүүд түүнээс урьдчилан сэргийлэх, нэрвэгдэгсдэд үзүүлэх анхны тусламж сэдвээр 24 цаг, Аюулт үзэгдэл ослын үед үүрэг гүйцэтгэх нь сэдвээр 4 цаг, нийт 36 цагийн лекц, 4 цагийн дадлага сургуулийг зохион байгуулж ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</p>
	<p>1.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон газар хөдлөлтийн бүртгэлийн мэдээллийн санг баяжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгтэй мэдээлэл болон мэргэжилтэн харилцан солилцох, үндэсний мэргэжилтэн бэлтгэх, дадлагуулах ажлыг зохион байгуулах</p> <p>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Одон орон, геофизикийн хүрээлэнгээр хийж гүйцэтгүүлсэн 12 аймаг болон Улаанбаатар, Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2018 онд Geoportals системд оруулан олон нийтийн хүртээл болгож ашиглаж эхлүүлсэн. Үүний хүрээнд байгууллагын мэргэжилтэн нарыг ашиглаж сургах сургалтыг 2019 онд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулан ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Барилга, хот байгуулалтын яам/</p> <p>Аймгийн Байнгын ажиллагаатай зөвлөлөөс аймгийн нийт барилга, байгууламжийн судалгааг гаргаж, Гамшиг судлалын хүрээлэнд хүргүүлсэн бөгөөд мэдээллийн санг Онцгой байдлын ерөнхий газарт байгуулан ажиллаж байна. Мөн аймгийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн А/322 дугаар захирамжаар Барилга байгууламжийн паспортжуулалтын ажлыг зохион байгуулах орон тооны бус 11 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийг байгуулаад байна.</p> <p>МХГ-аас аймгийн хэмжээнд шинээр баригдсан 6 шинэ барилгад улсын комиссын дүгнэлтийг үндэслэн гэрчилгээжүүлж ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Дорнод аймаг/</p> <p>ШУА-ын ООГХ-ын Мандалговь салбар нь тус аймагт 2014 байгуулагдсан. Одоогийн байдлаар тус аймгийн нутаг дэвсгэрт газар хөдлөлийн</p>

		<p>чичирхийллийг бүртгэх өргөн зурвасын станц 1, хүчтэй газар хөдлөлийн үед гамшгийг урьдчилан амжиж анхаарах зориулалттай станц 3ш, соронзон вариацийн станц 1ш тус тус ажиллаж газар хөдлөлийн үндэсний мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэлтэд оролцсон байна. Газар хөдлөлийн мэдээллийн анхан шатны боловсруулалтыг орон нутгийн станцууд хариуцан ажиллах журамд шилжихээр бэлтгэл ажил хийгдэн мэргэжилтний мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтаас гадна дадлагажуулах ажил 2019 онд хийгдэж ООГХ-ийн хэмжээнд системийн өөрчлөлт хийх бэлтгэл ажил хийгдсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дундговь аймаг/ /Хэрэгжилт 70%/</i></p>
<p>2 дугаар зорилтын хүрээнд: Газар хөдлөлтийн аюулын үнэлгээ хийж, ерөнхий болон бичил мужлалын зураг зохиох, газар хөдлөлт бүртгэх станцын сүлжээг өргөтгөх;</p>		
	<p>2.1. Монгол орныг хамарсан газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураг боловсруулах ажлыг нэгдсэн аргачлал, шинжлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурлан зохион байгуулах</p> <p><i>/2009-2015 он Хэрэгжилт 70%/</i></p>	<p>2018 оны 3-р улиралд БХБЯ-наас “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрийн газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил”-ыг 9 аймгийн (Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл) бичил мужлалын зураг хийх судалгааны ажил батлагдаж нийт 399 сая төгрөгийн төсвөөр судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. 2019 онд энэхүү захиалгат ажлын санхүүжилт олгогдоогүй учраас судалгааны ажил зогссон. 2019 оны 10 дугаар сард захиалгат ажлыг гүйцэтгэх гэрээг БХБЯ-тай дахин хийж захиалгат ажлыг 2022 онд хүлээлгэн өгнө.</p> <p style="text-align: right;"><i>/Барилга, хот байгуулалтын яам/ /Хэрэгжилт 70%/</i></p>
	<p>2.2. Газар хөдлөлтийн өндөр эрсдэл бүхий хот, суурин газар, бүсүүдийн тулгуур төв болон зарим суурин газрын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:10000-ны масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох ажлыг үе шатаар хэрэгжүүлэх</p> <p><i>/2009-2015 он Хэрэгжилт 70%/</i></p>	<p>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Одон орон, геофизикийн хүрээлэнгээр хийж гүйцэтгүүлсэн 12 аймаг болон Улаанбаатар, Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2012-2018 оны хооронд хийж гүйцэтгүүлээд олон нийтийн хүртээл болгон холбогдох дүрэм журам норм норматив баримт бичигт тусган ажиллаад байна. Мөн үлдсэн 9 аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2018-2021 онд хийж гүйцэтгэхээр Одон орон, геофизикийн хүрээлэнтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлэн, хоёрдугаар шатны тайланг хүлээн авсан байна.</p> <p>2018 оноос БХБЯ-ны захиалгаар “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил”-ыг 9 аймгийн (Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл) бичил мужлалын эхний шатны тайланг БХБЯ-нд хүлээлгэн өгсөн. 2017 оноос эхлэн Монгол орны нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураг боловсруулах шинжлэх ухааны төслийг БХБЯ-ны захиалгаар хэрэгжүүлэн судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Одон орон геофизикийн хүрээлэн/ /Хэрэгжилт 70%/</i></p>
	<p>2.3. Газар чичирхийллийг бүртгэх, мэдээлэл боловсруулах байнгын станцыг шинээр байгуулах</p> <p><i>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</i></p>	<p>Богд сумд Газар хөдлөлтийг бүртгэх станц шинээр баригдаж 2013 онд ашиглалтад орсон мэдээллийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн Онцгой байдлын газраас ирүүлсэн мэдээллийн дагуу Баянлиг, Баянговь, Богд сумдад 2015 оны 12 дугаар сарын 11-нд 4,7 магнитын газар чичирхийлэлт болсон тул газар дээр нь очиж ажиллаа. Учирсан хохирлын тооцоог гаргаж, аймгийн МХГазар болон Онцгой байдлын газарт хүргүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Баянхонгор аймаг/ /Хэрэгжилт 70%/</i></p> <p>2013 оноос эхлэн өнөөг хүртэл газар хөдлөлтийг бүртгэх өргөн зурвасын Guralp станцыг Vlgm станцад суурилуулан өнөөдрийн байдлаар бүрэн ажиллуулан ашиглаж байна. Газар хөдлөлийн өндөр эрсдэл буюу 9 балл бүхий зарим сумдад чичирхийллийг бүртгэх станц байгуулах шаардлага</p>

		<p>байгаа боловч түүнийг байгуулах талаар өнөөдөр боломж бүрдээгүй байна гэж холбогдох газрууд үзсэн байна. Булган аймгийн газар хөдлөлт бүртгэх станцын дэд бүтцийг сайжруулах талаар геофизикийн хүрээлэнгийн удирдлагад хандаад байгаа ба боловсон хүчний чадавхийг нь дээшлүүлэх талаар системтэй арга хэмжээг авч байна. Станцын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, 24 цагийн турш хяналтыг хийж, анхан шатны мэдээлэл боловсруулалтыг хийж гүйцэтгэх, магнитуд нь 3.5 дээш газар хөдлөлтийг ОБГ болон сумын удирдлагуудад мэдээлж байна. ООГХ-ийн “Үндэсний мэдээллийн төв”-д шууд горимоор мэдээлэл бүрдүүлэлт 95 хувь, мэдээлэл дамжуулалтыг 90 хувьтай гүйцэтгэсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Булган аймаг/</i></p> <p>Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор газар хөдлөлтийн гамшгийн аюулыг бууруулах судалгааны ажлыг эрчимжүүлэх, түүний идэвхжлийн төлөв байдал, хүчтэй голомтуудын горимыг судлах зорилгоор газар хөдлөлтийг бүртгэх байнгын ажиллагаатай станцыг Дундговь аймгийн Мандалговь хотод байгуулсан бөгөөд 2019 оны байдлаар ШУА-ын ООГХ-ийн Мандалговь салбар нэртэйгээр 7 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дундговь аймаг/</i></p> <p>2013 онд Улаанбаатар хот орчимд хүчтэй газар хөдлөлтийн өмнө явагдах эвдрэл болон геофизик орны өөрчлөлтийг хянах зорилгоор геофизикийн мониторингийн станцуудыг байгуулсан ба газар хөдлөлтийг бүртгэх 16 станц, хагарлын шилжилт хөдөлгөөнийг хянах GPS-ын 7 станц (+3 нүүдлийн), газрын хэв гажилтыг тогтоох станц (tiltmeter) 6 станцыг байгуулсан. 2017 онд Хустайн идэвхтэй хагарлын бүсэд ОХУ-ын судлаачидтай хамтран газрын хэв гажилтыг хэмжих сүлжээ станц бүхий 6 страйнметрийн станцыг суурилуулан хэвийн ажиллагааг ханган засвар үйлчилгээг ханган ажиллаж байна. Эдгээр станцуудын мэдээллийг шууд горимоор ООГХ-ийн ҮМТ-д хүлээн авч мэдээлэл боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Одон орон геофизикийн хүрээлэн/ /Хэрэгжилт 70%/</i></p>
2.4. Орон нутагт ажиллаж байгаа газар хөдлөлт бүртгэх станцын дэд бүтцийг сайжруулах боловсон хүчний чадавхийг нь дээшлүүлэх	<p>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Орон нутагт ажиллаж байгаа газар хөдлөх станцын дэд бүтцийг сайжруулах, боловсон хүчний чадавхийг нь дээшлүүлэх сургалтад 4 сараас 7 сар хүртэл 3 сарын хугацаатай 1 хүн хамруулсан. 2018 онд 4 инженер хамруулсан ба салбарын инженер Магистрийн зэрэг хамгаалсан. ШУА-ийн ООГ-н хүрээлэнгийн Цэцэрлэг салбарын барилгын халаалтын системийг сайжруулахад 4,8 сая төгрөгний хөрөнгийн асуудлыг хүрээлэнгээс шийдвэрлэсэн. 2019 онд барилгын засварын ажлыг хийлгэхээр санал хүргүүлсний дүнд 4,836,030 төгрөгний засварын ажлыг хийсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Архангай аймаг/</i></p> <p>Одон орон геофизикийн судалгааны хүрээлэнгийн Өлгий салбар нь газар хөдлөлтийг бүртгэх “CRALP” өргөн зурвасыг ашиглан газар хөдлөлтийг бүртгэн мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудыг мэдээлэлээр шуурхай ханган ажиллаж байгаа ба салбарын дэд бүтцийг сайжруулах, боловсон хүчний чадваржуулах ажлыг үе шаттай хийж хэрэгжүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Баян-Өлгий аймаг/</i></p> <p>Аймгийн ЗДТГ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төвөөс инженер техникийн мэргэжлийн ажилтанууд томилогдон ажиллаж сургалтад байнга хамрагдсан байна.</p> <p>Орон нутагт газар хөдлөлт бүртгэх станц бий болсноор инженер техникийн ажилтнуудын ур чадвар сайжирч мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Баянхонгор аймаг/</i></p>

		<p>Станцыг хэвийн тасралтгүй үйл ажиллагааг 24 цагийн турш хяналтыг хийж, анхан шатны мэдээлэл боловсруулалтыг хийж гүйцэтгэх, магнитуд нь 3.5 дээш газар хөдлөлтийг ОБГ болон сумын удирдлагуудад мэдээлж байна. ООГХ-ийн “Үндэсний мэдээллийн төв”-д шууд горимоор мэдээлэл бүрдүүлэлт 95%, мэдээлэл дамжуулалтыг 90%-тай хийж гүйцэтгэсэн байна. 2014 онд болзошгүй хүчтэй газар хөдлөлтийн аюулаас “Амжиж анхааруулах систем”-ийн станцыг Дашинчилэн суманд 1, Могод суманд 3 станц байгуулагдан Булган аймгийн хэмжээнд 4 “ААС” станц ажиллаж байна. <i>/Булган аймаг/</i></p> <p>ШУА-ын ООГХ-ийн Мандалговь салбар нь Дундговь аймгийн Сайнцагаан сумын төвд байрлаж байна. Газар хөдлөлийн мэдээллийг бүртгэх өргөн зурвасын станц 1, ААС 3 ширхэг ажиллаж байна. Улсын хэмжээний станцуудын мэдээллийг нэгтгэн боловсруулах ажлыг хийхэд шаардагдах өндөр хурдны интернетэд холбогдох ажил 2019 онд хийгдсэн байна. <i>/Дундговь аймаг/</i></p> <p>Завхан аймгийн Тосонцэнгэл суманд газар хөдлөлтийг бүртгэх станц ажиллаж байгаа бөгөөд тус конторын барилгад 2011 онд 10 сая төгрөгийн урсгал засвар хийсэн. Орон нутагт ажиллаж байгаа газар хөдлөлт бүртгэх станцын дэд бүтцийг сайжруулах боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх талаар анхаарч ажиллаж байна. Тосонцэнгэл дэх газар хөдлөлт бүртгэх станц хэвийн ажиллаж байна. <i>/Завхан аймаг/</i></p> <p>2014 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 4 сая төгрөгөөр газар хөдлөлийн станцын ажилчдын техник тоног төхөөрөмж авахад дэмжлэг үзүүлсэн байна. <i>/Увс аймаг/</i></p> <p>ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн харьяа газар хөдлөлтийг бүртгэх орон нутаг дахь 12 станцын хэвийн үйл ажиллагааг хангах, багаж тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх, шинэчлэх, станцын техникийн хүчин чадлыг өргөтгөх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Газар хөдлөлтийг бүртгэх Цэцэрлэг, Өлгий, Улаангом, Мандалговь, Сэлэнгэ станцуудын мэдээлэл хадгалах санах ойн төхөөрөмж температурын нөлөөнөөс үүдэлтэйгээр гэмтсэнийг засварлан хэвийн ажиллагаанд оруулсан байна. Мөн Цэцэрлэг, Өлгий, Улаангом станцуудын хувьд газар хөдлөлтийн сигнал нь температурын өөрчлөлтөөс (хэт халах, хөрөх) болж ихээхэн тасалдалтай байсан байна. Температурын нөлөөллийг багасгах зорилготойгоор газар хөдлөлт бүртгэх багаж байрлаж буй нүхэн байруудын дулаалгын ажлуудыг хийсэн байна. Ховд аймгийн Булган суман дахь BLNM, Увс аймгийн Сагил суман дахь SAGM станцуудын тоног төхөөрөмжийн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Орон нутгийн бүх газар хөдлөлтийг бүртгэх станцууд дээр бусад станцынхаа мэдээллийг хүлээн авч газар хөдлөлтийн анхан шатны мэдээлэл боловсруулалтын ажлыг хийх туршилтыг 9-11 саруудад амжилттай хэрэгжүүллээ. 2019 онд Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд шинээр BUMAR станцыг байгуулсан. Энэхүү станцын мэдээллийг үүрэн холбооны оператор болох Жи Мобайл-ийн 3G сүлжээг ашиглан шууд горимоор ООГХ-ийн ҮМТөвд хүлээн авч мэдээлэл боловсруулалтын ажлыг хийж байна. “Газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем”-ийг 2014 онд Солонгос улсын төслийн баг бүрэн ажиллагаанд оруулан хүлээлгэн өгсөн. ОБЕГ-тай хамтран уг системийг бүрдүүлэн ажиллуулж байгаа ба ООГХ нь Сэлэнгэ, Дундговь, Булган аймгуудад байгуулагдсан газар хөдлөлтийг бүртгэх 12 станцын техникийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. <i>/Одон орон геофизикийн хүрээлэн/ /Хэрэгжилт 70%/</i></p>
	<p>2.5. Газар хөдлөлтийн судалгаа эрхэлдэг байгууллагыг газар хөдлөлт бүртгэх</p>	<p>Газар хөдлөлт бүртгэх сүлжээ болон геофизикийн станцуудын хүрээг өргөтгөн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, бүртгэх хүчин чадлыг сайжруулах ажил үе шаттайгаар хөгжүүлэх</p>

	<p>нүүдлийн станц болон геофизикийн орчин үеийн иж бүрэн багаж, техник хэрэгслээр хангах</p> <p>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>төлөвлөгөө гарсан боловч төсөв хөрөнгийн дутагдалтай байгаа тул удааширч байна.</p> <p>1. Хээрийн станцыг сайжруулалт</p> <ul style="list-style-type: none"> • Станц дээр дуут болон гэрлэн дохиоллын систем суурилуулах. • Станцын сенсоровын нүхэн байрыг 3м гүн ухаж байгуулах. • Тэжээлийн болон мэдээлэл дамжуулах байрыг сенсоровын нүхэн байрнаас 30м-70м зайд байгуулах. • Станцын тэжээлийн болон сенсоровын нүхэн байрнуудад хаалганы мэдрэгч суурилуулах. • Нарны дэлгэц болон батерейны хүчдэл, гүйдэл хянах контролёр суурилуулж төвийн станцаас хянах. • Ус чийгний түвшин болон температур хянах сенсор суулгах. • Нүхэн байрнуудад дулаалга хийх • Хүрээлэнгээс зохион байгуулсан 3 сарын хугацаатай сургалтад Булган станцын эрдэм шинжилгээний дадлагжигч 3 ажилтаныг хамруулсан байна. <p style="text-align: right;">/Булган аймаг/</p> <p>2016 оноос станцад өргөн зурвасын Guralp CMG-3ESPC сейсмометр дижитайзер, GPS-ын хамт ажиллаж байна. Одон орон геофизикийн хүрээлэнгийн системийн шинэчлэлтийн ажлын хүрээнд станцын мэдээлэл дамжуулах хурд сайжирсан 8Мв-аар холбогдож байна. Мөн дотоод техник хэрэгслийн хүчин чадлыг сайжруулах ажил төлөвлөгдөөд ирэх оны төсвийн зардлаар шинэчлэгдэхээр болсон байна.</p> <p style="text-align: right;">/Дундговь аймаг/</p> <p>2013 онд Улаанбаатар хот орчимд хүчтэй газар хөдлөлтийн өмнө явагдах эвдрэл болон геофизик орны өөрчлөлтийг хянах зорилгоор геофизикийн иж бүрэн мониторингийн станцуудыг байгуулсан ба газар хөдлөлтийг бүртгэх 16 станц, хагарлын шилжилт хөдөлгөөнийг хянах GPS-ын 7 станц (+3 нүүдлийн), газрын хэв гажилтыг тогтоох станц (tiltmeter) 6 станцыг байгуулсан байна. 2017 онд Хустайн идэвхтэй хагарлын бүсэд ОХУ-ын судлаачидтай хамтран газрын хэв гажилтыг хэмжих сүлжээ станц бүхий 6 страйнметрийн станцыг суурилуулан мэдээллийг шууд горимоор ҮМТ-д хүлээн авч байна. 2018 онд Францын судлаачидтай хамтран цацраг идэвхт радоныг хэмжих байнгын 1 станцыг шинээр суурилуулсан байна. Мөн 100м гүн бүхий цооногт усны радон хэмжих зориулалт бүхий 2 барометрийг суурилуулан ажиллуулж байна.</p> <p style="text-align: right;">/Одон орон геофизикийн хүрээлэн/ /Хэрэгжилт 70%/</p>
	<p>2.6. Хүн ам олноор суурьшсан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хөрсний хурдатгалын бичлэг /акселограмм/ хийх</p> <p>/2009-2014 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Одон орон, геофизикийн хүрээлэн 2012 оноос эхлүүлэн Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн хэмжээнд газар хөдлөлийн бичил мужлалын зураглал, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэн 2018 онд Geoportals системд оруулан олон нийтийн хүртээл болгож ашиглаж эхлүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">/Барилга, хот байгуулалтын яам/ /Хэрэгжилт 70%/</p>
	<p>2.9 Нийслэлийн орон сууцны олон нийтийн зориулалттай барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлыг шалгах паспортжуулах үзлэг шалгалтын ажлыг хийж мэдээллийг хот байгуулалтын</p>	<p>Барилга, хот байгуулалт яам нь аймаг, нийслэлийн засаг дарга нарт өөрийн нутаг дэвсгэрт хамаарах нийт барилга байгууламжид паспортжуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар анхаарч ажиллах тухай албан бичгийг 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/312 тоот албан бичгээр хүргүүлсэн байна. Үүний хүрээнд Говь-Сүмбэр аймагт 16 барилга байгууламжид паспортжуулалтын ажил хийгдсэн бөгөөд 2 орон сууцны барилга байгууламж хамрагдсан байна. Нийслэлийн хэмжээнд 250 сая төгрөгийг төсвийг батлуулсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/146 дугаар захирамжийн хүрээнд төрийн өмчийн их, дээд сургуулийн 14, дунд сургуулийн 29, цэцэрлэгийн 12, эмнэлгийн 3, түүх,</p>

	<p>мэдээллийн санд оруулах</p> <p>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>соёлын 2, олон нийтийн 16, нийт 76 барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, бат бэх найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах, паспортжуулах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:</p> <p>Урьдчилсан шатны судалгааны ажлуудыг (инженер-геологи, хийц, бүтээцээс дээж авч лабораторид шинжлэх, шурф /нүх/ ухаж суурийн бат бэх шалгах гэх мэт) хийж дууссан. Мөн 2019 онд аж ахуйн нэгжийн хүсэлт, гэрээгээр 7 барилгад биет, хэмжилт судалгаа хийж, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, бат бэх найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулан хүлээлгэн өгсөн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа – 4; • Нийслэлийн прокурорын газрын – 1; • Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын харьяа - 2 барилга байна. <p>/Барилга, хот байгуулалтын яам/ /Хэрэгжилт 70%/</p>
<p>3 дугаар зорилтын хүрээнд: Хот суурин болон бүс нутгийн эрсдэлийн үнэлгээг хийх;</p>		
	<p>3.1. Хангай, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх</p> <p>Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх</p> <p>/2009-2014 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэн Нийслэлийн 9 дүүрэг, 12 аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг төслийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд холбогдох мэдээллийг аймгуудад хийж, ГХБХБГ-т ажлын тайлан, холбогдох зургийг хүлээлгэн өгсөн байна. Дээрх ажлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 онд "Geoportал" системд Улаанбаатар хот болон Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон 12 аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг олон нийт ашиглах боломжтойгоор нэвтрүүлсэн байна.</p> <p>/Барилга, хот байгуулалтын яам/ /Хэрэгжилт 70%/</p>
	<p>3.2. Хот, суурин газруудын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний ажлыг дуусгаж, мэдээллийн сан байгуулах</p> <p>/2015-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>БХБЯ, ОБЕГ, ООГХ хамтран баталсан 2018 оны 2018/175 тоот зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу 2018 онд эхлүүлсэн "Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил"-ыг үргэжлүүлэн хийхэд шаардлагатай 2 тэрбум төгрөгөөс 2019 оны улсын төсөвт 400.0 сая төгрөг батлагдаж, Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологийн судалгааны ажлыг хийж дуусгасан байна.</p> <p>/Онцгой байдлын ерөнхий газар/</p> <p>Налайх дүүрэг 2019 оны 7 дугаар сар, Багахангай дүүрэг 9 дүгээр сар, Багануур 11 дүгээр сард тус тус "Дүүргийн хэмжээнд" гамшгийн эрсдэлийн тойм судалгааг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд аюулт үзэгдлийн төрөл тус бүрээр зохион байгуулсан. Тойм судалгааны үр дүнд Налайх дүүрэгт газар хөдлөлт, хүчтэй цасан болон шороон шуурга, Багахангай дүүрэгт хүчтэй цасан болон шороон шуурга, зуд, Багануур дүүрэгт үер, газар хөдлөлтийн эрсдэлтэй тодорхойлогдсон байна. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн "Ерөнхий боловсролын сургуулиудад тойм судалгаа хийх" тухай удирдамжийн дагуу нийслэлийн хэмжээнд Төрийн өмчийн ерөнхий боловсролын нийт 206 сургуулиас 79 сургуульд Гамшгийн эрсдэлийн тойм судалгааг зохион байгуулж, сургуулийн захирал, ажилчид, эцэг эх, ахлах ангийн сурагчдийн нийт 1174 төлөөллийг хамруулсан байна. Сургуулиудад тохиолдож</p>

		<p>болзошгүй аюулт үзэгдлийн төрөл тус бүрээр эрсдэлийн түвшинг тодорхойлоход бага түвшний эрсдэлтэй 9, дунд түвшний эрсдэлтэй 44, их түвшний эрсдэлтэй 26 сургууль байна. Гамшгийн эрсдэлийн тойм судалгааны нийт дүнгээр сургуулиудад газар хөдлөлт, объектийн гал түймрийн эрсдэл өндөр байгаа нь харагдсан байна.</p> <p>Нийслэлийн 169 хорооноос 109 хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч, ажилчид, оршин суугчдын нийт 1174 төлөөллийг хамруулж, гамшгийн эрсдэлийн тойм судалгааг зохион байгуулсан байна. Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн тойм судалгааны аргачлал болон индикаторын аргачлалыг ашиглан тухайн хорооны нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй аюулт үзэгдлийн төрөл тус бүрээр эрсдэлийн түвшинг тодорхойлоход бага түвшний эрсдэлтэй 6, дунд түвшний эрсдэлтэй 76, их түвшний эрсдэлтэй 27 хороо байна. тойм судалгаагаар тодорхойлогдсон гамшгийн эрсдэлийн мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын Орон зайн мэдээлийн санд оруулсан байна.</p> <p style="text-align: right;">/НЗДТГ/</p> <p>2013 онд аймгийн төвийн хэмжээнд ашиглагдаж буй бүх барилга байгууламжийн бүртгэл тооллого хийгдэн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээг Барилга хот байгуулалтын яамны захиалгаар Алтантуул удирдагчтай төслийн баг ажиллан эрсдэл 43%-тай гэсэн дүгнэлт гарсан. Мөн аймгийн төвийн ашиглагдаж буй 39 орон сууны барилга байгууламжид газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байна. 2017 оны 4 дүгээр сард Архангай аймгийн нутаг дэвсгэрт байгаа боловсрол,эрүүл мэндийн байгууллагууд болон орон сууцнуудад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн судалгаа хийж Газар зохион байгуулалт, Геодези,Зураг зүйн газарт 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 233 тоотор хүргүүлж, БХБЯ, аймгийн ЗДТГ-ын ХБТХэлтэс, ОБГ, МХГ-т хүргүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">/Архангай аймаг/</p> <p>Баянхонгор аймгийн хэмжээний эмнэлэг, сургууль, цэцэрлэг, албан контор, үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламжийн насжилт, эрсдэлийн судалгааг гарган МУШадар сайдаар ахлуулсан ажлын хэсэгт танилцуулж ГХГЗЗГазарт хүргүүлсэн. 2017 оны 4 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Барилга хот байгуулалтын яам, ГЗБГЗЗГазрын хамтарсан Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах давтан сургалтад хамрагдсан байна. Уг сургалтаар QGIS, ARSGIS , AUTOCAD програмуудыг суулгах, мэдээ тайланг бэлтгэн гаргах, шинээр орж байгаа болон засвар шинэчлэлт хийж байгаа инженерийн шугам сүлжээний мэдээллийг цахим программ оруулах сургалтад хамрагдаж холбогдох материалуудыг авч ирсэн өнөөгийн байдлаар Баянхонгор сумын Есөн булаг 9- р багийн инженерийн шугам сүлжээний 1250 метр ариутгах татуургын шугамыг мэдээллийн санд бүрэн оруулаад байна. Шинээр ашиглалтад орж байгаа барилга байгууламжид албан бичиг хүргүүлэн заавар зөвлөгөөг өгч инженерийн шугам сүлжээний мэдээллийг гүйцэтгэлийн зургаар гаргуулан хүлээн авч байна. 2018 оны 1-р улиралд watson.gov.mn сайтыг БХТөвөөс ГЗБГЗЗГазар ашиглалтад хүлээж авснаар хэмжилт хийгдсэн шугам сүлжээний мэдээлэл мэдээллийн санд бүрэн оруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Баянхонгор аймаг/</p> <p>Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2014 онд Форум Арт ХХК-аар гүйцэтгүүлсэн бөгөөд төлөвлөгөөний дагуу БХБС-ын 2006 оны 120 дугаар тушаалаар батлагдсан “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” БНБД /22.01-01*/2006/-ын дагуу “Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд газар хөдлөлтийн 6 баллд тэсвэртэй байхаар барилга байгууламжийг төлөвлөж байсан бол манай аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг Одон орон геофизикийн судалгааны хүрээлэн хийж 5 дугаар сард хүлээлгэн өгсөнөөс хойш Сүмбэр</p>
--	--	--

		<p>сумын 1,2-р багт 7 балл, 3-р багт 6 балл байхаар тооцож, зураг төсвийн ажлуудыг гүйцэтгэж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Говьсүмбэр аймаг/</i></p> <p>Аймгийн Засаг даргын 2017 оны А/89 дүгээр захирамжаар газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах Байнгын ажиллагаатай зөвлөл, зөвлөлийн ажиллах журмыг баталсан байна. Зөвлөлийн даргаар аймгийн Засаг даргын үйлдвэрлэл дэд бүтэц, хот төлөвлөлт хууль эрх зүйн асуудал хариуцсан орлогч, зөвлөлийн орлогч даргаар Онцгой байдлын газрын дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, нарийн бичгийн даргаар онцгой комиссын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, зөвлөлийн гишүүн 14 нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Байнгын ажиллагаатай зөвлөл 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2019 оны 4 дүгээр сарын 4-ны өдрийн хурлаар батлан хэрэгжилтийг Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газарт хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 63 дугаар тогтоол, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн аймгийн Засаг даргын 2018 оны 01-А/220 дугаар захирамжаар Дархан-Уул аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, ажиллах журмыг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хуралдаж үйл ажиллагааны төлөвлөгөөг хуралдсан. Энэ сард 2019 оны тайланг танилцуулах, 2020 оны зорилтоо тодорхойлхоор ажиллаж байна. Онцгой байдлын ерөнхий газар, Гамшгийн эрсдэлийн удирдлагын газартай 2019 оны 10 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд аймгийн гамшгийн эрсдэлийн тойм үнэлгээг сургалтад зөвлөлийн гишүүдийг сургалтад хамруулсан. Мөн зөвлөлийн дарга 2020 онд аймгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан судалгаа хийх зорилгоор 180 сая төг ирэх оны төсөв суулгахаар ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дархан-Уул аймаг/</i></p> <p>Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 5 дугаар сард аймгийн Онцгой байдлын газар, Гамшгаас хамгаалах албад, Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, олон нийтийн төлөөлөл бүхий 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр Дорноговь аймгийн нутаг дэвсгэрийн түвшинд Гамшгийн эрсдэлийн тойм судалгааг хийсэн байна. Тойм судалгааг Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх нийтлэг заавар”-ыг мөрдлөг болгож, тохиолдож болох аюулын 9 төрлөөр хийхэд газар хөдлөлт дунд, дундаас дээш түвшинд үнэлэгдсэн. Уг гамшгийн эрсдэлийн тойм судалгаанд тулгуурлан тус аймгийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан байна. Тойм судалгааны зөвлөмжинд тулгуурлан Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2020-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2020 онд боловсруулан батлуулахаар ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дорноговь аймаг/</i></p> <p>Ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны А/103 тоот захирамжаар Хэрлэн сумын хэмжээнд байгаа хуучин /нурсан болон эвдэрч гэмтсэн ашиглаагүй/ барилга байгууламжуудыг фото зургаар баталгаажуулан, эзэмшигчийг тодорхойлж, буулгах үүрэг өгч иргэдийн эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах орчинг бүрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дорнод аймаг/</i></p> <p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 6 сургуулийн барилгад газар хөдлөлтийн гамшгийн үнэлгээ хийгдсэнээс их эрсдэлтэй 5, дунд эрсдэлтэй 1, барилга байна. 20 эмнэлгийн барилгаас их эрсдэлтэй 3, дунд эрсдэлтэй 3, бага эрсдэлтэй 11, судалгаа хийгдээгүй 3 барилга байна. Одоогоор Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийг буулгах ажлыг эхлүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дундговь аймаг/</i></p>
--	--	---

		<p>Гамшгаас хамгаалах тухай хууль Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ыг үндэслэн Аймгийн Засаг даргын 2018 оны А/128 дугаар захирамжаар орон нутгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг 18 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж үнэлгээ хийх объектуудад Баян-Өндөр, Жаргалант сумын ган, зудын эрсдэлийн үнэлгээ, Үерийн далан сувгийн эрсдэлийн үнэлгээ, Хотын цэвэр усан хангамжийн эрсдэлийн үнэлгээ, Хотын цахилгаан эрчим хүчний хангамжийн эрсдэлийн үнэлгээ, Хот төлөвлөлт гэсэн 5 үндсэн чиглэлээр эрсдэлийн үнэлгээг хийсэн байна. Үерийн эрсдэлийн үнэлгээний тайланг 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр ажлын хэсгийн хуралдаанаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээний танилцуулгыг ажлын хэсэг танилцуулан 2018 оны 10 дугаар сарын 10-ний өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тус тус танилцуулан ажилласан байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Шанд, Рашаант, Наран багуудад "Өлзий хутгийн наран" ХХК, "Эрд Уул" ХХК, "Эрин гүрэн" ХХК-нуудаар 1500м үерийн усны инженерийн хийцлэл бүхий төмөр бетон угсармал сувгийг 564 559 678 /таван зуун жаран дөрвөн сая таван зуун тавин есөн мянга зургаан зуун далан найман мянган төгрөг/-ийг гарган гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн аваад байна. 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Баян-Өндөр сумын Яргуйт толгодын хэсэг, Эрдэнэ, Уртын гол зэрэг гэр хорооллын багуудад 4,6 км шороон сувгийг шинэчлэн засварлах ажлыг гүйцэтгэсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Орхон аймаг/</i></p> <p>2015 онд БХБЯ-ны захиалгаар Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн байгууламж шугам сүлжээний мэдээллийн сан боловсруулах ажлын зургыг Боригтэс ХХК, Геоценоз ХХК-ны түншлэл хийж БХБЯам болон ГХБХБГ-т тус тус хүлээлгэн өгөөд байна. Мэдээллийн сан үүсгэн жил бүр баяжилт хийж ажиллаж байна. 2017 оны эхний хагас жилийн байдлаар Аймгийн МХГ, Онцгой байдлын газартай хамтран Аймагт ашиглагдаж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, ЗДТГ-ын барилгуудын газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг тогтоосон. Аймгийн хэмжээнд олон нийт 282 барилга байгууламж үүнээс аймгийн төвд 94 барилга байгууламж ашиглагдаж байна. Аймгийн төвд нийт 13 барилга байгууламж газар хөдлөлтөнд тэсвэргүй үнэлгээ авсан барилга байгууламжийг хүчитгэх дахин төлөвлөх ажлыг зохион байгуулж ажиллах талаар БАЗ-ийн хурлаар хэлэлцсэн байна. 2018 онд ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан хот байгуулалтын мэдээлийн санг нэвтрүүлэх турших зорилгоор "Хот төлөвлөлт" программыг танилцуулах, хэрэглэх талаар орон нутгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах бүсчилсэн сургалтыг 2018 оны 10 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Улиастай суманд зохион байгуулсан. Сургалтад Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл аймгийн ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Завхан аймаг/</i></p> <p>Шинээр ашиглалтанд орсон болон өргөтгөл хийгдсэн инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг 2019 онд бүрдүүлэн ажиллаж байна.Үүнд: Барилга угсралтын ажлыг мэдээллийн санд 24 барилга, цахилгаан дамжуулах шугам сүлжээний ажил 12 ажлыг мэдээллийн санд оруулсан, гэрэлтүүлгийн 4 ажил, ЦБУ, ЦУ, Ариутгах татуурга, дулааны шугам сүлжээний 3 ажил, авто замын 2 ажил, Холбооны 1 ажил Тохижилтын 2 ажлыг тус тус мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэн координатуудыг мэдээллийн санд оруулсан. Шинээр баригдсан барилгын геодизын иж бүрэн хэмжилт / барилгын координат, өндөржилт, гадна шугам сүлжээнүүд цахилгаан , усан хангамж ариутгах татуурга, дулаан хангамж, холбоо дохиолол / хийлгэн мэдээллийн санд бүртгэн ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Өвөрхангай аймаг/</i></p> <p>Шинээр ашиглалтанд орсон болон өргөтгөл хийгдсэн инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг 2019 онд бүрдүүлэн ажиллаж байна.Үүнд: Барилга угсралтын ажлыг мэдээллийн санд 24 барилга, цахилгаан</p>
--	--	---

		<p>дамжуулах шугам сүлжээний ажил 12 ажлыг мэдээллийн санд оруулсан, гэрэлтүүлгийн 4 ажил, ЦБУ, ЦУ, Ариутгах татуурга, дулааны шугам сүлжээний 3 ажил, авто замын 2 ажил, Холбооны 1 ажил Тохижилтын 2 ажлыг тус тус мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэн координатуудыг мэдээллийн санд оруулсан. Шинээр баригдсан барилгын геоизын иж бүрэн хэмжилт / барилгын координат, өндөржилт, гадна шугам сүлжээнүүд цахилгаан , усан хангамж ариутгах татуурга, дулаан хангамж, холбоо дохиолол / хийлгэн мэдээллийн санд бүртгэн ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Сэлэнгэ аймаг/ /хэрэгжилт 70%/</p>
	<p>3.3. Хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотод ашиглагдаж байгаа 1970 оноос өмнө баригдсан олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга, дэд бүтцийн байгууламжуудад үзлэг, тооллого явуулж, паспортжуулах, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн нэмэлт арга хэмжээг үе шатаар эхлүүлэх</p> <p>/2015-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус паспортжуулалтын зөвлөл 21 аймагт байгуулагдаад байгаа. Үүний хүрээнд жил бүрийн төсөвтөө барилга байгууламжийг паспортжуулах ажлын төсвийг тусган ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Барилга, хот байгуулалтын яам/</p> <p>2019 онд олон нийтийн 13, соёл урлагийн 3, их дээд сургуулийн 14, эмнэлэгийн 3, ерөнхий боловсролын сургуулийн 29, цэцэрлэгийн 12, түүхийн дурсгалт барилга 2, нийт 76 барилгад биет хэмжилт судалгаа хийж, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргасан байна.</p> <p style="text-align: right;">/Онцгой байдлын ерөнхий газар/</p> <p>2011-2017 оны хооронд 2000 оноос өмнө баригдсан олон нийтийн орон сууны 524 барилгад газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийж, паспортжуулан хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэсэн байна. 2016 онд Барилгын тухай хууль шинэчлэгдэж барилгын салбарт мөрдөж буй дүрэм, журмууд өөрчлөгдөж Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинээр баталсан. Журмын 4 дүгээр хэсгийн 4.8 дугаар заалтад барилга, байгууламжийг паспортжуулах, мэргэжлийн дүгнэлт гаргах ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн эдгээд гаргана гэж заасан боловч барилгын тухай хуульд паспортжуулах, мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрлийн төрөл байхгүй. Журмын 5 дугаар хэсгийн 5.4-дбарилга, байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, паспортжуулах зардал, санхүүжилтийг өмчлөгч өөрөө хариуцахаар тусгаж өгсөн байна. Одоогоор өөрийн хөрөнгөөр паспортжуулах хүсэлт ирүүлсэн, иргэн аж ахуйн нэгж байхгүй байна. Тиймээс цаашид нийслэлийн төсвийн хөрөнгөөр журмын дагуу барилгын чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, паспортжуулах эрх зүйн үндэсгүй болсон учир ажлыг цааш үргэлжлүүлэх боломжгүй болсон байна.</p> <p>Нийслэлийн 2019 оны төсөвт барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийж, паспортжуулахад 250 сая төгрөг батлагдсаны хүрээнд төрийн өмчийн их, дээд сургуулийн 14, дунд сургуулийн 29, цэцэрлэгийн 12, эмнэлгийн 3, түүх, соёлын 2, олон нийтийн 16 нийт 76 барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, бат бэх найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргаж, паспортжуулсан байна. Түүнчлэн аж ахуй, нэгжийн хүсэлт, гэрээгээр 7 барилгад биет, хэмжилт судалгаа хийж, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, бат бэх найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулан хүлээлгэн өгөв. Үүнд: Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа-4, Нийслэлийн прокурорын газрын-1, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын харьяа-2 барилга байна.</p> <p style="text-align: right;">/НЗДТГ/</p> <p>Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын БТХУБ Л.Цэрэннямбуу, "Дэлгэрэх" СӨХ-ны дарга Б.Шагдарсүрэн Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын</p>

	<p>мэргэжилтэн Д.Оюунчимэг нартай хамтран 1970 оноос өмнө баригдсан Эрдэнэбулган сумын төвийн орон сууцны барилгуудад үзлэг шалгалт хийсэн байна. Шалгалтанд хамрагдаж буй орон сууцны барилга байгууламжуудын анхны зураг төсөв ,техникийн баримт бичгүүд ,барилга байгууламж,инженерийн шугам сүлжээний ашиглалтын чанар байдал барилгын үндсэн хийц ,бүтээцийг анхны төлөвлөлтөөс өөрчилсөн эсэх талаар шалгалтыг хийсэн байна. Дээрхи барилгууд модон хучилттай шал тааз өмхөрч муудсан газар хөдлөлтийн үйлчлэлд тэсвэрлэх чадваргүй,дотор пийшингийн тоомцсго үйрч унасан насжилтийн хэмжээ хэтэрсэн,ихэнх нь шургааг болон чулуун ханатай барилгууд байна. Иймээс дахин төлөвлөлтөнд оруулах арга хэмжээ авах шардлагатай байна. Эрдэнэбулган суманд дахин төлөвлөлтийг 4 байршилд төлөвлөөд байна. 1-р байршил:Эрдэнэбулган сумын 3-р баг “Ундарга” ТӨХК – ийн хойд талд байрлалтай Барилгын 16 - 1969 онд, Барилгын 6 айл - 1957 онд, Барилгын 16 айл - 1957 онд тус тус ашиглалтад орсон орон сууцны барилгууд дахин төлөвлөлт хийсэн газар хэмжээ 7320 м2, төлөвлөж буй орон сууц нь 12x24 хэмжээтэй 6 давхар 4 блок нийт 96 айл ба эзэмшилд төлөвлөгдсөн үйлчилгээний барилга нь 12x18 хэмжээтэй 6 давхар байхаар төлөвлөсөн байна.</p> <p>2-р байршил: Эрдэнэбулган сумын 3-р баг Нийтийн номын сангийн зүүн талд байршилтай Ахуй үйлчилгээний 16 – 1969 онд, Захиргааны 10 – 1960 онд тус ашиглалтад орсон орон сууцнууд хамрагдах ба дахин төлөвлөлтийг 15*24 хэмжээтэй 6 давхар 2 блок 72 айлын орон сууцтай худалдааны төвтэй байхаар төлөвлөсөн байна.</p> <p>3-р байршил: Эрдэнэбулган сум 3-р баг Шаргай төвийн зүүн талд Худалдааны 11 айлын орон сууц - 1946 онд ашиглалтанд орсон сууцнууд ба дахин төлөвлөлтийг 12x24 м хэмжээтэй 6 давхар 4 блок 96 айлын орон сууц байхаар төлөвлөсөн байна.</p> <p>4-р байршил: 3-р баг Нийгмийн даатгалын зүүн талд Баазын 17-р байр – 1946 онд ашиглалтад орсон /12 айлын сууц/. Дахин төлөвлөлтийг 12x20 м хэмжээтэй 6 давхар 3 блок, 70 айлын орон сууц, худалдааны төвийн барилгын хамтаар төлөвлөж, эхний ээлжинд 3-р байршлын төлөвлөлт, зургийн ажлыг аймгийн Засаг даргын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хөтөлбөрт тусгуулахаар санал оруулан орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд 20 сая төгрөгийг тусгуулсан байна. Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах” журмын дагуу 2018 онд барилга байгууламжийг паспортжуулах болон гэрчилгээжүүлэх ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан суурь судаллагааны ажил хийгдсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Архангай аймаг/</i></p> <p>Аймгийн хэмжээнд 1970 оноос өмнө баригдсан барилгуудын судалгааг гаргасан байна. Иргэний болон үйлдвэрийн барилга, дэд бүтцийн байгууламжуудад үзлэг, тооллого явуулах, паспортжуулах ажлыг зохион байгуулахаар Аймгийн Засаг даргын захирамжаар “Ажлын хэсэг” байгуулсан гарсан боловч газар хөдлөлтийг тэсвэрлэлтийг тооцох багаж, хэрэгсэл байхгүй, хөрөнгө зардал шийдэгдээгүй хэвээр байна. 1963 онд ашиглалтанд орж байсан 6 дугаар байрыг буулгаж шинээр 25 айлын орон сууцны барилгыг 2015 онд байнгын ашиглалтад оруулсан байна. Мөн 1964 онд ашиглалтанд орж байсан 8 дугаар байрыг буулгаж шинээр 57 айлын орон сууцны барилгыг барьж 2017 оны 2 дугаар сард ашиглалтад оруулсан. 2019 онд 1, 3 дугаар байрыг дахин төлөвлөлтөд оруулан буулган дахин барих ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Баянхонгор аймаг/</i></p> <p>Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар инженерийн хийцтэй бүх барилга байгууламжуудыг тусгайлан боловсруулсан үзлэг тооллогод хамруулан насжилт хэтэрсэн, газар хөдлөлийн эсрэг арга хэмжээ авагдаагүй, эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжийн хэсэгчилсэн үзлэгийг хийх ажлын хэсгийг томилгоожуулан ажиллаж эхлээд эхний удаад ашиглалтаас хасаж буулгах</p>
--	---

барилгуудын нэрсийг гарган МХЕГ-т 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/298 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

/Булган аймаг/

Тус ажлын хүрээнд 2019 оны байдлаар аймгийн 18 сумын хэмжээнд ашиглагдаж буй сургууль, цэцэрлэг, орон сууц, соёлын төв, эмнэлэгийн барилгын эдэлгээний зэргийг насжилт, барилгын хийц, бүтээцийн бат бэхийн үнэлгээг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар болон улсын мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэнүүд хамтран нурах барилгын эрсдлийн үнэлгээг гаргаллаа. Судалгаанаас 4 орон сууц, 2 соёлын төв барилга, 1 цэцэрлэг нурах эрсдэлтэй гэсэн дүгнэлт гаргасан байна.

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлөөс санаачлан “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг 2017-2019 онд Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-тай хамтран хэрэгжүүлэх төслийн хүрээнд “Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ”, “Инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн хохирлын үнэлгээ” сэдэвт сургалт 21 аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллах орон тооны бус зөвлөлийн архитектор, инженерүүд Улаанбаатар хотод 2018 оны 06 дугаар сарын 04-08-ны өдрүүдэд холбогдох салбарын архитектор, инженерүүд сургалтад хамрагдсан байна.

Шадар сайдын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 78 дугаар тушаалаар батлагдсан Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох паспортжуулах журмын дагуу А/106 тоот захирамжаар аймгийн засаг даргын дэргэд ажиллах “Орон тооны бус паспортжуулах зөвлөл” байгуулсан. Зөвлөлийн гишүүд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлөөс санаачлан 2017-2019 онд Япон болон олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-тай хамтран хэрэгжүүлэх төслийн хүрээнд “Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ”, “Инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн хохирлын үнэлгээ” сэдэвт сургалтад 2018 оны 6 дугаар сарын 4-8-ны өдрүүдэд хамрагдсан байна.

Төслийн хүрээнд “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”, “Угсармал хавтгаалжин төмөр бетон барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”, “Цутгамал төмөр бетон барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”, “Дэд бүтэц, инженерийн байгууламж, шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”-ыг батлагдсаны дараа “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-д зааснаар ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулах, дүгнэлт гаргах үйл ажиллагаа үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд уг дүрэм гарсаны дараа ажлын хэсэг ажиллахаар бэлтгэл ажлууд хийгдсэн байна.

/Говь-Алтай аймаг/

Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламжийн судалгааг шинэчлэх, нарийвчлан гаргахаар аймгийн Засаг даргын 2018 оны А/164 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулж, судалгааг эхний ээлжинд барилгын судалгааг гаргаад байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 110 гаруй барилга байна.

Аймгийн хэмжээнд 6 сургууль, 5 цэцэрлэг, 3 дотуур байр, 2 спорт заал, 6 эмнэлгийн барилга, 41 орон сууц байна.

2018 оны АОНХСангийн 15 сая төгрөгөөр Сүмбэр сумын эмнэлэг-3, сургууль-2, цэцэрлэг-2 нийт 7 барилга байгууламжид паспортжуулалтын ажлыг ШУТИС-ийн харьяа “Реконстракшн төв”-р хийлгэж байна. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн паспортжуулалтыг хийхээр 2019 оны улсын төсөвт 50.0 сая төгрөгийг батлуулаад ажлыг хэрэгжүүлэн ажилласан байна.

/Говьсүмбэр аймаг/

“Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг буруулахад олон нийтийн оролцоо ба хариуцлага” үндэсний семинарт Шадар сайдаас өгсөн үүрэг даалгаврын

		<p>ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан суманд орон сууцны зориулалтаар ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь Мэргэжлийн хяналтын "Улсын байцаагч"-ийн дүгнэлтээр тогтоогдсон Дархан сумын 4-р багийн 2, 3, 4, 5-р брак байрууд, 5-р багийн үндсэн тосгоны 42, 43, 46, 47, 48, 49, 50 дугаар брак байрууд, 6-р багийн үндсэн тосгоны 56, 57, 58, 59, 60, 61, 62, 63 дугаар брак зэрэг нийт 19 орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах талаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын Тэргүүлэгчдийн 98 дугаар тогтооллыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дархан сумын 5-р багт 35, 36 дугаар брак байруудыг буулган дахин төлөвлөн барилгажуулах тухай аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын төлөөлөгчдын 2019 оны 67 дугаар тогтоол гарсан. Дээрх ажлын хүрээнд 2018 онд 6-р багийн 61-р брак байрыг буулган орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3028,0 сая төгрөгний төсөвт өртөгтэйгээр 60 айлын 5 давхар барилгыг "Минж проперти" ХХК гүйцэтгэж 2019 оны 6-р сард ашиглалтад оруулсан байна. 2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дахин 60 айлын 5 давхар барилгыг барих шийдвэр гарсан байна. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2018 оны 03-р сарын 22-ны өдрийн 01-А/99 тоот захирамжаар орон нутагт ашиглаж байгаа барилга байгууламжийг паспортжуулах ажлын хэсэг байгуулагдсан байна. Аймгийн Засаг даргын орлогчийн 2018.06.19-ны өдрийн 1-10/562 тоот албан тоотой урилга хүргүүлсний дагуу паспортжуулах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуй нэгж байгууллага үнийн саналыг ирүүлсэн байна. 2018-2019 онуудад нийт 22 барилга байгууламжийг паспортжуулж гэрчилгээ олгосон. Үүнд: Эмнэлэг-1, Нийтийн орон сууц-4, Цэцэрлэг-3, Үйлдвэрийн барилга-1, Цэвэрлэх байгууламж-5, Дэд өртөө-9, Шашны сургууль-1, Үйлчилгээний барилга-1 байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дархан-Уул аймаг/</i></p> <p>Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлөөс ирүүлсэн 2017 оны 1/9 тоот албан бичгийн дагуу аймгийн хэмжээнд ашиглагдаж буй орон сууц, олон нийтийн зориулалттай 1061 барилга байгууламжийн судалгааг холбогдох маягтын дагуу гаргаж хүргүүлсэн байна. Орон сууцны тухай хууль, БХБЯ-ны Сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцны барилгыг буулган шинээр барих журам"-ын дагуу нийтийн орон сууцны оршин суугчдаас ирүүлсэн хүсэлт, гомдлоор ажиллах комиссын бүрэлдэхүүнийг МХГ-ын даргын 2018 оны А/22 дугаартай тушаалаар баталсан байна. Уг комисс нь сумдад ашиглагдаж байгаа хуучны нийтийн орон сууцны төлөв байдалд хамтарсан үзлэг шалгалтыг 2 удаа хийж, барилга байгууламжийн ашиглалтын байдалд үнэлгээ өгч, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангуулах ажлын хүрээнд Барилга техникийн хяналтын улсын байцаагчийн 34 дүгнэлтийг гарган ажилласан байна. Үүнд: Замын-Үүд суманд ашиглалтын шаардлага хангахгүй байгаа 3 орон сууц /35, 36 дугаар байр, 24 айлын орон сууц/, ЕБ-ын 1-р сургууль, Замын-Үүд НААҮ ОНӨ" ХХК-ийн барилга, Хатанбулаг сум ашиглалтгүй байгаа төрийн өмчийн түрээсийн 2 байр, Даланжаргалан сумын ЗДТГ, Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн барилга зэрэг болно. Дүгнэлт гарсан "Замын-Үүд НААҮОНӨ" ХХК-ийн албан конторын барилгыг засварлах, Замын Үүд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн барилгыг буулган, шинээр 540 хүүхдийн сургуулийн барилга барих зураг төсвийг "Гаргал" ХХК-аар хийлгэж улсын төсөвт тусгуулах, Иххэт суманд орон сууцны 13-р байрыг засаж сайжруулах, Сайхандулаан суманд сургуулийн барилгад дотор засвар хийх, 8 айлын орон сууцыг орон нутгийн хөгжлийн сангийн 230 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр барих зэргийг ажлыг хийж гүйцэтгэсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дорноговь аймаг/</i></p> <p>Монгол улсын Шадар сайдын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 78 дугаар тушаалын журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2018 оны 6 сарын 15-ны А/278 дугаартай Аймгийн Засаг даргын захирамжаар зөвлөл байгуулан газар хөдлөлтөд тэсвэргүй барилгын судалгааг гарган аймгийн хэмжээнд газар хөдлөлтөд тэсвэргүй орон сууцны барилга-4 эмнэлгийн барилга-3,</p>
--	--	---

сургуулийн барилга-2, цэцэрлэгийн барилга-6 гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан. Аймгийн 21 сургууль, 17 цэцэрлэгийн барилгыг газар дээр нь очиж үзэж дүгнэлт гаргахаар ажиллаж байна. Одоогоор аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 4 газарт гэрчилгээ олгоод байна. 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр 15 сумын төсвийн байгууллагын нягтлан бодогчийн сургалтаар барилга байгууламжид паспортжуулах талаар сургалт өгч, 2016 оны 2 сарын 5-ны өдрөөс хойш ашиглалтад орсон барилга байгууламжийг гэрчилгээгээ авах тухай тоотыг хүргүүлэн ажилласан байна.

/Дундговь аймаг/

Орхон аймагт 1970 оноос өмнө баригдсан барилга байхгүй. Орон нутагт ашиглагдаж байгаа захиргаа, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны барилга байгууламжуудын судалгааг шинэчлэн гаргаж “Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар”-т хүргүүлэв. Судалгаагаар нийтийн орон сууцны 174, Амины орон сууцны 95, худалдаа үйлчилгээний 15, цэцэрлэгийн 30, ерөнхий боловсролын 20, их дээд, тусгай дунд сургуулийн 5, эрүүл мэндийн 19, нийт 358 барилга байгууламж ашиглагдаж байгаа гэж гарсан байна. Аймгийн хэмжээнд 174 нийтийн орон сууцны барилга, 27 амины орон сууцны барилга, 30 цэцэрлэг, 20 сургуулийн барилга, эмнэлгийн 19 барилга, худалдаа үйлчилгээний 15 барилга, үйлдвэрлэлийн 5 барилга болон инженерийн байгууламж, хорооллын гэрэлтүүлэгийн 65, нийт 355 барилга байгууламж хувийн хэрэгжсэн дүн мэдээтэй байна. Барилгын ашиглалт, насжилт, засвар үйлчилгээ хийх хугацааг тодорхойлох, засвар үйлчилгээг сайжруулах, инженерийн шугам сүлжээний ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгөхөд хувийн хэрэг нээж хөтлөх, баяжилт хийж байх нь барилгад ач тустай болохыг тухайн барилга объектын ашиглагч, өмчлөгч байгууллагуудад сурталчилж, хувийн хэргийг хэрхэн хөтлөх талаар зөвлөмж үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Барилгын материалын сорил шинжилгээний лабораторийг ГХБХБГ-ын дэргэд 2014 оны 5-р сард байгуулан үйл ажиллагааг эхлүүлээд байна. Лабораторт барилгын дүүргэгч материал элс, хайрга, цемент, бетон болон тоосго, блокны физик чанарыг тодорхойлж ажиллаж байна. Тайлант жилийн хугацаанд 42 байгууллагын 280 дээжийг шинжилгээнд хамруулж дүгнэлт олгосон байна.

Барилга хот байгуулалтын яамны батлагдсан тарифаар тооцож 2017 онд 2,6 сая төгрөгийг лабораторийн шинжилгээний төлбөр хураамжаас орон нутгийг хөгжүүлэх санд төвлөрүүлсэн байна.

Лабораторийг итгэмжлэлийн хүрээний шаардлагын хүрээнд:

- Захиргааны 4 дүгээр байрнд байсан зарим нэг байгууллагыг зориулалтын 186м² талбай бүхий байранд нүүлгэн шилжүүлсэн,
- Тоног төхөөрөмжүүдийг суурилуулан эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан
- Лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээг элс, хайрга, дайрга, бетон, цемент гэсэн төрлөөр итгэмжлэгдсэн Барилгын материалын төв лабораторитой хамтран хийж гүйцэтгэсэн. Арга хэмжээний хүрээнд лаборатори хоорондын шинжилгээний үр дүнд өөрчлөлт байхгүй хэвийн ажиллагаатай гэж тодрхойлогдсон болно.
- Итгэмжлэлийн хүрээний чанарын гарын авлагыг боловсруулан “Стандарт, хэмжилзүйн газарт итгэмжлэлийн хүсэлтийг гаргасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах” хөтөлбөрийн хүрээнд инженерийн шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах зорилгоор Орхон аймгийн газар доорхи инженерийн шугам сүлжээний хайгуул тодотголыг гүйцэтгэсэн “Геоценоци” ХХК-ийн ажлыг хангагч байгууллагуудтай хамтран хянан шалгаж хүлээн авах бэлтгэл ажил хангагдсан байна.

/Орхон аймаг/

2012 онд Зам, Тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг”-ийг ГХБГЗЗ Газраас 600 ширхэг

	<p>номыг захиалан авч аймгийн хэмжээний бүх сумдад ашиглагдаж байгаа барилга байгууламжид үзлэг шалгалт хийж, заавар зөвлөмж өгч хувийн хэргийн хөтлөлтийг хийж эхлээд байна.</p> <p>Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит барилгуудаас гадна аж ахуй нэгжийн нийт 1000 гаруй барилга байгууламжууд ашиглагдаж байна. Үүнээс 17,4% нь хувийн хэрэг хөтлөгдсөн байна.</p> <p>Цаашид 2017 онд багтаан бүх барилгуудын хувийн хэргийн баяжилтыг хийж дуусгахаар төлөвлөж байна. 2017 онд Цагаанхайрхан суманд 22 барилга, Шилүүстэй суманд 18 барилга, Цэцэн-Уул суманд 13 барилга, Баянтэс суманд 40 барилга, Асгат суманд 6 барилга, Ургамал суманд 14 барилга, Тэс суманд 8 барилга шинээр паспортжуулан газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн зэрэглэлийг аймгийн МХГ-ын улсын байцаагчтай хамтран тогтоох ажлыг зохион байгууллаа. Цаашид барилга байгууламжийг паспортжуулах, хувийн хэрэг хөтлөх ажлыг албан байгууллага, аж ахуйн нэгж, МХГ, БХТ-тэй хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.</p> <p>2018 онд аймгийн МХГ, Онцгой байдлын газартай хамтран аймагт ашиглагдаж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, ЗДТГ-ын барилгуудын газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээг тогтоосон. Аймгийн хэмжээнд нийт 282 барилга байгууламжийн үнэлгээг тогтоосон байна. Үүнээс аймгийн төвд 94 барилга байгууламж ашиглагдаж байна. Аймгийн төвд нийт 13 барилга байгууламж газар хөдлөлтөнд тэсвэргүй үнэлгээ авсныг хүчитгэх дахин төлөвлөх ажлыг зохион байгуулж БАЗ-ын хурлаар хэлэлцсэн. 2018 оны ажлын төлөвлөгөөг батлан гаргасан. Эхний ээлжийн барилгуудын санхүүжилтыг шийдвэрлэж ажлыг эхлүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Завхан аймаг/</i></p> <p>1970 оноос өмнө баригдсан газар хөдөлтийн эсрэг арга хэмжээ авагдаагүй орон сууц, сургууль, Дотуур байр, цэцэрлэг, эмнэлэг, Соёлын төв зэрэг олон нийтийн барилгын судалгааг гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн. Тарагт сумын Дотуур байр, Соёлын төв, Бат-Өлзий сумын Соёлын төвийг буулгаж шинээр барьж ашиглалад орж эхлээд байна. Газар хөдлөлтөд тэсвэргүй орон сууцны барилгуудын төлөвлөлт, үндсэн бүтээц, хийцэд өөрчлөлт хийхгүй байх, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 4.1.3.3. газар хөдлөлтийг тэсвэрлэхгүй орон сууцны барилга байгууламжийг буулган оронд нь орон сууцны шинэ хороолол, цогцолбор барьж байгуулах зорилтын хүрээнд холбогдох байгууллагуудад асуудал тавьж шийдвэрлүүлэх талаар холбогдох СӨХ, сумдын Засаг дарга, Тамгын газарт албан тоот хүргүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Өвөрхангай аймаг/</i></p> <p>2018 оны 06 дугаар сарын 04-өөс 08-ны өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газар, Япон олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Барилга хот байгуулалтын яамны зүгээс хамтран “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”, Угсармал хавтгайлж нь төмөр бетон барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”, “Цутгамал төмөр бетон барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”, Дэд бүтэц инженерийн байгууламж, шугам сүлжээний газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”-ын норм дүрмүүдийг танилцуулах сургалт зохион байгуулагдаж тус сургалтад барилга байгууламжийг паспортжуулах, газар хөдлөлтийн үйлчлэлд тэсвэрлэх чадварыг үнэлэх ажлыг дээрх норм дүрмүүд батлагдсаны дараа мэргэжлийн хяналтын байгууллага болон эрх бүхий байгууллага гүйцэтгэх тухай чиглэл өгсөн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Өмнөговь аймаг/</i></p> <p>2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Барилга, хот байгуулалтын яам болон барилгын хөгжлийн төвд нийтийн орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн</p>
--	---

		<p>барилгын дэлгэрэнгүй судалгааг гаргаж хүргүүлсэн байна. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн орон сууцны болон эрүүл мэнд боловсролын нийт 71 барилга байгууламж байгаагаас 1970 оноос өмнө баригдсан Газар хөдлөлийг тооцож бариагүй нийт 17 барилгад хөндлөнгийн мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргуулан хүчитгэх шаардлагатай байна. Сэлэнгэ аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн орон сууцны болон эрүүл мэнд боловсролын нийт 295 барилга байгууламж байгаагаас 1970 оноос өмнө баригдсан Газар хөдлөлийг тооцож бариагүй нийт 58 барилгад хөндлөнгийн мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргуулан хүчитгэх шаардлагатай байна. 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Эрүүл мэндийн яам болон Барилгын хөгжлийн төвд эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжын дэлгэрэнгүй судалгааг гаргаж хүргүүлэв. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 47 объект ашиглагдаж байгаа бөгөөд тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээллийг судалгаагаар гаргаж хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын яамнаас 2019 оны 3 дугаар сарын 08-ны өдрийн №04/459 тоот албан бичгээр ирсэн маягтын дагуу шинээр болон ашиглагдаж байгаа орон сууцны судалгааг хүргүүлэн цаашид шаардлагатай байгаа хөрөнгийг аймгийн хэмжээнд шийдвэрлэхээр ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Сэлэнгэ аймаг/</i></p> <p>Увс аймгийн хэмжээнд нийтдээ 1955-1970 онд ашиглалтад орсон 32 барилга байна. Улаангом сумын 1964 онд баригдсан Цогцолбор 1-р 10 жилийн сургуулийн хичээлийн 1-р байрны барилга, 1957 онд баригдсан 4-р 10 жилийн сургуулийн төв байрны барилга, 1955 онд баригдсан "Ойрад" ХДТ-ын байрны барилга, 1964 онд баригдсан Аймгийн ЗДТГ-ын барилгуудыг буулгаж эхний ээлжинд шинэчлэн барих. Мөн 1,2-р 36 айл, 1,2,3-р 12 айлын орон сууцнуудыг дахин төлөвлөлтөнд оруулах асуудлыг шийдвэрлэхээр санал хүсэлтийг 2020 онд төсвийн тухай хуулинд тусгуулахаар хүргүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</i></p>
	<p>3.4. Барилга байгууламжийг загварчилж бодит байдалд турших, дүн шинжилгээ хийх, барилгын бүтээц болон түүний элементийг газар хөдлөлтөд турших, багаж, тоног төхөөрөмж бүхий лабораторитой болгох, ашиглагдаж байгаа туршилтын багаж, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх</p> <p>/2009-2014 он Хэрэгжилт 70%/</p>	<p>ОБЕГ дээр хэрэгжиж буй JICA олон улсын байгууллагын төслийн хүрээнд 2019 онд барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг үнэлэх 5 багц иж бүрдэл багажийг БХБЯ, МХЕГ, НЗДТГ, БХТ, ГЗБГЗЗГ гэсэн байгууллагуудад хүргүүлэн, тус байгууллагууд барилга байгууламжийг паспортжуулах болон үнэлэх ажилдаа ашиглаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Барилга, хот байгуулалтын яам/</i></p> <p>Нийслэлд ашиглагдаж байгаа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн нийт 301 барилгаас 2019 онд 20 барилгад паспортжуулалтын дүгнэлт хийгдэж байна. Үүнд: Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэг, 98 дугаар цэцэрлэг, Сонгинохайрхан дүүргийн 86 дугаар сургууль, 12 дугаар сургууль, 84 дүгээр цэцэрлэг, Баянзүрх дүүргийн 85 дугаар сургууль, энэрэл эмнэлэг, 61 дүгээр цэцэрлэг, 8 дугаар цэцэрлэг, Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургууль, 56 дугаар цэцэрлэг, 9 дүгээр цэцэрлэг, Сүхбаатар дүүргийн хөгжим бүжгийн коллеж, 40 дүгээр цэцэрлэг, 75 дугаар цэцэрлэг, Хан-уул дүүргийн 12 дугаар цэцэрлэг, Налайх дүүргийн голомт цогцолбор сургууль, эрүүл мэндийн төв, 23 дугаар цэцэрлэг гэсэн 19 барилгад газар дээр хийсэн биет хэмжилт, судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулах ажил хийгдсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/НЗДТГ/</i></p> <p>Засгийн газрын 2017 оны 229 дүгээр тогтоолоор аймгийн "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв"-ийн барилгыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт шилжүүлж барилгын засварыг улсын төсвийн 126.6 сая төгрөгөөр "Гуулин-Эрдэнэ" ХХК-аар гүйцэтгүүлж, ашиглалтад оруулсан байна.</p> <p>Одоогийн байдлаар лабораторит пресс, шигшүүр, конус суулт, шмитын алх нийт 4 ширхэг тоног төхөөрөмж байгаа нь барилгын материалын сорилт, шинжилгээ хийхэд боломжгүй мөн материалын итгэмжлэл авахад шаардлага хангахгүй байна. Иймд барилгын материалын сорилт</p>

		<p>шинжилгээний лабораторид зайлшгүй шаардлагатай 14 ширхэг тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган УИХ-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвд хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгөх хүсэлтийг хүргүүлсэн байна. Орон нутагт хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх боломжгүй байна.</p> <p>Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилгын ажлыг улсын төсвийн 952.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Агни трейд” ХХК-аар гүйцэтгүүлж зоорийн болон 1 давхрын цутгалт, 2 давхрын арматурын хэв хашмалын ажил хийгдсэн бөгөөд барилга угсралтын явц 70.0 хувьтай байна. Энэ онд инженерийн шугам сүлжээний хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй бөгөөд 2019 онд Шадар сайдын багцад тусгуулах саналыг аймгийн Засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 1/1006 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">/Говь-Алтай аймаг/</p> <p>Даланзадгад сумын нийтийн орон сууцны барилгад үзлэг шалгалт, судалгаа хийж ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй 4 барилгыг тогтоож Барилга техникийн хяналтын улсын байцаагчийн актлах шийдвэр гарсан. Даланзадгад сумын 1, 2, 4, 9 дүгээр нийтийн орон сууцны барилгуудыг ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүйг тогтоож Барилга техникийн хяналтын улсын байцаагчийн актлах шийдвэр гарсан байна.</p> <p>Газар хөдлөлтөд тэсвэргүй ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 2-р орон сууцыг “Говийн өгөөж” ХХК, 3-р орон сууцыг “Хос бор морь” ХХК, 9-р орон сууцыг “Гурван бухат” ХХК шалгарч хуучин орон сууцны буулгалтын ажлыг бүрэн дуусгаж, тус газар дээр шинээр баригдах орон сууцыг эхлүүлсэн. Одоогийн байдлаар 2, 3-р орон сууцны шинээр баригдах орон сууцны ажлын явц 20 хувь, 9-р орон сууцны шинээр баригдах орон сууцны барилгын ажлын явц 65 хувьтай гүйцэтгэсэн байна.</p> <p style="text-align: right;">/Өмнөговь аймаг/ /Хэрэгжилт 70%/</p>
	<p>3.5. Эрдэс баялаг, уул уурхайн томоохон цогцолборуудыг дагаж байгуулагдах суурин газрын газар хөдлөлтийн эрсдэлийг тогтоосон баримт бичиг боловсруулах</p> <p>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Одон орон геофизикийн хүрээлэнгээс 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2017 онд 4 станц суурилуулж газар хөдлөлтийн чичиргээг нарийвчилсан судалгааг хийж газар хөдлөлтийн эрсдэлийг тогтоосон баримт бичиг боловсруулсан байна.</p> <p style="text-align: right;">/Өмнөговь аймаг/ /Хэрэгжилт 70%/</p>
	<p>3.6. Эрүүл мэнд болон боловсролын байгууллагын барилгын даац, бат бэх, газар хөдлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээ хийх</p> <p>/2010-2014 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн Байнгын хорооны 2018 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хамтарсан 05/13 дугаар тогтоолын хүрээнд Улсын хэмжээнд 3500 гаруй эрүүл мэндийн байгууллага байгаагаас 50 орчим хувь нь 1990 оноос өмнө ашиглалтад орсон эмнэлэгийн барилга байгууламжууд байгаагаас ашиглалтын шаардлага хангахгүй газар хөдлөлтөд тэсвэргүй 70 барилга байгууламж, боловсролын салбарт 3196 барилга байгаагаас ашиглалтын шаардлага хангахгүй газар хөдлөлтөд тэсвэргүй 181 барилга байгууламж тус тус байгаа бөгөөд буулган шинээр барихад 542 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн судалгаа гарсан байна. Уг асуудлыг жил бүрийн Улсын төсвийн тухай хуулинд тусгах чиглэлийг Засгийн газарт хүргүүлсэн бөгөөд 2020 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар саналаа хүргүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">/Барилга, хот байгуулалтын яам/</p> <p>МХЕГ-ын даргын баталсан 01/140 дүгээр удирдамжийн дагуу Булган аймгийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгуудын ашиглалтын төлөв байдал нь хууль, норматив, стандартын хэрэгжилтийг хангаж буй эсэхийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, эрсдэлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж ажилласан байна.</p>

	<p>Булган аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа, барилга байгууламжид хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, барилга байгууламжид эрсдэлийн үнэлгээ хийлгэх, албан шаардлага бичиж, Булган сумын 1-р сургууль, ХАА-н нэвтрүүлэх байр, Могод сумын ЗДТГ-зэрэг барилгад дүгнэлт гарган ажилласан байна. Мэргэжлийн хяналтын газраас Барилгын ашиглалтыг зогсоох улсын байцаагчийн акт 3, барилгын ашиглалтын төлөв байдлыг тодорхойлсон дүгнэлт 5-г үйлдэж, МХЕГ-ын барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг шалгалтанд хамрагдсан байгууллагуудад өгч үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллахыг зөвлөсөн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Булган аймаг/</i></p> <p>Тус ажлын хүрээнд аймгийн 18 сумын хэмжээнд ашиглагдаж буй сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн барилгын эдэлгээний зэргийг насжилт, барилгын даац бат бэхийн үнэлгээг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар болон улсын мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэнүүд хамтран нурах барилгын эрсдлийн үнэлгээг урьдчилсан байдлаар 1 цэцэрлэг нурах эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан байна. Мөн барилгын даац бат бэхэд үнэлэлт дүгнэлт өгөх Засаг даргын дэргэдэх орон тооны бус паспортжуулалтын зөвлөл барилгын эрсдлийн үнэлгээ гаргах тусгай эрх бүхий зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн судалгааг гаргаж үнийн санал авч байгаа бөгөөд үүний хүрээнд эрүүл мэндийн болон боловсрол, соёл, төрийн байгууллагуудын барилгын эрсдлийн үнэлгээ гарсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Говь-Алтай аймаг/</i></p> <p>Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламжийн судалгааг шинэчлэх, нарийвчлан гаргахаар аймгийн Засаг даргын 2018 оны А/164 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулж, судалгааг эхний ээлжинд барилгын судалгааг гаргаад байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 110 гаруй барилга байна.</p> <p>Аймгийн хэмжээнд 6 сургууль, 5 цэцэрлэг, 3 дотуур байр, 2 спорт заал, 6 эмнэлгийн барилга, 41 орон сууц байна.</p> <p>2018 оны АОНХСангийн 15 сая төгрөгөөр Сүмбэр сумын эмнэлэг-3, сургууль-2, цэцэрлэг-2 нийт 7 барилга байгууламжид паспортжуулалтын ажлыг ШУТИС-ийн харъяа "Реконстракшн төв"-р хийлгэж байна. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн паспортжуулалтыг хийхээр 2019 оны улсын төсөвт 50.0 сая төгрөгийг батлуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Говьсүмбэр аймаг/</i></p> <p>Мэргэжлийн хяналтын газраас аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн чиглэлийн 34 барилга байгууламжаас 826 барилга байгууламж бага эрсдэлтэй, 9 барилга байгууламж дунд эрсдэлтэй дүгнэгдсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дархан-Уул аймаг/</i></p> <p>Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй боловсролын байгууллагуудыг судалгааг Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн. Нийт эмнэлэг, цэцэрлэг, сургууль, орон сууцны барилгын 27% нь насжилт өндөртэй, барилгын нийт бат бэх болон газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар буурсан байна. 2019 оны 12 дугаар сарын 5-ны байдлаар аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны 25/358, 25/428 дугаар албан бичиг, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Төмөр замын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, АШУУИС-ийн харъяа Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургууль нийт 8 сургуульд гамшгийн эрсдэлийн тойм судалгааг хийж ажилласан байна. Тойм судалгаагаар тус сургуулиудын барилгын даац, бат бэх, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар бага, газар хөдлөлтийн эрсдэл их түвшинд үнэлэгдсэн. Гамшгийн эрсдэлийн тойм судалгаанд үндэслэн газар хөдлөлтийн эрсдэлийг</p>
--	---

бууруулах зөвлөмж гаргаж, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг тухайн сургуулиудад үүрэг болгосон байна.

/Дорноговь аймаг/

Эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын барилга, орон сууцнуудын бат бэхийг шалгах, барилгын хувийн хэргээр хангах ажлыг зохион байгуулж байна. Аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран сургууль, цэцэрлэг, соёлын төвийн 140 гаруй захирал, эрхлэгч нарт барилгын хувийн хэргийг хэрхэн хөтлөх талаар болон, барилгын хувийн хэргийг хөтлөх ямар ашиг тустай талаар сургалтыг зохион байгуулж орон нутгийн өмчийн барилга байгууламжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

/Дорнод аймаг/

Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран 2014 онд эрүүл мэндийн барилга байгууламжуудын судалгааг бүрэн хийж мэдээллийн сан үүсгэн ба 2015 онд Цагаанхайрхан сумын эрүүл мэндийн төвийн засвар 210 сая, аймгийн яралтай тусламжийн тасгийн засвар 190 сая төгрөгийн засварын ажлууд хийгдсэн ба Асгат суманд 15 ортой эмнэлгийн барилга ашиглалтанд оруулан хүлээн авсан байна. 2016 онд Баянхайрхан, Тэс, Цэцэн-Уул сумдын эрүүл мэндийн төвийн засвар, Сонгино суманд шинээр эрүүл мэндийн төв барих санал холбогдох гаруудад хүргүүлсэн байна.

2016 онд Цагаанчулуут, Улиастай суманд 320 хүүхдийн хичээлийн байр, Улиастай, Завханмандал суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Тосонцэнгэл суманд 500 хүний суудалтай соёлын төв, МСҮТ-ийн спорт заал, Ургамал, Эрдэнэхайрхан, Тосонцэнгэл сумд НИК ШТС-ийн барилга, Улиастай суманд 20 айлын орон сууц шинээр баригдаж ашиглалтанд ороод байна. Завхан аймгийн Дөрвөлжин сумын хичээлийн байр спорт заал, Баянтэс сумын 75 хүүхдийн дотуур байр, Улиастай сумын Жавхлант сургуулийн хичээлийн байрны засвар, Нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийн цусны салбар төвүүдэд засвар шинэчлэлийн ажил хийгдсэн байна.

/Завхан аймаг/

Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа эрүүл мэнд боловсролын байгууллагын судалгааг холбогдох хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлсэн ба 2011 оноос Газар хөдлөлийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар БД 31-103-00-ийн дагуу газар хөдлөлтийн тэсвэрлэлтээр нь ангилж хувийн хэрэгжүүлсэн. 11 сард болсон "Барилгын газар хөдлөлт, тэсвэрлэлтийн үнэлгээнд ашиглагдах багажны танилцуулах сургалтад 2 мэргэжилтэн хамрагдсан байна.

/Өвөрхангай аймаг/

Онцгой байдлын ерөнхий газартай хамтран 2018 онд нийтийн зориулалтын барилгын судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийж ажиллаа. Эрүүл мэнд болон боловсролын байгууллагын барилгын даац, бат бэх, газар хөдлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээг хийгдсэн байна.

/Өмнөговь аймаг/

2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Барилга, хот байгуулалтын яам болон барилгын хөгжлийн төвд нийтийн орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгын дэлгэрэнгүй судалгааг гаргаж хүргүүлсэн байна. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн орон сууцны болон эрүүл мэнд боловсролын нийт 71 барилга байгууламж байгаагаас 1970 оноос өмнө баригдсан Газар хөдлөлийг тооцож бариагүй нийт 17 барилгад хөндлөнгийн мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргуулан хүчитгэх шаардлагатай байна. Сэлэнгэ аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн орон сууцны болон эрүүл мэнд боловсролын нийт 295 барилга байгууламж байгаагаас 1970 оноос өмнө баригдсан Газар хөдлөлийг тооцож бариагүй нийт 58 барилгад хөндлөнгийн мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргуулан хүчитгэх шаардлагатай байна. 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Эрүүл мэндийн яам болон Барилгын хөгжлийн төвд эрүүл

		<p>мэндийн байгууллагын барилга байгууламжын дэлгэрэнгүй судалгааг гаргаж хүргүүлэв. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 47 объект ашиглагдаж байгаа бөгөөд тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээллийг судалгаагаар гаргаж хүргүүлсэн. 15 сумын төр, төсвийн байгууллагуудын барилга байгууламжийн ашиглалт болон насжилт тухайн барилгад гарсан эвдрэл гэмтлийн талаарх судалгааг авч ажилласан байна.</p> <p>15 сумын 62 барилга байгууламжид үзлэг шалгалт хийснээс барилгын зориулалтаар авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> - Цэцэрлэгийн барилга – 18 - Спорт заалны барилга – 2 - Сургуулийн барилга – 12 - Эмнэлэгийн барилга – 13 - Соёлын төвийн барилга – 14 <p>Хийсэн үзлэг шалгалтаар: Ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга байгууламж 2 байна. Үүнд:</p> <p>1. Хүдэр сумын эрүүл мэндийн төвийн барилга 1985 онд баригдсан. 2017 онд орон нутгийн хөгжлийн сангаар эмнэлгийн морго баригдсан. Эмнэлгийн модон шалыг хуулж бетон шал болгосон байна. Барилгын баруун хойд булангийн гадна хананд цууралт үүсэж ангайсан. Барилгын дулааны шугамын суваг цөмөрснөөс ус барилгын суурь руу нэвчиж сууринд суулт үүсгэсэн. Өнгөлгөөний тоосго үйрч бутарсан. Сууринд суулт өгснөөр цонхны шил цуурч хагарсан байдалтай яаралтай арга хэмжээ авахгүй бол барилга нурах аюултай байдал үүссэн байгаа тул мэргэжлийн хяналтын газраас дүгнэлт гаргуулж шинээр эмнэлэгийн барилга бариулах шаардлагатай байна.</p> <p>Дээрхи ажлын хүрээнд хийгдсэн 13 эмнэлгийн барилгын ажлаас шинээр баригдахаар 2019 оны улсын хөрөнгөөр № XVI.1.43 Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Хүдэр сум/ 2019-2020 онд баригдахаар нийт 705.0 сая төгрөг батлагдсан бөгөөд 2019 онд санхүүжих нь 300.0 сая төгрөг тусгагдсан. Мөн № XVI.1.42 Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Мандал сум, Түнхэл тосгон/ 2019-2020 онд баригдахаар нийт 1,200.0 сая төгрөг тусгагдсанаас 2019 онд 650.0 төгрөгөөр санхүүжигдэхээр улсын төсөвт тусгагдсан байна.</p> <p><u>Боловсролын салбарын хүрээнд:</u> Орхонтуул сумын 1 –р багийн сургуулийн барилга Сургуулийн дээврээс их хэмжээний ус гойждог. Сургуулийн барилгын урд хэсгийн сууринд суулт өгч гадна хананд хагарал өгсөн. Мөн барилгын хойд хэсэгт хагарал өгсөн. Барилгын хаяавч зарим газарт байхгүй. Урлаг заалны дээврийн мөгийн хавтан хагарсан. Сургуулийн хойд урд хэсэгт даацын 380 мм хана нэвт хагарч цуурсан байдалтай байна.</p> <p>Аймгийн мэргэжлийн хяналтын газрын барилга техникийн улсын байцаагчийн дүгнэлт гарч тухай барилга байгууламжид үйл ажиллагаа явуулахыг түр хугацаагаар зогсоосон. 2019 оны улсын төсөвт № XI.1.2.12 Сургуулийн барилгын дээврийн их засвар/Сэлэнгэ, Орхонтуул сум, 2 дугаар сургууль/ 2019 онд 55.4 сая төгрөгийн төсөв тусгагдсан. Мөн зориулалтын бус барилга байгууламжид үйл ажиллагаа явуулж буй 4 барилга</p> <ul style="list-style-type: none"> ▪ Алтанбулаг сум Дамбо цэцэрлэг, ▪ Орхон сумын дотуур байр, ▪ Орхонтуул сум Рашаант тосгоны цэцэрлэг ▪ Хүдэр сумын Соёлын төвийн барилга <p>Орхон сумын дотуур байрны барилга 2019 оны улсын төсөвт № XI.1.1.187 Дотуур байрын барилга, 75 ор /Сэлэнгэ, Орхон сум/ 2019-2020 онд нийт 1,500.0 сая төгрөг тусгагдсанаас 2019 онд 750.0 төгрөг батлагдсан. Зайлшгүй засвар үйлчилгээ хийгдэх шаардлагатай 9 барилга байгууламж байна. Үүнд :</p> <ul style="list-style-type: none"> ▪ Сайхан сумын 24- р цэцэрлэг
--	--	--

		<ul style="list-style-type: none"> ▪ Орхонтуул сумын Рашаант тосгоны сургууль ▪ Хушаат сумын сургууль ▪ Мандал сумын “Олимп” цэцэрлэг ▪ Баруунбүрэн сумын цэцэрлэгийн барилга ▪ Баруунбүрэн сумын сургуулийн барилга ▪ Хушаат сумын сургуулийн барилга ▪ Баянгол сумын сургуулийн барилга ▪ Алтанбулаг музейн барилга зэргийг тус тус засварлах шаардлагатай байна. <p>2019 оны улсын төсөвт № XI.1.2.14 Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Орхонтуул сум, 1 дүгээр сургууль/ 2019 онд 450.0 төгрөг тусгагдсан . Мөн № XI.1.2.15 Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Хушаат сум/ 2019 онд 600.0 сая төгрөгийн засвар тусгагдсан.</p> <p>Мөн № XI.1.2.11 Бага сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Цагааннуур сум/ 2019 онд 107.0 сая төгрөгийн засварын ажил тусгагдсан.</p> <p>Дээрхи барилгуудаас гадна боловсролын салбарын барилгын хүчин чадлын хүрэлцээ шаардлагаар шинээр баригдахаар улсын төсөвт № XI.1.1.186 Дотуур байрын барилга, 60 ор /Сэлэнгэ, Түшиг сум/ 2019-2020 онд баригдахаар нийт 1,000.0 сая төгрөг тусгагдсанаар 2018 онд 700.0 сая төгрөг, № XI.1.1.177 Дотуур байрын барилга, 100 ор /Сэлэнгэ, Сант сум/ 2019-2020 онд баригдахаар нийт 2,000.0 төгрөг тусгагдсанаас 2019 онд 1,100.0 сая төгрөг , № XI.1.1.225 Сургуулийн өргөтгөлийн барилга, 120 суудал /Сэлэнгэ, Зүүнбүрэн сум/ 2019-2020 онд баригдахаар нийт 1,500.0 сая төгрөг тусгагдсанаар 2019 онд 750.0 сая төгрөг тусгагдсан. № XI.1.1.231 Сургуулийн спорт заалын барилга /Сэлэнгэ, Алтанбулаг сум/ 2019-2020 онд нийт 1,200.0 сая төгрөг тусгагдсанаас 2019 онд 800.0 сая төгрөг, №XI.1.1.295 Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 3 дугаар баг/ 2019-2020 онд баригдахаар нийт 1,558.0 сая төгрөг төсөвт тусгагдсанаас 2019 онд 1,000.0 сая төгрөг тусгагдсан байна.</p> <p>/Сэлэнгэ аймаг/</p> <p>Итгэмжлэлийн хүрээнд 2018 онд 12 компани бетон шоо 228ш дээж, үл эвдэх 3, элс нь 3 дээж, хайрга 2 дээж блок 2 дээж, тоосго 2 дээж шинжилгээ хийсэн. Үүнээс "Арвижих -Увс"ХХК түргэн сумын 320 хүүхэдийн сургууль барилга 1.2-р давхар багана, дам нуруу бетон шоо, "Зоос- импекс "ХХК 3-р багт 75 хүүхэд цэцэрлэг 15 хоногтой баган шоо, "ДМТМ"ХХК 2.4-р баг 150 хүүхэдийн цэцэрлэг барилга багана бетон шоо, "Ундарга констракшн" ХХК 12-р багт 150 хүүхдийн барилга шугам суурь, багана, дам нурууны бетон шоон дээр тус тус шинжилгээ хийсэн байна.</p> <p>/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</p>
	<p>3.7. Хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын 1:1000-аас доошгүй масштабтай газрын дижитал зургийн санг байгуулах</p> <p>/2009-2014 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах” ажлыг улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2013-2015 онд “Бориг тэс” ХХК, “Геоценоз” ХХК-ууд хамтран гүйцэтгэсэн. 19 аймгийн төв, томоохон хот, суурин газруудын шугам сүлжээний 1:1000 масштабтай байр зүйн тоон зураглал дээр тухайн суурин газрын ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн нарийвчилсан мэдээллийг боловсруулж мэдээллийн санг тус яамны сервер дээр байрлуулсан байна. Энэ ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн мэдээллийн сан 21 аймгийн мэдээллийн санг нэгтгэн нэг мэдээллийн сан болгох ажил хийгдсэн байна.</p> <p>/Барилга, хот байгуулалтын яам</p> <p>/Хэрэгжилт 70%/</p>
<p>4 дүгээр зорилтын хүрээнд: Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах.</p>		
	<p>4.1. Газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны</p>	<p>Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/120 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын дагуу нийслэл, дүүргийн Газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны</p>

<p>төлөвлөгөөг томоохон хот суурин газар бүрээр боловсруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх</p> <p>/2009-2014 он хэрэгжилт 70%/</p>	<p>төлөвлөгөөг 2019 онд шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэн ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/НЗДТГ/</p> <p>Аймгийн засаг даргын 2011 оны 02 сарын 15-ны өдрийн а/48 тоот захирамжаар Аймгийн гамшгаас хамгаалах албад мэргэжлийн анги байгуулсан байна. Үүнд: Мэргэжлийн анги албадууд ,сум бүрт гамшгаас хамгаалах штаб зохион байгуулж ,бэлэн байдлын төлөвлөгөө гаргуулан ажиллаж байна .2018 онд мэргэжлийн алба ангиуд “Яаралтай цуглар” зарлан мэдээллийн серень дохиогоор 5 удаа ажиллуулж хувийн болон автомашин техникийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж хүн нэг бүрийн үүргэвч, багаж хэрэгсэлд үзлэгшалгалт хийж байгууллагын бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажилласан.Тус газар нь 3 сарын 29-нд байгууллагын зүүн талд гарч бэлэн байдлыг хангуулж ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Архангай аймаг/</p> <p>Байнгын ажиллагаатай зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн түвшинд зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэж байхаар төлөвлөн аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-д газар хөдлөлийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах бэлэн байдлыг хангах ажиллагаанд төв орон нутгийн жилийн төсвийн тодорхой хувийг зарцуулж байх санал оруулахаар ажиллаж байна. Цаашид төлөвлөгдөж байгаа аймгийн төв, Хутаг-өндөр, Рашаант, Бугат зэрэг томоохон суурингийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хот суурин газрын дахин хөгжүүлэх тухай хууль, холбогдох дүрэм, журмыг үндэслэн ашиглалтын улаан гэрчилгээ бүхий барилга байгууламжийг буулган, шинээр барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулах ашиглалтын шаардлага хангахгүй барилгын дахин төлөвлөлтийг тусгах чиглэлийг өгч ажлын зургийн даалгаварт тусгуулаад байна. Булган аймгийн нутаг дэвсгэр дээр байгаа 17 суурин газруудаас 3 сумаас бусад нь газар хөдлөлийн 8,9 баллын бүсэд байршдаг бөгөөд газар хөдлөлийн эрсдэл багатай бүсийн судалгааг гаргаж тухайн бүсэд барилга төлөвлөх талаар асуудал дэвшүүлэх нь хүндрэлтэй бөгөөд харин баригдах барилгуудын чанарт онцгой анхаарах шаардлагатай байна. Үүнээс гадна угсралт их засварын ажилд бат бэхийн талаас анхаарах анхаарлыг нэмэгдүүлэн бүх материалыг лабораторид өөрсдийн зүгээс шинжлүүлэх талаар онцлон анхаарч байна. Булган сумын орон сууцны 1960 аад оны үед баригдсан барилгуудад инженерийн биет үзлэг хийлгэхээр холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх чиглэлээр ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Булган аймаг/</p> <p>Аймгийн Засаг дарга Монгол Улсын Шадар сайдтай байгуулсан гэрээний дагуу тус аймагт Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулагдахад аймгийн онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллагуудын газар хөдлөлтийг гамшгийн үед ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийж бэлэн байдлыг хангуулсан байна.</p> <p style="text-align: right;">/Говь-Алтай аймаг/</p> <p>Аймгийн хэмжээнд тус газрын 2019 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн А/865 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах орон нутгийн албаны ажиллах нийтлэг журам”, “Гамшгаас хамгаалах орон нутгийн албаны удирдлагын бүтэц”, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дүгээр сарын 17-ны өдрийн 75 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн ангийн дүрэм” зэргийг мөрдлөг болгон 2 гамшгаас хамгаалах алба, 2 мэргэжлийн анги, 3 сумын, 22 байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийлгэн заавар зөвлөмж өгч, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангуулан ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Говьсүмбэр аймаг/</p>
---	--

	<p>Аймгийн засаг даргын 2019 оны 01-А/91 дүгээр захирамжаар байгуулагдсан гамшгийн эрсдэлийн тойм судалгаа гаргаж, аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, 2019 оны 10 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газартай хамтран аймгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын дагуу гамшгийн эрсдэлийн тойм судалгааг хийсэн байна.</p> <p>Эрсдэлийн тойм судалгаан дээр үндэслэн аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу боловсруулан Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын мэргэжилтнээр хянуулан, 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр аймгийн Засаг даргаар баталгаажуулан ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дархан-Уул аймаг/</i></p> <p>“Говийн чоно-2019” гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургууль, гамшгаас хамгаалах Иж бүрэн болон Команд штабын сургуулийн хүрээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд гамшгаас хамгаалах 11 алба, 21 тусгай зориулалтын мэргэжлийн анги, 14 сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшгийн үед дайчлан ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийж ажилласан байна.</p> <p>Аймгийн Онцгой байдлын газар, Гамшгаас хамгаалах албад, Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, олон нийтийн төлөөлөл бүхий 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр Дорноговь аймгийн нутаг дэвсгэрийн түвшинд Гамшгийн эрсдэлийн тойм судалгааг хийсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дорноговь аймаг/</i></p> <p>Аймгийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2019 оны 5 дугаар сард шинэчлэн боловсруулж, аймгийн Засаг дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга нараар батлуулсан бөгөөд хавсралт төлөвлөгөөнд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, бэлэн байдлыг дээшлүүлж ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дорнод аймаг/</i></p> <p>Аймгийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого төлөвлөлт хамтын ажиллагааны газрын Стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хянуулан аймгийн Засаг дарга, ОБЕГ-ын даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. 2019 онд Улиастай сумын Богдын гол багийн Политехник коллежийн оюутан сурагчдад болон ажилчдад объекын гал түймэр, газар хөдлөлтийн үед өөрийгөө аврах бусдад үзүүлэх анхны тусламж гал унтраагуур ашиглалт “Тактикийн сургуулийн” үйл явцыг ажлын зураг дээр тайлбарлаж дадлагажуулах сургалтыг зохион байгуулсан байна. Сургалтад 41 багш 246 оюутан нийт 287 хүн хамрагдсан. Мөн Улиастай сумын Жинст, Өлзийт, Чигэстэй, Товцог, Жаргалант, Богдын гол багийн ард иргэд, Баруун бүсийн худалдааны төвийн түрээслэгч нарыг 339,340 тогтоолын талаар мэдээлэл хийж үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 08 тоот “Хүн нэг бүрийн үүргэвчинд байх зүйл”-ийг танилцуулан ард иргэдийг серинь дохио 3 удаа дуугарахад багийн цугларах талбайд үүргэвчтэй цугларах талаар сургалт сурталчилгаа зохион байгуулж нийт 1200 хүн хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Завхан аймаг/</i></p> <p>2017 оны 3-р сард Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийн баг аймагт ирж ажиллан 2 дугаар сард гаргаж хүргүүлсэн барилга байгууламжын судалгааны мэдээллийг газар дээр нь ирж танилцан сургалт семинар хийн аймгийн онцгой комисстой хамтран ажилласан. Сэлэнгэ аймгийн Засаг даргын захирамж гарган ажиллаж байна. Тус захирамжийн 1-р хавсралтаар гамшгийн эрсдлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, 2-р хавсралтаар гамшгийн эрсдлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн</p>
--	--

	<p>ажиллах журам тус тус батлагдан ажиллаж хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Сэлэнгэ аймаг/</i></p> <p>"Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх зорилгоор Төв аймагт байнгын ажиллагаатай зөвлөлийг аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр 25-ны өдрийн А/38 тоот захирамжаар байгуулж, зөвлөлийн ажиллах журам, зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөг 4 зорилт, 27 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Төв аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/610 дугаартай захирамжаар аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулалтыг зохион байгуулах шийдвэрийн дагуу Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг ОБЕГ-тай хамтран 2018 оны 10 дугаар сарын 27-ноос 11 дүгээр сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан байна.</p> <p>Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулалт 2018 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 06.20 минутад сирень дохио дугарч, онцгой комисс, мэргэжлийн анги, салбар, цагдаа цэргийн бие бүрэлдэхүүн нь тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлын жагсаал, хувийн бэлтгэл байдлыг танилцуулсан. Мөн өдрийн 10.00 цагаас эхлэн эрэн хайх, аврах үзүүлэн сургуулалтад мэргэжлийн анги бүрэлдэхүүн, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй оролцож, үүрэг гүйцэтгэсэн байна.</p> <p>Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төслийн хүрээнд "Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ" сэдэвт сургалт семинар 2018 оны 6 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд Барилгын хөгжлийн төв, Япон улсын JICA төсөл хамтран "Монгол улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн сургалтад 1 мэргэжилтэн</p> <p>БХБЯ, ОБЕГ, Япон улсын ЖАЙКА төсөл хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд "Дэд бүтэц, Инженерийн байгууламж, шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал"-ыг боловсруулах ажлын хүрээнд барилгын дүрэм болон үнэлгээний аргачлалын сургалтад хамрагдсан байна.</p> <p>БХБЯ, БХТөв, японы ЖАЙКА төслөөс 2018 оны 11 сарын хамтран зохион явуулсан "Монгол улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд "Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээнд ашиглагдах багаж" сэдэвт сургалтад 2 мэргэжилтэн хамрагдсан</p> <p>Зохион байгуулж ажилласан тайланг хагас бүтэн жилээр холбогдох газруудад хүргүүлэн ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Төв аймаг/</i></p> <p>2018 онд аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, 19 сум, гамшгаас хамгаалах 11 алба, 38 мэргэжлийн анги, 296 албан газар аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж хүч хэрэгслийг дайчлан ажиллах төлөвлөгөөг шинэчлэн хийж баталгаажуулж, төлөвлөгөөтэй уялдуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгасан байна.</p> <p>Газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн төвийн Улаангом суманд боловсруулан ажиллаж байна.</p> <p>Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/290 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь тус аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан, Наранбулаг, Завхан, Өлгий, Өмнөговь, Тариалан, Улаангом, Түргэн зэрэг сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан. Бэлэн байдлын үзлэгт дээрх 10 сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн 1135 томилгоот бие бүрэлдэхүүн, 25 автомашин, 126 техник хэрэгсэл хамрагдсан байна.</p> <p>Тус үзлэгийн үеэр сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион</p>
--	--

		<p>байгуулж ажил, гамшиг аюулт үзэгдэлтэй тэмцэх чадамжинд үнэлгээ дүнгнэлт, заавар зөвлөмж өгсөн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</i></p>
	<p>4.2. Гамшгаас хамгаалах алба, аймаг орон нутагт явуулдаг газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага, сургалтад холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах, болзошгүй гамшгийн үед ажиллах хамтын ажиллагааг сайжруулж, газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлэх</p> <p>/2009-2014 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Болзошгүй гамшгийн аюулаас хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын томилгоот бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, гамшгийн үеийн хүч хэрэгсэл, харилцан ажиллагааг сайжруулах зорилгоор Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах тухай нийслэлийн Засаг даргын А/41 дүгээр захирамжийн хүрээнд Багануур, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Нүүлгэн шилжүүлэлт, Тээвэр зохицуулах алба, Холбоо зарлан мэдээллийн алба, Багахангай, Баянгол, Хан-Уул дүүргүүдэд нийслэлийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, Газар зохион байгуулах алба, Барилга хот байгуулалт, түр орон байраар хангах алба, Хүнсээр хангах алба зэрэг гамшгаас хамгаалах албадад удирдах бүрэлдэхүүний сургалтыг тус тус зохион байгуулж, байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/НЗДТГ/</i></p> <p>Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/184 тоот “Хяналт шалгалт, сургалт зохион байгуулах тухай” захирамж, удирдамжийн дагуу 15 сум нэг тосгоны иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан хаагчдад гарч байгаа гамшиг осол, аюулт үзэгдэл, гал түймрийн тоо хохиролыг бууруулахын тулд гамшгаас хамгаалах болон газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, дадлагыг зохион байгууллаа. Сургалтад нийт 994 ажилтан, алба хаагч, 154 сурагч, 214 иргэд хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Булган аймаг/</i></p> <p>Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулагдах үеэр гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын газар хөдлөлтийн үед хамтран ажиллах аврах ажиллагааны дадлага сургуулийг зохион байгуулж гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Говь-Алтай аймаг/</i></p> <p>Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/130 дугаар тушаалаар баталсан сургалтын хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сард баталсан “Говьсүмбэр аймагт 2018 онд зохион байгуулах гамшгаас хамгаалах ангиллын сургалтын нэгдсэн төлөвлөгөө”, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ангиллын сургалтыг: Удирдах бүрэлдэхүүний сургалт: 4 удаа 5 цаг 30 минутын сургалтыг 141 удирдах албан тушаалтанд, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн: 2 удаагийн 10 цагийн сургалтыг 86 томилгоот бүрэлдэхүүнд, Ажилтны: 57 удаагийн 99 цаг 30 минутын сургалтыг 1443 ажилтан, албан хаагчид, Оюутан, сурагчдын: 11 удаагийн 21 цагийн сургалтыг 3530 оюутан сурагчдад. Иргэдийн: 20 удаагийн 29 цагийн сургалтыг 1105 иргэнд танхимын болон дадлага хэлбэрээр зохион байгууллаа. Дээрх сургалтыг зохион байгуулахад аймгийн Улаан загалмайн хороо, Дэлхийн зөн ОУБ-ын Бор-Өндөр-1 ОНХХ, тухайн аж ахуйн нэгж байгууллагын дарга нар хамтран ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Говьсүмбэр аймаг/</i></p> <p>Аймгийн Засаг даргын 2017 оны 01-А/83 дугаар захирамж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/323 дугаар тушаал “Гамшгаас хамгаалах Иж бүрэн” сургууль зохион байгуулах зааврын дагуу Хонгор суманд “Команд штаб”-ын сургуулийг 2019 оны 5 дугаар сарын 22-23-ны</p>

	<p>өдрүүдэд, “Орхон суманд “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийг 2019 оны 10 дугаар сарын 30-31-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын даргын 2019 оны А/35, А/65 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг тус тус зохион байгуулсан байна.</p> <p>Хонгор сум: “Команд штаб”-ын сургууль Команд штабын сргуулийн цагийн байдлыг Хонгор сумын сумын 2 дугаар баг “Нам даваа” гэдэг газар ой хээрийн түймэр, Бог малын гоц халдварт мялзан өвчин гарсан цагийн байдал дээр удирдах бүрэлдэхүүнийг ажилуулж, шийдвэрийг Засаг дарын ажлын зурагт оруулж илтгэлүүдийг 12, 24, 96 цагаар сонсож заавар зөвлөмж өгч ажилласан байна.</p> <p>Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн төлөөлөгөөний дагуу Хонгор сумын Үрийн агуулахын урд талын 63 метрийн урттай үерийн даланг цэвэрлэж нийт 28 кг хог цэвэрлэж аюулгүй байдлыг ханган ажилласан байна.</p> <p>Сургуулийн удирдагч Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/323 дугаар тушаал Гамшгаас хамгаалах “Иж бүрэн” болон “Команд штаб”-ын сургууль зохион байгуулах зааврын дөрөвдүгээр бүлгийг удирдлага болгон дундын хянагч нарын дүнг үндэслэн Хонгор суманд зохион байгуулсан Гамшгаас хамгаалах “Команд штаб”-ын сургуулийг 91 хувь “А” буюу “Маш сайн” үнэлгээтэйгээр дүгнэгдсэн.</p> <p>Орхон сум: “Иж бүрэн” сургууль Штабын дадлага сургуулийг сумын Онцгой комиссын гишүүд, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүний дунд орон нутагт үүсэж болзошгүй, бодит нөхцөлд ойртуулсан “Газар хөдлөлт”, “Хүн малын гоц халдварт өвчин” гэсэн зохиомол 2 цагийн байдал өгч удирдлагын шийдвэр гаргалт, харилцан ажиллагаа, шийдвэрийн зурагт оруулсан байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний илтгэлийг бүлэг тус бүрээр, нэгдсэн илтгэлийг Засаг даргаас ажлын хэсэг сонгож, сургуулийн удирдагч, штабын дарга нар заавар зөвлөмж өгч ажиллалаа.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор сумын төвийн орон сууцны хорооллын иргэдийг нүүлгэн шилжүүлэх дадлагыг сургуулийн 2 дахь өдөр буюу 2019 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 10:55 цагт зохион байгуулахад орон сууцны хорооллын иргэдийн 88,9 хувь буюу нийт 271 иргэн хамрагдсан.</p> <p>Газар хөдлөлтийн гамшгийн дараа төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх боломжийг үзүүлэх зорилгоор сумын Онцгой комиссын хээрийн удирдлагын байр, эрүүл мэндийн үйлчилгээ, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг тасралтгүй явуулах боломжийг иргэдэд олгосон байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дархан-Уул аймаг/</i></p> <p>Аймгийн Засаг даргатай байгуулсан жилийн үр дүнгийн гэрээ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу “Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын дадлага, сургууль зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2018 оны А/177 дугаар захирамж гарч, 1.4 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэн “Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль, дадлага”-ыг Баян-Уул суманд 2018 оны 05 дугаар сард, иж бүрэн дадлага сургуулийг 10 дугаар сард Сэргэлэн суманд “Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үеийн удирдлага, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, аж ахуйн нэгж, байгууллагын харилцан ажиллагаа” сэдвээр астраномийн 48, оперативийн 120 цагийн багтаамжтай 3 үе шаттайгаар зохион байгуулсан байна. Тус сургуульд сумын гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн 181 хүн, 16 автомашин хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дорнод аймаг/</i></p> <p>Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 11-р сарын 30-ны өдрийн 339, 340-р тогтоолоор батлагдсан журмуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ОК-ын гишүүдэд мэдээлэл хийж гамшгаас хамгаалах, алба мэргэжлийн ангиудын удирдлага, сумдын Засаг дарга, аж ахуй нэгж байгууллагын дарга эрхлэгч</p>
--	--

	<p>нарт сургалт явуулж, сургуулийн үед зохион байгуулах ажлын удирдамж, төлөвлөгөө гарган, аймгийн “Зарлан мэдээлэл дохио дамжуулах журам”-ыг шинэчилэн боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан 2019 оны 9 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан байна.</p> <p>Дадлага сургуулилтад: Аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах 9 алба, 24 мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, болон аймгийн төвийн 6 багийн нийт 3688, ард иргэд, 24 сумдын алба мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, 112 багийн ард иргэд 8312, нийт 12000 хүн, хамрагдан оролцсон байна.</p> <p>Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу Идэр, Яруу сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, Нөмрөг, Түдэвтэй сумдад, команд штабын сургууль, Цагаанчулуут суманд гамшгаас хамгаалах иж бүрэн сургалтыг хэлтсийн даргын баталсан удирдамж хөтөлбөрийн дагуу 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдөр зохион явуулж, дээрхи сургуулиудаар сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, сумын онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, штабын удирдах бүрэлдэхүүн, сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, аж ахуйн нэгж байгууллагуудын дарга эрхлэгч ард иргэд оролцсон байна.</p> <p style="text-align: right;"><i>/Завхан аймаг/</i></p> <p>Байнгын ажиллагаатай зөвлөл, Жайка олон улсын байгууллага, Онцгой байдлын ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг холбогдох судалгаанд үндэслэн олон нийтийн барилга байгууламж, нийтийн болон хувийн орон сууц, гэр, бусад барилга, инженерийн болон цахилгааны шугам сүлжээний газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг 2019 онд хийсэн байна. Газар хөдлөлтийн ерөнхий үнэлгээгээр тус аймгийн төвд 9 баллын газар хөдлөлт болоход нийт 1439 барилгаас хийц бүтцийн хувьд 1, 4.2 дугаар зэрэглэлийн 37 барилгын 5.2 хувь, 7.1 дүгээр зэрэглэлийн 15 барилгын 17 хувь, 8 дугаар зэрэглэлийн 11 барилгын 30 хувь, 9 дүгээр зэрэглэлийн 1342 барилгын 50 хувь, 11 дүгээр зэрэглэлийн 23 барилгын 50 хувь, 12.2 дугаар зэрэглэлийн 11 барилгын 70 хувь нь буюу нийт 697 барилга нурах, эвдрэх эрсдэлтэй гэж гарч байна. Тус барилга, орон сууцанд амьдарч буй 1320 өрхийн 4488 иргэний амь нас, эрүүл мэндэд хохирол учрах магадлалтай гарсан байна. Иймд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг ажлын хэсэг зааврын дагуу боловсруулж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Өмнөговь аймаг/</i></p> <p>“Монгол улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл” –ийн хүрээнд Барилга хот байгуулалтын яамны зүгээс “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”, “Угсармал хавтгаалжин төмөр бетон барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал”, “Цутгамал төмөр бетон газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал” –ыг боловсруулж байгаатай холбогдуулан дээрх барилгын дүрмүүдийг танилцуулах сургалтыг 2018.06.04 -2018.06.08-ны өдрийн хооронд Барилгын хөгжлийн төвд зохион байгуулсан бөгөөд сургалтад холбогдох мэргэжилтэн Л.Мөнх-Одыг хамруулсан байна. 2018 оны 12 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан “ Гамшигт тэсвэртэй хот байгуулалт” сургалтад аймгийн Ерөнхий архитектор Б.Хангал хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Сэлэнгэ аймаг/</i></p> <p>Аймгийн Засаг даргын 2018 оны А/83 дугаар захирамжаар аймгийн Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийг шинэчлэн зохион байгуулсан. Тухайлбал: - Аймгийн хэмжээнд Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж, мэдээлэх, Эрүүл мэндийн, Хүнс, хөдөө аж ахуйн, Эрчим хүчээр хангах, Дулаанаар хангах, Санхүү, Зам тээвэр, Барилга, хот байгуулалт, Мэргэжлийн хяналт, Хэв журам сахиулах, Мэдээлэл, харилцаа холбоо зэрэг 11 алба, 19 суманд Эрүүл мэндийн алба, Хэв журам сахиулах</p>
--	---

		<p>албыг зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах албадын томилгоонд 343 албан тушаалтан томилогдсон байна.</p> <p>Аймгийн тусгай зориулалтын мэргэжлийн ангийг 37 албан газар, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны онцлогт нь тохируулан мэргэжлийн 67 анги, бүлэг, хэсгийг 943 томилгоот бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж тушаал шийдвэрийг гаргуулсан байна.</p> <p>Сумдын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг дотор нь мэргэжлийн ангийн удирдлага, холбоо, тандалтын бүлэг, аврах бүлэг, механикжуулсан бүлэг, эмнэлгийн бүлэг, хэв журам сахиулах бүлэг, мал хамгаалах бүлэг, сайн дурын бүлэг зэрэг бүлэг хэсэгтэйгээр ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг 71 албан тушаалтны томилгоот бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах 49 алба, тусгай зориулалтын 219 мэргэжлийн анги, бүлэг, хэсгийн бүрэлдэхүүнд 2635 албан тушаалтан томилогдоод байна. Мөн холбооны хэрэгсэл /гар станц, суурин утас/ 174 ширхэг, анхны тусламжийн цүнх 149 ширхэг, замын цагдаагийн багаж хэрэгсэл 8, суудлын автомашин 207, ачааны автомашин 85, тусгай зориулалтын автомашин 55, механизм 69, бусад багаж хэрэгсэл 1596 ширхэг байхаар тодотгол хийгдсэн байна.</p> <p>Монгол Улсын Шадар Сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг хангах, Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн түвшинд удирдлага зохион байгуулалтаар хангах, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги, төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил иргэдийнхарилцан ажиллагааг уялдуулах зорилгоор аймгийн Онцгой комиссоос “Газар хөдлөлтийн аюулын үеийн орон нутгийн удирдлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан байна.</p> <p>Аймгийн Засаг даргын “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлыг хангах тухай” 2018 оны 07 тоот албан даалгавар, аймгийн Онцгой байдлын газрын даргын 2018 оны 34/353 дугаар албан тоотын дагуу Улаангом сумын иргэдийг 4 цэгт нүүн шилжүүлэх талаар гарын авлага материал 25500 ширхэгийг бэлтгэн олшруулж 12 багийн айл өрх, иргэн бүрт хүргэх ажлыг Онцгой байдлын газрын албан хаагч, Улаангом сумын багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг дайчлан нийт 350 ухуулагчийг бэлтгэн мэргэжил, арга зүйгээр хангаж 12 баг болгон зохион байгуулж явуулсан байна.</p> <p>Нүүн шилжих дадлага сургуульд Улаангом сумын нийт 31012 хүнээс 22102 буюу 71.2 хувь нь хамрагдсан байна.</p> <p>Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдлэг чадвар олгох үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж 2018 онд иргэд, олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны нэгдсэн арга хэмжээний хүрээнд иргэдэд аливаа аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, өөрийгөө болон бусдыг аврах дадлага эзэмшүүлэх зорилгоор Улаангом сумын 12 багийн 25854 иргэдэд “Бэлэн бай” сэдэвт сургалтыг зохион байгуулж явуулсан байна.</p> <p>НҮБ-ын гамшгийн эрсдэлийг бууруулах газар, ОБЕГ-ын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газартай хамтран “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ, баримт бичгийг орон нутагт хэрэгжүүлэх нь” сэдэвт баруун бүсийн сургалтыг тус аймгийн Онцгой байдлын газарт зохион байгуулж явуулсан. Сургалтад баруун 5 аймгийн 25 албан тушаалтан оролцсон байна.</p> <p>Хил залгаа Завхан, Ховд, Баян-Өлгий аймгуудтай Гамшгийн үед болон болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар хамтран ажиллах гэрээг 2 жилийн хугацаатай байгуулсан байна.</p> <p>“Онцгой байдлын үед” хамтран ажиллах гэрээний төслийг аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газар, аймгийн Засаг дарга, гамшгаас хамгаалах 11 албад, тусгай зориулалтын мэргэжлийн 67 анги, бүлэг, хэсэг бүхий 44 албан газар, аж ахуйн нэгж байгууллага нарт хүргүүлж тухайн байгууллагуудын саналыг гэрээндээ тусгаж байгуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</i></p>
--	--	---

<p>4.3. Газар хөдлөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардлагатай багаж хэрэгслийг буцалтгүй тусламж, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хамруулан шинэчлэх арга хэмжээ авах</p> <p>/2015-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд 50.0 сая (114.2 тэрбум төгрөг) еврогийн үнэтэй хээрийн эмнэлгийг 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газар хүлээн авсан байна.</p> <p>-Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), Онцгой байдлын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-өөс бетоны бат бэх байдал хамжигч, хэт авианы долгион хэмжигч, зэврэлт хэмжигч, бетоны хамгаалалтын үе хэмжигч, өрөгт бүтээцтэй барилгын тоосгоны бат бэх хэмжигч 293.0 сая төгрөгийн үнэ бүхий 5 төрлийн 5 иж бүрдэл багажийг Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн, нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Барилгын хөгжлийн төвд 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр хүлээлгэн өгсөн байна.</p> <p>-Мөн нийслэлийн Онцгой байдлын газрын харьяа Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд 1.7 тэрбум төгрөгийн үнэтэй газар хөдлөлтийг биеэр мэдрэх төхөөрөмжийг 2019 оны 03 дугаар сарын 21 өдөр хүлээлгэн өгсөн. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ард, иргэдийн сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулж, нийт 17837 хүнд үйлчилсэн байна.</p> <p>/Онцгой байдлын ерөнхий газар/</p> <p>Улаанбаатар хотод Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн 04 дүгээр сард зохион байгуулсантай холбогдуулан бэлтгэлийг хангах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор нисгэгчгүй нисэх төхөөрөмж, цахилгаан үүсгүүр, байршил тогтоогч, камер, гэрэлтүүлэгч, хөдөлгөөнт болон суурин станц, эвхдэг ор, асар зэрэг нийт 277 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, барааг материалаар гамшгийн бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах техник, тоног төхөөрөмжийн нөөцийг нэмэгдүүлсэн байна. Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгө болон төсвийн хөрөнгө оруулалтаар 1,1 тэрбум төгрөгийн шууд дамжуулах дэлгэц, гар станц, суурин станц, асар майхан, цахилгаан үүсгүүр, хээрийн гал тогоо, УАЗ-22069 маркийн фургон автомашин 2, 4 дугуйтай квадрат цикл 2, ланд круйзер 200 авто машин 1, үүргийн гал унтраагуур 100 ширхгийг авч техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлсэн байна. Бүгд найрамдах Солонгос улсын Сөүл хотын Гал, гамшгаас хамгаалах газрын буцалтгүй тусламжаар 22 сая төгрөгийн 4 ширхэг Соната-7 маркийн автомашин, Скай хайпермаркет ХХК-аас 43 сая төгрөгийн үнэ бүхий аврах тавцан 1 ширхэг, хорт хий утаанаас хамгаалах баг 7 ширхгийг хандив тусламжаар хүлээн авсан байна.</p> <p>/НЗДТГ/</p> <p>Аймгийн ОБХ-т ямар нэгэн төсөл хөтөлбөрт хамрагдаагүй.Засгийн газрын хөтөлбөрийн дагуу ОБЕГ-аас 31,0 сая төгрөгний пурган машиныг аймгийн ОБГ-т өгсөн. Мөн аймгийн Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгө оруулалтаас 26,0 сая төгрөг шийдвэрлэж Шуурхай удирдлагын зарлан мэдээлэх төв байгуулсан байна. Цэнхэр сумын сургуулийн захиргаанд Дэлхийн зөн олон улсын байгууллагын буцалтгүй тусламжаар гал түймрийн бэлэн байдлыг хангах зорилгоор 5 төрлийн 20 багаж хэрэгсэл олгосон байна.</p> <p>/Архангай аймаг/</p> <p>ОБЕГ-аас тус аймгийн Онцгой байдлын газарт газар хөдлөлтийн гамшгийн үеийн эрэн хайх, аврах ажиллагааны багаж /Гар болон автомат ажиллагаатай таслагч, тэлэгч, өргөгч дэр, шөнийн гэрэлтүүлэг гэх мэт/ хэрэгслүүдээр 2015, 2016, 2017, 2018 онуудад шинээр нөхөн хангалт хийсэн байна.</p> <p>/Баянхонгор аймаг/</p>
--	--

		<p>2019 оны бүтэн жилд газар хөдлөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардлагатай багаж хэрэгслийн хангалт хийгдээгүй байна.</p> <p style="text-align: right;"><i>/Баян-Өлгий аймаг/</i></p> <p>2018 оны 3 сард Булган сумын арван хоёр жилийн 1-р сургуулийн нийт багш ажилтан, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламжын газар хөдлөлт, орон байрны галын аюулгүй байдлыг хэрхэн хангах, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг хэрхэн ашиглах талаар мэдлэг олгох танхимын сургалтыг 2 цагийн багтаамжтай хийсэн байна. Мөн 1, 6, 7-р цэцэрлэгийн багш ажилчдад аюулгүй амьдрах ухааны танхимын болон газар хөдлөлтийн аюулын үед авч хэрэгжүүлэх ажиллагааг дадлагын сургалтаар зохион байгуулж ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Булган аймаг/</i></p> <p>Аймгийн Онцгой комиссоос өгсөн үүргийн дагуу 18 сумын "Гамшгийн сан"-нд 10.000.000 төгрөгөөс доошгүй төгрөгийг төсөвт суулгаж, /болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, осол/, газар хөдлөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардлагатай багаж хэрэгслийг шат дараатай бүрдүүлэхээр ажиллаж байна. Газар хөдлөлтийн гамшгаас авран хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд аймаг, сумын орон нутгийн жилийн төсөвс тусгаж ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна. 2018 онд аймгийн гамшгийн санд 150.0 сая төгрөг төсөвлөгдсөнөөс 50.0 сая төгрөгөөр 116 тонн өвс, 48.9 сая төгрөгөөр 88 тонн хивгэн тэжээл нийлүүллээ. 2019 оны аймгийн гамшгийн санд 100.0 сая төгрөг, Есөнбулаг 8.0 сая, үлдсэн 17 сумд 10 сая төгрөг төсөвлөөд байна.</p> <p style="text-align: right;"><i>/Говь-Алтай аймаг/</i></p> <p>Газар хөдлөлтийн болзошгүй аюулт үзэгдэл техникийн холбогдолтой осол, гал түймэр гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох үеийн хүч хэрэгслийн чадавхыг дээшлүүлэх чиглэл дээр онцгой анхаарч тайлант жил орон нутгийн хөрөнгө оруулалт дэмжлэгээр шуурхай албаны туулах чадвар сайтай Ланд круизер загварын /70,000,000 төгрөг/ автомашин 1 ширхэг, шуурхай албаны туулах чадвар сайтай УАЗ 22069-033 загварын /21,400,000 төгрөг/ автомашин 1 ширхэг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Онцгой байдлын ерөнхий газрын хангалтаар гал түймэр унтраах үндсэн албаны тусгай зориулалтын MAN S/M2-3 загварын /623,835,855 төгрөг/ автомашин 1 ширхэг, ой хээр гал түймэр, эрэн хайх аврах ажиллагааны зориулалттай туулах чадвар сайтай Yamaha Grizzly 700 загварын 38,000,000 дөрвөн дугуйт мотоцикль 1 ширхэг, урсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагааны үе ашиглагдах дөрвөн хүний хийлдэг хөдөлгүүрт завь 1 ширхэг зэрэг нийт 5 нэгж 753,235,855 төгрөгийн өртөг бүхий техник хэрэгслийг орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар татан авсан нь онцгой байдлын газрын техик хэрэгслийн чадавх өссөн буюу техникийн бэлэн байдал дээшилсэн үзүүлэлттэй байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дархан-Уул аймаг/</i></p> <p>Газар хөдөлсөн нөхцөлд цацраг химийн аюулыг үнэлж мэдээлэх мэргэжлийн ангийг бэлэн байлгах, яаралтай цугларах, бэлэн байдлын үед цацраг хэмжигч RDS-110 багажаар орчны цацрагийг хэмжиж, аймаг орон нутгийн удирдлага, Онцгой комисс, Онцгой Байдлын Газар, Гамшгаас хамгаалах албад, штабын дарга нарт хурдан шуурхай мэдээлэх үүрэгтэй ажилладаг байна. Цаашид газар хөдлөлтийн гамшиг, цацраг химийн аюулыг үнэлж мэдээлэхэд ашиглах багаж төхөөрөмж нь өдөр цаг тутам шинэчлэгдэж байгаа тул буцалтгүй тусламж, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хамруулан сүүлийн үеийн нарийвчлал өндөртэй хэмжих хэрэгслээр хангах шаардлагатай байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дорнод аймаг/</i></p>
--	--	--

	<p>Гамшиг осол тохиолдсон үед ажиллах мэргэжлийн ангиудад ажлын чадавхыг дээшлүүлэх үндсэн дээр нэг ширхэг том оврын Эксковатор авахуулах саналыг аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлж, ОНХС-ийн хөрөнгөөр 130 сая төгрөгөөр худалдан авч Билэгт-Уудам ХХК хүлээлгэн өгсөн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дундговь аймаг/</i></p> <p>Орхон аймгийн хэмжээнд гамшиг осолтой тэмцэх, хор хохиролыг арилгах, хотын доторх, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор Хот тохижуулах газарт унверсал трактор 1, хүнд даацын ачаа тээврийн хово маркын авто машин 3-ийг 400 гаруй сая төгрөгөөр худалдан авсан. Баян-Өндөр суманд шинээр Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг дээшлүүлэх, алба хаагчдын бэлэн байдлыг хангах зорилгоор ажлын байрыг 45 000 000 /дөчин таван сая төгрөг/, Гал түймэр унтраах, аврах 81 дүгээр ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор 37 сая төгрөгөөр шуурхай албаны автомашин байрлуулах, сургалт дадлага зохион байгуулах талбайг барьж байгуулсан. Үер усны үед ашиглах ус соруулах мотопомп 3 авч бэлэн байдалд байлгаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Орхон аймаг/</i></p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Даланзадгад сумын ерөнхий боловсролын 2, 4, 5, 7, Цогтцэций сумын 6, "М.Борын нэрэмжит" сургуулийн нийт багш ажилчид, сурагчдад зохион байгуулсан байна. Тус дадлага сургуульд 147 бүлгийн 3870 сурагч, 465 багш ажилчид хамрагдаж, газар хөдлөлтийн аюулын үед "СУУ, НУУГД, ХҮЛЭЭ" зарчмыг баримтлан, чичирхийлэл намдсаны дараа аюулгүй зай талбайд нүүн шилжих дадлага сургуулийг зохион байгуулсан.</p> <p>Зарлан мэдээллийн дуут дохиогоор аймгийн Онцгой комисс, Гамшгаас хамгаалах албад, Даланзадгад сумын мэргэжлийн ангиудыг нутгийн удирдлагын ордны Даян хааны талбайд жагсааж, машин техник, багаж зэвсэглэмж, хүн нэг бүрийн хээрийн үүргэвчний бэлтгэл бэлэн байдлыг шалгасан байна.</p> <p>Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургалт зохион байгуулах тухай орон нутгийн 3 телевизэд, Монгол говь сонин, facebook хуудас болон eoffice.omnogobi.gov.mn цахим мэдээллийн сүлжээнд дэлгэрэнгүй мэдээ мэдээллийг өгч ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Өмнөговь аймаг/</i></p> <p>2013 онд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажилласнаар “Тогтвортой амьжиргаа” төслөөс 4655000 төгрөгний усны сав, Аэлхийн зөн олон улсын байгууллагаас 18,600,000 төгрөгийн үнэ бүхий гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмжүүдийг хүлээн авч үүрэг гүйцэтгэхэд ашиглаж байна.</p> <p>2014 онд монгол улсын Төрийн өмчийн хорооны 2014 оны 02 сарын 13-ны өдрийн 86 дугаар тогтоолоор “Мал индексжүүлсэн даатгал” төслөөс нийтдээ 18,700,175 төгрөгний үнэ бүхий тоног төхөөрөмж олгосоноос 15,865,527 төгрөгийн үнэтэй Уа3-469 машин авч парк шинэчлэлт хийсэн</p> <p>2015 онд Га3-66 автомашины тэвшин дээр ой хээрийн түймэр унтраах зориулалтаар тоноглож багаж зэвсэглэмж хийх хайрцаг, алба хаагчид суух зориулалтын сандалтай, 1200л усны багтаамж бүхий ёмкость, багаж зэвсэглэмж байрлуулах бэхэлгээ зэргийг хийж 385,0/мян/ төгрөгөөр берзентэн бүхээг авч тавьж тоноглогсон байна.</p> <p>Аврах аврах гал унтраах 43 дугаар ангийн шинээр баригдах галын депогийн барилга барих гүйцэтгэчийг Улаанбаатар хотод Худалдан авах ажиллагааны газарт 7 дугаар сард тендер шалгаруулалт зохион байгуулсан байна. Завхан аймгийн Улиастай сум дахь 43-р гал унтраах анги, Депогийн барилгын улаан шугамыг 2014оны 09 сарын 27 өдөр тавьж “БИ ЭНД КҮЙ” ХХК барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн 2016 оны 12-р сард А блокыг хэсэгчлэн улсын комисст хүлээлгэн өгсөн. В блок буюу 10 машины гражын</p>
--	--

		<p>дутуу ажил, гадна тохижилтын ажлыг 2017 онд гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтанд оруулсан байна. ДЗОУБ-ын Завханхангай орон нутгёён хөгжлийн хөтөлбөрөөс 14 ширхэг майхан авч өгч хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулахад ашиглах боломжтой болсон байна. Тэс суманд 4-р зэрэглэлийн 57-р анги гал унтраах анги шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>2018 оны 11-р сард зохион байгуулагдсан Монгол улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл, “Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээнд ашиглагдах багаж” сэдэвт сургалтыг Барилгын хөгжлийн төв, Японы олон улсын хамтын ажиллагааны Jica байгууллагатай хамтран зохион байгуулсан. Япон улсын буцалтгүй тусламжаар Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээнд ашиглах бетоны хатуулаг, өрөгт бүтээцтэй барилгын тоосгоны бат бэхийг тодорхойлох Шмитийн алх N,L төрөл, арматурын байршил, диаметр, хамгаалалтын үеийн зузаан, зэврэлтийн хэмжээг тодорхойлох PROFOMETER 630 AI+CORROSION багаж, бетоны ан цавын гүний хэмжээ ба бетоны шахалтын бат бэхийг хэт авиан долгионыг ашиглан тооцоолон гаргах PUNDIT LAB+ багажны сургалтад холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Завхан аймаг/</i></p> <p>Аймгийн Улаан загламайн хороотой хамтран тус аймгийн Давст, Хяргас, Малчин, Цагаанхайрхан, Өндөрхангай сумуудад гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулсан. Тус байгуулагдсан сайн дурын хэсгийн бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах зохион байгуулж, өнөөдрийн байдлаар Хяргас, Өндөрхангай суманд байгуулагдсан сайн дурын хэсгийг Австралийн Улаан Загалмайн Нийгэмлэгийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд аймгийн Улаан загалмайн хороотой хамтран тус бүр 10.0 сая төгрөгийн багаж хэрэгслийг хүлээлгэн өгсөн байна.</p> <p style="text-align: right;"><i>/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</i></p>
	<p>4.4. Олон нийтэд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх болон газар хөдлөлтийн гамшгийн үеийн авран хамгаалах сургалт зохион байгуулах, сурталчлах, гамшгийн хор холбогдлыг тайлбарлан таниулах</p> <p>/2009-2014 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Нийслэлийн хэмжээнд 2019 онд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 4 удаа, Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 5 удаа, Удирдах бүрэлдэхүүний сургалтыг 72 удаа, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалтыг 117 удаа, Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан ажилтны сургалтыг 683 удаа, оюутан сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалтыг 298 удаа, ард иргэдийн сургалтыг 292 удаа, Иргэд, сайн дурын бүлгийн сургалтыг 98 удаа тус тус зохион байгуулж, нийт 1569 удаагийн сургалтад 544,353 иргэнийг хамруулж, болзошгүй гамшгийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг, чадвар олгосон байна.</p> <p style="text-align: right;"><i>/НЗДТГ/</i></p> <p>Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах талаар Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгөгдсөн үүрэг, Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг тус тус хэрэгжүүлэх 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, сургалт дадлага сургууль зохион байгуулах ажлын хүрээнд жил бүрийн 03 дугаар сарын 4 дэх 7 хоногийн Пүрэв гарагийн 16 цагт улс орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах, дуут дохио дуугаргаж шалгах, дадлага хийгдэх шийдвэр гарсантай холбогдуулан, Булган аймгийн Засаг даргын 2019 оны 03-р сарын 12-ны өдрийн 01/309, 01/310 тоот албан бичгээр 16 сум, 1 тосгон 85 байгууллага, аж ахуйн нэгжид гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах үүрэг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж Онцгой байдлын газраас алба хаагчдыг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хуваарилан зарлан мэдээлэх дохиогоор хэрхэн ажиллах тухай заавар зөвлөмжийг өгч ажилласан. Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Б.Ууганбаярын “Газар хөдлөлтийн гамшигт бэлэн байдлаа хангадаг хариуцлагатай иргэн бэлтгэх</p>

нь” сэдэвт теле хичээлийг Булган сумын LED дэлгэцээр гаргаж олон нийтэд хүргэсэн. Булган сумын хэмжээнд 85 аж ахуйн нэгж байгууллагын 2398 том хүн, 3824 хүүхэд нийт 6222 хүн, 15 сум 1 тосгоны 2741 том хүн, 4112 хүүхэд хамрагдаж аймгийн хэмжээнд нийт 7936 хүүхэд, 5139 том хүн /нийт 13075 хүн/ 38 техник хамрагдсан байна.

/Булган аймаг/

“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд аймгийн Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 5 дугаар сургуулийн 3267 сурагчид “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр 10 цагийн сургалтыг зохион байгуулан гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллан дадлага сургуулийг явууллаа.

Тус дадлага сургуульд 3267 сурагч, 247 багш ажилчид хамрагдлаа. “Gamshgiin ayuliin tuhai zarlan medeelliin dohiogoor ajillah dadlaga surguuli 2019.03.22-ni 16:00 tsagt yavagdah tul irgen ta idevhtei oroltsono uu. GSA OBG” гэсэн мэдээллийг 5376 иргэдэд багц мессеж үйлчилгээгээр болон аймаг дахь Жи-мобайл, Юнител, Мобикомын салбаруудаар хүргэсэн.

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Прокурорын газар, Нэгдсэн эмнэлэг, Ерөнхий боловсролын 12 жилийн 1, 2, 3, 4, 5 дугаар сургуулийн багш ажилтан, сурагчид, 1, 2, 3, 5 дугаар цэцэрлэгийн ажилтан, Төмөр замын Чойр өртөөний ажилтан, Политехникийн коллежийн багш, ажилтан нийт 3879 хүнд Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам, Газар, хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, газар хөдлөлтийн үед өөртөө болон бусдад туслах зэрэг сэдвээр 15 цагийн танхимын, 10 цагийн дадлага сургалтуудыг зохион байгуулан, зарлан мэдээллийн дохиогоор ажиллах заавар, зөвлөмжийг өгч, Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх богино хэмжээний бичлэг, “Газар хөдлөлтийн гамшигт бэлэн байдлаа хангадаг хариуцлагатай иргэн бэлтгэх нь” сэдэвт теле хичээл үзүүллээ.

Аймгийн хэмжээнд зарлан мэдээллийн серень дохио 4, тусгай зориулалтын болон галын автомашин 12, төмөр замын зүтгүүрийн шүгэл дохио 1, нийт 17 техник хэрэгслээр үүрэн холбооны Жи Мобайлын утасны автомат цагийг ашиглан нэгэн зэрэг 1 минут үргэлжлүүлэн, 30 секундын завсарлагаатайгаар 3 удаа дохио өгч, өгөгдсөн дохионы дагуу төр захиргааны байгууллага, улсын онц чухал объектууд, хүн ам олноор цуглардаг аж ахуйн нэгж, байгууллага, цэцэрлэг, сургуулийн байгууллагуудын ажилтан албан хаагчид, оюутан сурагчид, ард иргэдийг тухайн албан байгууллага, барилга байгууламж, орон сууцанд байгаа байрлалаа орхин гарч, аймаг сумын хэмжээнд урьдчилан төлөвлөсөн 16 цугларах талбайд байрлуулах дадлагаар ажиллууллаа.

Газар хөдлөлтийн гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтад аймаг, сумын хэмжээнд 6644 хүнийг хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 13.6 хувиар өссөн байна.

Ард иргэдэд гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг сонирхолтойгоор хүргэх “Анхаар” аппликэйшн таниулан сурталчлах, гар утсанд татан суулгах талаар 11296 иргэнд мэдээлэл өгсөн байна.

/Говьсүмбэр аймаг/

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр, ОБЕГ-ийн даргын 11/756 дугаар үүргийн хүрээнд иргэдэд болзошгүй гамшгаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, бусаддаа тусламж дэмжлэг үзүүлэх, аюулгүй амьдрах орчныг бий болгох дадлыг хэвшүүлэх, өрхийн түвшинд гамшгийн бэлэн байдлыг хангах чадвар, хандлагыг олгох, гүйцэтгэх үүргийг ухуулан таниулах зорилгоор УЗХ, ГТУА-22 дугаар ангийн алба хаагчидтай хамтран нийт 10 удаа “Хэн ч, Хэзээ ч, Хаана ч бэлэн” буухиа тэмцээнийг зохион байгуулахад 452 иргэдийг хамруулж 50 цагийн сургалт, буухиаг зохион байгуулан ажилласан байна.

		<p>Буухиа тэмцээнийг ГТУА-22 дугаар ангийн дэргэдэх “Иргэдийг гамшгаас хамгаалах сургалтын цогцолбор” зохион байгуулж “Бэлэн бай” сургалтын багцаар танхимын сургалт хийж гүйцэтгэсэн байна.</p> <p>Буухиа тэмцээнийг дараах өртөөг дамжин хурд хүч, авхаалж самбаагаа сорин уралдахаар төлөвлөн зохион байгуулсан. Үүнд:</p> <p>Тэмцээний сугалааны дагуу баг тамирчид гараанаас гарахдаа нүдээ боож хээрийн цай хоол хийх бүтээгдэхүүнийг саад тойронгоо олж авах ба нүдээ боосон оролцогчийг араас нь багийн 1 гишүүн замыг нь зааж чиглүүлэх</p> <ol style="list-style-type: none"> 1. Бартаат зам туулан утаанаас дүрвэх өртөө бүхий утаат туннелээр мөлхөн гарах 2. Хамтын хүч өртөөнд 2 адиалаар бөмбөг харилцах 3. Цаасаар аяга хийх 4. Ус зөөвөрлөх 5. Асуулт хариултын өртөө 6. Гал унтраах өртөө 7. Эмнэлгийн анхны тусламжийн өртөө 8. Саадтай зам өртөө 9. Барилгын өндөр давхарт 3 сунадаг шатаар гарах гэсэн 9 төрлийн даалгаврыг хийж гүйцэтгэн уралдлаа. <p>Бүх баг даалгавраа хийж гүйцэтгэсний дараа нийт баг тамирчид маань “Хичээгээрэй” 32 тоот дасгалыг хийж хээрийн гал тогоог ажиллуулан цай хоол хийж идсэнээр тэмцээнийг дуусгаж байр эзлүүлэн шагнал урамшууллыг өгч дурсгалын зураг авхуулж байв. Аймгийн иргэд, оюутан сурагчдад гамшгаас хамгаалах боловсрол, гамшгийн үед өөрийгөө болон бусдыг аврах, газар хөдлөлтийн аюулын үед амьд гарах мэдлэг чадвар, дадлагыг олгох зорилгоор Дархан сумын 15-р багийн Мангирт хороололд Онцгой байдлын газраас санаачлан бүтээн байгуулагдсан “Иргэдийг гамшгаас хамгаалах дадлага сургалтын 4 давхар цогцолбор”-ийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн Аврах зам гарц хаагдсан үед өндрөөс аврах ажиллагааг зохион байгуулах дадлага сургуулийг</p> <ul style="list-style-type: none"> - Барилгын өндрөөс аврах тавцан ашиглах аргаар - Барилгын өндрөөс аврах хоолой ашиглах аргаар - Барилгын өндрөөс аврах олс ашиглах аргаар - Барилгын өндрөөс аврах сагс ашиглах аргаар аврах ажиллагааг тус тус зохион байгуулах дадлага сургуулийг Дархан Уул аймгийн албан байгууллагын ажилтан нар болон Гамшгийн менежмент хичээлийг судлаж байгаа их дээд сургуулийн оюутан сурагчдад мөн иргэдэд зохион байгуулан ажиллаж энэ хүрээнд Хэн ч хэзээ ч хаана ч бэлэн буухиа тэмцээнийг иргэд олон нийтийн дунд зохион байгуулж цогцолборын үйл ажиллагааг төгөлдөржүүлэн ажиллаж байна. <p>Энэхүү сургалт дадлагын цогцолбор бүтээн байгуулагдаж бодит дадлага сургуулийг зохион байгуулж байгаагийн үр дүнд Дархан уул аймгийн иргэд, ажилтан албан хаагчид, мэргэжлийн ангийн алба хаагчид гамшгаас хамгаалах түүнчлэн болзошгүй гамшиг ослын үед өөрийгөө болон өрөөлийг амьд гарах арга ухаанд дадлагажуулах, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтын үйл ажиллагаанд бүрэн хамрагдах боломжтой болсон байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дархан-Уул аймаг/</i></p> <p>Аймгийн Засаг даргын “Төсөл хэрэгжүүлэх тухай” А/305 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сургуулийн цогц аюулгүй байдлын удирдлага” төслийн арга хэмжээг ЕБ-ын 12 дугаар сургуулийн багш, ажилчид, сурагчид нийт 562 хүнийг хамруулан Хүүхдийн ивээх сантай хамтран аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол соёл урлагийн газар, Онцгой байдлын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрууд хамтран газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах сургалт, дадлагыг зохион байгуулсан байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор жил бүрийн 03 дугаар сарын 4 дэх 7 хоногийн Лхагва гарагийг “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгосонтой холбогдуулан гамшгийн хор холбогдлыг тайлбарлан таниулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын 102 хүн, ард иргэдээс 81 хүн нийт 183 хүн</p>
--	--	--

		<p>хамрагдаж, 22 аж ахуйн нэгж, байгууллагын 480 хүнийг хамруулан 28 цагийн танхимын сургалтыг зохион байгуулсан байна.</p> <p>Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийн тухай мэдээ мэдээллийг www.obg.gov.mn цахим хуудсаар, “Дорнод Онцгой” фэйсбүүк хуудас, мэдээллийн цахим самбар, үүрэн холбооны “багц мессеж” үйлчилгээгээр Чойбалсан хот, 14 сумын 1264 иргэдэд мессеж хэлбэрээр түгээж, орон нутгийн “Шинэ суваг”, “ТВ-6”, “Дорнод”, “Мижиг”, “PBS” ТВ-үүдээр тухай бүр нэвтрүүлж ажилласан байна.</p> <p style="text-align: right;">/Дорнод аймаг/</p> <p>Идэр, Яруу сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, Нөмрөг, Түдэвтэй сумдад, команд штабын сургууль, Цагаанчулуут суманд гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт зохион байгуулахад албан тушаалтан, ард иргэд зэрэг нийт 2198 гаруй хүнийг хамруулан 154 цагийн багтаамжтай танхимын болон тактикийн сургалтыг зохион явуулсан нь сум орон нутагт аливаа Гамшиг осол гарахад томилгоот бүрэлдэхүүнийг ажиллах мэдлэг, чадвар дадлага олгох, багаар хамтран ажиллах, бэлтгэлбэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">/Завхан аймаг/</p> <p>Сургалтын төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хамтран ажиллах зорилгоор гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын бүлэг, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, оюутан сурагчдад чиглэсэн сургалт, мэдээллийн үйл ажиллагааг тогтмолжуулж олон нийтийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. нийт 782 цагийн дадлага сургуулийг 68975 /давхардсан тоогоор/ хүнийг хамруулан зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;">/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</p>
	<p>4.5. Олон улсын арга хэмжээнд идэвхитэй оролцон гамшгийн хор холбогдлыг бууруулахад шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх</p> <p>/2009-2020 он Хэрэгжилт 70%/</p>	<p>Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний галын удирдлагын газар болон Солонгосын галын хүрээлэнгээс тус улсын Тэгү хотод 2019 оны 4 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан “Олон улсын галын аюулгүй байдлын 10 дахь удаагийн үзэсгэлэн яармаг” болон “Солонгосын галын хүрээлэнгийн олон улсын бага хурал”-д оролцож, туршлага солилцсон байна.</p> <p>Узбекистан Улсын Ташкент хотод 2019 оны 3 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “BACAC: Bridging the Gaps” олон улсын хуралд “Биологийн ослын үеийн аюулгүй байдлын болон эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагаа, салбар хоорондын уялдаа” сэдвээр Зооноз өвчин судлалын төвтэй хамтран илтгэл хэлэлцүүлж оролцсон байна.</p> <p>Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар туршлага судлах, мэдээлэл солилцох, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр Оросын Холбооны Улсын Красноярскийн Газар тариалангийн Улсын их сургуультай 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдөр, ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газартай 2019 оны 6 дугаар сарын 27-ны өдөр тус тус хамтран ажиллах санамж бичигт байгуулсан байна.</p> <p style="text-align: right;">/Онцгой байдлын ерөнхий газар/</p> <p>Япон улсын Осака хотод зохион байгуулагдсан Зүүн хойд азийн орнуудын нийгэмлэгийн “Гамшгийн эрсдэлийг бууруулах нь” сэдэвт 17 дугаар хуралдаанд 2019 оны 3 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд оролцож Япон улсын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх туршлагыг судалж ирсэн байна.</p> <p style="text-align: right;">/Баян-Өлгий аймаг/</p> <p>2019 онд 4, 7, 8 дугаар саруудад зохион байгуулагдсан Япон БНСУ, БНХАУ-д болсон сургалтуудад ОБГ-ын төлөөлөл оролцсон. НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн шугамаар зохион байгуулагдаж байгаа Аюулгүй хот төслийн</p>

		<p>сургалтад ОБГ, Булган сумын ЗДТГ, ГХБХБГ-ын төлөөлөл 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдөр оролцсон байна.</p> <p style="text-align: right;"><i>/Булган аймаг/</i></p> <p>“Говийн чоно-2019” олон улсын дадлага сургуульд Аймгийн засаг даргын орлогч, Мал эмнэлгийн газрын дарга, ГХБХБГ-ын дарга, Онцгой байдлын газраас газрын даргаар ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2019 оны 8 дугаар сарын 11-25-ны өдрүүдэд амжилттай оролцсон. Тус газрын Гал түймэр унтраах аврах 25 дугаар ангийн аврагч-гал сөнөөгч, ахлагч Т.Ууганбаярыг БНСУ-ын Галын академаас зохион байгуулсан олон улсын гал сөнөөгч аврагч нарын 14 хоногийн сургалтад хамруулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дундговь аймаг/</i></p> <p>Тус газрын Холбоо зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч Г.Нэргүйбаатар, ангиллын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Г.Уртнасан нар Тайландын вант улсын Банког хотноо “Хотуудын уур амьсгалаас үүсч байгаа эрсдэл, эмзэг байдлыг судлах, орон нутгийн удирдлагуудын хамтын ажиллагаа” сэдэвт сургалтад 2019 оны 11 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Орхон аймаг/</i></p> <p>Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын дагуу “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам” Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 тоот тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар” зэрэг баримт бичгийг мөрдлөг болгон сум орон нутгийн хэмжээнд газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийн тооцож эрсдлийг бууруулах төлөвлөгөө гаргахаар ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Сэлэнгэ аймаг/</i></p> <p>Гамшгийн эрсдлийг бууруулах мэдлэг ойлголтыг иргэдэд илүү хүртээмжтэй сонирхолтойгоор хүргэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжиж буй “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах нь” төслийн хүрээнд Batu digital компану “ANHAAR” нэртэй аппликэйшнийг тус газрын андройд утастай бүх албан хаагчдад суулгаж, 2019 онд албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудад зохион байгуулсан сургалтын үеэр сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>/Увс аймаг/ /Хэрэгжилт 70%/</i></p>
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололт:</p> <p>1.Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус паспортжуулалтын зөвлөл 21 аймагт байгуулагдсан.</p> <p>2. Улсын хэмжээнд байгаа барилга байгууламжийн нэгдсэн судалгааг гаргаж, газар хөдлөлтөд тэсвэртэй, хүчитгэх шаардлагатай мөн ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжаар ангилж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан Засгийн газрын тогтоол болон Байнгын хороодын тогтоолоор батлуулсаны дагуу 2020 оны Төсвийн тухай хуулинд тусгуулахаар санал хүргүүлсэн.</p> <p>3. Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд Одон орон, геофизикийн хүрээлэнгийн харьяа газар хөдлөлтийг бүртгэх орон нутаг дахь 12 станцын хэвийн үйл ажиллагааг хангах, багаж тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх,</p>

шинэчлэх, станцын техникийн хүчин чадлыг өргөтгөх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Монгол орны газар хөдлөлтийг бүртгэх станцыг нэгээр нэмэгдүүлж газар хөдлөлт бүртгэх хүчин чадлыг нэмэгдүүлэн ажиллаж байна. 9 аймгийн бичил мужлалын судалгааны ажлыг 2020 онд үргэлжлүүлэн хийхээр төлөвлөн ажиллаж байна. Хүчтэй газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем болон Улаанбаатар хот орчимд хүчтэй газар хөдлөлтийн өмнөх геофизик орны өөрчлөлтийг хянах станцуудын багаж тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх, шинэчлэх, станцын техникийн хүчин чадлыг өргөтгөх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

4.Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал нь зарим аймгуудад барилга байгууламжийн мэдээллийн сантай болсон, мөн аймгийн хэмжээнд гамшиг тохиолдсон үед авах арга хэмжээний бэлтгэл сургуулилт хийгдсэн.

5 . Гамшгийн эрсдэлийг олон нийтэд тулгуурлан бууруулах арга хэмжээг зохион байгуулж, иргэд аж ахуй нэгж, тусгай болон ерөнхий зориулалтын мэргэжлийн ангиуд гамшгийн үед хариу арга хэмжээ авах, аврах хор уршгийг арилгах үйл ажиллагаанд бэлтгэгдэн мэдлэг чадвар нь нэмэгдсэн.

6. Газар хөдлөлтийн судалгаа эрхэлдэг байгууллагын боловсон хүчний чадавхи нь дээшилсэн.

7. Барилгын төлөв байдлын мэдээллийн сан бүрдүүлэх эхлэл тавигдсан зэрэг сайн талууд байна.

Дугагдал:

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө төсөвт тухай бүр хүргүүлсэн хүсэлт хийгдэх ажлын дагуу тусгагдахгүй байна.

2. Аймгуудын хэмжээнд эвдрэл гэмтэлтэй, эрсдэлтэй барилгын судалгаа хийгдэх хөрөнгө санхүүжилт тусгагдахгүй, нарийвчилсан судалгаа хийгдэх чадахгүй байна.

3. Барилгад инженерийн биет үзлэг явуулахын тулд зарим хэсэгт буулгаж үзэх шаардлагатай ажилд зориулсан санхүүжилт, мөн олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга, дэд бүтцийн байгууламжуудад үзлэг, тооллого явуулж, паспортжуулах арга хэмжээнд төсөвлөсөн хөрөнгө дутагдалтай байна.

4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, аймаг, сумын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд төсөвлөсөн хөрөнгийн хэмжээ маш бага байна.

Анхаарах асуудлууд:

1.Төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, эдгээр байгууллагуудын тоо хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх. Төрөөс авах арга хэмжээнд илүү анхаарч ажиллах шаардлагатай байна.

2. Зайлшгүй шаардлагатай зарим барилгуудын үндсэн бүтээцэд хөндлөнгийн эрх бүхий байгууллагын үнэлгээ, дүгнэлт гаргах судалгааны ажлын зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгуулж байх шаардлагатай байна.

3. Гамшгийн эсрэг авах арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг иргэд болон байгууллага, салбар бүрээр анхаарч жил бүрийн төсөвт тусгуулж байх шаардлагатай байна.

4. Гамшгийн хор холбогдлыг бууруулахад шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх гэсэн ажлын хүрээнд аймгууд, БСШУЯ,ОБЕГ, СЯ, Монголын барилгын инженерүүдийн холбоо /МБИХ/-зэрэг байгууллагууд өөрсдийн хариуцах ажлуудыг бодитой хийж гүйцэтгэх хэрэгтэй байна.

5. Хот байгуулалт, барилгын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт газар чичирхийллийн нөлөөллийг тооцох, төлөвлөх хичээл нэмэх, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, кредит цагийг нэмэгдүүлэх, багш нарыг давтан сургах, мэргэшүүлэх гэсэн ажлын хүрээнд СЯ, ШУТИС-ийн Барилгын инженер-

		<p>архитектурын сургууль, бусад хувийн их дээд сургуулиуд анхаарч ажиллах хэрэгтэй байна.</p> <p>6. Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон газар хөдлөлтийн бүртгэлийн мэдээллийн санг баяжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгтэй мэдээлэл болон мэргэжилтэн харилцан солилцох, үндэсний мэргэжилтэн бэлтгэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулах гэсэн ажлын хүрээнд БСШУСЯ, СЯ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, аймгууд анхаарч ажиллах хэрэгтэй байна.</p> <p>7. Монгол орныг хамарсан газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураг боловсруулах ажлыг нэгдсэн аргачлал, шинжлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурлан зохион байгуулах гэсэн ажлын хүрээнд холбогдох аймгууд БСШУСЯ, СЯ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв тодорхой ажил зохион байгуулж ажиллах хэрэгтэй байна.</p> <p>8. Газар хөдлөлтийн өндөр эрсдэл бүхий хот, суурин газар, бүсүүдийн тулгуур төв болон зарим суурин газрын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:10000-ны масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох ажлыг үе шатаар хэрэгжүүлэх гэсэн ажлын хүрээнд хийгдэх ажил удаашралтай байна.</p> <p>9. Хот, суурин газруудын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний ажлыг дуусгаж, мэдээллийн сан байгуулах ажил удаашралтай байна.</p> <p>Дараах заалтуудын биелэлт хангалтгүй байна. Үүнд:</p> <p>1 дүгээр зорилтын хүрээнд:</p> <p>1. /1.1./ Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг идэвхижүүлэх гэсэн ажлын хүрээнд 25 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 10 аймаг, БСШУСЯ ирүүлээгүй байна.</p> <p>2. /1.2./ Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх авран хамгаалах чиглэлээр гадаад улсын зөвлөл, ижил чиг үүрэг бүхий зөвлөл, байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтын ажиллагааг тогтворжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгт элсэх, хамтарсан сургалт, семинар зохион байгуулахад туслалцаа үзүүлэх гэсэн ажлын хүрээнд 27 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 12 аймаг, БСШУСЯ, СЯ ирүүлээгүй байна.</p> <p>3. /1.3./ Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгтэй мэдээлэл болон мэргэжилтэн харилцан солилцох, үндэсний мэргэжилтнийг бэлтгэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулах гэсэн ажлын хүрээнд 24 байгууллага тайлан ирүүлэхээс Баян-Өлгий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 14 аймаг, БСШУСЯ, СЯ ирүүлээгүй байна.</p> <p>4. /1.4./ Гамшгийн хор холбогдлыг бууруулахад шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх гэсэн ажлын хүрээнд 26 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 18 аймаг, БСШУСЯ, СЯ, МБИХ ирүүлээгүй байна.</p> <p>5. /1.5./ Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх сургалт зохион байгуулах гэсэн ажлын хүрээнд 25 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 17 аймаг, БСШУСЯ, СЯ ирүүлээгүй байна.</p> <p>6. /1.6./ Хот байгуулалт, барилгын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт газар чичирхийллийн нөлөөллийг тооцох, төлөвлөх хичээл нэмэх, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, кредит цагийг нэмэгдүүлэх, багш нарыг давтан сургах, мэргэшүүлэх гэсэн ажлын хүрээнд 3 байгууллага тайлан ирүүлэхээс СЯ,</p>
--	--	---

	<p>ШУТИС-БИАС ирүүлээгүй байна. /1 аймаг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна./</p> <p>7./1.7/.Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон газар хөдлөлтийн бүртгэлийн мэдээллийн санг баяжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгтэй мэдээлэл болон мэргэжилтэн харилцан солилцох, үндэсний мэргэжилтэн бэлтгэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулах гэсэн ажлын хүрээнд 3 байгууллага тайлан ирүүлэхээс СЯ, БСШУСЯ, ООГФХ ирүүлээгүй байна. /БХБЯ болон 2 аймаг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна./</p> <p>2 дугаар зорилтын хүрээнд:</p> <p>8./2.1/. Монгол орныг хамарсан газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураг боловсруулах ажлыг нэгдсэн аргачлал, шинжлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурлан зохион байгуулах гэсэн ажлын хүрээнд 25 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 21 аймаг БСШУСЯ, СЯ, ООГФХ ирүүлээгүй байна.</p> <p>9./2.2/.Газар хөдлөлтийн өндөр эрсдэл бүхий хот, суурин газар, бүсүүдийн тулгуур төв болон зарим суурин газрын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:10000-ны масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох ажлыг үе шатаар хэрэгжүүлэх гэсэн ажлын хүрээнд 25 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 21 аймаг БСШУСЯ, СЯ ирүүлээгүй байна.</p> <p>10./2.3/. Газар чичирхийллийг бүртгэх, мэдээлэл боловсруулах байнгын станцыг шинээр байгуулах гэсэн ажлын хүрээнд 3 байгууллага тайлан ирүүлэхээс БСШУСЯ, СЯ зэрэг 2 байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>11./2.4/. Орон нутагт ажиллаж байгаа газар хөдлөлт бүртгэх станцын дэд бүтцийг сайжруулах боловсон хүчний чадавхийг нь дээшлүүлэх гэсэн ажлын хүрээнд 25 байгууллага тайлан ирүүлэхээс Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 14 аймаг ирүүлээгүй байна.</p> <p>12./2.5/. Газар хөдлөлтийн судалгаа эрхэлдэг байгууллагыг газар хөдлөлт бүртгэх нүүдлийн станц болон геофизикийн орчин үеийн иж бүрэн багаж, техник хэрэгслээр хангах гэсэн ажлын хүрээнд 3 байгууллага тайлан ирүүлэхээс БСШУСЯ, СЯ зэрэг 2 байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>13./2.6/. Хүн ам олноор суурьшсан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хөрсний хурдатгалын бичлэг /акселограмм/ хийх гэсэн ажлын хүрээнд 3 байгууллага тайлан ирүүлэхээс ООГФХ, БСШУСЯ, СЯ зэрэг 3 байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>3 дугаар зорилтын хүрээнд:</p> <p>14./3.1/. Хангай, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх, Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх гэсэн ажлын хүрээнд 28 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 21 аймаг, БСШУСЯ, СЯ, ОБЕГ, ООГФХ ирүүлээгүй байна.</p> <p>15./3.2/. Хот, суурин газруудын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний ажлыг дуусгаж, мэдээллийн сан байгуулах гэсэн ажлын хүрээнд 27 байгууллага тайлан ирүүлэхээс Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 10 аймаг, БСШУСЯ, СЯ, ООГФХ байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>16./3.3/.Хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотод ашиглагдаж байгаа 1970 оноос өмнө баригдсан олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга, дэд бүтцийн байгууламжуудад үзлэг, тооллого явуулж, паспортжуулах, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн</p>
--	---

	<p>нэмэлт арга хэмжээг үе шатаар эхлүүлэх гэсэн ажлын хүрээнд 27 байгууллага тайлан ирүүлэхээс Баян-Өлгий, Дорнод, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 9 аймаг, БСШУСЯ, СЯ, ООГФХ байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>17./3.4/.Барилга байгууламжийг загварчилж бодит байдалд турших, дүн шинжилгээ хийх, барилгын бүтээц болон түүний элементийг газар хөдлөлтөд турших, багаж, тоног төхөөрөмж бүхий лабораторитой болгох, ашиглагдаж байгаа туршилтын багаж, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх гэсэн ажлын хүрээнд 26 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 19 аймаг, БСШУСЯ, СЯ, ОБЕГ байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>18./3.5/. Эрдэс баялаг, уул уурхайн томоохон цогцолборуудыг дагаж байгуулагдах суурин газрын газар хөдлөлтийн эрсдэлийг тогтоосон баримт бичиг боловсруулах гэсэн ажлын хүрээнд 27 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 20 аймаг, НЗДТГ, БХБЯ, БСШУСЯ, СЯ, ОБЕГ, ООГФХ байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>19./3.6/. Эрүүл мэнд болон боловсролын байгууллагын барилгын даац, бат бэх, газар хөдлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээ хийх гэсэн ажлын хүрээнд 26 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дундговь, Орхон, Сүхбаатар, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 10 аймаг, БСШУСЯ, СЯ, ОБЕГ байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>20./3.7/. Хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын 1:1000-аас доошгүй масштабтай газрын дижитал зургийн санг байгуулах гэсэн ажлын хүрээнд 3 байгууллага тайлан ирүүлэхээс БСШУСЯ, СЯ, ООГФХ ирүүлээгүй байна.</p> <p>4 дүгээр зорилтын хүрээнд: Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах</p> <p>21./4.1/. Газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөөг томоохон хот суурин газар бүрээр боловсруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх гэсэн ажлын хүрээнд 24 байгууллага тайлан ирүүлэхээс Баян-Өлгий, Баянхонгор, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 10 аймаг, БХБЯ, ОБЕГ байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>22./4.2/.Гамшгаас хамгаалах алба, аймаг орон нутагт явуулдаг газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага, сургалтад холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах, болзошгүй гамшгийн үед ажиллах хамтын ажиллагааг сайжруулж, газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлэх гэсэн ажлын хүрээнд 24 байгууллага тайлан ирүүлэхээс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий 12 аймаг, БХБЯ, ОБЕГ байгууллага ирүүлээгүй байна.</p> <p>23./4.3/.Газар хөдлөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардлагатай багаж хэрэгслийг буцалтгүй тусламж, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хамруулан шинэчлэх арга хэмжээ авах гэсэн ажлын хүрээнд 24 байгууллага тайлан ирүүлэхээс Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 8 аймаг, БХБЯ ирүүлээгүй байна.</p> <p>24./4.4/. Олон нийтэд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх болон газар хөдлөлтийн гамшгийн үеийн авран хамгаалах сургалт зохион байгуулах, сурталчлах, гамшгийн хор холбогдлыг тайлбарлан таниулах гэсэн ажлын хүрээнд 3 байгууллага тайлан ирүүлэхээс БСШУСЯ, БХБЯ, ОБЕГ ирүүлээгүй байна.</p> <p>25./4.5/. Олон улсын арга хэмжээнд идэвхитэй оролцон гамшгийн хор холбогдлыг бууруулахад шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг</p>
--	--

		нэвтрүүлэх гэсэн ажлын хүрээнд 3 байгууллага тайлан ирүүлэхээс БСШУСЯ, БХБЯ зэрэг 2 байгууллагууд ирүүлээгүй байна.						
8.	Төслийг хэрэгжүүлэгч талуудын ажиллагаанд өгөх үнэлгээ	хамтын өгөх	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилсан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн хүрээнд жил бүр төлөвлөгөө гарган тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж байгаа ч хөрөнгийн асуудлаас болж төлөвлөсөн ажлууд хэрэгжихгүй хүндрэл учирч байна. <i>/Барилга, хот байгуулалтын яам/</i>					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	
		70.0%	4	70 %	70 %	70 %	70 %	
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ						
		... %						

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН
ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**
/2019 оны жилийн эцсийн байдлаар/

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулан яам, холбогдох дээд байгууллагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөрийн ерөнхий танилцуулга

“Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр” нь Засгийн газрын 2009 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдаж 2009-2014, 2015-2020 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжиж байна.

Хөтөлбөрийн зорилго нь Монгол орны нутаг дэвсгэрт учирч болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хүчтэй газар хөдлөлтийн голомт бүхий бүс нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах, ашиглагдаж байгаа зарим барилга, байгууламжийн хийц, бүтээцийг хүчигтэх замаар эвдрэл, нуралтаас үүсэх хохирлыг багасгах, орон сууц, олон нийт, иргэн болон үйлдвэрийн барилга, зам гүүр, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлыг хангаж, байгалийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Хөтөлбөр нь:

1. Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх;
2. Газар хөдлөлтийн аюулын үнэлгээ хийж, ерөнхий болон бичил мужлалын зураг зохиох, газар хөдлөлт бүртгэх станцын сүлжээг өргөтгөх;
3. Хот суурин болон бүс нутгийн эрсдэлийн үнэлгээг хийх;
4. Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах гэсэн 4 зорилтын хүрээнд хэрэгжиж байна.

Тус хөтөлбөрийн 4 зорилтод хүрэх үйл ажиллагааны 25 заалт бүрээр хэрэгжилтийг хувиар тооцон гаргаж хавсралтаар үзүүлэв. Хөтөлбөр хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар **70.0** хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 1

Хөтөлбөрийн зорилт	Арга, хэмжээ	Хэрэгжилтийн түвшин /хувиар/
Зорилт 1. Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх.	7	70
Зорилт 2. Газар хөдлөлтийн аюулын үнэлгээ хийж, ерөнхий болон бичил мужлалын зураг зохиох, газар хөдлөлт бүртгэх станцын сүлжээг өргөтгөх.	6	70

Зорилт 3. Хот суурин болон бүс нутгийн эрсдэлийн үнэлгээг хийх.	7	70
Зорилт 4. Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах гэсэн 4 зорилтын хүрээнд хэрэгжиж байна.	5	70
Дүн	25	70.0

Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна:

/1.1/ заалтын хүрээнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоол, Засгийн газрын 157 дугаар тогтоол “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хамтарсан 05/13 дугаар тогтоол, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/467 тоот албан бичгийг хүргүүлэн хэрэгжилтийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргуулж холбогдох байгууллагуудад цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

/Барилга, хот байгуулалтын яам/

2. Аймгийн Засаг даргын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн А/115 дугаар захирамж, Онцгой байдлын газрын даргын 04 дүгээр сарын 11-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Улаан загалмайн хороотой хамтран 4 дүгээр сарын 12-ноос 15-ны өдрүүдэд Баян-Уул суманд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Жаргалан, Тайшир сумдад Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг, 5 дугаар сарын 18-24-ний өдрүүдэд Дэлгэр сумын Гуулин тосгонд гамшгаас хамгаалах иж бүрэн, Цогт, Чандмань сумдад команд штабын сургууль, Дэлгэр, Эрдэнэ, Бигэр сумдад Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг, 6 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд Дарви суманд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, бусад сумдад бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулсан.

Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль, Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт сумдын онцгой комисс, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн нийт 1206 хүнийг хамруулан мэргэжил арга зүйн зөвлөмж чиглэл өглөө. Дээрх сумдын Засаг даргын захирамжаар 5-15 хүний бүрэлдэхүүнтэй гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, 8-10 хүний бүрэлдэхүүнтэй гал унтраах сайн дурын хэсгийг тус тус байгуулж, тэдгээрийн ажиллах журам, эрүүл мэндийн анхны шатны тусламжийн чиглэлээр сургалтыг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан байна.

/Говь-Алтай аймаг/

/1.2/-заалтын хүрээнд:

1. Барилга, хот байгуулалтын яам Онцгой байдлын ерөнхий газар, Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-тэй хамтран 2019 оны 3 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд “Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хүчитгэл хийх аргачлал” сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургалтад аймаг нийслэлийн МХЕГ-ын

байцаагчид, аймгуудын ГХБХБГ-ын мэргэжилтнүүд болон НЕТГ-ын мэргэжилтэн зэрэг 50 гаруй хүн хамрагдсан байна.

/Барилга, хот байгуулалтын яам/

2. Гадаад улс оронд зохион байгуулагдсан 67 удаагийн айлчлал, хурал, зөвлөгөөн, уулзалт, сургалт, семинар, үзэсгэлэнд Онцгой байдлын байгууллагаас давхардсан тоогоор нийт 257 алба хаагч оролцсон. Үүнээс газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр дараах бага хурал, дадлага сургууль зохион байгуулагдсан. Үүнд:

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газартай хамтран Нью Дели хотод зохион байгуулсан "Гамшигт тэсвэртэй дэд бүтэц" сэдэвт бага хуралд 2019 оны 03 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд 2 алба хаагч, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Шинэ Дэли хотод зохион байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны улсуудын "Газар хөдлөлтийн үед хот дотор эрэн хайх, аврах ажиллагаа" сэдэвт дадлага сургалтад 2019 оны 11 дүгээр сарын 4-8-ны өдрүүдэд 1 алба хаагч, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлгээс Тайландын Вант Улсын Засгийн газартай хамтран тус улсын Чинан Май хотод зохион байгуулсан "Олон улсын эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлгийн Ази, Номхон далайн бүсийн газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах дадлага сургууль"-д 2019 оны 12 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд 1 алба хаагч тус тус оролцсон байна.

/Онцгой байдлын ерөнхий газар/

3. Нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй "Гамшигт тэсвэртэй хотууд" төслийн нэгдүгээр үе шат 2016-2018 онд хэрэгжиж, 2019-2020 онд хэрэгжих төслийн 2 дугаар үе шатыг нийслэлийн 9 хороонд хэрэгжүүлэхээр 2018 оны 12 сард Хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Төслийн хүрээнд "Эрсдэлгүй айл-Аюулгүй хөрш" аяныг 2019 оны 4-9 дүгээр сард зохион байгуулж, нийслэлийн 9 хорооны гамшгийн менежментийн багийн 154 хүнийг чадавхжуулах сургалтад хамруулан сургагч багшаар, 2019 оны 5 дугаар сард 9 хорооны 54 иргэнийг бэлэн бай модулийн сургагч багшаар тус тус бэлтгэж, нийт 9244 иргэнийг сургалтад хамруулж, болзошгүй гамшгийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг, чадвар олгосон байна.

/НЗДТГ/

4. Аймгийн Засаг даргын баталсан 2019 онд зохион байгуулах гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөөний дагуу Дэлхийн зөн, Мерси кор, Каритас Монгол олон улсын байгууллага, Японы хүүхдийг ивээх сан зэрэг олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран иргэдэд чиглэгдсэн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтыг энэ хугацаанд 9 удаа, 515 хүнд зохион байгуулсан байна.

/Баян-Өлгий аймаг/

5. ОХУ-ын Тува улсын онц байдлын яамтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Уг гэрээний хүрээнд 2019 онд Төв аймгийн ОБГ-ын 8-н албан хаагчдыг сургаж бэлтгэсэн байна.

/Төв аймаг/

/1.3/-заалтын хүрээнд:

1. Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Одон орон, геофизикийн хүрээлэнгээр хийж гүйцэтгүүлсэн 12 аймаг болон Улаанбаатар, Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2018 онд Geoportals системд оруулан олон нийтийн хүртээл болгон ашиглаж эхлүүлсэн байна.

/Барилга, хот байгуулалтын яам/

2. Гамшгийн хор холбогдлыг бууруулахад шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх талаар олон улсын туршлага, техник технологи судлаж барилгын зураг төсвийг тухайн орон нутгийн онцлогийг харгалзан инженер геологийн судалгааг өндөр түвшинд хийж үнэн зөв дүгнэлт гаргахад мэргэжлийн байгууллагуудтай 2017 оноос эхлэн хамтран ажиллаж байна.

/Завхан аймаг/

3. Гамшгийн эрсдлийг бууруулах мэдлэг ойлголтыг иргэдэд илүү хүртээмжтэй сонирхолтойгоор хүргэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжиж буй "Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах нь" төслийн хүрээнд Batu digital company "ANHAAR" нэртэй аппликэйшнийг тус газрын андройд утастай бүх албан хаагчдад суулгаж, 2019 онд албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудад зохион байгуулсан сургалтын үеэр сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.

/Увс аймаг/

/1.4/-заалтын хүрээнд:

1. Онцгой байдлын ерөнхий газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран "Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн газар хөдлөлтийн тусгай тоноглол бүхий танхимд газар хөдлөлтийг биеэр мэдрүүлэх төхөөрөмжийг 2019 оны 3 дугаар сард суурилуулсан. Сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн чичирхийлэл нэмэгдэж байгаатай холбогдуулан ард иргэдэд газар хөдлөлтийн 3-12 баллын газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрүүлэх төхөөрөмжийг суурилуулснаар 342 удаагийн сургалтаар 30034 иргэнийг сургалтад хамруулж, газар хөдлөлтийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг, ойлголт өгсөн. 2. Мөн Улаанбаатар хотод Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2019 оны 4 дүгээр сард зохион байгуулсантай холбогдуулан бэлтгэлийг хангах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 9.5 сая төгрөгийн өртөг бүхий нисгэгчгүй нисэх төхөөрөмж 2, байршил тогтоогч 1 ширхгийг тус тус худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

/НЗДТГ/

1. Гамшгийн эрсдлийг бууруулах мэдлэг ойлголтыг иргэдэд илүү хүртээмжтэй сонирхолтойгоор хүргэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжиж буй "Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах нь" төслийн хүрээнд Batu digital company "ANHAAR" нэртэй аппликэйшнийг тус газрын андройд утастай бүх албан хаагчдад суулгаж, 2019 онд албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудад зохион байгуулсан сургалтын үеэр сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.

/Увс аймаг/

/1.5/-ын хүрээнд:

1. ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүн амын сан, Азийн хөгжлийн банкны төсөл, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Норвегийн тусламжийн байгууллага зэрэг олон байгууллагатай хамтран нийслэлийн дүүрэг, хөдөө орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүд ард иргэдэд анхны тусламжийн сургалт явуулж ирсэн. Энэ хүрээнд яаралтай тусламжийн үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг яаралтай тусламжийн мэргэжлийн эмч нараас бэлтгэн эмч мэргэжилтнүүд болон ард иргэдэд энэхүү сургалтыг тасралтгүй хүргэж ирсэн байна.

/Эрүүл мэндийн яам/

/2.2/ Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Одон орон, геофизикийн хүрээлэнгээр хийж гүйцэтгүүлсэн 12 аймаг болон Улаанбаатар, Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2012-2018 оны хооронд хийж гүйцэтгүүлээд олон нийтийн хүртээл болгон холбогдох дүрэм журам норм нормативын баримт бичигт тусган ажиллаж байна. Мөн үлдсэн 9 аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2018-2021 онд хийж гүйцэтгэхээр Одон орон, геофизикийн хүрээлэнтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлэн, хоёрдугаар шатны тайланг хүлээн аваад байна.

/Барилга, хот байгуулалтын яам/

/2.4/ Орон нутагт ажиллаж байгаа газар хөдлөх станцын дэд бүтцийг сайжруулах, боловсон хүчний чадавхийг нь дээшлүүлэх сургалтад 4 сараас 7 сар хүртэл 3 сарын хугацаатай 1 хүн хамруулсан. 2018 онд 4 инженер хамруулсан ба салбарын инженер Магистрийн зэрэг хамгаалсан. ШУА-ийн ООГ-н хүрээлэнгийн Цэцэрлэг салбарын барилгын халаалтын системийг сайжруулахад 4,8 сая төгрөгний хөрөнгийн асуудлыг хүрээлэнгээс шийдвэрлэсэн. 2019 онд барилгын засварын ажлыг хийлгэхээр санал хүргүүлсний дүнд 4,836,030 төгрөгний засварын ажлыг хийсэн байна.

/Архангай аймаг/

Одон орон геофизикийн судалгааны хүрээлэнгийн Өлгий салбар нь газар хөдлөлтийг бүртгэх "CRALP" өргөн зурвасыг ашиглан газар хөдлөлтийг бүртгэн мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудыг мэдээлэлээр шуурхай ханган ажиллаж байгаа ба салбарын дэд бүтцийг сайжруулах, боловсон хүчний чадваржуулах ажлыг үе шаттай хийж хэрэгжүүлж байна.

/Баян-Өлгий аймаг/

/2.9/ Барилга, хот байгуулалт яам нь аймаг, нийслэлийн Засаг дарга нарт өөрийн нутаг дэвсгэрт хамаарах нийт барилга байгууламжид паспортжуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар анхаарч ажиллах тухай албан бичгийг 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/312 тоот албан бичгээр хүргүүлсэн. Энэ хүрээнд Говь-Сүмбэр аймагт 16 барилга байгууламжид паспортжуулалтын ажил хийгдсэн бөгөөд 2 орон сууцны барилга байгууламж хамрагдсан байна. Нийслэлийн хэмжээнд 250 сая төгрөгийг төсвийг батлуулсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/146 дугаар захирамжийн хүрээнд төрийн өмчийн их, дээд сургуулийн 14, дунд сургуулийн 29, цэцэрлэгийн 12, эмнэлгийн 3, түүх, соёлын 2, олон нийтийн 16, нийт 76 барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, бат бэх найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах, паспортжуулах ажлыг гүйцэтгэсэн байна.

/Барилга, хот байгуулалтын яам/

/3.2/ БХБЯ, ОБЕГ, ООГХ хамтран баталсан 2018 оны 2018/175 тоот зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу 2018 онд эхлүүлсэн “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил”-ыг үргэжлүүлэн хийхэд шаардлагатай 2 тэрбум төгрөгөөс 2019 оны улсын төсөвт 400.0 сая төгрөг батлагдаж, Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологийн судалгааны ажлыг хийж дуусгасан байна.

/Онцгой байдлын ерөнхий газар/

/3.6/ Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн Байнгын хорооны 2018 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хамтарсан 05/13 дугаар тогтоолын хүрээнд Улсын хэмжээнд 3500 гаруй эрүүл мэндийн байгууллага байгаагаас 50 орчим хувь нь 1990 оноос өмнө ашиглалтад орсон эмнэлэгийн барилга байгууламжууд байгаагаас ашиглалтын шаардлага хангахгүй газар хөдлөлтөд тэсвэргүй 70 барилга байгууламж, боловсролын салбарт 3196 барилга байгаагаас ашиглалтын шаардлага хангахгүй газар хөдлөлтөд тэсвэргүй 181 барилга байгууламж тус тус байгаа бөгөөд буулган шинээр барихад 542 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн судалгаа гарсан. Уг асуудлыг жил бүрийн Улсын төсвийн тухай хуулинд тусгах чиглэлийг Засгийн газарт хүргүүлсэн бөгөөд 2020 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар саналаа хүргүүлсэн байна.

/Барилга, хот байгуулалтын яам/

/4.2/ Болзошгүй гамшгийн аюулаас хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын томилгоот бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, гамшгийн үеийн хүч хэрэгсэл, харилцан ажиллагааг сайжруулах зорилгоор Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах тухай нийслэлийн Засаг даргын А/41 дүгээр захирамжийн хүрээнд Багануур, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Нүүлгэн шилжүүлэлт, Тээвэр зохицуулах алба,

Холбоо зарлан мэдээллийн алба, Багахангай, Баянгол, Хан-Уул дүүргүүдэд нийслэлийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, Газар зохион байгуулах алба, Барилга хот байгуулалт, түр орон байраар хангах алба, Хүнсээр хангах алба зэрэг гамшгаас хамгаалах албадад удирдах бүрэлдэхүүний сургалтыг тус тус зохион байгуулж, байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангуулсан байна.

/ИЗДТГ/

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/184 тоот “Хяналт шалгалт, сургалт зохион байгуулах тухай” захирамж, удирдамжийн дагуу 15 сум нэг тосгоны иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан хаагчдад гарч байгаа гамшиг осол, аюулт үзэгдэл, гал түймрийн тоо хохиролыг бууруулахын тулд гамшгаас хамгаалах болон газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, дадлагыг зохион байгууллаа. Сургалтад нийт 994 ажилтан, алба хаагч, 154 сурагч, 214 иргэд хамрагдсан байна.

/Булган аймаг/

/4.5/ Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний галын удирдлагын газар болон Солонгосын галын хүрээлэнгээс тус улсын Тэгү хотод 2019 оны 4 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан “Олон улсын галын аюулгүй байдлын 10 дахь удаагийн үзэсгэлэн яармаг” болон “Солонгосын галын хүрээлэнгийн олон улсын бага хурал”-д оролцож, туршлага солилцсон. Узбекистан Улсын Ташкент хотод 2019 оны 3 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “BACAC:Bridging the Gaps” олон улсын хуралд “Биологийн ослын үеийн аюулгүй байдлын болон эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагаа, салбар хоорондын уялдаа” сэдвээр Зооноз өвчин судлалын төвтэй хамтран илтгэл хэлэлцүүлж оролцсон. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар туршлага судлах, мэдээлэл солилцох, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр Оросын Холбооны Улсын Красноярскийн Газар тариалангийн Улсын их сургуультай 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдөр, ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газартай 2019 оны 6 дугаар сарын 27-ны өдөр тус тус хамтран ажиллах санамж бичигт байгуулсан байна.

/Онцгой байдлын ерөнхий газар/

Япон улсын Осака хотод зохион байгуулагдсан Зүүн хойд азийн орнуудын нийгэмлэгийн “Гамшгийн эрсдэлийг бууруулах нь” сэдэвт 17 дугаар хуралдаанд 2019 оны 3 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд оролцож Япон улсын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх туршлагыг судалж ирсэн байна.

/Баян-Өлгий аймаг/

ДҮГНЭЛТ:

1. Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээс хойш барилгын паспортжуулалт, газар хөдлөлийн лаборатори байгуулах гм их хэмжээний санхүүжилт шаардлагатай ажлууд санхүүгийн хүндрэлээс шалтгаалан хэрэгжихгүй, мөн аймаг орон нутаг, салбарын яамд хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарал хандуулахгүй байгаагаас шалтгаалан хэрэгжилт удаашралтай 2019 оны жилийн эцсийн байдлаар **70.0** хувийн биелэлттэй байна.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлага зохицуулалтаар хангаж, чиглүүлж ажиллах үндсэн хэрэгжүүлэгч байгууллагууд болох ЗТХЯ, БСШУСЯ, СЯ, ШУТИС-ийн Барилгын инженер-архитектурын сургууль, Монголын барилгын инженерүүдийн холбоо /МБИХ/, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар өөрсдийн хариуцах ажлын биелэлтийг 2019 онд хангалтгүй гаргаж ирүүлсэн байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хангалтгүй хэрэгжсэн дараах ажлуудыг 2020 онд багтаан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

/1.7/ Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон газар хөдлөлтийн бүртгэлийн мэдээллийн санг баяжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгтэй мэдээлэл болон мэргэжилтэн харилцан солилцох, үндэсний мэргэжилтэн бэлтгэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулах;

/2.6/ Хүн ам олноор суурьшсан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хөрсний хурдатгалын бичлэг /акселограмм/ хийх;

/3.1/ Хангай, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх;

/3.4/ Барилга байгууламжийг загварчилж бодит байдалд турших, дүн шинжилгээ хийх, барилгын бүтээц болон түүний элементийг газар хөдлөлтөд турших, багаж, тоног төхөөрөмж бүхий лабораторитой болгох, ашиглагдаж байгаа туршилтын багаж, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх;

/3.5/ Эрдэс баялаг, уул уурхайн томоохон цогцолборуудыг дагаж байгуулагдах суурин газрын газар хөдлөлтийн эрсдэлийг тогтоосон баримт бичиг боловсруулах;

/3.6./ Эрүүл мэнд болон боловсролын байгууллагын барилгын даац, бат бэх, газар хөдлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээ хийх;

2. Газар хөдлөлтийн гамшигт өртсөн тохиолдолд хамгийн түрүүнд орогнох байр болон цэвэр ус, хоол хүнсний нөөцийн асуудал чухал тул болзошгүй газар хөдлөлтийн гамшгийн үед дүүрэг бүрт 100 мянгаас доошгүй хүний 1 сарын хэрэгцээг хангах нөөц бүрдүүлэх, тэдгээрийг хадгалах, чанар аюулгүй байдлыг хангах агуулах, сав тоног төхөөрөмжийг байгуулах;

3. Хөтөлбөрийг хэрэгжилтийн хугацаа 2020 онд дуусч байгаатай холбогдуулан хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүдийг цаашид хэрхэн хэрэгжүүлэх, хөтөлбөрийг сунгах болон шинээр хөтөлбөр боловсруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх;

4. Тайлан хангалтгүй ирүүлсэн холбогдох байгууллагууд Үндэсний хөтөлбөрт туссан хэрэгжилт удаашралтай дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд 2020 онд тодорхой ажил зохион байгуулж, дэлгэрэнгүй тайланг заасан хугацаанд ирүүлэх шаардлагатай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЧАНАРТ ТАВИХ ЛАБОРАТОРИЙН ХЯНАЛТЫГ
ӨРГӨЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Төслийн агуулга		Гүйцэтгэл		
1	Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр” Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 308 дугаар тогтоолоор баталсан.		Хөтөлбөрийн үндсэн зорилго нь барилга байгууламжид хэрэглэх барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүний чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэн, барилгын чанар, аюулгүй байдлыг хангах, улмаар хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.		
2	Санхүүжилтийн эх үүсвэр		<ul style="list-style-type: none"> - Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө - Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж; - Засгийн газрын баталгаа гаргасан үнэт цаас (Бонд) - Төр хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө - Хувийн хөрөнгө оруулалт - Бусад эх үүсвэр 		
3	Хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжүүлэх нийт хугацаа		<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам уг төслийг 2014-2020 онд хэрэгжүүлнэ.</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:</p> <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хотын БМСШЛаборатори - Аймаг, нийслэлийн Засаг дарга, - Орон нутгийн барилгын материалын лабораториуд, - хувийн хэвшил 		
4	Хөтөлбөрийн зорилтууд		<p>Зорилт1. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох;</p> <p>Зорилт2.Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн хяналтын тогтолцоог бий болгох;</p> <p>Зорилт3.Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийг өргөжүүлэх;</p> <p>Зорилт4.Хүний нөөц, боловсон хүчнийг бэлтгэх;</p>		
5	Зардал	Төсөв /Нийт шаардагдах зардал/	60 тэрбум		
		Тухайн жилд төсөвлөсөн	353.2 сая төгрөг		
		Гүйцэтгэл /Тухайн жилд/	1.412.1 сая төгрөг		
		Үүнд:	Төсөв /он/	Гүйцэтгэл	хувь
			1.412.1 сая төгрөг	1.412.1 сая төгрөг	100%
6. Хөтөлбөрийн зорилтууд, хэрэгжилт					
6	Зорилт 1. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд				
	1.1. Барилгын материалын чанар аюулгүй байдлын тухай хуулийн төсөл боловсруулах	<p>2016 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан Барилгын тухай хуулинд Барилгын материалын чанар аюулгүй байдлын талаар 4 дүгээр зүйлийн 4.1.17, 5 дугаар зүйлийн 5.9, 13 дугаар зүйл, 43 дугаар зүйл, 47 дугаар зүйлийн 47.2.2, 47.2.10, 47.3 дахь заалтуудаар барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүний чанарт тавих лабораторийн хяналтын тогтолцоог зохицуулан уг хуулийн хүрээнд Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”-нд барилгын материалын чанар аюулгүй байдалтай холбоотой зохицуулалтыг Техникийн зохицуулалт, стандарт, нормоор зохицуулах заалтууд орсон. “Барилгын материал, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ыг шинээр боловсруулах Техникийн даалгавар боловсруулаад байна.</p> <p align="right">/Хэрэгжилт 100%/</p>			
	1.2. Чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан барилгын материал, бүтээгдэхүүн,	Барилгын материал, бүтээгдэхүүний чанар, түүнд тавих хяналтын чиглэлээр Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ын баримт			

<p>худалдаалах болон чанарт тавих хяналтын чиглэлээр эрх зүйн орчинг бүрдүүлэх</p>	<p>бичиг, БХБСайдын 2019 оны 67 дугаар тушаалаар батлуулсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд доорх заалтуудыг тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Барилгын материалын үйлдвэрүүдийн дотоодын лабораторийг бэхжүүлнэ. • Бүтээгдэхүүний хөндлөнгийн хяналтын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, судалгаа, сорилтын чиглэлээр өргөжүүлэн улсын лавлагаа лаборатори байгуулна. • Барилгын материалын үйлдвэрийн бүртгэл, бүтээгдэхүүний баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн сан бий болгох ажлууд болно. <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>1.3 Лабораторийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, урвалж бодисуудыг гаалийн болон нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлүүлэх асуудлыг судлан боловсруулах</p>	<p>Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд жил бүр гаалийн татвар, тарифын бодлого боловсруулан Гаалийн тарифын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр Гаалийн тарифын зөвлөлийн дарга бөгөөд Сангийн сайдад хүргүүлж ажилласан. Эдгээр татвар, тарифын бодлогын төсөлд үйлдвэр болон лабораторит хэрэглэгдэх химийн түүхий эд, урвалж, бодисуудыг хамруулан хүргүүлсэн боловч сүүлийн 3 жил тус зөвлөл уг асуудлыг хэлэлцээгүй байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 40%/</p>
<p>1.4. Бүтээгдэхүүний баталгаажуулалттай холбогдсон хууль эрх зүйн орчинг судлах, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах</p>	<p>Барилгын материал, бүтээгдэхүүнд Тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтад хамруулан Тохирлын гэрчилгээ олгох 3 байгууллага ажиллаж байна. 2019 онд нийт барилгын хөгжлийн төвөөс 80, БАК-62, БХҮНТөв-40 нийт 182 аж ахуй нэгжид тохирлын гэрчилгээ олгосон болно.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 90%/</p>
<p>1.5 Барилгын норм, нормативын баримт бичгийг туршилт, судалгаа, шинжилгээн дээр үндэслэн боловсруулах, өөрийн орны нөхцөлд тохируулан нутагшуулах, олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх</p>	<p>Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан барилгын салбарын техникийн бодлогын баримт бичгийн боловсруулалтыг сайжруулах “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”-г шинээр боловсруулан Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар баталсан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогод цемент экспортлох зорилт туссантай холбогдуулан цементийн Евро EN-ийн 14 стандартыг орчуулан СХЗГ-ын Техникийн хороогоор хэлэлцүүлэн дэмжигдсэн болно.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>1.6 Өөрийн оронд үйлдвэрлэсэн болон импортоор оруулж ирсэн барилгын материал, хийц бүтээгдэхүүний талаар судалгаа хийж, мэдээллийн сан байгуулж ажиллуулах</p>	<p>Барилгын салбарыг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтын хүрээнд үндэсний үйлдвэрүүдийг дэмжин ажиллаж, “150 мянган айлын орон сууц үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 12 гол нэр төрлийн материалын эрэлт, нийлүүлэлтийн судалгаа гаргасан. Гол нэрийн 12 материалын 80 хувийг дотооддоо үйлдвэрлэж байгаа бөгөөд одоогийн байдлаар үйлдвэрлэл-импортын харьцаа 80 хувь байна. Барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг Монголын Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо ТББ-тай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа тул тус холбоо Тусгай зөвшөөрөлтэй барилгын материалын үйлдвэрүүдийн мэдээллийн санг бүрдүүлж байна. Мөн барилгын материал, бүтээгдэхүүний баталгаажуулалтын мэдээллийг нэгтгэн “Тохирлын гэрчилгээ”-тэй барилгын материалын үйлдвэрийн мэдээллийн санг үүсгэх зорилгоор “БАК” ХХК, “БХҮНТ” ТББ, “БХТ” ТӨААТҮГ-уудын мэдээллийг “Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сан”-д оруулж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>1.7. Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон барилгын материалын сорилт, шинжилгээний лабораториудад орчин үеийн өндөр нэрийвчлал</p>	<p>БМСШЛ-ийг Засгийн газрын тогтоолоор БХТөв ТӨҮҮГазрын харьяанд үйл ажиллагаа явуулж байна. Барилгын материалын сорил шинжилгээний төв лабораторит 2019 оны 4 дүгээр сард 28 иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Мөн шинээр байгуулах лабораторийн тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, Улаанбаатар хотын болон орон нутгийн барилгын</p>

<p>бүхий дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг сонгон нийлүүлэх</p>	<p>материалын сорил шинжилгээний лабораторид Улсын болон орон нутаг, зээл тусламжаар 21 аймгийг 3 багц иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангахаар ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>1.8 Лабораторийн сорилт, шинжилгээ хийх үйлчилгээний үнэ тарифыг боловсронгуй болгож, төсвийн санхүүжилтийг үе шаттай бууруулах арга хэмжээ авах</p>	<p>Зураг төсөл эрдэм шинжилгээний институт"-ийн захирлын 2014 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 71 дугаар тушаалаар батлагдсан үнэ тарифыг мөрдөж ажиллаж байна.</p> <p>Барилгын материалын сорил шинжилгээний лабораторийн мөрдөж байгаа үйлчилгээний үнийг улс орны эдийн засаг, барилгын салбарын эдийн засгийн хямралтай уялдуулан өөрчлөөгүй. 2016 онд эдийн засгийн асуудалтай холбогдон төсвөөс санхүүжилт хийгдээгүй болно.</p> <p>УИХ-ын 2016 оны 34 дүгээр тогтоол, УИХ-ын Байнгын хорооны 2018 оны 05 дугаар сарын 09-ний 05/13 тоот тогтоолуудыг үндэслэн Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн бүтэц орон тоог батлаж, цалин хөлс, холбогдох зардлыг 2019 оноос эхлэн Улсын төсвөөс 240,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг гаргахаар болсон болно.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>1.9 Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид хэрэглэгдэх түүхий эд, бүтээгдэхүүний турших аргын стандартыг боловсруулж, төр, орон нутаг, хувийн хэвшлийн лабораторийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх</p>	<p>Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид 451 ширхэг стандарт ашиглагдаж байна. Барилгын материалд хэрэглэгдэж байгаа дотоодын түүхий эдэд хэрэглэгдэх стандартуудын тооллогын хийж, шинэчлэх шаардлагатай стандартуудын саналыг СХЗГазарт хүргүүлэн дэмжигдсэн. Цементийн евро 14 нэр төрлийн стандартыг боловсруулан батлуулахаар хүргүүлээд байна.</p> <p>EN 197-1;2011 цементийн найрлага, техникийн шалгуур EN 197-2;2014 цементийн 2-р хэсэг тохирлын үнэлгээ EN 413-1;2011 өргийн цемент найрлага техникийн шаардлага EN 413-2;2016 өргийн цемент турших арга EN 196-1;2016 цемент турших арга бат бэх тодорхойлох EN 196-2;2013 цементийн химийн шинжилгээ EN 196-3;2016 цементийн турших арга барьцалдах хугацаа болон эзлэхүүний жигд өөрчлөлтийг тодорхойлох арга EN 196-5;2011 цемент турших арга EN 196-7;2007 цемент нунтаглалт EN 196-8;2010 цементийн бат бэх тодорхойлох EN 196-9;2010 цементийн дулаан ялгаруулалт EN 196-10;2016 цементийн хромын хэмжээ EN 14216;2016 бэхжилтийн үеийн дулаан стандартуудыг стандартын техникийн хороогоор албажуулахаар хүргүүлэн хүлээгдэж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>1.10 Шинжлэх ухааны академи, их, дээд сургууль бусад лабораторуудын хооронд төрөлжих, дагнах, хорших, хамтарч шинжилгээ судалгаа хийх харилцаа, холбоог тогтоон, барилгын материалын судалгаа, шинжилгээний ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>2018 оноос ШУТИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна. Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид хийгдэж байгаа туршилт, шинжилгээг улсын хэмжээнд итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран хяналт мониторинг хийж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>1.11. Барилгын материалын үйлдвэрлэлийн дотоодын чанарын удирдлагын тогтолцоонд олон улсын арга, туршлага, стандартыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<p>Салбарын яамнаас барилгын материалын үйлдвэрүүдийн дотоодын лабораторийн хяналтыг сайжруулах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд энэ талаар "Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгасан. Барилгын материалын зөвлөх инженерүүд орон нутгийн болон үйлдвэрийн лабораторийг чадавхижуулах чиглэлд зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 40%/</p>
<p>1.12. Барилгын материалын чанарт тавих хяналтын үйл ажиллагааг төрийн бус</p>	<p>Барилгын материал бүтээгдэхүүнд Тохирлын үнэлгээ явуулж, Тохирлын гэрчилгээ олгох үйл ажиллагааг БХТ-өөс гадна БАК ХХК, БХҮНТ ТББ-ууд СХЗГ-аас итгэмжлэл аван гүйцэтгэж байна. Цаашид</p>

байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх	эрчим хүчний хэмнэлттэй барилгын цонхонд шошго олгох ажлыг зохион байгуулахаар холбогдох ТББ, хувийн хэвшил /Ачит үйлс ХХК лабораторийн үйл ажиллагаа явуулдаг/-тэй хамтран ажиллаж байна. <i>/Хэрэгжилт 70%/</i>
Зорилт 2. Барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүний чанарт тавих лабораторийн хяналтын тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд	
2.1.Барилгын материалын чанарын хяналтыг хамрах хүрээгээр нь байгууллага, орон нутаг, улсын түвшинд хэрэгжүүлэхээс гадна зориулалтаар нь түгээмэл хэрэглээний буюу мэргэжлийн лаборатори, тусгай зориулалтын буюу төрөлжсөн лаборатори байгуулах замаар зохион байгуулах	Барилга, хот байгуулалтын Сайдын А/193 тоот тушаалаар батлагдсан дүрмийн хүрээнд барилгын материалын лабораторийг Улаанбаатар хот, аймгуудад үйд ажиллагааны чиглэлээр нь төрөлжүүлэн хөгжүүлж өргөжүүлэх зорилго тавин ажиллаж байна. Каритас Чех репаблик Монгол ТББ-тай хамтран Монгол улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн хүрээнд дахин төлөвлөлтөөр нураагдаж буй Барилгаас үүсэх хог хаягдал ба түүнийг дахин ашиглах нь сэдэвт сургалтад нийт 75 барилгын салбарын мэргэжилтэнд практик сургалт зохион байгуулсан. 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Стандарт, хэмжил зүйн газар, БНХАУ-ын үндэсний барилгын материалын хяналт, баталгаажуулалтын групп, химийн шинжилгээг Мон-Цемент, Мак, Хөтөл, Налгартушиг, БАК, ШУТИС-ийн БАС, Зам Тээврийн Хөгжлийн Төвийн лабораторийн нийт 20 химичид практик сургалт зохион байгуулж хийж цементийн химийн сорилт шинжилгээ зааж сургасан болно. <i>/Хэрэгжилт 70%/</i>
2.2.Барилгын материалын үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний чанарыг стандартад заасан үндсэн үзүүлэлтээр нь баталгаажуулах ажлыг өөрийн лабораторид буюу гэрээний үндсэн дээр итгэмжлэгдсэн лабораторид тогтоож, дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлж ажиллах	СХЗГазрын баталгаажуулалтын албаны итгэмжлэлээр БХТөвийн харьяа Баталгаажуулалтын алба хамтран ажиллаж байна. Барилгын материалын чанарт тавих хяналтыг үйл ажиллагааг баталгаажуулалтын албуудаар дамжуулан хийж 21 аймгийн ГХБХБГазартай хамтран орон нутагт үйлдвэрлэж байгаа импортоор орж ирдэг барилгын материал бүтээгдэхүүнийг баталгаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Барилгын материал, хийц бүтээцийн шинжилгээний багаж тоног төхөөрөмжийг 2019 онд Стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулан жилийн хугацаатай гэрчилгээ авсан болно. <i>/Хэрэгжилт 70%/</i>
2.3 Барилгын түгээмэл хэрэглээний материал, түүхий эд, бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, физик механик үндсэн шинж чанар, зарим технологийн шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох мэргэжлийн лабораторийг аймаг, орон нутгийн түвшинд хяналт хийх зорилгоор байгуулж, өргөжүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх	Барилгын материалын сорилт шинжилгээний төв лаборатори орон нутгийн барилгын материалын лабораториудад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, орон нутгийн шинжээч, лаборантуудыг барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид дадлагажуулах, сургах ажлыг зохион байгуулсан болно. <i>/Хэрэгжилт 70%/</i>
2.4.Барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүний үндсэн шинж чанараас гадна галд тэсвэрлэлт, цацраг идэвхи, эрүүл ахуй, органик материал, хийц бүтээц болон асфалт бетон, хөрсний физик-механик, технологийн буюу эдэлгээний шинж чанар, хими-эрдэсийн бүтэц, найрлагад бүрэн сорилт, шинжилгээ хийх гэх мэт мэргэжлийн болон төрөлжсөн лабораторийг улсын түвшинд хяналт хийх зорилгоор Улаанбаатар хотод байгуулах	Улаанбаатар хотод ажиллаж байгаа барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид өнөөдрийн байдлаар 9 төрлийн лабораторийн туршилт шинжилгээ хийж ажиллаж байна. Гэвч барилгын материалын төрөл нэмэгдэж байгаатай уялдан шинэ тоног төхөөрөмж, нарийн мэргэжлийн инженерүүд зайлшгүй шаардлагатай байна. Одоогийн байдлаар Онцгой байдлын ерөнхий газрын лабораторид барилгын материалын галын шинжилгээ, туршилтын ажлыг хийж дүгнэлтийг гаргаж байна. <i>/Хэрэгжилт 70%/</i>
2.5.Гаалийн хяналтын лаборатори нь Монгол Улсын	Замын-Үүдийн чөлөөт бүст "Барилгын материалын импортын хангамж, тээвэр ложистикийн төв" байгуулах төслийг салбарын

<p>хил, гаалиар орж ирж байгаа барилгын материалын үндсэн шинж чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд мэргэжлийн болон төрөлжсөн лабораторитай хамтран хурдавчилсан аргаар үнэлгээ дүгнэлт өгөх ажлыг гүйцэтгэх</p>	<p>яамнаас боловсруулсан бөгөөд энэхүү төвд барилгын материалын сорил шинжилгээний лаборатори байгуулах талаар тусган ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>2.6 Барилгын материалын чанарын хяналтыг үйл ажиллагааны хэлбэрээр нь үйлдвэрлэгчийн болон хөндлөнгийн хяналтаар зохион байгуулах</p>	<p>Барилгын материал, бүтээгдэхүүний чанарын хяналтыг үйлдвэрлэлийн дотоод лабораториор болон хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториудаар хянаж байна. Бүтээгдэхүүнд баталгаажуулалт хийхдээ баталгаажуулалтын шинжээчийн авсан дээжид итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторийн хийсэн шинжилгээний үр дүнг харгалзан үнэлгээ хийж байна. Барилгын материал, бүтээгдэхүүнд Тохирлын үнэлгээ хийхдээ Тохирлын үнэлгээний 3 байгууллага дотоодын болон хөндлөнгийн лабораторийн дүгнэлт, ялангуяа баталгаажуулалтын шинжилгээний дүгнэлтийг үндэслэн орон тооны бус “Баталгаажуулалтын алба”-аар хэлэлцүүлэн “Тохирлын гэрчилгээ” олгох эсэхийг шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>2.7 Барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн барилгын материалын лаборатори нь оролтын хяналт (түүхий эд), технологийн хяналт (үйлдвэрлэлийн дамжлага буюу явц), гаралтын хяналт (бэлэн бүтээгдэхүүнд)-д лабораторийн шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллаж үйлдвэрлэгчийн (дотоод) хяналтын үйл ажиллагааг зохион байгуулах</p>	<p>2019 онд Барилгын материалын сорил шинжилгээний лабораторид тавигдах MNS ISO/IEC 17025:2017 стандартын дагуу чанарын гарын авлага боловсруулан мөрдөж ажиллах талаар материал үйлдвэрлэгчдэд зөвлөгөө өгч, хамтран ажиллаж байна. Дотоодын барилгын материалын үйлдвэрүүдийн тусгай зөвшөөрлийг олгох ажлын мэргэжлийн экспертийн баг нь үйлдвэрүүдийг өөрийн дотоодын хяналтын лабораторитой байх зөвлөмж хүргүүлж, үйлдвэрлэгч өөрийн лабораторитой болж байгаа бөгөөд дотоодын хяналтаа хийж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
<p>2.8 Барилгын материалын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг чанарын баталгаажуулалт, тохирлын үнэлгээнд хамруулах ажлыг мэргэжлийн холбоод, бусад байгууллагуудад зохих журмын дагуу эрх олгох замаар хөндлөнгийн хяналтыг өргөжүүлэх, зохион байгуулах</p>	<p>“Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо”, “Цонх хаалга үйлдвэрлэгчдийн холбоо” зэрэг ТББ-уудын төлөөлөл Баталгаажуулалтын байгууллагуудын шинжээчээр ажиллахын зэрэгцээ тэдгээр байгууллагын төлөөлөл “Баталгаажуулалтын алба”-ны гишүүнээр оролцон ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
<p>2.9. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн дагуу стандартчиллын төв байгууллагаас эрх авсан итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээ олгох</p>	<p>Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн дагуу стандартчиллын төв байгууллагаас эрх авсан итгэмжлэгдсэн баталгаажуулалтын албаны байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Баталгаажуулалтын албаны үйл ажиллагаанд Стандарт хэмжил зүйн газар нь хуулийн хүрээнд хяналт тавьж ажилладаг болно. 2019 оны байдлаар 3 алба үйл ажиллагаа явуулж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
<p>2.10 Орон сууц, зочид буудал, эмнэлэг, сургууль цэцэрлэг зэрэг иргэний барилга байгууламжуудын эрчим хүчний хэмнэлт, дулааны алдагдал, дуу чимээ тусгаарлах шинж чанарын үзүүлэлтийг тогтоох зөөврийн лаборатори байгуулах</p>	<p>ШУТИС-ийн БАС-ийн дэргэд “Эрчим хүчний хэмнэлтийн төв” болон ЭХЗХ-ны дэргэдэх байгууллага орон сууц, зочид буудал, эмнэлэг, сургууль цэцэрлэг зэрэг иргэний барилга байгууламжуудыг эрчим хүчний хэмнэлт, дулааны алдагдал, дуу чимээ тусгаарлах шинж чанарын үзүүлэлтийг тогтоох зөөврийн лаборатори ажиллуулж, үнэлгээ, дүгнэлт гаргаж байна. Цаашид БХТ-ийн дэргэдэх Барилгын физикийн лаборатори байгуулах төсөл боловсруулсан. “Ачит үйлс” ХХК-ийн лаборатори цонхны эрчим хүч хэмнэлтийн үзүүлэлтүүдийг үздэг бөгөөд итгэмжлэлийн материал бүрдүүлэн СХЗГ-т хүсэлтээ гаргаад байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
<p style="text-align: center;">Зорилт 3. Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийг өргөжүүлэх зорилтын хүрээнд</p>	

<p>3.1.Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн дагуу стандартчиллын төв байгууллага нь барилгын материалын сорилт шинжилгээний лабораториудад итгэмжлэл олгож, итгэмжлэгдсэн лаборатори нь холбогдох стандартын дагуу барилгын материал бүтээгдэхүүнд сорилт шинжилгээ хийдэг тогтолцоонд шилжих</p>	<p>Стандарчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн дагуу стандартчиллын төв байгууллага нь барилгын материалын сорилт шинжилгээний лабораториудад итгэмжлэл олгож, итгэмжлэгдсэн лаборатори нь холбогдох стандартын дагуу барилгын материал бүтээгдэхүүнд туршилт шинжилгээ хийж байна.</p> <p>2019 онд Улаанбаатар хотын Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторид 13014 ширхэг дээжний сорилт, шинжилгээний хариунд хяналт тавьж мониторинг хийсэн байна. Одоогоор мөрдөгдөж байгаа Стандарчилал, тохирлын үнэлгээний хуулиар итгэмжлэгдсэн лабораториуд нь барилгын материалд сорилт, туршилт хийж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
<p>3.2 Аймгийн төв тус бүрт цемент, будаг, керамик, металл, зэрэг 5-8 багц нэр төрлийн лабораторийг үе шаттайгаар шинээр байгуулах, зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн дутууг нэмж нийлүүлэх, шинэчлэх</p>	<p>Аймгийн төв тус бүрт цемент, будаг, керамик, металл, зэрэг 5 нэр төрлийн лабораторийг үе шаттайгаар шинээр байгуулахаар зорилт тавин ажиллаж байна. Одоогийн байдлаар 21 аймаг тус бүрт бетон дүүргэгчийн лаборатори болон керамик эдлэхүүний лабораториуд хэвийн ажиллаж байгаа болно.</p> <p>2019 онд аймаг тус бүр орон нутгийн хөрөнгөөр барилгын материалын лабораторийн шаардлагатай зарим тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>Улсын төсөв болон зээл тусламжаар аймгуудын лабораториудыг өргөжүүлэх, иж бүрэн тоног төхөөрөмжөөр ханган, нэмэгдүүлэх саналыг боловсруулан холбогдох газарт тогтмол хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>21 аймаг тус бүр 3 багц -Металл хийц эдлэхүүний лаборатори /21 аймагт/ -Цонх хаалганы лаборатори /21 аймагт/ -Цементийн лаборатори /14 аймагт/ шаардлагатай тоног төхөөрөмжүүд /иж бүрэн/</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>3.3 Улаанбаатар хот дахь Зураг төсөл, эрдэм шинжилгээний институт (цаашид “институт” гэх)-д дулаан-цахилгаан, өргөх машин механизм, цахилгааны утас, газар хөдлөл, органик материал, төмөр, бетон эдлэхүүний үйлдвэрлэл туршилтын цехийн 7 багц нэр төрлийн лабораторийг шинээр байгуулах, бетон дүүргэгч, керамик, цемент холбогч, хими, будаг, хуванцар, хаалга-цонх, металл, рентген шинжилгээний багц нэр төрлийн лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн дутууг нэмж авах, шинэчлэх</p>	<p>Барилгын хөгжлийн төвийн дэргэд Зураг төсөл эрдэм шинжилгээний институт байгуулагдан 2 жил ажиллаад улмаар 2016 онд Засгийн газрын тогтоолоор татан буугдсан.</p> <p>-Дулаан-цахилгаан -Өргөх машин механизм, цахилгааны утас -Газар хөдлөл гэсэн 3 багц нэр төрлийн лабораторийг шинээр байгуулахаар зорилт тавин ажиллаж байгаа боловч санхүүгийн асуудлаас шалтгаалан тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдэхгүй байна.</p> <p>2019 онд улсын төсвөөр 1.412 тэрбум төгрөгийн 28 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэн 2019 онд ашиглалтад орсон болно.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
<p>3.4 Замын-Үүд болон жилийн туршид тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг байгын ажиллагаатай хиймийн боомтод импортын барилгын материалд физик, механик туршилт, шинжилгээ хийх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий хурдавчилсан аргаар чанарыг хянах лаборатори байгуулах</p>	<p>Барилга, хот байгуулалтын сайд 2015 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Засгийн газартай байгуулсан Санамж бичигт энэ асуудлыг тусгаснаас гадна “Хөгжлийн зам” хөтөлбөр, “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-д тус тус тусган холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа болно.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
<p>3.5 Барилгын материалын үйлдвэр бүр үйлдвэрлэлийн</p>	<p>Уг шаардлагыг тохирлын үнэлгээ хийж байгаа үйлдвэрүүдэд тавьж дотоодын лабораторигүй үйлдвэрийг лабораторитой болж,</p>

явцад бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт хийх дотоодын лабораторитай байх	баталгаажуулалт хийлгэхийг үүрэг болгон “Тохирлын гэрчилгээ”-ний гэрээнд тусган хэрэгжүүлж байна. <i>/Хэрэгжилт 100%/</i>
3.6 Лабораторийн нэр төрөл, тоног төхөөрөмжийн судалгааг нарийвчлан хийж, төсөв хөрөнгийн зохицуулалт хийж ажиллах	Монгол Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын Хорооны 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 05/13 тоот тогтоолоор “...барилга байгууламжийн хийц, бүтээцийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг тогтоох, турших, дүгнэлт өгөх, барилгын төлөвлөлт, угсралт, ашиглалтын үе шатны чанар, аюулгүй байдлыг хянах чиглэлээр нэгдсэн лабораторийн сүлжээг нийслэл хот, аймаг бүрд бий болгон ажиллуулах, тэдгээрийг боловсон хүчин, багаж техник, тоног төхөөрөмжөөр хангах, барилгын материалын сорил шинжилгээний төв лабораторийн бүтэц, орон тоог баталж, цалин хөлс, холбогдох зардлыг 2019 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх” гэсэн заалт тусгагдаж уг заалтын хүрээнд 2020 онд шаардлагатай төсвийг Сангийн Яаманд хүргүүлсэн боловч 2020 оны Төсвийн тухай хуулинд тусгагдаагүй болно. <i>/Хэрэгжилт 40%/</i>
3.7 Орон нутаг дахь лабораторийн хөрөнгө оруулалт ба урсгал зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх	Монгол Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын хүрээнд барилгын материалын лабораторийн төсөв хөрөнгийг улсын төсөвт суулгахаар, шаардлагатай тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвөөс гаргуулахаар ажиллаж байна. <i>/Хэрэгжилт 100%/</i>
3.8 Хувийн хөрөнгө оруулалтаар лаборатори байгуулан ажиллахыг бодлогоор дэмжих	Хувийн хэвшлийн лабораториуд байгуулагдаж байна. Тухайлбал, Ачит үйлс ХХК-ийн цонхны лаборатори, “Аргай чулуу” ХХК-ийн бетон, керамикийн лаборатори зэрэг 10 гаруй лаборатори байгуулагдаад байна. <i>/Хэрэгжилт 100%/</i>
Сорилт 4 . Хүний нөөц, боловсон хүчнийг бэлтгэх зорилтын хүрээнд	
4.1.Лабораторийн ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах, туршлагажих нөхцөлийг хангах	Төв лабораторийн шинжээч нарын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор -MNS ISO/IEC 17025:2018 стандартын сургалтад 6 хүн, Химийн задлан шинжилгээний сургалтад 4 хүн, Хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах сургалтад 2 хүн, Шударга ёс ба авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад 8 хүн, Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн Барилгаас гарах хог хаягдал ба түүнийг дахин ашиглах нь сургалтад 11 хүн, БХТ-д Инженер техникийн ажилтнуудад зориулсан чадавхижуулах сургалтад 6 хүн тус тус хамрагдсан бөгөөд нийт 6 төрлийн сургалтад шинжээч, лаборантууд хамрагдсан байна. <i>/Хэрэгжилт 100%/</i>
4.2 Лабораторийн хүний нөөцийг дотоод болон гадаад орнуудад сургаж бэлтгэх, дадлагажуулах, харилцан солилцох, давтан сургах, мэргэшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	СХЗГ, “Мон-Цемент”ХХК мөн БНХАУ-ын байгууллагатай хамтран 2019.12.02-2019.12.04-нд БМСШЛ-д цементийн химийн шинжилгээ хийх талаар сургалт зохион байгуулж мэргэжилтнүүдийг сургасан болно. Нийт 7 төрлийн сургалтад 11 шинжээч, лаборант хамрагдан сертификат авсан байна. <i>/Хэрэгжилт 70%/</i>
4.3 Орон нутгийн барилгын материалын сорилт, шинжилгээний лаборатори болон ижил төстэй байгууллагуудын шинжээч, лаборантуудыг барилгын материалын сорилт, шинжилгээний төв лабораторт дадлагажуулж, сертификат олгох сургалтыг нэвтрүүлэх	Орон нутгийн барилгын материалын лабораториудад ажиллаж байгаа шинжээчдийг дадлагажуулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна. - Дорнод аймгийн ГХБХБГ-ын БМЛ-д Чанарын гарын авлага боловсруулахад, - Орхон аймгийн ГХБХБГ-ын БМЛ-д сорилт шинжилгээний үр дүнг архивлаж хадгалахад, - Завхан аймгийн ГХБХБГ-ын БМЛ-д хайрга, дайрга, бетон сорьц, керамик тоосго, явган зам талбайн хавтангийн дээжид физик механик сорилт хийж хариуг боловсруулахад, - Дорноговь аймгийн ГХБХБГ-ын БМЛ-д Чанарын гарын авлага боловсруулж, итгэмжлэлээ сунгах материал бэлтгэхэд, - Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын БМЛ-д бетон гулдмайн дээжид сорилт шинжилгээ хийж үр дүнг тооцох,

		- Увс аймгийн ГХБХБГ-ын БМЛ-д гарын үсгийн хэвний загвараа СХЗГ-т гаргах гэх мэт 16 аймгийн БМЛ-д тус тус 36 удаагийн мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн. /Хэрэгжилт 70%/
	4.4 Газар хөдлөл, хими, хөрсний гэх мэт нарийн төвөгшилтэй лабораторид гадаадын мэргэжилтэн урьж, хамтран ажиллах, сургалт явуулах	Барилгын материалын сорил шинжилгээний лабораторид мэргэжилтэн урих, сургалт явуулах, ажилчдыг Япон Улсад сургалтад хамруулах талаар гадаадын донор байгууллагууд, сургалтын байгууллагуудад санал хүргүүлсэн боловч санхүүгийн асуудлаас шалтгаалан тодорхой сургалтанд хамрагдаагүй болно. /Хэрэгжилт 0%/
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Ололт: А.Төрөөс барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг байгуулах талаар арга хэмжээ авч ажилласаны үр дүнд Улаанбаатар хотод өөрийн байртай 9 төрлийн лаборатори үйл ажиллагаа явуулж байна. Б. Аймаг орон нутагт барилгын материалын лабораторийн эхлэл тавигдаж өнөөдрийн байдлаар улсын төсвөөр Ховд, Дорноговь, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Өмнөговь, Баянхонгор аймгууд барилгын материалын лабораторийн барилга бариулан ашиглалтанд оруулаад байна. В. Ховд, Архангай, Дорноговь, Баянхонгор, Баян-Өлгий зэрэг аймгууд барилгын материалын лабораторидоо Стандарт, хэмжил зүйн газраас итгэмжлэл аваад байна. Г.Улаанбаатар хотын Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд 1.412,000,000 төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Д.Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид 95 ширхэг тоног төхөөрөмжөөр 96 нэр төрлийн дээжинд 202 үзүүлэлтээр шинжилгээ хийж байна. Е.Тоног төхөөрөмж болон 5 лабораториор хүчин чадлаа нэмэгдүүлсэнээр 2020 он гэхэд бүрэн ажиллаж 715 үзүүлэлтээр шинжилгээ хийх боломж бүрдэнэ. Дутагдал: А.Үйлдвэрлэгч, барилгын материал нийлүүлэгчид бүтээгдэхүүний чанарт анхаарахгүй хямд зардлаар барилга угсралтын ажил гүйцэтгэж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор учруулж байгаа нь барилгын зарим материал дээр харагдаж байна. Иймээс дотоодын үйлдвэрлэгчдийн материалын чанарыг дээшлүүлэхэд дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж ашиглах, холбогдох мэргэжилтэнг бэлтгэх нь чухал юм. Б. Дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнд болон импортын барилгын материалын чанарт тогтмол сорилт, туршилт, судалгаа хийж чадахгүй байгаа тул лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хүний нөөцийн цогц систем, бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байгааг нотолж байна. В.Улс орны эдийн засгийн байдалтай холбоотойгоор лабораторийн тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж чадахгүй байна. Г.Орон нутагт ажлын орон тоо, бүтцээс шалтгаалан барилгын материалын лабораторийг өргөжүүлэх, тогтвортой ажиллуулж чадахгүй байгаа зэрэг асуудлууд байна. Д. Хууль эрх зүйн орчныг сайжруулах гм төсөв хөрөнгөтэй холбогдолгүй удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалж хэрэгжээгүй арга хэмжээ байгаад цаашид анхаарах шаардлагатай байна.
8	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 308 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр" –ийг 4 зорилтын хүрээнд 2016 -2020 он хооронд хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа хангалттай боловч сүүлийн жилүүдэд барилгын материалын лабораториудыг өргөжүүлэх санхүүжилт дутмаг, үйл ажиллагаа нь өргөжихгүй

		байгаагаас шалтгаалан барилгын материалын чанар болон барилгын ажлын үе шатны хяналт сайжрахгүй байна.					
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлтийн дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		Хэрэгжилтийн түвшин 70.%	4	70	70	70	70
10	Хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)						

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЧАНАРТ ТАВИХ ЛАБОРАТОРИЙН
ХЯНАЛТЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**
/2019 оны жилийн эцсийн байдлаар/

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

ХОЕР. ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

“Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр” нь Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18 -ны өдрийн 308 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд уг хөтөлбөрийг 2014-2020 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь барилга байгууламжид хэрэглэх барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүний чанарт тавих лабораторын хяналтыг өргөжүүлэн, барилгын чанар, аюулгүй байдлыг хангах, улмаар хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Тус хөтөлбөрийн 4 зорилтод хүрэх үйл ажиллагааны заалт бүрээр хэрэгжилтийг хувиар тооцон гаргаж хавсралтаар үзүүлэв. Хөтөлбөр хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар **70.0 хувийн** биелэлттэй байна.

№	Хөтөлбөрийн зорилт	Арга, хэмжээ /тоо/	Хэрэгжилтийн түвшин
1	Зорилт 1. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох	12	70%
2	Зорилт 2. Барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүний чанарт тавих лабораторийн хяналтын тогтолцоог бий болгох	10	70%
3	Зорилт 3. Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийг өргөжүүлэх	8	70%
4	Зорилт 4. Хүний нөөц, боловсон хүчнийг бэлтгэх	4	70%
	Дүн	34	70%

Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Зорилт – 1. Хууль эрх зүйн орчинг сайжруулах хүрээнд:

/1.1/ Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”-нд барилгын материалын чанар аюулгүй байдалтай холбоотой зохицуулалтыг техникийн зохицуулалт, стандарт, нормоор зохицуулах заалт орсон дагуу “Барилгын материал, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ыг шинээр боловсруулах техникийн даалгавар боловсруулаад байна.

/1.4/ Барилгын материал, бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтад хамруулан тохирлын гэрчилгээ олгох 3 байгууллага ажиллаж байна. 2019 онд Барилгын хөгжлийн төвөөс 80, БАК-62, БХҮНТөв-40, нийт 182 аж ахуй нэгжид тохирлын гэрчилгээ олгосон байна.

Зорилт - 2. Барилгын материалын лабораторийн хяналтыг нэмэгдүүлэх хүрээнд:

/2.8/ “Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо”, “Цонх хаалга үйлдвэрлэгчдийн холбоо” зэрэг ТББ-уудын төлөөлөл баталгаажуулалтын байгууллагуудын шинжээчээр ажиллахын зэрэгцээ тэдгээр байгууллагын төлөөлөл “Баталгаажуулалтын алба”-ны гишүүнээр оролцон ажиллаж байна.

/2.9/ Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн дагуу стандартчиллын төв байгууллагаас эрх авсан итгэмжлэгдсэн баталгаажуулалтын албаны байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Баталгаажуулалтын албаны үйл ажиллагаанд Стандарт, хэмжил зүйн газар нь хуулийн хүрээнд хяналт тавьж ажилладаг болно. 2019 оны байдлаар 3 алба үйл ажиллагаа явуулж байна.

/2.10/ ШУТИС-ийн БАС-ийн дэргэд “Эрчим хүчний хэмнэлтийн төв” болон ЭХЗХ-ны дэргэдэх байгууллага орон сууц, зочид буудал, эмнэлэг, сургууль цэцэрлэг зэрэг иргэний барилга байгууламжуудыг эрчим хүчний хэмнэлт, дулааны алдагдал, дуу чимээ тусгаарлах шинж чанарын үзүүлэлтийг тогтоох зөөврийн лаборатори ажиллуулж, үнэлгээ, дүгнэлт гаргаж байна. Цаашид БХТ-ийн дэргэд барилгын физикийн лаборатори байгуулах төсөл боловсруулсан. “Ачит үйлс” ХХК-ийн лаборатори цонхны эрчим хүч хэмнэлтийн үзүүлэлтүүдийг үздэг бөгөөд итгэмжлэлийн материал бүрдүүлэн СХЗГ-т хүсэлтээ гаргаад байна.

Зорилт-3. Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийг өргөжүүлэх хүрээнд:

/3.1/ 2019 онд Улаанбаатар хотын Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторид 13014 ширхэг дээжний сорилт, шинжилгээний хариунд хяналт тавьж мониторинг хийсэн байна. Одоогоор мөрдөгдөж байгаа Стандартчилал, тохирлын үнэлгээний хуулиар итгэмжлэгдсэн лабораториуд нь барилгын материалд сорилт, туршилт хийж байна.

/3.3/ 2019 онд улсын төсвөөс 1.412 тэрбум төгрөгийн 28 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэн 2019 онд ашиглалтад орсон.

/3.8/ Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийг өргөжүүлэх зорилгоор хувийн хэвшлийн лабораториуд байгуулагдаж байна. Тухайлбал “Ачит үйлс” ХХК-

ийн цонхны лаборатори, “Аргай чулуу” ХХК-ийн бетон, керамикийн лаборатори зэрэг 10 гаруй лаборатори байгуулагдаад байна.

Зорилт-4. Барилгын материалын лабораторийн хүний нөөц, боловсон хүчин бэлтгэх хүрээнд:

/4.1/ Төв лабораторийн шинжээч нарын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор -MNS ISO/IEC 17025:2018 стандартын сургалтад 6 хүн, Химийн задлан шинжилгээний сургалтад 4 хүн, Хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах сургалтад 2 хүн, Шударга ёс ба авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад 8 хүн, Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн барилгаас гарах хог хаягдал ба түүнийг дахин ашиглах нь сургалтад 11 хүн, Барилгын хөгжлийн төвд инженер техникийн ажилтнуудад зориулсан чадавхижуулах сургалтад 6 хүн тус тус хамрагдсан бөгөөд нийт 6 төрлийн сургалтад шинжээч, лаборантууд хамрагдсан байна.

“Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэний давуу талууд :

1.Төрөөс барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг байгуулах талаар арга хэмжээ авч ажилласаны үр дүнд Улаанбаатар хотод өөрийн байртай 9 төрлийн лаборатори үйл ажиллагаа явуулж байна.

2. Аймаг орон нутагт барилгын материалын лабораторийн эхлэл тавигдаж өнөөдрийн байдлаар улсын төсвөөр Ховд, Дорноговь, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Өмнөговь, Баянхонгор аймгууд барилгын материалын лабораторийн барилга бариулан ашиглалтанд оруулаад байна.

3. Ховд, Архангай, Дорноговь, Баянхонгор, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Орхон зэрэг аймгуудын барилгын материалын лабораториуд Стандарт, хэмжил зүйн газраас итгэмжлэл аваад байна.

4. Улаанбаатар хотын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд 1.412.000.000 төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Уг лабораторид 95 тоног төхөөрөмжөөр 96 нэр төрлийн дээжид 202 үзүүлэлтээр шинжилгээ хийж байна.

5. Тоног төхөөрөмж болон 5 лабораториор хүчин чадлаа нэмэгдүүлсэнээр 2020 он гэхэд бүрэн хүчин чадлаараа ажиллаж 715 үзүүлэлтээр шинжилгээ хийх боломж бүрдэх зэрэг сайн тал байна.

Дутагдалтай талууд:

1. Үйлдвэрлэгч, барилгын материал нийлүүлэгчид бүтээгдэхүүний чанарт анхаарахгүй хямд зардлаар барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор учруулж байна. Иймээс дотоодын үйлдвэрлэгчдийн нийлүүлж буй материалын чанарыг сайжруулж, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж ашиглах, холбогдох мэргэжилтэнг бэлтгэх зэрэг асуудалд анхаарах шаардлагатай байна.

2. Дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний чанар мөн импортын барилгын материалын чанарт тогтмол сорилт, туршилт, судалгаа хийж чадахгүй байгаад анхаарч

лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, боловсон хүчний бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3. Улс орны эдийн засагтай холбоотойгоор лабораторийн тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж чадахгүй байна.

4. Орон нутагт ажлын байр, орон тоо, бүтцээс шалтгаалан барилгын материалын лабораторийг өргөжүүлэх, боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад бэрхшээлтэй олон асуудлууд гарч байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

1. Аймаг тус бүрт цемент, будаг, керамик, металл зэрэг 4 нэр төрлийн лабораторийг үе шаттайгаар шинээр байгуулах зорилт тавин ажилласны дүнд одоогийн байдлаар бүх аймгуудад бетон дүүргэгчийн лаборатори иж бүрэн ажиллаж байна.

2. Орон нутгийн барилгын материалын лабораторид ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг Улаанбаатар хотын сорилт шинжилгээний лабораторид 7 ба 14, 21 хоногоор дадлагажуулах ажлыг БХТөвийн төлөвлөгөөнд тусгуулан дагалдан сургах ажил хуваарийн дагуу зохион байгуулагдаж хэвшсэн байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүний чанарт тавих лабораторийн хяналтын тогтолцоог бий болгох зорилтуудын хүрээнд хэрэгжилт хангалтгүй ажлуудыг яаралтай хийж гүйцэтгэх;

2. Барилгын сорилт, шинжилгээний лабораторийг өргөжүүлэх зорилтын хүрээнд хийгдэх ажлууд санхүүжилт шийдвэрлэгдээгүй шалтгаанаар жил бүр тодорхой үр дүнд хүрэхгүй, бодит ажил хийгдэхгүй байгаа тул санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, хөтөлбөрийн биелэлтийг хангуулахад холбогдох байгууллагууд онцгой анхаарч ажиллах;

3. Замын-Үүд болон жилийн туршид тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг байнгын ажиллагаатай хилийн боомтуудад импортын барилгын материалд физик, механик туршилт, шинжилгээ хийх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий хурдавчилсан аргаар чанарыг хянах лаборатори байгуулах зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

4. Хөтөлбөрт тусгагдсан хүний нөөц, боловсон хүчнийг бэлтгэх ажлыг холбогдох газрууд 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ” ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2019 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл																																						
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>“Түрээсийн орон сууц” хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 248-р тогтоолоор батлагдсан.</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Орон сууц худалдан авах боломжгүй, түрээсийн орон сууцанд амьдрах сонирхолтой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн өмчийн бүх хэлбэрийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах.</p>																																						
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> ➢ Улс, орон нутгийн төсөв; ➢ Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт; ➢ Гадаад дотоодын зээл тусламж; ➢ Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө; ➢ Бусад. 																																						
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p>																																						
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, ашиглах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;</p> <p>Зорилт 2. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, ашиглах бодлого, зохицуулалтын таатай орчныг бүрдүүлэх;</p> <p>Зорилт 3. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж ашиглах.</p>																																						
5.	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td data-bbox="269 1010 375 1163">Зардал</td> <td data-bbox="375 1010 586 1163">Төсөв (нийт шаардагдах зардал)</td> <td colspan="4" data-bbox="586 1010 1508 1163"> <p>Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ: 1,118,905.44 сая төгрөг, үүнээс Улсын төсвийн хөрөнгө оруулалт: 108,288.04 сая төгрөг, Орон нутгийн төсөв, Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө: 478,613.93 сая төгрөг</p> <p>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт: 532,003.47 сая төгрөг.</p> </td> </tr> <tr> <td data-bbox="269 1163 375 1226">Үүнд:</td> <td data-bbox="375 1163 586 1226">Төсөв</td> <td data-bbox="586 1163 773 1226">Гүйцэтгэл (2018)</td> <td data-bbox="773 1163 935 1226">Гүйцэтгэл (2019)</td> <td data-bbox="935 1163 1508 1226">Хувь</td> </tr> <tr> <td data-bbox="269 1226 375 1289"></td> <td data-bbox="375 1226 586 1289">Улсын төсөв</td> <td data-bbox="586 1226 773 1289">108,288.04</td> <td data-bbox="773 1226 935 1289">40,000.0</td> <td data-bbox="935 1226 1508 1289">-</td> <td data-bbox="935 1226 1508 1289">100%</td> </tr> <tr> <td data-bbox="269 1289 375 1436"></td> <td data-bbox="375 1289 586 1436">Орон нутгийн төсөв, Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө</td> <td data-bbox="586 1289 773 1436">478,613.93</td> <td data-bbox="773 1289 935 1436">4,300.00</td> <td data-bbox="935 1289 1508 1436">-</td> <td data-bbox="935 1289 1508 1436">9,0%</td> </tr> <tr> <td data-bbox="269 1436 375 1562"></td> <td data-bbox="375 1436 586 1562">Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт</td> <td data-bbox="586 1436 773 1562">532,003.47</td> <td data-bbox="773 1436 935 1562">-</td> <td data-bbox="935 1436 1508 1562">-</td> <td data-bbox="935 1436 1508 1562">-</td> </tr> <tr> <td data-bbox="269 1562 375 1667"></td> <td data-bbox="375 1562 586 1667">Хөгжлийн банкны санхүүжилт</td> <td data-bbox="586 1562 773 1667"></td> <td data-bbox="773 1562 935 1667">54,000.00</td> <td data-bbox="935 1562 1508 1667">189,600.00</td> <td data-bbox="935 1562 1508 1667">100%</td> </tr> </table>	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	<p>Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ: 1,118,905.44 сая төгрөг, үүнээс Улсын төсвийн хөрөнгө оруулалт: 108,288.04 сая төгрөг, Орон нутгийн төсөв, Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө: 478,613.93 сая төгрөг</p> <p>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт: 532,003.47 сая төгрөг.</p>				Үүнд:	Төсөв	Гүйцэтгэл (2018)	Гүйцэтгэл (2019)	Хувь		Улсын төсөв	108,288.04	40,000.0	-	100%		Орон нутгийн төсөв, Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө	478,613.93	4,300.00	-	9,0%		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	532,003.47	-	-	-		Хөгжлийн банкны санхүүжилт		54,000.00	189,600.00	100%				
Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	<p>Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ: 1,118,905.44 сая төгрөг, үүнээс Улсын төсвийн хөрөнгө оруулалт: 108,288.04 сая төгрөг, Орон нутгийн төсөв, Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө: 478,613.93 сая төгрөг</p> <p>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт: 532,003.47 сая төгрөг.</p>																																						
Үүнд:	Төсөв	Гүйцэтгэл (2018)	Гүйцэтгэл (2019)	Хувь																																				
	Улсын төсөв	108,288.04	40,000.0	-	100%																																			
	Орон нутгийн төсөв, Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө	478,613.93	4,300.00	-	9,0%																																			
	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	532,003.47	-	-	-																																			
	Хөгжлийн банкны санхүүжилт		54,000.00	189,600.00	100%																																			
6.	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилт:</p> <p>1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:</p>	<p>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.</p> <p>1.1.Орон сууцны тухай хуульд түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, ашиглах, түрээслэгч, түрээслүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага, түрээсийн төлбөртэй холбогдсон нэмэлт, өөрчлөлт оруулах</p> <p>Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2019.12.02-ны өдөр УИХ-д өргөн</p>																																						

барьсан. УИХ-ын 2019.12.18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар уг хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр УИХ-ын ЭЗБХ-нд шилжүүлээд байна.

Уг хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлэх, түүнд иргэдийг хамруулах ажлыг хэрхэн зохион байгуулах талаар тусгасан.

Биелэлт 100%.

1.2.Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах, тэдэнд хөнгөлөлт үзүүлэх журам боловсруулж хэрэгжүүлэх

“Түрээсийн орон сууц” хөтөлбөр баталсан Засгийн газрын 248 дугаар тогтоолын тогтоох хэсгийн 3-т “хөтөлбөрт хамрагдах нөхцөл, шалгуур үзүүлэлт болон тухайн жилд мөрдөх түрээсийн орон сууцны нэг сарын төлбөрийн хэмжээг баталж мөрдүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайдад даалгасугай” гэж заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны өдрийн 26 дугаар тушаалаар баталсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулж байгаа бөгөөд дараах нөхцөл, шаардлагыг хангасан иргэн бүртгүүлэх боломжтой байна. Үүнд:

- Эрх зүйн бүрэн чадамжтай, 21 насанд хүрсэн байх;
- тухайн орон нутагт байнга оршин суудаг байх;
- түрээсийн барьцаа, төлбөр болон орон сууцны ашиглалтын зардалаа төлөх боломжтой тогтмол орлоготой байх;
- бүртгүүлэх өдрийн байдлаар өөрийн өмчлөлийн инженерийн хангамжтай орон сууцгүй байх.

Дээрх шаардлагыг хангаж, бүртгэгдсэн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах сонгон шалгаруулалтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ.

д/д	Зорилтот бүлгийн ангилал	Түрээсийн орон сууцнаас олгох квот /хувь/		Шалгуур үзүүлэлт
		Нийслэл	Орон нутаг	
1	Залуу гэр бүл	20	10	Хүүхдийн тоо, түүнээс бага насны хүүхдийн тоо
2	Төрийн албан хаагч	25	30	Төрд ажилласан хугацаа
3	Хувийн байгууллага болон хувиараа хөдөлмөр эрхлэгч	20	20	Хүүхдийн тоо, түүнээс бага насны хүүхдийн тоо
4	4 түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл	5	5	Хүүхдийн тоо, түүнээс бага насны хүүхдийн тоо
5	Өрх толгойлсон эцэг, эх	5	5	Хүүхдийн тоо, түүнээс бага насны хүүхдийн тоо
6	Ахмад настан	15	20	Нас болон төрөөс хүртсэн гавьяа, шагнал
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	5	5	Хөдөлмөр чадвар алдагдалтийн хувь, хэмжээ, зэрэг төрөл болон чадвараа алдсан хугацаа
8	Байгалийн гамшигт үзэгдэлд өртсөн иргэн	5	5	Гамшигт өртсөн хугацаа болон гамшигт учирсан хохирлын хэмжээ

Биелэлт 100%.

1.3.Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэхэд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийг буцаан төвлөрүүлэх тогтолцоог бүрдүүлэх

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2016 оны 38, 298, 169 дүгээр тогтоолуудаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ /хуучнаар/ болон “Бэрэн”

		<p>группийн захиалгаар баригдаж ашиглалтад орсон 1512 айлын төрийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Мөн Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоолоор “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын дуусаагүй барилгын балансад бүртгэлтэй 1542 айлын орон сууцны 28 блок барилгыг өөрийн өртгөөр нь Хөгжлийн банкинд шилжүүлэх замаар гүйцээн барихад шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэн, ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоолоор дээрх тогтоолын хүрээнд ашиглалтад орсон 1542 айлын орон сууцыг аймаг, нийслэлийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж, эдгээр барилгуудыг барихад зарцуулсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг 5 жилд багтаан Монгол Улсын Хөгжлийн банкинд эргэн төлөх арга хэмжээ авахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан.</p> <p>Засгийн газрын удаа дараагийн тогтоолуудын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 3054 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулахад Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэрээс гаргасан 189.6 тэрбум төгрөгийн зээлийн төлбөрийг улсын төсвөөс эргэн төлөхөөр тогтсон боловч хэрэгжилт өнөөдрийн байдлаар хангагдаагүй байна.</p> <p>Иймд түрээсийн орон сууцны санхүүжилтийг шийдвэрлэх болон түрээсийн орон сууцанд хамрагдсан иргэдээс одоо түрээслэж буй орон сууцаа өмчилж авах хүсэлтийг Барилга, хот байгуулалтын яам болон “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-д удаа дараа гаргасны дагуу Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны 138 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх” журмыг батлуулсан.</p> <p>Ингэснээр иргэд одоо амьдарч буй түрээсийн орон сууцныхаа урьдчилгаа 30 хувийг 5 жилд багтаан бүрдүүлж, үлдсэн төлбөрийг ипотекийн зээлд хамрагдах хэлбэрээр төлөх эсхүл нийт төлбөрийг ямар нэгэн хүү болон ашгийн нэмэгдэлгүйгээр 5 жилд тэнцүү хуваан төлж, өөрийн өмчид шилжүүлэх боломж бүрдэхээс гадна уг төлбөрийг түрээсийн орон сууцны зардалд зарцуулахаар зохицуулсан.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%.</p> <p>1.4.Түрээсийн орон сууцны нэг сарын түрээсийн төлбөрийн хэмжээг Үндэсний статистикийн хорооноос гаргадаг жил бүрийн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд тулгуурлан өрхийн дундаж орлогын 25 хувиас хэтрэхгүй байхаар хот, хөдөөд ялгавартай тогтоож мөрдүүлэх</p> <p>Үндэсний статистикийн хорооноос “Монгол Улсын нэг өрхийн сарын дундаж орлого”-ын түвшин 2016 онд 1,007.1 мянга, 2017 онд 1,117.9 мянга, 2018 онд 1,281.5 мянган төгрөг болсныг албан ёсоор мэдээлсэнтэй уялдуулж тус яамнаас түрээсийн орон сууцны 1м.кв талбайн сарын төлбөрийг 2016 онд Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 28 дугаар тушаалаар нийслэлд 5500 төгрөг, орон нутагт 4000 төгрөг, 2017 онд Барилга, хот байгуулалтын сайдын 25 дугаар тушаалаар нийслэлд 6000 төгрөг, орон нутагт 4500 төгрөг байхаар тус тус тогтоон мөрдөж ирсэн. Уг төлбөрийн хэмжээг 2018, 2019 онуудад иргэдийн амьжиргаанд дарамт үүсгэхгүй байх үүднээс дахин нэмэгдүүлээгүй байна.</p> <p>Түрээсийн орон сууцны талбайн хамгийн хэмжээ 29м.кв, дээд хэмжээ 69.8 м.кв байгаа бөгөөд дунджаар 47.9 м.кв талбайтай орон сууцыг иргэдэд түрээслүүлж байна. Ингэснээр сард иргэнээс дунджаар нийслэлд 300.0 мянган төгрөг, орон нутагт 225.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрт авч байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%.</p> <p>1.5. Барилгын хийц, бүтээцээс хамааруулан орон сууцны барилгын 1м2 талбайн бодит өртгийг тооцон гаргаж, жил бүр индексжүүлэх замаар барилгын үнийн тогтолцоог шинэчлэх</p> <p>Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалаар дараах үнэ бүрдлийн норм ба дүрмийг батлаад байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм” /БД 81-106-16/-ийг 1 дүгээр хавсралтаар; 2. “Барилга, байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ”-г 2 дугаар хавсралтаар; 3. “Гадна зам талбай, бусад жижиг барилга, тохижилтын ажлын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ”-г 3 дугаар;
--	--	--

		<p>4. “Гадна инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ”-г 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 114 дүгээр тушаалаар “Барилга байгууламжийн үнийн индекс тооцох дүрэм” /БД 81-105-17/-ийг баталсан бөгөөд Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.10 дахь заалт болон дээрх дүрмийг үндэслэн Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 133 дугаар тушаалаар “Барилга байгууламжийн 2017 оны үнийн индекс”, 2019 оны 220 дугаар тушаалаар “Барилга байгууламжийн 2018 оны үнийн индекс”-ийг тус тус батлан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн мөрдөж ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%.</p>																					
<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.</p>		<p>2.1.Түрээсийн орон сууц, түүний инженерийн дэд бүтцийг шинээр барих, өргөтгөх хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын байгууллага, хандивлагч орнуудын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр үе шаттай шийдвэрлэх; Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд баригдсан зарим орон сууцны хорооллын дэд бүтцийг улсын төсвөөс дараах байдлаар санхүүжүүлсэн. Инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг бусад эх үүсвэрээс зарцуулаагүй байна.</p> <table border="1" data-bbox="592 720 1490 926"> <thead> <tr> <th>№</th> <th>Аймгийн нэр</th> <th>Шугам сүлжээний дүн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Сэлэнгэ Зүүн хараа</td> <td>283,209,904</td> </tr> <tr> <td>2</td> <td>Дархан-Уул</td> <td>77,613,971</td> </tr> <tr> <td>3</td> <td>Архангай</td> <td>71,670,066</td> </tr> <tr> <td>4</td> <td>Хэнтий</td> <td>1,670,167,536</td> </tr> <tr> <td>5</td> <td>Буянт-Ухаа 2 хороолол</td> <td>1,961,270,660</td> </tr> <tr> <td colspan="2" style="text-align: center;">НИЙТ</td> <td>4,063,932,137</td> </tr> </tbody> </table> <p>2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх зорилгоор гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын зээл авах төрийн байгууллагад Засгийн газар, Хөгжлийн банкнаас баталгаа гаргах Түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх хүрээнд барилгын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн түрээсийн орон сууцны төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Барилга, хот байгуулалтын яамнаас 2018 онд 6 төслийн саналыг, 2019 онд 1 төслийн саналыг Монгол Улсын Хөгжлийн банкинд уламжилсан. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу тус саналуудыг судлан үзэж, холбогдох шийдвэрүүдийг тухайн төсөл хэрэгжүүлэгчдэд хүргүүлсэн бөгөөд санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна. Учир нь МУХБ-наас тогтоосон шаардлагыг хангаж чадаагүй.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%.</p> <p>2.3.Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгох Хөтөлбөр хэрэгжих хугацаанд зөвхөн Сэлэнгэ аймгийн Орон нутгийг хөгжүүлэх сангаас орон сууцны барилга барьж байгаа 3 компанид 1520,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, дэмжлэг үзүүлсэн байна. <u>Сэлэнгэ аймаг</u> Хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааны хүрээнд аймаг хөгжүүлэх сангаас дараах хөнгөлөлттэй зээлийг орон сууц, хотхон хороолол барих хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон байна. Үүнд: 2015 онд “Ган мон энжелс” ХХК-ийн Баянгол, Ерөө, Цагааннуур, Шаамар сумдад байрлах тус бүр нь 25 айлын нийт 100 айлын орон сууцны барилгын угсралтын ажилд зориулан 720 сая төгрөг; 2015 онд “Гурван тулгат цамхаг” ХХК-ийн Сүхбаатар суманд байрлах “Сэлэнгэ хотхон”-ы барилга угсралтын ажилд зориулан 500.0 сая төгрөг; 2016 онд “Алтанбилэг” ХХК-ийн Алтанбулаг суманд байрлах “Хаус хороолол”-ын барилга угсралтын ажилд зориулан 300.0 сая төгрөг нийтдээ 1520.0 сая төгрөг олгосон байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>	№	Аймгийн нэр	Шугам сүлжээний дүн	1	Сэлэнгэ Зүүн хараа	283,209,904	2	Дархан-Уул	77,613,971	3	Архангай	71,670,066	4	Хэнтий	1,670,167,536	5	Буянт-Ухаа 2 хороолол	1,961,270,660	НИЙТ		4,063,932,137
№	Аймгийн нэр	Шугам сүлжээний дүн																					
1	Сэлэнгэ Зүүн хараа	283,209,904																					
2	Дархан-Уул	77,613,971																					
3	Архангай	71,670,066																					
4	Хэнтий	1,670,167,536																					
5	Буянт-Ухаа 2 хороолол	1,961,270,660																					
НИЙТ		4,063,932,137																					

	<p>2.4.Түрээсийн орон сууцны барилга барих иргэн, хуулийн этгээд инженерийн болон нийгмийн дэд бүтцэд ойрхон байрлалд газар эзэмших, ашиглахад зохих журмын дагуу дэмжлэг үзүүлэх, энэ тухай жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах</p> <p>Хөтөлбөр хэрэгжих хугацаанд доорх нэр бүхий аймаг, орон нутгийн ИТХ-аас орон сууцны барилга барьж байгаа компаниудад хөнгөлөлттэй нөхцлөөр газар олгож, дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p><u>Нийслэл</u></p> <p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 3/08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Түрээсийн орон сууцыг хөгжүүлэх, залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу Монгол улсын Хөгжлийн банк болон БНХАУ-ын Хөгжийн банкны санхүүжилтээр Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5.0 га талбайд түрээсийн орон сууцны зориулалттай барилгуудын бүтээн байгуулалт хийхээр төлөвлөн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн.</p> <p>Төслийн хүрээнд 9, 12 давхар 29-66 м2 талбай бүхий 1-3 өрөө 935 айлын орон сууц, 50 м2 талбай бүхийн 64 айлын нам давхрын сууцнуудаас бүрдэх ба нийт 1006 айлын орон сууц, 250 хүүхдийн цэцэрлэг, 685 авто машины дулаан зогсоол, 267 ил зогсоол, худалдаа үйлчилгээний 2406 м2 тайбай баригдахаар төлөвлөгдсөн. Энэхүү төслийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 144 дүгээр тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр, Ханын материал орчимд "Түрээсийн орон сууцыг хөгжүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхээр баталсан.</p> <p><u>Архангай аймаг</u></p> <p>Эрдэнэбулган сумын 5-р баг Булганхангай хороололд 120 айлын орон сууц барих дэд бүтэц гадна цэвэр бохир дулааны шугам хийгдсэн, газрын зөвшөөрөл байршил шийдэгдсэн.</p> <p><u>Баян-Өлгий аймаг</u></p> <p>2014-2015 онд Өлгий сумын 12-р багт 900 айлын 136500м2 Хутты мекен 648 айлын орон сууцны хороололд 107000м2, нийт 243500м2 газрыг олгосон.</p> <p><u>Булган аймаг</u></p> <p>Орон сууцны барилга, хотхон, хороолол барих ажлыг дэмжиж, "Алтайн бумбат" ХХК-д 66 айлын орон сууцны барилгын, иргэн А.Батсуурьт 25 айлын орон сууцны барилгын, "Жинсийн орой" ХХК-д 40 айлын орон сууцны барилгын, "Нида" ХХК-д 120 айлын орон сууцны цогцолборын, "Нүнжигт Сансар" ХХК-д 50 айлын орон сууцны барилгын газрыг тус тус шийдвэрлэж өгсөн байна.</p> <p><u>Говьсүмбэр аймаг</u></p> <p>Төмөр замын 3 дугаар анги 24 айлын, Төмөр замын 22, 16 дугаар зөрлөгт нийт 32 айлын, Ус, цаг уур, орчны шинжилгээний алба 10 айлын орон сууцыг ажилчдын орон сууцны зориулалтаар барьж ашиглалтад оруулсан бөгөөд газрыг албан байгууллагын нэр дээр хөнгөлөлттэй нөхцлөөр авсан. 2017 онд 123 өрх байр түрээслэн амьдарч байна.</p> <p><u>Дархан-Уул аймаг</u></p> <p>2014-2017 онд түрээсийн орон сууц барих зорилгоор Дархан сумын 13-р баг, Техникийн коллежийн хойд талд 5500м2, 30-р хороололд 2 байрлалд тус бүр 1000м2, нийт 7500м2 газар олгогдсон.</p> <p><u>Дорноговь аймаг</u></p> <p>Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт "Мандах наран" хорооллын 268 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг гүйцэтгэж буй хөрөнгө оруулагч "Гантулга трейд" ХХК-д аймаг орон нутгаас орон сууцны 0,88 га газрыг үнэ төлбөргүй олгож, тус барилгын дэд бүтцийн асуудлыг орон нутгийн хөгжлийн сангийн 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдсэн.</p> <p><u>Дундговь аймаг</u></p> <p>Сайнцагаан сумын 7-р багийн нутаг дэвсгэрт, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн урд талд 2,0 га газрыг "Түрээсийн орон сууцны хороолол"-ын зориулалтаар эзэмшүүлэх сонгон шалгаруулалт зарлаж, "Тааны амт" ХХК, "Мандал шилтгээн" ХХК-ийн түншлэлд олгосон байна.</p> <p><u>Орхон аймаг</u></p>
--	---

	<p>2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Говил багт 3000 м2 газрыг орон сууцны барилга зориулалтаар, Орон сууцны 7-р хороололд 1024 м2 газрыг 6 байршилд төсөл сонгон шалгаруулалтаар олгосон. Дээрх сонгон шалгаруулалтаар авсан газарт орон сууцны барилгажилтын төсөл хэрэгжүүлэх явцад түрээсийн орон сууц хөтөлбөрийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p> <p>2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу Говил багт 3000 м2 газрыг орон сууцны барилга барих зориулалтаар Бурхууд ХХК-нд эзэмшүүлсэн. Төсөл хэрэгжиж дуусахад тодорхой тооны барилгыг түрээсийн орон сууцны санд шилжүүлэхээр гэрээ хийгдсэн. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар захиргааны IV байрыг ашиглалтад орсонтой холбоотойгоор орон сууцны 1-21 дүгээр байранд үйл ажиллагаа эрхэлж байсан ГХБХБГ, "Боловсрол, соёл, урлагийн газар, Сэлэнгэ голын сав газрын захиргаа зэрэг төрийн захиргааны 3, төслийн 1 байгууллагыг шилжүүлж, суларсан орон сууцны зориулалттай барилгыг түрээсийн орон сууцны зориулалтаар 18 айл өрх гэрээ байгуулан орсон. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш түрээсийн орон сууцны санд 58 орон сууцтай болсон байна.</p> <p><u>Өвөрхангай аймаг</u></p> <p>Арвайхээр болон Хархорин сумдад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 1250 айлын орон сууцны газрыг 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган олгосон байна. Орон сууцны газар олгохдоо барилга барих гэж буй аж ахуй нэгжтэй нийт барилгын ашигттай талбайн 2 хувийг түрээсээр ашиглах гэрээ байгуулах санал тавих замаар түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх талаарх хэлэлцүүлгийг аймгийн Засаг дарга, барилгын компаниудын дунд зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p> <p><u>Сүхбаатар аймаг</u></p> <p>Түрээсийн орон сууцны барилга барихаар санал хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжид инженерийн шугамд ойрхон байрлалд газар эзэмших хүсэлтийг газрын тухай хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэхээр Цагдаагийн ажилчдын 40 айлын орон сууцны барилгын 2716 м2 газрыг шийдвэрлэсэн байна.</p> <p><u>Сэлэнгэ аймаг</u></p> <p>"Ган Мон Энжелес" ХХК-ийн Баянгол суманд баригдсан 25 айлын орон сууцанд сумын Засаг даргын 2015 оны А/199 дүгээр захирамжаар 1500 м2; "Ган Мон Энжелес" ХХК-ийн Ерөө суманд баригдсан 25 айлын орон сууцанд сумын Засаг даргын 2015 оны А/140 дүгээр захирамжаар 600 м2; "Ган Мон Энжелес" ХХК-ийн Шаамар суманд баригдсан 25 айлын орон сууцанд сумын Засаг даргын 2015 оны А/116 дугаар захирамжаар 3000 м2; "Ган Мон Энжелес" ХХК-ийн Цагааннуур суманд баригдсан 25 айлын орон сууцанд сумын Засаг даргын 2015 оны А/91 дүгээр захирамжаар 3000 м2; "Гурван тулгат цамхаг" ХХК-ийн Сүхбаатар суманд баригдаж буй "Сэлэнгэ хотхон"-д зориулан аймгийн Засаг даргын 2015 оны А/97 дугаар захирамжаар 23405 м2; "Алтанбилэг" ХХК-ийн Алтанбулаг суманд баригдсан "Хаус" Хороололд сумын Засаг даргын 2016 оны А/67, 68 дугаар захирамжуудаар 12052 м2 газруудыг тус тус газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган олгосон байна.</p> <p>"Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар Мандал суманд баригдсан 9 давхар 126 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээг 2015 оны аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 304.0 сая төгрөгөөр шийдвэрлэсэн. Мөн Сүхбаатар сумын "Мөрөөдөл", "Залуус", "Сэлэнгэ" хотхон хорооллын чиглэлд инженерийн дэд бүтэц тавих ажилд 2014-2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад 5.6 тэрбум төгрөг тусгуулсан бөгөөд ажлыг "Набсан" ХХК-иар гүйцэтгүүлэн байнгын ашиглалтад оруулсан. Энэхүү хөрөнгө оруулалтын ажлаар дулааны шугамын өргөтгөл шинэчлэлт, ус, дулаан хуваарилах 3 төв, цэвэр ус, ариутгах татуургын шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлууд хийгдэж Сүхбаатар сум зүүн талруугаа тэлж, өргөжих орон сууцны болон хаус хороолол баригдах нөхцөл боломж бүрдээд байна.</p> <p><u>Увс аймаг</u></p> <p>Улаангом сумын 3-р багийн нутаг дэвсгэрт 105 айлын орон сууц барих зориулалтаар 2,6 га газрыг ТОСК-д 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн. Төрийн өмчийн түрээсийн 105 айлын орон сууцны гадна цахилгаан, дулаан, цэвэр, бохир, хэрэглээний халуун усны шугам сүлжээг ОНХСангийн 481,7 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэсэн. Аймгийн 2017 газар зохион байгуулалтын ерөнхий</p>
--	--

		<p>төлөвлөгөөнд 9 байршилд 2,06 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар орон сууц барих зориулалтаар олгохоор тусгасан.</p> <p><u>Ховд аймаг</u> Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ-ын санхүүжилтээр баригдах эхний ээлжийн 120 айлын орон сууцны хорооллыг барих газрыг 15 жилийн хугацаатайгаар аймгийн Засаг даргын 2014 оны А/93 дугаар захирамжаар олгож, ТОСК-ийн барилгын ЦТП, гадна шугам сүлжээг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 414,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авч, үлдэгдэл санхүүжилтийг 2017 онд олгосон байна.</p> <p><u>Хөвсгөл аймаг</u> Түрээсийн орон сууц барих сонирхолтой хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг орон нутгийн хэмжээнд дэмжиж ажиллах зорилгоор тус хөтөлбөрийг сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Түрээсийн орон сууцны барилга барих иргэн, хуулийн этгээд инженерийн болон нийгмийн дэд бүтцэд ойрхон байрлах газар олгох судалгааг хийж, 2017 онд 0,5 га газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%</p>																																																																
3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:		<p>3.1.Түрээсийн орон сууцны барилга захиалан бариулах, эсхүл шинээр ашиглалтад орсон боловч борлогдоогүй орон сууцнаас худалдан авах замаар төрийн өмчийн түрээсийн 1300 айлын орон сууцны сан бүрдүүлэх</p> <p>Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2016 оны 38, 298, 169 дүгээр тогтоолуудаар "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ /хуучнаар/ болон "Бэрэн" группийн захиалгаар баригдаж ашиглалтад орсон 1512 айлын төрийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Мөн Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоолоор "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ-ын дуусаагүй барилгын балансад бүртгэлтэй 1542 айлын орон сууцны 28 блок барилгыг өөрийн өртгөөр нь Хөгжлийн банкинд шилжүүлэх замаар гүйцээн барихад шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэн, ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоолоор дээрх тогтоолын хүрээнд ашиглалтад орсон 1542 айлын орон сууцыг аймаг, нийслэлийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж, эдгээр барилгуудыг барихад зарцуулсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг 5 жилд багтаан Монгол Улсын Хөгжлийн банкинд эргэн төлөх арга хэмжээ авахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан.</p> <table border="1" data-bbox="630 1157 1468 1688"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Байршил</th> <th colspan="4">Түрээсийн орон сууцны тоо</th> </tr> <tr> <th>38-р тогтоол</th> <th>298-р тогтоол</th> <th>169-р тогтоол</th> <th>Нийт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Улаанбаатар хот</td> <td>350</td> <td>223</td> <td>214</td> <td>787</td> </tr> <tr> <td>2</td> <td>Дархан-Уул</td> <td>83</td> <td>-</td> <td>69</td> <td>152</td> </tr> <tr> <td>3</td> <td>Увс</td> <td>84</td> <td>-</td> <td>21</td> <td>105</td> </tr> <tr> <td>4</td> <td>Ховд</td> <td>96</td> <td>-</td> <td>20</td> <td>116</td> </tr> <tr> <td>5</td> <td>Архангай</td> <td>120</td> <td>-</td> <td>-</td> <td>120</td> </tr> <tr> <td>6</td> <td>Хэнтий</td> <td>96</td> <td>-</td> <td>24</td> <td>120</td> </tr> <tr> <td>7</td> <td>Сэлэнгэ, Мандал</td> <td>90</td> <td>-</td> <td>12</td> <td>102</td> </tr> <tr> <td>8</td> <td>Хэнтий, Бор-Өндөр</td> <td>10</td> <td>-</td> <td>-</td> <td>10</td> </tr> <tr> <td></td> <td>Нийт</td> <td>929</td> <td>223</td> <td>360</td> <td>1512</td> </tr> </tbody> </table> <p style="text-align: right;">Биелэлт 100%.</p>	№	Байршил	Түрээсийн орон сууцны тоо				38-р тогтоол	298-р тогтоол	169-р тогтоол	Нийт	1	Улаанбаатар хот	350	223	214	787	2	Дархан-Уул	83	-	69	152	3	Увс	84	-	21	105	4	Ховд	96	-	20	116	5	Архангай	120	-	-	120	6	Хэнтий	96	-	24	120	7	Сэлэнгэ, Мандал	90	-	12	102	8	Хэнтий, Бор-Өндөр	10	-	-	10		Нийт	929	223	360	1512
№	Байршил	Түрээсийн орон сууцны тоо																																																																
		38-р тогтоол	298-р тогтоол	169-р тогтоол	Нийт																																																													
1	Улаанбаатар хот	350	223	214	787																																																													
2	Дархан-Уул	83	-	69	152																																																													
3	Увс	84	-	21	105																																																													
4	Ховд	96	-	20	116																																																													
5	Архангай	120	-	-	120																																																													
6	Хэнтий	96	-	24	120																																																													
7	Сэлэнгэ, Мандал	90	-	12	102																																																													
8	Хэнтий, Бор-Өндөр	10	-	-	10																																																													
	Нийт	929	223	360	1512																																																													

3.2.Орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх (8060 хүртэл айлын)

Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоолоор "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ-ын дуусаагүй барилгын балансад бүртгэлтэй 1542 айлын орон сууцны 28 блок барилгыг өөрийн өртгөөр нь Хөгжлийн банкинд шилжүүлэх замаар гүйцээн барихад шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлсэн.

Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоолоор дээрх тогтоолын хүрээнд ашиглалтад орсон 1542 айлын орон сууцыг аймаг, нийслэлийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж, эдгээр барилгуудыг барихад зарцуулсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг 5 жилд багтаан Монгол Улсын Хөгжлийн банкинд эргэн төлөх арга хэмжээ авахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан.

№	Байршил	Түрээсийн орон сууцны тоо
		223-р тогтоол
1	Улаанбаатар хот	972
2	Орхон	315
3	Говь-Алтай	120
4	Хөвсгөл	135
	Нийт	1542

Мөн Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Булган, Говьсүмбэр, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгуудад 240 айлын, нийслэл Улаанбаатар хотод ахмадын 300, түр суурьшуулах 318, гэр хорооллын дахин төлөвлөлтийн түр суурьшуулах 154 айлын, нийт 772 айлын орон сууцыг худалдан авч түрээсийн зориулалтаар ашиглаж байна.

Булган аймаг

Хууль зүй, дотоод хэргийн яамны хөрөнгө оруулалтаар Булган аймгийн Цагдаагийн газрын захиалгаар Булган сумын 5 дугаар багт Цагдаагийн газрын эзэмшлийн ажилчдын байрыг засварлаж, 12 айлын орон сууцыг түрээсийн зориулалтаар иргэдэд эзэмшүүлж байна.

Говьсүмбэр аймаг

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар төрийн албан хаагчдад зориулсан 22 түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, төрийн албан хаагчдад түрээслүүлж байна. Төрийн байгууллагууд оросын цэргийн зориулалттай 5 давхар байрнуудаас засварлан авч, залуу албан хаагчдыг орон сууцаар хангаж байна.

Дорноговь аймаг

Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт "Мандах наран" хорооллын 268 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг гүйцэтгэж буй хөрөнгө оруулагч "Гантулга трейд" ХХК-нд аймаг орон нутгаас орон сууцны 0,88 га газрыг үнэ төлбөргүй олгож, тус барилгын дэд бүтцийн асуудлыг орон нутгийн хөгжлийн сангийн 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдсэн.

Тус хороололд 80 айлын орон сууцны 2 барилга, үйлчилгээний төвтэй 54 айлын орон сууцны 2 барилга, нийт 4 барилга барихаар төлөвлөж байгаа бөгөөд гэрээний эхний ээлжийн орон сууц 2017 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орсон. Тус хорооллын орон сууцны 1 м2-ийг үнийг 650000 төгрөгөөр зорилтот бүлэгт худалдан борлуулахаар гэрээнд тусгасан. Мөн Замын-үүд сумын нутаг дэвсгэрт 180 айлын орон сууцны барилгыг Нутгийн зөвлөлийн хөрөнгө оруулалтаар барихаар ажлыг эхлүүлсэн. Аймгийн Засаг даргын 2016 оны А/284 тоот захирамжаар Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт 30 айлын орон сууц барих газрыг "Энержи парагон" ХХК-д үнэ төлбөргүй олгосон бөгөөд тухайн орон сууцны 30%-д бага дунд орлоготой, нийгмийн эмзэг хэсэгт зориулсан түрээсийн орон сууц байлгах нөхцөлтэйгээр гэрээ байгуулсан байна.

Дундговь аймаг

2013 онд аймгийн Засаг даргын тамгын газрын захиалгаар 12 айлын түрээсийн орон сууцыг "Бади" ХХК Орон нутгийн сангийн 563,1 сая төгрөгийн хөрөнгөөр барьж, ашиглалтад оруулсан. 2015 онд тус аймгийн Сайн цагаан суманд "Жигүүр оргил" ХХК-ийн захиалгаар баригдсан 50 айлын орон сууцнаас Орон нутгийн

	<p>хөгжлийн сангийн 300,0 сая төгрөгөөр 54 м2 талбай бүхий 6 айлын орон сууцыг худалдан авч, нийт 18 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлсэн байна.</p> <p><u>Орхон аймаг</u> Аймгийн Засаг даргын тамгын газар орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, “Неман констракшн” ХХК-ийн барьж ашиглалтад оруулсан Баян-Өндөр хотхоноос 1-2 өрөө бүхий 40 орон сууцыг орон нутгийн түрээсийн орон сууцны санд худалдан авч, зорилтот бүлгийн иргэдийг хамруулсан байна. 2017 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар захиргааны IV байрыг ашиглалтад оруулж орон сууцны 1-21 дүгээр байранд үйл ажиллагаа эрхэлж байсан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Сэлэнгэ голын сав газрын захиргаа зэрэг төрийн захиргааны 3, төслийн 1 байгууллагыг шилжүүлж, суларсан сууцнуудад түрээсийн орон сууцны зориулалтаар 18 өрхтэй гэрээ байгуулж оруулсан байна. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш түрээсийн орон сууцны санд 58 орон сууцтай болоод байна.</p> <p>2019 онд түрээслэж буй орон сууцны түрээсийн орлого 62,8 сая төгрөгийг орон нутаг хөгжүүлэх “Эрдэнэт сан”-д төвлөрүүлсэн. Баян-Өндөр сумын Цагаанчулуут багт баригдаж байгаа 315 айлын орон сууцны барилгыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоолоор гэрээний үндсэн дээр орон нутагт шилжүүлж байгаатай холбогдуулан “Иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2019 оны 106 дугаар тогтоолоор батлуулсан ба тус байрны 70 хувийг түрээсийн орон сууцны санд бүртгэн ашиглахаар шийдвэрлэсэн.</p> <p><u>Өмнөговь аймаг</u> Манлай сумын төрийн албан хаагчийн 12 айлын орон сууц, Ноён сумын төрийн албан хаагчийн 12 айлын орон сууц, Номгон сумын 16 айлын орон сууцнуудыг тус тус түрээслүүлж байна.</p> <p><u>Сүхбаатар аймаг</u> Хөтөлбөрийн хүрээнд газрын асуудлыг хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон “Грийн таун” хорооллоос 72м2 талбайг, Цагдаагийн ажилчдын орон сууцны барилгаас 87.5м2 талбайг тус тус орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санд авч, орон нутгийн өмчид бүртгээд байна.</p> <p><u>Төв аймаг</u> Түрээсийн орон сууцны хөтөлбөрийг 2018 оноос хэрэгжүүлж эхлэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас жил бүр 400.0 сая төгрөг төлөвлөн баригдаж буй орон сууцнаас төсөл сонгон шалгаруулж 2 аж ахуйн нэгжээс 20 түрээсийн орон сууцыг нийт 711,3 сая төгрөгөөр худалдан авч түрээсийн орон сууцны санг бүрдүүлэн ажиллаж байна. Түрээсийн орон сууцны санд түрээсийн байрны 2 жилийн төлбөр 21,0 сая төгрөг төвлөрсөн. Энэхүү хөрөнгөөр түрээсийн орон сууц авахаар төлөвлөж байна. Түрээсийн орон сууцны хөтөлбөр 2018 оноос хэрэгжиж эхэлсэн тул одоогоор их болон урсгал засварт хөрөнгө төлөвлөөгүй цаашид их засварт хөрөнгө төлөвлөх болно. Түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдахаар 156 зорилтот бүлгийн иргэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн болон бизнесийн байгууллагын албан хаагчид, залуу гэр бүлээс өргөдөл ирүүлсэн. Түрээсийн орон сууцны хангамжийг дан ганц орон нутгийн төсвөөр шийдвэрлэхэд хүндрэлтэй байна.</p> <p><u>Хэнтий аймаг</u> “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд түрээсийн орон сууцны сан бүрдүүлж ашиглах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хэрлэн сумын 3 дугаар багт төлөвлөгдсөн “Шинэ Өндөрхаан” хорооллын орон сууцны хэсэгт “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болж, аймгийн Засаг дарга ТОСК ТӨҮГ-тай гэрээ байгуулан ажилласан. Аймгийн зүгээс дэд бүтцийн асуудлыг хариуцаж, орон нутгийн төсвийн 4,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна инженерийн шугам сүлжээг уурын зуухны хамт, 365,0 сая төгрөгөөр гадна цахилгааны ажлыг хийлгэж, 100% ашиглалтад оруулсан.</p> <p><u>Улаанбаатар хот</u> Улаанбаатар хотод ахмадын 300, түр суурьшуулах 318, гэр хорооллын дахин төлөвлөлтийн түр суурьшуулах 154 айлын, нийт 772 айлын орон сууцыг худалдан авч түрээсийн зориулалтаар ашиглаж байна.</p> <p>Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх Ханын материалын үйлдвэрийн хашаанд байрлах 5 га газарт “Түрээсийн орон сууцыг хөгжүүлэх” төсөл хэрэгжүүлэхээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн</p>
--	---

Хурлаар хэлэлцүүлж, 2017 оны 144 дүгээр тогтоолыг гаргуулаад байна. Тус төслийн төлөвлөлтөөр орон сууцны зориулалттай 1006 айлын 9 давхар бүхий 8 блок, 12 давхар бүхий 2 блок, 267 авто машины дулаан зогсоол, 685 авто машины гадна зогсоолтой худалдаа үйлчилгээний төв, нам давхарын 64 айл бүхий орон сууцны бүтээн байгуулалт бүхий хорооллыг төлөвлөөд байна.

Биелэлт 30%

3.3.Хувийн хэвшлийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх (7840 хүртэл айлын)

Энэ ажлын хүрээнд нийслэл Улаанбаатар хот, Орхон, Баянхонгор аймгуудад түрээсийн орон сууцанд амьдрах сонирхолтой иргэдийн судалгааг албан ёсоор хийлгэсэн байна. 2019 оны байдлаар нийслэлд 30803 өрх, орон нутагт 3868 өрх орон сууц түрээслэн амьдарч байна.

Баянхонгор аймаг

Аймгийн хэмжээнд инженерийн бүрэн хангамжтай 7941 айлын орон сууцны 87 барилга байдгаас 242 айлын орон сууцанд түрээслэгч айл өрх амьдардаг судалгаа байна.

Орхон аймаг

2016 онд түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 410 гаруй иргэний өргөдлийг хүлээн авч иргэдийн бодит байдалтай танилцаж хөтөлбөрт хамрагдах иргэдийн судалгаатай болоод байна. Судалгаанд хамрагдсан иргэдээс сугалааны зарчмаар сонгон шалгаруулан 34 иргэнийг хөтөлбөрт хамруулаад байна.

2017 онд түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 88 иргэний өргөдлийг хүлээн авч, иргэдийн бодит байдалтай танилцаж, хөтөлбөрт хамрагдах боломжтой 18 иргэн тус хөтөлбөрт хамрагдан орон сууцанд орсон.

Өвөрхангай аймаг

Аймгийн хэмжээнд түрээсийн орон сууцанд амьдардаг иргэдийн судалгаа хийгдэж байна.

Увс аймаг

ТОСК ТӨҮГ-ын захиалгаар баригдсан төрийн өмчийн түрээсийн орон сууцанд сугалаагаар зорилтот бүлгийн 84 өрхийг хамруулсан. 2017 оны 2 дугаар сард 70 м2 хүртэл талбайтай 21 айлын орон сууцыг түрээслэсэн.

Ховд аймаг

Түрээсийн орон сууцанд орох иргэдийн судалгаа гаргасан. Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 28 дугаар тушаалаар батлагдсан "Иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам"-ын хүрээнд 03 дугаар сарын 17-25-ны өдрүүдэд Төрийн Орон сууцны корпорацийн 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тус аймагт ажиллаж, 96 айлыг түрээсийн орон сууцанд хамруулав. Аймгийн хэмжээнд 2775 айлын орон сууцны 115 барилга ашиглагдаж байгаагаас 148 айлын орон сууцыг иргэдэд түрээсэлж байгаа бөгөөд эрүүл ахуй, аюулгүй байдалд нь Сууц өмчлөгчдийн холбоотой хамтран хяналт тавин ажиллаж байна.

Биелэлт 100%.

3.4.Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны барилга захиалж бариулах тохиолдолд барилга угсралтын ажлыг зохих туршлагатай орон нутгийн компаниар гүйцэтгүүлэх, тэдний чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авах

Орон нутагт баригдаж байгаа барилгын бүх төрлийн ажлыг орон нутгийн компаниудын дэмжлэгтэйгээр гүйцэтгэж байна.

2020.03.16

№	Төслийн нэр	Хүчин чадал	Түрээсийн орон сууцанд шилжсэн.	БУА-г гүйцэтгэгч компани	Гүйцэтгэгч компаний албан хаяг
1	Нийслэл	3564	1536	Үндэсний бүтээн байгуулалтын корпораци ХХК	Улаанбаатар хот 17030, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 26, "Их Хуралдай" оффисын барилга 1206 тоот

2	Дархан	189	152	Бурхантын бүтээн байгуулалтын корпораци ХХК	Дархан-уул аймаг, Дархан хот, 5 дугаар баг, 20 дугаар хороолол
3	Увс	105	105	Мөнхийн Увс Ундраа ХХК	Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг
4	Сэлэнгэ	126	102	Гүүд Кэстл ХХК	Улаанбаатар хот, БЗД, 1-р хороо, Токиогийн гудамж, Нисора цамхаг
5	Ховд	120	116	Ховдын Өргөө ХХК	Ховд аймаг, Жаргалант сум, Баатархайрхан баг, Үйлдвэрийн район 1 тоот
6	Хэнтий	120	120	Дүрт Уул ХХК	Улаанбаатар хот, СХД, 15-р хороо, Москва 44-73 тоот
7	Архангай	120	120	Хасу мандал Трейд ХХК	Улаанбаатар хот, ХУД, 2-р хороо, Арьс ширний үйлдвэрийн хашаа, өөрийн байр
8	Бор-Өндөр	20	10	Боршоон Ундраа ХХК	Улаанбаатар хот, БЗД, Энхтайвны өргөн чөлөө, Монросцвет-н байр, 1 давхар, 3 тоот
9	Хангай хороолол /УБ/	3290	223	Бэрэн групп	Улаанбаатар хот, ХУД, 15-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Бэрэн цамхаг 50-р байр, Ш/х-36- 278
10	Говь-Алтай	120	120	"Хөх бүрдний эх" ХХК	Монгол, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо
11	Хөвсгөл	135	135	"Батбүрдэл" ХХК	Монгол, Улаанбаатар, Баянгол, 11-р хороо, Хасбаатар 43 1
12	Орхон	315	315	"Очир Ундраа групп" ХХК	Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сүхбаатарын талбай 8/1, Сити Тауэр бизнес төв
НИЙТ		4395	3054		
Биелэлт 100%.					
3.5.Түрээсийн орон сууцны сангийн их болон урсгал засварын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, ашиглалтын хэвийн ажиллагааг хангах Энэхүү асуудлыг БХБСайдын 2016.02.23-ны өдрийн 28 дугаар тушаалаар баталсан "Иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам"-ын 5 дугаар зүйл буюу "Түрээслүүлэгчийн эрх, үүрэг" хэсэгт тусгаж, зохицуулсан бөгөөд түрээсийн					

		<p>орон сууцны өмчлөгчид түрээсийн орон сууцны сангийн их болон урсгал засварын зардал, өдөр тутмын ашиглалт, үйлчилгээний зардлыг хариуцан ажиллаж байна.</p> <p><u>Орхон аймаг</u></p> <p>Түрээсийн орон сууцны их болон урсгал засварын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, ашиглалтын хэвийн ажиллагааг хангах журам боловсруулж батлуулсан.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%.</p>
		<p>3.6.Түрээсийн орон сууцны ашиглалт, зохицуулалтыг хариуцах бүтцийн нэгжийг байгуулж, тогтвортой ажиллуулах</p> <p>Төрийн өмчийн түрээсийн орон сууцны сангийн эзэмшил, ашиглалтыг хариуцаж буй ТОСК ТӨҮГ нь байгуулагынхаа бүтцэд түрээсийн орон сууцны асуудал хариуцсан нэгжийг байгуулан ажиллаж байна. Орхон болон Дундговь аймгуудад түрээсийн орон сууцны ашиглалт, зохицуулалтыг эдгээр аймгуудын Орон нутгийн өмчийн газар хариуцан ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 100%.</p>
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p><u>Ололт</u></p> <p>Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш анх удаа орон сууц худалдан авах боломжгүй иргэдэд зориулсан төрийн өмчийн 1512 айлын, орон нутгийн өмчийн 1542 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг хамруулаад байна. Мөн орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Булган, Говьсүмбэр, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгуудад 240 айлын, нийслэл Улаанбаатар хотод ахмадын 300, түр суурьшуулах 318, гэр хорооллын дахин төлөвлөлтийн түр суурьшуулах 154 айлын, нийт 772 айлын орон сууцыг худалдан авч түрээсийн зориулалтаар ашиглаж байна. Хувийн хэвшил орон нутагт 3868 өрхийг, Улаанбаатар хотод 30803 өрхийг түрээсийн орон сууцаар хангаж байна.</p> <p>Улс орон эдийн засгийн хүндрэлтэй байгаа энэ үед ард, иргэдээ орон сууцжуулах, тэдний амьдралын нөхцлийг сайжруулах, төв, суурин газрын агаар, хөрсний бохирдлыг зохих хэмжээгээр бууруулах, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих зэрэгт энэхүү хөтөлбөр зохих хувь нэмрээ оруулж байна.</p> <p>Орон нутагт хямд өртөгтэй түрээсийн орон сууцнууд бий болсноор нэн шаардлагатай байгаа боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах боломж нөхцөл бүрдэж байна.</p> <p><u>Дутагдал</u></p> <p>Орон нутгийн төсөвт хөтөлбөрийн санхүүжилтэд зориулж шаардлагатай хөрөнгө тусгахгүй байна. Аймгуудын орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө хомс байна. Санхүүжилтгүйн улмаас хөтөлбөр хугацаандаа хэрэгжихгүй, хөтөлбөрийн зорилго, зорилтууд хэрэгжихгүй байх эрсдэл байна.</p> <p>УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т нийслэлд 2016 он хүртэл жил бүр 1000 айлын түрээсийн орон сууцыг, 2017-2020 онуудад жил бүр 2000 айлын түрээсийн орон сууцыг нийлүүлэхээр тусгасан хэдий ч Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх зорилтын хүрээнд тайлант хугацаанд Нийслэлийн ИТХ, Засаг дарга 772 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлэн ашиглаж байна. Мөн Баян-Өлгий, Архангай, Баянхонгор, Дорнод зэрэг аймгууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хөрөнгө шийдвэрлүүлэх талаар холбогдох дээд байгууллагуудад хандаагүй мөртлөө хөрөнгө тусгагдаагүй гэсэн шалтгаанаар хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санаачлагагүй ажилласан байна.</p>
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Тус яамнаас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч, БХБСайдтай аймаг, нийслэлийн Засгийн дарга байгуулдаг жил бүрийн гэрээнд орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх талаар тусгаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн яамны 2017 оны 01/2818 тоот албан бичгээр “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт чиглэл хүргүүлж ажиллалаа. Мөн Барилга, хот байгуулалтын яамнаас “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан. Тус хөтөлбөрт түрээсийн орон сууцны санг 18,488 өрхөөр нэмэгдүүлэх зорилт тавьсан. Энэ хүрээнд БНХАУ-ын Засгийн</p>

	<p>газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт "Ногоон нуур - 1008 айлын орон сууц" төсөл, БНСУ-ын Засгийн газрын хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт "Солонго -1", "Солонго -2", 5002 айлын орон сууцны төсөл, Сонгинохайрхан нутаг дэвсгэрт "Баянголын ам" 2000 айлын орон сууцны төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бэлтгэл хангаад байна. Дээрх төслүүд хэрэгжсэнээр 2021-2023 онд төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан 8010 өрхөөр нэмэгдэх боломжтой юм.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3-т заасныг баримтлан "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн. Уг үнэлгээгээр "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэл нь "хэрэгжих шатанд" буюу 73 хувьтай гэж үзэж байна. Хэдийгээр хэрэгжих шатандаа явж байгаа боловч уг хөтөлбөрийг хугацаанд нь багтааж дуусгахын тул эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн "Түрээсийн орон сууцыг аливаа хэлбэрээр иргэнд өмчлүүлж болно" гэсэн байдлаар өөрчлөх эсхүл бодлогын өөр шийдэл байх боломжтой гэсэн зөвлөмжийг өгсөн. Зөвлөмжийн дагуу төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслэгчдэд нь өмчлүүлэх талаар журмын төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор "Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам"-ыг батлуулсан. Энэ хүрээнд Улаанбаатар хотод 290 айлын орон сууцыг, Говь-Алтай аймагт 120 айлын орон сууцыг, Хөвсгөл аймагт 135 айлын орон сууцыг, Орхон аймагт 315 айлын орон сууцыг иргэдэд түрээслээд өмчлүүлэх гэрээний нөхцөлтэйгөөр түрээслэж байна.</p> <p>Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газраас дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Засгийн газраас ард иргэдийг орон сууцжуулах чиглэлээр олон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталж байгаа боловч, хөрөнгийг шийдвэрлэж өгдөггүйгээс ихэнх хөтөлбөрүүд хэрэгжихгүй, цаасан дээр үлддэг. Өмнө баталсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө байхгүй байхад шинээр хөтөлбөрүүд боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөдөг. Энэ тал дээр дүгнэлт хийж, хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэхэд анхаарах; ➤ Тус яамны ХНХЯ-ны мэдээгээр, манай улсын нийт өрхийн 29,6 хувь буюу 174,798 өрх ядуурлын түвшингээс доогуур амьжиргаатай байна. Эдгээр өрхүүдийн орон сууцны нөхцлийг сайжруулах, хангамжийг нэмэгдүүлэхэд төр, засгийн зүгээс онцгойлон анхаарч байж, төв суурин газрын агаар, хөрсний бохирдлыг бууруулах боломжтой. Иймээс "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд Засгийн газраас онцгойлон анхаарч, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутгийн төсөвт жил бүр тодорхой хэмжээний хөрөнгө тусгаж байх шаардлагатай байна; ➤ Улс, орны эдийн засгийн хүндрэлтэй холбоотой түрээсийн орон сууцны түрээсийн төлбөрийг нэмэгдүүлэх чиглэлийг Сангийн яамнаас өгч байна. Үүнийг буруу гэж үзэж байна. Жил бүр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууцны барилгууд олноор ашиглалтад орж байгаа хэдий ч зорилтот бүлгийн иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууц цөөн байна. Иймээс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулах, түрээсийн орон сууцаар хангах, халамжийн бодлогоор дэмжихэд онцгойлон анхаарч ажиллах талаар халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу ХНХЯ болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт ЗГХЭГ-аас чиглэл хүргүүлэх; ➤ Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох яамд тухай бүр нэгтгэн, цаашид шийдвэрлүүлэх арга хэмжээний саналын хамт ЗГХЭГ-т хүргүүлдэг ч тайлангийн мөрөөр ЗГХЭГ ямар ч ажил зохион байгуулдаггүй, тулгамдсан
--	--

			<p>асуудлууд ч шийдвэрээ хүлээсээр үлдэж байгаад онцгойлон анхаарч, холбогдох яамд, аймаг орон нутгийн удирдлагуудад хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар удирдамж, чиглэл хүргүүлж ажиллахад анхаарах;</p> <p>➤ Засгийн газрын 2016 оны 298 дугаар тогтоолын хүрээнд 2017 онд улсын төсөвт 15,0 тэрбум төгрөгийг тусган шийдвэрлүүлсэнээс өөрөөр "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд улс, орон нутгийн төсвөөс дорвитой хөрөнгө оруулалт хийгдээгүй болно. Төрийн болон орон нутгийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 3054 айлын орон сууцыг Хөгжлийн банкны 189,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 38, 169 дүгээр тогтоолуудад уг зээлийн эргэн төлөлтийг улсын төсөвт үе шаттайгаар тусгах, зээлийн хүүг орон сууцны түрээсийн төлбөрийн орлогоос төлж байхаар шийдвэрлэсэн боловч, төсвийн хүндрэлтэй холбоотойгоор уг зардал төсөвт тусгагдан батлагдаагүй өнөөдрийг хүрсэн. Энэхүү хөрөнгийг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.</p>			
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		92.1%	3	94%	92.5%	90 %
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ” ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2020.03.23

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, ЗГХЭГ болон холбогдох дээд байгууллагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 248-р тогтоолоор батлуулсан.

Хөтөлбөрийн зорилго: Орон сууц худалдан авах боломжгүй, түрээсийн орон сууцанд амьдрах сонирхолтой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн өмчийн бүх хэлбэрийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулахад оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК, аймаг, нийслэлийн Засаг дарга.

Санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын хэмжээ:

- Улс, орон нутгийн төсөв;
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;
- Гадаад дотоодын зээл тусламж;
- Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;
- Бусад.

Нийт төлөвлөсөн хөрөнгө оруулалтын хэмжээ: 1,118, 905.44 сая төгрөг. Үүнээс:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалт: 108, 288.04 сая төгрөг,
- Орон нутгийн төсөв, Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө: 478, 613.93 сая төгрөг.
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт: 532, 003. 47 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хэрэгжих хугацаа: 2015-2021 он

Хөтөлбөрийн зорилтууд:

Барилга, хот байгуулалтын яам өөрийн хамаарах арга хэмжээг дараах зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнд:

Зорилт 1. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, ашиглах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

Зорилт 2. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, ашиглах бодлого, зохицуулалтын таатай орчныг бүрдүүлэх;

Зорилт 3. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж ашиглах.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Барилга, хот байгуулалтын яам Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт тусгагдсан 3 зорилтын хүрээнд 15 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.

“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн дээрх 3 зорилтын хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100 хувийн биелэлттэй - 12, 70 хувийн биелэлттэй - 2, 40 хувийн биелэлттэй - 1, 0 хувьтай арга хэмжээ байхгүй. **Хөтөлбөрийн хэрэгжилт 92.1 хувьтай, “үр дүнтэй” хэрэгжсэн гэж дүгнэж байна.**

Хэрэгжилтийн түвшин: /Зорилт, арга хэмжээ тус бүрээр/

	Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ	Арга хэмжээ	Биелэлт					Үнэлгээ
			100	70	40	0	ҮБ	
	Зорилт 1. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, ашиглах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;							
1	1.1. Орон сууцны тухай хуульд түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, ашиглах, түрээслэгч, түрээслүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага, түрээсийн төлбөртэй холбогдсон нэмэлт, өөрчлөлт оруулах	1	1	-	-	-	-	100
2	1.2. Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах, тэдэнд хөнгөлөлт үзүүлэх журам боловсруулж хэрэгжүүлэх	1	1	-	-	-	-	100
3	1.3. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэхэд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийг буцаан төвлөрүүлэх тогтолцоог бүрдүүлэх	1	1	-	-	-	-	100
4	1.4. Түрээсийн орон сууцны нэг сарын түрээсийн төлбөрийн хэмжээг Үндэсний статистикийн хорооноос гаргадаг жил бүрийн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд тулгуурлан өрхийн дундаж орлогын 25 хувиас хэтрэхгүй байхаар хот, хөдөөд ялгавартай тогтоож мөрдүүлэх	1	1	-	-	-	-	100
5	1.5. Барилгын хийц, бүтээцээс хамааруулан орон сууцны барилгын 1м2 талбайн бодит өртгийг тооцон гаргаж, жил бүр индексжүүлэх замаар барилгын үнийн тогтолцоог шинэчлэх	1	1	-	-	-	-	70
	Зорилт-1-ийн дундаж үнэлгээ	5	4	1	-	-	-	94
	Зорилт 2. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, ашиглах бодлого, зохицуулалтын таатай орчныг бүрдүүлэх;							
6	2.1.Түрээсийн орон сууц, түүний инженерийн дэд бүтцийг шинээр барих, өргөтгөх хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын байгууллага, хандивлагч орнуудын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр үе шаттай шийдвэрлэх	1	1	-	-	-	-	100
7	2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх зорилгоор гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын зээл авах	1	1	-	-	-	-	100

	төрийн байгууллагад Засгийн газар, Хөгжлийн банкнаас баталгаа гаргах							
8	2.3.Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгох	1	1	-	-	-	-	100
9	2.4.Түрээсийн орон сууцны барилга барих иргэн, хуулийн этгээд инженерийн болон нийгмийн дэд бүтцэд ойрхон байрлалд газар эзэмших, ашиглахад зохих журмын дагуу дэмжлэг үзүүлэх, энэ тухай жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах	1	-	1	-	-	-	70
	Зорилт-2-ын дундаж үнэлгээ	4	3	1	-	-	-	92.5
	Зорилт 3. Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж ашиглах.							
10	3.1.Улсын төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орнуудын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр түрээсийн орон сууцны барилга захиалан бариулах, эсхүл шинээр ашиглалтад орсон боловч борлогдоогүй орон сууцнаас худалдан авах замаар төрийн өмчийн түрээсийн 1300 айлын орон сууцны сан бүрдүүлэх	1	1	-	-	-	-	100
11	3.2. Орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх (8060 хүртэл айлын)	1	-	-	1	-	-	40
12	3.3. Зах зээл дээр ашиглагдаж байгаа түрээсийн зориулалттай орон сууцны нарийвчилсан судалгаа гаргаж, эрүүл ахуй, аюулгүй байдал, стандартын нөхцөл, шаардлагыг хангуулах замаар хувийн хэвшлийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх (7840 хүртэл айлын)	1	1	-	-	-	-	100
13	3.4. Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны барилга захиалж бариулах тохиолдолд барилга угсралтын ажлыг зохих туршлагатай орон нутгийн компаниар гүйцэтгүүлэх, тэдний чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авах	1	1	-	-	-	-	100
14	3.5. Түрээсийн орон сууцны сангийн их болон урсгал засварын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, ашиглалтын хэвийн ажиллагааг хангах	1	1	-	-	-	-	100
15	3.6. Түрээсийн орон сууцны ашиглалт, зохицуулалтыг хариуцах бүтцийн нэгжийг байгуулж, тогтвортой ажиллуулах	1	1	-	-	-	-	100
	Зорилт-3-ын дундаж үнэлгээ	6	5	-	1	-	-	90
	Нийт дүн	15	12	2	1	-	-	92,1

Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн томоохон ажлуудыг дурдвал:

Зорилт-1-ийн хүрээнд:

1. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2019.12.02-ны өдөр УИХ-д өргөн барьсан. УИХ-ын 2019.12.18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар уг хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр УИХ-ын ЭЗБХ-нд шилжүүлээд байна.

2. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны өдрийн 26 дугаар тушаалаар баталсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын

хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулж байна. 2019 онд журмын дагуу 837 иргэнийг хамруулсан байна.

3. Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоолоор ашиглалтад орсон 1542 айлын орон сууцыг аймаг, нийслэлийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн. Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны 138 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх” журмыг батлуулсан.

4. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 133 дугаар тушаалаар “Барилга байгууламжийн 2017 оны үнийн индекс”, 2019 оны 220 дугаар тушаалаар “Барилга байгууламжийн 2018 оны үнийн индекс”-ийг тус тус батлан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн ажиллаж байна.

Зорилт-2-ын хүрээнд:

1. Түрээсийн орон сууц, түүний инженерийн дэд бүтцийг шинээр барих, өргөтгөх хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын байгууллага, хандивлагч орнуудын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр үе шаттай шийдвэрлэх ажлын хүрээнд 2019 онд түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд баригдсан зарим орон сууцны хорооллын дэд бүтцийг улсын төсвөөс санхүүжүүлсэн. Нийт 4,063,932,137 төг зарцуулсан байна.

2. Түрээсийн орон сууцны барилга барих иргэн, хуулийн этгээд инженерийн болон нийгмийн дэд бүтцэд ойрхон байрлалд газар эзэмших, ашиглахад зохих журмын дагуу дэмжлэг үзүүлэх, энэ тухай жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5.0 га талбайд түрээсийн орон сууцны зориулалттай барилгуудын бүтээн байгуулалт хийхээр төлөвлөн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн. Энэхүү төслийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 144 дүгээр тогтоолоор батлуулсан. Архангай, Өвөрхангай, Увс, Хөвсгөл зэрэг бараг бүх аймгууд энэ чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна.

Зорилт-3-ын хүрээнд:

1. Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоолоор ашиглалтад орсон 1542 айлын орон сууцыг аймаг, нийслэлийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн. Улаанбаатарт 1759, Дархан-Уул аймагт 152, Говь-Алтай аймагт 120 зэрэг нийт 3054 айлын орон сууцны сан бүрдүүлсэн.

2. 2019 онд орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Булган, Говьсүмбэр, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгуудад 240 айлын, нийслэл Улаанбаатар хотод ахмадын 300, түр суурьшуулах 318, гэр хорооллын дахин төлөвлөлтийн түр суурьшуулах 154 айлын, нийт 772 айлын орон сууцыг худалдан авч түрээсийн зориулалтаар ашиглаж байна.

Архангай аймаг: Эрдэнэбулган сумын 5 дугаар баг, Булганхангай хороололд ТОСК-ийн захиалгаар баригдсан 120 айлын орон сууцыг төрийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн. Булган аймаг: 12 айлын орон сууцыг түрээсийн зориулалтаар иргэдэд эзэмшүүлж байна. Говьсүмбэр аймаг: 22 түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, төрийн

албан хаагчдад түрээслүүлж байна. Дархан-Уул аймаг: ТОСК-ны захиалгаар 189 айлын орон сууц баригдаж, 81 өрх түрээсийн орон сууцанд хамрагдсан. Дундговь аймаг: 53 өрх түрээсийн орон сууцанд амьдарч байна. Орхон аймаг: түрээсийн орон сууцны санд 58 орон сууцтай болоод байна. Өвөрхангай аймаг: 1145 айлын орон сууцны 33 барилга ашиглалтад орж, хэрэгцээ хангагдаж, түрээсийн орон сууцны хэрэглээ төдийлөн өндөр биш байна. Өмнөговь аймаг: Манлай сумын төрийн албан хаагчийн 12 айлын орон сууц, Ноён сумын төрийн албан хаагчийн 12 айлын орон сууц, Номгон сумын 16 айлын орон сууцнуудыг тус тус түрээслүүлж байна. Төв аймаг: түрээсийн орон сууцны санд 20 орон сууц бүрдүүлсэн.

3. Улаанбаатар хот, Орхон, Баянхонгор аймгуудад түрээсийн орон сууцанд амьдрах сонирхолтой иргэдийн судалгааг албан ёсоор хийлгэсэн байна. 2019 оны байдлаар хувийн хэвшлийн орон сууцыг нийслэлд 30803 өрх, орон нутагт 3868 өрх түрээслэн амьдарч байна.

4. Орон нутагт баригдаж байгаа барилгын бүх төрлийн ажлыг орон нутгийн компаниудын дэмжлэгтэйгээр гүйцэтгэж байна. Тухайлбал: Үндэсний бүтээн байгуулалтын корпораци ХХК нь 1536 айлын орон сууцыг Улаанбаатар хотод, Дархан хотод Бурхантын бүтээн байгуулалтын корпораци ХХК нь 152 айлын орон сууц, Увс аймагт Мөнхийн Увс Ундраа ХХК нь 105 айлын зэрэг орон сууцыг барьсан байна.

Хэрэгжилт хангалтгүй, 40 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ байна. Үүнд:

1.Хөтөлбөрийн /3.2/ “Орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх (8060 хүртэл айлын)”

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Хөтөлбөрийн хэрэгжилт 92.1 хувьтай, “үр дүнтэй” хэрэгжсэн гэж дүгнэж байна.

2. Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш анх удаа орон сууц худалдан авах боломжгүй иргэдэд зориулсан төрийн өмчийн 1512 айлын, орон нутгийн өмчийн 1542 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг хамруулаад байна. Мөн Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Булган, Говьсүмбэр, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгуудад 240 айлын, нийслэл Улаанбаатар хотод ахмадын 300, түр суурьшуулах 318, гэр хорооллын дахин төлөвлөлтийн түр суурьшуулах 154 айлын, нийт 772 айлын орон сууцыг худалдан авч түрээсийн зориулалтаар ашиглаж байна. Хувийн хэвшил орон нутагт 3868 өрхийг, Улаанбаатар хотод 30803 өрхийг түрээсийн орон сууцаар хангаж байна. Улс орон эдийн засгийн хүндрэлтэй байгаа энэ үед ард, иргэдээ орон сууцжуулах, тэдний амьдралын нөхцлийг сайжруулах, төв, суурин газрын агаар, хөрсний бохирдлыг зохих хэмжээгээр бууруулах, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих зэрэгт энэхүү хөтөлбөр зохих хувь нэмрээ оруулж байна.

Орон нутагт хямд өртөгтэй түрээсийн орон сууцнууд бий болсноор нэн шаардлагатай байгаа боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах боломж нөхцөл бүрдэж байна.

3. Аймгуудын орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө хомс байгаагаас шалтгаалан орон нутгийн төсөвт хөтөлбөрийн санхүүжилтэд зориулж хангалттай хөрөнгө тусгахгүй байна.

4. Хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх зорилтын хүрээнд тайлант хугацаанд Нийслэлийн ИТХ, Засаг дарга 772 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлэн ашиглаж байна. Мөн Баян-Өлгий, Архангай, Баянхонгор, Дорнод зэрэг аймгууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хөрөнгө шийдвэрлүүлэх талаар холбогдох дээд байгууллагуудад хандаагүй мөртлөө хөрөнгө тусгагдаагүй гэсэн шалтгаанаар хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санаачлагагүй ажилласан байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хөтөлбөрийг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт жил бүр тусгахад төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага анхаарч ажиллах;

2. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргаа идэвх санаачлагатай ажиллаж, хөрөнгө санхүүжилтээс бусад өөрсдөөс шалтгаалах арга хэмжээг авч ажиллах;

3. Засгийн газрын 2016 оны 298 дугаар тогтоолын хүрээнд 2017 онд улсын төсөвт 15,0 тэрбум төгрөгийг тусган шийдвэрлүүлсэнээс өөрөөр “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд улс, орон нутгийн төсвөөс дорвитой хөрөнгө оруулалт хийгдээгүй. Төрийн болон орон нутгийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 3054 айлын орон сууцыг Хөгжлийн банкны 189,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 38, 169 дүгээр тогтоолуудад уг зээлийн эргэн төлөлтийг улсын төсөвт үе шаттайгаар тусгах, зээлийн хүүг орон сууцны түрээсийн төлбөрийн орлогоос төлж байхаар шийдвэрлэсэн боловч, төсвийн хүндрэлтэй холбоотойгоор уг зардал төсөвт тусгагдан батлагдаагүй өнөөдрийг хүрсэн байна.

4. Дээрх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлэхийг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/ нарт даалган, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ -2019 ОН

N	Төслийн нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Санхүүжилтийн гүйцэтгэл /сая.төг/		Санхүүжилтийн эх үүсвэр, /зарцуулалтын тайлбар/	Шалгуур үзүүлэлт		Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилт хувь
			Суурь он	2019 он		суурь он	2019 он		
ШИЛЖИН ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД									
1	3.Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл	142,166.8	149,578.7	2,785.6	Гадаад зээл, тусламж, /БНХАУ-ын хөнгөлөлт тэй зээл/	Төслийн ажлын явц 85 хувь. Нийт 2592 айлын орон сууц ашиглалтанд орсон. СБД-ийн 7-р хорооллын инженерийн шугам сүлжээний ажил 100% дуусч, МҮОНРТ-ийн хорооллын шугам сүлжээ угсралтын ажил 47,2%-ийн гүйцэтгэлтэй байна	Төслийн ажлын явц 100 хувь. Шугам сүлжээний угсралтын ажлыг бүрэн дуусгасан байна.	<p>МҮОНРТ-ийн хорооллын шугам сүлжээ угсралтын ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Дулаан дамжуулах төв /1 ком/- ийн ажил - Дулааны 1780 м шугамын угсралтын ажил - Цэвэр усны 4200м шугамын угсралтын ажил - Бохир усны 1700м шугамын угсралтын ажил - 10 кВ-ын хуваарилах байгууламж /ХБ/ - 3 ком - 10кВ -ын 3,6 км кабелийн сувагчлалд 19,84 км кабель сунгах ажил - 10 кВ-ын 6 км кабель шугамын угсралтын ажил - 2*630кВА-ын хаалттай дэд өртөө - бш - 2*1000кВА-ын дэд өртөө 2ш - 2*1000м3 усан сангийн барилга - Өргөлтийн насос станцын барилгын ажлуудыг 100% хийж гүйцэтгэсэн. <p>Дээрхи ажлуудыг 2017-2019 онуудад улсын комисст бүрэн хүлээлгэн өгсөн байна.</p> <p>4. 110/35/10 кВ-ын 2 иж бүрдэл дэд өртөө болон 110 кВ-ын ЦДАШ-ын угсралтын ажлын хүрээнд :</p> <ul style="list-style-type: none"> - 110/35/10 кВ-ын 40,0 МВА-ын чадалтай “Телевиз” , “7-р хороолол” дэд станцуудын барилга угсралтын ажил- 100% -220/110/35 кВ-ын “Улаанбаатар” дэд станцын өргөтгөл – 100 % - 110 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ - 23.0 км – 100% 	100%

							Багц-4 ажлын Өмчлөлийн асуудлыг шийдвэрлүүлэхээр ТӨБЗГ-т материалыг хүргүүлсэн.	Биелэлт 95%
	Төслийн хэрэгжилт							
2	4.Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл Нийт 26,655.6 сая төгрөг	53,638.0	13,309.2	13,346.4	Гадаад зээл, тусламж, /АХБ-ны хөнгөлөлт тэй зээл/ Төслийн ажлын явц 69 хувь. Өвөрхангай аймгийн цэвэрлэх байгууламжийг улсын комисст өгсөн. Өмнөговь аймгийн цэвэрлэх байгууламжийн ажил 50%, Архангай аймгийн цэвэрлэх байгууламжийн ажил 45%-тай байна. Дорноговь аймгийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын гэрээг байгуулсан.	Төслийн ажлын явц 90 хувь. Өвөрхангай аймгийн цэвэрлэх байгууламжийн туршилт тохируулга, сургалтын ажлыг гүйцэтгэнэ. Архангай, Өмнөговь аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлыг дуусган, туршилт тохируулгын ажлыг эхлүүлнэ.	1. Архангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг барилга угсралтын “ЧММ” ХХК гүйцэтгэж, 2019.10.15-нд байнгын ашиглалтад оруулсан. Гүйцэтгэл -100% 2. Өмнөговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг гүйцэтгэгч “Н Эй Би” ХХК, “Эс энд Эй трейд” ХХК, “Сан” ХХК, “Байгууламж” ХХК-ний түншлэл 2017 оноос эхлэн гүйцэтгэж байна. Гүйцэтгэл -80% 3. Дорноговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг “Эйч Эн Си барилга” ХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл- 50%	100% Биелэлт 91%
	Төслийн хэрэгжилт		<p>АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл, арга хэмжээг 2016 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>- Өвөрхангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг барилга угсралтын “Комфорт Импекс” ХХК гүйцэтгэж, 2018.11.15-нд байнгын ашиглалтад оруулсан. Гүйцэтгэл -100%</p> <p>- Архангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг барилга угсралтын “ЧММ” ХХК гүйцэтгэж, 2019.10.15-нд байнгын ашиглалтад оруулсан. Гүйцэтгэл -100%</p> <p>- Өмнөговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг гүйцэтгэгч “Н Эй Би” ХХК, “Эс энд Эй трейд” ХХК, “Сан” ХХК, “Байгууламж” ХХК-ний түншлэл 2017 оноос эхлэн гүйцэтгэж байна. Гүйцэтгэл -80%</p> <p>- Дорноговь аймгийн Сайншанд хотын цэвэрлэх байгууламжийн ажлыг 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлж, 2-р тунгаагуурын ханын арматурчлал, сараалжийн, дэд өртөөний барилгуудын гадна фасадын ажил,</p>					

				<p>үйлдвэрийн барилгын гадна өрлөгийн ажил, лаг боловсруулах цех, уурын зуухны барилгуудын өрлөг, хучилтын цутгалтын ажлууд хийгдсэн. Гүйцэтгэл 50%</p> <p>- Өвөрхангай аймгийн Баянгол сумын бохир усны шугам сүлжээ, насос станцын нэмэлт ажлын хүрээнд үерийн усны бетон далангийн 200м сувгийн ажил бүрэн дууссан. Гүйцэтгэл 98%.</p> <p>- Нийтийн аж ахуйн байгууллагуудын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх баг Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймгуудад 2019 оны 09-10 дугаар сард ажиллаж, дээрхи аймгуудын НААБ-уудын Төлөөлөн удирдах зөвлөлд Стратеги төлөвлөгөөг танилцуулан, хүлээлгэн өгсөн.</p> <p>- Төслийн бүрэлдхүүнд багтаж байгаа “Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа ТТ9100” дэд төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 200 айлд сайжруулсан нүхэн жорлон хамтарч барихаас 47 айлын нүхэн жорлонг барьж, ашиглалтад оруулсан байна.</p> <p>Мөн дээрх төслийн хүрээнд дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>1. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 2.5 км цэвэр усны шугамын зураг төсөл боловсруулж, 2019.07.14-нд магадлал хийлгэн баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Замын Үүд суманд Ус дулаан дамжуулах төв 10-ын дулаан хангамжийн 2-р хэлхээний 380 метр дулааны өгөх буцах, хэрэгцээний халуун усны өгөх буцах шугам, хүйтэн усны 5 шугамын угсралтын ажлыг хийсэн.</p> <p>Мөн цэвэр усны эх үүсвэрийн 2-р худгаас дулааны төв станц хүртлэх 2.5 км цэвэр усны шугамын ажлыг хийж, 2019.12.05-нд байнгын ашиглалтад оруулсан.</p> <p>2.Өвөрхангай аймгийн Хужирт сумын төвд хоногт 310 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулан баталгаажуулж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, үнэлгээ хийж АХБ-нд 2019.12.12-нд хүргүүлсэн.</p>					
3	5.Дархан хотын бохир усны менежментийн төсөл	49,481.0	14,333.3	10,756.1	Гадаад зээл, тусламж, /АХБ-ны хөнгөлөлт тэй зээл/	Төслийн ажлын явц 64 хувь. 16 барилгын ажлыг эхлүүлж гүйцэтгэл 64%-тай байна. Нийт 6 хэсгийн 4 хэсгийн ажлыг дуусгасан. Дулааны насос станцын барилгын засварыг дуусгасан.	Төслийн ажлын явц 64 хувь. Нийт 6 хэсгээс үлдсэн 2 хэсгийн ажлыг гүйцэтгэнэ.	Төслийн үр дүн 1 – А1 багц - Цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлын явцад баригдах нийт 39 барилга болон 3 насос станцын засвар шинэчлэлийн ажлуудаас барилгын ажлын гүйцэтгэл - 55%, - Зураг төслийн ажлын явц - 97%	100%
	Нийт 25,089.4 сая төгрөг				Төслийн хэрэгжилт	<p><u>Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:</u></p> <p>1. Төслийн үндсэн худалдан авалтаас хэмнэгдсэн зээлийн хөрөнгөөр "А2-4. Бохирын шугам хоолойн өргөтгөл шинэчлэл" багц ажлын хүрээнд "Цагаан зуун" ХХК нь ф300 мм-ийн голчтой 1770 м шугам, 52 худгийн барилгын ажлыг гүйцэтгэн, 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулсан.</p>			

					<p>2. Төслийн хүрээнд “Бридж констракшн” ХХК нь ф300 мм-ийн голчтой 290 м шугам, 13 худгийн барилгын ажлыг гүйцэтгэн, 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгсөн.</p> <p>3. Төслийн худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөний дагуу техникийн шаардлага хангасан эксковаторыг Дарханы ус сувгийн байгууллагад 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгсөн.</p> <p>4. А2-7 багц. Бохирын насос станцын засварын ажлын хүрээнд насос станцыг шинэчлэх, бохирын нэмэлт шугам хоолойн ажлын зураг төслийг “Эрчим төсөл” ХХК боловсруулж, батлуулсан.</p> <p>5. Дархан-Уул аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 07 тоот тогтоолоор “Бридж констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн 714,5 сая төгрөгийн үнэ бүхий бохир усны ф355 мм-ийн голчтой 1600 м хуванцар хоолой, ф800 мм-ийн 1230 м төмөр бетон хоолой, ф300 мм-ийн 290м хуванцар хоолойг, мөн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 10-р сарын 04-ний өдрийн 88 тоот тогтоолоор “Бридж констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн 234,2 сая төг-ийн үнэ бүхий бохир усны шугам хоолойг, “Цагаан зуун” ХХК-ийн гүйцэтгэсэн 633 сая төг-ийн үнэ бүхий бохир усны шугам хоолойг тус тус Дархан ус суваг ХК-ийн балансад бүртгэх зөвшөөрөл олгосон.</p> <p>6. “Дархан дулааны сүлжээ” ТӨХК-д 1 тэрбум 260,3 сая төг-ийн үнэ бүхий дулааны насос станц, цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамыг хүлээлгэн өгч, барилга байгууламжийн ашиглалтын ногоон гэрчилгээ олгосон.</p> <p>7. Төслийн хэмнэгдсэн хөрөнгөөр нэмэлт 2 байршилд бохир усны шугам угсрахтай холбогдуулан газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг шинэчлэн 2019 оны 03-р сарын 13-ны өдөр АХБ-аар батлуулсан.</p> <p>8. Төслийн байгаль орчны хяналтын зөвлөхтэй 2019 оны 03-р сард, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэнтэй 2019 оны 09-р сард, Дархан дахь төслийн нэгжийн захиргааны ажилтан/орчуулагчтай 2019 оны 10-р сард тус тус гэрээ байгуулан, ажиллуулж байна.</p>				
4	6.Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх	35,000.0	9,999.9	12,961.1	Улсын төсөв	Төслийн ажлын явц 50 хувь. 2018 онд 23 картын 161360 м3 лагийг суллан үнэргүйжүүлж бордоо болгох ажлыг эхлүүлж, 144000 м3 өдөр тутмын шингэн лагийг боловсруулан бордоо болгох ажил хийгдсэн.	Төслийн ажлын явц 75 хувь, Лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх ажил хийгдэнэ.	2019 онд нийт 44 картын 320327 м ³ лаг, өдөр тутмын 249382 м ³ лаг, хуримтлагдсан хур 241169 м ³ лаг нийт 810878 м ³ лагийн бүрэн цэвэрлэж үнэргүйжүүлэн боловсруулж бордоо болгох ажлыг хийж дуусгасан. Мөн Төв цэвэрлэх байгууламжаас гарч буй түүхий лагийн овор хэмжээг багасгах, үнэрийг бууруулах зорилгоор хоногт 2500м ³ лаг усгүйжүүлэх хүчин чадалтай автоматжсан байгууламжийг ашиглалтад оруулсан. Биелэлт 100%	100%
		Төслийн хэрэгжилт		Дүгнэлт. /Тайлбар/					
5	7.Улаанбаатар хотын Төв	705,376.0	-	-	Гадаад зээл, тусламж,	Бэлтгэл ажил. Төслийн гүйцэтгэгчтэй	Төслийн ажлын явц 10 хувь. Барилга	Шинэ цэвэрлэх байгууламжийн ажлын нарийвчилсан зураг төслийг Шанхай хотын зураг төслийн хүрээлэнд	100%

цэвэрлэх байгууламж				/БНХАУ-ын хөнгөлөлт тэй зээл/	гэрээ байгуулах, Ажлын хэсэг томилогдож, хэлэлцээрийн ажлыг эхлүүлэх бэлтгэл хангаж байна.	угсралтын ажлыг эхлүүлнэ.	боловсруулан дуусгасныг орчуулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөж 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Барилгын хөгжлийн төвд экспертиз хийлгүүлсэн.	
	35,268.8	-	498.3	Улсын төсөв			Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчилж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар ерөнхий үнэлгээг хийлгэж баталгаажуулсан. Төслийн барилга угсралтын талбайн бэлтгэл ажлыг хангаж түр ажилчдын байр, хашаа, цамхагт краныг байршуулан, биологи цэвэрлэгээний байгууламжийн суурийн газар шорооны ажил, бетон зуурмагний узель угсрах, байгууламжийн суурийн ул бетон цутгах зэрэг ажлуудыг гүйцэтгээд байна. Ажлын явц 15%	
	Төслийн хэрэгжилт	<p>Шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн сонгон шалгаруулалтыг Франц улсын “Артелиа Вил энд Транспорт компани”-ний боловсруулсан ТЭЗҮ-г үндэслэн Түлхүүр гардуулах нөхцөлөөр ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралт, тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажлыг олон улсын ЕРС гэрээний зарчим дээр төслийн гүйцэтгэгчийг шалгаруулсан.</p> <p>Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Чайна Тисижу сивил инженеринг групп” ба “Бээжин констракшн инженеринг групп”-уудын консорциум, зураг төсөл боловсруулах ажлыг Франц улсын “Артелиа Вил энд Транспорт компани”-ий боловсруулсан ТЭЗҮ-г үндэслэн барилга байгууламж, технологийн ажлын нарийвчилсан зургийг БНХАУ-ын Шанхай хотын “Инженерийн зураг төслийн институт” ХХК /Shanghai municipal engineering design institute Co, LTD/ гүйцэтгэж Монгол улсын БНБД бусад стандартад нийцүүлэн зургийг монгол хэл дээр хувиргах ажлыг Монгол Улсын “Сивил инженеринг консалтинг” ХХК, “Криетив монголия” ХХКомпаний түншлэл гүйцэтгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Төслийн гэрээний заалтын дагуу гүйцэтгэгч компани цэвэрлэх байгууламжийн эх загварын батлуулах үүрэгтэй ба эх загвар зургийг 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн ЭЗ-5/2019 тоот магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулан албажуулсан ба эх загвар зургийн дагуу эхний ээлжинд Аэротенкийн зургийн ажлын суурийн зургийг гүйцэтгэсэн. - Төслийн зураг төсөлд шаардагдаж буй техникийн нөхцөлүүдийг сунгах ажлыг зохион байгуулан ЭХЯ-наас Цахилгаан хангамжийн 45/2019 тоот техникийн нөхцөл, Дулаан хангамжийн 145с/2019/87 тоот, Мэдээлэл холбооны зохицуулах газраас Холбооны ТН-В546/2019 тоот техникийн нөхцөлүүдийн сунгалтыг тус тус аван зургийн компаниудад хүргүүлсэн. - Барилгын талбай дээр “Лэнд тест” ХХКомпанийн хийж гүйцэтгэж буй инженер-геологийн судалгаа хийгдэж магадлалын ерөнхий дүгнэлтийн хүрээнд талбайн Буурь хөрсний хяналтын №19/045 тоот акт боловсруулагдан батлаагаажуулсан. <p>Эхний ээлжийн барилга угсралтын ажил болох биологи цэвэрлэгээний байгууламжийн талбайн хөрс хуулалт хийгдэн, талбай дээр ул бетон цутгах ажлын бэлтгэлийг ханган, ус зайлуулах 32 цооног өрөмдөж хөрсний усыг зайлуулан суурийн ул бетон цутгалтын ажлыг эхлүүлсэн.</p>						

				<ul style="list-style-type: none"> - Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын бэлтгэл ажлын хүрээнд 120 м3/цагийн хүчин чадалтай бетон зуурмагийн 2 үзэлийг угсарч туршилт хийн “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-аар №ТЗ БМУ-БЭ-376/2019 тоот технологийн зааврыг батлуулсан ба зуурмагийн үзэлийн машин механизм, тоног төхөөрөмжүүдийг шалгаж МХЕГ-аас №18000000104 тоот аюулгүй ажиллагааны гэрчилгээг авсан. - 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн эх загвар зураг батлагдсан тул 2019 оны 09-р сарын 27-нд Бохир ус цэвэрлэх, төмөр бетон хийцтэй, онцгой төвөгшилтэй барилга байгууламж дээр барилгын ажил эхлүүлэх 01/2019 тоот зөвшөөрөл авсан. - Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын талбайд өмнөд биологи цэвэрлэгээний талбайн хөрс хуулалт хийж 6770 м2 талбай дээр 10 см зузаантай бэлтгэл ул бетоны ажлыг /700 м3/ цутгалтыг хийсэн ба барилга угсралтын талбайд өмнөд биологийн цэвэрлэгээний сангийн суурийн 1-р үеийн суурийн бетон арматурын ажлыг 2046м2 талбай дээр хийгдэж нийт 800м3 М400 маркын бетон цутгалт хийгдэж 10-р сарын 23-ны өдөр өвлийн горимд шилжсэн. 					
6	8.Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэлт	52,430.4	-	-	Гадаад зээл, тусламж, /БНПУ-ын хөнгөлөлт тэй зээл/	Төслийн ажлын явц 10 хувь. Ажлын зураг төсөл боловсруулагдаж дууссан. Сонгон шалгаруулалт зарласан боловч компани шалгараагүй байна.	Төслийн ажлын явц 20 хувь. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна.	Төслийн тендер шалгаруулалтыг яаралтай зохион байгуулах шаардлагатай байгаа тул нөхцөлт зээлийн хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 3-т “Зээлээр санхүүжих төслийг хэрэгжүүлэх Польшийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад Монгол Улсын худалдан авах ажиллагааны холбогдох хууль, журмыг мөрдлөг болгоно” гэж заасны дагуу урьдчилсан худалдан авах ажиллагааны тендерт оролцох Польш Улсын холбогдох шаардлагыг хангасан компаниудад Батламж бичиг /Letter of Confirmation/ олгуулах асуудлыг Польш Улсын Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлэх хүсэлтийг 2019 оны 12 дугаар сарын 10-ны 01/4599 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	Үнэлэх боломжгүй
		Төслийн хэрэгжилт		<p>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд байгуулсан Нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр аймгуудын төвд бохир ус цэвэрлэх байгууламж барих /Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Завхан Увс/” ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг Сангийн яамнаас ирүүлсэн зөвшөөрлийн дагуу 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл зохион байгуулсан.</p> <p>Энэхүү тендер нэг оролцогчтой бөгөөд тендерийн өгөгдлийн хүснэгтийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэхүү тендерт Бүгд Найрамдах Польш Улсын Сангийн яамнаас олгосон Батламж бичигтэй Польш Улсын компаниуд оролцох эрхтэй бөгөөд түншлэлийн хэлбэрээр оролцож болно. Түншлэлийн гишүүд нь аль ч улсынх байж болно.” гэж заасан шаардлагын “Энэхүү тендерт Бүгд Найрамдах Польш Улсын Сангийн яамнаас олгосон Батламж бичигтэй Польш Улсын компаниуд оролцох эрхтэй ...” гэсэн Эрх бүхий тендерт оролцогчийн ерөнхий шаардлагыг Тендерт оролцогч хангаагүй тул тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 29 дүгээр зүйлийн 29.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасныг тус тус үндэслэн</p>					

				Бүгд Найрамдах Польш Улсын "VEKTO" Sp.Zo.o компанийн толгойлсон түншлэлийн тендерээс татгалзсан тухай зөвлөмжийг Үнэлгээний хороо 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар гаргасан. Зөвлөмжийг захиалагчид хүргүүлж, захиалагч тендерт оролцогчид 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 03/3999 тоот албан бичгээр мэдэгдсэн. Энэхүү албан бичгийг СЯ, Польш Улс дахь Монгол Улсын элчин сайдын яаманд цахим шуудангаар нэгэн зэрэг мэдэгдсэн.					
7	9.Тайшир-Алтай ус хангамж төсөл Нийт 10,541,679.33 евро	42,543.5 /14,0 сая евро/	8,090.3	21,924.9	Гадаад зээл, тусламж, /Австрийн хөнгөлөлт тэй зээл/	Төслийн ажлын явц 20 хувь. Төслийн бэлтгэл ажил хангагдсан. Барилга угсралтын ажил эхлээгүй байна.	Төслийн ажлын явц 50 хувь. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.	Төслийн холбогдох барилга угсралтын ажлууд бүрэн дууссан бөгөөд тоног төхөөрөмж суурилуулалт зарим нэг заслын ажил хийгдэж байна. Биелэлт 70%	100%
	Төслийн хэрэгжилт	Барилга, хот байгуулалтын яам, Бүгд Найрамдах Австри Улсын "Тиролер Рохре" ХХК-тай " Сураг төсөл-нийлүүлэлт-барилга угсралт "-ын ажлын гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд туслан гүйцэтгэгчээр Австри Улсын "ОСТАП" ХХК, Монгол Улсын "Сайрам булган" ХХК, "МОГҮМБ Констракшн" ХХК гэх компаниуд ажиллаж байна. Төслийн хүрээнд шаардлагатай зураг төслийг боловсруулан 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Төслийн хүрээнд дараах ажлууд хийгдэж ажлын гүйцэтгэл 70 хувийн гүйцэтгэлтэй явж байна. Үүнд: - Ус цэвэршүүлэх байгууламжийн барилга угсралтын ажил бүрэн дууссан. - Нөөц усны барилга /усан сан/ угсралтын ажил бүрэн дууссан. - 14 метрийн гүнтэй ус авах цооногийн төмөр бетон цутгалтын ажил бүрэн дууссан. - Өргөлтийн насос станцын барилга угсралтын ажил бүрэн дууссан. - 54 км урттай ган шугам хоолой угсрах ажлын 27 км урт шугамыг угсарч дууссан. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх барилгын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгүүлэхээр Барилгын хөгжлийн төвтэй 2019 оны 6 дугаар сарын 2019/92 гэрээг байгуулан захиалагчийн хяналт гүйцэтгүүлэн ажиллаж байна.							
8	10.Туул усан сан барих төсөл	964,900.0	-	-	Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх	Бэлтгэл ажил. Санхүүжилтийг шийдвэрлэхээр ажилласан.	Бэлтгэл ажил. Санхүүжилтийг шийдвэрлэнэ.	Туул усан цогцолборын урьдчилсан ТЭЗҮ-ийг 2011 онд Престиж групп ХХК, 2015 онд УСУГ-ын захиалгаар Юүшин инженеринг корпораци боловсруулсан. Төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийн асуудал шийдэгдээгүй.	Үнэлэх боломжгүй
	Төслийн хэрэгжилт	Дүгнэлт. /Тайлбар/							

9	11.Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт	57,246.0	0	11,257.6	Гадаад зээл, тусламж, /АХБ-ны хөнгөлөлт тэй зээл/	Бэлтгэл ажил. Төслийг эхлүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангасан.	Төслийн ажлын явц 30 хувь. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.	<p>АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй МОН 3713 төслийн хүрээнд Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Сүхбаатар аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл арга хэмжээг 2019 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>1. Булган аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламж барих төслийн гүйцэтгэгчээр “Заг инженеринг” ХХК, “Престиж Инженеринг” ХХК, “Жиангсу Зэюү Энв. Протекшн” түншлэл шалгарч, 2019.05.07-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэл 55%.</p> <p>2. Хөвсгөл аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламж барих төслийн гүйцэтгэгчээр “Набсан” ХХК, “Эс энд Эй Трэйд” ХХК-ний түншлэл шалгарч, 2019.06.11-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэл 55%.</p> <p>3. Хэнтий аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламж барих төслийн гүйцэтгэгчээр “Комфорт импекс” ХХК шалгарч, 2019.08.22-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэл 10%.</p> <p>4. Дундговь аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламж барих төслийн гүйцэтгэгчээр “Сайн констракшн” ХХК, “САН” ХХК-ийн түншлэл шалгарч, 2019.12.27-нд гэрээ байгуулсан.</p> <p>5. Сүхбаатар аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламж барих төслийн гүйцэтгэгчээр “Хүрд” ХК, “Хөнан Байхуй Энвайронментал Протекшн” ХХК-ийн түншлэл шалгарч, гэрээ байгуулахаар ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Биелэлт 30%</p>	100%
	Төслийн хэрэгжилт	Төслийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Булган аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн хүрээнд:							

						<ul style="list-style-type: none"> - Биологи цэвэрлэгээний барилгын төмөр бетон цутгалтын ажил, талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил бүрэн дууссан. - Үйлдвэрийн, механик цэвэрлэгээний барилгын 0,00 түвшингийн суурийн төмөр бетон цутгалтын ажил, бохир усны, дренажийн бохир усны барилгын 0,00 түвшингийн төмөр бетон цутгалтын ажил, лаг боловсруулах цехийн барилгын суурийн цутгалт, ханын арматурчлалын ажил хийгдсэн. <p>Хөвсгөл аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Биологи цэвэрлэгээний блокийн барилгын ханын арматурчлал, механик цэвэрлэгээний блокийн суурийн цутгалтын ажил, үйлдвэрийн барилгын баганын арматурчлалын ажил хийгдсэн. - Захиргааны, дэд өртөөний, харуулын байрны барилгуудын хучилтын цутгалтын ажил дууссан. - Цэвэрлэгдсэн усны насос станцын гадна өрлөгийн ажил, бохир усны, дренажийн барилгын цутгалт, өрлөгийн угсралтын ажлуудыг гүйцэтгэсэн. - Талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил, цэвэр ус, дулааны шугамын угсралтын ажил бүрэн дууссан. - Лаг, элсний талбайн бетоны ажил дууссан. <p>Хэнтий аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - ЦДАШ-ын угсралтын ажил, Захиргааны, дэд өртөөний барилга, харуулын барилгуудын өрлөг, хучилтын ажлууд хийгдэж дууссан. 				
10	12.Барилгын арматурын үйлдвэр, Орхон аймаг Баян-Өндөр сум	53,254.7	10,900.0		Хувийн хэвшил	Төслийн ажлын явц 70 хувь. Үйлдвэрийн барилгын ажил бүрэн дуусч, тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна.	Төслийн ажлын явц 100 хувь. Үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлыг бүрэн дуусгана.	Төслийн хүрээнд үйлдвэрийн барилгын ажил бүрэн дууссан. Үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна. Домен 35 м.куб 100%, домен 70 м.куб 60%, кран 100%, хүчилтөрөгчийн конвертор 85%, цахилгаан нуман зуух 80%, шанаган зуух 80%, тасралтгүй цутгах машин 80%, хөргөлтийн усан сан 100%, хүчилтөрөгчийн станц 100%, цувих 40%. Үйлдвэр ашиглалтад оруулах хугацаатай уялдуулан үйлдвэрийн шугамуудыг үе шаттайгаар ашиглалтад оруулна.	70%	
		78,945.3	-	73,852.7	Хөгжлийн банкны санхүүжилт					
		Төслийн хэрэгжилт		Хэрэгжилт /шилжин хэрэгжих/						
	Нийт дүн	1,564,874.5	196,211.5	147,382.7						

ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮД									
1	105. "Эко яармаг-1" гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл	212,683.0	5,614.2	202.8	Эх үүсвэр шийдвэрлэгдээгүй	Бэлтгэл ажил. Төслийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	Төслийн ажлын явц 40 хувь. Газар чөлөөлөлт бүрэн хийгдэнэ. Зураг төслийг боловсруулна. Гадна шугам сүлжээний угсралт, орон сууцны барилгын 1-р ээлжийн барилга угсралтын ажлууд хийгдэнэ.	Төслийн газар чөлөөлөлтийн ажлын хүрээнд 2014-2015 онуудад 82 нэгж талбарын айл өрхтэй Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 3 талт гэрээ байгуулж, иргэдийн газрыг "Буянт Ухаа 1", "Буянт Ухаа 2" хорооллын орон сууцаар сольж, чөлөөлж авсан. 2019 онд 1-р ээлжийн барилгын талбайг чөлөөлөх ажлын хүрээнд 26 нэгж талбарын айл өрхөд түр суурьшуулах төлбөрийг хүлээлгэн өгч, нийт 64 нэгж талбарын газрыг чөлөөлөх ажил эхэлсэн. Төслийн газар чөлөөлөлт 90% Төслийн хүрээнд 2014-2018 онуудад Инженер геологийн судалгаа, Байрзүйн зураг, ТЭЗҮ, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эскиз зураг тус тус хийгдэж, магадлалаар орж, хянан батлагдсан бөгөөд техникийн нөхцөлүүд авагдаж 2019 онд сунгагдсан. 2017 онд төслийн гадна шугам сүлжээний зураг төсөл, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний түншлэлийн гэрээ байгуулсанаар ажил нь эхэлсэн. 2019 онд дулаан хангамжийн асуудалтай холбоотой хүндрэл гарч ажил нь удааширсан ч одоогоор дуусах шатанд орсон. 2020 оны I улиралд магадлалаар орж хянан батлагдана. Ажлын явц 15%	40%
	Төслийн хэрэгжилт	2014, 2016, 2018 онуудад төслийн ерөнхий төлөвлөгөөний зурагт 3 удаагийн өөрчлөлт оруулан 2018 оны 12 сард шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөний эскиз зургийг холбогдох албан байгууллагуудаар батлуулсан. Төслийн барилга угсралтын ажлыг төслийн хүрээнд хамтран ажиллах байгууллагыг сонгон шалгаруулалт зарлаж, шалгарсан байгууллагатай бүтээгдэхүүн хуваах нөхцөлтэй хамтран ажиллах хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Төслийн зардал: 2014-2018 оны хороонд төсөл хэрэгжүүлэлтийн зардалд нийт 5,8 тэрбум төгрөг. Үүнд:							

					“Буянт Ухаа 1” болон “Буянт Ухаа 2” хорооллын орон сууцаар газраа сольсон иргэдийн зардал 5,6 тэрбум төгрөг, төслийн бэлтгэл ажлын зардал 256,0 сая төгрөг байна. 2019 онд төслийн хүрээнд ТОСК ТӨҮГ-ийн зүгээс нийт 202,8 сая төгрөгийг газар чөлөөлж түр суурьшуулах зардалд зарцуулсан. Нийт- 5,817,442 төгрөг			
2	106.Ногоон нуур орчмын 1008 айлын орон сууцны төсөл	138,354.0		Гадаад зээл, тусламж, /БНХАУ-ын буцалтгүй тусламж/	-	Төслийн ажлын явц 30 хувь. Зураг төсөл боловсруулах, газар шорооны ажил, төмөр бетон хийцийн ажил, гадна шугам сүлжээний ажлыг гүйцэтгэнэ.	Сангийн сайд болон БХБ-ын сайдын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хамтарсан 27/30 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдсан. Төслийн хүрээнд дараах ажлууд хэрэгжсэн байна. Үүнд: 1. Сүхбаатар дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэрт 3,8 га газарт баригдах 1008 айлын орон сууцны хорооллын ТЭЗҮ, ажлын иж бүрэн зураг төслийг боловсруулж, магадлалаар хянуулан батлуулсан. 2. Орон сууцны хорооллын ажлын зураг төсөл боловсруулахад шаардагдах цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, мэдээлэл холбооны техникийн нөхцлүүдийг холбогдох газруудаас авч, шугам сүлжээний зураг төслийг боловсруулан, хянуулан батлуулсан. 3. Төслийн ТЭЗҮ, ажлын иж бүрэн зураг төсөл, төсвийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн ажлын алба болон Төслийн менежментийн компанитай хэлэлцэж, тохиролцож, 2019 оны 11 дүгээр сард эцэслэн хүлээлгэн өгсөн. 4. Барилгын түр байрны бетон суурийг цутгаж, түр ус хангамж, ариутгах татуургын шийдвэрлэх хүрээнд цэвэр усны төв шугамаас огтолгоо авч 150 м шугам хоолой, төмөр бетон худаг барьж, бохирын 20 м3-ийн төмөр сав суулгасан. 5. Барилгажих талбай дээр байрлаж буй 37 айлын судалгааг хийж, 10 айлын газар чөлөөлөлтөд шаардагдах 2,0 тэрбум төгрөгийг 2020 оны улсын төсөвт тусгуулсан.	100%
		1,085.0		Улсын төсөв				

							3 нэгж талбарыг чөлөөлөхөөр Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийн газар, төслийн нэгж, газар өмчлөгч иргэн нарын хооронд "Газар чөлөөлөх 3 талт гэрээ" байгуулан, газар чөлөөлөлтийн ажил хийгдэж эхлээд байна.		
		600.0	539.6	Улсын төсөв			Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал		
		Төслийн хэрэгжилт		Дүгнэлт: Төслийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл бүрэн хангагдсан.					
3	107.Инженерийн дэд бүтцийг сайжруулах төсөл /Бичил дэд төв/-ийн 1 дүгээр үе шат	276,003.8	-	-	Гадаад зээл, тусламж, /БНХАУ-ын буцалтгүй тусламж/	-	Бэлтгэл ажил	Засгийн газрын 2017 оны 179 дүгээр тогтоолын хүрээнд 2020-2021 онд инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийн төсөл арга хэмжээний жагсаалтыг /2020-2021/ шинэчилж ажлын тоо хэмжээг тодотгон төслийн танилцуулгыг бэлтгэн эхний ээлжийн төслийн жагсаалтыг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар 2019.05.28-ны өдөр батлуулсан бөгөөд төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Хятадын төслийн маягтын дагуу боловсруулан Сангийн яаманд болон Монгол Улсад суугаа БНХАУ-ын Элчин сайдын яаманд 2019.06.25-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн. Мөн төслийн хураангуй танилцуулгыг холбогдох загвар маягтын дагуу бэлтгэж 2019.11.06-ны өдөр Сангийн яаманд болон Монгол Улсад суугаа БНХАУ-ын Элчин сайдын яаманд хүргүүлсэн.	100%
			170.0	645.3	Улсын төсөв				
		Төслийн хэрэгжилт		Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 06 сарын 20-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хэрэгжих инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий бичил дэд төвүүд байгуулах, төвлөрсөн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг БНХАУ-ын засгийн газраас МУ-ын засгийн газарт олгох 2.0 тэрбум юаны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2017-2020 онд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр нийт 6 бүлгийн 55 багц төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан.					

				<p>Уг жагсаалтад нийт 6 дүүргийн /БГД,БЭД, СХД, ЧД,ХУД, СБД/ 43 хорооны нутаг дэвсгэрт дэх төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох бололцоогүй гэр хорооллын дундын болон захын бүсийн тодорхой байршлуудад бие даасан 50 ширхэг бичил дэд төвийг үе шаттай барьж байгуулахаар тусгасан.</p> <p>Дээрх төсөл арга хэмжээний жагсаалт, төслийн танилцуулгад орсон ажлуудаас СБД-ийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Бичил дэд төв” /Сервис центр/-ийн барилга угсралт, инженерийн шугам сүлжээг барих ажлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж 2019-2020 онд гүйцэтгэхээр нийт 4.2 тэрбум төгрөг төсвөлсөн. Үүнээс 2019 онд 900.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Уг ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - дэд төвийн барилга угсралтын ажлын явц 40%, - ф150 мм-ийн бохир усны шугам 1.2 км, ф300 мм-ийн цэвэр усны шугам 1.0 км-ийг тус тус барьж гүйцэтгэсэн. <p>Ажлын явцтай нийслэлийн Засаг даргын орлогч, яамны газрын дарга, БХТ-ийн хяналтын инженер газар дээр нь 2019.09.12-ны өдөр очиж танилцан, хүйтний улирлаас өмнө ажлаа эрчимжүүлэх, мөн тулгамдаад буй асуудлыг яам, нийслэлээс шийдвэрлүүлэх тал дээр анхаарч ажиллаж байгааг дурдаад, удирдлагаас үүрэг, чиглэл өгч, хяналт тавьж ажилласан.</p>		
				<p>Инженерийн дэд бүтцийг сайжруулах төсөл /Бичил дэд төв/-ийн хүрээнд Улсын төсвөөс урьдчилсан санхүүжилтээр 2018 онд 170,0 сая, 2019 онд 645.3 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.</p>		
	Дүн	628,125.8	6,384.2	1,387.7	Хэрэгжилт /шинээр хэрэгжих/	80%
	Нийт дүн	2,193,000.3	202,595.7	148,770.4	Нийт үнэлгээ	88,1%

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“МОНГОЛ УЛСЫН 2018-2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-Т
ТУССАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 290 дүгээр тогтоолоор тодотгон батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилт, зохион байгуулалтыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ГУРАВ. ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т нийт 13 арга хэмжээг хийж гүйцэтгэхээс шилжин хэрэгжих 10, шинээр хэрэгжүүлэх 3 төсөл арга хэмжээг тусгасан байна.

	Төслийн нэр	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн түвшин	Гүйцэтгэлийн үнэлгээ
ШИЛЖИН ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД				
1	Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл	Төслийн ажлын явц 100 хувь. Шугам сүлжээний угсралтын ажлыг бүрэн дуусгасан байна.	95%	100%
2	Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл-МОН-3388	Төслийн ажлын явц 90 хувь. Өвөрхангай аймгийн цэвэрлэх байгууламжийн туршилт тохируулга, сургалтын ажлыг гүйцэтгэнэ. Архангай, Өмнөговь аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлыг дуусган, туршилт тохируулгын ажлыг эхлүүлнэ.	91%	100%
3	Дархан хотын бохир усны менежментийн төсөл	Төслийн ажлын явц 64 хувь. Нийт 6 хэсгээс үлдсэн 2 хэсгийн ажлыг гүйцэтгэнэ.	75,6%	100%
4	Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх	Төслийн ажлын явц 75 хувь, Лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх ажил хийгдэнэ.	100%	100%
5	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж	Төслийн ажлын явц 10 хувь. Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	15%	100%
6	Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэлт	Төслийн ажлын явц 20 хувь. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна.	Үнэлэх боломжгүй	
7	Тайшир-Алтай ус хангамж төсөл	Төслийн ажлын явц 50 хувь. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.	70%	100%
8	Туул усан сан барих төсөл	Бэлтгэл ажил. Санхүүжилтийг шийдвэрлэнэ.	Үнэлэх боломжгүй	

9	Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт	Төслийн ажлын явц 30 хувь. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.	30%	100%
10	Барилгын арматурын үйлдвэр, Орхон аймаг Баян-Өндөр сум	Төслийн ажлын явц 100 хувь. Үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлыг бүрэн дуусгана.	80%	70%
ДҮН				96,2
ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТЭСЛҮҮД				
1	“Эко яармаг-1” гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл	Төслийн ажлын явц 40 хувь. Газар чөлөөлөлт бүрэн хийгдэнэ. Зураг төслийг боловсруулна. Гадна шугам сүлжээний угсралт, орон сууцны барилгын 1-р ээлжийн барилга угсралтын ажлууд хийгдэнэ.	15%	40%
2	Ногоон нуур орчмын 1008 айлын орон сууцны төсөл	Төслийн ажлын явц 30 хувь. Зураг төсөл боловсруулах, газар шорооны ажил, төмөр бетон хийцийн ажил, гадна шугам сүлжээний ажлыг гүйцэтгэнэ.	30%	100%
3	Инженерийн дэд бүтцийг сайжруулах төсөл /Бичил дэд төв/-ийн 1 дүгээр үе шат	Бэлтгэл ажил		100%
ДҮН				80,0
НИЙТ ҮНЭЛГЭЭ				88,1

Үүнээс 2019 онд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу хөтөлбөрийн 13 арга хэмжээний биелэлт **88,1 хувьтай**, үнэлэх боломжгүй 2 ажил байна.

Хэрэгжилтийн түвшин /хувиар/

№	Үзүүлэлт	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн түвшин /%/
1	Шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээ	10	96,2
2	шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	3	80
НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ		13	88,1%

Хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжилт тус бүрээр танилцуулж байна. Үүнд:

1. Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл

Төслийн зорилго: Улаанбаатар хотын агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах, VII, XIV хорооллыг барилгажуулах эхлэлийг тавих, VII хороолол, МҮОНРТ орчмын хорооллыг инженерийн дэд бүтцэд холбох, VII, МҮОНРТ-ийн хорооллын цахилгаан хангамжийг сайжруулахад оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ
Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн ЗДТГ
Хэрэгжих хугацаа: 2010.11.19- 2019.12.30

Төслийн зорилтууд:

1-р зорилт: Улаанбаатар хотын VII, XIV хороололд нийт 2592 айлын орон сууц барих.

2-р зорилт: Орон сууцны VII хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх.

3-р зорилт: МҮОНРТ-ын орчмын хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх.

4-р зорилт: Улаанбаатар хотын VII хороолол, МҮОНРТ-ийн орчмын хорооллыг цахилгааны эх үүсвэрээр хангах 23,3 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам болон “Улаанбаатар” дэд станцын өргөтгөл, “7-р хороолол”, “Радио телевиз” дэд станцын угсралтын ажлыг гүйцэтгэх.

Төслийн хэрэгжилтийн түвшин 95 хувьтай хэрэгжсэн байна.

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж /хувь/	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
	95%	4	100	80%	100%	100%

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлууд хийгдсэн. Үүнд:

Төслийн хүрээнд МҮОНРТ, VII, XIY хорооллын инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлууд үндсэндээ хийгдэж дуусаад байна. Үүнд:

1. МҮОНРТ орчмын хороололд Ус дулаан дамжуулах төвтэй холбосон 105 м /хос шугам/ шугам сүлжээ. 1 ширхэг дулааны худаг, гадна бохир усны 1100 метр шугам сүлжээ, 30 ширхэг худаг болон Баянгол дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт дулааны 1760 метр шугам сүлжээ, 7 ширхэг цутгамал худгийн угсралтын ажлыг гүйцэтгэн 2019 оны 8-р сарын 4-ний өдөр тус тус ашиглалтад оруулсан.

2. МҮОНРТ Чингэлтэй дүүргийн 5,8-р хорооны нутаг дэвсгэрт нийт 1700 метр бохир усны шугам сүлжээний, 54 ширхэг худгийн угсралтын ажлыг гүйцэтгэсэн.

3. МҮОНРТ-ийн усан сан, өргөлтийн насос станц, цэвэр усны шугамын ажлын хүрээнд цэвэр усны 4200 метр шугам сүлжээ, 3 ширхэг цутгамал худаг, 18 ширхэг угсармал худгийн угсралтын ажлыг 2019 онд бүрэн гүйцэтгэсэн.

4. Төслийн хүрээнд 2019 онд МҮОНРТ, VII, XIY хороололд 10 кВ-ын хуваарилах байгууламж-3 ком, 2х630 кВА-ын цахилгааны дэд өртөө -1 ком, 2х1000 кВА-ын дэд өртөө 1 ком, тэдгээрийн тэжээлийн 10 кВ-ын 25,0 км урттай цахилгааны кабель шугамын угсралтын ажил зэрэг 11 нэр төрлийн ажлыг гүйцэтгэсэн байна.

5. Тасганы усан сангийн хяналтын системийн шилэн кабелийн ажил бүрэн дуусч, 2019 рны 12 дугаар сарын 16-ны өдөр комисс ажиллан, байнгын ашиглалтад оруулсан. Цахилгааны ажлын хувьд: 800 кВА-ын чадалтай нөөцийн дизель генератор суурилуулсан. ХТП-1054 дэд өртөөнөөс буусан 2 ш трансформатор, 10 кВ-ын тоног төхөөрөмжийг эзэмшигч байгууллага УСУГ-т хүлээлгэн өгсөн.

Санал, зөвлөмж.

1. Дуусаагүй барилга бүртгэлд байгаа 70,0 сая ам.долларын өртөг бүхий 2592 айлын орон сууцны барилга, 33,4 тэрбум төгрөгийн дулаан, цэвэр бохир усны шугам, цахилгааны шугам сүлжээ, дэд станцуудыг өмчлөгчийн эзэмшилд шилжүүлэх талаар холбогдох шийдвэрүүдийг гаргуулах,

2. Төслийн төгсгөлийн тайланг холбогдох дүрэм журамд нийцүүлэн боловсруулж, тус яаманд 2020 оны 01 дүгээр улиралд багтаан ирүүлэх арга хэмжээ авах,

2. Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл - МОН-3388

Төслийн зорилго: Бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэ технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасч, орон нутгийн оршин суугчдын эрүү ахуй, орчны стандартыг дээшлүүлэх юм.

Төслийн хүрээнд Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймгийн төвүүдэд био өнгөр тогтоогч бүхий идэвхжүүлэгч лагийн технологи ашигласан орчин үеийн үр ашигтай цэвэрлэх байгууламж барихаас гадна дээрх аймгуудын нийтийн аж ахуйн байгууллагуудын бүтцийн шинэчлэл, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа хийгдэнэ.

Төвлөрсөн цэвэрлэх байгууламжаас болон гэр хорооллоос гарсан лагийг дахин боловсруулж ашиглах тухай “Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа /ТТ9100/”-г зээлийн төсөлтэй хамт баталж, хэрэгжүүлнэ.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Архангай, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь аймгийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2016-2020

Төслийн үе шат:

	1-р үе шат	2-р үе шат
Төслийн нэр	Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл нэмэлт санхүүжилт
Төслийн дугаар:	G0204-МОН	МОН-3388
Соёрхон баталсан өдөр:		2016 оны 5-р сарын 20
Хүчин төгөлдөр болсон өдөр:	2010 оны 7-р сарын 30	2016 оны 7-р сарын 05
Хүлээн авагч:	Монгол Улсын Засгийн Газар	Монгол Улсын Засгийн Газар
Хэрэгжүүлэгч агентлагууд:	БХБЯ, Өмнөговь, Дорноговь аймгийн ЗДТГ	БХБЯ, Өмнөговь, Дорноговь, Архангай, Өвөрхангай аймгийн ЗДТГ
Төслийн нийт өртөг:	21.9 сая ам.доллар	21.17 сая ам.доллар
Монгол Улсын Засгийн Газар	6.9 сая ам.доллар	1.74 сая ам.доллар
Азийн хөгжлийн банк	15.0 сая ам.доллар /буцалтгүй тусламж/	19.43 сая ам.доллар /хөнгөлөлттэй зээл/
Төсөл хэрэгжиж дуусах хугацаа	2019 оны 11-р сарын 30	2019 оны 12-р сарын 31

Төслийн зорилтууд:

Зорилт 1. Төслийн удирдлага, хэрэгжилтэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ;

Зорилт 2. Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралт.

Төсөл нь Төслийн удирдлага, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралтын ажлуудыг дуусгах, Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжууд болон цэвэрлэх байгууламжаас гарах лагийг боловсруулж, хөрсний бүтцийг сайжруулахад ашиглах шахмал түлш хийх гэсэн 3 зорилтын хүрээнд нийт 9 багц ажлыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төслийн хэрэгжилтийн түвшин /өссөн дүнгээр/ 91%-тай хэрэгжсэн байна.

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ /хувь/	Хэрэгжилт /хувь/		Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
	2019 оны төл-ний биелэлт	91%			

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Архангай аймгийн Цэцэрлэг хотод баригдах цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажилд аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/536 тоот захирамжаар байгуулагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ажиллаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн.

- Дорноговь аймгийн Сайншанд хотын цэвэрлэх байгууламжийн ажлыг 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлж, 2-р тунгаагуурын ханын арматурчлал, сараалжийн, дэд өртөөний барилгуудын гадна фасадын ажил, үйлдвэрийн барилгын гадна өрлөгийн ажил, лаг боловсруулах цех, уурын зуухны барилгуудын өрлөг, хучилтын цутгалтын ажлууд хийгдсэн. Нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувьтай.

- Өвөрхангай аймгийн Хужирт сумын 310 м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсвийг 2019 оны 04 дүгээр сард магадлалаар хянуулан батлуулж, тендерийг 2019 оны 11-р сард зарлан, дүгнэж байна.

- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төвийн ус, дулаан дамжуулах төв-10-ын дулаан хангамжийн 2-р хэлхээний 380 м бетон сувгийг цутгаж, дулааны өгөх, буцах, хэрэгцээний халуун усны, хүйтэн усны нийт 5 шугамын угсралтын ажлыг гүйцэтгэсэн. Цэвэр усны эх үүсвэрийн 2-р худгаас дулааны төв станц хүртэлх 2,5 км цэвэр усны шугам угсарч дуусган, 2019 оны 12 дугаар сарын 05-нд комисс ажиллаж, ашиглалтад оруулсан.

- Өвөрхангай аймгийн Баянгол сумын бохир усны шугам сүлжээ, насос станцын нэмэлт ажлын хүрээнд үерийн усны бетон далангийн 200м сувгийн ажил бүрэн дууссан. Ажлын гүйцэтгэл 98 хувьтай.

- Нийтийн аж ахуйн байгууллагуудын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх баг Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймгуудад 2019 оны 09-10 дугаар сард ажиллаж, дээрхи аймгуудын НААБ-уудын Төлөөлөн удирдах зөвлөлд Стратеги төлөвлөгөөг танилцуулан, хүлээлгэн өгсөн.

- Төслийн бүрэлдхүүнд багтаж байгаа “Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа ТТ9100” дэд төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 200 айлд сайжруулсан нүхэн жорлон хамтарч барихаас 47 айлын нүхэн жорлонг барьж, ашиглалтад оруулаад байна.

Санал, зөвлөмж

1. Өмнөговь аймгийн Даланзадгад хотын цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах,

2. Төслийн бүрэлдхүүнд багтаж байгаа “Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа ТТ9100” дэд төслийн хүрээнд гэр хорооллын сайжруулсан нүхэн жорлонгийн хувилбарууд, өтгөн лагийг цуглуулах, зайлуулах тогтвортой үйлчилгээг хэрэгжүүлэх болон лагийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хөрс сайжруулах чиглэлээр ашиглах туршилтын төсөл боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах,

3. Дархан хотын бохир усны менежментийн төсөл

Төслийн зорилго: Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах, бохир усны төв цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга болон насос станцын үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэх, Дархан хотын ус сувгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэхэд оршино.

Монгол Улсын Дархан-Уул аймгийн хот байгуулалт түүний төлөвлөлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ээлтэй, тогтвортой байдлаар хөгжүүлснээр чанар аюулгүй байдлын үзүүлэлтийн түвшин дээшилж, хүн амын амьдрах орчны төлөв байдал сайжирна.

Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын 2 дахь том хотод үйлдвэржилтийг дэмжих, төвлөрлийг сааруулах, хот хөдөөгийн ялгааг арилгах үндсэн нөхцөл бий болж, Дархан хотын бохир усны менежмент сайжирч, бохир ус цэвэрлэх төв байгууламж (ТЦБ), ариутгах татуургын үйл ажиллагааны түвшин дээшилнэ. Дархан хотын ус сувгийн байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлж, байгууллагын бодлого бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоход дэмжлэг болно.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Дархан-Уул аймгийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2015.08.25 - 2020.11.30. /Нийт 63 сар/

Төслийн зорилтууд:

Зорилт 1. Цэвэрлэх байгууламж шинэчлэн барих;

Зорилт 2. Дулааны болон бохирын шугам сүлжээ, насос станц шинэчлэх;

Зорилт 3. Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх.

Төслийн хүрэх үр дүн:

Үр дүн 1: Бохир ус цэвэрлэх байгууламж шинэчлэгдэнэ.

Төслийн үр дүнд орчин үеийн Үйлдвэрлэлийн бүтээмж өндөртэй, эрчим хүчний хэмнэлттэй цэвэрлэх процесс болох биофильмт технологийг (идэвхжүүлсэн лаг) ашиглах шинэ цэвэрлэх байгууламж ашиглалтад орох бөгөөд нийт барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг шинээр барьж суурилуулж тоноглоно.

Төслийн хүрээнд одоо ашиглагдаж буй 2, ашиглалтгүй байгаа 1 насос станцыг бүрэн шинэчилж тоногложоор цэвэрлэх байгууламжид төвлөрөх бохир усны цуглуулалтыг ихэсгэж эрчим хүчний хэмнэлттэй цэвэрлэх боломжийг бий болгоно.

Орчин үеийн бохир усны лаборатори ашиглалтад орсоноор усны чанарыг олон улсын стандартад нийцүүлэн шинжилж, үр дүнг гаргадаг болно.

Үр дүн 2: Дулааны болон бохирын шугам хоолой шинэчлэгдэнэ.

Төслөөр ашиглалтын шаардлага хангахгүй нийт 9,2 км урт бохир усны шугам хоолойг шинэчилнэ. Ингэснээр үйлдвэрүүдийн бохир усыг урьдчилсан цэвэрлэх байгууламжаар дамжуулан төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх, мөн хотын төвийн хэрэглэгч ихтэй шугамуудын ачаалал багасан найдвартай ажиллагаа дээшлэх нөхцөл бий болно.

Мөн цэвэрлэх байгууламжийг төвийн дулааны сүлжээнд холбох зорилгоор 1,2 км дулааны хос шугам хоолойг шинээр, дулааны 3-р насос станцын тоног төхөөрөмж болон цахилгаан тоноглолыг шинэчилнэ. Цэвэрлэх байгууламж төвийн дулаанд холбогдсоноор цаашдын ашиглалтын зардал буурч, ажилчдад ажиллах таатай нөхцөл бүрдэнэ.

“Дархан Ус суваг” ХК-д өдөр тутмын үйлчилгээний зориулалттай тоног төхөөрөмж нийлүүлэн ажлын хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулна.

Үр дүн 3: Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх.

НАА-н салбарын менежментийн чадавхийг хөгжүүлэх, ашиглалт ба засвар үйлчилгээг сайжруулах, онцгой байдлын үед авах арга хэмжээний нарийвчилсан зураг төсөл боловсруулан хэрэгжүүлж, түүнд хяналт тавьж мэргэжлийн дэмжлэг үзүүлэх боломжийг бий болгоно.

Төслийн хэрэгжилтийн явцад сургалт болон сургалтын аяллууд зохион байгуулагдана. Төслийн хэрэгжилтийн явцад цэвэр ба бохир усны үнэ тарифын шинэчлэл, ариун цэврийн орчин болон хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар бодлого тодорхойлох яриа хэлэлцүүлэг хийнэ. Байгаль орчны менежмент, ариун цэвэр ба хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар олон нийтийг хамруулсан компани ажил зохион байгуулна.

Төсөл хэрэгжүүлэхтэй зэрэгцүүлэн НАА-н үйлчилгээний институт бүтцийг хөгжүүлэх, стратеги төлөвлөлт ба үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн Техникийн тусалцааны төслийг хэрэгжүүлнэ.

Төсөл нь цэвэрлэх байгууламж, насос станц, дулааны болон бохирын шугам сүлжээ шинэчлэх, төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх гэсэн 3 зорилтын хүрээнд хэрэгжиж байна.

Төслийн хэрэгжилтийн түвшин 75,6 хувьтай хэрэгжсэн байна.

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт /хувь/		Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
	Хэрэгжилтийн түвшин /өссөн дүнгээр/	75,6 %				
			3	64,9	94,9	79,7

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Төслийн үндсэн худалдан авалтаас хэмнэгдсэн зээлийн хөрөнгөөр “А2-4. Бохирын шугам хоолойн өргөтгөл шинэчлэл” багц ажлын хүрээнд “Цагаан зуун” ХХК нь ф300 мм-ийн голчтой 1770 м шугам, 52 худгийн барилгын ажлыг гүйцэтгэн, 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулсан.

2. Төслийн хүрээнд “Бридж констракшн” ХХК нь ф300 мм-ийн голчтой 290 м шугам, 13 худгийн барилгын ажлыг гүйцэтгэн, 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгсөн.

3. Төслийн худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөний дагуу техникийн шаардлага хангасан эксковаторыг Дарханы ус сувгийн байгууллагад 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгсөн.

4. А2-7 багц. Бохирын насос станцын засварын ажлын хүрээнд насос станцыг шинэчлэх, бохирын нэмэлт шугам хоолойн ажлын зураг төслийг “Эрчим төсөл” ХХК боловсруулж, батлуулсан.

5. Дархан-Уул аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 07 тоот тогтоолоор “Бридж констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн 714,5 сая төгрөгийн үнэ бүхий бохир усны ф355 мм-ийн голчтой 1600 м хуванцар хоолой, ф800 мм-ийн 1230 м төмөр бетон хоолой, ф300 мм-ийн 290м хуванцар хоолойг, мөн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 10-р сарын 04-ний өдрийн 88 тоот тогтоолоор “Бридж констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн 234,2 сая төг-ийн үнэ бүхий бохир усны шугам хоолойг, “Цагаан зуун” ХХК-ийн гүйцэтгэсэн 633 сая төг-ийн үнэ бүхий бохир усны шугам хоолойг тус тус Дархан ус суваг ХК-ийн балансад бүртгэх зөвшөөрөл олгосон.

6. “Дархан дулааны сүлжээ” ТӨХК-д 1 тэрбум 260,3 сая төг-ийн үнэ бүхий дулааны насос станц, цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамыг хүлээлгэн өгч, барилга байгууламжийн ашиглалтын ногоон гэрчилгээ олгосон.

7. Төслийн хэмнэгдсэн хөрөнгөөр нэмэлт 2 байршилд бохир усны шугам угсрахтай холбогдуулан газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг шинэчлэн 2019 оны 03-р сарын 13-ны өдөр АХБ-аар батлуулсан.

8. Төслийн хүрээнд нийгмийн хөгжлийн, жендерийн үйл ажиллагааны, хэлэлцүүлэг-оролцооны, оролцогч талуудын харилцаа холбооны, олон нийтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус батлуулан хэрэгжүүлэн ажилласан байна.

Санал, зөвлөмж

1. Дархан хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх барилгын ажилд шаардагдах бараа материал, тоног төхөөрөмж, машин механизм, ажиллах хүч, барилгын ажил явагдаж буй барилгын тоог нэмэгдүүлэн үндсэн гүйцэтгэгч Пфайфер болон Эмит түншлэлд барилгын ажлын хоцрогдлоо энэ онд нөхөж чадахгүй тохиолдолд гэрээний хариуцлага тооцох,

2. Дархан хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлын ерөнхий гүйцэтгэгч Пфайфер болон Эмит түншлэлийн удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулан, үйл ажиллагааг эрчимжүүлж, байнгын хяналт тавьж, хоцрогдлыг арилгуулах арга хэмжээ авах.

4. Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх

Төв цэвэрлэх байгууламжийн лагийг үнэргүйжүүлэх, боловсруулах зорилгоор Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.1.20 дахь заалтад “Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх” арга хэмжээг 2018-2020 онуудад 35,0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгагдан батлагдаж, энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн “Ногоон сууц” ТББ, “Ногоон титэм” ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээг, Засгийн газрын 2018 оны 73 дугаар тогтоолыг үндэслэн “Хийрэв” ХХК, “Ховд тул” ХХК, “Эко тайхи” ХХК-тай ажил гүйцэтгэх шууд гэрээг, лаг усгүйжүүлэх байгууламж барих түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй нээлттэй тендер шалгаруулалтаар “Ай вай и зэт групп” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулан, ажиллуулсан.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн.

2019 онд нийт 44 картын 320327 м³ лаг, өдөр тутмын 249382 м³ лаг, хуримтлагдсан хур 241169 м³ лаг нийт **810878** м³ лагийн бүрэн цэвэрлэж үнэргүйжүүлэн боловсруулж бордоо болгох ажлыг хийж дуусгасан.

Мөн Төв цэвэрлэх байгууламжаас гарч буй түүхий лагийн овор хэмжээг багасгах, үнэрийг бууруулах зорилгоор хоногт 2500м³ лаг усгүйжүүлэх хүчин чадалтай автоматжсан байгууламжийг ашиглалтад оруулсан.

5. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж

Төслийн зорилго: Улаанбаатар хотод төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Монгол улсын чанарын стандартыг хангасан хаягдал усыг байгальд нийлүүлэх, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам

Хэрэгжих хугацаа: 2019-2023 он

Төслийн нийт өртөг: 262,7 сая ам.доллар

Төслийн зорилтууд:

Зорилт 1. Зураг төсөл, барилга угсралтын ажил;

Зорилт 2. Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалт;

Зорилт 3. Сургалт, туршилт тохируулга, ашиглалтанд оруулах.

Төсөл нь цэвэрлэх байгууламж, насос станц, дулааны болон бохирын шугам сүлжээ шинэчлэх, төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх гэсэн 3 зорилтын хүрээнд ажилласан байна.

Төслийн ажлын явц 15 хувьтай хэрэгжиж байна.

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Төслийн зураг төсөл боловсруулах ажлыг БНХАУ-ын "Шанхай хотын инженерийн зураг төслийн институт" ХХК гүйцэтгэж, барилгын эх загвар зурагт 2019 оны 9-р сарын 12-ны өдрийн ЭЗ-5/2019 тоот магадлалын ерөнхий дүгнэлт гарсан.

-Барилгын талбай дээр инженер геологийн судалгаа хийгдэж магадлалын ерөнхий дүгнэлтийн хүрээнд талбайн буурь хөрсний хяналтын №19/045 тоот акт гарсан.

-Төслийн зураг төслийг боловсруулахад шаардагдах цахилгаан, дулаан, мэдээлэл холбооны техникийн нөхцлүүдийг авч зургийн компаниудад хүргүүлсэн.

-Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2019 оны 9-р сарын 27-ны өдөр авч, дараах ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд:

-120м3/цаг-ийн хүчин чадалтай бетон зуурмаг үйлдвэрлэх узелийн угсралтын ажил 100%,

-төслийн түр барилгын ажил 70%,

- биологи цэвэрлэгээний талбайн хөрс хуулалтын ажил 50%,

- барилгын суурийн хөрс хуулалтын ажил 30%,

- хөрсний даацны хэмжилт болон ул хөрсний нягтруулалтын ажил хийгдэж биологи цэвэрлэгээний С хэсгийн нийт 800м3 М400 маркийн ул бетон цутгалтын ажил 5%,

-биологи цэвэрлэгээний байгууламжийн талбай дээр инженер геологийн судалгааны дагуу гүний усны түвшин доошлуулах 32 цооног өрөмдөж ул бетон цутгах бэлтгэл ажлыг ханган бетоныг хөлдөхөөс хамгаалах хучилтыг 10-р сарын 23-ны өдөр хийж талбайг өвлийн горимд оруулж хамгаалалт хийгдээд байна.

Санал, зөвлөмж

- Монгол Улсын Сангийн яам болон БНХАУ-ын ЭКСИМ банкттай хийх санхүүжилтийн зээлийн гэрээг байгуулахад дэмжлэг үзүүлэх, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр ханган ажиллах.

- Төслийн 2019 оны төлөвлөгөөнд туссан боловч удаашралтай байгаа ажлуудад анхаарч, 2020 оны төлөвлөгөөнд тусгах, төслийн хэрэгжилтийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулан, төслийг батлагдсан графикийн дагуу хэрэгжүүлж ажиллах.

- Төслийн байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийлгэж, баталгаажуулах.

- Барилга архитектурын зураг төсөл, Ариутгах татуургын тоног төхөөрөмжийн зураг төсөл, лаг боловсруулах тоног төхөөрөмжийн зураг төсөл, үнэр дарах системийн зураг төсөл, цахилгаан автоматжуулалтын зураг төслийг тус тус боловсруулж, батлуулах.

6. Тайшир-Алтай ус хангамж төсөл

Төслийн зорилго: Говь-Алтай аймгийн төвийн ус хангамжийн одоо ашиглаж байгаа эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Тайширын усан сангаас эргийн далд байгууламжаар усыг шүүрүүлэн авч 54.7 км урттай далд шугам хоолойгоор дамжуулан Алтай хотын 19 мянган хүн амын амьдрах нөхцөл болон тэдэнд үзүүлэх усны үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ

Төслийн нийт өртөг: 14,0 сая евро

Барилга, хот байгуулалтын яам, Бүгд Найрамдах Австри Улсын “Тиролер Рохре” ХХК-тай “**Зураг төсөл-нийлүүлэлт-барилга угсралт**”-ын ажлын гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд туслан гүйцэтгэгчээр Австри Улсын “ОСТАП” ХХК, Монгол Улсын “Сайрам булган” ХХК, “МОГҮМБ Констракшн” ХХК гэх компаниуд ажиллаж байна. Төслийн хүрээнд шаардлагатай зураг төслийг боловсруулан 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.

Төслийн хүрээнд хийгсэн ажлууд:

- Ус цэвэршүүлэх байгууламжийн барилга угсратын ажил бүрэн дууссан.
- Нөөц усны барилга /усан сан/ угсралтын ажил бүрэн дууссан.
- 14 метрийн гүнтэй ус авах цооногийн төмөр бетон цутгалтын ажил бүрэн дууссан.
- Өргөлтийн насос станцын барилга угсралтын ажил бүрэн дууссан.
- 54 км урттай ган шугам хоолой угсрах ажлын 27 км урт шугамыг угсарч дууссан.

Нийт барилга байгууламжийн угсралтын ажил **70 хувийн гүйцэтгэлтэй** байна.

7. Туул усан сан барих төсөл

Туул усан цогцолборын урьдчилсан ТЭЗҮ-ийг 2011 онд Престиж групп ХХК, 2015 онд УСУГ-ын захиаллагаар Юүшин инженеринг корпораци боловсруулсан байна. Мөн АНУ-ын мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламжаар ундны усны эх үүсвэрийг ашиглан, дулааны цахилгаан станцын технологийн хэрэгцээнд ашиглах зорилгоор холбогдох ТЭЗҮ, техникийн зураг төсөл боловсруулж байгаатай холбогдуулан хэрэгцээ шаардлагыг уялдуулахаар хүлээлтийн байдалтай байна.

Үнэлэх боломжгүй

8. Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт -МОН-3713

Төслийн зорилго: Төслийн хүрээнд Булган, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн төвүүдэд био өнгөр тогтоогч бүхий идэвхжүүлэгч лагийн технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасч, орон нутгийн оршин суугчдын эрүүл ахуй, орчны стандартыг дээшлүүлэхэд оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Булган, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгуудын ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2019-2022

Төслийн зорилтууд:

Зорилт 1. Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ ;

Зорилт 2. Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралт;

Төсөл нь Төслийн удирдлага, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралт гэсэн 2 зорилтын хүрээнд нийт 6 багц ажлыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төслийн ажлын явц 30% -тай хэрэгжиж байна.

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

1-р зорилтын хүрээнд: В1 багц. Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх компани сонгон шалгаруулах ажлын даалгаварыг боловсруулж, Үнэлгээний хороонд танилцуулсан. Ажлын гүйцэтгэл 80%.

2-р зорилтын хүрээнд: Булган аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын гүйцэтгэгч “Заг инженеринг” ХХК, “Престиж Инженеринг” ХХК, “Жиангсу Зэюү Энв. Протекшн” түншлэлтэй 2019 оны 5 дугаар сард гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн. Биологи цэвэрлэгээний барилгын төмөр бетон цутгалтын ажил, талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил бүрэн дууссан. Үйлдвэрийн, механик цэвэрлэгээний барилгын 0,00 түвшингийн суурийн төмөр бетон цутгалтын ажил, бохир усны, дренажийн бохир усны барилгын 0,00 түвшингийн төмөр бетон цутгалтын ажил, лаг боловсруулах цехийн барилгын суурийн цутгалт, ханын арматурчлалын ажил хийгдсэн. Барилга угсралтын ажил 50 хувьтай байна.

Хөвсгөл аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг “Набсан” ХХК, “Эс энд Эй Трэйд” ХХК-ний түншлэл 2019 оны 6 дугаар сараас эхлүүлж, биологи цэвэрлэгээний блокийн барилгын ханын арматурчлал, механик цэвэрлэгээний блокийн суурийн цутгалтын ажил, үйлдвэрийн барилгын баганын арматурчлалын ажил хийгдсэн. Захиргааны, дэд өртөөний, харуулын байрны барилгуудын хучилтын цутгалтын ажил дууссан. Цэвэрлэгдсэн усны насос станцын гадна өрлөгийн ажил, бохир усны, дренажийн барилгын цутгалт, өрлөгийн угсралтын ажлуудыг гүйцэтгэсэн. Талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил, цэвэр ус, дулааны шугамын угсралтын ажил бүрэн дууссан. Лаг, элсний талбайн бетоны ажил дууссан. Барилга угсралтын ажил 55 хувьтай байна.

Хэнтий аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг “Комфорт импекс” ХХК 2019 оны 8 дугаар сараас эхлүүлж, ЦДАШ-ын угсралтын ажил, Захиргааны, дэд өртөөний барилга, харуулын барилгуудын өрлөг, хучилтын ажлууд хийгдэж дууссан. Барилга угсралтын нийт ажил 10 хувьтай байна.

Булган, Хөвсгөл аймагт ажиллах төслийн хяналтын инженерүүдийг сонгон шалгаруулж, ажилд нь оруулсан.

Санал, зөвлөмж

1. Сүхбаатар болон Дундговь аймгуудын төвд баригдах цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авах.

10. Барилгын арматурын үйлдвэр, Орхон аймаг Баян-Өндөр сум.

Орхон аймгийн Баян-Өндөр суманд байгуулагдаж байгаа Бэрэн ХХК-ний гангийн үйлдвэр нь 2018 онд өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 4,4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө оруулалт хийсэн.

Төслийн хүрээнд үйлдвэрийн барилгын ажил бүрэн дууссан.

2019 онд Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 73,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлаас дараах ажлууд хийгдсэн байна.

Үүнд:

- Домен 35 м.куб 100%,
- домен 70 м.куб 60%,
- кран 100%,
- хүчилтөрөгчийн конвертор 85%,
- цахилгаан нуман зуух 80%,
- шанаган зуух 80%,
- тасралтгүй цутгах машин 80%, хөргөлтийн усан сан 100%,
- хүчилтөрөгчийн станц 100%, цувих 40%.

Үйлдвэр ашиглалтад оруулах хугацаатай уялдуулан үйлдвэрийн шугамуудыг үе шаттайгаар ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Шинээр хэрэгжих төслүүд:

1. “Эко яармаг-1” гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл

Төслийн зорилго:

- Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгааг хангах зорилгоор гэр хорооллын газрыг зохион байгуулах, төлөвлөх, барилгажуулах;
- Айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбогдсон, өнөөгийн стандартад нийцэхүйц сүүлийн үеийн технологи бүхий шийдэлтэй тохилог орон сууцаар хангах;
- Хотын агаар болон хөрсний бохирдлын хувийг багасгах;
- Гэр хорооллын орон зайг ашиглах, дахин төлөвлөх, хүн амын эмх цэгцтэй төлөвлөлт бүхий суурьшлыг үүсгэх;

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ, ТОСК

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ТОСК ТӨХХК

Хэрэгжих хугацаа: 2014-2022

Төслийн хүчин чадал:

- 1,920 өрх айл
- 12 давхар, 28 блок
- 30м2- 71м2 бүхий 1-4 өрөөний зохион байгуулалт
- 240 хүүхдийн цэцэрлэг
- 600 хүүхдийн сургуулийн өргөтгөл /34-р сургууль/
- Үйлчилгээний төвийн 1 барилга
- Музейн барилга
- Хотхон дотор авто машин зорчихгүй байх төлөвлөлтийн шийдэл

Мөн төслийн хүрээнд ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, спорт цогцолбор, хүүхдийн эко тоглоомын талбай зэргийг төлөвлөсөн.

Бэлтгэл ажил:

Төслийн бэлтгэл ажил хүрээнд **2014-2018 онуудад** Инженер геологийн судалгаа, Байрзүйн зураг, ТЭЗҮ, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эскиз зураг тус тус хийгдэж, магадлалаар орж, хянан батлагдсан бөгөөд техникийн нөхцөлүүд авагдаж 2019 онд сунгагдсан.

2017 онд төслийн гадна шугам сүлжээний зураг төсөл, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний түншлэлийн гэрээ байгуулсанаар ажил нь эхэлсэн. 2019 онд дулаан хангамжийн асуудалтай холбоотой хүндрэл гарч ажил нь удааширсан байна.

2014, 2016, 2018 онуудад төслийн ерөнхий төлөвлөгөөний зурагт 3 удаагийн өөрчлөлт оруулан 2018 оны 12 сард шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөний эскиз зургийг холбогдох албан байгууллагуудаар батлуулсан.

Төслийн газар чөлөөлөлтийн ажлын хүрээнд 2014-2015 онуудад 82 нэгж талбарын айл өрхтэй Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 3 талт гэрээ байгуулж, иргэдийг газрыг “Буянт Ухаа 1”, “Буянт Ухаа 2” хорооллын орон сууцаар сольж, чөлөөлж авсан. 2019 онд 1-р ээлжийн барилгын талбайг чөлөөлөх ажлын хүрээнд 26 нэгж талбарын айл өрхөд түр суурьшуулах төлбөрийг хүлээлгэн өгч, нийт 64 нэгж талбарын газрыг чөлөөлөх ажил эхэлсэн. Төслийн газар чөлөөлөлт 90 хувьтай байна.

2. Ногоон нуур орчмын 1008 айлын орон сууцны төсөл

Төслийн зорилго: Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1008 айлын орон сууцны хотхоныг ил болон далд авто зогсоол, гадна дотор инженерийн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, дэд өртөөний хамт барихад оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2019-2023

Төслийн зорилтууд:

Зорилт-1. “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн Техник эдийн засгийн үзүүлэлт, зургийн даалгавар батлуулах, ажлын зураг төсөл, төсөв боловсруулах, Хятадын талтай нэг бүрчлэн санал солилцох, эцэслэн хүлээлгэж өгөх;

Зорилт-2. Барилгажих талбайн бэлтгэл ажлыг хангах, газар чөлөөлөх;

Зорилт-3. Төслийн ерөнхий гүйцэтгэгч компани сонгон шалгаруулах, Тендерийн баримт бичиг боловсруулах, Хятадын талтай санал солилцох, баримт бичигт тусгах.

Төслийн ажлын явц 30% -тай хэрэгжиж байна.

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлууд хийгдсэн. Үүнд:

1. Сүхбаатар дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэрт 3,8 га газарт баригдах 1008 айлын орон сууцны хорооллын ТЭЗҮ, ажлын иж бүрэн зураг төслийг боловсруулж, магадлалаар хянуулан батлуулсан.

2. Орон сууцны хорооллын ажлын зураг төсөл боловсруулахад шаардагдах цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, мэдээлэл холбооны техникийн нөхцлүүдийг холбогдох газруудаас авч, шугам сүлжээний зураг төслийг боловсруулан, хянуулан батлуулсан.

3. Төслийн ТЭЗҮ, ажлын иж бүрэн зураг төсөл, төсвийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн ажлын алба болон Төслийн менежментийн компанитай хэлэлцэж, тохиролцож, 2019 оны 11 дүгээр сард эцэслэн хүлээлгэн өгсөн байна.

4. Барилгын түр байрны бетон суурийг цутгаж, түр ус хангамж, ариутгах татуургын шийдвэрлэх хүрээнд цэвэр усны төв шугамаас огтолгоо авч 150 м шугам хоолой, төмөр бетон худаг барьж, бохирын 20 м³-ийн төмөр сав суулгасан.

5. Барилгажих талбай дээр байрлаж буй 37 айлын судалгааг хийж, 10 айлын газар чөлөөлөлтөд шаардагдах 2,0 тэрбум төгрөгийг 2020 оны улсын төсөвт тусгуулсан. 3 нэгж талбарыг чөлөөлөхөөр Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийн газар, төслийн нэгж, газар өмчлөгч иргэн нарын хооронд “Газар чөлөөлөх 3 талт гэрээ” байгуулан, газар чөлөөлөлтийн ажил хийгдэж эхэлсэн.

Санал, зөвлөмж.

1. Төслийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллах

3. Инженерийн дэд бүтцийг сайжруулах төсөл /Бичил дэд төв/-ийн 1 дүгээр үе шат

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 06 сарын 20-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хэрэгжих инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий бичил дэд төвүүд байгуулах, төвлөрсөн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын засгийн газарт олгох 2.0 тэрбум юаны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2017-2020 онд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр нийт 6 бүлгийн 55 багц төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан.

Уг жагсаалтад нийслэлийн 6 дүүргийн /БГД, БЗД, СХД, ЧД,ХУД, СБД/ 43 хорооны нутаг дэвсгэрт дэх төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох бололцоогүй гэр хорооллын дундын болон захын бүсийн тодорхой байршлуудад бие даасан 50 ширхэг бичил дэд төвийг үе шаттай барьж байгуулахаар тусгасан.

Дээрх төсөл арга хэмжээний жагсаалт орсон СБД-ийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Бичил дэд төв” /Сервис центр/-ийн барилга угсралт, инженерийн шугам сүлжээг барих ажлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж эхний ээлжийн газар чөлөөлөлт, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Уг ажлын хүрээнд:

- дэд төвийн барилга угсралтын ажлын явц - 40%,
- ф150 мм-ийн бохир усны шугам 1.2 км, ф300 мм-ийн цэвэр усны шугам 1.0 км-ийг тус тус барьж гүйцэтгэсэн байна.

Мөн нийслэлийн 2018 оны төсвийн 10.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны “Бичил дэд төв”-ийн ус, дулаан хангамж, нам даралтын халаалтын зуух, авто зам, гадна тохижилт, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж, 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ашиглалтад оруулсан.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 140 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 88,1 хувийн биелэлтэй байна.

2. Төсөл, арга хэмжээ нэг бүрт тусгайлан өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг харъяалах газар, төслийн нэгжийн удирдлагад үүрэг болгов.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“150 МЯНГАН АЙЛ-ОРОН СУУЦ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2020.03.26

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, ЗГХЭГ болон холбогдох дээд байгууллагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 202 дугаар тогтоолоор баталсан.

Хөтөлбөрийн зорилго: Төв, суурин газарт амьдардаг нийт өрхийн дийлэнх олонхын худалдан авах чадварт нийцсэн, монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд, салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд, аймаг, нийслэлийн Засаг дарга

Санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын хэмжээ:

- улс, орон нутгийн төсөв;
- гадаадын зээл, тусламж;
- гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас;
- концесс;
- бусад эх үүсвэр.

Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ: 12,137,556.4 сая төгрөг

Хэрэгжих хугацаа: I үе шат: 2019-2020 он;

II үе шат: 2021-2023 он.

Хөтөлбөрийн зорилтууд:

Барилга, хот байгуулалтын яам өөрийн хамаарах арга хэмжээг дараах зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнд:

Зорилт 1. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

Зорилт 2. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай инженерийн дэд бүтцэд холбогдсон тохилог гэр, амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

Зорилт 3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих;

Зорилт 4. Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах.

ГУРАВ. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, хөтөлбөр 2019 оны 05 дугаар сард батлагдсан тул хэрэгжилтийн түвшин 15 хувьтай, 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшин: /2019 оны жилийн эцсийн байдлаар/

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин /2023 он/	Хүрсэн түвшин /2019 он/	Хэрэгжилт, хувиар
Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд шинээр баригдах орон сууц	айлын тоо	5,189	50,189	9229	18,4
Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд инженерийн хангамжид холбогдох амины орон сууц	айлын тоо	-	10,000	948	9,5
Хэрэгжилтийн дундаж үнэлгээ /хувь/					15,0

Хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилтийг зорилт, арга хэмжээ тус бүрээр харуулбал:

	Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ	Арга хэмжээ	Биелэлт					Үнэлгээ
			100	70	40	0	ҮБ	
	Зорилт 1. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;							
1	1.1. иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн	1	-	-	1	-	-	40

	санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх;							
2	1.2. орон сууцны даатгалын тогтолцоог боловсронгуй болгох;	1	-	1	-	-	-	70
3	1.3. орон сууцны ашиглалт, үйлчилгээ хариуцсан байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг оновчтой тогтоох, нийтийн зориулалттай орон сууцны барилгын засвар, үйлчилгээний зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;	1	1	-	-	-	-	100
4	1.4. гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлүүлэх;	1	1	-	-	-	-	100
5	1.5. орон сууцны хөнгөлөлттэй зээлийн урьдчилгаа төлбөрийг тэтгэврийн даатгалын нэрийн дансны хуримтлалаас бүрдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх.	1	-	-	-	1	-	0
	Зорилт-1-ийн дундаж үнэлгээ	5	2	1	1	1	-	70
	Зорилт 2. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай инженерийн дэд бүтцэд холбогдсон тохилог гэр, амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх;							
6	2.1. төв, суурин газрын гэр хорооллын газрыг иргэдийн шууд оролцоотойгоор дахин төлөвлөж, газрыг зүй зохистой ашиглах хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	1	1	-	-	-	-	100
7	2.2. инженерийн хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх төслийг үе шаттай хэрэгжүүлж, орон сууцны хотхон хороолол, түүний нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг барих нөхцөлийг бүрдүүлэх;	1	1	-	-	-	-	100
8	2.3. ухаалаг, бие даасан, дэвшилтэт технологи бүхий дэд бүтцийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаад, дотоодын зээл, тусламж, концессын гэрээгээр барьж байгуулахыг дэмжих, байгалийн нөөцийн хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, нутагшуулах;	1	-	1	-	-	-	70
9	2.4. гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэхэд барилга угсралтын болон барилгын материал үйлдвэрлэгч үндэсний компаниудыг татан оролцуулах;	1	1	-	-	-	-	100
10	2.5. иргэдийг гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, төлөвлөхтэй холбогдсон мэдээ мэдээллээр хангах, сургалт, уулзалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх зэргээр иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх, иргэдийн бүлэг байгуулахад дэмжлэг үзүүлэх;	1	1	-	-	-	-	100

11	2.6. шинээр төлөвлөх орон сууцны хорооллын унд ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, бохир усыг дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх;	1	-	1	-	-	-	70
12	2.7. усны менежментийг боловсронгуй болгох, унднаас бусад хэрэгцээнд гадаргын болон хуримтлуулсан ус, цэвэршүүлсэн процессын усыг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх.	1	-	1	-	-	-	70
Зорилт-2-ын дундаж үнэлгээ		7	4	3	-	-	-	90
Зорилт 3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих;								
13	3.1. хот, суурин газрын хэт төвлөрлийг сааруулах, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх хүрээнд дагуул, хаяа хот, дүүрэг, тосгодыг жигд тэнцвэртэйгээр хөгжүүлж иргэдийн орон сууцны хангамж, хүртээмжийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх;	1	1	-	-	-	-	100
14	3.2. орон сууцны барилгын эрчим хүч (цахилгаан болон дулаан)-ний хэрэглээний түвшинг тодорхойлж, гэрчилгээ олгох, дулааны эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг тарифын бодлогоор дэмжих, тоолууржуулах замаар хэрэглээндээ тохирсон төлбөр төлдөг тогтолцоонд шилжих;	1	-	1	-	-	-	70
15	3.3. орон сууцны барилгыг байгалийн нөөцийн хэмнэлттэй байдлаар төлөвлөх, угсармал хийц, эдлэлээр барьж байгуулахтай холбогдсон норм, дүрэм, стандартыг боловсронгуй болгох, мөрдүүлэх, энэ чиглэлээр инженер, техникийн ажилчдыг сургах, мэргэшүүлэх;	1	-	1	-	-	-	70
16	3.4. ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн дэд бүтцийг бий болгох, инженерийн хангамжид эрчим хүч, ус хангамжийн хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж, хэрэгслийг нэвтрүүлэх ажлыг бүх талаар дэмжих;	1	1	-	-	-	-	100
17	3.5. орон нутгийн засаг захиргаа, сууц өмчлөгчдийн оролцоотойгоор дулааны алдагдал ихтэй, угсармал орон сууцны барилгуудыг дулаалах, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж, шинээр барих төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;	1	1	-	-	-	-	100
18	3.6. эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцны нийлүүлэлтийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох;	1	-	-	-	1	-	0
16	3.7. ахуйн хог, хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох;	1	-	-	-	1	-	0

17	3.8. орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай, хүртээмжтэй ил, далд авто зогсоол, оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх тохилог орчинг бүрдүүлэх шаардлагыг тусган хэрэгжүүлэх;	1	-	1	-	-	-	70
19	3.9. хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөх, барих төслийг үе шаттай хэрэгжүүлэх.	1	-	1	-	-	-	70
Зорилт-3-ын дундаж үнэлгээ		9	3	4	-	2	-	70
Зорилт-4. Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах								
20	4.1. орон сууцны зориулалттай гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн 30-аас доошгүй хувийг зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулахад зориулах;	1	1	-	-	-	-	100
21	4.2. хүн амын амьжиргааны түвшингээс доогуур орлоготой, 0-18 насны 4-өөс дээш хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эцэг (эх), хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настануудыг тэргүүн ээлжинд халамжийн болон түрээсийн орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлэх;	1	-	1	-	-	-	70
22	4.3. төрийн албан хаагч орон сууц худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх хүрээнд боломжит арга хэмжээг судалж, хэрэгжүүлэх.	1	-	1	-	-	-	70
Зорилт-4-ийн дундаж үнэлгээ		3	1	2	-	-	-	80
Нийт үнэлгээ		24	9	10	2	3	-	80

Хөтөлбөрийн хүрээнд дараах томоохон ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

Зорилт-1-ийн хүрээнд:

1. Барилга, хот байгуулалтын яамнаас Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль болон Орон сууцны тухай хуулийг нэгтгэн Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьсан.

2. Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгөөр 2019 онд техникийн зохицуулалтын баримт бичиг 3, барилгын норм ба дүрэм 25, барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал 52, стандарт 22-ыг тус тус шинээр болон шинэчлэн боловсруулсан байна.

3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон дагалдаж гарсан журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар үнэт цаасжуулах зардалтай холбоотой зохицуулалтуудыг тодорхой болгох зорилгоор Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн

зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдсан. Үүний дагуу Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуультай холбоотой хууль, журмууд болон ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргагч МИК актив тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайланд судалгаа хийгдсэн.

4. Амьдран суух зориулалтаар анх удаа зөвхөн хувьдаа орон сууцны барилга барьсан эсхүл орон сууц худалдан авсан Монгол Улсын иргэнд зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ.” гэсэн заалтын хүрээнд 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.4-т заасны дагуу 6 сая төгрөгийн хөнгөлөлт эдлэх бөгөөд энэхүү хөнгөлөлтийг тус хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т заасны дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эдэлнэ.

Зорилт-2-ын хүрээнд:

1. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 2019 онд нийслэлд 2002 айлын орон сууц ашиглалтад орсон байна.

2. Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд нийслэлд 289, Өвөрхангай аймагт 55, Төв аймагт 87 өрх инженерийн бүрэн хангамжид, 517 өрх төвлөрсөн халаалтын системд тус тус холбогдож, нийт 948 өрх орон сууцны нөхцлөө сайжруулсан байна.

3. “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ын хүрээнд 2019 онд нийт 1820 иргэнд орон сууцны хөнгөлөлттэй зээлийг олгосон.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд нийт 8 байршилд ф350- ф1000 голчтой 11,65 хос км шугамыг шинээр татах болон өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийхээр төлөвлөж, гүйцэтгэсэн байна.

5. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэх 26 байршил, 77 хэсэгчилсэн талбайд 1,539.16 га газарт, 16,317 нэгж талбарыг хамруулан баталсан. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөх барилгажуулах ажлын хүрээнд 2014-2018 онд нийт 7227 айлын орон сууц ашиглалтад орсон. 2019 онд 2002 айлын орон сууц ашиглалтад орсон бөгөөд төслийн хүрээнд нийт 9229 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан байна.

6. Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг 50 байршилд хэрэгжүүлж, 13500 өрхийг инженерийн бүрэн хангамжид холбох хүрээнд Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны 220 нэгж талбарт “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлж 220 нэгж талбайн 285 өрхийг инженерийн бүрэн хангамжид холбосон.

7. ХБНГУ-ын GIZ-ийн бүс нутгийн “Азийн хотуудын нөөцийн цогц менежмент: Хотын Нэксус” төсөл, “Эрэл” ХХК, “Ариг” банк, Цайз газрын эздийн Эко хотхон хоршооны төлөөллүүд Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороонд “Цайз газрын эзэмшигчдийн эко хотхон” байгуулах 5 талт хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, “Цайз эко” хотхоны газар ашиглалтын план зураг, барилгын эхний загваруудыг хийж гүйцэтгэсэн. Төслийн хүрээнд баригдах 712 айлын амины орон сууцны загвар 20 айлын амины орон сууцны эрчим хүчний хэмнэлттэй эко зураг төслийг боловсруулж, эхний 4 айлын амины орон сууцыг гэрээ байгуулсан иргэдэд хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.

8. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд гадна инженерийн шугам сүлжээний ажилд 2019 онд нийслэлийн төсвөөс 15,0 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Зорилт-3-ын хүрээнд:

1. Агаар орчны бохирдлыг бууруулах ногоон зээлийг БОАЖЯ-аас арилжааны 3 банктэй хамтран зах зээлд гаргах ажлыг зохион байгуулсан. Зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 3,7 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн бөгөөд гэрийн дулааны алдагдлыг багасгах, цахилгаан халаагуур худалдан авах, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулахад олгосон байна.

2. Улаанбаатар хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лаг, хаягдлыг байгальд ээлтэй, халгүй аргаар шатааж, эрчим хүч үйлдвэрлэх туршилтын төслийг 2019 онд эхлүүлж, гэр хорооллын 2000 айл өрхийн ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй байдлаар шийдсэн.

3. Агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотын хэмжээнд машины хаягдал дугуйг цуглуулан, байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй аргаар дахин боловсруулж, резинэн хавтан үйлдвэрлэж, Нийслэлийн 18 сургууль, цэцэрлэгийн гадна талбайг /6050м2/ тохижуулах ажлыг хийж байна.

4. Орон сууцны барилгын эрчим хүчний /цахилгаан болон дулааны/ хэрэглээний түвшинг тодорхойлж гэрчилгээ олгох дулааны эрчим хүчний хэмнэлтгэй хэрэглээг тарифын бодлогоор дэмжих, тоолууржуулах замаар хэрэглээгээрээ төлдөг тогтолцоонд шилжих, орон сууцны барилгын эрчим хүчний хэрэглээний ангилал зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журмыг Эрчим хүчний яамнаас боловсруулж, холбогдох газруудаас санал авч байна.

5. Нийслэлийн шинэ суурьшлын бүсийг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах 5 байршилд дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар орон сууцны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд: Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо, “Буянт-Ухаа” орон сууцны хороолол орчимд байрлах 2.23 га газар, Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийн 129.0 га газар, Сонгино-Хайрхан дүүргийн 32 дугаар хороо, Авто худалдааны төв орчмын шинэ суурьшлын бүсийн 11.0 га газарт газар, Баянзүрх дүүргийн 20, 23 дугаар хороо, Улиастайн амны шинэ суурьшлын бүсийн 107.6 га газар.

6. Угсармал орон сууц дулаалах батлагдсан зураг төсөв, эрчим хүчний аудит, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ зэрэг суурь судалгааг хийж, улсын төсөвт гадна дулаалга, гадна фасад хийлгэх, засварлах ажилд 12,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг суулгасан. Үүнээс газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийгдсэн угсармал орон сууцны гадна дулаалга, гадна фасад хийлгэх 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 24 барилгад дулаан техникийн шинэчлэлийг хэрэгжүүлсэн.

7. 2019 онд БГД, 2-р хорооны Баруун уулын 0.6 км, ХУД, 8-р хороо Сонсголлонгийн 0.25 км, СХД, 21-р хороо Нарангийн 0.45 км буюу нийт 3 байршилд 1,015 км үерийн хамгаалалтын байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. Нийт 8 байршилд 2.1 км урт авто замын гадаргуун ус зайлуулах шугам сүлжээг шинээр хийж, 57 шүүрт худаг, 58 үзлэгийн худгийг ашиглалтад оруулсан.

Зорилт-4-ийн хүрээнд:

1.Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд орон нутгийн өмчийн 1542 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг хамруулсан.

2.Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Булган, Говьсүмбэр, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгуудад 240 айлын, нийслэл Улаанбаатар хотод ахмадын 300, түр суурьшуулах 318, гэр хорооллын дахин төлөвлөлтийн түр суурьшуулах 154 айлын, нийт 772 айлын орон сууцыг худалдан авч түрээсийн зориулалтаар ашиглаж байна. Эдгээр түрээсийн орон сууцнуудын 30 хувь буюу 776 орон сууцыг төрийн албан хаагчдад, 5 хувь буюу 128 орон сууцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд түрээслүүлсэн байна.

3. Хувийн хэвшил орон нутагт 3868 өрхийг, Улаанбаатар хотод 30803 өрхийг түрээсийн орон сууцаар хангаж байна.

4. Сангийн яам “Төрийн албан хаагчид орон сууцны дэмжлэг олгох журам”-ын төслийг боловсруулж, салбарын яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.

Хэрэгжилт хангалтгүй 0 хувьтай дараах 3 арга хэмжээ байна. Үүнд:

1.Хөтөлбөрийн /1.5/ “орон сууцны хөнгөлөлттэй зээлийн урьдчилгаа төлбөрийг тэтгэврийн даатгалын нэрийн дансны хуримтлалаас бүрдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх”;

2. Хөтөлбөрийн /3.6/ “эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцны нийлүүлэлтийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох”;

3. Хөтөлбөрийн /3.7/ “ахуйн хог, хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох”.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1.Хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.

2. Улсын хэмжээнд 2019 онд 13,999 айлын орон сууц ашиглалтад орсон 12027 нь нийслэлд, 1972 нь орон нутагт байна.

Манай улсад 2018 оны байдлаар 894,496 өрх амьдарч байсны 590,371 өрх нь төв суурин газарт, үүний 38,1 хувь нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдарч байсан бол 2019 оны байдлаар 897,850 өрх амьдарч байгаагийн 606,765 өрх нь төв, суурин газарт, үүний 39,4 хувь нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдарч байна. Энэ нь өмнөх оны суурь түвшингээс 1,3 хувиар нэмэгдсэн байна.

3. Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд орон нутгийн өмчийн 1542 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг хамруулсан.

Мөн Улаанбаатар хотод 2019 онд гэр хорооллын 357 өрх төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоод байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Нийслэлийн зүгээс 3 талт гэрээг баталгаажуулж иргэдийн газар чөлөөлөх ажил эхэлдэг тул дээрх гэрээг баталгаажуулах хугацаанаас газар чөлөөлөх ажлын явц хамаардаг. Нийслэл, дүүргийн газрын алба, үл хөдлөх хөрөнгийн хэлтсийн хоорондын ажлын уялдаа холбооноос шалтгаалж, 3 талт гэрээ байгуулсан иргэд газраа хуваах, худалдан борлуулах, шинээр гэрчилгээ гаргуулах тохиолдлууд их байгаа нь газар чөлөөлөх ажилд шууд нөлөөлж, төслийн хэрэгжилтийг удаашруулж байна.

Иймд Нийслэл, дүүргийн газрын алба, үл хөдлөх хөрөнгийн хэлтэс зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож буй байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулахад анхаарч ажиллах;

2. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу аливаа нэгж талбарын газар болон үл хөдлөх хөрөнгийг үнэлүүлж, үнэлгээнд тохирсон нөхөх олговрыг олгох 3 талт гэрээг газар өмчлөгч эсвэл эзэмшигчтэй байгуулдаг. 1 нэгж талбарт 2 ба түүнээс дээш айл өрх оршин суудаг тохиолдол их байдаг тул нөхөх олговор нь айл өрх болгоны орон сууцны асуудлыг шийдэхэд хүрэлцээгүй байдаг нь газар чөлөөлөх ажилд хүндрэл учруулж байна. Иймд хөрөнгө санхүүжилттэй холбоотойгоор гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах ажлын хэрэгжилт хангагдахгүй байгаа тул энэ асуудалд анхаарч, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Гүнболд/, Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/ нарт даалгах;

3. Иргэдийг орон сууцжуулах, гэр хорооллыг дахин зохион байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд инженерийн хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэх зэрэг ажлуудад шаардагдах санхүүжилтийг улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламжид хамруулах ажлыг санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон санхүүгийн бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэхийг тус яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/ нарт даалгах;

4. Хэрэгжилт хангалтгүй 0 хувьтай дээр дурдсан 3 арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/-д үүрэг болгох.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

10.6 Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт /журмын 5 дугаар хавсралт/, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл				
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН төсөл” Төслийн зорилго: Төсөлд хамрагдсан хотуудын хөгжлийг үр ашигтай, зөв төлөвлөх, чанартай, найдвартай, өргөн хүрээг хамарсан нийтийн аж ахуйн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэхэд оршино. Төслийн онцлог: Төсөлд хамрагдаж буй сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, нэн тэргүүнд шаардагдах дэд бүтцийн барилга байгууламжийг барих, түүний ашиглалт үйлчилгээг хариуцах оператор компанийг байгуулж чадавхжуулах зэрэг ажлуудыг хамарсан цогц шийдэл гаргах юм. Шийдвэр: 2011 онд Монгол Улс, АХБ-ны хооронд буцалтгүй тусламжийн гэрээ, 2016 оны 04 дүгээр сард зээлийн хэлэлцээр тус тус байгуулсан.</p>				
2	Санхүүжилтийн эх үүсвэр	АХБ-ны буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл				
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ				
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Өмнөговь, Дорноговь аймгийн ЗДТГ				
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1.Төслийн сумдын хөгжлийг үр ашигтай, зөв төлөвлөх Зорилт 2.Төслийн сумдын дэд бүтцийг хөгжүүлэх Зорилт 3.Төслийн сумдад нийтийн аж ахуйн үйлчилгээний тогтвортой байгууллагыг бий болгоход дэмжлэг үзүүлэх</p>				
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	21,9 сая ам.доллар			
		Үүнд:	Гэрээний нэр	Төсөв (нийт) /төг/	Гүйцэтгэл /төг/	Хувь
		Багц 0	Төслийн удирдах болон хэрэгжүүлэх нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх	1,161,128.68	1,103,072.24	95%
		Багц А1	Төслийн удирдах болон хэрэгжүүлэх нэгжүүдэд үзүүлэх олон улсын зөвлөх үйлчилгээ	31,615.73	31,615.73	100%
		Багц А2	Төслийн удирдах болон хэрэгжүүлэх нэгжүүдэд үзүүлэх дотоодын зөвлөх үйлчилгээ	21,485.24	20,625.83	96%
		Багц А3	Байгууллага, хүний нөөцийн хөгжил ба чадавхи бэхжүүлэх, ерөнхий төлөвлөгөө боловсруулах болон хил дамнасан хамтын ажиллагааг сайжруулах	1,621,384.98	1,621,384.98	100%
		Багц А4	Үйл ажиллагааны менежментийн гэрээ байгуулах болон үйлчилгээний зохицуулагчийг бий болгоход дэмжлэг үзүүлэх	492,510.77	492,510.77	100%
		Багц В4	Зураг төсөв, тендерийн баримт бичиг боловсруулах, барилгын ажилд хяналт хийх (Дорноговь аймаг)	559,098.80	559,098.80	100%
		Багц В5	Зураг төсөв, тендерийн баримт бичиг боловсруулах, барилгын ажилд хяналт хийх (Өмнөговь аймаг)	947,708.00	947,708.00	100%

	Багц В3	Өмнөговь аймгийн Даланзадгад сумын усан сан, гүний худаг, цэвэр усны шугам, бохир ус зайлуулах шугамын барилгын ажил	815,286.82	815,286.82	100%
	Багц В1.1	Сайншанд сумын цэвэр, бохир ус, дулааны системийг сайжруулах	2,641,324.29	2,640,898.21	100%
	Багц В1.2	Сайншанд сумын 8,4 МВт дулааны зуухны ханган нийлүүлэлт, угсралт	970,582.97	967,758.43	100%
	Багц В1.3	Сайншанд сумын замын ажил	798,847.76	798,847.76	100%
	Багц В1.4	Замын Үүд сумын цэвэр, бохир усны системийг сайжруулах	1,672,709.42	1,672,485.96	100%
	Багц В1.5	Замын Үүд сумын дулааны системийг сайжруулах	1,491,235.08	1,491,235.06	100%
	Багц В1.6	Замын Үүд суманд хатуу хог хаягдал пресслэгч нийлүүлэх, суурилуулах	68,000.00	68,000.00	100%
	Багц В1.7	Замын Үүд сумын 3-р сургууль, 1 ба 3 дугаар цэцэрлэгийг дулааны нэгдсэн шугамд холбох, хогийн цэгийн хашаа барих, хүнхээл ухах ажил	190,000.00	181,331.95	100%
	Багц В1.8	Сайншанд сумын хатуу хог хаягдал тээвэрлэх машин механизм нийлүүлэх	69,300.00	69,300.00	100%
	Багц В1.9	Замын-Үүд сумын хатуу хог хаягдал тээвэрлэх машин механизм, хогийн контейнер нийлүүлэх	97,295.00	97,295.00	100%
	Багц В2.1	Гурвантэс сумын цэвэр, бохир усны систем	2,049,721.52	2,046,379.10	100%
	Багц В2.2	Ханбогд сумын цэвэр, бохир ус, дулааны систем	2,700,291.48	2,700,291.48	100%
	Багц В2.3	Цогтцэций сумын цэвэр, бохир усны систем	1,128,479.76	1,128,331.76	100%
	Багц В2.4	Гурвантэс, Цогтцэций сумдын замын ажил	1,495,584.05	1,495,584.05	100%
	Багц С1	Төслийн сумдад хог хаягдлын машин, механизм нийлүүлэх	698,759.00	698,759.00	100%
	Багц	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	56,345.65	56,345.65	100%
	Багц	Газар чөлөөлөлт	100,000.00	-	0%
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.			
	1-р зорилтын хүрээнд:	А3 зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Гэрээний хугацаа 2015 оны 9-р сарын 15-нд дуусгавар болсон. Сайншанд, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын 2025 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон "Шинэ Сайншанд" орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, улсын экспертизээр батлуулан, 2015 оны 8-р сарын 24-нд Барилгын хөгжлийн төвийн архив, сумдад хүлээлгэн өгсөн.			
	Хүрэх үр дүн 1:	Сумдын институцийн хөгжлийн стратеги тайланг сум тус бүрээр боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хилийн боомт тус бүр дээр хөрш улстай хамтарсан комисс байгуулах үүрэг бүхий улсын хэмжээний боомтын удирдлага байгуулах тухай шинэ Боомтын тухай хуулинд тусгуулах санал боловсруулсан бөгөөд хууль 2014 оны 4-р сараас хэрэгжиж эхэлсэн.			
	2-р зорилтын хүрээнд:	Дууссан барилгын ажлууд:			
	Хүрэх үр дүн 1:	2013.05-2013.10 - Даланзадгад хотод 1,000 м3 усан сан, 1,4 км цахилгаан дамжуулах шугам, гүний худаг, 1,4 км ус дамжуулах шугам, гэр хороололд 4,7 км			

7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Дүгнэлт: Төсөл 3 зорилтын хүрээнд 100 хувь буюу “үр дүнтэй” хэрэгжсэн гэж дүгнэж байна.</p> <p>Ололт: Төсөлд хамрагдаж буй сумдын 2025 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, түүнд үндэслэн сумдад нэн даруй шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэн, тэрхүү дэд бүтцийг цаашид ашиглах байгууллагыг бий болгож, төслийг цогцоор нь хэрэгжүүлсэн. Мөн төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдлага, зохион байгуулалт, менежмент сайн байснаас гадна захиалагч, гүйцэтгэгч, орон нутгийн хамтын ажиллагаа маш сайн байсан тул төсөл амжилттай хэрэгжсэн гэж дүгнэж байна. Төслийн үр шимийг 6 сумын 74.300 хүн хүртэж байгаа бөгөөд 2025 оны түвшинд 125.000 хүн хүртэх инженерийн дэд бүтэц бий болсон. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг төсөл хэрэгжсэн 6 сумын 1000 өрхийг хамруулан хийхэд нийт оршин суугчид төслийн үр дүнг “хангалттай сайн” гэж үнэлсэн. Төслийн үр дүнд цэвэр усны гүний худаг 3ш, цэвэр усны шугам 38,1 км, бохир усны шугам 31,9 км, дулааны шугам 10,6 км, ус түгээх байр 11ш, бохир усны насос станц 4ш, цэвэрлэх байгууламж 2ш, цахилгаан дамжуулах шугам 10,7 км, дулаан дамжуулах төв 3ш, 8,4 МВт-ын дулааны зуух, автозам 6 км, үерийн хамгаалалтын далан 1,8 км тус тус барьж ашиглалтад оруулсан. Мөн 4ш нягтруулагчтай хогны машин, 3ш бохир ус зөөврийн машин, 3ш дугуйт ачигч, усалгааны машин 1ш, хогны машин 2 болон хаягдал нягтруулан шахах тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулсан.</p>				
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Төслийн Өмнөговь, Дорноговь аймгуудын "Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг"-үүд болон орон нутаг, гүйцэтгэгч, захиалагч талууд байнга хамтран ажилласан. АХБ-ны хяналтын ажлын хэсэг төслийн хэрэгжилтийг маш сайн гэж дүгнэсэн. Үүнд: Төслийн гэрээ байгуулалт, зарцуулалт дэвшүүлсэн зорилгоо тогтмол хангаж байсан тул АХБ-ны төслийн гүйцэтгэлийн хяналтын системд 2014 оны 1-р сараас хойш тасралтгүй 7 улирлын турш “сайн” үнэлгээтэй ажилласан. 2015 оны 6-р сарын 1-4-ний өдрүүдэд АХБ-ны Захирлуудын зөвлөлийн гишүүд төслийн Замын-Үүд, Сайншанд, Ханбогд, Цогтцэций сумдаар айлчилж, төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцсан. Төсөл нь гүйцэтгэл болон нэмэлт санхүүжилтийн бусад шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа нь АХБ, МУЗГ-ын зүгээс Сайншанд, Даланзадгад болон нэмэлт 2 аймгийн төвийн бохир усны цэвэрлэгээ, менежментийг сайжруулах төслийн сунгалт хийхээр харилцан тохиролцох үндэслэл болсон.</p>				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		100%	3	100%	100%	100%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ				
	(ЗГХЭГ-ын үнэлгээ)	... %				

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“ӨМНӨГОВЬ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХИЛИЙН ОЙРОЛЦОО СУУРИН ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН G0204-МОН
ТӨСӨЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

2019.12.21

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН төсөл”-ийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн зорилго: Төсөлд хамрагдсан хотуудын хөгжлийг үр ашигтай зөв төлөвлөх, чанартай, найдвартай өргөн хүрээг хамарсан нийтийн аж ахуйн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэхэд оршино.

Төслийн онцлог: Төсөлд хамрагдаж буй сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, нэн тэргүүнд шаардагдах дэд бүтцийн барилга байгууламжийг барих, түүний ашиглалт үйлчилгээг хариуцах оператор компанийг байгуулж чадавхжуулах зэрэг ажлуудыг хамарсан цогц шийдэл гаргах юм.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Өмнөговь, Дорноговь аймгийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2010-2019

		2-р үе шат
Төслийн нэр	Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл нэмэлт санхүүжилт
Төслийн дугаар:	G0204-МОН	МОН-3388
Соёрхон баталсан өдөр:		2016 оны 5-р сарын 20
Хүчин төгөлдөр болсон өдөр:	2010 оны 7-р сарын 30	2016 оны 7-р сарын 05
Хүлээн авагч:	Монгол Улсын Засгийн Газар	Монгол Улсын Засгийн Газар
Хэрэгжүүлэгч агентлагууд:	БХБЯ, Өмнөговь, Дорноговь аймгийн ЗДТГ	БХБЯ, Өмнөговь, Дорноговь, Архангай, Өвөрхангай аймгийн ЗДТГ
Төслийн нийт өртөг:	21.9 сая ам.доллар	21.17 сая ам.доллар
Монгол Улсын Засгийн Газар	6.9 сая ам.доллар	1.74 сая ам.доллар
Азийн хөгжлийн банк	15.0 сая ам.доллар /буцалтгүй тусламж/	19.43 сая ам.доллар /хөнгөлөлттэй зээл/
Төсөл хэрэгжиж дуусах хугацаа	2019 оны 11-р сарын 30	2019 оны 12-р сарын 31

Төслийн зорилтүүд:

Зорилт 1. Төслийн сумдын хөгжлийг үр ашигтай, зөв төлөвлөх;

Зорилт 2. Төслийн сумдын дэд бүтцийг хөгжүүлэх;

Зорилт 3. Төслийн сумдад нийтийн аж ахуйн үйлчилгээний тогтвортой байгууллагыг бий болгоход дэмжлэг үзүүлэх.

ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төслийн сумдын хөгжлийг үр ашигтай, зөв төлөвлөх, төслийн сумдын дэд бүтцийг хөгжүүлэх, төслийн сумдад нийтийн аж ахуйн үйлчилгээний тогтвортой байгууллагыг бий болгоход дэмжлэг үзүүлэх гэсэн 3 зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төсөл дээрхи 3 зорилтын хүрээнд 100 хувь буюу “үр дүнтэй” хэрэгжсэн гэж дүгнэж байна. Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
	100%	3	100%	100%	100%

Төслийн хүрээнд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэн, ашиглалтад оруулсан. Үүнд:

1. Сайншанд, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын 2025 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон “Шинэ Сайншанд” орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, улсын экспертизээр батлуулан, орон нутагт хүлээлгэн өгсөн.

2. Сайншанд хотод 6,45 км цэвэр усны шугам, 5,06 км бохир усны шугам, 2,7 км дулааны шугам, 8,4 МВт хүчин чадалтай дулааны зуух, дагалдах насос, тоног төхөөрөмж, зуухны барилга, харуулын байр, цахилгаан дамжуулах дэд станц, дизель цахилгаан үүсгүүр, хамгаалалтын хашаа, 2 км хатуу хучилттай авто зам барьж, ашиглалтанд оруулж, хатуу хог хаягдлын машин ханган нийлүүлсэн.

3. Даланзадгад хотод 1,000 м3 усан сан, 1,4 км цахилгаан дамжуулах шугам, гүний худаг, 1,4 км ус дамжуулах шугам, гэр хороололд 4,7 км бохир усны шугам барьж, ашиглалтад оруулсан.

4. Замын-Үүд суманд 13,4 км цэвэр усны шугам, 7,87 км бохир усны шугам, 3 ш ус түгээх байр, 2 ш бохир усны насосны станц, 3 км дулааны шугам, 3 ш дулаан дамжуулах төв, 3 ш дизель цахилгаан үүсгүүр барьж, ашиглалтанд оруулж, хог пресслэгч ханган нийлүүлж, хатуу хаягдлыг булж зайлуулах цэгийн ажил болон цэцэрлэг, сургуулийг нэгдсэн дулааны шугамд холбох ажил хийгдсэн.

5. Гурвантэс суманд 100 м3 багтаамжтай усан сан, 2 ш гүний худаг, 3,2 км цахилгаан дамжуулах шугам, 5,7 км цэвэр усны шугам, 4,1 км бохир усны шугам, бохир ус цэвэрлэх байгууламж, 3 ш ус түгээх байр, 2 км хатуу хучилттай авто зам, 1,8 км үерийн далан барьж, ашиглалтанд оруулсан.

6. Цогтцэций суманд 2 ш 100 м3 багтаамжтай усан сан, 0,6 км цахилгаан дамжуулах шугам, 3 ш ус түгээх байр, бохир усны насосны станц, 6,6 км цэвэр усны шугам, 5,8 км бохир усны шугам барьж, ашиглалтанд оруулсан.

7. Ханбогд суманд 5.5 км цэвэр усны шугам, 8.4 км бохир усны шугам, 5.4 км цахилгаан дамжуулах шугам, 2 км дулааны шугам, 2 ш ус түгээх байр, бохир ус цэвэрлэх байгууламж барьж, ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

8. Төслийн хэрэгжилтийн талаар 2011 оны суурь судалгаанд 996 өрх, 2015 оны явцын судалгаанд 1001 өрх, төслийн төгсгөлийн үр дүн, нийгэм, жендерийн судалгаанд 1000 өрхийг тус тус хамруулж, судалгаа авч нэгтгэхэд оршин суугчид төслийн үр дүнг “хангалттай сайн” гэж үнэлсэн.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Төсөл 3 зорилтын хүрээнд 100 хувь буюу “үр дүнтэй” хэрэгжсэн гэж дүгнэж байна.

2. Төслийн Өмнөговь, Дорноговь аймгуудын "Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг"-үүд болон орон нутаг, гүйцэтгэгч, захиалагч талууд байнга хамтран ажилласан. АХБ-ны хяналтын ажлын хэсэг төслийн хэрэгжилтийг маш сайн гэж дүгнэсэн байна. Төслийн гэрээ байгуулалт, зарцуулалт дэвшүүлсэн зорилгоо тогтмол хангаж байсан тул АХБ-ны төслийн гүйцэтгэлийн хяналтын системд 2014 оны 1-р сараас хойш тасралтгүй 7 улирлын турш “сайн” үнэлгээтэй ажилласан. 2015 оны 6-р сарын 1-4-ний өдрүүдэд АХБ-ны Захирлуудын зөвлөлийн гишүүд төслийн Замын -Үүд, Сайншанд, Ханбогд, Цогтцэций сумдаар айлчилж, төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцсан. Төсөл нь гүйцэтгэл болон нэмэлт санхүүжилтийн бусад шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа нь АХБ, МУЗГ-ын зүгээс Сайншанд, Даланзадгад болон нэмэлт 2 аймгийн төвийн бохир усны цэвэрлэгээ, менежментийг сайжруулах төслийн сунгалт хийхээр харилцан тохиролцох үндэслэл болсон байна.

3.Төсөлд хамрагдаж буй сумдын 2025 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, түүнд үндэслэн сумдад нэн даруй шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэн, тэрхүү дэд бүтцийг цаашид ашиглах байгууллагыг бий болгож, төслийг цогцоор нь хэрэгжүүлсэн.

4. Төслийн үр шимийг 6 сумын 74.300 хүн хүртэж байгаа бөгөөд 2025 он гэхэд 125.000 хүн хүртэх инженерийн дэд бүтэц бий болсон байна.

5. Төслийн үр дүнд цэвэр усны гүний худаг 3ш, цэвэр усны шугам 38,1 км, бохир усны шугам 31,9 км, дулааны шугам 10,6 км, ус түгээх байр 11ш, бохир усны насос станц 4ш, цэвэрлэх байгууламж 2ш, цахилгаан дамжуулах шугам 10,7 км, дулаан дамжуулах төв 3ш, 8,4 МВт-ын дулааны зуух, автозам 6 км, үерийн хамгаалалтын далан 1,8 км тус тус барьж ашиглалтад оруулсан. Мөн 4ш нягтруулагчтай хогны машин, 3ш бохир ус зөөврийн машин, 3ш дугуйт ачигч, усалгааны машин 1ш, хогны машин 2 болон хаягдал нягтруулан шахах тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулсан.

6. Төсөл хэрэгжсэнээр гэр хорооллын айл өрхүүдийн цэвэр усны шугаманд холбогдсон ус түгээх байрнаас ус авдаг өрхийн тоо 2011 онд 21,6 хувь байсан бол 2019 онд 66,1 хувь болж 45 хувиар өссөн байна.

Төслийн хэрэгжилттэй холбоотой нийт 50 боть материалыг архивт хүлээлгэн өгсөн байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл				
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, шийдвэрийн огноо, дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	"Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл МОН-3388" Төслийн зорилго нь бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэлэг технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасч, орон нутгийн оршин суугчдын эрүүл ахуй, орчны стандартыг дээшлүүлэх юм. Төвлөрсөн цэвэрлэх байгууламжаас болон гэр хорооллоос гарсан лагийг дахин боловсруулж ашиглах тухай "Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа (ТТ9100)-г зээлийн төсөлтэй хамт баталсан. ТТ9100 төслийн зорилго нь төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжууд болон цэвэрлэх байгууламжаас гарах лагийг бүрэн боловсруулж, гадаргуун ба гүний ус, хөрсний бохирдлыг бууруулах замаар хот суурин, хүрээлэн буй орчны нөхцөл сайжирч, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хөрсний бутцийг сайжруулахад болон шахмал түлш хийх туршилт хийхэд оршино. Шийдвэр: 2016 оны 04 дүгээр сард АХБ, МЗГ-тай төсөл хэрэгжүүлэх зээлийн гэрээг байгуулсан.				
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж: МОН-3388 төслийн нийт өртөг 21.17 сая ам доллар, үүнээс АХБ-ны хөнгөлөлттэй зээл 19.43 сая ам доллар, МУЗГ 1.74 сая ам доллар. ТТ9100 буцалтгүй тусламж 1.0 сая ам доллар				
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Архангай, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь аймгийн ЗДТГ				
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Төслийн удирдлага, зөвлөх үйлчилгээ Зорилт 2. Барилгын ажил, тоног төхөөрөмж				
5	Зардал	Төсөв (нийт шаардагд ах зардал)	21.17 сая ам.доллар			
		Үүнд:	Гэрээний нэр	Төсөв (нийт)	Гүйцэтгэл	Хувь
		Багц В1	Төслийн удирдлага, хэрэгжилтэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ	1,009,484.99	585,405.94	58%
		Багц В2	Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ	370,247.20	324,239.15	88%
		Багц В3	Сайншанд хотын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, 4,4 км бохирын шугамын зураг төслийг "Хайдродизайн" ХХК боловсруулаад, магадлалаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн.	95,377.16	95,377.16	100%
		Багц В4	Төслийн удирдлага	650,000.00	615,531.85	95%
		Багц В5	Төслийн гэрээт ажилтан: Байгаль орчны зөвлөх, Цахилгааны зөвлөх	70,000.00	-	0%
		Багц А1.1	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Архангай аймгийн Эрдэнэбулган сум)	3,394,528.47	2,786,615.06	82%
		Багц А1.2	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Дорноговь аймгийн Сайншанд сум)	3,720,000.00	42,505.21	1%

	Багц А1.3	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Өмнөговь аймгийн Даланзадгад сум)	3,565,532.25	2,277,872.21	64%
	Багц А1.4	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Өвөрхангай аймгийн Арвайхээр сум)	11,865.68	11,865.68	100%
	Багц А1.6	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Өвөрхангай аймгийн Арвайхээр сум)	4,081,272.75	3,720,264.66	91%
	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.			
6	1-р зорилтын хүрээнд:	<p>1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: В1 багц Төслийн удирдлага, хэрэгжилтэд дэмжлэг тусалцаа үзүүлэх зөвлөх компаниар шалгарсан БНХАУ-ын "EASEN International" Co., Ltd/туслан гүйцэтгэгч Монгол Улсын "Монхидроконстракшн" ХХК-тай гэрээг 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан. Зөвлөх компани төслийн 4 аймгийн (Өвөрхангай, Өмнөговь, Архангай, Дорноговь) төвд баригдах бохир усны цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, ажлын тоо хэмжээг хянаж, техникийн тодорхойлолт бэлтгэн, тендерийн баримт бичгийг боловсруулсан. Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Дорноговь аймгуудын төвд баригдаж буй цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажилд тогтмол хяналт тавьж ажилласан. Нийт зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэл 80%. Хүрэх үр дүн нь: Архангай, Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь аймгуудын төвд био өнгөр тогтоогч бүхий идэвхит лагийн системтэй бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын үе шатанд, туршилт тохируулгад хяналт тавьснаар цэвэрлэх байгууламж баригдаж, үйл ажиллагаа жигдэрнэ. В2 багц Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад тусалцаа үзүүлэх зөвлөх компани Монгол Улсын "Эм Ти Юү" ХХК-"Интернэйшнл пауэр" ХХК-ийн түншлэлтэй гэрээг 2017 оны 9 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан. Байгууллагын бүтцийн шинэчлэлийн зохимжит хувилбарыг боловсруулж, батлуулах, хэрэглэгч төвтэй үйлчилгээг дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, ажиллах хүчний ажлын үр чадвар, ажлын үр дүнг сайжруулах арга замуудыг тодорхойлох, ус хангамжийн шугам сүлжээний гидравлик загварчлал боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлтийг боловсруулах ажлуудыг хийсэн. НААҮБ-уудын 3 жилийн бизнес төлөвлөгөө боловсруулах, шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйл ажиллагаатай холбогдуулан менежментийн зохицуулалт хийх ажлуудыг тус тус хийсэн. НААҮБ-уудын үр ашгийг дээшлүүлж, зардлыг бууруулах, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн бүтцийн шинэчлэл, чадавхийг бэхжүүлэх талаар арга зүйн зөвлөмжөөр хангах, харилцан санал солилцох зорилготой сургалтуудыг зохион байгуулсан. Мөн НААҮБ-уудад ажлын байрны дэргэдэх сургалт зохион байгуулсан. Нийт зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэл 98%. Хүрэх үр дүн нь: Төслийн аймгуудын НААҮБ-ын санхүү, хүний нөөц, байгууллагын үйл ажиллагааны чадавхи сайжирч, шинэ цэвэрлэх байгууламжийг технологийн дагуу ашиглана. В3 багц Дорноговь аймгийн Сайншанд хотын 4.4 км бохирын шугам, цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төслийг боловсруулан, магадлалаар баталгаажуулсан. Нийт зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэл 100%.</p>			
	Хүрэх үр дүн 1:				

	2-р зорилтын хүрээнд:	<p>2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: A1.3 Өмнөговь аймгийн Даланзадгад хотын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын хүрээнд Барилга угсралтын ажилд цахилгааны эх үүсвэр шаардлагатай байсан учраас цахилгаан дамжуулах агаарын 10 Кв-ын шугамын угсралтын ажил, 10/0,4кВ-ын 2*400кВа хүчин чадалтай цахилгааны хаалттай дэд өртөөний угсралтын ажлыг бүрэн дуусган, холбогдох ил далд ажлын акт, бичиг баримтуудыг бэлтгэн, техникийн комисс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж хүлээлгэн өгсөн. Биологи цэвэрлэгээний блокийн барилгын доторлогооны ажил, технологийн шугам сүлжээний ажил бүрэн дууссан. 5.1 км бохир усны шугамын угсралтын ажил, лаг боловсруулах цех, лагийн талбайн ажлууд дууссан. Үйлдвэрийн, механик цэвэрлэгээний блокийн барилгын ажил 50 хувьтай хийгдэж, 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс хүйтний улиралд түр зогссон. 2020 оны 4 дүгээр сараас барилга угсралтын ажил ажлын хуваарийн дагуу үргэлжлэн хийгдэнэ. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 75 хувь.</p>
	Хүрэх үр дүн 1:	<p>A1.4 Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын цэвэрлэх байгууламжийн бүх барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Арвайхээрт ажиллаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн. Тохируулга, зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. 2020 оны 8 дугаар сарын 1 хүртэл хийгдэнэ. Нийт барилгын ажлын гүйцэтгэл 100%.</p>
	Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.	<p>A1.1 Архангай аймгийн Цэцэрлэг хотод баригдах цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажилд аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/536 тоот захирамжаар байгуулагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ажиллаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн. Цэвэрлэх байгууламжийн технологийн туршилт, тохируулга, зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. 2020 оны 10 дугаар сарын 1 хүртэл хийгдэнэ. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувь.</p> <p>A1.2 Дорноговь аймгийн Сайншанд хотын цэвэрлэх байгууламжийн ажлын барилга эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг орон нутгийн ГХБХБ-ын газраас №БАЗ-БУ-02/2019 тоотой авсан. Барилга угсралтын ажлын графикийн дагуу гүйцэтгэгч 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс ажлаа эхэлсэн. Биологи цэвэрлэгээний блокийн барилгын тэнцвэржүүлэх сангийн хэв хашмалын ажил, 2-р тунгаагуурын ханын арматурчлал, сараалжийн, дэд өртөөний барилгуудын гадна фасадын ажил, үйлдвэрийн барилгын гадна өрлөгийн ажил, лаг боловсруулах цех, уурын зуухны барилгуудын өрлөг, хучилтын цутгалтын ажлууд хийгдсэн. Гадна цэвэр, бохир усны шугамын ажил, Ар, Өвөршандын 4.4 км бохир усны коллекторын шугамын угсралтын ажлууд дуусах шатандаа байна. Үйлдвэрийн барилгын 1-р давхрын ханын өрлөг, шалны цутгалтын ажил дууссан. Нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40 хувьтай. Хүйтний улиралд түр зогссон. Хүрэх үр дүн нь: Архангай, Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь аймгуудын төвд био өнгөр тогтоогч бүхий идэвхит лагийн системтэй бохир ус цэвэрлэх байгууламжтай болж, цэвэрлэх байгууламжаас гарах бохир ус стандартад нийцэж, лагийг хөрсний бүтцийг сайжруулахад, шахмал түлш хийж ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасч, орон нутгийн оршин суугчдын эрүүл ахуй, орчны стандартыг дээшлүүлнэ.</p>
7	Дүгнэлт (ололт, дутагдал, асуудлууд) анхаарах	<p>Дүгнэлт: Төслийн хэрэгжилтийн түвшин /өссөн дүнгээр/ 74 хувь, 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт 91%-тай, “үр дүнтэй” гэж дүгнэж байна. Ололт: Төсөлд хамрагдаж буй аймгуудын хот байгуулалт, дэд бүтэц, нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна. Анхаарах асуудлууд:</p> <ul style="list-style-type: none"> - Өмнөговь аймгийн Даланзадгад хотын цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах; - Төслийн бүрэлдхүүнд багтаж байгаа “Лагийн менежментэд үзүүлэх техникийн тусалцаа ТТ9100” дэд төслийн хүрээнд гэр хорооллын сайжруулсан нүхэн жорлонгийн хувилбарууд, өтгөн лагийг цуглуулах, зайлуулах тогтвортой үйлчилгээг хэрэгжүүлэх болон лагийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хөрс сайжруулах чиглэлээр ашиглах туршилтын төсөл боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах.

8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийг амжилттай, хугацаанд нь хэрэгжүүлэхэд АХБ, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, төслийн аймгийн Засаг дарга нар, ЗДТГ, ГХГЗЗГ, НААҮБ-ууд, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчид, Төслийн зөвлөх компаниуд, төсөл хэрэгжүүлэх нэгж нягт хамтран ажиллаж байна.			
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
		91%	2	93%	88%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ			
	(ЗГХЭГ-ын үнэлгээ)	... %			

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“ЗҮҮН ӨМНӨД ГОВИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН ОЙРОЛЦОО СУУРИН
ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН МОН-3388 ТӨСӨЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

2019.12.21

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

АХБ-ны хөнгөлөлттэй зээл, Монгол Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, Билл Гейтсийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл МОН-3388”-ийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР.ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Төслийн зорилго: Бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэ технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасч, орон нутгийн оршин суугчдын эрүү ахуй, орчны стандартыг дээшлүүлэх юм.

Төслийн хүрээнд Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймгийн төвүүдэд био өнгөр тогтоогч бүхий идэвхжүүлэгч лагийн технологи ашигласан орчин үеийн үр ашигтай цэвэрлэх байгууламж барихаас гадна дээрх аймгуудын нийтийн аж ахуйн байгууллагуудын бүтцийн шинэчлэл, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа хийгдэнэ.

Төвлөрсөн цэвэрлэх байгууламжаас болон гэр хорооллоос гарсан лагийг дахин боловсруулж ашиглах тухай “Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа /ТТ9100/”-г зээлийн төсөлтэй хамт баталж, хэрэгжүүлнэ.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Архангай, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь аймгийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2016-2020

Төслийн үе шат:

	1-р үе шат	2-р үе шат
Төслийн нэр	Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл нэмэлт санхүүжилт
Төслийн дугаар:	G0204-МОН	МОН-3388
Соёрхон баталсан өдөр:		2016 оны 5-р сарын 20
Хүчин төгөлдөр болсон өдөр:		2016 оны 7-р сарын 05
Хүлээн авагч:	Монгол Улсын Засгийн Газар	Монгол Улсын Засгийн Газар
Хэрэгжүүлэгч агентлагууд:	БХБЯ, Өмнөговь, Дорноговь аймгийн ЗДТГ	БХБЯ, Өмнөговь, Дорноговь, Архангай, Өвөрхангай аймгийн ЗДТГ
Төслийн нийт өртөг:	21.9 сая ам.доллар	21.17 сая ам.доллар

Монгол Улсын Засгийн Газар	6.9 сая ам.доллар	1.74 сая ам.доллар
Азийн хөгжлийн банк	15.0 сая ам.доллар /буцалтгүй тусламж/	19.43 сая ам.доллар /хөнгөлөлттэй зээл/
Төсөл хэрэгжиж дуусах хугацаа	2017 оны 5-р сарын 31	2019 оны 12-р сарын 31

Төслийн зорилтууд:

Зорилт 1. Төслийн удирдлага, хэрэгжилтэд дэмжлэг, тусалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ;

Зорилт 2. Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралт.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төсөл нь Төслийн удирдлага, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралтын ажлуудыг дуусгах, Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжууд болон цэвэрлэх байгууламжаас гарах лагийг боловсруулж, хөрсний бүтцийг сайжруулахад ашиглах шахмал түлш хийх гэсэн 3 зорилтын хүрээнд нийт 9 багц ажлыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төслийн хэрэгжилтийн түвшин /өссөн дүнгээр/ 74 хувь, 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт 91%-тай, “үр дүнтэй” гэж дүгнэж байна. Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ /хувь/	Хэрэгжилт /хувь/		Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
	Төслийн хэрэгжилт	74%	2	63	85
2019 оны төл-ний биелэлт	91%	2	93%	88%	

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

- Архангай аймгийн Цэцэрлэг хотод баригдах цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажилд аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/536 тоот захирамжаар байгуулагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ажиллаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн.

- Дорноговь аймгийн Сайншанд хотын цэвэрлэх байгууламжийн ажлыг 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлж, 2-р тунгаагуурын ханын арматурчлал, сараалжийн, дэд өртөөний барилгуудын гадна фасадын ажил, үйлдвэрийн барилгын гадна өрлөгийн ажил, лаг боловсруулах цех, уурын зуухны барилгуудын өрлөг, хучилтын цутгалтын ажлууд хийгдсэн. Нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувьтай.

- Өвөрхангай аймгийн Хужирт сумын 310 м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсвийг 2019 оны 04 дүгээр сард магадлалаар хянуулан батлуулж, тендерийг 2019 оны 11-р сард зарлан, дүгнэж байна.

- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төвийн ус, дулаан дамжуулах төв-10-ын дулаан хангамжийн 2-р хэлхээний 380 м бетон сувгийг цутгаж, дулааны өгөх, буцах, хэрэгцээний халуун усны, хүйтэн усны нийт 5 шугамын угсралтын ажлыг гүйцэтгэсэн. Цэвэрл усны эх үүсвэрийн 2-р худгаас дулааны төв станц хүртэлх 2,5 км цэвэр усны шугам угсарч дуусган, 2019 оны 12 дугаар сарын 05-нд комисс ажиллаж, ашиглалтад оруулсан.

- Өвөрхангай аймгийн Баянгол сумын бохир усны шугам сүлжээ, насос станцын нэмэлт ажлын хүрээнд үерийн усны бетон далангийн 200м сувгийн ажил бүрэн дууссан. Ажлын гүйцэтгэл 98 хувьтай.

- Нийтийн аж ахуйн байгууллагуудын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх баг Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймгуудад 2019 оны 09-10 дугаар сард ажиллаж, дээрхи аймгуудын НААБ-уудын Төлөөлөн удирдах зөвлөлд Стратеги төлөвлөгөөг танилцуулан, хүлээлгэн өгсөн.

- Төслийн бүрэлдхүүнд багтаж байгаа “Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа ТТ9100” дэд төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 200 айлд сайжруулсан нүхэн жорлон хамтарч барихаас 47 айлын нүхэн жорлонг барьж, ашиглалтад оруулаад байна.

Дараах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

-Өмнөговь аймгийн Даланзадгад хотын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил,

-Төслийн бүрэлдхүүнд багтаж байгаа “Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа ТТ9100” дэд төслийн хүрээнд гэр хорооллын сайжруулсан нүхэн жорлонгийн хувилбарууд, өтгөн лагийг цуглуулах, зайлуулах болон шахмал түлш хийх туршилтын ажил.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төслийн хэрэгжилтийн түвшин /өссөн дүнгээр/ 74 хувь, 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт 91%-тай, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл МОН-3388”-ийн хэрэгжүүлэх нэгж /Б.Оюун/-д үүрэг болгох нь:

- Өмнөговь аймгийн Даланзадгад хотын цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах,

- Төслийн бүрэлдхүүнд багтаж байгаа “Лагийн менежментэд үзүүлэх техникийн туслалцаа ТТ9100” дэд төслийн хүрээнд гэр хорооллын сайжруулсан нүхэн жорлонгийн хувилбарууд, өтгөн лагийг цуглуулах, зайлуулах тогтвортой үйлчилгээг хэрэгжүүлэх болон лагийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хөрс сайжруулах чиглэлээр ашиглах туршилтын төсөл боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах,

2. Төслийг хугацаанд нь чанартай хэрэгжүүлж дуусгахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллахыг тус яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/, Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/ нарт даалгах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл				
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	"Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл МОН-3713" Төсөл, хөтөлбөрийн зорилго: Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 нэмэлт санхүүжилтийн төслийн зорилго нь бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэ технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багасч, орон нутгийн оршин суугчдын эрүүл ахуй, орчны стандарт дээшилнэ. Шийдвэр: 2016 оны 04 дүгээр сард АХБ, МЗГ-тай төсөл хэрэгжүүлэх зээлийн гэрээг байгуулсан.				
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж: МОН-3713 төслийн нийт өртөг 21.75 сая ам.доллар, үүнээс АХБ-ны хөнгөлөлттэй зээл 20 сая ам.доллар, МУЗГ 1.75 сая ам.долларын татварын хөнгөлөлт.				
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Булган, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн ЗДТГ				
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ Зорилт 2. Барилгын ажил, тоног төхөөрөмж				
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	21.17 сая ам.доллар			
		Үүнд:	Гэрээний нэр	Төсөв (нийт)	Гүйцэтгэл	Хувь
		Багц В1	Техникийн дэмжлэг үзүүлэх зөвлөхүүд	100,000.00		
		Багц В2	Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ	450,000.00		
		Багц В3	Орон нутагт барилгын ажлын хяналт хийх зөвлөхүүд	132,000.00		
		Багц В4	ТУН-ийн үйл ажиллагааны зардал	951,748.42		
		Багц В5	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Булган аймгийн Булган хот)	3,203,304.63	1,429,416.88	45%
		Багц А1.1	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Дундговь аймгийн Мандалговь хот)	2,675,333.33		
		Багц А1.2	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Хэнтий аймгийн Чингис хот)	3,203,304.63	825,322.40	26%
		Багц А1.3	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Хөвсгөл аймгийн Мөрөн хот)	3,376,408.07	1,942,882.08	58%
		Багц А1.4	Цэвэрлэх байгууламж болон холбогдох үйлчилгээ (Сүхбаатар аймгийн Баруун Урт хот)	3,692,416.67		
		Багц А1.6	Төслийн сумдад хатуу хог хаягдал, бохир тээвэрлэх машин механизм нийлүүлэх	550,000.00		

	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.
	1-р зорилтын хүрээнд:	1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: В1 багц Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх компани сонгон шалгаруулах ажлын даалгаварыг боловсруулж, Үнэлгээний хороонд танилцуулах ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 80%.
	Хүрэх үр дүн 1:	Хүрэх үр дүн нь: Төслийн аймгуудын НААҮБ-ын санхүү, хүний нөөц, байгууллагын үйл ажиллагааны чадавхи сайжирч, шинэ цэвэрлэх байгууламжийг технологийн дагуу ашиглана.
	2-р зорилтын хүрээнд:	2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: A1.1 Булган аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн тендер шалгаруулалт, гэрээ байгуулалт, барилга угсралтын ажил. Төслийн зээлийн хэлэлцээр 2019 оны 2 дугаар сарын 18-нд хүчин төгөлдөр болсныг үндэслэн АХБ-аас 2019 оны 2 дугаар сарын 19-нд АХБ-аас тендер зарлах зөвшөөрөл ирсэн. Тендерийг 2019 оны 2 дугаар сарын 22-нд өдөр тутмын сонинд зарлан, дүгнэж, “Заг инженеринг” ХХК, “Престиж Инженеринг” ХХК, “Жиангсу Зэюү Энв. Протекшн” түншлэлтэй 2019 оны 5 дугаар сарын 7-нд гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажлыг 2019 оны 5 дугаар сарын 30-нд эхлүүлсэн. Биологи цэвэрлэгээний барилгын төмөр бетон цутгалтын ажил, талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил бүрэн дууссан. Үйлдвэрийн, механик цэвэрлэгээний барилгын 0,00 түвшингийн суурийн төмөр бетон цутгалтын ажил, бохир усны, дренажийн бохир усны барилгын 0,00 түвшингийн төмөр бетон цутгалтын ажил, лаг боловсруулах цехийн барилгын суурийн цутгалт, ханын арматурчлалын ажил хийгдэж, хүйтний улиралд хийгдэх ажлуудын технологийн карт боловсруулан гаргаж, барилга угсралтын график гарган ажиллаж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна.
	Хүрэх үр дүн 1:	A1.4 Хөвсгөл аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн тендер шалгаруулалт, гэрээ байгуулалт, барилга угсралтын ажил. Тендерийг 2020 оны 04 дүгээр сард зарлан, дүгнэж, “Набсан” ХХК, “Эс энд Эй Трэйд” ХХК-ний түншлэлтэй 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдөр гэрээ байгуулсан. Гэрээт ажлын хугацаа 2021 оны 6 дугаар сарын 30. Гүйцэтгэгч барилга угсралтын ажлаа 2019 оны 6 дугаар сарын 20-ноос эхлүүлсэн. Биологи цэвэрлэгээний блокийн барилгын ханын арматурчлал, механик цэвэрлэгээний блокийн суурийн цутгалтын ажил, үйлдвэрийн барилгын баганын арматурчлалын ажил хийгдсэн. Захиргааны, дэд өртөөний, харуулын байрны барилгуудын хучилтын цутгалтын ажил дууссан. Цэвэрлэгдсэн усны насос станцын гадна өрлөгийн ажил, бохир усны, дренажийн барилгын цутгалт, өрлөгийн угсралтын ажлууд хийгдсэн. Талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил, цэвэр ус, дулааны шугамын угсралтын ажил бүрэн дууссан. Лаг, элсний талбайн бетоны ажил дууссан. Хүйтний улирлын түр зогсолт хийсэн. Барилга угсралтын нийт ажил 55 хувьтай байна. A1.4 Хэнтий аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн тендер шалгаруулалтын ажил Цэвэрлэх байгууламжийн зураг төсөл 2019 оны 5 дугаар сард батлагдсан. Тендерийг 2019 оны 6 дугаар сарын 21-нд зарлан, дүгнэж, “Комфорт импекс” ХХК-тай 2019 оны 8 дугаар сарын 22-нд гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил 2019 оны 8 дугаар сарын 30-наас эхэлсэн. ЦДАШ-ын угсралтын ажил бүрэн дууссан, түр цахилгаан хангамжийн зөвшөөрөл авсан. Захиргааны, дэд өртөөний барилга, харуулын барилгуудын өрлөг, хучилтын ажлууд хийгдэж дууссан. Хүйтний улирлын түр зогсолт хийсэн. Барилга угсралтын нийт ажил 10 хувьтай байна. A1.5 Сүхбаатар аймгийн цэвэрлэх байгууламжийн тендер шалгаруулалтын ажил. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг 2019 оны 10 дугаар сарын 24-нд өдөр зарлан, дүгнэж, 2019.12.31-нд “Хүрд” компанитай гэрээ байгуулсан. A1.2 Дундговь аймгийн цэвэрлэх байгууламжийн тендерийн шалгаруулалтын ажил. Тендерийг 2019 оны 10 дугаар сарын 18-нд тендер зарлан, дүгнэж, 2019.12.27-нд “Сан констракшн” ХХК, “Сан” ХХК-ийн түншлэлтэй гэрээ байгуулсан.
6	Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.	

7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Дүгнэлт: Төслийн 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт 90%-тай, “үр дүнтэй” гэж дүгнэж байна.</p> <p>Ололт: Төсөлд хамрагдаж буй аймгуудын хот байгуулалт, дэд бүтэц, нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.</p> <p>Анхаарах асуудлууд: Сүхбаатар болон Дундговь аймгуудын төвд баригдах цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авах.</p>			
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийг амжилттай, хугацаанд нь хэрэгжүүлэхэд АХБ, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, төслийн Булган, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг дарга нар, ЗДТГ, ГХГЗЗГ, НААУБ-ууд, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчид, ТУН нягт хамтран ажиллаж байна.			
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
		90%	2	90%	90%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ			
		... %			

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“ЗҮҮН ӨМНӨД ГОВИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН ОЙРОЛЦОО СУУРИН
ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН МОН-3713 ТӨСӨЛ”-ИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

2019.12.21

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

АХБ-ны хөнгөлөлттэй зээл, Монгол Улсын Засгийн газрын хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3713 төсөл”-ийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн зорилго: Төслийн хүрээнд Булган, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн төвүүдэд био өнгөр тогтоогч бүхий идэвхжүүлэгч лагийн технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасч, орон нутгийн оршин суугчдын эрүүл ахуй, орчны стандартыг дээшлүүлэхэд оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Булган, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгуудын ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2019-2022

Төслийн зорилтууд:

Зорилт 1. Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ ;

Зорилт 2. Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралт.

ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төсөл нь Төслийн удирдлага, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Цэвэрлэх байгууламжийн барилга, угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралт гэсэн 2 зорилтын хүрээнд нийт 6 багц ажлыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төслийн 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт 90%-тай, “үр дүнтэй” гэж дүгнэж байна. Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ /хувь/	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
	90%	2	90%	90%

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

1-р зорилтын хүрээнд: В1 багц. Төслийн аймгуудын НААҮБ-ын хөгжил, чадавхийг сайжруулахад туслалцаа үзүүлэх зөвлөх компани сонгон шалгаруулах ажлын даалгаварыг боловсруулж, Үнэлгээний хороонд танилцуулсан. Ажлын гүйцэтгэл 80%.

2-р зорилтын хүрээнд: Булган аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын гүйцэтгэгч “Заг инженеринг” ХХК, “Престиж Инженеринг” ХХК, “Жиангсу Зэюү Энв. Протекшн” түншлэлтэй 2019 оны 5 дугаар сард гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн. Биологи цэвэрлэгээний барилгын төмөр бетон цутгалтын ажил, талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил бүрэн дууссан. Үйлдвэрийн, механик цэвэрлэгээний барилгын 0,00 түвшингийн суурийн төмөр бетон цутгалтын ажил, бохир усны, дренажийн бохир усны барилгын 0,00 түвшингийн төмөр бетон цутгалтын ажил, лаг боловсруулах цехийн барилгын суурийн цутгалт, ханын арматурчлалын ажил хийгдсэн. Барилга угсралтын ажил 50 хувьтай байна.

Хөвсгөл аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг “Набсан” ХХК, “Эс энд Эй Трэд” ХХК-ний түншлэл 2019 оны 6 дугаар сараас эхлүүлж, биологи цэвэрлэгээний блокийн барилгын ханын арматурчлал, механик цэвэрлэгээний блокийн суурийн цутгалтын ажил, үйлдвэрийн барилгын баганын арматурчлалын ажил хийгдсэн. Захиргааны, дэд өртөөний, харуулын байрны барилгуудын хучилтын цутгалтын ажил дууссан. Цэвэрлэгдсэн усны насос станцын гадна өрлөгийн ажил, бохир усны, дренажийн барилгын цутгалт, өрлөгийн угсралтын ажлуудыг гүйцэтгэсэн. Талбай доторх шугам сүлжээний угсралтын ажил, цэвэр ус, дулааны шугамын угсралтын ажил бүрэн дууссан. Лаг, элсний талбайн бетоны ажил дууссан. Барилга угсралтын ажил 55 хувьтай байна.

Хэнтий аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг “Комфорт импекс” ХХК 2019 оны 8 дугаар сараас эхлүүлж, ЦДАШ-ын угсралтын ажил, Захиргааны, дэд өртөөний барилга, харуулын барилгуудын өрлөг, хучилтын ажлууд хийгдэж дууссан. Барилга угсралтын нийт ажил 10 хувьтай байна.

Булган, Хөвсгөл аймагт ажиллах төслийн хяналтын инженерүүдийг сонгон шалгаруулж, ажилд нь оруулсан.

Хэрэгжилт хангалтгүй нэг арга хэмжээ байна.

Сүхбаатар болон Дундговь аймгийн төвд баригдах цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төслийн 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт 90%-тай, “үр дүнтэй” гэж дүгнэж байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Сүхбаатар болон Дундговь аймгуудын төвд баригдах цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авахыг ТХН /Б.Оюун/-д үүрэг болгох.

2. Төслийн хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллахыг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Хөрөнгө

оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/, Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/ нарт даалгах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Төслийн агуулга	Гүйцэтгэл				
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>Төслийн зорилго: Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, VII, XIV хорооллыг барилгажуулах эхлэлийг тавих, VII, МҮОНРТ орчмын хорооллыг инженерийн дэд бүтцэд холбох, VII, МҮОНРТ-ийн хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах.</p> <p>Шийдвэрийн огноо, дугаар:</p> <p>1. УИХ-ын 2008.12.4-ний өдрийн 41-р тогтоол; “Зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай”</p> <p>2. Монгол Улсын Засгийн газрын 2009.9.16-ны өдрийн 289-р тогтоол; “Зээлийн хөрөнгийн хуваарилалтын тухай”</p> <p>3. ЗТБХБ-ын сайдын 2009.12.18-ны өдрийн 343-р тушаал; “Төсөл хэрэгжүүлэх тухай”</p> <p>4. ЗТБХБ-ын сайдын 2011.7.20-ны өдрийн 201-р тушаал; “Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах тухай”</p>				
2	Санхүүжилтийн эх үүсвэр	<p>1. Монгол Улсын төсвөөс 17,5 сая ам.доллар.</p> <p>2. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр БНХАУ-ын ЭКСИМ банкнаас 100 сая ам.доллар, нийт 117,5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.</p>				
3	Хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам Хэрэгжих нийт хугацаа: 2011.10. 20-2018. 11. 01.	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам</p>				
4	Төслийн зорилтууд	<p>Зорилт 1. Улаанбаатар хотын VII, XIV хороололд нийт 2592 айлын орон сууц барих</p> <p>Зорилт 2. Орон сууцны VII хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх</p> <p>Зорилт 3. МҮОНРТ-ын орчмын хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх</p> <p>Зорилт 4. Улаанбаатар хотын VII хороолол, МҮОНРТ-ийн орчмын хорооллыг цахилгааны эх үүсвэрээр хангах 23,3 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам болон “Улаанбаатар” дэд станцын өргөтгөл, “7-р хороолол”, “Радио телевиз” дэд станцын угсралтын ажлыг гүйцэтгэх</p>				
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Төслийн нийт шаардагдах хөрөнгө: 117,5 сая ам.доллар			
		Үүнд:		Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1:	Улаанбаатар хотын VII, XIV хороололд нийт 2592 айлын орон сууц барих гэрээний дүн	70,5 сая ам.доллар	67.5 сая ам.доллар	95
		Багц 2:	Улаанбаатар хотын VII, МҮОНРТ орчмын хорооллын гадна инженерийн шугам сүлжээ барих гэрээний дүн	47,0 сая ам.доллар	47.0 сая ам.доллар	100
		Багц 3:	Инженерийн шугам сүлжээний зураг төслийн үнэ	1,037,8 сая ам.доллар	1,037,8 сая ам.доллар	100
	Багц 4:	Техник хяналт, магадлашгүй ажил	1.608.5 сая ам.доллар	722.8 мян. ам.доллар	60	
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт	Ажлуудын биелэлт				

<p>1-р зорилтын хүрээнд: Улаанбаатар хотын VII, XIV хороололд нийт 2592 айлын орон сууц барих</p>	<p>1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: Ажлын гүйцэтгэл 100%. Ашиглалтад оруулсан орон сууцнууд: 1. Улаанбаатар хотын VII хороололд 1800 айлын орон сууц барих ажлын гүйцэтгэл: (72 айлын 25 барилга) 100% 7-А блок: Тус блокт 2x72, 4x144 буюу нийт 720 айлын орон сууц, 7-В блок: Тус блокт 2x72, 4x144 буюу нийт 720 айлын орон сууц, 7В блокын 144x1 буюу 513 байр, 144x1 буюу 516, 518 байр, 7-С блок: Тус блокт 1x72, 2x144 буюу нийт 360 айлын орон сууц. 2. XIV хороололд 792 айлын орон сууц барих ажлын гүйцэтгэл: (72 айлын 11 барилга) 100% 14-А блок: Тус блокт 3x144 буюу нийт 432 айлын орон сууц, 14-В блок: Тус блокт 2x144 буюу нийт 288 айлын орон сууц, 14-С блок: Тус блокт 1x72 айлын орон сууц.</p>
<p>2-р зорилтын хүрээнд: VII хорооллын инженерийн шугам сүлжээний угсралтын ажил. Хүрэх үр дүн: Орон сууцны VII хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэснээр тус хорооллыг барилгажуулах үндсэн нөхцөл бүрдэнэ.</p>	<p>2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: 100%. 1. Цахилгааны хуваарилах байгууламж (РП) 4 ком, 2x630кВА-ийн хаалттай дэд өртөө (14ком), 10кВ-ын цахилгаан хангамжийн 40,42 км кабель шугам, гүүрэн байгууламжийн хамт бүрэн гүйцэтгэж, 2017 оны 09-р сард комисс ажиллуулж хүлээлгэн өгсөн. 2. VII хороололд 6 ширхэг Ус, дулаан дамжуулах төв /ЦТП/ барихаар төлөвлөсний дагуу 3 ширхэг ус, дулаан дамжуулах төвийг улсын комисс ажиллуулан хэрэглэгчдийг ус дулаанаар хангаад байна. Үлдсэн 3 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажил бүрэн хийгдэж техникийн комисс ажиллуулсан. 3. 4 ба 6-ын холбоос 325 метр магистраль шугамын угсралтын ажлыг 2012 онд бүрэн гүйцэтгэж, комисст хүлээлгэн өгсөн. 4. VII хорооллын дулаан хангамжийн гадна шугам сүлжээ /ф159-ф500 мм диаметр, 2268 метр (хос шугам)/-ний угсралтын ажлыг бүрэн гүйцэтгэж, эхний ээлжийн 1530 м шугам сүлжээг 2015 оны 9 сард комисст хүлээлгэн өгсөн. Үлдсэн 768,4 м дулаан хангамжийн шугам сүлжээнд техникийн комисс ажиллуулж байнгын ажиллагаанд залгасан. . 5. VII хорооллын цэвэр ус хангамжийн шугам сүлжээ /ф300 мм диаметр, 3948 метр/-ний угсралтын ажлыг 2015 онд бүрэн гүйцэтгэж, 2016 оны 1 сард комисст хүлээлгэн өгсөн. 6. Бохир усны 21-р коллекторын ф600 мм диаметр бүхий нийт 1600 метр шугам сүлжээний угсралтын ажлаас 2013 онд 60 метр, 2014 онд 1345 метр, 2015 онд 195 метр тус тус гүйцэтгэж, 2015 оны 9 дүгээр сард комисст хүлээлгэн өгч ашиглалтанд оруулсан. 7. Бохир усны шугам-1 сүлжээ /Ф200-Ф400мм диаметр, 2300 метр/-ний угсралтын ажлаас нийт 1912 метр шугамын угсралтын ажлыг гүйцэтгэж 2016 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр комисст бүрэн хүлээлгэн өгсөн. 388 метр шугам сүлжээ газар чөлөөлөлтөөс шалтгаалан хийгдэхгүй болсон. 8. 5500 метр холбооны кабель шугам, худаг сувагчлалын ажил гүйцэтгэхээс 5217 метр шугамыг угсарсан. Нийт 58 худаг хийгдэхээс 72 худаг хийгдсэн ба 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр комисс ажиллуулан “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-нд хүлээлгэн өгсөн.</p>
<p>3-р зорилтын хүрээнд: МҮОНРТ-ийн хорооллын инженерийн шугам сүлжээний угсралтын ажил</p>	<p>3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан: Ажлын гүйцэтгэл 100% БГД-ийн 11-р хороонд, ЧД-ийн 7,8-р хороонд цахилгааны хуваарилах байгууламж 3 ком, 2*630кВА-ын чадалтай 10/0,4кВ-ын дэд өртөө 1 ком, 2*1000кВА-ын хүчин чадалтай дэд өртөө 2 ком, 25 км тэжээлийн кабель шугам мөн УДДТ-1 ком, дулааны шугам 1760 метр, цэвэр усны шугам 4200 метр, бохир усны шугам 1700 метр, 2*1000м3 усан сан, өргөлтийн насос станц тус тус барьж гүйцэтгэсэн.</p>

<p>4-р зорилтын хүрээнд: Улаанбаатар хотын VII хороолол, МҮОНРТ-ийн орчмын хорооллыг цахилгааны эх үүсвэрээр хангах 23,3 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам болон "Улаанбаатар" дэд станцын өргөтгөл, "7-р хороолол", "Радио телевиз" дэд станцын угсралтын ажлыг гүйцэтгэх.</p>	<p>4-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан: Ажлын гүйцэтгэл 100%. 1. 110/35/10кВ-ын "7-р хороолол" дэд станцын барилга угсралтын ажил, дэд станцын тоног төхөөрөмжийг угсарч дууссан ба туршилт тохируулга бүрэн хийгдсэн. 2. 110/35/10кВ-ын "Радио телевиз" дэд станцын барилга, тоног төхөөрөмж угсралтын ажил бүрэн гүйцэтгэж дууссан. 3. "220/110/35кВ-ын "Улаанбаатар" дэд станцыг өргөтгөж шугамын порталууд болон хуурай салгуурууд, тусгаарлагчууд, газардуулгын байгууламжийг бүрэн гүйцэтгэсэн. 4. "Улаанбаатар" дэд станцаас 110/35/10кВ-ын "7-р хороолол" дэд станц хүртэлх 14,9 км 110кВ-ын ЦДАШ-ын угсралтын ажил бүрэн дууссан. 5. 110/35/10кВ-ын "7-р хороолол" дэд станцаас 110/35/10кВ-ын "Радио Телевиз" дэд станц хүртэлх 8,4 км, 2 хэлхээт 110кВ-ын ЦДАШ-ын угсралтын ажил 2015 оны 9 дүгээр сард бүрэн дууссан. Дээрх ажлуудыг 2016 оны 11 дүгээр сард комисс ажиллуулан "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-нд хүлээлгэн өгсөн.</p>					
<p>7 Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Дүгнэлт: Төслийн хэрэгжилтийн түвшин 95 хувьтай, "бүрэн хэрэгжсэн" гэж дүгнэж байна. Ололт: Гэр хорооллыг барилгажуулах, дэд бүтцээр хангах, утааг багасгах, хөрсний бохирдлыг бууруулах, тухайн хороололд оршин суугчдын амьдрах тав тухтай орчинг бүрдүүлсэн. VII, XIV хороололд 2592 айлын орон сууц барьснаар хүн амыг орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан. Анхаарах асуудлууд: 1.Төслийн хүрээнд бий болсон барилга байгууламж, шугам сүлжээг төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийвэрлүүлэх, 2. Төслийн гүйцэтгэгч Бэрэн, Цагаанхуаран ХХК-ийн зээл, зээлийн хүүг төлөх асуудлыг хууль, хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх</p>					
<p>8 Төсөл, хөтөлбөрийг талуудын хамтын өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>	<p>хэрэгжүүлэгч ажиллагаанд</p>		<p>Төсөл хэрэгжүүлэхэд оролцсон талууд захиалагч, гүйцэтгэгч, зургийн автор, орон нутгийн захиргаа гэх мэт байгууллагууд нягт хамтран ажилласан.</p>			
<p>9 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)</p>	<p>Биелэлт дундаж</p>	<p>Зорилтын тоо</p>	<p>Зорилт 1</p>	<p>Зорилт 2</p>	<p>Зорилт 3</p>	<p>Зорилт 4</p>
<p>10 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ</p>	<p>95%</p> <p>4</p> <p>100%</p> <p>80%</p> <p>100%</p> <p>100%</p>					
<p>(ЗГХЭГ-ын үнэлгээ)</p>	<p>Нэгдсэн үнэлгээ</p> <p>... %</p>					

**“УЛААНБААТАР ХОТЫН VII, XIV, МҮОНРТ-ИЙН ХОРООЛЛЫН
ОРОН СУУЦ, ДЭД БҮТЦИЙН ТӨСӨЛ” -ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

2019.12.21

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

БНХАУ-ын ЭКСИМ банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл”-ийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн зорилго: Улаанбаатар хотын агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах, VII, XIV хорооллыг барилгажуулах эхлэлийг тавих, VII хороолол, МҮОНРТ орчмын хорооллыг инженерийн дэд бүтцэд холбох, VII, МҮОНРТ-ийн хорооллын цахилгаан хангамжийг сайжруулахад оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2010.11.19- 2019.12.30

Төслийн зорилтууд:

1-р зорилт: Улаанбаатар хотын VII, XIV хороололд нийт 2592 айлын орон сууц барих.

2-р зорилт: Орон сууцны VII хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх.

3-р зорилт: МҮОНРТ-ын орчмын хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх.

4-р зорилт: Улаанбаатар хотын VII хороолол, МҮОНРТ-ийн орчмын хорооллыг цахилгааны эх үүсвэрээр хангах 23,3 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам болон “Улаанбаатар” дэд станцын өргөтгөл, “7-р хороолол”, “Радио телевиз” дэд станцын угсралтын ажлыг гүйцэтгэх.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төслийн хэрэгжилтийн түвшин 95 хувьтай, “бүрэн хэрэгжсэн” гэж дүгнэж байна. Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж /хувь/	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
	95%	4	100%	80%	100%	100%

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлууд хийгдсэн. Үүнд:

Төслийн хүрээнд МҮОНРТ, ҮИ, ХИҮ хорооллын инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлууд үндсэндээ хийгдэж дуусаад байна. Үүнд:

1. МҮОНРТ орчмын хороололд Ус дулаан дамжуулах төвтэй холбосон 105 м /хос шугам/ шугам сүлжээ. 1 ширхэг дулааны худаг, гадна бохир усны 1100 метр шугам сүлжээ, 30 ширхэг худаг болон Баянгол дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт дулааны 1760 метр шугам сүлжээ, 7 ширхэг цутгамал худгийн угсралтын ажлыг гүйцэтгэн 2019 оны 8-р сарын 4-ний өдөр тус тус ашиглалтад оруулсан.

2. МҮОНРТ Чингэлтэй дүүргийн 5,8-р хорооны нутаг дэвсгэрт нийт 1700 метр бохир усны шугам сүлжээний, 54 ширхэг худгийн угсралтын ажлыг гүйцэтгэсэн.

3. МҮОНРТ-ийн усан сан, өргөлтийн насос станц, цэвэр усны шугамын ажлын хүрээнд цэвэр усны 4200 метр шугам сүлжээ, 3 ширхэг цутгамал худаг, 18 ширхэг угсармал худгийн угсралтын ажлыг 2019 онд бүрэн гүйцэтгэсэн.

4. Төслийн хүрээнд 2019 онд МҮОНРТ, ҮИ, ХИҮ хороололд 10 кВ-ын хуваарилах байгууламж-3 ком, 2х630 кВА-ын цахилгааны дэд өртөө -1 ком, 2х1000 кВА-ын дэд өртөө 1 ком, тэдгээрийн тэжээлийн 10 кВ-ын 25,0 км урттай цахилгааны кабель шугамын угсралтын ажил зэрэг 11 нэр төрлийн ажлыг гүйцэтгэсэн байна.

5. Тасганы усан сангийн хяналтын системийн шилэн кабелийн ажил бүрэн дуусч, 2019 рны 12 дугаар сарын 16-ны өдөр комисс ажиллан, байнгын ашиглалтад оруулсан. Цахилгааны ажлын хувьд: 800 кВА-ын чадалтай нөөцийн дизель генератор суурилуулсан. ХТП-1054 дэд өртөөнөөс буусан 2 ш трансформатор, 10 кВ-ын тоног төхөөрөмжийг эзэмшигч байгууллага УСУГ-т хүлээлгэн өгсөн.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төслийн хэрэгжилтийн түвшин 95 хувьтай, “бүрэн хэрэгжсэн” гэж дүгнэж байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Дуусаагүй барилга бүртгэлд байгаа 70,0 сая ам.долларын өртөг бүхий 2592 айлын орон сууцны барилга, 33,4 тэрбум төгрөгийн дулаан, цэвэр бохир усны шугам, цахилгааны шугам сүлжээ, дэд станцуудыг өмчлөгчийн эзэмшилд шилжүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн байгаадаа анхаарч, холбогдох шийдвэрүүдийг гаргуулах,

2. Барилгын гэрээний үлдэгдэл 1909,0 сая ам доллар, чанарын баталагааны 1699,0 сая ам долларын санхүүжилтыг олгох асуудлыг тус яамтай хамтран Сангийн яамаар шийвэрлүүлэх,

3. Улаанбаатар хотын 7, 14-р хорооллын орон сууц, дэд бүтцийн төслийн гүйцэтгэгч Бэрэн, Цагаанхуаран ХХК-дын зээл, зээлийн хүүг төлүүлэх асуудлыг хууль, хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэхийг Хуулийн хэлтэс /Б.Нямдорж/-д үүрэг болгох

4. Төслийн төгсгөлийн тайланг холбогдох дүрэм журамд нийцүүлэн боловсруулж, тус яаманд 2020 оны 01 дүгээр сарын 05-ны дотор ирүүлэх арга хэмжээ авах,

5. Төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу төсөл хэрэгжүүлэхэд оролцон ажилласан Бэрэн, Цагаанхуаран ХХК-дын зээлийг холбогдох хууль, журмын хүрээнд төлүүлэх арга хэмжээг холбогдох яам болон орон нутагтай хамтран хэрэгжүүлэхийг

Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/ нарт даалгах;

6.Төсөл хэрэгжиж дуусч буйтай холбогдуулан архивт хүлээлгэн өгөх материалуудаа бэлтгэн, хүлээлгэн өгч дуусгах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>“Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл FR-01/Франц” Төслийн зорилго: Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, түүнчлэн хүн амыг аюулгүй эрүүл орчинд амьдрах, үйлдвэр, орон сууцны барилга нэмэгдэн баригдах нөхцлийг бүрдүүлэх, бохир усны цэвэрлэгээний үр дүнг дээшлүүлэх, хотын хөгжлийг эрчимжүүлэх зэрэг эдийн засгийн болон нийгмийн хэрэгцээг хангахад оршино. Шийдвэр: -Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улс (БНФУ)-ын Засгийн газрын хооронд 2008 онд байгуулсан “Санхүүгийн протокол”; -Монгол Улсын Сангийн яам болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс Натиксис банкны хооронд байгуулсан зээлийн гэрээ - Сангийн яам ба Орхон аймаг хооронд 2009 оны 07 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан Дамжуулан зээлдүүлэх гэрээ - Сангийн яам ба Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан Дамжуулан зээлдүүлэх гэрээ - Эрдэнэт хотын захиргаа, Францын Egis Всеom International компанийн хооронд 2008 оны 07-р сарын 01-ний өдөр байгуулсан гэрээ</p>			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж: БНФУ-ын хөнгөлөлттэй зээл			
3	Хэрэгжүүлэгч байгууллага хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга хот, байгуулалтын яам</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Орхон аймаг /хэрэгжих хугацаа: 2013-2017 он/</p>			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1.Хоногт 24000 м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай иж бүрэн цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулах: – 9,224,836,218.00 төгрөг, нийт төсөлд эзлэх хувь 35.0%</p> <p>Зорилт 2. Эрдэнэт хотын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ үзүүлэх– 800,000.00 евро, нийт төсөлд эзлэх хувь 5.5%</p> <p>Зорилт 3. Бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн тоног төхөөрөмжийг захиалах, нийлүүлэх, тээвэрлэх, угсарч, суурилуулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, засвар үйлчилгээг баталгаат хугацаанд хариуцах – 8,735,000 евро, нийт төсөлд эзлэх хувь 59.5%</p>			
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Монгол Улсын төсөв 9.224.836.218 төгрөг БНФУ-ын Засгийн газрын зээл 9.535.000.0 евро		
		Үүнд:	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1	9.224.836.218 төг	9.224.836.218 төг	100%
		Багц 2 (г.м)	8.000.000.0 евро	7.793.752.0 евро	97%
		Багц 3 (г.м)	8.735.000.0 евро	8.207.735.53 евро	94%
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт: 1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн	<p>Ажлуудын биелэлт</p> <p>1-р зорилтын хүрээнд: 2018 онд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр бохир ус хүлээн авах насосны станц, элс баригч, анхдагч тунгаагуурууд, анхдагч тунгаагуурын хувиарлах, насосны станц, Аэротенк, аэротенк лагийн насосны станц, хоёрдугаар тунгаагуурууд, ус хэмжигчийн байр, ЦРП-6-гийн өргөтгөл подстанц, агаар өгөх байгууламж, анхдагч болон биологийн лаг өтгөрүүлэгч, лаг усгүйжүүлэх байгууламж ,гадна дулаан, цэвэр бохир усны шугам, гадна гэрэлтүүлэг, зам талбай , технологийн шугам, тоног төхөөрөмжийн угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2 дугаар зорилтын хүрээнд 2019 оны 9 дүгээр сарын 09-ний өдрөөс БНФУ-ын “СЭУЗ Интернэшнл” ХХК-ийн инженерүүд ажиллаж, цахилгаан тоног төхөөрөмжийн холболт, дотоод сүлжээ, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллах ажиллагааг хянан</p>			

		шалгаж, туршилт тохируулгын ажлыг гүйцэтгэж, 2020 оны 5 дугаар сараас бохир ус хүлээн авахад бэлэн болгохоор ажиллаж байна.				
	3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:	3-р зорилтын хүрээнд: Цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг суурилуулан угсарч дуусган техникийн комиссыг 2018 оны 9-р сарын 26-нд ажиллуулсан.				
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Дүгнэлт: Төсөл 97.5 хувьтай "үр дүнтэй" хэрэгжсэн гэж дүгнэж байна.</p> <p>Ололт: Манай орны нийтийн аж ахуйн салбарт цэвэрлэх байгууламжийн шинэ техник, технологи нэвтэрсэн.</p> <p>Дутагдал: Барилгын гүйцэтгэгч компанийн төлбөрийн чадвар, санхүүжилтээс шалтгаалан графикт хугацаанаасаа хоцорсон. Анхаарах асуудал: Төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу зээлийг холбогдох байгууллагаар хууль, журмын хүрээнд хугацаанд нь төлүүлэхэд анхаарч ажиллах.</p>				
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэхэд оролцогч талууд болох "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Зураг төслийн байгууллага, гүйцэтгэгч, БНФУ-ын "СУЭЗ Интернэшнл" ХХК болон ТХН хоорондын хамтын ажиллагаа сайн байсан.				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		98%	3	90%	97%	100%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ				
	(ЗГХЭГ-ын үнэлгээ)					

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“ЭРДЭНЭТ ХОТЫН БОХИР УСНЫ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ” -ИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

2019.12.21

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

БНФранц Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эрдэнэт хотын бохир усны цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл” -ийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн зорилго: Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Орхон аймгийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2013- 2020

Төслийн зорилтууд:

1-р зорилт: Цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, лагийг усгүйжүүлэх,

2-р зорилт: Цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн туршилт тохируулга, гадна тохижилт.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төслийн хэрэгжилтийн түвшин 97,5 хувьтай, “бүрэн хэрэгжсэн” гэж дүгнэж байна. Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж /хувь/	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
	97,5%	2	100%	95%

Төслийн хүрээнд дараах томоохон ажлууд хийгдсэн. Үүнд:

Төслийн хүрээнд 2013-2017 онд “Ар дааган” ХХК, “Байгууламж” ХХК-ийн түншлэл Эрдэнэт хотод 20 000 м3/хоногийн хүчин чадалтай биологи цэвэрлэгээний цэвэрлэх байгууламжийг барьсан.

Энэ хугацаанд Бохир ус хүлээн авах насосны станц, элс баригч, анхдагч тунгаагуурууд, анхдагч тунгаагуурын хувиарлах, насосны станц, Аэротенк, аэротенк лагийн насосны станц, хоёрдугаар тунгаагуурууд, ус хэмжигчийн байр, ЦРП-6-гийн өргөтгөл подстанц, агаар өгөх байгууламж, анхдагч болон биологийн лаг өтгөрүүлэгч, лаг усгүйжүүлэх байгууламж, гадна дулаан, цэвэр бохир усны шугам, гадна гэрэлтүүлэг, зам талбай, технологийн шугам, тоног төхөөрмжийн угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Барилга угсралтын ажил болон тоног төхөөрмжүүдийн угсралт бүрэн дууссан.

Байгууламжийг ашиглалтад оруулах зорилттой ажиллаж 2019 оны 9 дүгээр сарын 09-ний өдрөөс барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор БНФУ-ын “СЭУЗ Интернэшнл” ХХК-иас инженерүүд ирж цахилгаан тоног төхөөрөмжийн холболт, дотоод сүлжээ, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллах ажиллагааг хянан шалгаж 2020 оны 5 дугаар сараас бохир ус хүлээн авахад бэлэн болгох бэлтгэл ажлыг хангаж байна.

Анхаарах асуудал:

Цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлыг дуусган, гадна тохижилт, гэрэлтүүлэг, автоматжуулалтын ажлыг иж бүрэн хийж дуусгах.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.

Төслийн хэрэгжилтийн түвшин 97,5 хувьтай, “бүрэн хэрэгжсэн” гэж үнэлэв.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ.

1. Цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлыг дуусган, гадна тохижилтын ажлыг иж бүрэн хийж дуусган, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулан, ашиглалтад хүлээлгэн өгөх ажлыг 2020 оны эхний хагас жилд багтаан зохион байгуулахыг ТХН /Б.Доржоо/-д үүрэг болгох;

2. Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн ашиглагч байгууллагаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 16-р хуралдаанаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг сонгосон шийдвэр гарсан тул ашиглагч байгууллагад цэвэрлэх байгууламжийг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/ нарт даалгах;

3. Эрдэнэт хотын төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу зээлийг холбогдох хууль, журмын хүрээнд хугацаанд нь төлүүлэхэд анхаарч ажиллахыг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/ нарт даалгах;

4. Төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу зээлийг хугацаанд нь төлөх арга хэмжээг холбогдох яам болон орон нутагтай хамтран хэрэгжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/ нарт даалгах;

5. Төсөл хэрэгжиж дуусч буйтай холбогдуулан архивт хүлээлгэн өгөх материалуудаа бэлтгэн, хүлээлгэн өгөхийг ТХН /Б.Доржоо/-д үүрэг болгох.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Төслийн агуулга	Гүйцэтгэл				
1	Төслийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>Төслийн нэр: Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл.</p> <p>Төслийн зорилго: Дархан хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, бохир болон дулааны шугам сүлжээг шинэчлэх, төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэхэд оршино.</p> <p>Монгол Улсын Дархан-Уул аймгийн хот байгуулалт түүний төлөвлөлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ээлтэй, тогтвортой байдлаар хөгжүүлснээр чанар аюулгүй байдлын үзүүлэлтийн түвшин дээшилж, хүн амын амьдрах орчны төлөв байдал сайжирна.</p> <p>Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын 2 дахь том хотод үйлдвэржилтийг дэмжих, төвлөрлийг сааруулах, хот хөдөөгийн ялгааг арилгах үндсэн нөхцөл бий болж, Дархан хотын бохир усны менежмент сайжирч, бохир ус цэвэрлэх төв байгууламж (ТЦБ), ариутгах татуурга болон насос станцын үйл ажиллагааны түвшин дээшилнэ. Мөн Дарханы ус сувгийн байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлж, байгууллагын бодлого бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоход дэмжлэг болно. Мөн Дархан хотын НАА-н байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, бүтцийг оновчтой боловсронгуй болгох үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлэн Техникийн туслалцааг хэрэгжүүлнэ.</p>				
2	Санхүүжилтийн эх үүсвэр	АХБ-ны зээл: АХБ-ны Ердийн эх үүсвэрээс 9.45 сая ам.доллар, АХБ-ны Тусгай сангийн эх үүсвэрээс 9.05 сая ам.доллар, МУЗГ 2.18 сая ам доллар.				
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Дархан-Уул аймгийн ЗДТГ</p> <p>Хэрэгжих хугацаа: 2015.08.25 - 2020.11.30 /Нийт 63 сар/</p>				
4	Төслийн зорилтууд	<p>1. Цэвэрлэх байгууламж насос станц шинэчлэх</p> <p>2. Дулааны болон бохирын шугам сүлжээ шинэчлэх</p> <p>3. Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх</p>				
5	Төсөв (нийт шаардагдах зардал)	20.68 сая ам.доллар				
	Зардал	Үүнд:	Гэрээний нэр	АХБ-ны санхүүжилт		
				Гэрээний дүн	Гүйцэтгэл	Хувь
		A1	Цэвэрлэх байгууламж ба насос станц	12,515,345	5,850,379	47%
		A2-1	Дулааны шугам сүлжээ шинэчлэх	458,086	458,086	100%
		A2-2	Бохирын шугам сүлжээ шинэчлэх	630,347	459,619	73%
		A2-3	Дулааны насос станцын барилгын засварын ажил	72,971	72,971	100%
		A2-4	Бохирын шугам хоолойн өргөтгөл шинэчлэлийн ажил	217,423	217,423	100%
		A2-5	Цэвэрлэх байгууламжийн ажилчдын автобус нийлүүлэх	60,877	60,877	100%
A2-6	Дархан Ус Суваг ХК-д зөөврийн гагнуурын авто машин болон экскаватор нийлүүлэх	215,496	215,496	100%		

	C1	Зээл хэрэгжүүлэх зөвлөх	1,733,464	1,273,640	73%
	C1-1	Техник эдийн засгийн үндэслэлийн тайлан	28,000	28,000	100%
	C1-2	Байгал орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг шинэчлэн боловсруулах	27,600	27,600	100%
	C2-1	Байгаль орчны хяналтын мэргэжилтэн	5,415	5,415	100%
	C2-1	Байгаль орчны хяналтын мэргэжилтэн	25,600	11,039	43%
	C2-3	Нүүлгэн шилжүүлэлт, нийгмийн хөгжил, жендерийн хяналтын мэргэжилтэн	16,280	8,892	55%
	Төслийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.		
6	1-р зорилтын хүрээнд:		1.1 Барилга байгууламж болон тоног төхөөрөмж шинээр барьж суурилуулах, тоноглох ажлын хүрээнд ЦБ-ын ерөнхий төлөвлөгөө, өндөржилт, гадна тохижилт, зай хэмжээ, технологийн шугам сүлжээ, гадна цахилгаан, гадна холбооны зураг төслүүдийг 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр экспертизэд хүргүүлэн, 2019 оны 4-р сарын 26-нд батлуулсан. СКАДА систем, ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан түшиц хана, урсгал хэмжигчийн зураг төслүүдийг батлуулахаар ажиллаж байна. Зураг төслийн ажлын явц 97%		
	Бохир ус цэвэрлэх байгууламж шинэчлэх		1.2 Цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлын хүрээнд баригдах нийт 39-н барилга болон 3-н насос станцын засвар шинэчлэлийн ажлуудаас 2019 онд барилгын ажлын 55%-ыг хийж гүйцэтгээд байна. 1-р зорилтын хүрээнд хийгдэж буй ажлын явц 2019 оны эцсээр өссөн дүнгээр 64.9%.		
	2-р зорилтын хүрээнд:		Бохир усны шугам хоолойг шинэчлэх ажлын хүрээнд "Бридж Констракшн" ХХК гүйцэтгэгчээр ажиллаж үйлдвэрийн бүсийн 3.2 км бохирын шугам сүлжээг 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 2018-01/47 дугаартай комиссын актаар, А3 хэсгийн автовокзал 1.325 км шугамыг 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Д-2018-01/47-2 дугаартай комиссын актаар, А4 хэсгийн хотын төвийн насос станц 1.23 км шугамыг 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Д2018-01/47-3 дугаартай комиссын актаар, А6 хэсгийн 14-р багийн эмнэлгийн 0.211 км шугамыг 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Д2018-01/47-4 дугаартай комиссын актуудаар тус тус хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан. Багц А2-1 ажлын хүрээнд "Хүрд" ХХК нь цэвэрлэх байгууламжийн дулааны 2.195км шугамыг 2018 оны 11 дүгээр сарын 14-ний Д-2018-01/48 тоот комиссын актаар, Дулааны насос станц №3 хаалттай дэд өртөө дулааны даралт өсгөх 320тн/цаг хүчин чадалтай насос станц №3 болон 6/04кВА-ын 2*400 КВА чадалтай хаалттай дэд өртөөг 2018-01/48-1 дугаартай комиссын актуудаар тус тус ашиглалтад оруулсан. Мөн "Дархан есөн ундраа" ХХК-ийн гүйцэтгэсэн Дулааны насос станц №3 хаалттай дэд өртөөний барилгын засварын 24.0х12.0м 1 давхарын барилгын ажлыг 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Д2018-01/46 дугаартай комиссын актаар хүлээлгэн өгсөн. 2019 онд дараах инженерийн шугам сүлжээг ашиглалтад орууллаа. "Бридж Констракшн" ХХК нь А5 хэсгийн Эрүүл мэндийн 2-р төвийн 0.2км шугамыг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 23/2019Д дугаартай комиссын актаар, Багц А2-4 ажлын хүрээнд "Цагаан зуун" ХХК В1 хэсгийн хуучин Дархан 20.3 байрнаас 15 дугаар сургууль хүртэл 0.4км, В2 хэсгийн 1.37км шугамуудыг 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 21/2019Д дугаартай комиссын актаар тус тус хүлээлгэн өгсөн. Нийт 6.9 км шугам хоолойг шинээр барьж, 4.6 км шугамыг сэргээн засварласан.		
	Дулааны болон бохирын шугам хоолой шинэчлэх				

	3-р зорилтын хүрээнд:	Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2016-2017 онд нийт 6 сургалт зохион байгуулсан. Үүнд: Худалдан авах үйл ажиллагаа, болон авлигатай тэмцэх арга хэмжээ гэрээний удирдлага; Барилгын салбарын удирдлагын менежмент, Үйлдвэрлэлийн бохир усыг цэвэршүүлэх менежмент; Төсөл дээрх 7 гол асуудлаарх хэлэлцээр зохион байгуулж шийдвэр гаргасан зэрэг 4 сургалтад 111 хүн хамрагдсаны 28 хүн нь эмэгтэй оролцогч байсан. Харин хотын бохир ус, байгаль орчны менежмент; Гэр хороололд төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийг ашиглах сонголтууд зэрэг сургалтуудад 190 хүн хамрагдсаны 62 нь эмэгтэй оролцогч байсан.					
	Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхыг бэхжүүлэх	Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2018 онд нийт 7 сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: Төслийн санхүүгийн удирдлагын менежмент, болон аудитын систем; Гэрээний менежмент болон авлигатай тэмцэх арга хэмжээнүүд; Барилгын салбарын хяналтын менежмент; Төсөл дээрх 7 гол асуудлаарх хэлэлцүүлэг зохион байгуулж, шийдвэр гаргасан; Цэвэрлэх байгууламж дах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдал зэрэг 5 сургалтад 158 хүн хамрагдсаны 47 хүн нь эмэгтэй оролцогч байсан. Мөн хотын бохир ус, байгаль орчны менежмент; Гэр хороололд төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийг ашиглах сонголтууд зэрэг 2 сургалтуудад 208 хүн хамрагдсаны 82 нь эмэгтэй оролцогч байсан.					
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололттой тал: Барилгын ажлыг эрчимжүүлэх зорилгоор 7 хоног бүрийн уулзалтыг зохион байгуулж тулгарч байгаа асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэж байна.</p> <p>Дутагдалтай тал: Цаашид төслийг хэрэгжилтийг тайлагнахдаа хийх ажлын бодит хэмжээг төлөвлөж хүрсэн түвшинтэй харьцуулан тодорхой тайлагнах.</p> <p>Анхаарах асуудлууд: төсөл 2020 онд дуусахтай холбогдуулан төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу зээлийг холбогдох хууль, журмын хүрээнд хугацаанд нь төлүүлэх, цэвэрлэх байгууламж баригдаж дууссаны дараа ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх асуудалд анхаарч ажиллах.</p>					
8	Төслийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Дархан-Уул аймгийн Засаг даргын №А/445 тоот захирамжаар " Дархан хотын бохир усны менежементийн МОН3244/3245 " төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Төсөлд оролцогч талуудын хамтын ажиллагаа сайн байгаа боловч төслийн үндсэн гүйцэтгэгчийн барилгын ажил хугацаанаас хоцрогдолтой байгаа тул төслийн хэрэгжилт "тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэж байна.					
9	Төслийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	
		Хэрэгжилийн түвшин	75.6%	3	64.9%	94.9%	79.7%
10	Төслийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ					
	(ЗГХЭГ-ын үнэлгээ)	... %					

**“ДАРХАН ХОТЫН БОХИР УСНЫ МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ
МОН-3244/3245 ТӨСӨЛ” -ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

2019.12.21

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн зорилго: Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах, бохир усны төв цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга болон насос станцын үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэх, Дархан хотын ус сувгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэхэд оршино.

Монгол Улсын Дархан-Уул аймгийн хот байгуулалт түүний төлөвлөлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ээлтэй, тогтвортой байдлаар хөгжүүлснээр чанар аюулгүй байдлын үзүүлэлтийн түвшин дээшилж, хүн амын амьдрах орчны төлөв байдал сайжирна.

Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын 2 дахь том хотод үйлдвэржилтийг дэмжих, төвлөрлийг сааруулах, хот хөдөөгийн ялгааг арилгах үндсэн нөхцөл бий болж, Дархан хотын бохир усны менежмент сайжирч, бохир ус цэвэрлэх төв байгууламж (ТЦБ), ариутгах татуургын үйл ажиллагааны түвшин дээшилнэ. Дархан хотын ус сувгийн байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлж, байгууллагын бодлого бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоход дэмжлэг болно.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Дархан-Уул аймгийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2015.08.25 - 2020.11.30. /Нийт 63 сар/

Төслийн зорилтууд:

Зорилт 1. Цэвэрлэх байгууламж шинэчлэн барих;

Зорилт 2. Дулааны болон бохирын шугам сүлжээ, насос станц шинэчлэх;

Зорилт 3. Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх.

Төслийн хүрэх үр дүн:

Үр дүн 1: Бохир ус цэвэрлэх байгууламж шинэчлэгдэнэ.

Төслийн үр дүнд орчин үеийн Үйлдвэрлэлийн бүтээмж өндөртэй, эрчим хүчний хэмнэлттэй цэвэрлэх процесс болох биофильмт технологийг (идэвхжүүлсэн лаг) ашиглах шинэ цэвэрлэх байгууламж ашиглалтад орох бөгөөд нийт барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг шинээр барьж суурилуулж тоноглоно.

Төслийн хүрээнд одоо ашиглагдаж буй 2, ашиглалтгүй байгаа 1 насос станцыг бүрэн шинэчилж тоногосноор цэвэрлэх байгууламжид төвлөрөх бохир усны цуглуулалтыг ихэсгэж эрчим хүчний хэмнэлттэй цэвэрлэх боломжийг бий болгоно.

Орчин үеийн бохир усны лаборатори ашиглалтад орсонор усны чанарыг олон улсын стандартад нийцүүлэн шинжилж, үр дүнг гаргадаг болно.

Үр дүн 2: Дулааны болон бохирын шугам хоолой шинэчлэгдэнэ.

Төслөөр ашиглалтын шаардлага хангахгүй нийт 9,2 км урт бохир усны шугам хоолойг шинэчилнэ. Ингэснээр үйлдвэрүүдийн бохир усыг урьдчилсан цэвэрлэх байгууламжаар дамжуулан төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх, мөн хотын төвийн хэрэглэгч ихтэй шугамуудын ачаалал багасан найдвартай ажиллагаа дээшлэх нөхцөл бий болно.

Мөн цэвэрлэх байгууламжийг төвийн дулааны сүлжээнд холбох зорилгоор 1,2 км дулааны хос шугам хоолойг шинээр, дулааны 3-р насос станцын тоног төхөөрөмж болон цахилгаан тоноглолыг шинэчилнэ. Цэвэрлэх байгууламж төвийн дулаанд холбогдсоноор цаашдын ашиглалтын зардал буурч, ажилчдад ажиллах таатай нөхцөл бүрдэнэ.

“Дархан Ус суваг” ХК-д өдөр тутмын үйлчилгээний зориулалттай тоног төхөөрөмж нийлүүлэн ажлын хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулна.

Үр дүн 3: Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх.

НАА-н салбарын менежментийн чадавхийг хөгжүүлэх, ашиглалт ба засвар үйлчилгээг сайжруулах, онцгой байдлын үед авах арга хэмжээний нарийвчилсан зураг төсөл боловсруулан хэрэгжүүлж, түүнд хяналт тавьж мэргэжлийн дэмжлэг үзүүлэх боломжийг бий болгоно.

Төслийн хэрэгжилтийн явцад сургалт болон сургалтын аяллууд зохион байгуулагдана. Төслийн хэрэгжилтийн явцад цэвэр ба бохир усны үнэ тарифын шинэчлэл, ариун цэврийн орчин болон хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар бодлого тодорхойлох яриа хэлэлцүүлэг хийнэ. Байгаль орчны менежмент, ариун цэвэр ба хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар олон нийтийг хамруулсан компаниг ажил зохион байгуулна.

Төсөл хэрэгжүүлэхтэй зэрэгцүүлэн НАА-н үйлчилгээний институт бүтцийг хөгжүүлэх, стратеги төлөвлөлт ба үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн Техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төсөл нь цэвэрлэх байгууламж, насос станц, дулааны болон бохирын шугам сүлжээ шинэчлэх, төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх гэсэн 3 зорилтын хүрээнд хэрэгжиж байна.

Төслийн хэрэгжилтийн тайлан болон 2019 оны төлөвлөгөөний биелэлттэй танилцаад, дараах үнэлгээ, дүгнэлт, санал зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Төслийн хэрэгжилтийн түвшин 75,6 хувь, 2019 оны төлөвлөгөөний биелэлт 80,6 хувь, төслийн хэрэгжилтийг “хэрэгжих шатанд” гэж үнэлэв. Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт /хувь/		Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
	Хэрэгжилтийн түвшин /өссөн дүнгээр/	75,6 %	3	64,9	94,9	79,7
2019 оны төлөвлөгөөний биелэлт	80,6 %	3	66,2	95,0	78,0	

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Төслийн үндсэн худалдан авалтаас хэмнэгдсэн зээлийн хөрөнгөөр “А2-4. Бохирын шугам хоолойн өргөтгөл шинэчлэл” багц ажлын хүрээнд “Цагаан зуун” ХХК нь ф300 мм-ийн голчтой 1770 м шугам, 52 худгийн барилгын ажлыг гүйцэтгэн, 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулсан.

2. Төслийн хүрээнд “Бридж констракшн” ХХК нь ф300 мм-ийн голчтой 290 м шугам, 13 худгийн барилгын ажлыг гүйцэтгэн, 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгсөн.

3. Төслийн худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөний дагуу техникийн шаардлага хангасан эксковаторыг Дарханы ус сувгийн байгууллагад 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгсөн.

4. А2-7 багц. Бохирын насос станцын засварын ажлын хүрээнд насос станцыг шинэчлэх, бохирын нэмэлт шугам хоолойн ажлын зураг төслийг “Эрчим төсөл” ХХК боловсруулж, батлуулсан.

5. Дархан-Уул аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 07 тоот тогтоолоор “Бридж констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн 714,5 сая төгрөгийн үнэ бүхий бохир усны ф355 мм-ийн голчтой 1600 м хуванцар хоолой, ф800 мм-ийн 1230 м төмөр бетон хоолой, ф300 мм-ийн 290м хуванцар хоолойг, мөн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 10-р сарын 04-ний өдрийн 88 тоот тогтоолоор “Бридж констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн 234,2 сая төг-ийн үнэ бүхий бохир усны шугам хоолойг, “Цагаан зуун” ХХК-ийн гүйцэтгэсэн 633 сая төг-ийн үнэ бүхий бохир усны шугам хоолойг тус тус Дархан ус суваг ХК-ийн балансад бүртгэх зөвшөөрөл олгосон.

6. “Дархан дулааны сүлжээ” ТӨХК-д 1 тэрбум 260,3 сая төг-ийн үнэ бүхий дулааны насос станц, цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамыг хүлээлгэн өгч, барилга байгууламжийн ашиглалтын ногоон гэрчилгээ олгосон.

7. Төслийн хэмнэгдсэн хөрөнгөөр нэмэлт 2 байршилд бохир усны шугам угсрахтай холбогдуулан газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг шинэчлэн 2019 оны 03-р сарын 13-ны өдөр АХБ-аар батлуулсан.

8. Төслийн байгаль орчны хяналтын зөвлөлтэй 2019 оны 03-р сард, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэнтэй 2019 оны 09-р сард, Дархан дахь төслийн нэгжийн захиргааны ажилтан/орчуулагчтай 2019 оны 10-р сард тус тус гэрээ байгуулан, ажиллуулж байна.

9. Төслийн хүрээнд нийгмийн хөгжлийн, жендерийн үйл ажиллагааны, хэлэлцүүлэг-оролцооны, оролцогч талуудын харилцаа холбооны, олон нийтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус батлуулан хэрэгжүүлэн ажилласан байна.

Төслийн хүрээнд дараах ажлын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

-Төслийн хүрээнд А1 багц буюу цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах, материал тоног төхөөрөмж ханган нийлүүлэх болон барилгын ажил графикт хугацаанаас хоцорч байгаа тул А1 багц ажлын шинэчилсэн төлөвлөгөөг 2019 оны 09-р сарын 10-ны өдөр ТУХороогоор батлуулсан. Энэ төлөвлөгөөний дагуу барилгын ажил 2019 оны эцэст 93%-д хүрэхээс бодит гүйцэтгэл 55%-тай, 38%-ийн хоцрогдолтой байна.

-2018 оны 12-р сарын 01-03-ны өдрүүдэд ажилласан АХБ-ны ажлын хэсгээс А1 багцын ерөнхий гүйцэтгэгчийг 2019 оны барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөөг нарийвчлан боловсруулах, туслан гүйцэтгэгчийг 3-аас багагүй болгож нэмэгдүүлэх зэрэг үүрэг өгөгдсөн боловч ажиллах хүчний төлөвлөгөө 39,5%, машин механизмийнх 66,8%, барилгын ажил явагдаж буй барилгын тоог нэмэгдүүлэх төлөвлөгөө 28,5%, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт 56,8% -тай, төлөвлөгөөг биелүүлээгүй, хангалтгүй ажилласан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төслийн хэрэгжилтийн түвшин 75,6 хувь, 2019 оны төлөвлөгөөний биелэлт 80,6 хувь, төслийн хэрэгжилтийг “хэрэгжих шатанд” гэж үнэлэв.

Дархан хотын бохир усны цэвэрлэх байгууламж, насос станцын барилгын ажил гэрээт хугацаанаас 38%-аар, ажиллах хүчний хангалт 60,5%-аар, сарын дундаж ажлын гүйцэтгэл 70%-аар хоцрогдолтой явагдаж байна. Энэ нь төслийн ерөнхий гүйцэтгэгч Пфайфер болон Эмит түншлэлийн зохион байгуулалт хангалтгүй, мэргэжлийн чадамж сул, туршлагагүй, хариуцлагагүй үйл ажиллагаатай шууд холбоотой гэж үзэж байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Дархан хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх барилгын ажилд шаардагдах бараа материал, тоног төхөөрөмж, машин механизм, ажиллах хүч, барилгын ажил явагдаж буй барилгын тоог нэмэгдүүлэн, төлөвлөгөөний хоцрогдлоо нөхөх, ажлаа эрчимжүүлэх, барилгын менежерийг барилгын талбайд тогтмол ажиллуулах, гэрээнд заасан үүргээ хугацаанд нь хэрэгжүүлж ажиллахыг Пфайфер болон Эмит түншлэлд үүрэг болгох;

2. Дархан хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлын ерөнхий гүйцэтгэгч Пфайфер болон Эмит түншлэлийн удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулан, үйл ажиллагааг эрчимжүүлж, байнгын хяналт тавьж, хоцрогдлыг арилгуулах арга хэмжээ

авах, гэрээг дүгнэн хариуцлага тооцож ажиллахыг “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл”-ийн нэгж /Б.Баасан/-д даалгах;

3. Төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу зээлийг холбогдох хууль, журмын хүрээнд хугацаанд нь төлүүлэхэд анхаарч ажиллахыг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/ нарт даалгах;

4. Төслийн хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарч, төслийг хугацаанд нь чанартай хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллахыг Төслийн удирдах хороо /С.Магнайсүрэн/, Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/, Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/ нарт үүрэг болгох;

5. Төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу зээлийг хугацаанд нь төлөх арга хэмжээг холбогдох яам болон орон нутагтай хамтран хэрэгжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/ нарт даалгах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	“Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” төслийн зорилго нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг хөгжүүлэх, хэрэгжүүлэх замаар барилгын салбарын эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгоход түлхэц үзүүлэхэд оршино. Шийдвэр: 2016 онд НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр болон Барилга, хот байгуулалтын сайд төслийн баримт бичигт гарын үсэг зурсанаар төсөл албан ёсоор эхэлсэн.			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Буцалтгүй тусламж: Даян дэлхийн байгаль орчны сан /ДДБОС/ GEF			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга хот байгуулалтын яам Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) тооцоо судалгааг бий болгох Зорилт 2. Барилгын салбарт ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааг бий болгох, хэрэгжүүлэх Зорилт 3. ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааны үр дүнг хэмжих, тайлагнах, нотлох (MRV) механизмыг бий болгох			
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	1,314,863.00		
		Үүнд:	Төсөв 2018, ам доллар	Гүйцэтгэл 2018, ам доллар	Хувь
		Үйл ажиллагаа 1	23.400.00	23.337.00	100%
		Үйл ажиллагаа 2	320.063.00	195.518.14	61%
		Үйл ажиллагаа 3	197.717.00	169.333.25	85%
		Үйл ажиллагаа 4	50.000.00	16.369.00	33%
	Дүн	591.180.00	404.557.39	68%	
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:				
	1-р зорилтын хүрээнд:	Үр дүн 1.1-ийн хүрээнд: ХХЯ-ын талаарх тоо мэдээллийг цуглуулах, тооллогын тогтолцоог хэрэгжүүлэх шийдвэр гаргагчид болон техникийн ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг төслөөс боловсруулан бэлтгэж, чадавх бий болгох, бэхжүүлэх сургалтуудыг 2019 оны 3 дугаар сарын 18, 21, 6 дугаар сарын 04, 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. - Сургалтын үр дүнд тооллогын тогтолцоо, түүний чанарын хяналт шалгалт, тоон мэдээлэлд тавигдах шаардлага, ялгарлыг тооцоолох томъёолол, холбогдох тоон мэдээллээр хангах байгууллага зэрэг мэдвэл зохих ойлголтуудыг оролцогчдод таниулан мэдлэгийг дээшлүүлсэн. Оролцогчид барилгын салбарын ХХЯ-ыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтээс ялгарлын бууралтын тооцооллыг хийх талаар хангалттай мэдлэгийг олж авсан.			
	Үр дүн 1.2: Барилгын салбар дах эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн тооллогын тоо баримт, статистик мэдээллийг цуглуулах, аргачлал боловсруулах	Үр дүн 1.2 -ийн хүрээнд: Барилгын салбарын ХХЯ-ыг тооцоох аргачлал” БНбД23-02-2019”-ыг БХБС-ын тушаалаар 2020.02.13-ний өдөр батлуулсан. Барилгын салбарын ХХЯ-ын тооллогын цахим системийг бий болгосон. http://ghgconstruction.gov.mn/ . Тус яам болон Эрчим хүчний зохицуулах хорооны хооронд хүлэмжийн хийн тооллогын цахим системийг хамтран ажиллуулах тухай санамж бичгийг 2019.01.04-ний өдөр байгуулсан.			

<p>Үр дүн 1.3: Барилгын салбар дах ХХЯ, эрчим хүчний хэрэглээний суурь түвшинг тодорхойлж тогтоох</p>	<p>Үр дүн 1.3 -ын хүрээнд: Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийг хөгжүүлэх ажлыг 2018 оны 4 дүгээр сараас 10 дугаар сарын хугацаанд Аствишн ХХК хийж гүйцэтгэсэн. Тооллогын вэб тогтолцоо нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон барилгуудаас ялгарах хүлэмжийн хийн ялгарлын тоон мэдээллүүд, ирээдүйд барилгын салбарт хэрэгжүүлэх эрчим хүчний хэмнэлтийн төсөл хөтөлбөрүүдийг Хэмжих, тайлагнах, нотлох үйл ажиллагааг агуулсан байх юм. Энэ нь төрийн болон хувийн салбарт уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Олон улсын донор байгууллагуудын санхүүжилтийг татах боломжийг бий болгохоос гадна барилгын эрчим хүчний талаарх мэдлэгийг олон нийтэд таниулахад дэмжлэг үзүүлж байна. 2018 оны 10 дугаар сарын 16-нд цахим системийг хөгжүүлж дуусан, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Системд дата өгөгдлүүдийг оруулж дуусгах, тооллогын тооцоог шалгах, тест тохируулга болон тооцооны үр дүнг газрын зургаар, графикаар харуулах ажлуудыг 2019 онд хийлээ. Систем ашиглагчдад зориулсан гарын авлага боловсруулан гаргасан.</p> <p>- Хүлэмжийн хийн тооллогын бүтэц зохион байгуулалтыг бий болгох ажлын хүрээнд, төрөөс барилгын салбарт баримтлах бодлогын баримт бичгийн төслийн бодлого боловсруулах үндэслэл хэсэгт "байгаль орчинд ээлтэй, техник технологи нэвтрүүлэх замаар ХХЯ-ыг бууруулах, эрчим хүчний хэрэглээ, дулаан алдагдлыг бууруулах" тухай, төлөвлөлт үйл ажиллагааны 3.5.3-д "ХХЯ-ыг бууруулах, эрчим хүч хэмнэх, хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх" тухай заалтуудыг тус тус тусгуулсан. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийн 5.3.2-т "Барилгын салбарт хүлэмжийн хийн тооллого, хэмжих тайлагнах нотлох тогтолцоог бий болгон, үйл ажиллагааг жигдрүүлэх" ажлыг нэмж тусгуулсан. Энэ нь салбарын хэмжээнд хүлэмжийн хийн тооллогыг явуулах эрхзүйн зохицуулалт болно. Тооллого хийхэд оролцогч талууд хоорондын зохицуулалтыг бий болгохоор БХБЯ, ЭХЗХ хооронд 2019 оны 1 дүгээр сарын 4-нд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын суурь түвшнийг төвлөрсөн сүлжээнд холбогдсон 6 төрлийн барилга байгууламжид урьдчилсан байдлаар тооцож, барилгын нэг метр квадратад зарцуулах эрчим хүчний хэрэглээнээс 0.12 тон СО2-той тэнцэхүйц хүлэмжийн хий ялгардаг болохыг тогтоосон.</p>
<p>Үр дүн 1.4: Барилгын салбар дах ХХЯ, эрчим хүчний хэрэглээний суурь түвшинг тодорхойлж тогтоох</p>	<p>Үр дүн 1.4 -ийн хүрээнд: Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын суурь түвшинг төвлөрсөн сүлжээнд холбогдсон 6 төрлийн барилга байгууламжид урьдчилсан байдлаар тооцож, барилгын нэг метр квадратад зарцуулах эрчим хүчний хэрэглээнээс 0.12 тон СО2-той тэнцэхүйц хүлэмжийн хий ялгардаг болохыг тогтоосон. Суурь түвшинг тодорхойлох аргачлалыг 2020 оны 01 дүгээр сард батлуулсан.</p>
<p>2-р зорилтын хүрээнд:</p>	<p>Барилгын салбарт ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааг бий болгох, хэрэгжүүлэх</p>

<p>Хүрэх үр дүн 2.1: Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зохистой үйл ажиллагааг үнэлэх хүрээг тогтоож, нэн шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох</p>	<p>Барилгын салбарын ХХЯ-ыг бууруулах тэргүүлэх арга хэмжээг тодорхойлох үнэлгээний арга хэрэгслийг бий болгох, боловсруулах ажлын хүрээнд, барилгын эрчим хүчний хэмнэлттэй технологийн хөрөнгө оруулалт болон байгаль орчны үр нөлөөг харьцуулан тооцох боломжтой Marginal Abatement Cost Curve (МАСС) буюу Өртөг, үр ашгийн шинжилгээний муруйн арга хэрэгсэл, аргачлалыг боловсруулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний хэмнэлттэй технологиуд болох ашигт үйлийн коэффициент өндөртэй нам даралтын уурын зуух, сайжруулсан дулаалга, 3 давхар шиллэгээ бүхий цонх, дулаан эргүүлэн ашиглагчтай агаар сэлгэлтийн систем, нарны зайн хавтан, эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг гэсэн технологиудын хөрөнгө оруулалтын өртөг, хүлэмжийн хийн ялгарлын үр нөлөөний шинжилгээг хийж тооцсон. - Аргачлал болон үр дүнг 2018 оны 8 дугаар сард барилгын материал үйлдвэрлэгч, нийлүүлэгч, банк санхүүгийн байгууллагууд, олон улсын байгууллагууд болон төрийн байгууллагуудын төлөөллийг хамруулан хэлэлцүүлж, санал шүүмжүүдийг авч тусган, дахин сайжруулсан. Өртөг үр нөлөөний шинжилгээний аргыг танилцуулж, тооцоог хэрхэн хийх, ашиглах талаар талуудын чадавхийг бэхжүүлсэн. Аргачлал болон программыг https://bit.ly/2PPTzPS линкэнд олон нийтэд нээлттэй байршуулан ашиглах боломжийг бүрдүүлэв.
<p>Үр дүн 2.2: ҮОТХХЯБУА-г боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцох гол талууд хоорондын уялдаа бүхий үйл ажиллагааны зохистой бүтцийг бүрдүүлэх</p>	<p>Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрт Барилгын салбарын гүйцэтгэх үүргийг хэрхэн тусгах тухай хэлэлцүүлгийг 2019 оны 6-р сарын 27-нд салбарын мэргэжилтнүүдийн хамруулан зохион байгуулав. Уг хэлэлцүүлэгт БХБЯ, БОАЖЯ, Эрчим хүчний зохицуулах хороо, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн НАМА төсөл зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцож, ХХЯ-ыг бууруулах талаар барилга, хот байгуулалтын бодлогод туссан баримт бичиг, цуглуулсан суурь дата, статистик мэдээллийг дэлгэрэнгүй судалж, хэлэлцсэнээр бодлого төлөвлөлтөд хэрхэн уялдуулах, ямар байдлаар тусгах тухай саналын хувилбарууд гаргасан. Хэлэлцүүлгийн үр дүнд ХХЯ-ыг бууруулахад Барилгын салбарын оруулах хувь нэмрийг эхний байдлаар тодорхойлон, улмаар Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын авах арга хэмжээнд барилгын салбараас тусгах эхний саналыг тодорхойлов.</p> <ul style="list-style-type: none"> - ХХЯ-ыг бууруулах арга хэмжээг зохицуулах, хэрэгжүүлэх байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох хүрээнд, хүлэмжийн хийн тооллогыг албажуулах зорилгоор Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогын баримт бичигт тодорхой саналуудыг оруулж, хэлэлцэн, бодлого боловсруулах үндэслэл, үндсэн чиглэлүүд, бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд болон бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус тус тусгуулж батлуулсан.

<p>Үр дүн 2.3: Санхүүжилтийн сонголтуудыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, ҮОТХХЯБҮА-г боловсруулах амжилттай хэрэгжүүлэхэд хувийн болон төрийн салбарын чадавх хөгжүүлсэн байх</p>	<p>Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.77.2-д "Ногоон хувийн орон сууц" загвар төслийг үе шаттай эхлүүлэхээр тусгагдсан. Энэ хүрээнд Барилга, хот байгуулалтын яамнаас "Ногоон сууц хотхон" загвар төслийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгын ажлын зураг төсөл боловсруулах 2019/01 тоот даалгаврыг 2019 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр баталж, улмаар уг төслийн шилдэг зураг төсөл шалгаруулах уралдааныг нээлттэй зарласан. Уралдаанд шалгарсан "Эн Эс Партнерс" ХХК-тай 2019 оны 4 дүгээр 26-ны өдөр НАМА CD003-19 тоот гэрээг байгуулж, 80 айлын хотхоны зураг төсөл боловсруулан, БХБЯ-нд хүлээлгэн өгөөд байна. Цаашид уг төслийн гадна цахилгаан, ус хангамж, ариутга татуурга, ус зайлуулах суваг хоолой, гадна холбоожуулалтын зураг төслийг боловсруулах шаардлагатай хөрөнгийг (урьдчилсан байдлаар 117.2 сая төгрөг) НАМА төслөөс санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр НҮБХХ болон донор байгууллагатай ажиллаж байна.</p> <p>- Ногоон барилгын үнэлгээний сургалт. БХБЯ, БОАЖЯ, ЭХЗХ болон Олон улсын санхүүгийн корпораци хоорондын санамж бичгийн хүрээнд, 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Ногоон барилгын үнэлгээний EDGE системийн талаар 1 өдрийн 50 хүнийг хамруулсан сургалтыг НАМА төсөл хамтран зохион байгуулсан. Тус сургалтад хамрагдагсад Ногоон барилгын үнэлгээ хийх Эксперт-ийн шалгалт өгөхөөр бэлтгэж байна. Энэхүү сургалтад БХБЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын 3 мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>- 2019 оны 5 сарын 11-ний өдөр Барилгын эрчим хүчний хэмнэлтийг тооцох ногоон барилгын үнэлгээний ЭДЖ экспертүүдийг чадавхжуулах сургалтыг 20 хүнийг хамруулан зохион байгуулав.</p>
<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Үр дүн 3.1: Сонгогдсон ҮОТХХЯБҮА-ны хяналт хийх (ХХЯ болон бусад) гол үзүүлэлтүүдийг тогтоох, хянах</p>	<p>3-р зорилтын хүрээнд төлөвлөгөөнийхөө дагуу: Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний үр дүнг хэмжих боломжит үзүүлэлтүүдийг харьцуулан судалж, хэлэлцүүлэн, Монгол Улсын барилгын салбарын онцлогт нийцсэн үзүүлэлтүүдийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Барилгын хүлэмжийн хийн ялгарлын бууралт (тнСО₂тэнцэх/жил); 2. Барилгын нүүрсхүчлийн хийн ялгарал (тнСО₂/м²/жил); 3. Байнгын эрчим хүчний эх үүсвэр (кВтц/м²/жил); 4. Дотоод орчны чанар (нүүрсхүчлийн хийн түвшин, дотоод орчны агаарын хэм, чийгшил, суурилуулсан агааржуулалтын систем). <p>Үүнээс гадна нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болох хүйсийн тэгш байдал ба хүүхэд (хүүхдийн тоо, эрэгтэй, эмэгтэй хүний тоо) болон эрчим хүчний хэмнэлтийн эдийн засгийн үр ашиг гэсэн үзүүлэлтүүдээр хэмжиж, тооцохоор тодорхойлсон. Хэмжих, тайлагнах, нотлох системийн аргачлалыг боловсруулан, гол оролцогч талуудаас санал шүүмж авч, тусган сайжруулсан.</p>

	<p>Үр дүн 3.3: MRV системийн хэрэгжилтэнд зориулагдсан чадавх бэхжүүлэх</p>	<p>ХХЯ-ы талаарх тоо мэдээллийг цуглуулах, тооллого хийхэд оролцогч шийдвэр гаргагчид болон техникийн ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг төслөөс боловсруулан бэлтгэж, чадавх бий болгох, бэхжүүлэх сургалтуудыг 2019 оны 3 дугаар сарын 18, 21, 6 дугаар сарын 04, 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан.</p> <p>- Сургалтын үр дүнд тооллогын тогтолцоо, түүний чанарын хяналт шалгалт, тоон мэдээлэлд тавигдах шаардлага, ялгарлыг тооцоолох томъёолол, холбогдох тоон мэдээллээр хангах байгууллага зэрэг мэдвэл зохих ойлголтуудыг оролцогчдод таниулан мэдлэгийг дээшлүүлсэн. Оролцогчид барилгын салбарын ХХЯ-ыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтээс ялгарлын бууралтын тооцооллыг хийх талаар хангалттай мэдлэгийг олж авсан.</p> <p>- Түүнчлэн чадавх бэхжүүлэх зорилгоор нийт 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 51 хүнийг чадавхжуулсан. "Загвар төслийн эрчим хүчний бодит хэрэглээг хэмжих, бүртгэх тайлагнах" сэдэвт сургалтыг 5 загвар төсүүдийн хэмжих, тайлагнах, нотлох буюу барилгын эрчим хүчний бодит хэрэглээ, ашиглалтыг хариуцсан ажилтнуудад зориулсан загвар төслүүдийн жишээн дээр барилгын эрчим хүчний алдагдлыг бууруулах аргууд, эрчим хүчний хэрэглээний хэмнэлтийг хэмжих, тайлагнах, нотлох ажиллагаа, хэмжилт, тооцооллын аргачлалтай танилцаж, дадлагажих зорилгоор 2019 оны 6 сард зохион байгуулав. Барилгын ХХЯ-ын бууралтыг тооцох аргачлал, хэмжих, тайлагнах нотлох ажиллагааг илүү ойлгомжтой, хэрэглэхэд дөхөмтэй болгохын тулд "Барилгын ХХЯ-ын бууралтыг Хэмжих Тайлагнах, Нотлох ажиллагааны гарын авлага"-ыг боловсруулж, загвар төслийг хамтран хэрэгжүүлэгч талуудад хүлээлгэн өгөв.</p>				
7	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Дүгнэлт: Төслийн хэрэгжилтийн түвшин 80.2 хувь, "тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэж байна. Энэхүү төсөл нь барилгын салбараас ялгарах хүлэмжийн хийн тооллогын аргачлалыг батлуулан, тооллогын цахим системийг бий болгож, барилгын инженер, архитекторуудад барилгын эрчим хүчний хэмнэлт, дулаан алдагдлын чиглэлээр сургалт зохион байгуулж, загвар төслүүдийг хэрэгжүүлсэн нь барилгын салбарт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах НҮБ-ийн суурь конвенцыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.</p> <p>Ололт: Хүлэмжийн хийн тооллогын цахим систем болох "Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим систем"-ийг хөгжүүлж, нэвтрүүлсэн нь барилгын салбарт ач холбогдолтой ажил болсон.</p> <p>Анхаарах асуудлууд: Төслийн дараагийн үе шатанд эрчим хүчний хэмнэлтийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг дэмжих санхүүгийн хэрэгслийг хэрэгжүүлэх, загварчлах, Барилгын эрчим хүчний хэмнэлтийн төв болон Хас банктэй хамтран ЭХХ-ийн арга хэмжээг үнэлэх санхүүгийн байгууллагуудад зориулсан удирдамж, аргачлал боловсруулах, Хэмжих, тайлагнах, нотлох асуудал хариуцсан ажилтнуудын хэрэгцээг тодорхойлох үнэлгээ хийж, тэдний чадавхийг бэхжүүлэх, хөтөлбөр боловсруулах зэрэг асуудалд анхаарч ажиллах.</p>				
8	<p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>	<p>Барилга, хот байгуулалтын яам, төсөл хэрэгжүүлэх нэгж, гүйцэтгэгч, зөвлөхүүдийн хамтын ажиллагаа сайн байна.</p>				
9	<p>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)</p>	<p>Биелэлт дундаж</p>	<p>Зорилтын тоо</p>	<p>Зорилт 1</p>	<p>Зорилт 2</p>	<p>Зорилт 3</p>
		<p>80.2%</p>	<p>3</p>	<p>91%</p>	<p>75%</p>	<p>85%</p>
10	<p>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)</p>	<p>Нэгдсэн үнэлгээ</p> <p>... %</p>				

**“БАРИЛГЫН САЛБАРЫН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ АРГА ХЭМЖЭЭ /НАМА/ ТӨСӨЛ” -ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

2020.02.21

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ /НАМА/ төсөл”-ийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн зорилго: Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг хөгжүүлэх, хэрэгжүүлэх замаар барилгын салбарын эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгоход түлхэц үзүүлэхэд оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

Хэрэгжих хугацаа: 2016-2019

Төслийн зорилтууд:

Зорилт 1. Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) тооцоо судалгааг хийх;

Зорилт 2. Барилгын салбарт ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааг бий болгох, хэрэгжүүлэх;

Зорилт 3. ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааны үр дүнг хэмжих, тайлагнах, нотлох (MRV) механизмыг бий болгох.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төсөл нь барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) тооцоо судалгааг хийх; барилгын салбарт ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааг бий болгох, хэрэгжүүлэх; ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааны үр дүнг хэмжих, тайлагнах, нотлох (MRV) механизмыг бий болгох гэсэн 3 зорилтын хүрээнд нийт 31 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, 100 хувьтай арга хэмжээ 17, 70 хувьтай арга хэмжээ 7, 40 хувьтай арга хэмжээ 6, 0 хувьтай арга хэмжээ 1 байна.

Төслийн хэрэгжилтийн түвшин **80.2** хувь, тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж /хувь/	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
Төслийн хэрэгжилт	80.2 %	3	91.4	74.2	75

Төслийн 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ тус бүрээр үнэлбэл:

Төслийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд хийгдсэн байна. Үүнд:

1. Барилгын салбарын ХХЯ-ыг тооцоох аргачлал” БНбД23-02-2019”-ыг БХБС-ын тушаалаар 2020.02.13-ний өдөр батлуулсан.

2. Барилгын салбарын ХХЯ-ын тооллогын цахим системийг бий болгосон. <http://ghqconstruction.gov.mn/>

3. Тус яам болон Эрчим хүчний зохицуулах хорооны хооронд хүлэмжийн хийн тоологын цахим системийг хамтран ажиллуулах тухай санамж бичгийг 2019.01.04-ний өдөр байгуулсан.

4. ХХЯ-ын суурь түвшинг тогтоох ажлын хүрээнд төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон 3000 гаруй барилгын эрчим хүчний хэрэглээнд үндэслэн, аргачлалын дагуу ХХЯ-ын суурь түвшнийг тогтоосон.

5. ЭХХ-тэй технологийн өртөг, үр нөлөөний тооцоог хийх ажлын хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй технологийн өртөг, үр нөлөөг тооцох аргачлал, загвар боловсруулж, технологийн сонголт бүрээр өртөг үр нөлөөний шинжилгээний муруйг боловсруулан дүн шинжилгээ хийсэн. Бодлого боловсруулагч, технологи үйлдвэрлэгч, нэвтрүүлэгч болон хөрөнгө оруулагчдад танилцуулж, хэлэлцүүлсэн.

6. Барилгын эрчим хүчний үр ашгийг сайжруулах, эрчим хүчний хэмнэлт гаргах тал дээр бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч албан тушаалтнуудын чадавхыг сайжруулах чиглэлээр Словак улсын Братислав хотноо туршлага судлах хөтөлбөрт БХБЯ, ЭХЗХ, УБХЗАА, НҮБХХ, ДДНХБ, ОСНААУГ, НАМА төслөөс хамрагдан, Словак улсын орон сууц болон төрийн өмчит барилгын өнөөгийн нөхцөл байдал, хуучин барилгыг дулаалах, засвар үйлчилгээ эрхлэх хууль эрх зүйн орчин, барилгын шинэчлэл хийх, шинэчлэлийг санхүүжүүлэх арга замуудын талаар туршлага судалж ирсэн.

7.Төслийн хүрээнд дараах загвар төслүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд: Говь-Алтай аймгийн Жаргалан сумын сургуулийн дээврийн дулаалга, дотор халаалтын системийн шинэчлэлт, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын халаалтын системийн шинэчлэлт, Барилгын хөгжлийн төвийн лабораторийн барилгын засвар, Эрчим хүчний зохицуулах хорооны барилгын нарны цахилгаан үүсгүүр суурилуулах загвар төслүүд хэрэгжсэн. Энэхүү загвар төсөл хэрэгжсэнээр 153 сурагч, 36 багш ажилтан, нийт 189 хүн үр шимийг нь хүртсэн байна.

Дараах 7 арга хэмжээний хэрэгжилт 0-40 хувьтай байна. Үүнд:

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ тоо	Биелэлт /хувиар/				%	
			100%	70%	40%	0%		
1	1-р зорилт. Барилгын салбарын ЭХ-ний хэрэглээ, ХХЯ-ын	1.1.Хүлэмжийн хийн тооллогын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжих байгууллагуудын мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх	2	2	-	-	-	91.4
2	тооллогын тогтолцоог бий болгох, суурь түвшинг тодорхойлох	1.2.Барилгын салбарт мэдээллийн хүртээмж боловсронгуй арга зүй бүхий төлөвшсөн, бүрэн ажиллагаатай ЭХ-ний хэрэглээ, хяналт, ХХТТогтолцоог бий болгох	4	2	2	-	-	
3		1.3.Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлыг суурь түвшинг тодорхойлох, тогтоох	1	1	-	-	-	
1-р зорилтын хэрэгжилт			7	5	2	-	-	
4	2-р зорилт. Барилгын салбарт тэргүүн ээлжинд	2.1. Барилгын салбарт тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх ХХЯ-г бууруулах арга хэмжээг тодорхойлох	2	-	2	-	-	74.3
5	хэрэгжүүлэх ХХЯ-г бууруулах арга хэмжээг тодорхойлох,	2.2. ХХЯ-г бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд гол оролцогч талуудын хоорондын уялдаа бүхий үйл ажиллагааны зохистой бүтцийг бүрдүүлэх	3	1	-	2	-	
6	хөгжүүлэх, загвар төсөл санхүүжүүлж, хэрэгжүүлэх	2.3. Үндэсний арга хэмжээг амжилттай боловсруулан хэрэгжүүлэх, санхүүжүүлэх чиглэлээр төр ба хувийн хэвшлийн оролцогчдын чадавхийг бэхжүүлэх	4	3	1	-	-	
7		2.4. Барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй загвар арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.	3	2	1	-	-	
8		2.5. Барилгын салбарт ХХЯ-г бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг дэмжих санхүүгийн арга хэрэгсэл боловсруулах	2	-	-	2	-	
2-р зорилтын хэрэгжилт			14	6	4	4	-	
8	3-р зорилт. ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааны үр дүнг хэмжих, тайлагнах, нотлох тогтолцоог бий болгох	3.1. Барилгын салбарт тохирсон ХТН системийг боловсруулах, хэрэгжүүлэх	2	-	1	-	1	75
9		3.2. ХХЯ-ыг бууруулах үндэсний арга хэмжээнд ХТН тогтолцоог хэрэгжүүлэх, институтын бүтцийг бэхжүүлэх зорилгоор чадавхи бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.	8	6	-	2	-	
3-р зорилтын хэрэгжилт			10	6	1	2	1	
НИЙТ ДҮН			31	17	7	6	1	80.2

1. Төлөвлөгөөний /3.2.2/ “Хүлэмжийн хийн үзүүлэлтүүдийг хэмжих, тайлагнах, нотлох тогтолцооны стандарт, арга зүй боловсруулах”, /0%/

2. Төлөвлөгөөний /2.2.1/ “ХХЯ-ыг бууруулах арга хэмжээний бүтэц зохицуулалтын олон улсын туршлага, үндэсний нөхцөл байдлыг судлах, оновчтой зохицуулалтыг санал болгох”, /40%/

3. Төлөвлөгөөний /2.2.2/ “ХХЯ-ыг бууруулах арга хэмжээний бүтэц зохицуулалтад оролцогч талуудын үүрэг ролийг тодорхойлох”, /40%/

4. Төлөвлөгөөний /2.5.2/ “Эрчим хүчний хэмнэлтийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг дэмжих санхүүгийн хэрэгслийг хэрэгжүүлэх, загварчлах, /40%/

5. Төлөвлөгөөний /2.5.3/ “Барилгын эрчим хүчний хэмнэлтийн төв болон Хас банктай хамтран ЭХХ-ийн арга хэмжээг үнэлэх санхүүгийн байгууллагуудад зориулсан удирдамж, аргачлал боловсруулах, /40%/

6. Төлөвлөгөөний /3.3.1/ “Хэмжих, тайлагнах, нотлох асуудал хариуцсан ажилтнуудын хэрэгцээг тодорхойлох үнэлгээ хийж, тэдний чадавхийг бэхжүүлэх, хөтөлбөр боловсруулах, /40%/

7. Төлөвлөгөөний /3.3.3/ “Сургалтад оролцогсдын дунд явуулах чадавхи бэхжүүлэх сургалтын дараах үнэлгээг боловсруулж, хэрэгжүүлэх, /40%/

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төсөл нь 3 зорилтын хүрээнд нийт 31 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай арга хэмжээ 17, 70 хувьтай арга хэмжээ 7, 40 хувьтай арга хэмжээ 6, 0 хувьтай арга хэмжээ 1 байгаа бөгөөд төслийн хэрэгжилтийн түвшин **80.2** хувь, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.

Энэхүү төсөл нь барилгын салбараас ялгарах хүлэмжийн хийн тооллогын аргачлалыг батлуулан, тооллогын цахим системийг бий болгож, барилгын инженер, архитекторуудад барилгын эрчим хүчний хэмнэлт, дулаан алдагдлын чиглэлээр сургалт зохион байгуулж, загвар төслүүдийг хэрэгжүүлсэн нь барилгын салбарт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах НҮБ-ийн суурь конвенцыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ.

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан 0-40 хувийн хэрэгжилттэй дээрх 7 арга хэмжээг 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, Төслийн дараагийн үе шатыг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллахыг төслийн нэгж /Б.Хишигжаргал/-д үүрэг болгох,

2. Төслийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг, бодлогын удирдамжаар ханган ажиллахыг яамны газар, хэлтсүүдэд /Ц.Баярбат, О.Лхагвацэдэн, Б.Алтайбаатар, С.Должинсүрэн/ нарт даалгах,

3. Төсөл хэрэгжиж дуусч буйтай холбогдуулан төслийн хүрээнд гаргасан тушаал, шийдвэр, баримт материалыг архивын нэгж болгон холбогдох архивт хүлээлгэн өгөх.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>Төслийн нэр: "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"</p> <p>Шийдвэрийн огноо, дугаар:</p> <p>1. Монгол Улсын Засгийн газрын 2017.11.15-ны өдрийн "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 311-р тогтоол;</p> <p>2. Сангийн сайдын 2019.02.14-ний өдрийн "Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай" 24 дүгээр тушаал;</p> <p>3. Барилга, хот байгуулалтын сайдын 2019.06.10-ны өдрийн "Төслийн удирдах хороо байгуулах тухай" 106 дугаар тушаал;</p> <p>Төслийн зорилго: Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн зорилго нь цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Монгол Улсын чанарын стандартыг хангасан усыг байгальд нийлүүлэх, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.</p>			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв, хөнгөлөлттэй зээл: БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 1.0 /нэг/ тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих" төслийн нийт өртөг 262.7 сая ам.доллар, үүнээс Монгол Улс: 5% буюу 13.1 сая ам.доллар; БНХАУ: 95% буюу 249.6 сая ам.доллар			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам			
4	Төслийн зорилтууд	Зорилт 1. Зураг төсөл, барилга угсралтын ажил			
		Зорилт 2. Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалт			
		Зорилт 3. Сургалт, туршилт тохируулга, ашиглалтанд оруулах			
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	262.7 сая ам.доллар		
		Үүнд:	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
		БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл	249.6 сая ам.доллар	-	0%
		Монгол улсын төсөв	35.6 тэрбум төгрөг	0.63 тэрбум төгрөг	2%
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:				
	1-р зорилтын хүрээнд: Зураг төсөл, барилга угсралтын ажил	<p>Үр дүн 1.1-ийн хүрээнд: 1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: Төслийн зураг төсөл боловсруулах ажлыг БНХАУ-ын "Шанхай хотын инженерийн зураг төслийн институт" ХХК гүйцэтгэж Монгол Улсын БНБД бусад стандартад нийцүүлэн зургийг монгол хэл дээр хөрвүүлэх ажлыг Монгол Улсын "Сивил инженеринг консалтинг" ХХК, "Криетив монголиа" ХХК-ийн түншлэл гүйцэтгэж байна. Барилгын эх загвар зурагт 2019 оны 9-р сарын 12-ны өдрийн ЭЗ-5/2019 тоот магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулан загвар зургийн хамт эхний ээлжинд азротенкийн байгууламжийн буурь, суурийн хэсгийн зургийг батлуулсан ба ажлын зураг төсөлд шаардагдаж буй цахилгаан, дулаан, холбооны техникийн нөхцлүүдийн хугацааг сунгуулсан. Мөн барилгын талбай дээр инженер геологийн судалгаа хийгдэж магадлалын ерөнхий дүгнэлтийн хүрээнд талбайн буурь хөрсний хяналтын №19/045 тоот акт боловсруулагдан баталгаажсан ба байгууламжийн орц гарц гаргах талбайн газрыг чөлөөлүүлж газрын координатыг баталгаажуулсан.</p>			

	Хүрэх үр дүн 1: Эх загвар зураг, ажлын нарийвчилсан зургийг боловсруулан батлуулах	Барилга угсралтын ажлын хүрээнд 2019.09.27-ны өдөр бохир ус цэвэрлэх, төмөр бетон хийцтэй, онцгой төвөгшилтэй барилга байгууламж дээр барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг авч 120м3/цаг-ийн хүчин чадалтай бетон зуурмаг үйлдвэрлэх узелийн угсралтын ажил 100%, төслийн ИТА болон ажилчдын түр барилгын ажил 70%, эхний ээлжийн барилга угсралтын ажил болох биологи цэвэрлэгээний талбайн хөрс хуулалтын ажил 50%, барилгын суурийн хөрс хуулалтын ажил 30%, хөрсний даацын хэмжилт болон ул хөрсний нягтруулалтын ажил хийгдэж биологи цэвэрлэгээний С хэсгийн нийт 800м3 М400 маркийн ул бетон цутгалтын ажил 5% хийгдээд байна. Мөн биологи цэвэрлэгээний байгууламжийн талбай дээр инженер геологийн судалгааны дагуу гүний усны түвшин доошлуулах 32 цооног өрөмдөж ул бетон цутгах бэлтгэл ажлыг ханган 10-р сарын 23-ны өдөр бетоныг хөлдөхөөс хамгаалах хучилтыг хийж талбайг өвлийн горимд оруулж хамгаалалт хийгдээд байна.				
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Дүгнэлт: Төслийн 2019 оны хэрэгжилт 90 хувьтай, тухайн жилд төлөвлөсөн ажлуудаа “үр дүнтэй” хэрэгжүүлэн ажилласан гэж үнэлэв.</p> <p>Анхаарах асуудлууд: Монгол Улсын Сангийн яам болон БНХАУ-ын ЭКСИМ банкттай хийх санхүүжилтийн зээлийн гэрээг байгуулахад дэмжлэг үзүүлэх, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр ханган ажиллах,</p> <p>- Төслийн 2019 оны төлөвлөгөөнд туссан боловч удаашралтай байгаа ажлуудад анхаарч, 2020 оны төлөвлөгөөнд тусгах, төслийн хэрэгжилтийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулж, төслийг батлагдсан графикайн дагуу хэрэгжүүлж ажиллах.</p>				
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийг амжилттай, хугацаанд нь хэрэгжүүлэхэд Сангийн яаманд БНХАУ-ын ЭКСИМ банкттай зээлийн гэрээ байгуулахад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж өгөх, Барилга, хот байгуулалтын яамнаас барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авах, БОАЖЯ-тай байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ батлуулах, Эрчим хүчний яам болон "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-тай хамтран цахилгаан, дулаан болон холбооны техникийн нөхцөлүүдийн хугацааг сунгуулах ажлуудыг хамтран хэрэгжүүлсэн. Нийслэлийн ЗДТГ болон СХД-ийн газрын албатай төслийн орц, гарцны асуудлаар хамтран ажиллаж орц, гарцны газрын солбицол, координатыг баталгаажуулах, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас төслийн зуурмагийн узельд мэргэжлийн хяналтын дүгнэлт гаргуулах, Ус сувгийн удирдах газар болон Төв цэвэрлэх байгууламжтай хамтран шинэ захын насосны станцын барилга байгууламжийн шинэчлэл, шинээр барих асуудалд дүгнэлт өгөх, 2018 онд МХЕГ-аас тус байгууламж дээр хийгдсэн ажлын хэсгийн дүгнэлттэй танилцах ажлуудыг тус тус хийсэн. "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-аас Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын нэгтгэсэн дүгнэлт, бетон зуурмагийн тохирлын үнэлгээ, технологийн зааврыг боловсруулан зохих зөвшөөрлийг авч БМСШЛабораториор сорил, шинжилгээний дүнг баталгаажуулсан зэргээс үзэхэд төсөл хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаа сайн байна.				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		90.00%	3	90%	-	
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ				
	(ЗГХЭГ-ын үнэлгээ)	... %				

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ
ШИНЭЭР БАРИХ ТӨСӨЛ” -ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

2019.12.20

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн зорилго: Улаанбаатар хотод төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Монгол Улсын чанарын стандартыг хангасан хаягдал усыг байгальд нийлүүлэх, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ
Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам
Хэрэгжих хугацаа: 2019-2023 он
Төслийн нийт өртөг: 262,7 сая ам.доллар

Төслийн зорилтууд:

- Зорилт 1. Зураг төсөл, барилга угсралтын ажил;
- Зорилт 2. Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалт;
- Зорилт 3. Сургалт, туршилт тохируулга, ашиглалтанд оруулах.

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн эхний үе шат механик цэвэрлэгээний байгууламжийг 1964 онд, анхдагч тунгаагуурыг 1968 онд, биологи цэвэрлэгээний үе шатыг 1978 онд тус тус барьж ашиглалтад оруулсан.

Дани, Испани, Голланд улсуудын санхүүжилтээр цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг хэсэгчлэн шинэчилсэн боловч үйлдвэрийн бохир усыг урьдчилан

цэвэрлэлгүй нийлүүлдэг, лагийг боловсруулдаггүй зэрэг шалтгааны улмаас бохир усыг бүрэн цэвэрлэлгүй Туул голд нийлүүлэн байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, Улаанбаатар хотод үнэр тархаах болсон.

Иймд Монгол Улсын засгийн газрын 2017 оны 311 дүгээр тогтоолоор “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгуулахмжийг шинээр барих төсөл”-ийг БНХАУ-ын Засгийн газрын 1,0 тэрбум ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Шинэ цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ-г Францын “Артелла Вил энд Транспорт компани” боловсруулсан бөгөөд түлхүүр гардуулах гэрээний нөхцлөөр зураг төсөл боловсруулах, барилгын ажил, тоног төхөөрөмж суурилуулах ажлын ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Чайна Тисижу сивил инженеринг групп” шалгарсан.

Цэвэрлэх байгууламжийн барилгын болон технологийн нарийвчилсан зураг төслийг Шанхай хотын “Инженерийн зураг төсөл” ХХК гүйцэтгэж, зургийг монгол хэл дээр хөрвүүлэх ажлыг “Сивил инженеринг консалтинг” ХХК-ийн түншлэл гүйцэтгэж байна.

ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төсөл нь цэвэрлэх байгууламж, насос станц, дулааны болон бохирын шугам сүлжээ шинэчлэх, төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх гэсэн 3 зорилтын хүрээнд ажилласан байна.

Төслийн 2019 оны хэрэгжилт 90 хувьтай, тухайн жилд төлөвлөсөн ажлуудаа хэрэгжүүлэн ажилласан гэж үнэлэв.

Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт /хувь/		Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
2019 оны төлөвлөгөөний биелэлт	90%	3	90	-	-	

БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан 2019 төлөвлөгөөний биелэлт:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хугацаа		Үнэлгээ /хувь/				
		Эхлэх	Дуусах	100	70	30	0	ХБ-гүй
1	Төслийн нэгж байгуулах	2019.07.01	2019.12.31	1				
2	Ажилтан, зөвлөх авах	2019.07.01	2019.12.31			1		
3	Төслийн данс нээлгэх	2019.07.01	2019.12.31	1				
4	Эх загвар зураг төсөл батлуулах	2019.07.01	2019.09.30	1				
5	Усны чанар, технологийн судалгаа	2019.07.01	2019.07.31	1				
6	Геодези, геологийн судалгаа	2019.07.01	2019.09.05	1				
7	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нийгмийн нөлөөллийн үнэлгээ	2019.07.01	2019.12.31			1		
8	Газар шорооны ажил	2019.08.01	2019.12.31			1		

9	Суурийн зураг төсөл	2019.08.01	2019.12.31			1		
10	Барилга бүтээцийн зураг төсөл	2019.08.01	2019.12.31			1		
11	Барилга архитектурын зураг төсөл	2019.08.01	2019.12.31			1		
12	Ариутгах татуургын тон.төх-ийн зт	2019.09.15	2019.12.31			1		
13	Лаг боловс.тон.төх-ийн ЗТөсөл	2019.09.15	2019.12.31			1		
14	Үнэр дарах систем ЗТ	2019.09.15	2019.12.31			1		
15	Цах. Автоматжуулалтын ЗТ	2019.09.15	2019.12.31			1		
16	Арматур, хэв хашмал бэлтгэх байр	2019.07.01	2019.09.15			1		
17	Талбайн кемп барих бэлтгэл ажил	2019.07.01	2019.12.31		1			
18	Ажлын байрны тон.төх-ийн байг-лалт	2019.07.01	2019.12.31		1			
19	Талбайн кемп барих	2019.07.01	2019.10.31		1			
20	Нэвтрэх зам	2019.07.01	2019.08.31	1				
21	Арматур хэв хашмал бэлтгэх байр	2019.07.01	2019.10.31			1		
22	Бетон зуурмагийн узель	2019.07.01	2019.09.30	1				
23	Барилгын ажлын ус, цахилгаан хангамжийн байгууламж	2019.07.01	2019.09.30	1				
24	Суурийн нүх ухах	2019.07.01	2021.07.30	1				
25	Технологийн байгууламжийн суурийн нүх	2019.08.01	2021.07.30	1				
26	Технологийн байгууламжийн суурийн ажлын 5%	2019.08.10	2019.12.31				1	
				10	3	12	1	
Дундаж үнэлгээ				90 %				

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Төслийн зураг төсөл боловсруулах ажлыг БНХАУ-ын "Шанхай хотын инженерийн зураг төслийн институт" ХХК гүйцэтгэж, барилгын эх загвар зурагт 2019 оны 9-р сарын 12-ны өдрийн ЭЗ-5/2019 тоот магадлалын ерөнхий дүгнэлт гарсан.

-Барилгын талбай дээр инженер геологийн судалгаа хийгдэж магадлалын ерөнхий дүгнэлтийн хүрээнд талбайн буурь хөрсний хяналтын №19/045 тоот акт гарсан.

-Төслийн зураг төслийг боловсруулахад шаардагдах цахилгаан, дулаан, мэдээлэл холбооны техникийн нөхцлүүдийг авч зургийн компаниудад хүргүүлсэн.

-Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2019 оны 9-р сарын 27-ны өдөр авч, дараах ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд:

-120м3/цаг-ийн хүчин чадалтай бетон зуурмаг үйлдвэрлэх узелийн угсралтын ажил 100%,

-төслийн түр барилгын ажил 70%,

- биологи цэвэрлэгээний талбайн хөрс хуулалтын ажил 50%,

- барилгын суурийн хөрс хуулалтын ажил 30%,

- хөрсний даацны хэмжилт болон ул хөрсний нягтруулалтын ажил хийгдэж биологи цэвэрлэгээний С хэсгийн нийт 800м3 М400 маркийн ул бетон цутгалтын ажил 5%,

-биологи цэвэрлэгээний байгууламжийн талбай дээр инженер геологийн судалгааны дагуу гүний усны түвшин доошлуулах 32 цооног өрөмдөж ул бетон цутгах бэлтгэл ажлыг ханган бетоныг хөлдөхөөс хамгаалах хучилтыг 10-р сарын 23-ны өдөр хийж талбайг өвлийн горимд оруулж хамгаалалт хийгдээд байна.

Төслийн хүрээнд дараах ажлын хэрэгжилт хангалтгүй, 30 хувьтай байна. Үүнд:

- Төслийн байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийлгэж, баталгаажуулах,

- Барилга архитектурын зураг төсөл, Ариутгах татуургын тоног төхөөрөмжийн зураг төсөл, лаг боловсруулах тоног төхөөрөмжийн зураг төсөл, үнэр дарах системийн зураг төсөл, цахилгаан автоматжуулалтын зураг төслийг тус тус боловсруулж, батлуулах.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төслийн 2019 оны хэрэгжилт 90 хувьтай, тухайн жилд төлөвлөсөн ажлуудаа “үр дүнтэй” хэрэгжүүлэн ажилласан гэж үнэлэв.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Монгол Улсын Сангийн яам болон БНХАУ-ын ЭКСИМ банктай хийх санхүүжилтийн зээлийн гэрээг байгуулахад дэмжлэг үзүүлэх, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр ханган ажиллахыг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/, Санхүүгийн хэлтэс /С.Должинсүрэн/ нарт даалгах,

- Төслийн 2019 оны төлөвлөгөөнд туссан боловч удаашралтай байгаа дээрхи ажлуудад анхаарч, 2020 оны төлөвлөгөөнд тусгах, төслийн хэрэгжилтийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулж, төслийг батлагдсан графикайн дагуу хэрэгжүүлж ажиллахыг төслийн нэгж /Т.Болорчулуун/-д үүрэг болгох.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	Төслийн нэр: “Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1008 айлын орон сууцны хотхон” төсөл Шийдвэр: •УИХ-ын 2010 оны 36-р тогтоолын хавсралт •Засгийн газрын 2016 оны 174-р тогтоол •Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр •УБ хотын 2020 оны хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө •Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр “Солилцох захидал” - 2019.04.25 •Монгол Улсын УБ хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх “Протокол” 2019.07.26			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгө Монгол улсын төсвийн хөрөнгө			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам			
		Хэрэгжих нийт хугацаа: 2019.04.01- 2022.10.30			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт-1. Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн техник эдийн засгийн үзүүлэлт, зургийн даалгавар батлуулах, ажлын зураг төсөл, төсөв боловсруулахад хяналт тавьж хамтран ажиллах			
		Зорилт-2. Барилгажих талбайн бэлтгэл ажил, газар чөлөөлөх			
		Зорилт-3. Тендерийн баримт бичиг боловсруулах, гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах			
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	347,400,000 юань		
		Үүнд:	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
		БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл	132,0 тэрбум төгрөг	-	0%
		Монгол улсын төсөв	7.42 тэрбум төгрөг	0.34	2%
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:				
	1-р зорилтын хүрээнд: Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн ТЭЗҮ, зургийн даалгавар батлуулах, ажлын зураг төсөл, төсөв боловсруулах Хүрэх үр дүн 1: Эрх зүйн баримт бичгүүдийг батлуулах	Үр дүн 1.1-ийн хүрээнд: Сангийн Яам, БХБЯ-ны сайдын 2019 оны 2 дүгээр сарын 15-ны өдрийн хамтарсан 27/30 тоот тушаалаар Төсөл хэрэгжүүлэх нэгжийн орон тооны бүтцийг батлав. -Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр “Солилцох захидал”-ыг үзэглэв. -БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, БНХАУ-ын Бугат хотын буцалтгүй тусламжийн албаны дарга Ли Юун Жан нар “Монгол Улсын Улаанбаатар хотын Гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай Төсөл хэрэгжүүлэх “Албан протокол”-д 2019 оны 7 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурж батлав.			

Хүрэх үр дүн 2. ТЭЗҮ, ажлын зураг төсөв боловсруулж дуусгах

БХБЯ-ны сайдын 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Зураг төсөл боловсруулах ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөө”-г удирдлага болгон ажиллав. -Төслийн барилга угсралт болон зураг төслийн ажлуудад нийслэлийн төр захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллалаа. Мөн Нийслэлийн Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн А/804 тоот захирамжаар Нийслэлийн Засаг даргын орлогч Мөнгөншагайгаар ахлуулсан хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тус ажлын хэсэгт Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч, барилгын инженер нар орж ажиллав. - БХБЯ-аас Сүхбаатар дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэр дэх 3,8 га талбайд баригдах 1008 айлын орон сууцны хорооллын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг 2019 оны 5-р сард зарлагдаж, Барилгын зураг төслийн “Интеллект тауэр” ХХК-ийг сонгон шалгарч зураг төслийн ажил гүйцэтгэсэн. -Ажлын зураг төсөл боловсруулахад шаардагдах гадна инженерийн шугам сүлжээний холбогдох 8 техникийн нөхцөлийн ачааллыг тооцуулан, харьяа яам, агентлаг болон Нийслэлийн мэргэжлийн байгууллагуудад албан хүсэлт гаргах, БХБЯ-ны техникийн нөхцөлийн комиссын хурлаар нь хэлэлцүүлэх, холбогдох баримт бичгийг хүлээн авч, зураг төсөл, төсвийг хугацаа алдалгүй бэлэн болгов. Үүнд:

ЭХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын “Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны нутагт баригдах 1000 айлын түр суурьших орон сууцны хороолол, сургуулийн барилгын цахилгаан хангамжийн зураг төсөл боловсруулах даалгавар” 2019.07.31-ны 1019/4-79 дугаар Ажлын хэсгийн дарга бөгөөд эрчим хүчний яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын “Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутагт баригдах 1008 айлын түр суурьших орон сууцны хороолол, сургуулийн барилгын цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн сунгалт” 2019.07.01-ны 34с/2019/87 дугаар Эрчим хүчний яамны бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын техникийн нөхцөл /Халаалт, хэрэгцээний халуун ус, салхилуулга 6в магистраль, ДХ642 дугаартай худгаас холболттой Дэнжийн 1000-ын салаанаас тусдаа шугам татаж ДДТ суурилуулан холбох. /2019.07.01 № 16/2019/ Ус сувгийн удирдах газрын техникийн нөхцөл 142/17 тоот техникийн нөхцөлийг үндэслэв. Цэвэр, бохир усны холболт /2019.06.28 №367/19/ Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээний төрийн өмчит хувьцаат компанийн /шугам, дэд станц зөөх/ техникийн нөхцөл 2019.08.16 №15/03159/19 Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээний төрийн өмчит хувьцаат компанийн техникийн нөхцөл /Шинэ холболт 630кВт/ 2019.08.16 №15/03158/19 Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны техникийн нөхцөл /Телефон тоо (ширхгээр)/ 2019.06.12 № ТН-D406/2019 Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны техникийн нөхцөл /Агаарын багана, кабель шугамын байгууламжийг шилжүүлэх /2019.08.26 №ТН-С603/2019. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дарга, зураг төслийн компанийн инженерүүдийн хамтарсан баг 2019 оны 10 дугаар сарын 24-ны өдөр БНХАУ-ын Бугат хотод зорчиж, ажлын зураг, төсөв /А3 форматаар хэвлэсэн нийт 1500 гаруй хуудас/ баримт бичгүүдийг биечлэн хүлээлгэж өгөв.

	<p>2-р зорилтын хүрээнд: Барилгажих талбайн бэлтгэл ажил, газар чөлөөлөлт, бусад. Хүрэх үр дүн: Барилгын талбайг бэлтгэх</p>	<p>Барилгажих талбайн бэлтгэл ажил, газар чөлөөлөлт, бусад. Барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт тавих Монгол болон Хятад талын инженер техникийн ажилтнуудын түр байр /контор/-ны газар шороо, нил бетон суурь /47м3/ цутгаж бэлэн болгов.Инженер техникийн ажилтнуудын ариун цэврийн өрөөг бетон шугаман суурь цутгаж, 2.4м*6м хэмжээтэй төмөр чингэлэгийг дулаалга хийж өнгөлгөөний материалаар хана, дээврийг нь өнгөлөн, 3тн нөөц усны сав, суултуур-2ш, ханын хөтөвч-1ш, угаагуур-1ш тус тус тоногдсон эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөөг хийлгэв. Бохир усны 20м3-ийн төмөр савыг 3м гүнд суулгах, ф150мм хуванцар хоолой-40м, ф100мм хуванцар хоолой 8м-ийг тус тус дулаалгатайгаар угсарч, төмөр бетон худгийн хамт хийж гүйцэтгэв. Тус цооног нь ариун цэвэр эрүүл ахуйн хувьд битүүмжлэл сайтай, байгаль экологид сөрөг нөлөөгүй, хөрсний бохирдол үүсгэхээргүй, бохирыг соруулж зайлуулахаар тооцож хийсэн болно. Түр цэвэр усан хангамжийн хувьд 500мм-ийн төв шугамаас огтолгоо авч төмөр бетон худаг-1ш, 150м хуванцар хоолойг 1,3-3,1 м гүнд угсарч, дулаалан хийж гүйцэтгүүлэв. Барилгын талбай руу төв замаас орох автомашины орц гарц дээрх холбооны тулгуур шон, түүнд холбогдсон кабель шугамыг буулган орцыг чөлөөлөв. БНХАУ-ын Зээл тусламжийн агентлагийн дэд дарга, Бугат хотын буцалтгүй тусламжийн алба болон менежментийн компанийн төлөөлөгчидийн 5 удаагийн ажлын айлчлал хийсэн бөгөөд энэхүү айлчлалаар зураг төсөл, төсөв, тендерийн баримт бичиг боловсруулах, барилгын талбай бэлтгэх ажлуудыг танилцуулах, санал солилцох, холбогдох яам, байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзах уулзалт, хурал, зөвлөгөөн зохион байгуулах зэргээр байнга хамтран ажиллалаа.</p>				
7	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, асуудлууд) (ололт, анхаарах асуудлууд)</p>	<p>Дүгнэлт: Төслийн 2019 оны хэрэгжилт 85 хувьтай, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв. Ололттой тал: 1. Төсөл хэрэгжүүлэх нэгжээс санаачлан Нийслэлийн холбогдох байгууллагуудыг оролцуулсан “Ажлын хэсэг” байгуулсан нь зураг төслийн болон барилгын талбай бэлтгэх ажлын явцыг түргэтгэхэд нэлээд ач холбогдолтой ажил байв. 2. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд газар чөлөөлөлтийн асуудлаар газар эзэмшигч айлуудтай биечлэн очиж уулзан, төсөл хөтөлбөрийнхөө талаар танилцуулсан нь иргэдэд нааштай хандлагыг бий болгон гацаанд байсан газар чөлөөлөлтийн асуудал шийдэгдэхэд чухал ач холбогдолтой ажил байв. 3. БНХАУ-ын менежментийн компани болон Зураг төслийн гүйцэтгэгч байгууллагатай нягт нээлттэй хамтран ажилласны үр дүнд зураг төсөлтэй холбоотой асуудлууд эцэслэгдэн шийдвэрлэгдэж тухай бүр уулзалт зохион байгуулж, саналын зөрүүг арилган барилга угсралтын ажил эхлэх нөхцөл бүрдэв.</p>				
8	<p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>	<p>Барилга, хот байгуулалтын яам болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн хамтын ажиллагаа хэвийн байна.</p>				
9	<p>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)</p>	<p>Биелэлт дундаж</p>	<p>Зорилтын тоо</p>	<p>Зорилт 1</p>	<p>Зорилт 2</p>	<p>Зорилт 3</p>
		<p>85%</p>	<p>3</p>	<p>100%</p>	<p>70%</p>	<p>ХБ-гүй</p>
10	<p>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)</p>	<p>Нэгдсэн үнэлгээ ... %</p>				

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**“НОГООН НУУР 1008 АЙЛЫН ОРОН СУУЦ” ТӨСЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

2019.12.21

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1008 айлын орон сууцны хотхон” төслийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн зорилго: Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1008 айлын орон сууцны хотхоныг ил болон далд авто зогсоол, гадна дотор инженерийн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, дэд өртөөний хамт барихад оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БХБЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2019-2023

Төслийн зорилтууд:

Зорилт-1. “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн Техник эдийн засгийн үзүүлэлт, зургийн даалгавар батлуулах, ажлын зураг төсөл, төсөв боловсруулах, Хятадын талтай нэг бүрчлэн санал солилцох, эцэслэн хүлээлгэж өгөх;

Зорилт-2. Барилгажих талбайн бэлтгэл ажлыг хангах, газар чөлөөлөх;

Зорилт-3. Төслийн ерөнхий гүйцэтгэгч компани сонгон шалгаруулах, Тендерийн баримт бичиг боловсруулах, Хятадын талтай санал солилцох, баримт бичигт тусгах.

Төслийн товч танилцуулга:

УИХ-ын 2010 оны 36-р тогтоолын хавсралт, Засгийн газрын 2016 оны 174-р тогтоол, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УБ хотын 2020 оны хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө, 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулагдсан Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын “Солилцох захидал”, 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр байгуулагдсан Монгол Улсын УБ хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх “Албан протокол”-ыг үндэслэн “Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1008 айлын орон сууцны хотхон” төсөл хэрэгжиж байна.

Сангийн сайд болон БХБ-ын сайдын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хамтарсан 27/30 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдсан. БХБ-ын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 70 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн дүрмийг баталсан.

ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төслийн 2019 оны хэрэгжилт 85 хувьтай, төсөл “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж /хувь/	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
	85%	3	100%	70%	ХБ-гүй

Төслийн хүрээнд 2019 онд дараах томоохон ажлууд хийгдсэн. Үүнд:

1.Сүхбаатар дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэрт 3,8 га газарт баригдах 1008 айлын орон сууцны хорооллын ТЭЗҮ, ажлын иж бүрэн зураг төслийг боловсруулж, магадлалаар хянан батлуулсан.

2.Орон сууцны хорооллын ажлын зураг төсөл боловсруулахад шаардагдах цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, мэдээлэл холбооны техникийн нөхцлүүдийг холбогдох газруудаас авч, шугам сүлжээний зураг төслийг боловсруулан, хянуулан батлуулсан.

3.Төслийн ТЭЗҮ, ажлын иж бүрэн зураг төсөл, төсвийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн ажлын алба болон Төслийн менежментийн компанитай хэлэлцэн тохиролцож, 2019 оны 11 дүгээр сард эцэслэн хүлээлгэн өгсөн байна.

4.Төслийн барилгын ажлын бэлтгэл хангах төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, нийт 32 ажил тусгаснаас 20 ажил бүрэн биелсэн байна.

5. Барилгын түр байрны бетон суурийг цутгаж, түр ус хангамж, ариутгах татуургын шийдвэрлэх хүрээнд цэвэр усны төв шугамаас огтолгоо авч 150 м шугам хоолой, төмөр бетон худаг барьж, бохирын 20 м³-ийн төмөр сав суулгасан.

6. Барилгажих талбай дээр байрлаж буй 37 айлын судалгааг хийж, 10 айлын газар чөлөөлөлтөд шаардагдах 2,0 тэрбум төгрөгийг 2020 оны улсын төсөвт тусгуулсан. 3 нэгж талбарыг чөлөөлөхөөр Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийн газар, төслийн нэгж, газар өмчлөгч иргэн нарын хооронд “Газар чөлөөлөх 3 талт гэрээ” байгуулан, газар чөлөөлөлтийн ажил хийгдэж эхлээд байна.

Иймд төслийн газар чөлөөлөлтийн асуудалд анхаарч ажиллан, үлдсэн 3 айлын газрыг барилгын ажил эхлэхээс өмнө чөлөөлөх арга хэмжээ авах шаардлагатай.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1.Төслийн 2019 оны төлөвлөгөөний биелэлт 85 хувьтай, төсөл “хэрэгжих шатанд” гэж үнэлэв.

2. Төслийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангах хүрээнд 2019 онд нийт 32 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 20 ажил бүрэн биелж, төслийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангагдсан байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1.Төслийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг, бодлогын удирдамжаар ханган ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Б.Баярбат/, Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Гантулга/, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /Б.Алтайбаатар/ нарт даалгах;

2.Төслийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллахыг “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн нэгж /Л.Ганбаатар/-т үүрэг болгов.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

10.7 Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан, хамтран ажилах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ХООРОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2020.01.10

Нэг. Зорилго

Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчтай 21 аймаг, Нийслэлийн Засаг дарга нарын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар 2019 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, яамны удирдлагыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Гүйцэтгэлийн түвшинг үнэлсэн байдал

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Нийслэл, 21 аймгийн Засаг дарга нар Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлсэн талаар 2019 оны гэрээний хэрэгжилтийг гаргаж ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, аймаг тус бүрээр энэхүү үнэлгээг гаргалаа.

А. Хангайн бүсийн аймгууд:

1. Архангай аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 69 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 69 арга хэмжээний 36 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 26 арга хэмжээ 70 хувьтай, 6 арга хэмжээ 30 хувьтай байна. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай арга хэмжээ 1, үнэлэх боломжгүй арга хэмжээ байхгүй байна. Хэрэгжилтийн дундаж хувь- 80.8 байна.

Ажлын чиглэл	Үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%			
Хот байгуулалтын чиглэлээр	79.1	6	5	-	-1	-	12	
Газрын харилцааны чиглэлээр	80.5	11	6	3	-	-	20	
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	82.9	10	5	2	-		17	
Нийтийн аж ахуйн чиглэлээр	78.0	4	5	1	-	-	10	
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	88.75	5	3	-	-	-	8	
Бусад	70.0		2	-	-	-	2	
Дүн /Архангай/		36	26	6	1	-	69	

БХБСайд, Архангай аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /7/ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахаар Барилга, хот байгуулалтын яаманд гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлагдсаны дүнд Барилгын зураг төсөл, зөвлөх үйлчилгээний “Өрх” ХХК шалгаран бүх шатны хэлэлцүүлгийг ард иргэд, аймгийн удирдлагууд болон мэргэжлийн хэлтэс, агентлагын хүрээнд зохион байгуулсан байна. Аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгаагаар бүрэн хангаж ажилласан бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 сарын 02-ны өдрийн ээлжит долоодугаар хуралдааны А/12 дугаар тогтоолоор “Цэцэрлэг хотын 2038 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г батлуулсан байна.

2. /14/ Газар эзэмших ашиглах эрхийн дуудлага худалдааг Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тогтоолын дагуу анхны үнийг тооцож аймгийн хэмжээний дуудлага худалдааг бүртгэн 14 сумын 60 байршилд дуудлага худалдаа явуулж орон нутгийн төсөвт 285.973.300 төгрөг төвлөрүүлсэн байна.

3. /19 / 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршлыг аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 06 дугаар, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 119 дүгээр тогтоолоор батлуулсан байна. Үүнд: Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар төрөөс үнэ төлбөргүй нэг удаа 436 иргэнд 34.66 га газрыг, шинээр 18 суманд 359 иргэнд 29.33 га газрыг, эзэмшиж байсан хашааны газраа 9 суманд 69 иргэнд 4.77 га газрыг, улсын чанартай авто замын дагуу 1 суманд 8 иргэнд 0.56 га газрыг өмчлүүлсэн байна.

4. /34/ Аймаг, сум, суурин газруудын одоогоор ашиглагдаж байгаа инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийн тоо хэмжээ, өнөөгийн байдлын судалгааг 19 сумаар гарган ГХБХБГ-ын мэдээллийн санд оруулсан байна. Засвар үйлчилгээ хийгдсэн шугам сүлжээний мэдээллийг шинчлэх, засварлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

5. /45/ Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн дагуу өмчлөл харгалзахгүй барилга байгууламжийг хувийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус онд шинээр ашиглалтанд 18 барилга угсралтын ажил шинээр хувийн хэрэг нээж 19 барилгын их засварын ажилд холбогдох хувийн хэрэгт баяжилт хийн ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

6. / 48/ 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 42 төсөл арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 13 төсөл арга хэмжээ, Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламж өвсний үндэс хөтөлбөрөөр 1 төсөл арга хэмжээ нийт 56 төсөл арга хэмжээнд 49 тэрбум 990.4 сая төгрөг гэрээлэгдэн захиалагчийн хяналт хэрэгжүүлснээс улсын төсвийн 21 төсөл арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн 13 төсөл арга хэмжээ, Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламж өвсний үндэс хөтөлбөрөөр 1 төсөл арга хэмжээ буюу нийт 35 төсөл арга хэмжээний 32 тэрбум 463.3 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажлууд ашиглалтанд орсон байна. Улсын төсвийн 21 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихээр төлөвлөгдсөн байна.

7. /56/ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2 дугаар сургуулийн 960 хүүхдийн хичээлийн байр, Цэнхэр, Хотонт сумдын 240 хүний суудалтай Соёлын төв, Өгийнуур сумын 120 хүүхдийн дотуур байр, Жаргалант сумын 250 хүүхдийн хичээлийн байр, Төвшрүүлэх, Батцэнгэл сумын ЗДТГ-ын конторын барилга, 3-р сургуулийн засвар, Мал эмнэлгийн барилга, Цэцэрлэгт хүрээлэн, Чулуут, Цахир сумдын 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилга, Булган, Тариат сумдын 50 хүүхдийн цэцэрлэг, Булган, Чулуут сумдын Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлын зураг төслүүдийг захиалан гүйцэтгүүлж дууссан байна.

8. /58/ Ус хангамжийн харуул хамгаалалт хараа хяналтыг сайжруулах үүднээс Хяналтын камерыг шинэчлэн шилэн кабель шинээр татсан. Цэцэрлэг хотын удны усны эх үүсвэрийн харуул хамгаалалтыг сайжруулах зорилгоор Тарвуугийн голын усны эх үүсвэрийн байгууламжийн хашааны гадуур Эко нарны зайн гэрэлтүүлгүүдийг шинээр сууриллуулсан байна.

9. /63/ Азийн хөгжлийн банкны зээлээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3388 төсөл”-ийн хүрээнд Цэцэрлэг хотод баригдаж буй цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний барилга угсралтын ажил дуусаж байнгын ашиглалтад хүлээлгэн өгөөд байна. Тус ажлын хүрээнд оффисын барилга, лаг боловсруулах үйлдвэрийн барилга, насос станцын барилга, хүлэмжийн барилга, лагийн талбай, харуулын байр, дэд станцын барилгын ажлууд цогцоороо хийгдсэн. Мөн гүйцэтгэгч компани нэг жилийн турш технологийн туршилт, зүгшрүүлэлтийг хийж инженер, техникийн ажилчдыг дадлагажуулах ажлыг эхлүүлсэн зэрэг ажлууд байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ байна. Үүнд:

1. /11/ Хот, суурин газрын төлөвлөлт болон дахин хөгжүүлэх төслийн боловсруулах хэрэгжүүлэх сургалтанд сумдын засаг дарга, ИТХ, аймаг сумын ЗДТГ-ын удирдлагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулах;

2./20/ Архангай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт суулгах;

3. /25/ Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах;

4. /30/ Газрын тухай хуулийн 58-р зүйлд заасны дагуу хөрс, орчны бохирдол ихээр үзүүлж байгаа Иргэн ААНБ-ын эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулах;

5. /50/ Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл болон Хөдөлмөрийн яамны "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан"-гийн зээлд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн ажлын тайланг гаргах;

6. /55/ Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

7. /61/ "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх; - зэрэг ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг "хэрэгжих шатандаа" буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Санал, зөвлөмж:

1. Тайлан мэдээг гэрээний дагуу тайлагнаж хэвших.

2. Архангай аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын харилцааны чиглэлээр 3 төсөл арга хэмжээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 2 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 1 арга хэмжээ 30 хувийн хэрэгжилттэй байгаа тул нийт 7 арга хэмжээний хэрэгжилтийг нягтлан үзэж 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Баянхонгор аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 67 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 67 арга хэмжээний 47 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 7 арга хэмжээ 70 хувьтай, 8 арга хэмжээ 30 хувьтай байна. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай арга хэмжээ 5, үнэлэх боломжгүй арга хэмжээ байхгүй байна. Хэрэгжилтийн дундаж хувь- 80.1 байна.

Хүснэгт 2

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%			
Хот байгуулалтын чиглэлээр	100.0	11	-	-	-	-	11	
Газрын харилцааны чиглэлээр	74.73	12	1	5	1	-	19	
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	88.8	15	1	1	1	-	18	

Нийтийн аж ахуйн чиглэлээр	60.0	4	2	-	3		9
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	78.7	5	1	2	-	-	8
Бусад	70,0	-	2	-			2
Дүн /Баянхонгор/		47	7	8	5	-	67

БХБСайд, Баянхонгор аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /2/ Баянхонгор сумын “Шинэ суурьшлын бүс”-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө 2019 оны 04 дүгээр сарын 19-ны Аймгийн ИТХ-ын 16/2 дугаар тогтоолоор батлуулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг Баянхонгор сумын Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаж “Шинэ суурьшлын бүс”-д эрчим хүчээр хангах ажлыг хийхээр 200.0 сая төгрөгийн орон нутгийн сангийн хөрөнгөөс шийдэж “Баянхонгор Эрчим хүч”ХК улсын төсвийн хөрөнгөөр 14 ортой эмнэлгийн барилга, 640 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлуудыг гүйцэтгэж байна.

2. /13/ Аймгийн хэмжээнд 2019 оны “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа”-ны орлогын төлөвлөгөө 150 000 000 төгрөг бөгөөд 12 сарын 01-ний байдлаар дуудлага худалдааны орлого 725 621 700 төгрөгийг төсөвт төвлөрүүлээд байна. “Газрын цахим бирж” программыг аймгийн хэмжээнд нэвтрүүлэн барьцаа болон зах зээлийн үнийн мэдээ, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг тухай бүр нь бүртгэн ажиллаж байна. 2019 онд 6 сумд 47 нэгж талбарт газар барьцаалах үйл ажиллагааг, 6 сумд 30 нэгж талбарт зах зээлийн үнийн мэдээг Цахим биржийн системд бүртгэсэн байна. Мөн 2019 оноос өмнөх бүртгэлийн хувьд 20 сумд 614 нэгж талбарын үнийн мэдээ, 20 сумд 1228 барьцааны бүртгэл, үүнээс 248 барьцаа чөлөөлсөн бүртгэлийг нөхөн бүртгэсэн байна.

3. /32/ Баянхонгор сумын хэмжээнд одоогоор ашиглаж байгаа инженер хангамжийн эх үүсвэр, барилга байгууламжийн өнөөгийн байдлын судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийсэн байна.

4. /33/ Шинээр ашиглалтад орж байгаа инженерийн барилга, байгууламж шугам сүлжээний ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудад хүлээлгэн өгч хамгаалалтын зурвас тогтоогдож, ашиглалт, хамгаалалтыг сайжруулан ажилласан байна.

5. /40/ Баянхонгор сумын Номгон 1-р багийн Баян-Ойт цогцолбор сургуулийн хуучин барилгыг нурааж шинээр 250 хүүхдийн бага сургууль, цэцэрлэгийн цогцолборыг барилгыг “Хаш гоёо” ХХК 1.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр барьж ашиглалтад оруулсан байна. “Номундалай” лаборатори сургуулийн 1200 хүүхдийн хичээлийн байрны барилгыг энэ онд шинээр барьж эхлэн 2020 онд ашиглалтад хүлээлгэн өгөх гэрээтэй барилга угсралтын ажлыг “Хаш гоёо” ХХК гүйцэтгэн улсын төсвийн 6.9 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэж байна. Тухайн шинэ барилгыг ашиглалтад орсны дараа хуучин барилгыг нураахаар төлөвлөж байна.

6. /43/ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд

Бууцагаан сумын хуучин сургууль, дотуур байрыг засварлан иргэдийн жижиг дунд үйлдвэрлэлийн бизнес эрхлэх нөхцлийг бүрдүүлсэн байна. Мөн Баянхонгор сумын 12-р байрны дээврийн засвар, 34-р байрны гадна фасадны дулаалга, дээврийн ажпуудыг ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийлгэн барилга байгууламжийн ашиглалтын явцыг сайжруулах арга хэмжээ авсан байна.

7. /47/ Баянхонгор аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 44 бүтээн байгуулалтын ажилд 92 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Үүнээс 2019 онд 44 тэрбум төгрөгний санхүүжилт батлагдаж барилга угсралтын ажлын биелэлт 90%-тай үнэлэгдсэн байна. Барилга угсралтын ажлын хяналтыг ХОХБТХ, ГХБХБГ, БХТөв болон МХГ зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран хяналт хийж, алдаа дутагдлыг тухай бүрд нь шийдвэрлэж ажилласан байна.

8. /48/ Барилга, хот байгуулалтын Сайдын 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/193 тоот тушаалаар батлагдсан "Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм"-ийг өөрийн барилгын материалын лабораторид тохируулан ГХБХБГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 20 өдрийн 21 дүгээр тушаалаар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.

9. /49/ 2019 онд Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас Иргэн Ц.Ганхуяг Хуванцар цонх үйлдвэрлэлийн чиглэлээр 60,0 сая төгрөгний зээлэнд хамрагдсан байна.

10. /50/ Барилгын салбарын инженер техникийн ажилчдад мэдээлэл өгөх норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх чиглэлээр 2019 оны 04 дүгээр сарын 22-нд сургалт зохион байгуулж 30 инженер техникийн ажилчид хамрагдсан байна. Сургалтаар "Барилгын ажил эхлэх зөвшөөрөл авах, комиссоор хүлээлгэн өгөхөд гардаг түгээмэл асуудал", "Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн танилцуулга", "Барилгын лабораторын үйл ажиллагаа танилцуулга", "Стандарчлал тохирлын үнэлгээний тухай хууль", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн орчин" зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийсэн байна.

11. /58/ Баянхонгор сумын Номгон 1-р багийн 18 айлын 3-р байрыг нурааж шинээр 30 айлын орон сууцны барилга барихаар суурийн ажил хийгдсэн байна. Тухайн орон сууцанд амьдарч байсан айлуудад 270,0 сая төгрөгний хөнгөлөлт үзүүлэхээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулан санхүүжилтыг ОНХСангаас шийдвэрлэн олгосон зэрэг ажлууд байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 15 арга хэмжээ байна. Үүнд:

1. /12/ Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн газрыг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа эрхийн зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгах, мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, дуусгах;

2. /16/ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний гөлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3. /17/ 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.;

4. /18/ Баянхонгор аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт суулгах.

5./23/ Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах 2019 онд тооллого хийж байгаа аймгуудаас бусад нь /Дундговиос бусад аймаг/;

6. /24/ Нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах шинээр байгуулагдсан болон өөрчлөлт орсон объектын талаарх мэдээллийг бүрдүүлж геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байх.

7./31/ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх инженерийн дэд бүтцийн ажлуудын судалгаа, зураг төсөл, ТЭЗҮ хийхэд шаардагдах хөрөнгө санхүүжилтийн тооцоо судалгааг гаргаж орон нугийн төсөвт тусгах, инженерийн шугам сүлжээний эх үүсвэрийн судалгаа, зураг төсөл, сум суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж, мэргэжлийн байгууллагуудын саналыг сайтар тусгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж байх.

8. /38/ Инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах;

9. /49/ Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан ‘Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих’ хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл болон Хөдөлмөрийн яамны “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих.

10. /51/ Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах.

11. /60/ Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

12. /63/ Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 209 дүгээр тогтоолыг аймагт хэрэгжүүлэх.

13. /64/ Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “Орон нутгийн удирдлагын бүрэн эрхийн хүрээнд усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох” заалтыг хэрэгжүүлэх;- зэрэг ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатанд” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Санал зөвлөмж:

1. Баянхонгор аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Газрын харилцааны чиглэлээр 6 төсөл арга хэмжээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 2 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 3 арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн чиглэлээр 2 арга хэмжээнүүд 30 хувийн хэрэгжилттэй байгаа тул нийт 14 арга хэмжээний биелэлтийг нягтлан үзэж 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

3. Булган аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **69** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт **69** арга хэмжээний **37** арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, **32** арга хэмжээ 70 хувьтай, **1** арга хэмжээ 30 хувьтай байна. Үнэлэх боломжгүй арга хэмжээ байхгүй байна. Хэрэгжилтийн дундаж хувь- **85.7** байна.

Хүснэгт 3

Ажлын чиглэл	Үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо				Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%		
Хот байгуулалтын чиглэлээр	89.2	5	8	-	-	-	13
Газрын харилцааны чиглэлээр	87,0	14	4	2	-	-	20
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	80.0	6	12	-	-	-	18
Нийтийн аж ахуйн чиглэлээр	90,0	6	3	-	-	-	9
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	88.7	5	3	-	-	-	8
Бусад	70.0	-	2	-	-	-	2
Дүн /Булган/		36	32	2	-	-	70

БХБСайд, Булган аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /3/ Хишиг-Өндөр сумын төвийн ерөнхий төлөвлөгөөнд орон нутгийн төсвөөс 45,0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгчээр “ММ Архитектур” ХХК шалгаран, 2019 оны 07-р сарын 01-нд хүлээлгэн өгсөн байна. Хялганат тосгоны төвийн ерөнхий төлөвлөгөөг “Эрхэт Констракшн” ХХК-тай 60,0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж 2018 онд 10,0 сая төгрөгийг тосгоны төсвөөс, 2020 онд 20,0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэгдэл санхүүжилтийг тосгоны төсвөөс батлуулахаар шийдвэрлэсэн байна.

2. /8/ Аймгийн төвд хэрэгжих ногоон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн уулзалтыг 2019 оны 11-р сард БХБ-ын яаманд зохион байгуулж шаардлагатай мэдээллээр ханган тухай бүрд нь дэмжлэг үзүүлэн ажилласан байна. Орон нутгийн зүгээс төслийн багийнхан, БХБ-ын яамны ХБГХБХЗГ-тай уулзаж Ногоон хөгжлийн үзэл баримтлалд суурилсан хот тосгоны иж бүрэн ерөнхий төлөвлөгөө хийлгэх саналыг танилцуулсан байна.

3. /16/ Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийг вэб хувилбарт нэвтрүүлэхтэй холбогдсон бүсчилсэн /Дархан хот/ сургалтад холбогдох албан тушаалтан, мэргэжилтэн, газрын даамлуудыг хамруулж ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/124 дүгээр тушаалаар 2019 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн Газрын кадастрын мэдээллийн сангийн веб системийг газрын харилцааны үйл ажиллагаанд 100 хувь нэвтрүүлсэн байна.

4. /29/ Бэлчээрийн газарт хортон мэрэгчтэй тэмцэх ажлын хүрээнд Гурванбулаг суманд 15000 га, Могод суманд 6000 га, Хишиг-Өндөр суманд 5000 га, Сайхан суманд 6000 га, Дашинчилэн суманд 18800 га, Рашаант суманд 8000 га талбайд нийт 40800 га талбайд энгийн механик, болон биологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулж улсын төсвөөс 65,2 сая төгрөгийг зарцуулсан байна. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Дашинчилэн суманд 2, Баяннуур суманд 1, Рашаант суманд 1, Гурванбулаг суманд 2, Могод суманд 2, Сайхан суманд 1, Баян-агт суманд 1, Тэшиг суманд 1, Бугат суманд 1 тус тус шинээр худаг гарган тус ажилд нийт 204 сая төгрөгийг зарцуулсан байна.

5. /34/ Булган аймгийн Сайхан сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээний зураг төсөл /Усан хангамж/-ийг “Мон Кузбас” ХХК-аар 28,0 сая төгрөгөөр Цэвэр усан хангамжийн 3572у/м шугам, ус түгээгүүрийн ухаалаг худаг 5ш, 100м3 эзэлхүүнтэй цэвэр усан сан, 116м-ийн гүнээс гаргасан гүний худаг, 160кВА-ийн 10/04кв-ийн КТПН дэд өртөө, 10квийн төмөр бетон агаарын шугам, 0,4кв-ийн кабель шугамын зураг төсөл хийлгэж, экспертизээр батлуулан хүлээн авсан. Зураг төслийн дагуу эхний ээлжинд 800 гаруй метр цэвэр усны шугам, ухаалаг худаг 1ш, 100м3 усан сан, дэд станц, 10/04 кв-ийн шугамын ажлыг 476,0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.

6. /36/ Булган аймгийн Баян-Агт сумын нэгдсэн дулаан эх үүсвэр 2,6мВт, 1,9км дулаан шугам, Сайхан сумын 100м3 цэвэр усны эх үүсвэр, 800м цэвэр усны шугам, ус түгээх 2 байр, Хялганат тосгоны 3,2км дулаан, цэвэр усны шугам, Бугат суманд 100м дулааны шугам, Сайхан суманд 65м дулааны шугамыг ашиглалтад оруулж, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулж, хамгаалалтын зурвасыг тогтоосон байна.

7. /45/ Булган аймагт хэрэгжсэн Улс, орон нутаг, төсөл хөтөлбөр, хувийн хөрөнгө оруулалтын 31 барилга байгууламжид ажил эхлэх зөвшөөрлийг олгож, 41 барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж, байнгын ашиглалтад оруулсан байна.

8. /64/ Булган аймгийн төвд 3000 м3/хоног хүчин чадалтай биологийн цэвэрлэх байгууламж барих ажлыг Азийн хөгжлийн банкнаас 8.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр дэмжигдсэн, төслийн гүйцэтгэгчээр 2019 оны 5 дугаар сард “Заг инженеринг” ХХК шалгарч, ажлын явц 60 орчим хувьтай 2020 оны 10 дугаар сард багтаан ашиглалтад хүлээлгэж өгөх график төлөвлөгөөтэй ажиллаж байна.

9. /65/ Булган аймгийн төвд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 3000 м3/хоног хүчин чадалтай биологийн цэвэрлэх байгууламжийн ажил эхэлж байгаатай холбогдуулан 2, 3 дугаар багийн эхний 3-4 гудамжны айл өрхийг байгаль орчинд ээлтэй боловсон жорлон барих ажлыг санаачлан зураг төсөл боловсруулан Азийн хөгжлийн банкны төслийн нэгжид хүргүүлж 70,000 а.долларын дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэгдсэн ба 2020 оны орон нутгийн төсөвт оролцооны 202,5 сая төгрөг тусгуулсан зэрэг ажлууд байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. /19/ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулах;

2. /20/ “Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”;- зэрэг ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатанд” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Санал зөвлөмж:

1. Булган аймгийн хувьд газрын харилцааны чиглэлээр 2 төсөл арга хэмжээ 30 хувийн хэрэгжилттэй байгаа тул энэ 2 арга хэмжээний биелэлтийг нягтлан үзэж 2019 оны төлөвлөгөөнд тусгуулж ажиллах шаардлагатай байна.

4. Орхон аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 69 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 69 арга хэмжээний 34 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 28 арга хэмжээ 70 хувьтай, 3 арга хэмжээ 30 хувьтай, 4 арга хэмжээ 0 хувьтай, үнэлэх боломжгүй арга хэмжээ байхгүй байна. Хэрэгжилтийн дундаж хувь-**84.1** байна.

Хүснэгт 4

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо				Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%		
Хот байгуулалтын чиглэлээр	89.0	7	4	-	-	-	11
Газрын харилцааны чиглэлээр	85.8	10	9	-	-	-	19
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	65.5	6	7	2	3	-	18
Нийтийн аж ахуйн чиглэлээр	73.6	5	4	1	1	-	11
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	85.0	4	4	-	-	-	8
Бусад	100.0	2	-	-	-	-	2
Дүн /Орхон/		34	28	3	4	-	69

БХБСайд, Орхон аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /3/ Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын хүрээнд Дэнж, Эрдэнэ багт 3.6км, Баянбулаг 0.3км, Булаг багт 0.4км, Даваат багт 2.1км, Наран багт 0.7км, Рашаант багт 0.8км, Цагаанчулуут багт 0.4км авто замын, үерийн хамгаалалтын Баянцагаан багт 1.7км, Шанд, Наран, Рашаант багт 0.85км, Булаг багт 0.4км, Уртын гол багт 0.5км, Шанд багт 0.2км урт далан сувгийн ажлууд хийгдсэн байна. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу 2020 оноос хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудын зураг төсөл боловсруулах орон нутгийн төсөвт тусгагдсан 285.000.000 төгрөгийн хүрээнд 7 барилга байгууламжийн зураг

төслүүдийг эрх бүхий байгууллагуудаар гүйцэтгүүлэн аймгийн ерөнхий архитектороор батлуулсан байна.

2. /4/ Орон нутгийн төсөв 140.2сая төгрөгөөр нийтийн эзэмшлийн 13 байршилд 13830.8м² хотын ногоон байгууламж нэмэгдүүлэх, зүлэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Хотын цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газраас цэцэгт байгууламжид 8 нэр төрлийн 42.3 мянган ширхэг нэг наст ургамлыг хүлэмжинд үрслүүлэн 7 байршилд шилжүүлэн суулгасан байна. Шинээр 93ш буйлс, 90 голт борыг нийтийн эзэмшлийн талбайд нөхөн тарьсан. Орон нутгийн хэмжээнд мод тарих өдрөөр төрийн байгууллагууд болон томоохон аж ахуйн нэгж байгууллагууд хамтран биеийн тамир спортын бүс болох Сархиа уулын хойд энгэрт 84 байгууллагын оролцоотой 1218ш, хот орчмын ногоон бүс Баян-Өндөр уулын урд энгэрт 10 байгууллагын оролцоотой 425ш шинэс, Хүрэнбулгийн аманд Эрдэнэт үйлдвэр ТӨХК 400ш-ийг тус тус, чимээгүй хотын зүүн урд, урд хэсэгт ойн төгөл байгуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин 14 иргэнийг ажлын байраар ханган 300ш, Цагаанчулуутын аманд 600ш, А1001 улсын чанартай авто зам дагуу 668ш мод нийт долоон байршилд 3611ш модыг тарьсан байна.

3./18/ Тайлант онд Баян-Өндөр суманд газар өмчлүүлэх тухай 893 өргөдөл хүлээн авч 765 иргэнд 55.28га, Жаргалант суманд 63 өргөдөл хүлээн авч 38 иргэнд 7.6га газрыг тус тус өмчлүүлсэн байна. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилт /2019 онд иргэнд өмчлүүлэх газар / аймгийн хэмжээнд 111,04% биелсэн байна.

4. / 26/ Газрын харилцаа, геодези, зурагзүйн газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/105 дугаар тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журам”-ын дагуу Баян-Өндөр суманд 2, Жаргалант суманд 5 нийт 7 мониторингийн байнгын ажиглалтын сүлжээний цэг дээр 20725 га бэлчээрийн газрыг хамруулан хийж гүйцэтгэн үр дүнг Газрын мэдээллийн санд 100 % оруулсан байна.

5./35/ 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Гэр хорооллын дэд бүтцийн /Баянбулаг, Булаг, Даваат, Наран, Рашаант, Цагаанчулуут/ ажлын гүйцэтгэгчээр “Хемон констракшн” ХХК шалгарсан ажлын гүйцэтгэл 90%-тай, энэ онд багтааж дуусахаар ажиллаж байна. 2019 онд орон нутгийн 4,6 тэрбум төгрөг, улсын төсвийн 3,4 тэрбум төгрөг, болзошгүй аваарын зардлын 243,7 сая төгрөгийн хөрөнгө тус тус батлагдсан байна.

6. /42/ Барилгын тухай хуулийн 32.1.5-д зааснаас бусад барилга байгууламжийн угсралтын ажилд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгож гэрчилгээ олгох ажлыг дүрэмд заасны дагуу аймгийн ГХБХБГазар эрхлэн гүйцэтгэж дүрмийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. 2019 онд 62 барилгын ажилд эхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгож, барилга угсралтын нэг ажилд үргэлжлүүлэх зөвшөөрөл олгон зөвшөөрлийн гэрчилгээнд тэмдэглэл хийж баталгаажуулан, мэдээллийн санд бүртгэл хөтлөн, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын захиалагчийн хяналтын тайланг Барилгын хөгжлийн төв ТӨҮГТ-т хүргүүлэн ажилласан байна.

7. /46/ Орхон аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Булаг багт баригдаж байгаа 16 сургуулийн спорт заалны барилга, 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Баянцагаан багийн Үерийн хамгаалалтын далан барих ажил, Цэвэрлэх байгууламжийн үерийн далан барих, Эрдэнэ багийн 11-р цэцэрлэгийн 150 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, Жаргалант сумын ЕБС-ийн дотуур байрны

барилгын ажилд Барилгын хөгжлийн төв ТӨҮГТ байгуулсан гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Барилга угсралтын ажилд захиалчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан Барилгын хөгжлийн төвд тогтмол хүргүүлж ажилласан байна.

8. /59/ Орон нутгийн төсвөөр Цагаанчулуут багт УДДТөв-5-ийн барилга-375 сая төгрөг, Наран, Цагаан чулуут багт гадна дулаан цэвэр усны шугам, Даваат, Булаг, Баянбулаг багт ус түгээх байр холбох цэвэр усны ф80 шугамын хамт, Баянцагаан багт УДДТөвийн барилга 4ш, 4520м урт ус, дулааны гадна шугам, Их залуу багт УДДТөвийн барилга, Дэнж багийн орон сууцны 1,2,3-р байрны гадна шугам, Эрдэнэ багт 49-р гудамд гүний худаг /ухаалаг төхөөрөмжтэй/, Говил багт ус түгээх 64-р худгийн ухаалаг төхөөрөмжтэй болгох, “Мон-2301”- төслийн хүрээнд хийгдсэн гэр хорооллын ус хангамжийн эх үүсвэр дээр баригдсан хөв цөөрмийг засварлах зэрэг ажлуудын зураг төсөв бэлэн болж ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулалт хийж байна. Мөн Эрдэнэт үйлдвэр 3.137 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хотын төв цэвэр усны 2Ф426мм -3.8км урт, Ф630мм-ийн -2.2км урт шугам, цэвэр усны тоолуурын 4 пункт барилгыг “Хангилцаг” ХХК, “Эрдэнэт лайт” ХХК, “Дөлгөөн тэргүүн” ХХКомпаниудаар гүйцэтгүүлэн хүлээн авсан зэрэг ажлууд байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ байна. Үүнд:

1. /39/ Монгол Улсын Их хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалт “орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах”; 0%-тай ажил эхлээгүй байна.

2./50/ Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээлэлийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх; /30%-тай байна./

3. / 52/ Барилгын ажил түр зогсох хугацаанд барилга байгууламжийн чанар аюулгүй байдлыг хангах, барилгын бүрэлдэхүүн хэсгийг эвдэрч гэмтэхээс хамгаалах, барилгын ажлыг үргэлжлүүлэх нөхцөл бүрдүүлэх үүднээс аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран үзлэг шалгалт тогтмол зохион байгуулах; /0%-тай/

4. /53/ Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга, байгууламжийн бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж ажиллах; /0%-тай/

5. /56/ Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх; /30% -тай байна./

6. /62/ Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-нд цэвэр, бохир усны зөөврийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх; /0%-тай/

7. /66/ Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлж хэвших; /30% -тай байна./- зэрэг ажлууд байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Санал, зөвлөмж:

1. Орхон аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 5 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 2 арга хэмжээ 30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй байгаа тул нийт 7 арга хэмжээг нягтлан үзэж 2020 оны үр дүнгийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

5. Өвөрхангай аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 70 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 70 арга хэмжээний 24 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 17 арга хэмжээ 70 хувьтай, 6 арга хэмжээ 30 хувьтай байна. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай арга хэмжээ 1, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж хувь- 92.0 байна.

Хүснэгт 5

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%			
Хот байгуулалтын чиглэлээр	85.3	9	3	-	1	-	13	
Газрын харилцааны чиглэлээр	90.5	16	3	-	1	-	20	
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	100.0	16	2	-	-	-	18	
Нийтийн аж ахуйн чиглэлээр	77.7	6	1	1	1	-	9	
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	91.2	7	-	1	-	-	8	
Бусад	70.0	1	1	-	-	-	2	
Дүн /Өвөрхангай/		55	10	2	3	0	70	

БХБСайд, Өвөрхангай аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1./3/ Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсвийг Барилга хот байгуулалтын Сайдын багцаас 500.0 сая төгрөгөөр, Бүрд, Есөнзүйл, Сант, Уянга сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв хийлгэхээр 210.0 сая төгрөгийн төсвийг тухайн сумдын орон нутгийн хөгжлийн санд тусгуулсан. Сант сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Орон нутгийн хөгжлийн сангийн 45.0 сая төгрөгөөр, Уянга сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсвийг Орон нутгийн хөгжлийн сангийн 70.0 сая төгрөгөөр "Инженер геодези" ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна.

2. /13/ Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсвийг Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 500.0 сая төгрөгөөр, Бүрд, Есөнзүйл, Сант, Уянга сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв хийлгэхээр 210.0 сая төгрөгийн төсвийг тухайн сумдын Орон нутгийн хөгжлийн санд тусгуулсан. Сант сум орон нутгийн хөгжлийн сандаа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв хийлгэхээр 45.0 сая төгрөг, Уянга сум орон нутгийн хөгжлийн сандаа 70.0 сая төгрөгийн төсвийг тусган тендер зарлаж, тус сумдын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг “Инженер геодези” ХХК гүйцэтэж хүлээлгэн өгсөн байна.

3. /14/ Аймгийн хэмжээнд газар эзэмшигч 453 иргэн, 119 аж ахуйн нэгж байгууллагын газрын зөрчлийг арилгуулж, иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн 2639 нэгж талбарын талбайн хэмжээний зөрүүг арилгах арга хэмжээг авч, газрын улсын бүртгэл, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулсан байна.

4. /20/ Аймгийн хэмжээнд 2019 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар 971 иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлөх өргөдөл гаргасан. Нийт 971 иргэнд 65.38 га газрыг зориулалтаар өмчлүүлсэн. Үүнд 114 иргэнд 9.55 га одоо эзэмшиж буй газрыг -853 иргэнд 55.58 га газрыг шинээр -4 иргэнд 0.25 га газрыг улсын чанартай авто замын дагуу тус тус гэр бүлийн хэрэгцээнд үнэ төлбөргүй өмчлүүлсэн байна.

5. /34/ Арвайхээр сумын 874м бохир усны шугам, дулааны 280.7м гол шугамыг өргөтгөж 1249.5м шугамыг шинээр хийх ажлын саналыг Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яаманд хүргүүлсэн. Дулааны цахилгаан станц баригдахад шинээр баригдах дулаан дамжуулах төвүүдэд холбогдох 2 дугаар контурын шугам сүлжээний өргөтгөл шинэчилэлийн ажлын төлөвлөлтийн ажил хийгдэж зураг төслийг гүйцэтгэх компанийг шалгаруулах тендер зарлагдсан байна.

6. /41/ Шинээр ашиглалтад орж байгаа инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллах үед мэдээллийн санд оруулсан байх үүрэг өгч геодезийн ажилтан мэдээллийг хүлээн авч мэдээллийн санд тухай бүр оруулсан. 2019 онд нийт 38 барилга, байгууламжийг мэдээллийг мэдээллийн санд бүртгэсэн байна. Арвайхээр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчилэн боловсруулсан “Зууны гүүр” ХХК-тай хамтран “Хот байгуулалтын мэдээллийн сан” -д Арвайхээр сумын газар дээрх болон газар доорх инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулсан. “Хот байгуулалтын мэдээллийн сан”-д 100 гаруй барилга байгууламжийн мэдээллийг бүрэн оруулсан байна.

7. /45/ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 68 дугаар тогтоол “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу 50 барилга байгууламжид ажил эхлүүлэх зөвшөөрөл, 2 барилгад ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоолыг 2019 оны 1 дүгээр сараас хэрэгжүүлж 52 барилга, байгууламжийг хүлээн авах комиссыг зохион байгуулж ажиллуулан ашиглалтад оруулсан байна.

8. /46/ Аймгийн хэмжээнд 63 барилгын ашиглалтын байдалд үзлэг хийж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар их засвар хийх ажлын тоо хэмжээг тодорхойлж тендер зарлуулсан байна. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авсан байна.

9. /49/ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд эхэлсэн 9 барилга байгууламж, 2019 онд шинээр эхэлсэн 27 барилга, байгууламжид захиалагчийн хяналтыг 7-10 удаа хийж

заавар, зөвлөмжийг өгч ажиллан, нийт 28 барилга байгууламжийг ашиглалтад оруулсан. Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны сайдаар ахлуулсан ажлын хэсэг Өвөрхангай аймагт ажиллах үед Арвайхээр суманд баригдаж байгаа 928 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажилтай танилцуулж гадна тохижилт, инженерийн шугам сүлжээний ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний сунгалтыг хийж, барилга байгууламжийг ашиглалтанд оруулах шийдвэр гаргуулсан байна.

10. /50/ Орон нутгийн онцлогт тохируулан Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын “Барилгын материалын лабораторийн дүрэм”, Барилгын материалын лабораторийн дотоод журам”- ыг боловсруулан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн а/33 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Улирал тутам мэдээ, тайланг гарган Барилга хөгжлийн төвд хүргүүлсэн. 2019 онд нийт 526 дээжинд 2512 үзүүлэлтээр хийсэн 5.7 сая төгрөгийн 177 шинжилгээний хариуг хянан баталгаажуулсан байна.

11. /61/ Орон сууцны тухай хуулийн 8 дугаар зүйлийн дахь заалт: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04/01 дугаар хуралдаанаар Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 2013 онд хийгдсэн 3800 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний “В” блокын 20 га талбайд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрээр “ХАУС” хороолол болгох төлөвлөлтийн өөрчлөлтийн ажлын зургийг “Криетив Монголиа” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Хаус хороололд 175 айлын газар олголтыг хийн инженерийн төв шугаманд холбох салбар шугамын ажил 90%-тай хийгдэж, 75 айлын хаус ашиглалтад орсон байна.

12. /65/ Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр “Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН- 3388 төсөл”-өөр хэрэгжиж байгаа Арвайхээр хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчилэн барих ажлын гүйцэтгэгчээр “Комфорт импекс” ХХК шалгарч 2018 оны 4 дүгээр сараас эхэлсэн. 2018 оны 11 сард барилга, байгууламжийн угсралтын ажил дуусч барилга байгууламжийг хүлээн авах комиссыг ажиллуулж хүлээлгэн өгсөн зэрэг ажлууд байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ байна. Үүнд:

1. /10/ Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, эсхүл хэлтсийн даргаар томилон ажиллуулах;

2. /18/ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

3. /39/ “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэрэлтүүлэг, хэрэглээний халуун усны хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр хангах загвар төслүүдийг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах ажлыг зохион байгуулж, орон нутгаас дэмжлэг үзүүлж ажиллах, ажлын үр дүнг тайлагнах.

4. /62/ “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

5. /67/ Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлэх;- зэрэг ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “бүрэн хэрэгжсэн” буюу үр дүн гарсан гэж дүгнэв.

Санал, зөвлөмж:

1. Өвөрхангай аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот байгуулалтын чиглэлээр 1 арга хэмжээ, Газрын харилцааны чиглэлээр 1 арга хэмжээ, барилга, нийтийн аж ахуйн чиглэлээр 2 арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн чиглэлээр 1 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй /30%/ гэсэн үнэлгээтэй байгаа тул нийт 5 арга хэмжээг нягтлан үзэж 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

6. Хөвсгөл аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 47 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 47 арга хэмжээний 24 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 17 арга хэмжээ 70 хувьтай, 4 арга хэмжээ 30 хувьтай байна. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай арга хэмжээ 1, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж хувь-82.0 байна

Хүснэгт 6

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Дүн тоо
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Хот байгуулалтын чиглэлээр	74.1	4	7	1	-	-	12
Газрын харилцааны чиглэлээр	87.0	11	8				19
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	83.5	10	7	-	-	-	16
Нийтийн аж ахуйн чиглэлээр	90.0	6	3	-		-	9
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	81.2	3	5	-			8
Бусад	70.0	-	1	-	-	-	1
Дүн /Хөвсгөл/		34	31	1	-	-	66

БХБСайд, Хөвсгөл аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /3/ Хөгжсөн Хөвсгөл” 2030, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө” 2030, “Авто замыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө” 2030, “Хөгжлийн хөтөч 2016- 2020” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2017-2020 онд хэрэгжүүлэх аймгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, 2019 онд аймгийн Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл зэрэг урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан 35 төсөл арга хэмжээг

хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт үе шаттайгаар тусган шийдвэрлэж гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

2. /19/ 2019 оны байдлаар Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 265 иргэнд 26.86 га газрыг өмчлүүлээд байна. Өссөн дүнгээр нийт аймгийн хэмжээнд 13670 иргэний 1356.34 га газрыг өмчлүүлээд байна. Үүнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 13656 иргэнд 1367.72 га, аж ахуйн зориулалтаар 14 иргэнд 7.74 га газрыг өмчлүүлээд байна.

3. /35/ Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Усан хангамж ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт үйлчилгээг “Хөвсгөл Ус суваг” ХХК, дулаан хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт үйлчилгээг “Хөвсгөл Дулааны станц” ТӨХК, цахилгаан хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт үйлчилгээг “Хөвсгөл Эрчим хүч” ХХК тус тус хариуцан ажиллаж байна.

4. /41/ Монгол улсын Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах байнгийн ажиллагаатай дэд зөвлөлийг аймгийн Засаг даргын 2018 оны А/467 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар байгуулсан бөгөөд тус зөвлөл нь жил бүр хийж гүйцэтгэх төлөвлөгөө гарган Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

5. /43/ Тайлант оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 68,71 дүгээртогтоолын дагуу ажил эхлүүлэх зөвшөөрлийг гүйцэтгэгч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу шинээр 72 барилга байгууламжид, сунгалтыг 11 барилга байгууламжид өгсөн, Улсын болон орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламж, засварын ажилд Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоол, Аймгийн засаг даргын 2018 оны А/623 дугаар захирамжийн дагуу 50 барилга байгууламжийн ажилд улсын комисс ажиллаж байнгын ашиглалтанд оруулсан байна.

6. /47/ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 58 барилга байгууламжийн ажилд жилийн туршид 204 удаа захиалагчийн хяналтыг хийж тухай бүр нь талбайн журналд тэмдэглэн үүрэг даалгавар өгч биелэлтийг шалган ажилласан байна.

7. /48/ Дүрмийн хүрээнд тайлант онд бетон дүүргэгч, керамик материалын шинжилгээг шахах пресс, автомат шигшүүр, хатаах шүүгээ, бутрамтгай чанар тодорхойлогч, асгаасны нягт тодорхойлогч, агаар агууламж, конусын суулт, шмидтийн алх, цахилгаан жин, хэмжлийн шилэн багаж, штангенциркул гэх зэрэг 32 төрлийн баталгаажсан, тохирлын гэрчилгээтэй тоног төхөөрөмж, багажаар 18 төрлийн сорилт шинжилгээг аймгийн хэмжээнд баригдаж байгаа барилга байгууламжид хийж дүгнэлтийг гаргуулсан байна.

8. /50/ Аймгийн хэмжээнд баригдаж байгаа 71 барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэгч нарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 396 норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх, сурталчилах, жил бүр зохион байгуулагддаг норм нормативын сургалтанд хамруулах, шинэ норм, нормативын баримт бичгийг худалдан авч судлах мөрдөж ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажиллаж байна. Мөн гүйцэтгэгч компаниудаар норм, нормативын сангийн төлбөрийг тогтмол хугацаанд нь төлж байх үүрэг чиглэлийг өгч ажиллаж байна.

9. /58/ Хөвсгөл аймаг нь Мөрөн хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулан мөрдөн ажиллаж байгаа бөгөөд мөрөн хотод аймаг бүрт 1000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа “Шинэ Мөрөн” 550

айлын орон сууцны хорооллын эхний ээлжийн 135 айлын 3 блок орон сууцыг ТОСК, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар барьж тайлант онд ашиглалтад оруулаад байна. Мөн тус хорооллын барилгын ажлыг үргэлжлүүлэн “Хөвсгөл геологи” ХХК 55 айлын 1 блок орон сууцны барилгыг энэ оны 06 дугаар сард барьж эхэлсэн бөгөөд ондоо багтаан ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

10. /60/ “Шинэ Мөрөн” хорооллын 135 айлын орон сууцыг “Түрээсийн орон сууц” хөтөлбөрөөр иргэдэд түрээсийн журмаар олгохоор Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 138 дугаар тогтоол гарсан. Уг тогтоолын хэрэгжилтийг ханган орон нутагт түрээсийн орон сууцыг иргэдэд олгох журмыг боловсруулан Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 16- ны өдрийн 111 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу сонгон шалгаруулалтыг хийж иргэдэд олгоод байна.

11. /66/ 2015 оноос улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 36 барилга, хувийн хувшлийн хөрөнгө оруулалтаар 15, нийт 51 барилга, байгууламж шинээр ашиглалтанд орж, эдгээр барилгын 96% нь зураг төсөвтөө хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй зам, шатны асуудлыг тусган хэрэгжүүлсэн байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн ихээр үйлчлүүлдэг хэсэгт буюу Нэгдсэн эмнэлгийн амбулаторын харалдаах замд дуут гэрлэн дохиог орон нутгийн 25,0 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулж ашиглалтанд оруулсан зэрэг ажлууд байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. /12/Хот байгуулалтын тухай хуулийн 9.1.4- т заасны дагуу аймаг, нийслэлийн хөгжлийн төсөл, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгол, шинэчлэл хийх асуудлыг санаачлан зохион байгуулах ажил хангалтгүй байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Санал, зөвлөмж:

1. Хөвсгөл аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хот байгуулалтын чиглэлээр 1 арга хэмжээг нягтлан үзэж 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Хангайн бүсийн аймгуудад өгсөн санал, зөвлөмж:

Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдтай **Хангайн бүсийн аймгуудын** /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/ Засаг дарга нар 2019 онд хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц, бусад ажлын чиглэлээр Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан, нийт 411 ажлуудын гүйцэтгэл **82.1** хувьтай, биелэлт "хэрэгжих шатанд" гол үр дүн гарч байна.

Дээрх тайланд дурьдсан 30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй Архангай аймгийн 7 арга хэмжээ, Баянхонгор аймгийн 15 арга хэмжээ, Булган аймгийн 2 арга хэмжээ, Орхон аймгийн 7 арга хэмжээ, Өвөрхангай аймгийн 5 арга хэмжээ, Хөвсгөл аймгийн 1 арга хэмжээг тус тус нягтлан үзэж 2020 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Хангайн бүсийн аймгуудад дараах нийтлэг дутагдал байна:

1. Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн газрыг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа эрхийн зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгах, мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, дуусгах;

2. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний гөлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3. 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.;

4. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тогтмол суулгах.

5. Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах 2019 онд тооллого хийж байгаа аймгуудаас бусад нь /Дундговиос бусад аймаг/;

6. Нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах шинээр байгуулагдсан болон өөрчлөлт орсон объектын талаарх мэдээллийг бүрдүүлж геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байх.

7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх инженерийн дэд бүтцийн ажлуудын судалгаа, зураг төсөл, ТЭЗҮ хийхэд шаардагдах хөрөнгө санхүүжилтийн тооцоо судалгааг гаргаж орон нугийн төсөвт тусгах, инженерийн шугам сүлжээний эх үүсвэрийн судалгаа, зураг төсөл, сум суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж, мэргэжлийн байгууллагуудын саналыг сайтар тусгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж байх.

8. Инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах;

9. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл болон Хөдөлмөрийн яамны "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих.

10. Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах.

11. Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

12. Салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд тайлагнах, мэдээ, судалгааг тогтоосон хугацаанд ирүүлэх, мэдээллээр хангах.

13. Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлэх.

14. Монгол Улсын Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “Орон нутгийн удирдлагын бүрэн эрхийн хүрээнд усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох” заалтыг хэрэгжүүлэх зэрэг ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна

Мөн Хангайн бүсийн аймгуудын хувьд мэдээ, судалгааг тогтоосон хугацаанд ирүүлэх, мэдээллээр хангах, хамтран ажиллах, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах, гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнах, тайлангийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд тайлагнах зэрэгт хангалтгүй нийтлэг учир дутагдал байгаа тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хангайн бүсийн аймгуудын үнэлгээг нэгтгэн харүүлбал:

	Аймгууд	Үнэлгээ%	Үнэлгээний хувь					Арга хэмжээний тоо
			100%	70%	30%	0%	ХБ	
1	Архангай	80.8	36	26	6	1	-	69
2	Баянхонгор	80.1	47	7	8	5	-	67
3	Булган	85.7	36	32	2	-	-	70
4	Орхон	84.1	34	28	3	4	-	69
5	Өвөрхангай	92.0	55	10	2	3	0	70
6	Хөвсгөл	82.0	34	31	1	-	-	66
	Хангайн бүсийн аймгуудын дундаж	82.1	242	134	22	13	-	411

Б. БАРУУН БҮСИЙН АЙМГУУД:

7. БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **72** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 72 арга хэмжээний 100 хувьтай арга хэмжээ 52, 70 хувьтай арга хэмжээ 12, 30 хувьтай арга хэмжээ 8 байна. Хэрэгжилт **86.6** хувьтай байна.

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Дүн тоо
		100%	70%	30%	0%	ХБ	
Хот байгуулалтын чиглэлээр	95	10	2	-	-	-	12
Газрын харилцааны чиглэлээр	84,2	14	4	3	-	-	21
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	92,7	15	2	1	-	-	18
Нийтийн аж ахуйн чиглэлээр	75,4	6	2	3	-	-	11
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	87,5	6	1	1	-	-	8
Бусад	85	1	1	-	-	-	2
Дүн /Баян-өлгий/	86,6	52	12	8	-	-	72

БХБСайд, Баян-өлгий аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1.Төлөвлөгөөний /6/ “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээллийг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах” хүрээнд Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан үүсгэхээр жижүүрийн хөтлөлтөд инженерийн шугам сүлжээг бүртгэж, ашиглалтад орсон барилгын бүртгэлийг хөтөлж байна.

Өлгий сумд байршилтай сургууль, цэцэрлэг, эмнэлэг, албан байгууллагын контор, банк, худалдаа үйлчилгээ, музей г.м. барилга байгууламжуудын болон инженерийн шугам сүлжээ, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулж, амжилттай хэрэгжүүлсэн.

2. Төлөвлөгөөний /13/ “Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн газрыг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа эрхийн зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгах, мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, дуусгах” ажлын хүрээнд газрын кадастрын “Лэнд менежер” програм хангамжийн хүрээнд аймгийн хэмжээнд аймаг сумдын Засаг даргын захирамжаар 2107 нэгж талбарын өмчлөлийн талбайн хэмжээний зөрүүг, 1466 нэгж талбарын эзэмшлийн газрын зөрүүг тус тус арилгуулж мэдээллийн санд оруулж ажилласан болно.

3. Төлөвлөгөөний /14/ “Аймгийн хэмжээнд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг Газрын биржийн цахим системээр явуулах ажлыг зохион байгуулах” ажлын хүрээнд Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам” Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоол “Газрын биржийн үйл ажиллагааны журам батлах тухай” тогтоолуудын дагуу аймгийн хэмжээнд цахимаар нийт 34 байршилд Газрын дуудлага худалдаа явуулахаар заралсанаас хууль журмын дагуу 27 байршилийг эзэмшүүлж орон нутгийн орлогод нийт 67, 724,000 төгрөг оруулав.

4. Төлөвлөгөөний /20/ “2006 онд “Ландмен” ХХК Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг /2007-2015-2021он хүртэл/ гүйцэтгэсэн. Цаашид аймгийн

ГЗБЕТөлөвлөгөөг шинээр хийх ба тодотгол хийх хөрөнгийн асуудал штидэгдээгүй боловч сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад 2020 онд 134.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан батлуулсан.

5. Төлөвлөгөөний /24/ “Геодезийн байнгын цэг тэмдэгтийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, тооллого хийх” ажлын хүрээнд Аймгийн засаг даргын 2019 оны А/136 тоот захирамж гаргуулан Баян-Өлгий аймгийн 13 сумын нутаг дэвсгэрт байгаа геодезийн байнгын цэг тэмдэгтийн тоолох ажлыг хийж гүйцэтгэсэн. Аймгийн хэмжээнд 363 геодезийн цэг, тэмдэгт тоологдож, цэг тэмдэгтийг сумын ЗДТГ-ын данс бүртгэлд оруулж, хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулав. Байнгын цэг тэмдэгтийг гэмтээсэн, устаж үгүй болсон судалгааг нэгтгэж ГЗБГЗЗГазарт 2019 оны 01 сарын 14-нд хэвлэж CD-ээр хүргүүлсэн.

6. Төлөвлөгөөний /25/ “Газар зүйн нэрийн салбар зөвлөл байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх, салбар зөвлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах” ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/750 тоот захирамжаар Газар зүйн нэрийн салбар зөвлөл байгуулагдсан. Аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн 13 сумдын Засаг дарга нар Газар зүйн нэрийн салбар зөвлөлийг тус тус байгуулсан.

7. Төлөвлөгөөний /35/ “Аймаг, сум, суурин газруудын одоогоор ашиглагдаж байгаа инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийн тоо хэмжээ, өнөөгийн байдлын судалгааг хийж ашиглалтын түвшинг тогтоох” ажлын хүрээнд аймаг, сум, суурин газруудын одоогоор ашиглагдаж байгаа инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, өнөөгийн байдлын судалгааг хийж 2019 оны 02-р сарын 11-ны өдөр ЗДТГ-ын ХОХБТХ-т ahmetkhozybai@yahoo.com цахим хаягаар хүргүүлсэн. 2019 оны Улсын төсвийн хөрөнгөөр аймгийн төвийн гудамж талбайн гэрэлтүүлэгт 1,2 тэрбум “Алтайн Байдраг констракш” ХХК гүйцэтгэж 2019 оны 12-р сарын 12-ны өдөр, аймгийн төвийн цэвэр бохир усны шугамын шинэчлэлд 914,4 сая “Билгүүн Од Констракшн” ХХК. Туслан гүйцэтгэгч “ИЕЛ” ХХК гүйцэтгэж 2019 оны 12-р сарын 02-ны өдөр, ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Өлгий сумын 11-р багт “ИЕЛ” ХХК цэвэр усны шугам татаж 2019 оны 08-р сарын 28-ны өдөр, Алтай сумын төвд трансформатор барих ажлыг 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, цэвэрлэх байгууламжийн карт барих ажлыг 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ашиглалтад оруулсан байна.

8. Төлөвлөгөөний /42/ “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалт, “орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах” ажлын хүрээнд Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/285 тоот захирамжаар 8 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус паспортжуулалтын зөвлөл байгуулсан байна.

Тус зөвлөл нь 2 удаа хуралдаж “Паспортжуулалтын зөвлөлийн дүрэм”-ийг боловсруулж батлуулсан. Шинээр баригдаж ашиглалтад орсон барилга байгууламжуудыг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг үндэслэн аймгийн Мэргэжлийн хяналтын газраас барилгын паспортыг олгож байна. 2019 онд нийт 15 шинээр баригдсан барилга байгууламжид ногоон өнгийн ашиглалтын гэрчилгээ олгосон зэрэг ажлууд байна.

Дараах 8 арга хэмжээ 30 хувьтай хэрэгжсэн байна. Үүнд:

1.Төлөвлөгөөний /18/ “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулах”,

2. /26/ “Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах”,

3. /28/ “Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөө байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээ байгуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, дүгнэлтийг агентлагт ирүүлэх”,

4. /39/ “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэрэлтүүлэг, хэрэглээний халуун усны хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр хангах загвар төслүүдийг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах ажлыг зохион байгуулж, орон нутгаас дэмжлэг үзүүлж ажиллах, ажлын үр дүн тайлагнах”,

5. /48/ “Барилга,хот байгуулалтын сайдын 2017оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах /дэлгэрүүлж сайдын тушаалыг оруулах/”,

6. /63/ “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж аймаг бүр жилд 15-аас доошгүй айлын орон нутгийн өмчийн түрээцийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг хамруулах”,

7. /64/ “Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-д нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”,

8. /69/ “Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлж, Аймгийн гэр хорооллын иргэдэд ус түгээсэн зардлын үнийн зөрүүг төсөвт тусгуулан батлуулсан байна.”- зэрэг ажлууд байна.

ДҮГНЭЛТ:

Барилга, хот байгуулалтын сайд болон Баян-өлгий аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2019 оны гэрээний хэрэгжилт **86,6** хувьтай “**хэрэгжих шатанд**” гэж үнэлэв.

САНАЛ,ЗӨВЛӨМЖ:

Баян-Өлгий аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын харилцааны чиглэлээр 3 арга хэмжээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 1 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 3 арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн чиглэлээр 1 арга хэмжээ 30 хувийн хэрэгжилттэй байгаа тул нийт 8 арга хэмжээг 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

8. УВС АЙМАГ

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 68 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 68 арга хэмжээний 100 хувьтай арга хэмжээ 54, 70 хувьтай арга хэмжээ 11, 30 хувьтай арга хэмжээ 3 байна. Хэрэгжилт **91,9** хувьтай байна.

Хүснэгт 1

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Дүн тоо
		100%	70%	30%	0%	ХБ	
Хот байгуулалтын чиглэлээр	97,5	11	1	-	-	-	12
Газрын харилцааны чиглэлээр	90	15	3	1	-	-	19
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	96,6	16	2	-	-	-	18
Нийтийн аж ахуйн чиглэлээр	71,1	3	4	2	-	-	9
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	96,2	7	1	-	-	-	8
Бусад	100	2	-	-	-	-	2
Дүн /Увс/	91,9	54	11	3	-	-	68

БХБСайд, Увс аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1.Төлөвлөгөөний /4/ “Улаангом сумын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайг нэмэгдүүлэн ажилласан. Үүнд 11-р багийн Гиваанбаатарын талбайн тохижилтын ажил-280 сая, 3-р багийн Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт- 3 тэрбум, сумын төвийн тохижилт-6-н тэрбум, 1,12-р багийн тохижилт-100 сая, Улаангом –Улаан уулын чиглэлийн дугуйн зам-242,5 сая, Ногоон паспорт төслөөр 4 га газар ногоон төгөл болгох ажил, 5-р багт 27,1 га талбайд Цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил 465 сая төгрөгөөр төсөвлөн хийж гүйцэтгэсэн.

2. /14/. Газрын биржийн цахим системийг ашиглан газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохион байгуулан ажиллаж байна. 2019 онд Баруунтуруун, Бөхмөрөн, Давст Завхан, Зүүнхангай, Өлгий, Тариалан, Түргэн, Тэс, Ховд, Хяргас, Цагаанхайрхан, Малчин, Улаангом сумуудад ШТС, фермер, орон сууц, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний зориулалтаар 43 байршилд 8.43 га газрын дуудлага худалдааг Газрын биржийн цахимд системд давхардсан тоогоор 93 удаа зарлаж зохион байгуулсан. Үүнээс Баруунтуруун, Бөхмөрөн, Давст, Завхан, Тэс, Малчин, Улаангом суманд штс, орон сууц, худалдаа үйлчилгээний зориулалтаар 12 байршилд 0.8 га газрыг эзэмшүүлж орон нутгийн төсөвт 33,710.2 мянган төгрөг төвлөрүүлсэн.

3. /22/. Нутаг дэвсгэртээ хамаарч байгаа цэг тэмдэгтийн тооллогийг сумын төвийн GPS-ийн цэгүүд дээр гүйцэтгэж нийт 131 цэг тэмдэгтийн хувийн хэргийн зургийг шинэчлэн ажилласан зэрэг ажлууд байна.

Дараах 3 арга хэмжээ 30 хувьтай хэрэгжсэн байна. Үүнд:

- 1.Төлөвлөгөөний /24/ “Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019- 2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах”,
2. Төлөвлөгөөний /60/ “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
3. Төлөвлөгөөний /61/ "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг ажлууд байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын сайд болон Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2019 оны гэрээний хэрэгжилт **91.9** хувьтай “**бүрэн хэрэгжсэн**” гэж үнэлэв.

Санал, зөвлөмж:

Увс аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын харилцааны чиглэлээр 1 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 2 арга хэмжээ, нийт 3 арга хэмжээг 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

9. ХОВД АЙМАГ

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **68** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 68 арга хэмжээний 100 хувьтай арга хэмжээ 47, 70 хувьтай арга хэмжээ 13, 30 хувьтай арга хэмжээ 5, 0 хувьтай арга хэмжээ 2 байна. Хэрэгжилт **88,3** хувьтай байна.

Хүснэгт 1

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Дүн тоо
		100%	70%	30%	0%	ХБ	
Хот байгуулалтын чиглэлээр	95	10	2	-	-	-	12
Газрын харилцааны чиглэлээр	76,6	11	6	3	1	-	21
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	90	14	1	2	-	-	17
Нийтийн аж ахуйн чиглэлээр	83,7	6	1	-	1	-	8
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	85	4	4	-	-	-	8
Бусад	100	2	-	-	-	-	2
Дүн /Ховд/	88,3	47	14	5	2	-	68

БХБСайд, Ховд аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1.Төлөвлөгөөний /5/ “Монгол Улсын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн хүрээнд холбогдох судалгааны материалыг боловсруулан, хүргүүлсэн.

2. /13/. Газрын улсын бүртгэлийг тогтмол хөтөлж, зөрчилтэй 202 иргэний көрүүтэй мэдээллийг арилгаж, цахим хэлбэрт оруулсан.

3. /18/. 2019 оны УИХ-ын 41-р тогтоолоор Ховд аймгийн Дарви, Цэцэг сум хил дамнасан нийт 172713,9 га газрыг улсын тусгай хамгаалалтад авсан байна зэрэг ажлууд байна.

Дараах 7 арга хэмжээ 0-30 хувьтай, тасарсан байна. Үүнд:

0%-тай арга хэмжээ 2 байна. Үүнд:

1.Төлөвлөгөөний /61/ "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх,

2. Төлөвлөгөөний /25/ “ Газар зүйн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах зэрэг ажлууд байна.

30%-тай арга хэмжээ 5 байна. Үүнд:

1. /17/ “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”,

2. /20/ “Ховд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах кардлыг орон нутгийн төсөвт тусгах,

3. /30/ “Газрын тухай хуулийн 58-р зүйлд заасны дагуу хөрс, орчны бохирдол ихээр үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулах”,

4. /47/ “Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах /дэлгэрүүлж сайдын тушаалыг оруулах /,

5. /55/ “Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах”- зэрэг ажлууд байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын сайд болон Ховд аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2019 оны гэрээний хэрэгжилт **88,3** хувьтай “хэрэгжих шатанд” гэж үнэлэв.

Санал, зөвлөмж:

Ховд аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын харилцааны чиглэлээр 4 арга хэмжээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 2 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 4 арга хэмжээ, нийт 7 арга хэмжээг 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

10. ЗАВХАН АЙМАГ

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 68 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 68 арга хэмжээний 100 хувьтай арга хэмжээ 52, 70 хувьтай арга хэмжээ 13, 30 хувьтай арга хэмжээ 1, 0 хувьтай арга хэмжээ 2 байна. Хэрэгжилт 89.2 хувьтай байна.

Хүснэгт 1

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Дүн тоо
		100%	70%	30%	0%	ХБ	
Хот байгуулалтын чиглэлээр	95,3	11	2	-	-	-	13
Газрын харилцааны чиглэлээр	90.5	13	6	-	-	-	19
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	91.1	14	3	1	-	-	18
Нийтийн аж ахуйн чиглэлээр	77.7	7	-	-	2	-	9
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	95.7	6	1	-	-	-	7
Бусад	85	1	1	-	-	-	2
Дүн /Завхан/	89.2	52	13	1	2		68

БХБСайд, Завхан аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /4/. Аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “НЕКСТ СТЕП ИНЖЕНЕРИНГ” ХХК боловсруулан гүйцэтгэж 2018 оны 10-р сард орон нутгийн судалгаа, мэдээллийг хүргүүлж, төлөвлөгөө эскиз байдлаар танилцуулга хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2019 оны 3-р сард ерөнхий төлөвлөгөөг бүрэн эхээр нь эцсийн байдлаар аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Улиастай сумын ЗДТГ-ын мэргэжилтэнүүд холбогдох инженер техникийн ажилчдыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох мэдээллээр ханган ажиллаж байна. 2019 оны 08 дугаар сард 6 багийн иргэдээс санал авах ажил зохион байгуулсан.

2. /16/. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны А/124 тоот тушаалаар Газрын кадастрын мэдээллийн сангийн Веб системийн сургалтыг 2019 оны

03 сарын 10-ны өдрөөс 4 хоногийн сургалтыг газрын даамлуудад зохион байгуулан, 2019 оны 06 сарын 24-ний өдрөөс эхлэн 24 сумын хэмжээнд нэвтрүүлсэн.

3. /19/. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах ажлын хүрээнд 2019 онд Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018.12.19-ний өдрийн №83 тогтоолоор батлуулж, тогтоолыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн. Уг тогтоолоор аймгийн хэмжээнд 2019 онд 516 иргэнд 40,4 га газрыг өмчлүүлхээр батлуулсан бөгөөд 3 дугаар улирлын байдлаар байдлаар 239 иргэнд 23.79 га газрыг өмчлүүлсэн байна. Жилийн эцсийн байдлаар 413 иргэнд 42.12 га газар өмчлүүлж аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 9068 иргэнд 854.5 га газрыг өмчлүүлсэн ба төлөвлөгөөний хэрэгжилт 80.6 га талбайн хэмжээ 104.3 хувьтай төлөвлөгөөг биелүүлсэн зэрэг ажлууд байна.

Дараах 3 арга хэмжээ 0-30 хувьтай, тасарсан байна. Үүнд:

0%-тай арга хэмжээ 2 байна. Үүнд:

1. Төлөвлөгөөний /58/ “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйл, 17 дугаар зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлэх”,

2. Төлөвлөгөөний /61/ "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг ажлууд байна.

30%-тай арга хэмжээ 1 байна. Үүнд:

1.Төлөвлөгөөний /54/ “Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах”- зэрэг ажлууд байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын сайд болон Завхан аймгийн засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2019 оны гэрээний хэрэгжилт **89,2** хувьтай “хэрэгжих шатанд” гэж үнэлэв.

Санал, зөвлөмж:

Завхан аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 1 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 2 арга хэмжээ, нийт 3 арга хэмжээг 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

11. ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **68** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 68 арга хэмжээний 100 хувьтай арга хэмжээ

42, 70 хувьтай арга хэмжээ 22, 30 хувьтай арга хэмжээ 3, 0 хувьтай арга хэмжээ 1 байна. Хэрэгжилт **84,2** хувьтай байна.

Хүснэгт 1

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Дүн тоо
		100%	70%	30%	0%	ХБ	
Хот байгуулалтын чиглэлээр	100	11	-	-	-	-	11
Газрын харилцааны чиглэлээр	88	13	4	3	-	-	20
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	77,6	7	8	2	-	-	17
Нийтийн аж ахуйн чиглэлээр	81	6	3	-	1	-	10
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	88,7	5	3	-	-	-	8
Бусад	70	-	2	-	-	-	2
Дүн /Говь-алтай/	84,2	42	22	3	1	-	68

БХБСайд, Говь-алтай аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Төлөвлөгөөний /5/. 2019 оны 3 сарын 22-ны өдрийн 2/535 тоот албан бичгээр хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд шаардлагатай судалгааг гаргаж Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн бөгөөд Барилгын хөгжлийн төвийн “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэлтэс”- ийн ажлын хэсэг тус аймагт 2019 оны 05 сард ажиллаж, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын хүрээнд 2018 оны 07 сарын 23-ний А/304 дугаар захирамжаар байгуулагдсан мэдээлэл, судалгаа гаргах ажлын хэсэг хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах төслийн багтай хамтран ажилласан байна.

2. /11/. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын орон нутгийн хөгжлийн сангийн 307.1 сая төгрөгөөр Алтай, Бугат, Баян-Уул, Төгрөг, Бигэр, Тонхил, Шарга, Цээл, Эрдэнэ сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан Засаг даргын Тамгын газар хүлээлгэн өгсөн бөгөөд хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна. Тайшир сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад 40.0 сая төгрөг батлагдсан байна.

3. /12/. Аймгийн хэмжээнд өмчилж байгаа 5314 нэгж талбар, эзмшиж, ашиглаж байгаа 1987 нэгж талбар газрыг мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж 95% хувийн хэрэгжилттэй явж байна. Иргэний өмчилж байгаа, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа газрын хэмжээ, (бодит газрын хэмжээ) нь Засагдаргын захирамжид заагдсан газрын хэмжээнээс зөрүүтэй өмчлөл 3720 нэгж талбар, эзэмшил 1760 нэгж талбарын зөрчлийг арилган, бүртгэгдээгүй нэгж талбаруудын газрын улсын бүртгэл, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулах ажил аймгийн хэмжээнд 83%-ийн гүйцэтгэлтэй байна зэрэг ажлууд байна.

Дараах 7 арга хэмжээ 0-30 хувьтай, тасарсан байна. Үүнд:

0%-тай арга хэмжээ 2 байна. Үүнд:

- 1.Төлөвлөгөөний /61/ "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
2. /25/ “ Газар зүйн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 201-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах- зэрэг ажлууд байна.

30%-тай арга хэмжээ 5 байна. Үүнд:

1. /17/ “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”,
2. /20/ “Ховд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах кардлыг орон нутгийн төсөвт тусгах,
3. /30/ “Газрын тухай хуулийн 58-р зүйлд заасны дагуу хөрс, орчны бохирдол ихээр үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулах”,
4. /47/ “Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангаж ажиллах,
5. /55/ “Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах”- зэрэг ажлууд байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын сайд болон Ховд аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2019 оны гэрээний хэрэгжилт **88,7** хувьтай “хэрэгжих шатанд” гэж үнэлэв.

Санал,зөвлөмж:

Ховд аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын харилцааны чиглэлээр 4 арга хэмжээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 2 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 4 арга хэмжээ, нийт 1 арга хэмжээг 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

БАРУУН БҮСИЙН АЙМГУУДАД ӨГӨХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдтай Баруун бүсийн аймгуудын /Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай/ Засаг дарга нар 2019 онд хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц, бусад ажлын чиглэлээр Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан, нийт **344** ажлуудын гүйцэтгэл **88,0** хувьтай, биелэлт "хэрэгжих шатанд" гэж үнэлэв.

Энэхүү тайланд дурьдсан, хэрэгжилт хангалтгүй 0-30 хувьтай арга хэмжээнүүд /Баян-Өлгий аймгийн 8 арга хэмжээ, Увс аймгийн 3 арга хэмжээ, Ховд аймгийн 7 арга хэмжээ, Завхан аймгийн 3 арга хэмжээ, Говь-Алтай аймгийн 4 арга хэмжээ/-ийг 2020 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Баруун бүсийн аймгуудын хувьд Хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт хангалттай сайн байгаа боловч барилга, барилгын материал, нийтийн аж ахуйн чиглэлээр төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт хангалтгүй, цаашид хэрэгжилтэд анхаарч, Барилга, хот байгуулалтын сайдтай байгуулах 2020 оны гэрээндээ тусган хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1. “Түрээсийн орон сууцны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн, орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх;

2. Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлж, аймгийн гэр хорооллын иргэдэд ус түгээсэн зардлын үнийн зөрүүг төсөвт тусгуулан батлуулах;

3. Нутаг дэвсгэртээ байрлах барилга байгууламжийн бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах,

4. “Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019- 2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах” зэрэг арга хэмжээ.

Баруун бүсийн аймгуудын үнэлгээг нэгтгэн харуулбал:

	Аймгууд	Үнэлгээ %	Үнэлгээний хувь					Арга хэмжээний тоо
			100%	70%	30%	0%	ХБ	
1.	Баян-Өлгий	86,6	52	12	8	-	-	72
2.	Увс	91,9	54	11	3	-	-	68
3.	Ховд	88,3	47	14	5	2	-	68
4.	Завхан	89,2	52	13	1	2	-	68
5.	Говь-Алтай	84,2	42	22	3	1	-	68
Баруун бүсийн аймгуудын дундаж		88.0	247	72	20	5	-	344

В. Төвийн бүсийн аймгууд:

12. Өмнөговь аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 66 арга хэмжээний 47 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 8 арга хэмжээ 70 хувьтай, 8 арга хэмжээ 30 хувьтай, 3 арга хэмжээ хэрэгжээгүй буюу 0 хувьтай байна. Хэрэгжилтийн дундаж хувь- **81,1%** байна.

Хүснэгт 1

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%			
Хот байгуулалтын чиглэлээр	79,1%	8	1	-	2	-	11	
Газрын харилцааны чиглэлээр	93,2%	16	2	1	-	-	19	
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	72,4%	9	3	4	1	-	17	
Нийтийн аж ахуйн чиглэлээр	85,6%	6	2	1	-	-	9	
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	91,3%	7	-	1	-	-	8	
Бусад	65%	1	-	1	-	-	2	
Дүн /Өмнөговь/	81,1%	47	8	8	3	-	66	

БХБСайд, Өмнөговь аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /2/ Аймгийн төвийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Үүнд: Шинэ суурьшлын бүсийн 90 га талбайн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, Төвийн хэсгийн 150 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Аргалант, Нанзад, Мод үржүүлэг гэр хорооллын газар дахин зохион байгуулалтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Үйлдвэржилтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд 210 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө зарцуулсан. Инженерийн бэлтгэл арга хэмжээ, Үерийн хамгаалалтын даланг барьж байгуулах арга хэмжээний хүрээнд аймгийн төв доторх гадаргуугийн ус зайлуулах гол шугамыг байгуулах ажлыг 2588,52 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн. Энэ ажил хийгдсэнээр аймгийн төв доторх 6,3 км автозамын ус болон зам дагуу орчмын гадаргуугийн усыг зайлуулах боломж нөхцөл бүрдсэн байна.

2. /3/ Аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу Даланзадгад сумын Гурвансайхан хорооллын 12 гудамжны 600 гаруй хашааны айл өрхийг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах ажлыг хийж гүйцэтгэсэн. Даланзадгад сумын төв болон гэр хорооллын 7080 метр гэрэлтүүлгийг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Аймгийн төвийн дулааны гол шугам сүлжээг шинэчлэх ажлыг орон нутгийн төсвийн 1.1 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Аймгийн төвд 2.2 дугуйн зам, 7 км хатуу хучилттай автозам, 11 км явган хүний зам, хатуу хучилттай зам дагасан гэрэлтүүлгийг барьж байгуулсан.

Цогтцэций сумын төвд 2.2 км дугуйн зам, гэрэлтүүлэгтэй хатуу хучилттай автозамыг барьж ашиглалтад оруулсан.

Аймгийн төд Даланзадгад сумын нийтийн орон сууц дунд иргэд зөвшөөрөлгүй 280 пин амбаар байрлуулсан байсныг чөлөөлж, чөлөөлсөн газарт хүүхдийн тоглоомын талбай, автозам, явган хүний зам, эко зогсоол, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн хамт барьж байгуулсан байна. Мөн 28 нийтийн орон сууцны гадна иж бүрэн тохижилт үүнээс 18 байрын гадна фасадыг шинэчилжээ.

Даланзадгад суманд Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган барилгажуулах ажлыг эхлүүлж **2, 3, 9 дүгээр орон сууцыг** буулган ажлыг эхлүүлсэн. 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Нийт **52** айлын орон сууц дахин төлөвлөлтөд хамрагдаж шинээр үйлчилгээний төвтэй, **135** айлын орон сууц баригдаж ашиглалтад орохоор байна.

Даланзадгад сумын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 13 га талбайд мод, бут, зүлэгжүүлэлтийн ажлыг шинээр хийж нийт 40 талбайн арчилгаа хамгаалалтын ажлыг хийж байна.

Сэврэй, Мандал-Овоо, Манлай, Номгон, Ноён сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах ажлыг зохион байгуулж ашиглалтад оруулсан байна. Шугам сүлжээний ажил ашиглалтад орсноор аймгийн бүх сумд цэвэр бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжтай болсон байна.

Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хадны суурьшлын бүсийн дахин төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, анх удаа газар өмчлөх, эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж, цахилгааны эрчим хүчээр хангах ажлыг орон нутгийн төсвөөс 2.6 тэрбум төгрөгөөр барьж байгуулжээ. Мөн ерөнхий төлөвлөгөөний дагуу хатуу хучилттай автозам, цахилгааны тараагуур шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгэж байна.

Баян-овоо, Баяндалай, Цогт-Овоо сумдын төвд хөгжлийн төлөвлөгөөний дагуу нийтийн эзэмшлийн ногоо байгууламж бүхий талбайг барьж байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Сумдад сургууль, цэцэрлэгийн барилгыг барьж байгуулж байна. Тухайлбал: Баян-Овоо, Цогт-овоо 320 хүүдийн сургууль, Цогтцэций 960 хүүхдийн сургууль, Манлай 100 хүүхдийн цэцэрлэг, Ноён, Номгон, Баяндалай сумдад соёлын төвийн барилгыг барьж ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Мөн 3, 4 дүгээр сургуулийн урлаг заалыг барьж байна. 9 сард 4 дүгээр сургуулийн урлаг заалыг ашиглалтад оруулжээ.

3. /13/ Булган суманд 2019 оны 06 сарын 16-ны өдөр 1 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулж 9220000 төгрөгийг төвлөрүүлсэн. Цогтцэций суманд давхардсан тоогоор 24 нэгж талбарыг дуудлага худалдаагаар олгохоор арга хэмжээ зохион байгуулж 13 нэгж талбараас 79,2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

4. /18/ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш аймаг, сумын Засаг даргын захирамжаар 38367 иргэнд 2938.66 га газрыг өмчлүүлсэн ба үүнээс 2857 иргэнд хуучин эзэмшиж байсан 248.95 га, 35483 иргэнд шинээр 2669.63 га газрыг тус тус үнэгүй, 27 иргэнд 20.08 га газрыг газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр үнээр нь өмчлүүлсэн байна. 2019 онд аймаг, сумын Засаг даргын захирамжаар 3797 иргэнд 284,21 га газрыг өмчлүүлсэн ба үүнээс 9 иргэнд хуучин эзэмшиж байсан 0,62 га, 3788 иргэнд шинээр 283,59 га газрыг тус тус үнэгүй өмчлүүлсэн байна.

5. /32/ Сумдын эрчим хүчний эх үүсвэрийн насжилт, хүчин чадал, өнөөгийн байдал, цаашдын хэрэгцээнд тулгуурлан энэ онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Даланзадгад дулааны цахилгаан станцын 1-р контурын магистраль шугамын өргөтгөл”-ийн ажлыг 407,41 м урт 984,2 сая төгрөгийн төсөвт өртгөөр “МЭЗ” ХХК, Цогтцэций сумын 2000МВт-ийн хүчин чадалтай хагас автомат уурын зуухны барилга, зуух суурилуулах барилга угсралтын ажлыг 923,2 сая төсөвт өртгөөр “Шүтээн-Эрдэнэ” ХХК, Баян-Овоо сумын 2000МВт-ийн хүчин чадалтай хагас автомат уурын зуухны барилга, зуух суурилуулах барилга угсралтын ажлыг 901,8 сая төсөвт өртгөөр “Шүтээн-Эрдэнэ” ХХК, Мөн “Даланзадгад сумын төвийн дулааны шугамыг өргөтгөх багц №1”, “ЦТП-7-ын өргөтгөл”-ийн барилга угсралтын ажлыг 503,5 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Сан” ХХК, “Даланзадгад сумын төвийн дулааны шугамыг өргөтгөх багц №2” 8-р баг Аргалант хороолол, 1-р багийн төвийн барилгын “Гадна дулааны шугамын өргөтгөлийн ажил” 1-р баг 209.5 м урт, 8-р баг 502.9 м урт гадна дулааны шугамын барилга угсралтын ажлыг 577,3 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Нэкт стандарт” ХХК, Даланзадгад сумын “Шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажил” Ф133-219 мм-ийн голчтой 1106 м, ус хангамжийн шугам: Ф57-133 мм-ийн голчтой 1698 м, Ариутгах татуургын шугам: Ф200-300 мм-ийн голчтой 2552 м шугам сүлжээний барилга угсралтын ажлыг 1,9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр “Набсан” ХХК тус тус хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй нийт 11 арга хэмжээ байна.
Үүнд:

1. /17/ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулах;

2. /36/ “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”- ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэрэлтүүлэг, хэрэглээний халуун усны хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр хангах загвар төслүүдийг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах ажлыг зохион байгуулж, орон нутгаас дэмжлэг үзүүлж ажиллах, ажлын үр дүнг тайлагнах;

3. /39/ Монгол Улсын Их хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалт “орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах”;

4. /45/ Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах /дэлгэрүүлж сайдын тушаалыг оруулах/;

5. /50/ Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх – 56 дах заалт;

6. /53/ Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

7. /59/ “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

8. /67/ Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, тайлагнах;

9. /8/ Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, эсхүл хэлтсийн даргаар томилон ажиллуулах;

10. /10/ Хот, суурин газрын төлөвлөлт болон дахин хөгжүүлэх төслийг боловсруулах, хэрэгжүүлэх сургалтад сумдын Засаг дарга, ИТХ, аймаг, сумын ЗДТГ-ын удирдлагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулах;

11. /48/ Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл болон Хөдөлмөрийн яамны "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан"-гийн зээлд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн ажлын тайланг гаргах.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Гэрээний 50, 56 дугаар заалт хоёр өөр шалгууртайгаар давхардаж тусгагдсан байсан тул нэг арга хэмжээгээр тооцож үнэлгээг өгсөн.

Санал, зөвлөмж:

1. Тайлан мэдээ гаргахдаа гэрээнд заасан арга хэмжээ бүрийг тоон болон чанарын үзүүлэлттэй нь уялдуулах, ямар байсныг ямар түвшинд хүргэсэнээ харьцуулж тайлагнаж хэвших. Тухайлбал: /21/Өмнөговь аймагт 1814 ширхэг геодезийн цэг, тэмдэгт байдаг. Тоолох, бүртгэлжүүлэх явцад устсан, гэмтсэн бол ямар арга хэмжээ авсан талаар эсхүл авах талаар тодорхой мэдээлэл байхгүй. Мөн /27/ 2018 оны үр дүнг ашиглан бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал болон бэлчээрийн экологийн чадавхийн зураглалыг шинээр хийсэн эсэх талаар тайланд бичээгүй. /51/ “Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн хэмжээнд осол, гэмтлийн тоо буурч, хөтөлбөрийн зорилт хангагдана гэсэн шалгуур үзүүлэлттэй байхад хэд байсан осол, хэд болж буурсан талаарх мэдээлэл байхгүй. Энэ арга хэмжээний тайланг хэнд, хэзээ, ямар хэлбэрээр илгээсэн тухай дурдаагүй байна.

2. Өмнөговь аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот байгуулалтын чиглэлээр 2 арга хэмжээ, газрын харилцааны чиглэлээр 1 арга хэмжээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 5 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 1 арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн чиглэлээр 1 арга хэмжээ, бусад чиглэлээр 1 арга хэмжээ 30 хувийн хэрэгжилттэй болон хэрэгжээгүй эдгээр 11 арга хэмжээний биелэлтийг нягтлан үзэж 2020 оны үр дүнгийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

13. Дорноговь аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 69 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 49 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 9 арга хэмжээ хэрэгжих шатанд 70 хувьтай, 2 арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй 30 хувьтай байна. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай арга хэмжээ 9 байна. Хэрэгжилтийн дундаж хувь- **83,5%** байна.

Хүснэгт 2

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо				үнэлэх боломжгүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%		
Хот байгуулалтын чиглэлээр	78,3%	8	2	-	2	-	12
Газрын харилцааны чиглэлээр	86,3%	15	2	-	2	-	19
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	74,7%	11	2	1	3	-	17
Нийтийн аж ахуйн чиглэлээр	81,8%	8	1	1	1	-	11
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	80%	5	2	0	1	-	8
Бусад	100%	2	-	-	-	-	2
Дүн/Дорноговь/	83,5%	49	9	2	9		69

БХБСайд, Дорноговь аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /4/ Сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж бүсүүдийг тодорхой тусгасны дагуу зураг төслийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар боловсруулсан. Уг төлөвлөлтийг сумдын газар зохион байгуулалтын нийтийн эдэлбэрийн газрын төлөвлөлтөд тусган Даланжаргалан суманд 0.26 га газарт төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор цэцэрлэгт хүрээлэн, Дэлгэрэх суманд 0.8 га газарт “Дорноговь их хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэн, Сайншанд суманд 0.795 га газарт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Буянт Ухаа цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулж, Дунд усны цэцэрлэгт хүрээлэнг өргөтгөж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нийт 10000 гаруй модоор нэмэгдүүлсэн байна.

2. /13/ Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд байгууллагын эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгүүдийн доорх газрын эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулалтын ажлыг хийж, газрын хэмжээ зөрүүтэй 116, мэдээллийн санд бүртгэгдээгүй 36 нэгж талбарын мэдээллийг мэдээллийн санд оруулсан байна. 2003-2017 оны хооронд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4 дэх заалтыг зөрчин Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайншанд, Өргөн, Хатанбулаг сумын 34 иргэнд давхардуулан олгосон газрын захирамжийн холбогдох заалтыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр хүчингүй болгосон. Аймгийн хэмжээнд

нийт 32915 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газрын улсын бүртгэлд бүртгэгдсэнээс 2019 оны жилийн эцсийн байдлаар 28702 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газрыг газрын кадастрын Лэнд менежер програм хангамжид бүртгэсэн байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 11 арга хэмжээ байна. Үүнд:

1. /46/ Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;
2. /59/ Орон сууцны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан заалтыг хэрэгжүүлэх;
3. /9/ Аймаг, Нийслэлийн ерөнхий архитекторыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, эсхүл хэлтсийн даргаар томилон ажиллуулах;
4. /10/ Аймаг, Нийслэл, хотын ерөнхий архитекторын томилгоонд хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн, мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй архитектор буюу мэргэжлийн хүнийг томилон ажиллуулах;
5. /24/ Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах;
6. /28/ Бэлчээрийн газрыг мониторингийн аргаар үнэлэх ажлын 2018 оны үр дүнг ашиглан аймгийн бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал болон бэлчээрийн экологийн чадавхийн зураглалыг шинээр хийх;
7. /33/ Аймаг, сум, суурин газруудын одоогоор ашиглагдаж байгаа инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийн тоо хэмжээ, өнөөгийн байдлын судалгааг хийж ашиглалтын түвшинг тогтоох;
8. /51/ Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх;
9. /53/ Барилгын ажил түр зогсох хугацаанд барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангах, барилгын бүрэлдэхүүн хэсгийг эвдэрч гэмтэхээс хамгаалах, барилгын ажлыг үргэлжлүүлэх нөхцөл бүрдүүлэх үүднээс аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран үзлэг шалгалт тогтмол зохион байгуулах;
10. /54/ Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийг бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж ажиллах;
11. /61/ “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;-зэрэг ажлууд байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Санал зөвлөмж:

Дорноговь аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот байгуулалтын чиглэлээр хэрэгжээгүй 2 арга хэмжээ, газрын харилцааны чиглэлээр хэрэгжээгүй 2 арга хэмжээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 1 арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувь, хэрэгжээгүй 3 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 1 арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй 30 хувь, 1 арга хэмжээ хэрэгжээгүй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр 1 арга хэмжээ хэрэгжээгүй байгаа тул эдгээр 11 арга хэмжээний биелэлтийг нягтлан үзэж 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

14. Дундговь аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 48 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 67 арга хэмжээний 62 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 3 арга хэмжээ 70 хувьтай, 1 арга хэмжээ 30 хувьтай байна. Хэрэгжүүлээгүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж хувь- **95%** байна.

Хүснэгт 3

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					үнэлэх боломжгүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%			
Хот байгуулалтын чиглэлээр	100%	11	-	-	-	-	11	
Газрын харилцааны чиглэлээр	98,3%	17	1	-	-	-	18	
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	100%	17	-	-	-	-	17	
Нийтийн аж ахуйн чиглэлээр	71,4%	7	2	1	1	-	11	
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	100%	8	-	-	-	-	8	
Бусад	100%	2	-	-	-	-	2	
Дүн /Дундговь/	95%	62	3	1	1	-	67	

БХБСайд, Дундговь аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /3/ Мандалговь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг тусгагдсан ажлуудаас 3000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэнгийн барилга угсралтын ажлын үргэлжлэл 500 сая төгрөг батлуулсан. /Зураг- 3.1/

Мөн дулааны 2 дугаар хэлхээний шугмын ажлын зураг төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээний зардал 150 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд тусгуулж батлуулсан. 3000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэнгийн барилга дуусгалтын ажилд 2019-2020 онд 2,0 тэрбум төгрөг батлуулснаас 2019 онд 1,0 тэрбум төгрөгөөр санхүүжинэ. Мандалговь хотын Айраг, Мандал багийн баруун талаар 2,8 км хатуу хучилттай авто зам

барих ажил 2019-2020 онд 2.2 тэрбум төгрөг батлуулснаас 2019 онд 1,2 тэрбум төгрөгөөр санхүүжинэ. /Зураг- 3.2/ : Мандалговь хотын 6/0,4кВ-ын шинэчлэлтийн ажилд 6/0.4 кВ-ын 250 кВа-ын дэд станц 4ш-ийг шинэ суурьшлын бүсэд, дэд станцын өргөтгөл 7ш, 0.4 кВ-ын ЦДАШ-55км, 6кв-ын ЦДАШ-24.1км, 6 кв-йн ЦДАКШ-5.5км-ыг 2018 онд дэлхийн банкны 2.15 сая.долларын хөрөнгөөр хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, ажлын зургийг боловсруулсан. Аймгийн төвийн шинээр баригдах 6,9 тэрбум төгрөгийн төсөвтэй хоногт 3000м³ хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж, 1.6 тэрбумын төгрөгийн төсөвтэй гэр хорооллын 5.57км ариутгах татуургын шугам нийт 8,5 тэрбум төгрөгийн ажлыг Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. /Зураг- 3.3/

Бүгд Найрамдах Солонгос Улсын “Экспорт Импорт” банкны хөрөнгөөр аймгийн төвд дулааны станцын 9,3 сая ам.долларын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн ажлын зургийг боловсруулж байна. /Зураг- 3.4, 3.4.1/

2. /4/ БНСУ-ын Гуяан хот, “Ногоон Ази” ОУТББ-тай хамтран Мандалговь хотын баруун хойд талаар тусгай зориулалтын ногоон байгууламж бий болгох элсний нүүдэл, салхины хурдыг бууруулахаар өмнөх онуудад 100 га талбайд мод тарьсан. Усалгааны систем нь гүний худаг, зохиомол цөөрмөөс усалгаа хийгдэж уст цэгээс алслагдсан хэсгийн ургалтын хэмжээ бага байсныг нэмэгдүүлэхээр цэвэр усны төвлөрсөн системд холбох ажлыг орон нутгийн 119,476,422 төгрөгөөр санхүүжүүлж хүлээн авсан. Ингэснээр дуслын системээр усалгаа хийх нөхцөл бүрдсэн. /Зураг- 4.1/

Аймгийн төвийн авто замын дагуу тохижилт ногоон байгууламжийн ажлыг улсын төсвийн 278,8 сая төгрөгөөр гүйцэтгэж байна. /зураг-4.2, 4.2.1/

Орон нутгийн 6 сая төгрөгөөр Сайхан-Овоо суманд 2 га, Цагаандэлгэр суманд 1га талбайд ногоон байгууламж, улсын төсвийн 30 сая төгрөгөөр Гурвансайхан суманд 3.5 га талбайд цэцэрлэгт ногоон байгууламж бий болсон. Мөн аймгийн хэмжээнд аж ахуй нэгж, иргэд нийт 15000 ширхэг модны суулгацыг тарьсан байна.

3. /12/ “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” гэрээт ажлын гүйцэтгэгчийн хүлээлгэж өгснөөс хойшхи өөрчлөлт болон нэмэгдсэн мэдээллийг программ хангамжид нөхөн оруулах ажлын хүрээнд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 9 дүгээр сарын 23-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд 15 сумын Газрын даамлуудыг аймгийн төв дээр ажиллуулж нөхөн бүрдүүлэлтийн ажлыг хуваарийн дагуу цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Аймгийн хэмжээнд аймаг, сумын Засаг даргын захирамжаар нийт 20815 нэгж талбарыг өмчлөл, эзэмшил, ашиглалтын зориулалтаар олгосон байна. Үүнээс газар эзэмших эрхтэй 6027 нэгж талбар, өмчлөх эрхтэй 14770 нэгж талбар, ашиглах эрхтэй 18 нэгж талбар мэдээллийн санд оруулж, нэгж талбар бүрээр нь төлбөр, татварын ногдуулалтыг хийж гүйцэтгэсэн. Мөн иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа газрын хэмжээ зөрүүтэй нэгж талбарын зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулж аймаг, сумын Засаг даргын захирамжаар 118 иргэн, аж ахуй нэгж, байгууллагын газрын талбайн хэмжээг өөрчлөн зөрчлийг арилгаж ажилласан байна.

4. /45/ Сайнцагаан сумын Залуус хорооллын гадна дулаан, цэвэр, бохир усны шугам, холбоо, цахилгааны шугам сүлжээний барилга угсралтын ажлыг “Б-Софт” ХХК 2,919 тэрбум

төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2019 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. /Зураг-45.1/ Мандалговь хотын 1,2 км үерийн далан байгууламжийн барилга угсралтын ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр “Химон констракшн” ХХК 1,424 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүлээлгэн өгсөн. /Зураг-45.2/ Дэрэн сумын 320 суудалтай сургуулийн барилга угсралтын ажлыг “Бум констракшн” ХХК 1,273 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. /Зураг-45.3.1, 45.3.2/ Сайнцагаан суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг “Монгол дээвэр” ХХК 895.8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдөр байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. /Зураг-45.5/ Баянжаргалан сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг “Ай И Би” ХХК 950.65 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. /Зураг-45.6/ Эрдэнэдалай сумын 22 ортой сум дундын эмнэлгийн барилга угсралтын ажлыг “Төсөв төсөл” ХХК 1,255 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд 2019 оны 12 дугаар сарын байдлаар дотор заслын ажлууд хийгдэж байна. Ажлын явц 92 хувийн гүйцэтгэлтэй. 2019 онд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. /Зураг-45.8/ Эрдэнэдалай сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг “Батлюкс” ХХК, “Боржин суварга” ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдөр байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. /Зураг-45.9/

Алслагдсан сумдын шилэн кабелийн сүлжээ Өлзийт сумын шилэн кабелийн сүлжээний барилга угсралтын ажлыг “Мон кабель системс” ХХК 580.7 сая төгрөгөөр, Дэлгэрхангай сумын шилэн кабелийн сүлжээний барилга угсралтын ажлыг “Нотсан” ХХК 478.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр тус тус гэрээ байгуулан 2019 оны 10 сард ашиглалтад хүлээлгэн өгсөн. Аймгийн Цагдаагийн газрын конторын барилгын угсралтын ажлыг “Ванхүү” ХХК 1,849 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. /Зураг-45.11/ Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн спорт тоглоомын талбайн тохижилтын ажлыг “Мандал шилтгээн” ХХК 178.19 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2019 оны 12 дугаар сарын 9-ний өдөр ашиглалтад оруулсан. /Зураг-45.16/ Дээрх барилга угсралтын ажлуудад нийт 152 удаагийн захиалагчийн хяналт гүйцэтгэж, тайланг жилийн эцсийн байдлаар Барилгын хөгжлийн төвд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 1/518 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. /61/ Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-дс “Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан.

УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрт 2020 хүртэлх хугацаанд “... хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтыг дэвшүүлсэн.

2. /59/ “Түрээсийн орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “бүрэн хэрэгжсэн” буюу үр дүн гарсан гэж дүгнэв.

Гэрээний 49, 55 дугаар заалт хоёр өөр шалгууртайгаар давхардаж тусгагдсан байсан тул нэг арга хэмжээгээр тооцож үнэлгээг өгсөн болно.

Санал зөвлөмж:

Дундговь аймгийн хувьд нийтийн аж ахуйн чиглэлээр 1 арга хэмжээ хангалтгүй буюу 30%тай, 1 арга хэмжээ хэрэгжээгүй байгаа тул эдгээр 2 арга хэмжээний биелэлтийг нягтлан үзэж 2020 оны төлөвлөгөөнд тусгуулж ажиллах шаардлагатай байна. Ялангуяа “Түрээсийн орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

15. Говьсүмбэр аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 49 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 67 арга хэмжээний 47 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 7 арга хэмжээ 70 хувьтай, 4 арга хэмжээ 30 хувьтай, 8 арга хэмжээг хэрэгжүүлээгүй буюу 0 хувь, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж хувь-71,3% байна.

Хүснэгт 4

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо				Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%		
Хот байгуулалтын чиглэлээр	70,1%	7	2	-	2	-	11
Газрын харилцааны чиглэлээр	93,2%	17	1	-	1	-	19
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	85,6%	13	1	-	2	1	17
Нийтийн аж ахуйн чиглэлээр	57,3%	5	1	2	3	-	11
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	91,4%	5	2	-	-	-	7
Бусад	30%	-	-	2	-	-	2
Дүн/Говьсүмбэр/	71,3%	47	7	4	8	1	67

БХБСайд, Говьсүмбэр аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /25/ Сумдын Засаг даргаар фото мониторингийн өөрчлөлтийг хээрийн аргаар үнэмлэх ажлыг сумдын газрын даамлуудтай хамтран 2019 оны 08 дугаар сарын 01-11-ний өдрүүдэд зохион байгуулсан байна. Тус ажлын хүрээнд 21 бэлчээр ашиглалтын хэсгийн 43 цэгийн 26 хэсгээс ургамлын дээж авч, орчны 172 фото зураг, метрийн заалттай буюу бүрхэцийн 387 фото зураг, нийт 559 фото зураг, хээрийн судалгааг ашиглан гүйцэтгэсэн.

Хээрийн судалгааны ажлын тайланг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01/428 тоот бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газарт хүргүүлсэн байна.

2. /35/ 2019-2020 онд 240 айлын орон сууц барихаар төлөвлөж, 1000 айлын орон сууцны шугам сүлжээний зураг төсвийн дагуу гадна бохирын шугам сүлжээний ажлыг улсын төсвийн 300.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авсан байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 12 арга хэмжээ байна. Үүнд:

1. /7/ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдаж батлагдах Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааг журмын төсөл, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журмын төсөлд санал өгөх;

2. /9/ Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын томилгоонд хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн, мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй архитектор буюу мэргэжлийн хүнийг томилон ажиллуулах;

3. /22/ Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах;

4./48/ Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх, сурталчилах, сургалт зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

5./49/Аймаг, нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдаж байгаа машин менизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх;

6./59/ “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

7. /63/ Шивээговь сумын хүн амыг баталгаат ундны усны эх үүсвэртэй болгох;

8. /66/ Баянтал сумын хүн амын ундны ус хангамжийг сайжруулах;

9. /57/ Орон сууцны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан заалтыг хэрэгжүүлэх;

10. /64/ Сумдын хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр Шивээговь, Баянтал зэрэг суманд хүн амын хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламжтай болох асуудлыг орон нутгийн түвшинд шийдвэрлэх;

11./67/ Нийтийн зориулалттай бүх барилга байгууламжуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах ажлыг тогтмол зохион байгуулж тайлагнах;

12./68/ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар салбарын жөндөрийн бодлогыг хэрэгжүүлж, тайлагнах;

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Гэрээний 49, 55 дугаар заалт хоёр өөр шалгууртайгаар давхардаж тусгагдсан байсан тул нэг арга хэмжээгээр тооцож үнэлгээг өгсөн.

Санал, зөвлөмж:

1. Говьсүмбэр аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот байгуулалтын чиглэлээр 2 арга хэмжээ, газрын харилцааны чиглэлээр 1 арга хэмжээ, барилга барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 2 арга хэмжээ, нийтийн аж ахуйн чиглэлээр 5 арга хэмжээ, бусад ажлын чиглэлээр 2 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй /30%/ буюу түүнээс доош үнэлгээтэй байгаа тул эдгээр 12 арга хэмжээг нягтлан үзэж 2020 оны гэрээнд тусгаж, хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

16. Төв аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 49 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 66 арга хэмжээний 51 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 10 арга хэмжээ 70 хувьтай, 3 арга хэмжээ 30 хувьтай, 2 арга хэмжээг хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай байна. Хэрэгжилтийн дундаж хувь- **93%** байна.

Хүснэгт 5

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо				Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%		
Хот байгуулалтын чиглэлээр	94,5%	9	2	-	-	-	11
Газрын харилцааны чиглэлээр	80%	11	6	-	2	-	19
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	85%	13	2	3	-	-	18
Нийтийн аж ахуйн чиглэлээр	100%	8	-	-	-	-	8
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	100%	8	-	-	-	-	8
Бусад	100%	2	-	-	-	-	2
Дүн /Төв/	93%	51	10	3	2	-	66

БХБСайд, Төв аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /2/ 2019 оны байдлаар нийт 22 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдан хэрэгжиж байна. Аргалант, Баянхангай сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.08.06-ны 91, 92 дугаар тогтоолоор батлагдсан. 2019 онд үлдсэн 5 сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр Архуст суманд “Эрхэт констракшн” ХХК, Мөнгөнморьт суманд “Эм Эм архитектур” ХХК, Баянцагаан, Өндөрширээт сумдад “Инженер геодези” ХХК-иуд шалгаран гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер дахин зарлагдаж, гүйцэтгэгчээр “Өрх” ХХК шалгаран гэрээ байгуулж, ажил эхэлсэн. Уг ерөнхий төлөвлөгөө боловсруулах шатанд суманд судалгаа, үнэлгээ боловсруулалт хийгдэн иргэд олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг Баянцагаан, Өндөрширээт сумдад судалгааны түвшинд 07-р сарын 31, 08-р сарын

08-нд, төлөвлөлтийн шатанд 09-р сарын 05- 08-ны өдүүдэд зохион байгуулсан. Архуст суманд 10-р сарын 17-нд зохион байгуулан ажилласан байна.

Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1000 айлын хорооллын дэд бүтэц байгуулах ажлын хүрээнд дэд бүтцийн ажлууд, 276 айлын орон сууцны барилга, 100 хүүхдийн цэцэрлэг баригдаж ашиглалтад орсон. 2019 онд 640 сурагчтай сургуулийн барилга, 270 айлын орон сууцны барилгууд баригдаж байна.

Зуунмод хотын шинэ дэд төвийг байгуулахаар нийт 20 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдан эхний ээлжийн шугам сүлжээ, авто зам байгуулж, 5 барилга ашиглалтад орж, 3 барилга баригдаж байна.

2 дахь ээлжийн 2000 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-аар Тэрүүлэгчдийн 2019 оны 89 дүгээр тогтоолоор батлуулсан.

Зуунмод сумын “Соёл амралтын хүрээлэн” цогцолбор байгуулах ажил 2017 онд 815,3 сая төгрөг, 2018 онд 599,8 сая төгрөг, 2019 онд 558,0 сая төгрөгөөр тохижилтын ажлууд хийгдсэн байна. Зуунмод сумын Зуунмод гол дагуух цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил нь 2017- 2018 онд дамжин хийгдэж, 483,8 сая төгрөг зарцуулсан. 6,7 га талбайд нийтийн амралтын бүс, ногоон байгууламж, цөөрөм байгуулагдсан.

Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу эхний ээлжинд дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг байгуулах ажил хийгдэж байна.

Аймгийн хэмжээнд 27 сум бүгд төвийн нэгдсэн цахилгаан хангамж, холбоо мэдээлийн сүлжээнд бүрэн холбогдсон.

10 сум хатуу хучилттай авто замаар холбогдсон буюу авто зам дагуу байрласан байна.

2./35/ Зуунмод хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу эхний ээлжийн 1000 айлын хороололд 846 айлын орон сууц 100 хүүхдийн цэцэрлэг, 640 хүүхдийн сургууль байгуулагдахаар төлөвлөгдсөн. Инженерийн хангамжийн дэд бүтэц байгуулах ажилд улсын төсвийн хөрөнгө оруулалаас 7,8 тэр бум төгрөгийг зарцуулсан. 2019 оны байдлаар 276 айлын орон сууцны барилга, 100 хүүхдийн цэцэрлэг баригдаж ашиглалтад орсон.

3. /43/ Монгол улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд шинээр ашиглалтад орж байгаа барилга байгууламжийн ашиглагч нарт зөвлөмж чиглэл өгөн, ажиллаж 2019 онд шинээр ашиглалтад орсон 14 барилга байгууламжид ногоон гэрчилгээ, 6 барилгад улаан гэрчилгээ олгосон байна. Мөн 315 барилга байгууламжуудад хувийн хэрэг хөтлүүлэн ажлаж байна.

Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 78 төсөл арга хэмжээг 27,01 тэр төгрөг зарцуулахаар батлагдсан. Үүнээс:

Сургуулийн барилга шинээр баригдах Цээл, Бүрэн, Батсүмбэр, Зуунмод сумдад сургуулийн барилгыг барьж дуусгасан. Баян-Өнжүүл, Жаргалант сумдын цэцэрлэгийн барилгуудыг ашиглалтад хүлээлгэн өгсөн. Их засварын ажил болох Зуунмод Унагалдайн

андууд, Бүжинхэн цэцэрлэгийн А, Б байр, Мөнгөнморьт сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг дуусгаж хүлээлгэн өгсөн.

Эрдэнэ, Батсүмбэр, Баяжаргалан сумдын дотуур байрны барилга ашиглалтад орсон. Сүмбэр, Баянжаргалан сумдын дотуур байрны барилгын их засварын ажлыг дуусгаж, хүлээлгэн өгсөн.

Эрүүл мэндийн төв шинээр баригдах Заамар сумын Хайлааст багт эрүүл мэндийн төвийн барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Их засвар ажил болох Баян-Өнжүүл ЭМТ-ийн өргөтгөл, их засварын ажил хийгдэж хүлээлгэн өгсөн.

Аргалант сумын ЗДТГ-ын барилгыг ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Баянцогт, Алтанбулаг сумдын спорт цогцолборын барилга, Дэлгэрхаан, Мөнгөнморьт, Баяндэлгэр сумдын Соёлын төвийн барилгыг ашиглалтад өгсөн байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ байна. Үүнд:

1. /39/ “Монгол Улсын Их хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Г азар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалт “орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах”;

2. /47/ Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.11 дэх заалт Барилга, хот байгуулалтын Сайддын 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/193 тоот тушаалаар батлагдсан “Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм”-ийг орон нутгийн барилгын материалын лабораторийн онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

3./53/ Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийг бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

4./19/ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.4-ийн зорилтын 5 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг орон нутагтаа зохион байгуулах, шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэх талаар сумын засаг дарга нартай хамтран ажиллаж шийдвэрлэх ;

5. /23/ Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах 2019 онд тооллого хийж байгаа аймгуудаас бусад нь /Дундговиос бусад нь/;

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “бүрэн хэрэгжсэн” буюу үр дүн гарсан гэж дүгнэв.

Санал, зөвлөмж:

1. Төв аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын харилцааны чиглэлээр 2 арга хэмжээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 3 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй /30%/ буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээг нягтлан үзэж 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

2. Цаашид тайлан мэдээ ирүүлэхдээ үг үсэг, утга найруулгын алдаагүй, тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар фото мэдээлэл, холбогдох баримтыг хавсаргаж байхыг анхаарах нь зүйтэй.

17. Дархан-Уул аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 47 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 67 арга хэмжээний 41 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 19 арга хэмжээ 70 хувьтай, 1 арга хэмжээ 30 хувьтай байна. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай арга хэмжээ 2, хугацаа болоогүй 4 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж **-88,4** хувьтай байна.

Хүснэгт 6

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%			
Хот байгуулалтын чиглэлээр	76,3%	6	3	-	2	1	12	
Газрын харилцааны чиглэлээр	83,5%	9	7	1	-	2	19	
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	84,4%	11	6	-	-	-	17	
Нийтийн аж ахуйн чиглэлээр	100%	8	-	-	-	1	9	
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	88,8%	5	3	-	-	-	8	
Бусад	100%	2	-	-	-	-	2	
Дүн /Дархан-Уул/	88,4%	41	19	1	2	4	67	

БХБСайд, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /4/ Хот суурин газруудын ногоон байгууламжийг ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусган төлөвлөн хэрэгжүүлэх, ногоон байгууламжийн тоо, хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх хүрээнд Дархан-Уул аймгийн төв Дархан хотыг 2020-2035 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Үүнд:

> Нийтийн хэрэгцээний бүс 588 га

- > Хамгаалалтын ногоон бүс 2609 га
- > Тусгай хамгаалалтын бүс /хогийн цэг, оршуулгын газар/ 568.9 га

Мөн нөөц нутаг дэвсгэрт:

- > Нийтийн хэрэгцээний ногоон бүс 165 га
- > Хамгаалалтын ногоон бүс 14.3 га байхаар тусгуулсан байна.

Хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд:

- “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнгийн 8,4 га талбайг шинээр цэцэрлэгжүүлж тохижуулан 5-н нэр төрлийн атракцион тоглоомууд байрлуулж,
- Дархан сумын 8-р багийн нутагт 3,5 га талбайд ногоон байгууламж байгуулах зураг төсөл хийж 900 метр хашаа барьж 500 ш мод тарьж усалгааны системтэй болгож, сүүдрэвч, хогийн сав, сандал явган замаар гадна тохижилтын зарим ажпуудыг тус тус гүйцэтгэсэн байна.

2. /14/ Аймгийн хэмжээнд нийт 22 байршлыг газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын дагуу зарласан үүнээс 8 нэгж талбар зарагдаж нийт 174,909,600 төгрөг, дуудлага худалдааны анхны үнэ 16,403,200 төгрөгийг тус тус орон нутгийн төсөвд төвлөрүүлсэн байна. Аймгийн хэмжээнд 2019 оны 01-А/118, захирамжаар нийт 42 нэгж талбарыг газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан байна. Үүнээс аймаг, сумын Засаг даргын 2019 оны 01-А/210, захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж ирсэн төслүүдийг журмын дагуу хүлээн авч 38 төслийг сонгон шалгаруулалтаар шалгаруулж аймгийн Засаг даргын 2019 оны 01-А/269 дугаар захирамжаар газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээг байгуулжээ.

3. /58/ БХБСайдын 2016 оны А/193 дугаар тушаалаар “Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм”-ийн дагуу Дархан ШУТИС лаборатори, Дархан Төмөрлөгийн үйлдвэрийн лабораторийг тус тус баталгаажуулж дүрмээ шинэчлэн баталсан. Төмөр бетон эдлэл, бетон зуурмаг, элс хайрга, дайрга, барилгын төмөр материалууд 100 хувь лабораторын шинжилгээнд хамрагдаж байна.

Дархан-Уул аймаг дахь ШУТИС нь нийт 35 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр 140 гаруй нэр төрлийн шинжилгээ хийж байна. Үүнд:

- Барьцалдах материалын Физик механик шинж чанар
- Бетон, Төмөр бетон, Бетон хольц, Бетон зуурмагын Физик механик шинж чанар
- Барилгын керамик материал
- Бүх төрлийн дүүргэгч материал
- Дуу тусгаарлах материал
- Барилгын хуурай хольц г.м

ШУТИС -ийн лаборатори нь 2019 оны эхний хагас жилийн байдлаар 12 ААНБ-ын хүсэлтээр 5 нэр төрлийн бүгээгдэхүүнд 19 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Түүнчлэн 3 бетон зуурмагын үйлдвэрийн дэргэд өөрсдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний хяналтын лабораторийг ажиллуулж байна. /Сонголон хайрхан ХХК, Их торгоны зам ХХК, Стандарт стилл ХХК/

Дархан Минж ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр нь үйлдвэрлэсэн бетоны чанарын үндсэн үзүүлэлтийг тодорхойлох иж бүрэн лаборатори байгуулж, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангажээ. Мөн Сонголон хайрхан ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр, Си Эм Пи Ай ХХК-ийн хүчитгэсэн төмөр бетон тулгуурын үйлдвэр, Эко ноос ХХК-ийн дулаалгын материалын үйлдвэрүүд өөрсдийн лаборатори байгуулан бүтээгдэхүүнд чанарын хяналтыг хийж байна. Аймгийн хэмжээнд нийт итгэмжлэгдсэн 2, бетоны 3 хяналтын лаборатори ажиллаж байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ байна. Үүнд:

1. /19/ 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2. /9/ Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, эсхүл хэлтсийн даргаар томилон ажиллуулах;

3. /10/ Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын томилгоонд Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн, мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй архитектор буюу мэргэжлийн хүнийг томилон ажиллуулах; зэрэг ажлуудын биелэлт хангалтгүй байна.

Хугацаа болоогүй 4 арга хэмжээ байна. Үүнд:

1. /1/ Хот байгуулалтын тухай хуулийн 9.1.6-д заасны дагуу хот байгуулалтын чиглэлээр хийгдсэн ажлын талаарх тайланг жил бүр хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх;

2. /17/ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3. /21/ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, 2020 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх хүсэлтийн хамт аймгийн ИТХ- аар хэлэлцүүлэн, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 2019 оны 12 дугаар сарын 5-ны дотор хүргүүлэх;

4. /60/ “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх- зэрэг ажлуудын биелэлт хангалтгүй байна.

Дүгнэлт:

1. Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

2. Гэрээний 51, 57 дугаар заалт хоёр өөр шалгууртайгаар давхардаж тусгагдсан байсан тул нэг арга хэмжээгээр тооцож үнэлгээг өгсөн.

Санал, зөвлөмж:

1. Дархан-Уул аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот байгуулалтын чиглэлээр 2 арга хэмжээ хэрэгжээгүй, 1 арга хэмжээний хугацаа болоогүй, газрын харилцааны чиглэлээр 2 арга хэмжээний хугацаа болоогүй, нийтийн аж ахуйн чиглэлээр 1 арга хэмжээ хугацаа болоогүй байгааг тус бүр нягтлан үзэж 2020 гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

2. Цаашид тайлан мэдээ ирүүлэхдээ үг үсэг, утга найруулгын алдаагүй, тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар фото мэдээлэл, холбогдох баримтыг хавсаргаж байхыг анхаарах нь зүйтэй.

18. Сэлэнгэ аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 68 арга хэмжээний 42 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 20 арга хэмжээ 70 хувьтай, 3 арга хэмжээ 30 хувьтай байна. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай арга хэмжээ 3 байна. Хэрэгжилтийн дундаж -83,5 хувьтай байна.

Хүснэгт 6

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Дүн тоо
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Хот байгуулалтын чиглэлээр	83,3%	9	1	1	1	-	12
Газрын харилцааны чиглэлээр	94%	16	4	-	-	-	20
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	82,2%	11	5	1	1	-	18
Нийтийн аж ахуйн чиглэлээр	56,3%	0	6	1	1	-	8
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	85%	4	4	-	-	-	8
Бусад							
Дүн /Сэлэнгэ/	83,5%	42	20	3	3	-	68

БХБСайд, Сэлэнгэ аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1./4/ Сүхбаатар сумын 5 дугаар багт аймгийн төв цэцэрлэгт хүрээлэн байгуулах зорилгоор 100 га газрыг төлөвлөөд байгаа бөгөөд дээрх газрын хур хогийн цэгийн хогийг цэвэрлэх ажлыг аймагт уул уурхайн олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд цэвэрлэн ажиллав. Мөн тус ажлын хүрээнд 2020 оны Улсын төсөвт 1,5 тэр бумтөгрөгийг 2020 оноос 2021 онд төсөл хэрэгжихээр батлагдсан ба 2020 онд 338 сая төгрөг батлагдсан.

2. /13/ Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон бодит газрын хэмжээ, Засаг даргын захирамжид заасан хэмжээнээс зөрүүтэй нэгж талбарын зөрчлийг арилгуулахаар сумдын газрын даамлуудад чиглэл өгч тайлант оны жилийн эцсийн байдлаар эзэмших эрхийн зөрчилтэй 85 нэгж талбар, өмчлөх эрхийн зөрчилтэй 2498 нэгж талбаруудын зөрчлийг арилган ажилласан байна. Газрын цахим биржид дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээсийн бүртгэл, үнийн мэдээг нөхөн бүртгэх ажлыг газрын цахим системд оруулсан байна. Үүнд: 2012-2016 оны хооронд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээлэл цуглуулах ГХ, ХҮ, Ү, ХА гэсэн 4 маягтаар цуглуулсан 56 үнийн мэдээ, 2019 оны байдлаар 17 сумын 404 барьцаа бүртгэл, давхардсан тоогоор 8 сумын 83 нэгж талбарын дуудлага худалдааны зарыг оруулснаас 42 нэгж талбарт дуудлага худалдааг зохион байгуулж, 233 зах зээлийн үнийн мэдээг шинээр нэмж бүртгэсэн байна.

3. /30/ Тайлант оны хугацаанд Сэлэнгэ аймгийн хэмжээнд хөрс, орчны бохирдол ихтэй нийт 15 нэгж талбарын 2570.59 га талбай бүхий бусдын эзэмшил газарт мэргэжлийн байгууллагаар газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны дүгнэлт гаргуулах ажлыг гүйцэтгүүлсэн байна. Үүнээс Баянгол суманд 5 нэгж талбарын 1867 га, Ерөө суманд 5 нэгж талбарын 700.7 га, Мандал суманд 4 нэгж талбарын 2.49 га, Сүхбаатар суманд 1 нэгж талбарын 0.4 га газрыг тус тус хамруулжээ.

4. /34/ 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараах ажлууд хийгдсэн.

- Төрийн байгууллагуудыг инженерийн шугам сүлжээнд холбох ажил /Шаамар сум/ 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн байна.

- Хоногт 250 м3 багтаамжтай цэвэрлэх байгууламж /Ерөө сумын Бугант тосгон/ Цэвэрлэх байгууламжийн усан сангийн бетон цутгалтын ажил хийгдэж дууссан. Мөн металл каракасан барилгын угсралтын ажил дууссан Төсөвт тусгагдсан бохирын шугам хоолойг засах, шинэчлэх ажлууд бүрэн хийгдэж дууссан байна.

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Орхон суманд “Нэгдсэн инженерийн шугам сүлжээ байгуулах ажил”-ыг Бурхант хясаат ХХК гүйцэтгэж 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн. Дулааны эх үүсвэрийг Орхон сумын засаг даргатай “Эл си би”ХХК барих ашиглах нөхцөлтэй концессын гэрээ байгуулан Халаалтын төвийн барилга, халаалтын тогоо тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг гүйцэтгэж орон нутгийн халаалтыг хариуцан ажиллаж байна.

1. /44/ “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд барилга угсралтын чиглэлээр 30, барилгын засвар, их засварын чиглэлээр 34, зам засварын чиглэлээр 8, хот тохижилтын

чиглэлээр 7, цахилгаан хангамжийн чиглэлээр 8 нийт 87 төсөл, арга хэмжээнд зөвшөөрөл өгчээ.

2. /67/ Аймгийн хэмжээнд 2019 онд 16 барилга, байгууламжийг ашиглалтад хүлээлцүүлсэн байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ байна. Үүнд:

1. /9/ Аймаг нийслэлийн ерөнхий архитекторыг аймгийн ГХБХБГазрын дарга, эсхүл хэлтсийн даргаар томилон ажиллуулах;

2. /49/ Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1,11 дэх заалт Барилга, хот байгуулалтын Сайдын 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/193 тоот тушаалаар батлагдсан “Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм”-ийг орон нутгийн барилгын материалын лабораторийн онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

3. /62/ “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

4. /11/ Хот суурин газрын төлөвлөлт болон дахин хөгжүүлэх төслийг боловсруулах, хэрэгжүүлэх сургалтад сумдын Засаг дарга, ИТХ, аймаг, сумын ЗДТГ -ын удирдлагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулах;

5. /43/ Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн төлөвлөгөө, Шадар сайдаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж тайлагнаж хагас, бүтэн жилээр тайланг гаргаж ирүүлэх;

6. /63/ Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11 -д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан. УИХ-н 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” хөтөлбөрт 2020 он хүртэлх хугацаанд” ... хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтыг дэвшүүлсэн зэрэг ажлуудын биелэлт хангалтгүй байна.

Дүгнэлт:

1. Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

2. Гэрээний 52, 58 дугаар заалт хоёр өөр шалгууртайгаар давхардаж тусгагдсан байсан тул нэг арга хэмжээгээр тооцож үнэлгээг өгсөн.

Санал, зөвлөмж:

Сэлэнгэ аймаг гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот байгуулалтын чиглэлээр 1 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй /30%/ , 1 арга хэмжээ хэрэгжээгүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 1 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй /30%/ , 1 арга хэмжээ хэрэгжээгүй, нийтийн аж ахуйн чиглэлээр 1 арга

хэмжээний хэрэгжилт хангалтгүй /30%/ , 1 арга хэмжээ хэрэгжээгүй, нийт 6 арга хэмжээг нягтлан үзэж 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Төвийн бүсийн аймгуудад өгсөн санал, зөвлөмж:

Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдтай **Төвийн бүсийн аймгуудын** /Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Төв, Дархан-Уул, Сэлэнгэ/ Засаг дарга нар 2019 онд хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц, бусад ажлын чиглэлээр Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан, нийт **470** ажлуудын гүйцэтгэл **85.1** хувьтай, "хэрэгжих шатанд" гол үр дүн гарч байна.

Дээрх тайланд дурьдсан 30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй Өмнөговь аймгийн 11 арга хэмжээ , Дорноговь аймгийн 11 арга хэмжээ, Дундговь аймгийн 2 арга хэмжээ, Говьсүмбэр аймгийн 12 арга хэмжээ, Төв аймгийн 5 арга хэмжээ, Дархан-Уул аймгийн 3 арга хэмжээ, Сэлэнгэ аймгийн 6 арга хэмжээ, хугацаа болоогүй Дархан-Уул аймгийн 4, Говьсүмбэр аймгийн 1 арга хэмжээг тус тус нягтлан үзэж 2020 төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Төвийн бүсийн аймгуудын хувьд мэдээ, судалгааг тогтоосон хугацаанд ирүүлээгүй, мэдээллээр хангах, хамтран ажиллах, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах талаар дутмаг, гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнах, тайлангийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд ирүүлж хэвших, зөв бичих дүрмийн, болон албан бичгийн стандарт, хэл найруулгын алдаатай зэрэг нийтлэг дутагдал байгаа тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төвийн бүсийн аймгуудын үнэлгээг нэгтгэн харуулбал:

Аймгууд	Үнэлгээ %	Үнэлгээний хувь					Арга хэмжээний тоо	
		100%	70%	30%	0%			
1	Өмнөговь	81.1	47	8	8	3	-	66
2	Дорноговь	83,5	49	9	2	9		69
3	Дундговь	95,0	62	3	1	1	-	67
4	Говьсүмбэр	71,3	47	7	4	8	1	67
5	Төв	93,0	51	10	3	2	-	66
6	Дархан-Уул	88.4%	41	19	1	2	4	67
7	Сэлэнгэ	83,5%	42	20	3	3	-	68
Төвийн бүсийн аймгуудын дундаж		85.1	339	76	22	28	5	470

Г. Зүүн бүсийн аймгууд:

19. Дорнод аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу **69** арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 69 арга хэмжээний 50 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 7 арга хэмжээ 70 хувьтай, 8 арга хэмжээ 30 хувьтай байна. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай 3 арга хэмжээ, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж - **84.3** хувьтай байна.

Ажлын чиглэл	Үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Дүн тоо
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Хот байгуулалтын чиглэлээр	89.2	10	1	-	1	-	12
Газрын харилцааны чиглэлээр	82.1	13	2	4	-	-	19
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	82.4	12	2	2	1	1	18
Нийтийн аж ахуйн чиглэлээр	73.0	6	1	2	1	-	10
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	96.3	7	1	-	-	-	8
Бусад	100	2	-	-	-	-	2
Дүн		50	7	8	3	1	69

БХБСайд, Дорнод аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /2/ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан “Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаж байна. Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдах 1000 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн батлуулсан бөгөөд энэхүү төлөвлөлтийн дагуу хорооллын эдэлбэр газраас засаг захиргааны нэгж, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, онцгой байдлын газарт үйл ажиллагаа явуулах зориулалтаар 7.64 га газрыг эзэмшүүлэх асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна.

2. /3/ Тайлант онд Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдах 1000 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтийн хүрээнд улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийхээр батлагдсан байна. Үүнд: Хорооллын гадна инженерийн 3,2 км шугам сүлжээ барих ажил; 640 суудалтай ерөнхий боловсролын сургуулийн барилга барих ажил; 150 ортой цэцэрлэгийн барилга барих ажил тус тус болно.

3. /4/ “Барилгын тухай” хууль, холбогдох норм дүрмийн дагуу шинээр барих барилга байгууламжийн зураг төсөл, орчны газрын төлөвлөлтөд барилга байгууламж болон ногоон байгууламж, авто зогсоолыг 70:30 харьцааг баримтлан зураг төсөв боловсруулах чиглэлийг зураг төсвийн болон барилга угсралтын ажлын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ 12 га-аар нэмэгдсэн байна.

4. /6/ Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээллийг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах ажлын хүрээнд одоо байгаа дулаан дамжуулах 74.5 км шугам, 130 худаг, цэвэр усны 63.3 км шугам, 237 худаг, бохирын 25.1 км шугам, 390 худаг, холбооны

19.7 км шугам, 95 худаг, шилэн кабелийн 650.5 км шугам сүлжээний мэдээллийн сан үүссэн байна.

5. /14/ Аймгийн хэмжээнд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг Газрын биржийн цахим системээр явуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд батлагдсан 75 байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зарлаж, цахим бирж програмд бүртгэсэн ба 35 байршлын газрын дуудлага худалдааны орлого 488.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

6. /20/ Тайлант онд нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэх ажлын зардалд Цагаан-Овоо сумын орон нутгийн төсөвт 53.9 сая төгрөгийг батлуулсан. Мөн “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хөрөнгөөр төсөл хэрэгжиж буй Хөлөнбуйр, Халхгол, Сэргэлэн сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлыг “Газар сервис” ХХК гүйцэтгэж байна.

7. /22/ Аймгийн хэмжээнд геодезийн үндсэн, дэд болон зураглалын 1954 цэг тэмдэгт байдгаас 1867 геодезийн цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдал, газар олголт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд устах, гэмтэх магадлалтай эсэхэд хяналт тавьж тооллогыг 96.2 хувьтай гүйцэтгээд байна.

8. /37/ Орон нутгийн төсвийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 2, 3, 6 дугаар багийн гудамжинд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий гэрэлтүүлэг суурилуулах ажлыг гүйцэтгэсэн байна.

9. /39/ Чойбалсан хотын газар доорх болон газар дээрх инженерийн барилга байгууламжийн шугам сүлжээний нэгдсэн мэдээллийн санг 2019 оны 05 дугаар сард ГЗБГЗЗГ-аас хүлээн авч инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.

10. /48/ Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дэргэдэх барилгын материалын лаборатори нь Стандарт хэмжилзүйн газрын даргын 2019 оны А/120 дугаар тушаалаар итгэмжлэгдсэн лаборатори болсон. Лабораторийн дүрэм журам, чанарын гарын авлага, лабораторийн бүртгэл зэрэг баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 11 арга хэмжээ байна. Үүнд:

1. /9/ Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, эсхүл хэлтсийн даргаар томилон ажиллуулах;

2. /17/ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3. /18/ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулах;

4. /21/ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, 2020 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх хүсэлтийн хамт аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 2019 оны 12 дугаар сарын 05-ны дотор хүргүүлэх;

5. /24/ Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах;

6. /45/ Барилгын ажил эхлэхтэй холбогдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад нэгээс доошгүй удаа зохион байгуулж, тайланг ирүүлэх;

7. /46/ Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заапт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах /дэлгэрүүлж сайдын тушаалыг оруулах/;

8. /48/ Лабораторийн дүрэм журам, чанарын гарын авлага, лабораторийн бүртгэл зэрэг баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

9. /51/ Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх /57/;

10. /60/ “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн байх;

11. /61/ “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээнүүд байна.

Хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. /49/ Тайлант хугацаанд “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл болон Хөдөлмөрийн яамны “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан”- гийн зээлд хамрагдсан аж ахуйн нэгж байхгүй байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Санал, зөвлөмж:

1. Аймгийн хэмжээн дэх ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилга байгууламжийн судалгааны дагуу холбогдох арга хэмжээг авч шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэх;

2. Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний биелэлтийг нягтлан үзэж 2020 оны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

20. Хэнтий аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 70 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 70 арга хэмжээнээс 50 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 14 арга хэмжээ 70 хувьтай, 4 арга хэмжээ 30 хувьтай байна. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай 2 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж хувь- **87.1** байна.

Хүснэгт 2

Ажлын чиглэл	Үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%			
Хот байгуулалтын чиглэлээр	92.3	12	-	-	1	-	13	
Газрын харилцааны чиглэлээр	87.5	13	6	1	-	-	20	
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	87.8	12	5	1	-	-	18	
Нийтийн аж ахуйн чиглэлээр	70.0	5	1	2	1	-	9	
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	92.5	6	2	-	-	-	8	
Бусад	100	2	-	-	-	-	2	
Дүн		50	14	4	2	-	70	

БХБСайд, Хэнтий аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /2/Батлагдсан хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2020 онд хэрэгжиж дуусч байгаа Өндөрхаан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг тооцож дүгнэлт гаргасан байна. Мөн Чингис хотын ерөнхий төлөвлөгөөний төслийг Хэрлэн сумын ИТХурлаар хэлэлцүүлж, АИТХурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн байна. Чингис хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байгаатай холбогдуулан Хэрлэн сумын 1-р багт “Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц”, Хэрлэн сумын 1-р баг аялал жуулчлалын гудамж байгуулах “Монгол эзэнт гүрний Мини парк” гэсэн 2 хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төсөл арга хэмжээнүүд боловсруулагдаж үе шаттайгаар хэрэгжиж байна.

2. /13/Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Чингис хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажилд 500,0 сая төгрөг, Хэрлэн сумын 1-р багт гэр хорооллын 23 айл бүхий 1 га газарт дахин төлөвлөлтийн ажилд Улсын төсөвт төлөвлөлтийн хүрээнд 650,0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус тусгуулан хэрэгжүүлж байна. БОАЖЯ-аас зарласан БОАЖЯ/2018060882 дугаартай “Мянганы суут хүн их эзэн Чингис хаан-түүхэн аялал жуулчлалын үндэсний парк” цогцолбор техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгэсэн Хот төлөвлөлтийн хүрээлэн ХХК нь сумын төвийн 536 га газарт 2035 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө,хүүхэд залуучуудын соёл,

амралтын хүрээлэнгийн ажлын зураг төсөл, спорт цогцолборын барилгын зураг төсөл, цанын баазын ажлын зураг төслийг тус тус хийж, суманд хүлээлгэж өгсөн байна.

3. /14/Монгол Улсын иргэний өмчилж байгаа газар, иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа газрын хэмжээ нь Засаг даргын захирамжид заасан газрын хэмжээнээс зөрүүтэй нэгж талбарын зөрчлийг арилгах ажлыг хэрэгжүүлэх талаар сумдын Газрын даамлуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулсан бөгөөд 2019 оны 12 дугаар сарын байдлаар нийт 8918 нэгж талбарын зөрчлийг арилган газрын кадастрын мэдээллийн санд оруулан ажилласан байна. Мөн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй нийт 529 нэгж талбарыг нэмж бүртгэсэн байна.

4. /15/Газрын цахим биржийн системээр аймгийн хэмжээнд газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг давхардсан тоогоор 198 нэгж талбарыг зарлаж 77 нэгж талбарын дуудлага худалдаа амжилттай зохион байгуулагдаж аймгийн төсөвт 467,9 сая төгрөгийг төвлөрүүлэн дуудлага худалдааны орлогын төлөвлөгөө 195%-тай биелэсэн байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ байна. Үүнд:

1. /11/Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын томилгоонд Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн, мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй архитектор буюу мэргэжлийн хүнийг томилон ажиллуулах;

2. /19/Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулах;

3. /48/ Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журмыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заапт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах /дэлгэрүүлж сайдын тушаалыг оруулах/;

4. /62/ “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн байх;

5. /63/ “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

6. /65/ Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан; мөн УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрт 2020 он хүртэлх хугацаанд “...хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтын хэрэгжилт хангалтгүй байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Санал зөвлөмж:

Хэрэгжилт хангалтгүй 6 арга хэмжээний биелэлтийг нягтлан үзэж 2020 оны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

21. Сүхбаатар аймаг

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 69 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 70 арга хэмжээний 35 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 14 арга хэмжээ 70 хувьтай, 15 арга хэмжээ 30 хувьтай. Тухайн онд хэрэгжүүлээгүй буюу 0 хувьтай 6 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж **-70.4** хувьтай байна.

Хүснэгт 3

Ажлын чиглэл	Үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо				Хугацаа болоогүй	Дүн тоо
		100%	70%	30%	0%		
Хот байгуулалтын чиглэлээр	78.3	7	3	1	1	-	12
Газрын харилцааны чиглэлээр	73.5	10	5	4	1	-	20
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	70.0	10	2	4	2	-	18
Нийтийн аж ахуйн чиглэлээр	56.0	3	2	4	1	-	10
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	75.0	4	2	2	-	-	8
Бусад	50.0	1	-	-	1	-	2
Дүн		35	14	15	6	-	70

БХБСайд, Сүхбаатар аймгийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. /3/ Хот байгуулалтын болон батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр барилгажилтын төсөл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгын ажлын зураг төсөл боловсруулах, мөн хэрэгжүүлэх ажлын зардлыг улс, орон нутгийн төсөв, гадны хандилагч орнуудын зээл, буцалтгүй хөрөнгийн эх үүсвэрт тусгуулан батлуулж ажиллаж байна. Дарьганга хүүхдийн зусланг орчин үеийн болгох хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Баруун-Урт сумын төвд Сүхбаатар өв соёлын төвийн барилгажилтын төсөл, Эрдэнэцагаан сумын 640 сурагчын суудалтай сургууль, Баруун-Урт сумын 200 хүүхдийн цэцэрлэг, Баруун-Урт сумын Дулааны станцын өргөтгөл, хотын доторхи шугам сүлээ, Баруун-Урт сумын 3000м3/хон хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламж, Баруун-Урт сумын 5,5км цэвэр ус, 2,0км ариутгах татуургын шугам сүлжээ, хотын доторхи 9.1 км авто замын сүлжээ гэх мэт төсөл арга хэмжээнүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн байна.

2. /19/ 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын тогтоолд Сүхбаатар аймгийн хэмжээнд нийт 69 га-д газрыг өмчлүүлэхээр төлөвлөгдсөн. Тогтоолыг хэрэгжүүлэхээр 2019 онд аймгийн хэмжээнд нийт 248 иргэнд 21,33 га газрыг өмчлүүлэхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар

хэлэлцүүлэн баталгаажуулан тогтоолыг хавсралт жагсаалтын хамт Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн байна.

3. /22/ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу дагуу аймгийн хэмжээнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг сумдаас батлагдан ирүүлсэн саналуудыг нэгтгэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит хуралдаанаар нийт 1068 иргэнд 83,03 га газрыг өмчлүүлэхээр батлуулж 2019 оны 10/13 дугаар тогтоолыг хавсралтын хамт холбогдох газарт хүргүүлж ажилласан байна.

4. /29/ Газрын даргын 2015 оны А/103 тушаалаар баталсан журам, Газрын даргын 2017 оны А/268 тоот тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрыг экологийн чадавхаар зураглах заавар”-т заасны дагуу экологийн чадавхийн зураглалыг аймгийн хэмжээнд хийж гүйцэтгэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлж ажилласан. Уг ажлын үр дүнд бэлчээр сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг Баяндэлгэр, Түвшинширээ сумдад 85000 га газарт, орон нутгийн болон төсөл хөтөлбөрийн 4600,000 төгрөгөөр хийхээр 2020 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан байна.

5. /49/ “Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм”-ийг орон нутгийн барилгын материалын лабораторийн онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019 оны 07 сарын 16 өдрийн А/31 тоот тушаалаар батлуулж лабораторийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 21 арга хэмжээ байна. Үүнд:

1. /9/ Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, эсхүл хэлтсийн даргаар томилон ажиллуулах;

2. /12/ Хот байгуулалтын тухай хуулийн 9.1.4-т заасны дагуу аймаг, нийслэлийн хөгжлийн төсөл, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгол, шинэчлэл хийх асуудлыг санаачлан зохион байгуулах;

3. /17/ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4. /20/ Сүхбаатар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт суулгах;

5. /21/ Засгийн газрын үйл ажиллагааны 5.2.4-ийн зорилтын 5 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловруулах ажлыг орон нутагтаа зохион байгуулах, шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэх талаар сумын Засаг дарга нартай хамтран ажиллаж шийдвэрлэх;

6. /25/ Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2019-2020 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах;

7. /32/ 2017-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.17, 5.4.11 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутаг дахь салбарын архивын баримтыг цахимжуулах ажлыг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, гэрээт ажилтнаар гүйцэтгүүлэх;

8. /34/ Аймаг, сум, суурин газрууд одоогоор ашиглагдаж байгаа инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам, сүлжээ, барилга байгууламжийн тоо хэмжээ, өнөөгийн байдлын судалгааг хийж ашиглалтын түвшинг тогтоох;

9. /39/ Аймаг, сумдын эрчим хүчний хэрэглээ /цахилгаан, дулаан, хангамж/-ний өнөөгийн байдал, хүчин чадал, цаашдын төлөвлөлтийн талаарх нарийвчилсан судалгаа гаргаж, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний саналыг боловсруулж, ирүүлэх;

10. /42/ Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах;

11. /46/ Барилгын ажил эхлэхтэй холбогдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад нэгээс доошгүй удаа зохион байгуулж, тайланг ирүүлэх;

12. /47/ Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”-ыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах”-ын хэрэгжилийг хангаж ажиллах /дэлгэрүүлж сайдын тушаалыг оруулах/;

13. /53/ “Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулж ажиллах;

14. /55/ Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийг бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

15. /58/ Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх;

16. /60/ “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;

17. /61/ “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

18. /63/ Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан.

19. /67/ Аймгийн нийтийн аж ахуйн байгууллага болох “Дөрвөлж” ХХК-ийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт тавих;

20. /68/ Монгол Улсын Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “Орон нутгийн удирдпагын бүрэн эрхийн хүрээнд усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох” заалтыг хэрэгжүүлэх

21. /70/ Барилга хот байгуулалтын сапбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, тайлагнах зэрэг арга хэмжээнүүд байна

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг “хэрэгжих шатандаа” буюу тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.

Санал, зөвлөмж:

1. Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг заалт тус бүрээр оновчтой тайлагнах;
2. Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний биелэлтийг нягтлан үзэж 2020 оны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Зүүн бүсийн аймгуудад өгсөн санал, зөвлөмж:

Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдтай **Зүүн бүсийн аймгуудын** /Дорнод, Хэнтий, Сүхбаатар/ Засаг дарга нар 2019 онд хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц, бусад ажлын чиглэлээр Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан, нийт 209 ажлуудын гүйцэтгэл **80.6** хувьтай, биелэлт "хэрэгжих шатанд" гол үр дүн гарч байна.

Дээрх тайланд дурьдсан 30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй Дорнод аймгийн 11 арга хэмжээ, Хэнтий аймгийн 6 арга хэмжээ, Сүхбаатар аймгийн 21 арга хэмжээг тус тус нягтлан үзэж 2020 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг зөвлөмж болгож байна.

Зүүн бүсийн аймгуудын хувьд мэдээ, судалгааг тогтоосон хугацаанд ирүүлэх, мэдээллээр хангах, хамтран ажиллах, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах, гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнах, тайлангийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд тайлагнах зэрэгт хангалтгүй нийтлэг учир дутагдал байгаа тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Зүүн бүсийн аймгуудын үнэлгээг нэгтгэн харуулбал:

	Аймгууд	Дүн	Үнэлгээний хувь					ХБ	Арга хэмжээний тоо
			100%	70%	30%	0%			
1	Дорнод	84.3	50	7	8	3	1	69	
2	Хэнтий	87.1	50	14	4	2	-	70	
3	Сүхбаатар	70.4	35	14	15	6	-	70	
Зүүн бүсийн аймгуудын дундаж		80.6	135	35	27	11	1	209	

Д. Нийслэл Улаанбаатар хот

1. Нийслэл

Нийслэлийн засаг даргын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр 2019 онд байгуулсан нийт 45 арга хэмжээний 30 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 12 арга хэмжээ 70 хувьтай, 2 арга хэмжээ 30 хувийн биелэлттэй, 1 арга хэмжээ үнэлэх боломжгүй байна. Хэрэгжилтийн дундаж - **89.2** хувьтай байна.

Хүснэгт-22

Ажлын чиглэл	үнэлгээ %	Төсөл, арга хэмжээний тоо					Дүн тоо
		100%	70%	30%	0%	ҮБ	
Хот байгуулалтын чиглэлээр	94.5	9	2	-	-	-	11
Газрын харилцааны чиглэлээр	76.3	3	4	1	-	-	8
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	89.2	9	2	1	-	1	13
Нийтийн аж ахуйн чиглэлээр	90.0	6	3	-	-	-	9
Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	100	2	-	-	-	-	2
Бусад	85.0	1	1	-	-	-	2
Дүн /Нийслэл УБ хот/	89.2	30	12	2	-	1	45

БХБСайд, Нийслэлийн Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1.Хот байгуулалтын чиглэлээр:

1. /6/ Хот байгуулалтын кадастрын дэд мэдээллийн санд авто зам -103.9 км, цэвэр усны шугам- 57 1 км, ус зайлуулах шугам 3,6 км, далан суваг - 8,2 км, ариутгах татуургын шугам- 33,5 км, дулааны шугам- 115км, цахилгааны шугам-299,4 км, холбооны шугам- 458,6 км, гэрэлтүүлгийн-718 шон, цэцэрлэг-296, сургууль- 323, улсын эмнэлэг- 38, хувийн эмнэлэг-325, Элчин сайдын яам-42, төрийн байгууллага-257, хүнсний дэлгүүр- 100, 152 хорооны хүн амын мэдээллийг шинэчлэн өдөр тутамдаа хөтлөн ажилласан байна.

2. /8/ Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг дүгнэх хот байгуулалтын үнэлгээ”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа” боловсруулах ажлуудыг Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжиж, зөвлөлийн гишүүдээс өгсөн санал, зөвлөмжийг тусган Барилга, хот байгуулалтын Сайдын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн байна. Тус ажлуудад Барилга, хот байгуулалтын Сайдын тушаалаар магадлал хийх орон тооны бус экспертүүд томилогдон ажиллаж магадлалын ерөнхий дүгнэлт хийгдсэн байна.

3. /11/ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дагалдан гаргах 7 журам, зааврыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 60 дугаар тушаалаар байгуулагдсан байна.

2.Газрын харилцааны чиглэлээр:

1. /13/ Газрын биржийн үйл ажиллагааны www.mle.mn веб хандалттай програмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Мөн 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв - Дүнжингарав салбарт Газрын биржийн цахим төвийг нээсэн. 2019 онд Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Газар, өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын дагуу нээлттэй дуудлага худалдааг Нийслэлийн 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар эзэмшүүлж, ашиглуулахаар тусгагдсан байршлуудад 4 удаа зохион байгуулсан. Сар бүр газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг оруулдаг ба 2019 онд нийслэл, дүүргийн байцаагч нараас 312 иргэн, хуулийн этгээдийн мэдээг цуглуулж нэгтгэн "Газрын цахим бирж"-ийн www.mle.mn сайтад оруулсан байна.

3. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр:

1./25/ Засгийн газрын 2017 оны 68 дугаар тогтоол "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм, 2017 оны 317 дугаар тогтоол "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн дагуу комиссын хуваарийг 7 хоногоор баталж, газрын www.mpa.ub.gov.mn цахим хуудсанд байршуулан, хуваарийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулан ажиллав. 2019 оны жилийн эцсийн байдлаар шинээр 758 барилга байгууламжид зөвшөөрөл олгож, 831 барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж акт баталгаажсан байна.

2. /26/ "Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийн хэрэгжилтийг ханган талаар нийслэлийн нутаг дэвсгэрт байрлалтай орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн ашиглалтын байдалд 340 СӨХ, 250 аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар барилга байгууламжийн ашиглалтын явцад барилгын дээврийн хучлага хар цаас хагарч гэмтсэн, ус чийгний үйлчлэлд орж дулаалгын материал норж, хучилтын хэсгээс цана цохидог, гадна тоосгон хана дулаан тэсвэрлэлтийг хангахгүй, 1958-1970-д онд баригдсан барилга байгууламжууд нь газар хөдлөлтийн тэсвэрлэх чадварыг хангахгүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн ба эдгээр нь ашиглалат, эдэлгээний хугацаанд засвар үйлчилгээг тогтоосон хугацаанд хийж байгаагүйгээс шалтгаалан, хөрөнгө санхүүгийн асуудлаас шалтгаалсан байна. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 133 заалт бүхий 38 улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг, хавсралт, зөвлөмжийн хамт гаргаж хүргүүлсэн байна.

3. /27/ Барилгын ажил эхлэхтэй холбогдуулан 2019 онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр байгууллагын 70 сургалтын 4554 инженер техникийн ажилтан албан хаагчдад, 110 салбарын сургалтыг 3923 албан хаагчдад тус тус зохион байгуулсан байна.

4. /31/ Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх зорилгоор "Барилгын тухай хууль болон холбогдох норм, дүрэм,

барилгын угсралтын ажилд илэрч буй нийтлэг зөрчил дутагдал, урьдчилан сэргийлэх арга зам, барилгын талбайд бетон зуурмаг, арматур, даацын бүтээцүүдийг хүлээн авах, арчлах, хэрэглэх аргачлал, барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох паспортжуулах журам, хөрсний усны горимын судалгаа, барилга байгууламжийг хөрсний уснаас хамгаалах арга замын талаар” 280 аж ахуйн нэгжид сургалт зохион байгуулсан.

Инженерийн дэд бүтцийн чиглэлээр:

1. /21/ Иргэн, хуулийн этгээдээс барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн байр зүйн зураг 387 акт үйлдэж, мэдээллийн санг баяжуулсан. Хот байгуулалтын мэдээллийн санд хот суурин газруудын газар дээрх болон газар доорх инженерийн шугам сүлжээний нийт 111829 метр шугамын батлагдсан ажлын зургийн трассыг оруулсан. Үүнд:

- Дулааны шугам 16945м
- Бохир усны шугам- 7608 м
- Цэвэр усны шугам- 77027м
- Цахилгааны шугам – 4803м
- Ус зайлуулах системийн шугам -322м
- Далан сувгийн зураг - 5124 м

30 буюу түүнээс доош хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. /15/Нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх" гэрээт ажлын хүрээнд нийт 390000 гаруй нэгж талбарын мэдээллийг засварлах, нөхөн бүрдүүлэх, судалгаагаар гарч ирсэн зөрчилтэй нэгж талбарын мэдээллийг засварлах, Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд баталгаажуулах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах;

2. /33/ Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Дэд хөтөлбөр-ийн хэрэгжилтийг хангуулж ажиллах;- зэрэг ажлуудын биелэлт хангалтгүй байна.

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг даргын хооронд хот байгуулалт, газрын харилцаа, инженерийн дэд бүтэц, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн чиглэлээр Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж арга хэмжээний биелэлт жилийн эцсийн байдлаар **89.2%** -тай байна.

Санал, зөвлөмж:

1. Нийслэлийн Засаг даргын гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэрэгжилт хангалтгүй 30%-тай 2 арга хэмжээг нягтлан үзэж 2020 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Бүсүүд болон Нийслэлийн үнэлгээг нэгтгэн харуулбал:

	Аймгууд	Үнэлгээ%	Үнэлгээний хувь					Арга хэмжээний тоо
			100%	70%	30%	0%	ХБ	
1	Хангайн бүсийн аймгуудын дундаж	82.1	242	134	22	13	-	411
2	Баруун бүсийн аймгуудын дундаж	88.0	247	72	20	5	-	344
3	Төвийн бүсийн аймгуудын дундаж	85.1	339	76	22	28	5	470
-	Зүүн бүсийн аймгуудын дундаж	80.6	135	35	27	11	1	209
5	/Нийслэл УБ хот/	89.2	30	12	2	-	1	45
	Бүсийн болон Нийслэлийн дундаж	83.95	993	329	93	57	7	1479

21 аймаг, нийслэлийн Засаг дарга нарын гэрээний хэрэгжилтэд хийсэн нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмж

Дүгнэлт:

Барилга, хот байгуулалтын сайдтай аймаг, нийслэлийн Засаг дарга нарын байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт 2019 онд төлөөлөн хэрэгжүүлэх **1479** арга хэмжээний хэрэгжилтэд тус яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас үнэлгээ хийж, дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймаг, нийслэлийн Засаг даргын гэрээний хэрэгжилт салбарын хэмжээнд “хэрэгжих шатанд” буюу дунджаар **83.95** хувьтай байна. Үүнээс: **Төв, Дундговь** аймгуудын гэрээ “**бүрэн хэрэгжсэн**” буюу 93.0-95.0%-тай, бусад аймгуудын гэрээ “хэрэгжих шатанд” буюу **70.4 – 92.0** %-тай үнэлэгдсэн болно.

Аймгуудын хувьд:

Гэрээнд туссан зорилтуудаас хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр тусгасан зорилтуудыг ихэнх аймгууд бүрэн хэрэгжүүлж 90-ээс дээш хувьтай үнэлэгдсэн байна.

Аймгуудад дараах нийтлэг дутагдал байна. Үүнд:

1. Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн газрыг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа эрхийн зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгах, мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, дуусгах;

2. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний гөлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тогтмол суулгах.

4. Нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах шинээр байгуулагдсан болон өөрчлөлт орсон объектын талаарх мэдээллийг бүрдүүлж геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байх.

5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх инженерийн дэд бүтцийн ажлуудын судалгаа, зураг төсөл, ТЭЗҮ хийхэд шаардагдах хөрөнгө санхүүжилтийн тооцоо судалгааг гаргаж орон нугийн төсөвт тусгах, инженерийн шугам сүлжээний эх үүсвэрийн судалгаа, зураг төсөл, сум суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж, мэргэжлийн байгууллагуудын саналыг сайтар тусгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж байх.

6. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан ‘Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих’ хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл болон Хөдөлмөрийн яамны “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих.

7. Аймаг, сумдын эрчим хүчний хэрэглээ /цахилгаан, дулаан, хангамж/-ний өнөөгийн байдал, хүчин чадал, цаашдын төлөвлөлтийн талаарх нарийвчилсан судалгаа гаргаж, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний саналыг боловсруулж, ирүүлэх;

8. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах;

9. Барилгын ажил эхлэхтэй холбогдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад нэгээс доошгүй удаа зохион байгуулж, тайланг ирүүлэх;

10. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”-ыг үндэслэн Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах”-ын хэрэгжилийг хангаж ажиллах /дэлгэрүүлж сайдын тушаалыг оруулах;

11. “Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулж ажиллах;

12. Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийг бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

13. Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх;

14. “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;

15. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

16. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан.

17. Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “Орон нутгийн удирдпагын бүрэн эрхийн хүрээнд усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох” заалтыг хэрэгжүүлэх; зэрэг ажлуудыг анхаарч ажиллах шаардлагатай байна.

Нийслэлийн хувьд:

1. Гэрээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **89.2%** -тай байна. Дараах ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд: Нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх” гэрээт ажлын хүрээнд нийт 390000 гаруй нэгж талбарын мэдээллийг засварлах, нөхөн бүрдүүлэх, судалгаагаар гарч ирсэн зөрчилтэй нэгж талбарын мэдээллийг засварлах, Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд баталгаажуулах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах;

2. Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах;- зэрэг ажлуудын биелэлт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Нэг. Аймгуудад:

1. Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээний заалтад туссан нийтлэг зөрчил бүхий хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний биелэлтүүдийг дахин нягтлан үзэж 2020 оны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Дараах арга хэмжээний биелэлтүүдэд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна
Үүнд:

1. Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн газрыг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа эрхийн зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгах, мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, дуусгах;

2. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл болон Хөдөлмөрийн яамны “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих.

3. Аймаг, сумдын эрчим хүчний хэрэглээ /цахилгаан, дулаан, хангамж/-ний өнөөгийн байдал, хүчин чадал, цаашдын төлөвлөлтийн талаарх нарийвчилсан судалгаа гаргаж, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний саналыг боловсруулж, ирүүлэх;

4. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах;

5. “Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулж ажиллах;

6. Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийг бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

7. Аймаг нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ашиглагдагдаж байгаа машин механизм, механикжуулалтын судалгаа гаргах, мэдээллийн санд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх;

8. “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;

9. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг болно.

Хоёр. Нийслэлд:

1. Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах;
2. Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд баталгаажуулах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах.

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

10.8 Зөвлөмжийн биелэлт

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тус яамны 2018 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох дүгнэлт, зөвлөмжийг ирүүлсэн.

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээнд дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлсэнээр тодорхой дэвшил гарсан бөгөөд зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төлөвлөлтийн уялдааг сайжруулж, үр дүнгийн үзүүлэлтийг нэмэгдүүлж, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын талаарх сургалтыг ЗГХЭГ, Удирдлагын академитай хамтран яам болон харьяа байгууллагынхаа албан хаагчдад 2 удаа явуулсанаар төлөвлөлт оновчтой болж, хэрэгжилтэд ахиц гарсан.

2. Тайлант хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар бусад газар, хэлтсүүд харьяа байгууллагуудтай харилцан уялдаа холбоотой ажиллаж, тайлан биелэлт ирүүлэх талаар арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласаны үр дүнд өмнөх онтой харьцуулахад тайлагнах ур чадвар тодорхой түвшинд ахисан.

3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор хөтөлбөр, төлөвлөгөө баталсан Барилга, хот байгуулалтын сайдын 2, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 7 тушаалыг хэрэгжүүлж ажилласан.

4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд өмнө нь гарсан шийдвэр, заалтыг хагас жилийн байдлаар нэг бүрчлэн шүүж, хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтуудыг хяналтаас хасуулсан.

5. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу салбарын хууль тогтоомжийг бүхэлд нь судалж, чиг үүргийн давхардал, хийдэл, зөрчил байгааг илрүүлэн холбогдох хуулиудад энэ асуудлаар оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулж тусгуулсан. Тус салбарын хэмжээнд 10 чиг үүрэгт хамаарах давхцал байгааг чиг үүргийн шинжилгээний үр дүнд илрүүлсэн. Тухайлбал: газар зохион байгуулалт, геодези зураг зүйн чиг үүргийн хүрээнд-5, орон сууц, инженерийн шугам сүлжээ, нийтийн аж ахуйн чиг үүргийн хүрээнд-5, мөн салбарын 7 чиг үүрэгт хамаарах асуудлыг дахин хуваарилах шаардлагатай байна. Үүнд: хот байгуулалт-2, барилга, барилгын материал-3, газар зохион байгуулалт, геодези зураг зүй-2.

Мөн хот байгуулалт, барилга, орон сууц, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц шаардлагатай байна.

6. Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүд, дүрэм журмын хэрэгжилтийг хянах, сайжруулах, төрийн байгууллагууд, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор төрийн

албан хаагч бүрийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчилж, холбогдох үүргийг тодорхой тусган биелэлтэд сар бүр хяналт тавьж, яамны сарын үйл ажиллагааны тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /www.unelgee.gov.mn/-д байрлуулж, сар бүр хугацаанд нь баталгаажуулан хүргүүлж хэвшсэн.

7. 2019 онд байгууллагын албан хаагчдын ажлын байрны таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны менежментийн чадамжийн индексийн түвшинг тодорхойлох зорилгоор удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжийн санал асуулгыг 9 бүлэг 90 асуулттай үнэлгээний картаар үнэлсэнээр менежментийн хувьд чадамжтай байгаа эсвэл шаардлага хангахгүй байгаа тухайгаа илүү бодитоор харах боломжтой болж, цаашдын стратеги зорилтоо дэвшүүлэхэд үндсэн үзүүлэлт, чиг хандлагыг тодорхойлогч болгон үйл ажиллагаандаа ашиглаж байна.

8. 2018 онд Шударга байдлын үнэлгээгээр тус яам доогуур үнэлгээ авсан тул Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан нийслэлийн хот байгуулалт, газрын харилцаа, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын албан хаагчдад зориулсан “Шударга ёс ба авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Нийслэлийн захиргааны 5 дугаар байранд зохион байгуулсан. Сургалтын үеэр “Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ? түүний мөн чанар” сэдвээр Улсын Ерөнхий Прокурорын газрын Сургалтын төвийн ахлах прокурор, Хууль цаазын шадар зөвлөх, доктор (Ph.D) Б.Өнөрмаа, “Монголын төрт ёсны түүхэн уламжлал төрийн түшээдийн ёс зүйтэй холбогдох нь” сэдвээр Удирдлагын академийн багш, доктор (Ph.D), профессор Т.Лхагваа, “Төрийн байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдвээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын референт С.Нямбаяр, “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх нь” сэдвээр Удирдлагын академийн багш, доктор (Ph.D) М.Амартүвшин нарыг урьж лекц уншууллаа.

Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны “Шударга байдлын үнэлгээ” 73,2 хувьтай болж, өмнөх онтой харьцуулахад 5,2 пунктээр өссөн байгаа нь яамны авлигатай тэмцэх дотоод үйл ажиллагаа сайжирч байгааг илтгэж байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

